Монгол улсын Үндэсний номын сан

НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН 2019

Эмхэтгэсэн: Б.Сарандэлгэр /Арга зүйч/

Ж.Ганхөлөг /Арга зүйч/

Хянасан: Д.Энхтунгалаг /МАЗЭШХ-ийн дарга/

2020 он

ӨМНӨХ ҮГ

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй аймаг, нийслэлийн нийтийн номын сангууд жил бүр хийсэн ажлынхаа үр дүн, тайланг Үндэсний номын сангийн Мэдээлэл, аргазүй-эрдэм шинжилгээний хэлтэст ирүүлснийг бид эмхэтгэн, 16 дахь удаагаа хүргэж байна.

Та бүхний илгээсэн тайланг хүлээн авч, эмхэтгэхийн зэрэгцээ номын сангийнхаа давуу, сул талд дүн шинжилгээ хийхэд хялбар байх үүднээс тайлан тус бүрээс номын сангийн гол үзүүлэлтээр харьцуулсан судалгааг хийж, схем диаграммаар хавсаргав.

Энэхүү “Нийтийн номын сангуудын тайлан” эмхэтгэл нь зорилго нэгт нөхөд өөрсдийн ажлын амжилт, үр дүнгээ бусад номын сангуудтай харьцуулан судалж, харилцан туршлага солилцон өдөр тутмынхаа ажил үйлс болоод цаашдын төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэхэд зохих хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна.

НОМЫН ЦАГААН БУЯН УЛАМ ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САН

АГУУЛГА

Өмнөх үг 2

Монгол улсын Үндэсний номын сангийн 2019 оны бүтээгдэхүүн нийлүүлэлтийн ажлын тайлан 5

Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын төв номын сангийн 2019 оны үйл ажиллагааны болон бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний тайлан 83

Хүүхдийн номын ордны 2019 он ажлын тайлан 137

Архангай аймгийн Нийтийн номын сангийн 2019 онд хийсэн ажлын тайлан 154

Баян-Өлгий аймгийн Нийтийн номын сангийн 2019 онд хийсэн ажлын тайлан 177

Баянхонгор аймгийн Нийтийн номын сангийн 2019 онд хийсэн ажлын тайлан 210

Булган аймгийн Төв номын сангийн 2019 онд хийсэн ажлын тайлан 223

Говь-Алтай аймгийн Нийтийн номын сангийн 2019 онд хийсэн ажлын тайлан 248

Говьсүмбэр аймгийн Нийтийн номын сангийн 2019 онд хийсэн ажлын тайлан 267

Дархан-Уул аймгийн Төв номын сангийн 2019 онд хийсэн ажлын тайлан 279

Дархан-Уул аймгийн Хүүхдийн номын ордны 2019 онд хийсэн ажлын тайлан.. 302

Дорноговь аймгийн Төв номын сангийн 2019 онд хийсэн ажлын тайлан 322

Дорнод аймгийн Төв номын сангийн 2019 онд хийсэн ажлын тайлан 331

Дундговь аймгийн Төв номын сангийн 2019 онд хийсэн ажлын тайлан 341

Завхан аймгийн Төв номын сангийн 2019 онд

хийсэн ажлын тайлан 356
Орхон аймгийн Номын төвийн 2019 онд
хийсэн ажлын тайлан 370
Өвөрхангай аймгийн Төв номын сангийн 2019 онд
хийсэн ажлын тайлан 383
Өмнөговь аймгийн Төв номын сангийн 2019 онд
хийсэн ажлын тайлан 407
Сүхбаатар аймгийн Нийтийн номын сангийн 2019 онд
хийсэн ажлын тайлан 447
Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн 2019 онд
хийсэн ажлын тайлан 505
Төв аймгийн Нийтийн номын сангийн 2019 онд
хийсэн ажлын тайлан 532
Увс аймгийн Төв номын сангийн 2019 онд
хийсэн ажлын тайлан 556
Ховд аймгийн Нийтийн номын сангийн 2019 онд
хийсэн ажлын тайлан 573
Хөвсгөл аймгийн Нийтийн номын сангийн 2019 онд
хийсэн ажлын тайлан 628
Хэнтий аймгийн Нийтийн номын сангийн 2019 онд
хийсэн ажлын тайлан 666

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН ЗАХИРЛЫН 2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН БИЕЛЭЛТ
(Илтгэх хуудас)

Хүснэгт 1

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт хэрэгжүүлэх арга хэмжээ	*Арга хэмжээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт / тоо, чанар, хугацаа/*	***Хэрэгжилтийн тайлан /2019 оны байдлаар/***	***Өөрийн үнэлгээ***	***Үнэлгээний багийн үнэлгээ***
1	2	3	4	5
А.Нийт ажил үйлчилгээ				
Нэг. “Соёлын өв, оюуны бүтээл, ном хэвлэлийг бүрдүүлэн, сан хөмрөгийн зохион байгуулалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулж, нээлттэй хүртээмжтэй мэдээллээр үйлчлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ				
1.1. Номын худалдаа, нөхөн бүрдүүлэлт, бэлэг солилцоогоор шинэ ном авах шинжлэх ухааны төрөл, салбараар ангилах, дансанд бүртгэх, ажиллах, карт бичих, Архив, Бэлтгэл фондыг шинэ номоор бүрдүүлэх, харилцаат номын сангуудад ном илгээх, хүлээн авах, 1.1.1. Номын худалдаа, нөхөн бүрдүүлэлт, бэлэг, хандив солилцоогоор шинэ номын баяжилт хийх;	- Сан хөмрөгийн бүрдүүлэлт, бүтцэд судалгааг улирал бүр хийнэ. “Гэр бүлийн уншлага, хүүхдийн уншлагын үйлчилгээг бий болгох зорилгоор шинэ ном, хэвлэлийг бэлэг, хандиваар чанартай ном хэвлэлээр бүрдүүлнэ.	- МУҮНС-ийн 2014-2018 оны ном бүрдүүлэлт, Номын сангийн үйл ажиллагааны тайлан НС-1 маягт судалгаа, гадаадын номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудтай ном солилцох ажлын харьцуулсан судалгааг тус тус гаргасан. - Номын сангийн өргөтгөл шинэ барилгын бэлтгэл ажлын хүрээнд “Гэр бүлийн уншлага, хүүхдийн уншлагын үйлчилгээг бий болгох зорилгоор шинэ ном, хэвлэлийг бэлэг, хандив, чанартай ном хэвлэлээр бүрдүүлэх, сан хөмрөг бүрдүүлэлтэд судалгаа гаргаж, сан хөмрөгийн баяжилт хийж байна.	**95** **95**	

1.1.2. Номын худалдаа, нөхөн бүрдүүлэлтээр төсөвлөсөн төсөвт багтаан уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн ном авна.	Сан хөмрөгийг уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн 400 нэрийн 1500 ширхэг номыг шинээр худалдан авч, бэлэг хандивын журмаар 700 нэрийн 2000 ширхэг ном, нөхөн бүрдүүлэлтээр 30-40 ширхэг номоор баяжуулна. - Бэлтгэл фондод 200 ном, Архивт шинээр 800 ном, 70 нэр төрлийн тогтмол хэвлэл хүлээн авч байрлуулах. -Гадаад солилцооны гэрээ байгуулсан харилцаат номын сангуудад: - 200 ном илгээж, - 300 ном, сонин -700, сэтгүүл-400, солилцоогоор хүлээн авна.	- Номын худалдаагаар 318 нэрийн 1681 ширхэг 33335110 төгрөгийн, бэлэг хандиваар 899 нэрийн 2335 ширхэг 32358415 төгрөгийн, солилцооны журмаар 325 нэрийн 331 ширхэг 3581500 төгрөгийн, диссертацийн 141 нэрийн 141 ширхэг 1460000 төгрөгийн, нөхөн бүрдүүлэлтийн 23 нэрийн 44 ширхэг 926100 төгрөгийн нийт 1706 нэрийн 4532 ширхэг 71661125 төгрөгийн ном, диссертац бүрдүүлж шинэ номын баяжилт хийсэн. Бэлтгэл фондод - 685 ном /114 нэрийн/ Архив фондод - 760 ном Гадаад солилцоо: Нийт гадаадын 12 орны 17 номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудтай ном солилцоо хийсэн. - Харилцаат номын санд илгээсэн ном - 223 ширхэг /38 нэрийн 3041000 төгрөг/; - Харилцаат номын сангаас хүлээн авсан ном - 331 ширхэг /325 нэрийн 3581500 төгрөг/, сонин - 648 ширхэг /2 нэрийн 122960 төгрөг/, сэтгүүл - 170 нэрийн 493 ширхэг, 914530 төгрөг	**100**	

1.1.3. Бүрдүүлэлтээр авсан номыг шинжлэх ухааны төрөл, салбараар ангилах, дансанд бүртгэх, ажиллах, карт бичих;	Бүрдүүлэлтээр авсан 3540 ширхэг номыг шинжлэх ухааны төрөл салбараар ангилж, дансалж бүртгэнэ. КОХА программд бүртгэн, картыг хэвлэж, каталогт байрлуулна. - Карт бичих- 6000, - Карт байрлуулах- 5200, - Редакц хийх-20000, - Карт хуулах- 5000	Бүрдүүлэлтээр авсан 3629 ширхэг /1751 нэрийн/ номыг шинжлэх ухааны төрөл салбараар ангилж, нийт 4320 ширхэг /1699 нэрийн/ номыг дансалж бүртгэв. Каталогт монгол 2481, өрнө дахины 103, диссертац 423, монгол судлалын 66, архивын 1520, монгол бичгийн 15, гадаад 911 нийт 6025 ширхэг карт шинээр бичиж, хэвлэн холбогдох каталогуудад 5259 ширхэг карт байрлуулж, 443 ширхэг каталогийн ялгагч хийсэн. Карт бичиж хэвлэх – 5519 Шинээр карт байрлуулах – 4759 Редакц хийх – 19097 Карт хуулах - 6486	**98**	
1.2. Сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтыг, сайжруулах, бүртгэл тооллого хийх; 1.2.1. Өрнө дахины сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтыг, сайжруулах, бүртгэл тооллого хийх;	Өрнө дахины сан хөмрөгийн тооллогын ажлыг үргэлжлүүлэн, аравтын ангиллын 300 000 ширхэг номын мэдээллийг шивж, 2-р формат, аравтын ангиллын 460000 номыг нэг бүрчилсэн дансанд “Тоолов” тэмдэг дарж, дүнг гаргасан байна.	- Өрнө дахины сан хөмрөгийн тооллогыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж, гэрээт ажилтнуудыг авч ажиллуулсан. - Өрнө дахины сан хөмрөгийн тооллогын ажлын хэсэг Нийт 616097 ширхэг /488231 нэрийн/ номын мэдээллийг шивж оруулсан. - Аравтын ангиллын 280512 ширхэг /199488 нэрийн/ номын мэдээллийг шивж оруулан. - Нийт орсон мэдээллээс 324503	**89**	

		ширхэг /254226 нэрийн/ номын үнийг шивж, нэг бүрчилсэн бүртгэлтэй тулган, тооллогын тэмдэглэгээг хийсэн. Дүн гаргах, тоолох ажил үргэлжилж байна. - ӨДСХ-ийн 115 ширхэг нэгбүрчилсэн бүртгэлийг хэлтсийн номын санчдад хуваан өгч, бүртгэлээс тушаалаар хасагдсан, салбарт шилжүүлсэн, актлагдсан номыг бүртгэлээс шүүж Google Driver програмд 80990 ширхэг номын мэдээлэл шивж уг ажил үргэжлэн хийгдэж байна.		
1.2.2. Сан хөмрөгийн зохион байгуулалт, эмх цэгцийг сайжруулах;	Сан хөмрөгүүдээс нийт 103200 ном хэвлэлийг шинээр ба буцаан байрлуулна. - Монгол номын фонд 64000 ном -Монгол судлал гар бичмэл номын фонд 7000 ном, - Өрнө дахины номын фонд жилд 5000 ном - Гадаад, дотоодын 190 нэрийн тогтмол хэвлэлийг шинээр хүлээн байрлуулан, 20000 тогтмол хэвлэлээр үйлчилж, буцаан байрлуулна. Сан хөмрөгийн зохион байгуулалт, эмх цэгцийг сайжруулах;	- Уншлагын танхимаар 69800 ном, диссертаци, 20000 тогтмол хэвлэл нийт 89800 уншуулахаас, 37434 ном, диссертаци, 16303 тогтмол хэвлэл нийт 53737 уншуулж төлөвлөгөөг 60% . - 76000 ном, диссертаци, 27200 сонин сэтгүүл нийт 103200 шинээр ба буцаан байрлуулахаас 43688 ном, диссертаци, 20918 тогтмол хэвлэл нийт 64606 байрлуулж төлөвлөгөөг 62 % .үйлчилсэн ба ном хэвлэлийг шинээр ба буцаан байрлуулсан. /60%/ • Төлбөртэй уншлагын танхимаар 717 ном, 458 нэгж 126 сонин, 113 нэгж 448 сэтгүүл Нийт 1623 үйлчлэв. • Шинээр 2191 ном диссертаци, 2859 сонин сэтгүүл Нийт 5050 хүлээн	**96**	

		авч байрлуулав. /Үүнээс 132 диссертаци/ • Үзэсгэлэнд 3158 ном, 154 нэгж, 613 тогтмол хэвлэл Нийт 3925 үйлчлэв. Фондууд нийт 376596 ном, 4465 сэтгүүл сонин нийт 381061 байрын шалгалт хийж, цэгцлэж янзлан, 1472 ялгагчийг хийв.		
1.2.3. Төвөд ном судрыг электрон каталогт оруулах, данс бүртгэлийг сайжруулах;	Төвд номын сан хөмрөг 3150 судар цэгцлэж, 1740 номыг электрон каталогт оруулж, 4330 номыг данслаж, 3480 ширхэг карт хэвлэнэ.	Төвд номын сан хөмрөг 15507 төвд ном судрыг ялган цэгцэлж, компьютерийн каталогт орсон ном судраас 2725 номыг шалгаж, дансанд бичиж бүртгэн, 986 номыг электрон каталогт оруулж, 1300 карт бичиж хэвлэн гаргав. -Уншигчдын асуусан монгол, төвөд судар номын аман болон бичгийн лавлагааг нийт 255 хүнд 219 номоор өгч бүртгэсэн. 1040 Төвөд судартдонтор ялгагч хийж, 4500 төвд, монгол ном судрыг баринтаглаж байрлуулав. - Шинээр 625 баринтаг хүлээн авав.	**98**	
1.2.4. Уншлаганд элэгдсэн ном хэвлэлийг сэлбэн засч, ном хэвлэлийг ариутгах;	4620 хэвлэмэл ном сэлбэн засч, 605 нэгж сонин сэтгүүлийг хавтаслана. - 272400 номыг стандартын	- Сэлбэн засагчид 612 нэгж сонин, 4 диссертаци, 219 албан бичиг, 1 данс нийт 836 нэгжлэн хавтаслаж, 5913 ном сэлбэн засав. /11545 хуудас нааж сэлбэж, 1114 урагдаж элэгдсэн хуудсыг хувилж нөхсөн/ - Ариутгагч нар 272400 ном хэвлэлийг ариутган цэвэрлэхээс	**100**	

	дагуу ариутгана.	303713 ном хэвлэлийг ариутгасан.		
1.3. Номын сангийн уламжлалт болон шинэ үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, төрөлжсөн уншлагын танхимуудаар чанартай үйлчилгээ үзүүлэх; 1.3.1. Номын сангийн уламжлалт болон шинэ үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, төрөлжсөн уншлагын танхимуудаар нийт 32000 уншигчид, 100000 ном, хэвлэлээр үйлчлэх;	Нийтийн уншлагын танхим, Ерөнхийлөгчийн нэрэмжит эрдэм шинжилгээний уншлагын танхим, Цахим төлбөрт болон тогтмол хэвлэлийн зэрэг 6 танхимуудаар уншлагын үйлчилгээ үзүүллээ. Нийт 32000 уншигчид, 100000 ном, хэвлэлээр үйлчилнэ. Үүнд: - МУ-ын Ерөнхийлөгчийн нэрэмжит эрдэм шинжилгээний уншлагын танхимаар 6300 уншигчид 20500 номоор, - Их уншлагын танхимаар 20000 уншигчдад 60000 номоор; - Тогтмол хэвлэлийн танхимаар 2200 уншигчдад сонин 16000 сонин, сэтгүүлээр; - Ойрын номын фондоос 20000 номоор; - Цахим, төлбөрт үйлчилгээний танхимаар: Цахим үйлчилгээ авах болон	Уншлагын танхимууд нийт 33922 уншигчид 94890 ном, хэвлэлээр үйлчтлж, 4612 хүнд аман лавлагаа өгч ажилласан. - МУ-ын Ерөнхийлөгчийн нэрэмжит эрдэм шинжилгээний уншлагын танхимаар 6303 уншигчид 17744 номоор, - Их уншлагын танхимаар 20278 уншигчдад 52522 номоор; - Тогтмол хэвлэлийн танхимаар 2211 уншигчдад 9256 сонин, 6868 сэтгүүлээр; - Ойрын номын фондоос 23673 номоор үйлчилсэн ба шинээр болон буцаан 23700 ном байрлуулсан. - Цахим, төлбөрт үйлчилгээний танхимаар: Цахим үйлчилгээ авах болон хувийн номтой үйлчлүүлэх 7641	**96**	

	хувийн номтой үйлчлүүлэх 1500-1600 хэрэглэгчдэд ая тухтай орчин, компьютер, интернетийн үйлчилгээ үзүүлнэ. - Уншигчийн үнэмлэхгүй түр үйлчлүүлэгч хэрэглэгчид буюу 2000 ирцэд 3500 ном, хэвлэлээр; - Албан байгууллага, ажилтнуудад солилцоогоор 1000 ширхэг номоор үйлчилнэ.	хэрэглэгчдэд ая тухтай орчин, компьютер, интернетийн үйлчилгээ үзүүлсэн. - Уншигчийн үнэмлэхгүй түр үйлчлүүлэгч хэрэглэгчид буюу 3216 ирцэд 3896 ном, хэвлэлээр; - Албан байгууллага, ажилтнуудад солилцоогоор 1001 ном, 571 нэгж 864 сэтгүүл, нийт 2436 ширхэг ном, хэвлэлээр үйлчиллээ.		
1.3.2. Номын сангийн уншигч, судлаачдыг нэмэгдүүлэх, уншлагыг дэмжих;	- Үнэмлэх нээлт: Их уншлагын танхимд /2500 уншигчдад/ - Эрдэм шинжилгээний уншлагын танхимд /300 уншигчдад/	- Үнэмлэх нээлт: Их уншлагын танхимд 2792 уншигчдад - Эрдэм шинжилгээний уншлагын танхимд 541 уншигчдад нийт 3333 уншигчдыг шинээр бүртгэв. - Үнэмлэх сунгалт 753 уншигч - Хувилах үйлчилгээний карт цэнэглэлтээр 22,245,000 төгрөгийн орлого оруулсан. Уншигчийн үнэмлэхийн хэвлэлтийг сайжруулан, дугаарыг товгор хэвлэлийн аргаар хийлгэж, шинэчлэн "Ном хур" хэвлэлийн газартай гэрээ байгуулан ажилласан.	**100**	
1.3.3. Уншигч, үйлчлүүлэгчдээс судалгаа, санал асуулга авч, дүн шинжилгээ хийж, үйлчилгээний чанарыг	Уншигч, үйлчлүүлэгчдээс судалгааг цахим хуудсаар болон санал асуулга, харилцан ярианы хэлбэрээр тогтмол авч судлан, улирал бүр дүн шинжилгээ хийж, үйл	Нийтийн уншлагын танхимын уншигчдаас сэтгэл ханамжийн болон харьцуулсан судалгааг нийт 12 удаа авч ажил, үйлчилгээндээ тусган ажилласан. Жишээ нь: “Хандлагаа өөрчилж, хамтдаа хөгжье”	**100**	

сайжруулах;	ажиллагаандаа тусгана. /улиралд 1-2 удаа/	аяны хүрээнд судалгаа авч, ном уншилт болон номын сангаар үйлчлүүлсэн хувийг харгалзан Нийтийн болон Ерөнхийлөгчийн нэрэмжит эрдэс шинжилгээний уншлагын танхимаас тус бүр “Шилдэг уншигч” шалгаруулж батламж гардууллаа. Ерөнхийлөгчийн нэрэмжит эрдэм шинжилгээний уншлагын танхимын 21 уншигчаас Монгол судлалын гадаад хэлээр хэвлэгдсэн номыг бүрдүүлэх зорилгоор судалгаа, санал авч, МУҮНС-гийн Мэргэжлийн зөвлөлд танилцуулсан.		
1.3.4. ЮНЕСКО-гийн ном, хэвлэл, товхимолыг бүрдүүлэх, бүртгэх, уншигчдад үйлчлэх;	НҮБ-ын хадгалагч номын сангийн хувьд ЮНЕСКО-гийн ном, хэвлэлийг хүлээн авч, ангилж, дансалж, каталогт бүртгэн, зохион байгуулж, уншигчдад үйлчлэх, сурталчилна.	Тайлангийн хугацаанд нийт 2310 ном ангилж, 1984 ном электрон каталогт бүртгэн, 1984 номын баркодыг хэвлэж наасан. Каталогт орсон номын картыг 3% хэвлэн, 5952 ширхэг карт хэвлэж, каталогт байрлуулсан. Тооллогыг хийж, ангилал, нэр, данс зөрсөн 480 ширхэг номын Коха программын мэдээлэлд засвар хийсэн. Тавиурын ялгагчуудыг шинэчлэн 105 ширхэг ялгагч хийж байрлуулав. Шинээр ирсэн ЮНЕСКО-гийн материал, товхимолуудыг өдөр тутам хүлээн авч байна. 23 уншигчид лавлагаа өгсөн.	**98**	
1.3.5. Номын сангийн тухай хуулийн 12-р зүйлийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн: Алслагдсан иргэдийн эрэлт хэрэгцээг судлах, шинэ ном хэвлэл, мэдээллээр үйлчлэх;	Алслагдсан нутаг дэвсгэрийн иргэд /тусгай байгууламжид буй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс/-т төлөвлөгөөний дагуу Зөөврийн номын сангийн үйлчилгээг 8-10 байгууллагын	МУҮНС Зөөврийн номын сангийн үйлчилгээг 5 байгууллагатай гэрээ байгуулан ажиллсан. Түгээмэл хөгжил Төв, Оюунлаг Ирээдүй ТББ, ШШГЕГ-ын харъяа хаалттай хорих 429-р анги, ШШГЕГ-ын харъяа хорих 441-р ангид 12 удаа нийт 470 хүнд 775 номоор	**98**	

	номын сангийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа иргэдэд улиралд 2-3 удаа очиж үйлчилсэн байна.	хүрч үйлчилсэн ба ШШГЕГ-ын харъяа хаалттай хорих 429-р анги, Хүүхдийн хорих 407-р ангиудад зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон ба нийт 1270 хүн хамрагдсан. Зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлдэг 4 байгууллагын номын санд шаардлагатай ном хэвлэлийг Хууль зүйн хүрээлэнгээс хууль эрх зүйн 4 нэрийн 20 ш ном, 2015-2018 оны “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлийн бүрэн дугаарууд болох 144 ширхэг сэтгүүлийг хандиваар бүрдүүлэн авч, 265 ширхэг ном, хэвлэл хандивлах ажлыг зохион байгуулсан.		
1.3.6. Улсын хэмжээнд нийтийн номын сангуудын зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлсэн тайлан, судалгааг нэгтгэх;	МҮҮНС, Хүүхдийн төв номын сан, УБ хотын нийтийн номын сан, аймгийн төв номын сангууд сангуудын зөөврийн номын сангийн нэгдсэн тайлан судалгаа гарган, үйлчилгээнд дүн шинжилгээ хийх. /Улиралд-1 удаа/	Зөөврийн номын сангийг үйлчилгээг БСШУС-ын Сайдын 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Дугаар А/821 тоот тушаалаар “Зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлэх журам”-ыг батлан хэрэгжүүлж байна. Монгол Улсын Үндэсний номын сан улсын хэмжээний нийтийн номын сангуудын зөөврийн номын сангийн үйлчилгээний тайлан мэдээг улирал бүр авч, нэгтгэж байна. 2019 онд аймаг, нийслэлийн төв номын сангууд болох 24 номын сангийн тайлангнэгтгэн яаманд өгч байна. 2019 онд аймаг, нийслэлийн төв номын сангууд болох 24 номын сан 718 байгууллагатай гэрээ байгуулан, 67685 үйлчлүүлэгчдэд зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэн үйлчилж, 67737 ширхэг ном уншуулж, алслагдсан	**100**	

		дүүрэг, сум, баг, тусгай байгууламж хорих анги, цэцэрлэг, сургууль, төрийн бус байгууллагуудтай хамтран номын сангийн Соёл олон нийтийн ажлыг 1315 удаа зохион байгуулж, 70918 хүмүүсийг хамруулсан байна. Зөөврийн номын сангийн тайлангийн танилцуулгыг 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Сухбаатарын талбайд зохион байгуулсан БСШУС-ын яамны "Нээлттэй өдөрлөг"-ийн арга хэмжээний хүрээнд сурталчиллаа.		
1.4. Номын соёл, уламжлал, ном хэвлэлийг олон нийтэд сурталчлах; 1.4.1. "Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг үндэсний бичиг, соёлыг сурталчлах,түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах;	БСШУС-ын яам, ЗГХА, СУГ бусад байгуулагуудтай хамтран улсын хэмжээнд хөтөлбөрийн дагуу үндэсний бичиг үсэг, соёлын баримтат өвийн үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хурал, тэмцээн, уралдаан зэрэг арга хэмжээг зохион байгуулж, олон нийтэд сурталчилан таниулна.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдлэх, бичиг соёлын дурсгалаа сурталчлах зорилгоор жил бүр зохион байгуулдаг "Үндэсний бичиг үсгийн баяр-2019" арга хэмжээ 2019 оны 5 дугаар сарын 3-ний өдрөөс 8-ны өдрүүдэд улсын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүллээ. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/253 дугаар тушаалын дагуу "ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСЭГ–ТУСГААР ТОГТНОЛ" уриатайгаар "Үндэсний бичиг үсгийн баяр – 2019" -ын арга хэмжээг зохион байгуулсан байна. - Нээлтийн арга хэмжээ 2019 оны 5 дугаар сарын 3-нд цагт Монгол улсын Үндэсний номын сангийн гадна талбайд зохион байгуулж МҮОНРТ-ээр шууд дамжуулсан. Нээлтийн ажиллагаанд УИХ-ийн гишүүн Г.Мөнхцэцэг, БСШУС-ын сайд	**100**	

		Ё.Баатарбилэг, ЗГХА, СУГ-ын дарга Г.Эрдэнэбат, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн дарга, Ардын багш С.Дулам болон МУИС, нийслэл, орон нутгийн номын сангийн төлөөлөл оролцсон. БСШУСЯ-ны "Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч" шагнал, 2018 оны "Шилдэг нийтийн номын сан"-д Үндэсний номын сангийн нэрэмжит "Ном цом" шагнал болон Үндэснийй бичиг үсгийн баярын хүрээнд зохион байгуулсан тэмцээн, уралдаан, олимпиадын шагнал гардуулах ажиллагааг зохион байгуулсан. - Зохиолчдын гарын үсэгтэй болон хэвлэлийн газруудын хямдралтай номын худалдааг 5-р сарын 3, 4-нд зохион байгуулж, 14 байгууллага, зохиолчид оролцлоо. - "Үнэт Ховор Номын Музей"-д 5 дугаар сарын 03-08-ны өдрүүдэд "Даавуу, торгон дээрх үндэсний баримтат өв" үзэсгэлэнг номын донтор, хошуу нутгийн газрын зураг, хаадын тамгатай зарлигууд мөн Монгол Шуудангаас гаргадаг нэн ховор "Торгон Марк" зэрэг 100-аад өвийг дэглэн 500 гаруй хүмүүст тайлбарлан сурталчилсан. - “Нийтийн номын сангийн үйл ажиллагааны тайланг боловсруулах аргазүйн зөвлөмж” сургалтыг орон нутгийн болон нийслэлийн нийтийн номын сангийн 40 орчим мэргэжилтнүүдэд зохион байгууллаа.		

		- “Даавуун артай соёлын баримтат өвийн өнөөгийн байдал” сэдэвт эрдэм шинжилгээ - онол практикийн хурлыг зохион байгуулж, эрдэмтэн судлаачдын 9 илтгэлийг хэлэлцүүлж, хурлын илтгэлүүдийг товхимол болгон хэвлүүлсэн. - Үнэт ховор номын танилцуулга брошурыг хэвлүүлсэн.		
1.4.2. Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу “Номын баяр”-ыг зохион байгуулна.	Ном хэвлэлийг сурталчлах зохиолчдын зохиол бүтээлийн болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 300 гаруй номоор гарган, номын сангийн үйл ажиллагааг сурталчилсан олон талт арга хэмжээг олон нийтэд зориулан зохион байгуулсан байна	- Номын сангийн үйл ажиллагааг сурталчилан зохиолчдын ойд зориулсан үзэсгэлэнг 320 номоор гаргасан - БНХАУ-ын хэвлэл мэдээллийн ерөнхий газар, Соёл, орчуулгын холбоо, МҮОНРТ-тэй хамтран Соёлын төв өргөөнд 9 дүгээр сарын 11-13-нд номын үзэсгэлэн зохион байгуулж, нийт 450 ширхэг номыг хүлээн авсан. -	**100**	
1.4.3. “Дэлхийн ном болон зохиогчийн эрхийг хамгаалах өдөр”-ийн үйл ажиллагааг зохион байгуулах;	Дэлхийн зохиолчдын бүтээл, ном хэвлэлийг сурталчилсан үзэсгэлэнг 100-120 номоор, “Он цагийн түүхэнд мөнхөрсөн орос сэтгүүлийн дээжис” үзэсгэлэнг 30 нэрийн сэтгүүлийн тайлбартай танилцуулга бэлтгэн, үзэсгэлэн зохион байгуулна. / IV сарын 23/	- Үндэсний номын сангийн танилцуулгыг шинэчлэн уншигчид болон зочид, төлөөлөгчдөд байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар монгол, англи хэлээр хэвлүүлсэн. - "Ном, зохиогчийн эрх" сэдэвт үзэсгэлэнг 41 номоор 7 хоног гаргаж, уншигч үйлчлүүлэгчдэд сурталчилсан. - “Он цагийн түүхэнд мөнхөрсөн орос сэтгүүлийн дээжис”-II үзэсгэлэнг 32 сэтгүүлээр дэглэж нугалбарын эхийг бэлтгэн хэвлүүлж, “Гадаадынхан Монголын тухай тогтмол хэвлэлд”	**100**	

		сэдэвт үзэсгэлэнд 40 сэтгүүл нэг бүрийн тайлбарыг бэлдэж үзэсгэлэнг дэглэв. /2019.04.23/ 320 хүн үзэж сонирхов.		
1.4.4. Эзэн богд Чингис хаан-Тэмүүжиний мэндэлсний 857 жилийн ой “Монгол бахархлын өдөр”-ийн арга хэмжээг зохион байгуулах,	Эзэн Чингис хааны талаарх эх сурвалж болон судалгааны 50 орчим бүтээлээр үзэсгэлэн, хэлэлцүүлэг, номын худалдаа зохион байгуулж, хэвлэл мэдээлэл, олон нийтэд сурталчилна.	Улс тунхагласны ойн баяр, Монгол бахархлын өдөр – Эзэн Чингис хааны мэндэлсний 857 жилийн ойд зориулсан “Монголын төрт ёсон ба бичиг соёлын өв” үзэсгэлэнг 2019 оны 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 25-ны өдрүүдэд Монголын түүхийг бүтээлцсэн алдарт хүмүүсийн түүхээр дамжуулан хойч үедээ түүх соёлоо сурталчлах, бахархах үзлийг төлөвшүүлэх зорилгоор: Монгол Улсын Үндэсний номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй ном, бичгийн дурсгалуудаар дараах сэдвийн хүрээнд : - Чингис хааны 857 жил - Соёмбо үсгийн 333 жил - Богд хааны 150 жилийн ой - Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын 108 жилийн ой - Монголын анхны Ерөнхий сайд, Халхын Сайн ноён хан Төгс-Очирын Намнансүрэнгийн үйл хэрэг зэрэгт холбогдох номын үзэсгэлэнг Монголын үндэсний музей, Зүүн хүрээ Дашчойлин хийд, хувь цуглуулагч Б.Амарсанаа зэрэг байгууллага, хүмүүстэй хамтран гаргалаа. Үзэсгэлэнг нийт 200 гаруй хүн үзэж сонирхов.	**100**	
1.5. Номын сангийн ном хэвлэлийг уншигч, олон нийтэд сурталчлах;	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн календарьчилсан	Тэмдэглэлт өдрүүдэд зориулсан сэдэвчилсэн номын үзэсгэлэнгийн календарьчилсан төлөвлөгөөний дагуу	**100**	

1.5.1. Шинэ номын болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг календарьчилсан төлөвлөгөөний дагуу сард 1-2 удаа гаргах;	төлөвлөгөөний дагуу 32 тэмдэглэлт өдөрт зориулсан номын үзэсгэлэнг уншигчдад 2600 гаруй номоор зохион байгуулна.	35 тэмдэглэлт өдөрт зориулсан номын үзэсгэлэнг уншигчдад 3925 ном, тогтмол хэвлэлээр зохион байгуулсан.		
1.5.2. Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг номын сангийн цахим хуудсаар /веб сайт/ сурталчлах;	Сэдэвчилсэн номын үзэсгэлэнд тавигдсан 2600 гаруй номын жагсаалт, үзэсгэлэнгийн танилцуулга, сурталчилгааг цахим хуудас, цахим орчин, хэвлэл мэдээллээр тогтмол сурталчилна. Энэ бусад номын сангууд, уншигчид лавлагаа мэдээллийг цаг тухайд хүртсэн байна. КОХА программаас вэб сайтын Үйлчилгээ цэсний Мэдээлэл-номзүйн үйлчилгээ булангийн Сэдэвчилсэн үзэсгэлэнгийн санамж өгөх номзүйг 32 сэдвээр нийт 2600 номын жагсаалтыг эмхэтгэн, оруулсан байна.	Түүхэн үйл явдал, баяр ёслолын үеэр гаргах сэдэвчилсэн номын үзэсгэлэнгийн жагсаалтыг тухайн цаг үеийн арга хэмжээнд зориулан нийт 2829ш номоор бэлтгэн хянаж, сэдэвчилсэн номын үзэсгэлэнгийн жагсаалтыг КОХА программд санамж өгөх номзүй хэлбэрээр байршуулав. Цахим хуудас, цахим орчин, хэвлэл мэдээллээр тогтмол сурталчилж байгаа нь бусад номын сангууд, уншигч, сонихогчид лавлагаа мэдээллийг цаг тухайд хүрэж байна.	**100**	
1.5.3. Зохиогч-уншигчдын уулзалт, зохиолчдын түүхэн ойд зориулсан номын үзэсгэлэн болон бусад олон нийтийн ажил зохион байгуулах;	- Зохиолчдын ойд зориулсан номын үзэсгэлэн, арга хэмжээ: -Монголын Зохиолчдын Эвлэлийн 90 жилийн ойд зориулсан номын үзэсгэлэн 85 номоор	- Монголын Зохиолчдын Эвлэлийн 90 жилийн ойд зориулсан номын үзэсгэлэнг 57 ном, сонин-2 хавтас. Сэтгүүл-3 хавтас, 6 дугаараар гаргасан ба 2019 онд МЗЭ-ийн 90 жилийн хүрээнд жилийн турш ном, зохиолчдын аливаа арга хэмжээг хамтран зохион байгуулж байна. - Дэлхийн яруу найргийн өдөрт – Б.Явуухулангийн 90 жилийн ойд	**100**	

	- Б.Явуухулан 90 жилийн ой, Дэлхийн яруу найргийн өдөрт зориулсан яруу найргийн уулзалт, номын үзэсгэлэн 60-70 номоор, - “П.Бадарч 80 жилийн ойд” номын үзэсгэлэн 65-70 номоор, - “С.Эрдэнэ 90 жилийн ойд” номын үзэсгэлэн 70-80 номоор, - “Ц.Гайтав 90 жилийн ойд” номын үзэсгэлэн 45-60 номоор, - Монгол Улс, БНХАУ хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд МУБИС-ийн НХУС-ийн Сэтгүүл зүйн тэхимтэй хамтран Хэвлэл мэдээлэл дэх Хятад-Монголын харилцааны талаарх мэдээллийн судалгааны ажилд “Үнэн” сонины 1949 оноос хойшхи материалуудыг бэлтгэн өгч, хамтран ажиллана.	зориулсан зохиолч уншигчдын хурал арга хэмжээнд зохиулан номын үзэсгэлэнг 34 ном, 6 нэгж сонин, 4 хавтас, 11 сэтгүүлээр гаргаж сурталчлав. - “П.Бадарч 80 жилийн ойд” номын үзэсгэлэн, номзүйн бүртгэлийг 375 ном, өгүүллээр, - “С.Эрдэнэ 90 жилийн ойд” номын үзэсгэлэн 75 номоор, - “Ц.Гайтав 90 жилийн ойд” номын үзэсгэлэн 68 номоор, Монгол Улс, БНХАУ хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд: - МУБИС-ийн НХУС-ийн Сэтгүүл зүйн тэхимтэй хамтран Хэвлэл мэдээлэл дэх Хятад-Монголын харилцааны талаарх мэдээллийн судалгааны ажилд “Үнэн” сонины 1949 оноос хойшхи материалуудыг бэлтгэн өгсөн. - Хятад, Монгол хоёр улсын үзэл санаа, соёлын солилцоо, эрдэмтэн шинжээчдийн хамтын ажиллагааг улам бэхжүүлэх үүднээс Хятадын Соёлын орчуулга судлагааны газар (CCTSS) болон Хятад улсын Боловсролын номын импорт экспортын компани хамтран "2019 оны Хятад, Монголын хамтарсан номын үзэсгэлэн"-г 9 дүгээр сарын		

		10-13-ны өдрүүдэд Соёлын төв өргөөнд зохион байгуулсан.		
	- Эрдэм шинжилгээний хурал, номын нээлт, хамтарсан хэлэлцүүлэгт зориулсан номын үзэсгэлэн зохион байгуулах /улиралд 2-3/	1. 2019 оны 1 дүгээр сарын 29-нд Шар нохой жилийн шилдэг ном шалгаруулах ёслолын ажиллагааг MNC телевизтэй хамтран зохион байгуулж 50-иад хүн оролцсон. 2. Дорнын их яруу найрагч Б.Явуухулангийн 90 жилийн ойд зориулсан зохиолч уншигчдын бага хурлыг 3-р сарын 21-ний "Дэлхийн яруу найргийн өдөр"-ийг тохиолдуулан зохион байгуулсан. Зохиолч уншигчдын уулзалтад СГЗ, зохиолч, яруу найрагч, Монголын Соёл Яруу найргийн Академийн тэргүүн Г.Мэн-Ооёо мэндчилгээ дэвшүүлж үг хэлж, СГЗ, зохиолч, МЗЭ-ийн Удирдах зөвлөлийн дарга До.Цэнджав "Монголын яруу найргийн үнэт зүйл, хөгжлийн төлөв", СУИС-ийн Урлаг, утга зохиолын тэнхимийн багш, утга зохиол судлаач, зохиолч Х.Чойдогжамц Б.Явуухулан "Тэхийн зогсоол" дуулийг экзистенциал – феноменологийн үүднээс шинжих нь" гэсэн илтгэлүүдийг тавьж, зохиолч, судлаачид яруу найрагийн хөгжлийн чиг хандлагын талаар судалгааны чухал асуудлыг ярьж, хэлэлцүүлсэн арга хэмжээнд 80 гаруй хүн оролцсон байна. 3. Монгол улсын хаан VIII Богд Жазандамба хутагтын мэндэлсний 150	**100**	

		жилийн ойд зориулсан “Наймдугаар Богд Жавзандамба хутагт шашин төрийг хослон баригч хаан хэмээхийн учир” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж МУИС, Богд хааны ордон музей, МБШТөв Гандантэгчэнлин хийдийн Эрдэм соёлын хүрээлэн зэрэг байгууллага болон эрдэмтэн судлаачид илтгэл тавьж хуралд 60 хүн урилгаар оролцлоо. 4. 5 дугаар сарын 17-нд МУҮНС, МЗЭ, УБХННС, “Идэр” дээд сургууль хамтран тус сургуулиас зохион байгуулсан “Шинэ толь II” яруу найраг, уран бичлэгийн улсын уралдааны 2-р шатны шалгаруулалтын арга хэмжээ /60 хүн оролцсон/ 5. Орчуулагч Н.Энхбаярын “Сохрын орон” номын нээлтийн арга хэмжээ 5 дугаар сарын 22-нд /80-90 хүн оролцсон/ 6. Зохиолч, МҮОНРТ-ийн сэтгүүлч Сарантуяагийн номын нээлт 5-р сарын 23-ны өдөр 7. Одкон холдинг ХХК-ийн ерөнхий захирал Л.Мөнхбатын санаачлагаар бүтсэн "Металыг цахилгаан ба хийгээр гагнах, зүсэх технологи" номын нээлт 5-р сарын 25-ны өдөр зохион байгуулсан. 8. ЗГХА, Соёл урлагийн газраас зохион байгуулсан Соёл урлагийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөр”-ийн хүрээнд Сүхбаатарын		

		талбайд “Монголчуудын номын соёл, модон барын хэвлэл” үзэсгэлэнг 33 ном бичгийн хэрэгслээр гарган сурталчилсан. 9. 6 дугаар сары 19- ны өдөр Өвөрхангай аймгийн Хар хорин хотын Л.Гомбосүрэн сангийн тэргүүн Г.Янживын “ БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Лувсанжамбаагийн Гомобосүрэн” номын нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулав. 10. "Дэлхийн номын сангууд дахь сурвалж бичгийн өв" хурлыг МУИС-ийн номын сан, МУИС-ын Монгол судлалын хүрээлэнтэй хамтран 8 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд оролцсонзохион байгуулсан ба хуралд гадаадын 22 эрдэмтэн, нийт 32 илтгэгч оролцлоо. 11. "Юань улс хаятад нангиадыг хэрхэн нэгтгэн удирдаж байсан тухай" Тайванийн их сургуулийн доктор Ван Мин Сүн 9 дүгээр сарын 9-ний өдөр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, нийт 50 гаруй хүн оролцсон. 12. 9 дүгээр сарын 11-ний өдөр Монгол Улсын Үндэсний номын санд "Хятад - Монголын Хятад судлал ба соёлын солилцооны эрдэм шинжилгээний хурал", "Монголын Хятад судлал ба соёлын хөгжлийн тайлан" бага хурлыг эрдэмтэн судлаач, зохиолч, орчуулагч, хэвлэн нийтлэгчдийн хүрээнд зохион байгуулсан. /Нийт 38 хүн оролцсон./ 13. Бүгд Найрамдах Беларусь Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Станислав В.Чепурной нийслэлийн хэмжээнд байгаа нийтийн, их дээд		

		сургууль, ЕБС, хувийн, байгууллагын дэргэдэх 40 гаруй номын сангуудад Беларуссын нэрт яруу найрагч Янка Купалагийн “Шүлгийн түүвэр”, Халх голын баатар нисэгч С.И.Грыцавецын намтар “Даль Жигүүртнүүдэд Тэнгэрийг Даатга” номыг гардуулах ёслол боллоо. Ёслолын арга хэмжээнд Бүгд найрамдах Беларусь улсаас монгол улсад суугаа Элчин сайд Станислав Чепурной, Элчин сайдын зөвлөх Мрочек, орчуулагч Фатима, уг номын орчуулагч СГЗ, нэрт орчуулагч,нийтлэлч Б.Галаарид, СГЗ, Монголын нэрт орчуулагч Г.Аким болон нийслэлийн номын сангуудын төлөөлөл номын санчид хүрэлцэн ирлээ. 14. “Дас Ихэр” сангаас эрхлэн хэвлүүлсэн “Жангар” туулийг улсын хэмжээний нийтийн номын сангуудад хандивлах ёслолыг зохион байгууллаа. Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Ч.Лодойдамбын нэрэмжит шагналт, түүхч, ахмад зохиолч, Жангар, Гэсэр судлаач, Ардын аман билэгзүйч Д.Суръягийн эмхэтгэсэн “Монгол Жангар” туулийг дэлгэрүүлэхээр “Дас ихэр” сангаас Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэвлүүлж Улсын хэмжээний 376 нийтийн номын сангуудад хандивлах үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Н.Хүрэлбаатар, УИХ-ын гишүүн Б.Жавхлан, БСШУС-ын Дэд сайд Г.Ганбаяр, ЗГХА Соёл урлагийн		

		бодлогын газрын дарга Г.Эрдэнэбат, зохиолч Д.Сүръягийн үр хүүхдүүд болон нийслэлийн нийтийн номын сангуудын төлөөлөл хүрэлцэн ирж оролцлоо.		
Хоёр. “Эрдэм шинжилгээ, арга зүйн удирдлагыг боловсронгуй болгох” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ				
2.1. Эх бичиг сурвалж судлал, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг эрчимжүүлэх; 2.1.1. Эх бичиг сурвалж судлал, судалгааны ажил хийх;	- Дөрвөн хэлний "Жамбалцанжид" судрын Ланз үсгийн юникодыг хийж хуулж бичих ажил хийгдэнэ. - Зава ламын "Хорчойнжин" бүтээлийг галиглах, ашигласан эх сурвалжуудын жагсаалт гаргана. - Есөн эрдэнийн Ганжуур судрын доторх гарчгийг бүртгэх, номын жагсаалт гаргаж, судалгаа хийнэ.	- Дөрвөн хэлний "Жамбалцанжид" судрын Соёмбо үсгийн юникодыг хийж хуулж бичив. /санскрит хэлээр/. - Зава ламын “Хорчойнчин” бүтээлийг галиглан, орчуулж дууссан ба ашигласан эх сурвалжуудын жагсаалтыг гаргаж дуусгав. - “Есөн эрдэнийн Ганжуур” судрын доторх номыг бүртгэж 710 номын жагсаалт гаргав. - Соёмбо үсгийн монголоор бичих юникодыг хийж, соёмбо үсгийн монгол “Итгэл” судрыг файл болгож дуусав.	**100**	
2.1.2. Судалгааны нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан үүсгэх, хамтарсан судалгаа хийх;	ШУА-ийн Түүх Археологийн хүрээлэн, Архивын Ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд гэрийн үеийн бичмэл болон гар бичмэл материалын нэгдсэн бүртгэл хийж солилцоно.	ШУА-ийн ШУА-ийн Түүх Археологийн хүрээлэн, Архивын Ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд: - Торгон өргөмжлөл бичгүүдийн судлагаа хийгдсэн. - Судалгааны мэдээллийн сан, жагсаалтыг харилцан солилцсон бөгөөд гэрийн үеийн бичмэл болон гар бичмэл эхийг зөвшөөрлийн дагуу цахимаар хуулбарлан авсан.	**96**	

		- Түүх археологийн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан Н. Хатанбаатарын хүсэлтээр Захирлын зөвшөөрлөөр 1134/96 дугаартай “Эрдэнэзуу ба Өндөр гэгээний намтар оршивой” гар бичмэлийн 36, 40. 55, 65, 71-99, 104 Нийт 33 нүүрийг хуулбарлаж авч судалгааны ажилдаа ашиглахтай холбогдуулж хамтарч ажиллав.		
2.2. ЗГҮАХ-ийн 3.2.44, НСТХ-ийн 9.4-р заалтыг хэрэгжүүлэх: 2.2.1. Номын сан судлалын онолын асуудалд судалгаа хийж, номын санчдын хүртээл болгож, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг эрчимжүүлэх;	Номын сан, номзүй, ном судлалын холбогдолтой 5-6 эрдэм шинжилгээ, онол практикийн өгүүлэл, илтгэл бэлтгэж нийтлүүлсэн байна.	Номын сан, номзүй, ном судлалын холбогдолтой ном, эрдэм шинжилгээ, онол практикийн өгүүлэл, илтгэл бэлтгэн нийтлүүлэв. Үүнд: Хэвлэн гаргасан бүтээлүүд: 1. Монгол Улсын Үндэсний номын сангийн эрдэнэсийн сан : /Зөвл. Ж.Сэржээ, Т.Баярлах, Ч.Гансүх Орч. Г.Гансүх Эмхэт. Д.Энхтунгалаг .-УБ :Соёмбо принтинг ,2019 .-176 х. -(МУҮНС) 2. “МУҮНС-ийн танилцуулга”-ыг нэмж засварлан, монгол англи хэлээр шинэчлэн хэвлүүлсэн. 3. Тунгалаг Б. “Монгол зөвлөлтийн эрэлхэг дайчид 1939 онд халхын голд японы түрэмгийлэгчидтэй баатарлагаар тулалдаж ялалт байгуулсан тухай өгүүлсэн номуудын товч тойм. -УБ., 2019. -165х. /Халхын голын ялалтын 80 жилийн ойд зориулав/ 4. “Даавуун артай соёлын баримтат өвийн өнөөгийн байдал” Эрдэм	**100**	

		шинжилгээний онол практикийн хурал. – Эмхэтгэл. -УБ.,2019. -77х. Илтгэл өгүүлэл: 1. Д.Энхтунгалаг “МУҮНС-ийн өнөөгийн байдал, хөгжлийн төлөв” сэдвээр илтгэл - танилцуулга бэлдэж, Монгол-Солонгосын номын сангуудын хамтын ажиллагааны хүрээнд Солонгосын НСХ-ноос ирсэн төлөөлөгчдийг хэлтсийн ажилтнуудын хамт хүлээн авч танилцуулав. 2. Т.Баярлах "Монголчуудын төвд хэлт зохиол бүтээлийн бүртгэл, каталогжуулалтын өнөөгийн байдал" /Дэлхийн номын сангууд дахь сурвалж бичгийн өв" ОУЭШХ-д тавьсан илтгэл; 3. Ч.Гансүх “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичгийн судалгаа 1913-1919 : шинээр олдсон зарим эх бичгийн тухай”. - Институт Богда-Гэгэна в историй Монголий . – Труды Института востоковедения РАН. – выпуск 25. -М., 2019 г.- 143-162 стр. 4. Б.Тунгалаг “Наймдугаар Богд Жавзандамба хутагтын номын сан хөмрөг бүрдүүлэх үйл ажиллагаа”. - Институт Богда-Гэгэна в историй Монголий . – Труды Института востоковедения РАН. – выпуск 25. -М., 2019 г.- 330-349 стр ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгийн сэтгүүлд хэвлэгдэв.		

		5. Ч.Гансүх “Даавуун артай соёлын баримтат өвийн өнөөгийн байдал” Эрдэм шинжилгээ онол практикийн хуралд “МУҮНС-д хадгалагдаж буй даавуун артай эх сурвалжууд” илтгэл. 6. Ч.Гансүх “Богд Хааны Ордон Музейн судар номыг цэгцэлсэн нь” /Унгар улсын Будапешт хотноо болсон 2019.04.25-26/ 7. Ч.Гансүх “Унгарын Шинжлэх Ухааны Академид хадгалагдаж байгаа монгол эх сурвалжуудын өв” /Дэлхийн номын сангууд дахь сурвалж бичгийн өв" ОУЭШХ-д тавьсан илтгэл; 8. Ч.Гансүх “Олон улсын каталогт Монголын номын сангуудын оруулах хувь нэмэр” /9 сарын 12 нд / 9. Ч.Гансүх “Наймдугаар Богдын зохиосон лүндэнгийн монгол төвөд хоёр эх сурвалжийн тухай 10. Ч.Гансүх “Наймдугаар Богд Жавзандамба хутагтын номын сан хөмрөг бүрдүүлэх үйл ажиллагаа, “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг (1914-1919) шинээр олдсон зарим эх бичгийн тухай 11. П.Гийхнаран “Даавуун баримтат өвийн хадгалалт хамгаалалт, өнөөгийн байдал” сэдвээр; 12. Х.Түмэнбаяр "Гарчиг болоод номын донторын хамаарал" сэдвээр тус тус илтгэл		

		"Номын санч" сэтгүүлд: 1. Д.Энхтунгалаг “Номын сангийн эдийн засгийн үйл ажиллагаа: мөн чанар, агуулга, үндсэн ангилалууд”; 2. Г.Гүнжинлхам “Улсын хэмжээний нийтийн номын сангуудын 2018 оны үйл ажиллагааны тайлан, судалгаанд хийсэн үнэлэлт, дүгнэлт”; 3. Б.Отгонтуяа “Номын сан дахь хорхой шавж, түүнтэй тэмцэх аргууд”; 4. Х.Ундрах “Ном унших ашиг тусын тухай 10 зөвлөмж”; 5. Ж.Ганхөлөг “Хөгжихийг хүссэн хүн бүхэнд”; 6. Б.Цогжаргал Номын сангийн лавлагаа номзүйн ажлын зөвлөмж” сэдвээр, 7. Г.Гүнжинлхам, Х.Ундрах нар “Баянхонгор аймгийн номын санчдын дунд “Ажил мэргэжил, ур чадвар”-ын уралдаан боллоо”, 8. Т.Түвшинтунгалаг “МУ-ын Үндэсний номын сан Олон улсын сургуультай хамтран 2 дахь жилдээ үзэсгэлэн зохион байгууллаа”,		
2.2.2. Үндэсний номын сангийн архивын баримтыг судалгаанд оруулах;	“Монгол Улсын Үндэсний номын сангийн архивын баримтын эмхтгэл”-ийг бэлтгэн, хэвлэн гаргана.	Монгол Улсын Үндэсний номын сангийн архивын материалуудыг скайнердаж, товьёог шивж “Архивын баримтын эмхтгэл”-ын эхийг бэлтгэн, МУҮНС-гийн 100 жилийн түүхийн баримтын эмхэтгэлийн Боть I хэвлүүлж байна.	**89**	
2.3. Номын сангуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах	Аймгуудын тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийх, эмхэтгэн Үндэсний номын	Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 362 нийтийн номын сангийн 358 номын сангийн үйл	**100**	

ажиллагааг боловсронгуй болгох; 2.3.1. Аймгуудын номын сангийн тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийх,	сангийн вэб сайтад тавина.	ажиллагаанд 2018 оны 5 дугаар сарын 1-ний БСШУС-ын сайдын А/245 тоот тушаал "Маягт, маягт нөхөх заавар батлах тухай" Соёл урлагийн салбарын захиргааны маягт, түүнийг нөхөх заврын дагуу 44 үзүүлэлтээр тайланг авч, нэгтгэн дүгнэж www.nationallibrary.mn вэб сайтад байршуулав.		
2.3.2. Нийтийн номын сангуудын хүрээнд ажлын амжилт, шинэ, бүтээлч санаачлага нэвтрүүлсэн номын санг алдаршуулах, манлайллын тогтолцоог бий болгох зорилгоор "Ном цом" шагнал олгох,	Нийслэл, аймгуудын нийтийн номын сангуудын тайланг дүгнэж, Үндэсний номын сангийн Захирлын 2018 оны 2 дугаар сарын 02-ны А/07 тоот тушаалаар баталсан журмын дагуу шалгарсан номын санд "Үндэсний бичиг үсгийн баяр"-ын арга хэмжээн дээр Үндэсний номын сангийн нэрэмжит шагнал "Ном цом" гардуулна.	Аймаг, сумдын нийтийн 358 номын сангийн тайлан, судалгааг хүлээн авч, нэгтгэн дүгнэж Хөвсгөл аймгийн Нийтийн номын сан шалгарч "Ном цом-2018"-ын эзэн болов. Өмнөх жилүүдэд тайланг дүгнэхдээ зөвхөн аймгийн төв номын сангийн үйл ажиллагааны тайлан болон СУ судалгаанд дүгнэлт хийдэг байсан бол энэ жил аймгийн төв номын сан болон сумдын номын сангийн үйл ажиллагаа, аймгийн хэмжээний номын санг хэрхэн аргазүйн талаас нь удирдаж байгааг харгалзан дүгнэснээрээ онцлог боллоо.	**100**	
2.3.3. Орон нутгийн номын сангуудын үйл ажиллагаатай танилцаж, арга зүйн зөвлөгөө өгөх;	Баян-Өлгий, Баянхонгор, Завхан, Говьсүмбэр, Орхон, Сэлэнгэ аймгийн Зүүн хараагийн номын санд биечлэн очиж аргазүйн зөвлөгөө өгч ажиллана	Тайлангийн хугацаанд 4 аймаг, 3 сумын номын санд биечлэн очиж, аргазүйн зөвлөгөө өгөв. Үүнд: 1. Баян-Өлгийн аймгийн Төв номын сан болон Толбо сумын номын сан; 2. Баянхонгор аймгийн Төв номын сан; 3. Завхан аймгийн төв номын сан болон Цагаан-Чулуут, Алдархаан сумын номын сангийн ажил байдалтай танилцаж холбогдох аргачлал зөвлөгөө өгч ажиллаа. 4. Төв аймгийн номын санд ажиллан,	**100**	

		нийт сумдын номын санчдын дунд зохион байгуулсан ажил мэргэжлийн уралдааны шүүн ажиллаж, номын санч тус бүрийн анхан шатны бүртгэлүүдтэй нэгбүрчлэн танилцаж аргазүйн зөвлөгөө өгч ажиллав.		
2.3.4. Хотын болон төрөлжсөн номын сан, номын санчдад арга зүйн зөвлөгөө, зөвлөмжийг өгөх;	Хотын болон их дээд сургуулийн номын сан, зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлэх гэрээт байгууллагын албан хүсэлтийн дагуу биечлэн очиж, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгнө.	Тайлангийн хугацаанд нийт 9 номын сан, байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан, аргазүйн зөвлөгөө өгөв. - Сонгинохайрхан дүүргийн “Сонгино хайрхан Оюунлаг Ирээдүй” ТББ-ын номын сан; - ШШГЕГ-ын 429-р хорих ангийн шинэ номын сан; - Чингэлтэй дүүргийн “Иргэний номын сан”; - МУИС-ийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж Хятад номыг хэрхэн Кохад оруулж байгаа талаар туршлага солилцон зөвлөгөө өгөв. - “Олонлог” академийн номын сангийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж аргазүйн зөвлөгөө өглөө. - МУҮНС-ийн Дорно дахины сан хөмрөгийн хятад номыг каталогжуулах төслийн хүрээнд тус сан хөмрөгийн ажил байдалтай танилцан зөвлөгөө өгөв. - “Эрэл констракшн” компаний нэрэмж ит, “Эрэл” олон улсын дунд сургуулийн удирдлагуудад номын санг шинээр байгуулахад нь аргазүйн зөвлөгөөг тус тус	**95**	

		өгч ажиллав. - МУБИС-ийн 2 сэлбэн засагч, Орон нутгийн номын санч нарт сэлбэн засах талаар заавар зөвлөгөө өгч ажлын туршлага солилцов. /2019.04.22/ - Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Олонлог сургуулийн урилгаар 6-7 ангийн нийт 86 сурагч, багш нарт “Ном сэлбэн засах талаар” сургалт явуулав. -		
2.3.5. “Номын санч” сэтгүүлээр мэргэжлийн онол-аргазүйн мэдээллээр хангах;	“Номын санч” мэргэжил онол-аргазүйн сэтгүүлийн 2019 оны №1, 2-ыг бэлтгэн хэвлүүлэх, үнэ төлбөргүй нийтийн номын сангуудад түгээсэн байна.	“Номын санч” мэргэжил онол-аргазүйн сэтгүүлийн 2019 оны №1-2-ын эхийг бэлтгэн, тус тус 400-450 ширхэг хэвлүүлж, холбогдох номын санд хуваарийн дагуу түгээв /аргазүйчид/.	**100**	
2.3.6. Номын сан судлал, ном зүйн мэргэжил арга зүйн онлайн мэдээллийн сантай болох;	Арга зүйн сан хөмрөгийн мэргэжлийн ном, сэтгүүлийн картын санг “Zotero” програмд оруулах ажлыг үргэлжлүүлэн баяжуулна.	Номын сангийн Веб хуудас болон фэйсбүүк хуудсанд: - “Сүхбаатар аймгийн номын санчид номын сангийн үйл ажиллагаатай танилцлаа”, “Innovative technologies for the library of the Future”, “7 statements librarians should rethink in 2019”, “Ирээдүйн уншигчид болох 21-р сургуулийн 44 сурагчид номын сангийн үйл ажиллагаатай танилцлаа”, “Улсын хэмжээний нийтийн номын сангуудын 2018 оны үйл ажиллагааны тайлан, судалгаанд хийсэн үнэлэлт, дүгнэлт”, Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд “Номын сангийн үйл ажиллагааны тайлан боловсруулах аргазүйн зөвлөмж” сэдэвт сургалт боллоо” зэрэг 6 сэдвээр, Номын санч сэтгүүлийн 2010-	**92**	

		2015 оны хоорондох 16 дугаарыг цахим хэлбэрт оруулан байршуулж, Зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлэх журам, ангиллын зөвлөмж, “Халхын голын түүхэн ялалт 80” санамж өгөх номзүйн бүртгэл хэвлэгдэн гарлаа, Солонгосын Соёлын яамны International Cultural Exchange (KOFICE) сан нь хөгжиж буй орнуудад боловсролын салбарыг дэмжих төсөл, ReDI төслийн багийнхан номын санд зочиллоо, "Дэлхийн номын сангууд дахь Монгол сурвалж бичгийн өв" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал МУҮНС-д болж байна, Спортын бага наадам амжилттай болж өндөрлөлөө мэдээллийг бэлтгэн байршуулав /Аргазүйчид/. - Номын санд болж буй үйл ажиллагааг тухай бүрт нь мэдээлж байна. - “Мэдээллийн самбар”-т Шинэ номын мэдээ №1-12-ыг тухай бүр өнгөтөөр хэвлэн байршуулав. /Номзүйчид/		
2.4. Номын сангийн эрх зүйн баримт бичиг, дүрэм, журам боловсруулах; 2.4.1. Номын сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн баримт бичиг, дүрэм, журам боловсруулах, хэрэгжилтэнд хяналт тавих;	- “MNS 5742:2007 Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага” стандартад нэмэлт өөрчлөлт оруулсан төслийг Стандарт хэмжилт зүйн газарт шинэчлэн батлуулах тухай санал дэвшүүлнэ. - “ISO11799: 2015 Архив	СХГ-ын даргын 2019 оны 7 сарын 4-ний өдрийн С/30 дугаар тушаалаар “MNS 5742:2019 Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага” Үндэсний стандартаар шинэчлэн батлагдав /Д.Энхтунгалаг, ажлын хэсэг/. - “ISO11799: 2015 Архив номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлага” стандтартыг монгол хэлнээ орчуулсныг MNS ISO 11799:2007-гийн оронд Үндэсний	**100**	

	номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлага" стандтартын монгол орчуулгыг MNS ISO 11799:2007-гийн оронд MNS ISO болгон шинэчлэн батлуулах тухай Стандарт хэмжилт зүйн газарт санал оруулна. - "Номын сангийн үйл ажиллагааны тайланг боловсруулах зөвлөмж"	стандартаар шинэчлэн батлуулахаар СХГ-ын Баримт бичгийн ТХ-ны 2019 оны 6 сарын хурлаар хэлцүүлж дэмжигдэв. СХГ-ын даргын 2019 оны 7 сарын 4-ний өдрийн С/30 дугаар тушаалаар "MNS ISO11799: 2019 Архив номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлага" стандарт Үндэсний стандартаар шинэчлэн батлагдав /Д.Энхтунгалаг, ажлын хэсэг /. - "Номын сангийн үйл ажиллагааны тайлан боловсруулах зөвлөмж"-ийг боловсруулан БСШУСЯ-наас зохион байгуулсан орон нутгийн соёл урлагийн салбарын удирдах ажилтнуудын сургалтаар хэлэлцүүлэв /Арга зүйчид/.		
2.4.2. Номын сангийн тухай хуулийн 22.2, 24.3, 25.2 дэх хэсэгт заасан журам боловсруулж, соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд журмын төслийг санал болгох;	МУҮНС-гийн Мэргэжлийн зөвлөл Номын сангийн хуулийг үндэслэн дараах журмын төслийг хэлэлцэн, холбогдох номын сангуудаас санал авч, санал боловсруулна. Үүнд: - "Номын сангийн сан хөмрөгт байхгүй, түүх болон судалгаа шинжилгээний ач холбогдол бүхий ном судрыг нөхөн бүрдүүлэх	Тайлангийн хугацаанд нийт 2 стандартын төсөл, 1 журмын төсөл, 2 аргачлал, 2 зөвлөмж, 7 судалгаа хийж дүгнэн хэлэлцүүлснээс гадна шинэ барилгатай холбоотой судалгаа, төсөл, төсвүүдийг боловсруулсан болно. Үүнд: - "Номын сангийн сан хөмрөгт байхгүй, түүх болон судалгаа шинжилгээний ач холбогдол бүхий ном судрыг нөхөн бүрдүүлэх журам"-ын төслийн Ном бүрдүүлэх боловсруулах хэлтсээс боловсруулж, МУҮНС-гийн Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэн яамны мэргэжилтэн Б.Баяраад хянуулахаар бэлтгэн өгсөн.	**100**	

	журам”-ын төсөл - “Хувийн номын санд дэмжлэг үзүүлэх журам” –ын төсөл - “Улсын болон орон нутгийн номын сангийн нэмэлт үйлчилгээ үзүүлэх журам” –ын төсөл зэрэг.	- "Чухал ач холбогдол бүхий ганц хувь бүтээл хадгалж байгаа хувийн номын санд дэмжлэг үзүүлэх журам"-ын төслийг Уншлага үйлчилгээний хэлтсээс боловсруулж, Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Үндэсний номын сангий цахим хуудсанд 5 дугаар сарын 22-ны өдрөөс 6 сарын 22-ны өдрүүдэд байршуулан санал авсан ба 6 дугаар сарын 18-нд 21 аймгийн номын сангийн эрхлэгч, номын санчдад журмыг танилцуулж, 11 дүгээр сарын 19-ны өдөр БСШУСЯ-наас томилогдсон ажлын хэсэг ирсэн саналын дагуу дахин боловсруулаад байна. - Нийтийн номын сангийн нэмэлт үйлчилгээ үзүүлэх журамыг боловсруулах үүднээс үйлчилгээний хүрэлцээ хангамж, уншигч хэрэглэгчдийн сонирхлын судлагааг хийж, холбогдох дүрэм журмыг судалж байна.		
2.4.3. Үндэсний номын сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөх аргачлал, зөвлөмж, журам боловсруулах, хэрэгжилтийг хангах;	- “МУҮНС-ийн цахим хэлбэрт оруулсан материалыг үндсэн бүртгэлд авах аргачлал”-ыг боловсруулна. - “МУҮНС-ийн төлбөрт үйлчилгээний журам”-д анализ хийж боловсронгуй	- “МУҮНС-ийн цахим хэлбэрт оруулсан материалыг үндсэн бүртгэлд авах, мэдээллийн сангийн хадгалалт хамгаалалтын талаар холбогдох судалгаа хийж байна. - “МУҮНС-ийн төлбөрт үйлчилгээний журам”-д анализ хийж, хэрэгжилт, уншигчдын судалгаа, үйлчилгээний чанарын стандартын талаар судалгаа хийсэн. - Гадаад, дотоодын цахим	**85**	

	болгож, хэрэгжүүлэх - Гадаад, дотоодын цахим материалыг бүрдүүлэх, архивлах, үйлчлэх талаар ҮНС-ийн Мэргэжлийн зөвлөлд санал оруулж, хэлэлцүүлнэ.	материалыг бүрдүүлэх эрдэм шинжилгээ судалгааны сангуудыг уншигчдын хүртээл болгох, цахим материалын аюулгүй байдлыг судлан, үйлчлэх судалгаа хийгдсэн. Бусад: - 2011-2018 оны “Номын санч” сэтгүүлд нийтлэгдсэн нийт мэдээллүүдийн агуулгын харьцуулалт судалгаа; - “Монгол Улсын Үндэсний номын сангийн онцлог” /Шинэ барилга, Өргөтгөлийн тухай/; - “Улсын хэмжээний нийтийн номын сангуудын зөөврийн үйлчилгээ үзүүлсэн байдлын судалгаа”, - "Шинээр мөрдөгдөж байгаа СУ судалгаанд нэмэлт оруулах санал”, МУҮНС-ын СУ судалгааг програмд оруулав. - “Нийтийн номын сангуудын суудлын тоо, хөрөнгө оруулалтын судалгаа”; - “Нийтийн номын сангуудын барилга байгууламжтай холбоотой судалгаа”-г хийж, Соёл урлагийн газарт хүргүүлэв. - “Нийтийн номын сангуудын хүрэлцээ хангамж” судалгаа; - “Нийтийн номын сангуудын үйл ажиллагааг шинэ НС1-НС4 судалгааны асуулгын дагуу дэлгэрэнгүй судалгааг нийт 358 номын сангуудаас авч нэгтгэв. - “Дорно дахины сан хөмрөгийн хятад ном хэвлэлийг Коха программд оруулах, каталогжуулах ажлын		

		аргачлал"; - "Номын сангийн үйл ажиллагааны тайлан боловсруулах аргазүйн зөвлөмж"; - "Номын сангийн лавлагаа номзүйн ажлын зөвлөмж"; - Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08-д нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэл аргачлалд санал; - "Соёл урлагийн тогтвортой байдал, удирдах ажилтны сургалт"-ын номын сангийн хэлэлцүүлгийн протоколыг бичиж, "Нийтийн номын сангуудын зөөврийн номын сангийн тайлан"-г улирал, жилээр авч нэгтгэн БСШУСЯ-нд хүргүүлэв. - "ҮНС-ийн салбарын шинэ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулан, давхар бүрт байрлах өрөө, тасалгааны зохион байгуулалтын ба шаардлагатай тоног, төхөөрөмж, техник хангамжийн төсөв", "2020 оны төсвийн төсөлд шинэ барилгатай холбогдон гарах төсөв" боловсруулав. /Хэлтэс тус бүр/.		
2.5. Номын санчдыг чадавхижуулахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх, 2.5.1. Мэргэжил, аргазүйн холбоотой хурал, зөвлөгөөн, семинар сургалт зохион байгуулах; /4-5 удаа/	- "Номын сангуудын мэдээллийн бүтээгдэхүүн, үйлчилгээ" сургалт / МУҮНС-ийн номын санчдад/	Нийт 8 удаа 233 номын санчид семинар, сургалт зохион байгуулав. - "Номын сангуудын мэдээллийн бүтээгдэхүүн, үйлчилгээ" сургалтыг МУҮНС-гийн номын санчдад, орон нутгийн номын санчдад хийсэн. - "Нийтийн номын сангийн үйл ажиллагааны тайланг боловсруулах	**100**	

	- “Номын сангийн үйл ажиллагааны тайланг боловсруулах аргазүйн зөвлөмж”-ийг танилцуулах сургалт. /Нийтийн болон бусад холбогдох номын сангийнханд/ - Шинэчлэн батлагдсан MNS 5742:2019 стандартад орсон нэмэлт өөрчлөлтийн талаар сургалт /Нийтийн болон бусад холбогдох номын сангийнханд/. - Шинэчлэн батлагдсан “Архив номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлага ISO11799: 2015” ба номын сангийн холбогдолтой олон улсын стандартын талаар сургалт /Нийтийн болон бусад холбогдох номын сангийн номын санчдад/	аргазүйн зөвлөмж” сургалтыг МАЗЭШХ-ээс орон нутгийн болон нийслэлийн нийтийн номын сангийн 40 орчим мэргэжилтнүүдэд зохион байгууллаа. Уг сургалтыг фэйсбүүк хуудсаар шууд бичлэг хийж, улсын хэмжээнд цахим мэдээллийн сүлжээг ашиглан сонирхсон номын санчдыг хамруулаа. - Үндэсний номын сангаас зохион байгуулсан “Нийтийн номын сан арга зүйн төв болох нь” сэдэвт сургалтаар “Номын сангийн үйл ажиллагаатай холбоотой шинээр гарсан хууль эрх зүйн баримтууд”, MNS 5742:2019, ISO11799: 2015” стандартуудыг танилцуулсан. Бусад: - Монголын номын сангуудын консорциумаас зохион байгуулсан “Номын сангийн лавлагааны ажлын өнөөгийн байдал, лавлагааны сан бүрдүүлэх боломж” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэгт “МУҮНС-ийн номзүйн ажлын өнөөгийн байдал, чиг хандлага” сэдвээр танилцуулга бэлдэж хэлэлцүүлэв /Б.Цогжаргал/ - “Номын сангийн үйл ажиллагааны тайлан боловсруулах зөвлөмж”-ийг боловсруулан БСШУСЯ-наас		

		зохион байгуулсан орон нутгийн соёл урлагийн салбарын удирдах ажилтнуудын сургалтаар хэлэлцүүлэв /Г.Гүнжинлхам/. - “Чухал ач холбогдол бүхий ганц хувь бүтээл хадгалж байгаа хувийн номын санд дэмжлэг үзүүлэх журам”-ын төслийг БСШУСЯ-наас зохион байгуулсан орон нутгийн соёл урлагийн салбарын удирдах ажилтнуудын сургалтаар хэлэлцүүлэв /Г.Гүнжинлхам/. - Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газраас Дорноговь аймгийн ЗДТГ – тай хамтран “Соёл урлаг – Тогтвортой хөгжил” зөвлөгөөний хүрээнд “Номын сангийн үйлчилгээ чанар, хүртээмж” сэдвээр /Т.Баярлах/		
Гурав. “Номын сангийн мэдээллийн технологийн үйлчилгээг боловсронгуй болгох, шинэ технологи нэвтрүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ				
3.1. Мэдээлэл технологийн үйлчилгээг боловсронгуй болгох ажлын хүрээнд: 3.1.1. Цахим номын сангийн нэгдсэн сүлжээний төсөл, дижитал номын сангийн судалгаа хийх;	Үндэсний цахим номын сангийн нэгдсэн сүлжээ байгуулах төсөл боловсруулах, номын сангийн программ, автоматжуулалтын нөхцөл байдлын судалгаа, харьцуулсан шинжилгээ хийгдэнэ.	Номын сангийн программ, автоматжуулалтын нөхцөл байдлын судалгаа, харьцуулсан шинжилгээг Узбекстан, Белорусь зэрэг улсын Үндэсний номын сангийн цахим сүлжээг судлан, монголын номын сангуудын автоматжуулалтын өнөөгийн байдал, холбогдох төсөл, судалгааг гарган ЗГХА, СУГ-т мэдээлэл бэлтгэн өгсөн. Мэдээллийн технолгийн компани,	**88**	

		байгууллагуудтай уулзалт хийж, судалгаа, мэдээлэл авсан.		
3.1.2. Коха прогроммын хөгжүүлэлт, боловсронгуй болгох;	Номын сангийн системийн аюулгүй байдал сайжруулалт дээр анхаарч боловсронуй болгох, КОХА системийн код, мэдээллийн бааз, системийн тохиргоог сайжруулж ажиллана.	*Сервер системийн аюулгүй байдал, сайжруулалт хийх;* Нэг сервер дээр цахилгааны хэлбэлзлийн улмаас системд нь эвдрэл үүссэнийг BackUp файлаас дахин сэргээн ачааллаж хэвийн ажиллагаанд оруулав *Мэдээллийн баазын нөөцлөлт архивлалт хийх;* Системийн дахин сэргээх файлыг 8 удаа үүсгэснээс 1 удаа ашиглаж, Өгөгдлийн бааз архивлалт сард 2 удаа хийснээс дахин ашиглалт 3 удаа хийгдсэн. - *Коха ситемийн тасалдалгүй ажиллагааг хангах, систем тохиргоог судлах;* Дэд процедуруудын зогсолт саатал 18 үүссэнээс систем архиктетурын функцийн засварлалтыг 5 удаа хийж, захиалгын буруу оруулалт цуцлах болон үйлчүүлэгчийн картын программын засварыг нийт 7 удаа хийж гүйцэтгэв. - Цахим ном уншилтын программ нь Коха системд хандалт хийхгүй 6 цагаас удаан байхаар холболт нь автоматаар салгагддаг байсныг уртасган 10 цаг болгов. Гадаад сүлжээний холболтыг	**90**	

		тасалдалгүй байлгах; - Төлбөрийн нэхэмжлэх авах болон сүлжээний тасалдалтай холбоотой асуудал шийдвэрлэлт 14 удаа гарснаас 2 нь хурд хангалттай хүрэхгүй байгааг Юнивишн компанитай зөвшилцөн шөнийн горимын хурдыг 6MB.prs болгон нэмэгдүүлэв. Дотоод сүлжээнд гарах мэдээллийн урсгалын найдвартай байдлыг хангах; - Кабелийн толгой болон утас гэмтсэнээс мөн хэрэглэгчийн компьютер дээрх холболт салснаас үүдэн сүлжээний холболтын тасалдал 16 удаа гарсны 10 удаагийн тохиолдол нь сүлжээний дамжуулах холболтын төхөөрөмж буюу свич дэх гацалт, өгөгдлийн урсгалын алдагдал зэргээс үүдэн үүсгэсэн дамжин холболт болгон 2-оос дээш свич ашигласнаас шалтгаалснбг засварлав. Сүлжээ зохион байгуулалт болон асуудалд шуурхай арга хэмжээ авах; - Компьютерийн байршил солих болон өөр байрлалд 9 удаа кабел татаж, 6 удаагийн 4-өөс дээш компьютерийн дотоод сүлжээ үүсгэн холбох ажил хийгдэв. Үүнээс 3-т нь үндсэн холболтын шугамын кабель шинээр татаж оруулав. - Системийн бүрэн нөөцлөлт архивлалтыг хийв. - Монгол фондын захиалга оруулахыг түр хааж, системд код оруулж; Коха		

		системд шинээр ном оруулахад гацалт үүссэнийг Бүрдүүлэлтийн хэсэгт кодын зөрүү гарсныг системийг бүтэн дахин эхлүүлэн хэвийн болгон; - МУИС-ийн Номын сангийн Хятад хэл дээрх номын каталогжуулалтыг судлав. - Хятад номын төсөлд түр тавьж; нөөцөд бэлтгэсэн байсан Optiplex 745 загварын 2 PC-д программ суулган өгч, 16 порт свичийг сүлжээний холболт хийсэн. Вэб хуудасны Каталогийн хэсэг рүү гаднаас хандахгүй байсан нь цахилгаан тасалдсанаас гадагшаа хандалтын сервис Коха дээр зогссоныг хэвийн болгов. Цахим номын сангийн системд шинэчлэлт хийх судалгаа хийв.		
3.2. Түүх соёлын хөдлөх зүйлийн 2018-2019 оны улсын тооллогыг хийх; 3.2.1. Түүх соёлын хөдлөх зүйлийн тооллогыг журмын дагуу хугацаанд чанартай хийж, тайлагнах;	Түүх соёлын хөдлөх зүйлийн 2018-2019 оны улсын тооллогыг БСШУС-ын Сайдын 2018 оны 11 сарын 30-ны А/756 дугаар тушаалаар томилогдсон Монголын Үндэсний номын сангийн Үнэт ховор номын фондын дурсгалт зүйлд тооллого хийх салбар комисс холбогдох хууль тогтоомж, удирдамжийн дагуу тооллогын ажлыг зохион байгуулж, 516 дэсийн дурсгалт зүйлсийг тоолж, тайлан гаргана.	Түүх соёлын хөдлөх зүйлийн 2018-2019 оны улсын тооллогын Салбар комисс: - Улсын тооллогын бүртгэлийн санд 516 өвийг бүрэн тоолуулж; - Яаралтай сэргээн засварлах 9 өвийн жагсаалтыг гаргасан. - Улсын тооллогын тайланг гарган, шаардлагатай бүх мэдээллээр ханган ажилласан.	**100**	

3.2.2. Соёлын өвийн улсын бүртгэл мэдээллийн санд мэдээллээ баталгаажуулах;	RCH программын мэдээллийг хянаж, архивлах, СӨҮТ-д хүлээлгэн өгснөөр Үнэт ховор номын фондын үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэл, мэдээлэл шинэчлэгдэн баталгаажина.	Тооллогын дата баазыг хуулж архивласан нийт хэмжээ 90,5 GB урьдчилсан байдлаар СӨҮТ-д хүлээлгэн өгч; 516 өвийг фото зургаар баримтжуулж зургийг шинэ архив үүсгэн хадгалж; Тооллогыг хугацаанд нь чанартай хийж, тайлан, бүртгэлийн дэвтэр, тооллогын тэмдэг зэргийг журмын дагуу Түүх соёлын хөдлөх дурсгалын улсын тооллогын комисст өгч дүгнүүлсэн.	**100**	
3.3. Мэдээллийн цахим сан бүрдүүлэх,үйлчилгээг сайжруулах, 3.3.1. Гар бичмэл, барын ном судрын тоон мэдээллийн санг баяжуулж, эх хувийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах;	Монгол гар бичмэл ном судрын 58000 нүүр хуудас тоон хэлбэрт оруулах ажлыг хийж, хадгалалтын найдвартай орчныг бүрдүүлнэ.	Монгол судлалын фондоос 58500 хуудас монгол гар бичмэл, барын ном судар тоон хэлбэрт оруулахаас 775 боть номын 54436 хуудас скайнердан тоон хэлбэрт шилжүүлсэн. Нийт 99911 хуудас материал тоон хэлбэрт оруулав.	**95**	
3.3.2. Гар бичмэл барын ном судрыг цахимаар уншуулах;	Эрдэм шинжилгээний уншлагын танхимын уншигчдын захиалсан гар бичмэл болон барын ном судрыг тоон хэлбэрт оруулж, 600-700 боть гар бичмэлийг тоон хэлбэрт оруулан уншигч судлаачдад уншуулна.	Гар бичмэл болон барын ном захиалгын дагуу 699 боть гар бичмэлийг тоон хэлбэрт шилжүүлэн, уншуулж үйлчлэв. - Hard desk-нд хуулж боть тус бүрт номын нэрээр файл үүсгэж хадгалав. - Сканерт орсон гар бичмэл, төвд ном, судар, диссертацийн 937 фолдерийг 8 үзүүлэлтээр жагсаалт хийж, мөн Hard disk-нд хуулж боть тус бүрт номын нэрээр файл үүсгэж хадгалав.	**98**	
3.3.3. Хадгалагдаж буй сан хөмрөгөөс	Номын фондуудаас “Scan Robot 2.0 MDS” сканнераар	Монгол судлалын сан хөмрөгөөс 219 диссертацийн 45475 хуудас, албан	**96**	

сонголттойгоор тоон хэлбэрт шилжүүлж, Цахим санг бүрдүүлж, уншигчдад үйлчлэх;	хэвлэмэл ном, диссертац, тогтмол хэвлэлийг тоон хэлбэрт оруулна.	хэрэгцээний 35 хуудас нийт 56831 хуудас материал тоон хэлбэрт оруулав. Сканнердсан тогтмол хэвлэлийн цахим хувилбарын засвар хийгдэж байна.		
Дөрөв. “Лавлагаа- номзүйн үйлчилгээг боловсронгуй болгох, уншигчдад мэдээлэл-номзүйн үйлчилгээг үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ				
4. Ерөнхий, салбар номзүйг системтэй хөгжүүлэх, Үндэсний номзүйн бүртгэлийг бэлтгэх, лавлагаа номзүйн үйлчилгээг үзүүлэх,	Ерөнхий, салбар номзүйн бүртгэл бэлтгэн хэвлүүлэх	“Номын сангийн тухай хууль”-ийн 9.2-р зүйлийг хэрэгжүүлэх: Ерөнхий, салбар номзүйг системтэй хөгжүүлэх, Үндэсний номзүйн бүртгэлийг бэлтгэх, лавлагаа номзүйн үйлчилгээ үзүүлэх бие даасан 5 номзүйн бүртгэл, 2 санамж өгөх номзүйг бэлтгэх хэвлүүлснээс гадна Дархан-Уул, Ховд, Говь-Алтай аймгийн Төв номын сангаас бэлтгэн гаргасан орон нутгийн ба санамж өгөх номзүйг хянаж засварлан оролцов. - Халх голын байлдааны ялалтын 80 жилийн ойд зориулан “Халхын голын түүхэн ялалтын тухай бүртгэн мэдээлэх нь: Санамж өгөх номзүй” номзүйн бүртгэл - Ардын уран зохиолч, Төрийн шагналт Пунцагийн Бадарчийн мэндэлсний 80 жилийн ойд зориулан зохиол бүтээлээр нь “МУ-ын Ардын уран зохиолч Пунцагийн Бадарч: Санамж өгөх номзүй”-г бэлтгэн 400 ширхэг хэвлүүлж, аймаг сумдын номын сангуудад тарааж байна (3,2х/х)	**100**	
4.1. Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэл гаргах;	“Сонин, сэтгүүлийн өгүүллийн номзүй”-н бүртгэлийн I-IV ботийг бэлтгэснийг хянах,	“Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэл:1988-2007”-ийг 4 ботиор эрхлэн,	**100**	

	хэвлүүлэх; /1988-1992/ /1993-1997/, /1998-2002/, /2003-2007/	92" (42,3х/х) "Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэлийг хянаж хэвлүүлэв. Үүнд: 1. "Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэл:1988-1992" 2. "Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэл:1993-1997" 3. "Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэл:1998-2002" 4. "Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэл:2003-2007"		
4.2. Үндэсний бүртгэн мэдээлэх номзүйн бүтээл гаргах;	"Монгол улсын Үндэсний номын сангийн архивын бүртгэн мэдээлэх номзүй"-н VII боть/2016-2019/ бэлтгэх	"Монгол улсын Үндэсний номын сангийн архивын бүртгэн мэдээлэх номзүй: 2016-2019" VII ботийг бэлтгэн хэвлүүлэв. (42,3х/х)	**100**	
4.3. Улсын хэмжээний тогтмол хэвлэлийн нэгдсэн мэдээллийн санг нээлттэй хүртээмжтэй болгох;	"Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн сан"-д хамрагдсан гэрээт номын сангуудад хяналт тавьж, цаг тухайд нь мэдээллээ авч хадгалах, нэгдсэн санг 10000 орчим материалаар тогтмол баяжуулж, лавлагаа мэдээллийг хүргэнэ.	"Үндэсний тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн сан"-г бий болгох зорилгоор аймгуудад хуваарилсан тогтмол хэвлэлүүдийн Зотеро программд оруулсан бичилтийг хүлээн авч, нэгтгэж байна. 2019 онд нийт **10896** материалаар тогтмол баяжуулав. Үүнд: - МУ-ын Үндэсний номын сангаас "Өдрийн сонин"-ы 2017-2019, "Үндэсний шуудан" сонины 2019, "Өнөөдөр" сонины 2019 он 7371 өгүүлэл. - Өнөөгийн Баянхонгор сонин 2008-2019 он /650ш бичлэг/ - Дорнод аймгийн "Талын анир" сэтгүүл /13 бичлэг/, "Дөл" /700 бичлэг/, "Дорнод" /302 бичлэг/ сонин. - Төв аймгийн "Төв таймс" 2018-2019 он /820 бичлэг/.	**100**	

		- МУБИС "Монголын үнэн" сонин 2019 оны 3,4-р улирал /498ш бичлэг/ - МУБИС "Өрхийн үйлдвэрлэл" сэтгүүл 2019 оны 3-р улирал /126ш бичлэг/ - Сэлэнгэ аймгийн "Сэлэнгийн мэдээ" сонин 2019-р оны 1-3-р улирал /96ш бичлэг/ - Эрдэнэт аймгийн "Өнөөгийн Эрдэнэт" сонин 2011-2013 он /210ш бичлэг/ - Ховд их сургууль "Биеийн тамир, спортын онол, арга зүй" сэтгүүл 2018 он /163ш бичлэг/ - СУИС, Монголын соёл урлаг судлал сэтгүүл 2017 он /52ш бичлэг/ - Ач анагаах ухааны их сургууль "Монголын анагаах ухаан" 2019 он, "Нүүр ам судлал" 2014, 2016, 2017 он /69ш бичлэг/ - Өвөрхангай аймаг "Улирал ба зохиолч" 2019 он 2-р улирал / 36ш бичлэг/ Аймаг орон нутгийн тогтмол хэвлэлийн нийт 3525 бичлэг.		
4.4. Шинээр ирсэн ном, хэвлэлийг уншигчдад сурталчлах;	"Шинэ номын мэдээ" товхимлыг сар бүр бэлтгэн, хянаж хэлтсүүд, харьяа байгууллага, номын сангийн уншигч, хувь хүмүүст цахим шуудангийн хаягаар нь илгээн, сурталчилна. /Сард 1 удаа №1-12/;	- "Шинэ номын мэдээ" товхимлын №1-12-ыг бэлтгэн хэлтсүүд, харьяа байгууллага, номын сангийн уншигч, хувь хүмүүст сар бүр и-мэйл хаягаар нь 146 хүнд хүргэж мэдээлэв. - "Шинэ номын мэдээ"-г хэвлэмэл хэлбэрээр Эрдэм шинжилгээний танхим, Нийтийн уншлагын танхим, Тогтмол хэвлэлийн уншлагын танхим, каталог болон үүдний	**100**	

		мэдээллийн самбарт, номын сангийн вэб хуудсанд электрон хэлбэрээр тус тус байршуулж сурталчлав.		
4.5. Төрөлжсөн картын санг баяжуулах;	Тогтмол хэвлэлийн өгүүллийн төрөлжсөн цахим картын санг “Үндэсний шуудан”- 2019 он, “Өнөөдөр”- 2018-2019 он, “Өдрийн сонин” 2017-2019 оны дугааруудаас баяжуулна.	1. Номзүйчид тогтмол хэвлэлийн өгүүллийн төрөлжсөн цахим картын санг 7371 өгүүллээр цаг тухайд нь тогтмол баяжуулан үйлчлэв. Үүнд: - Zotero программд “Өдрийн сонин”-ы 2019 оны бүх дугаарыг шүүж 650 өгүүллийн номзүйн мэдээ - “Үндэсний шуудан” сонины 2019 оны бүх дугаарыг шүүж 1641 өгүүллийн номзүйн мэдээ; - “Өнөөдөр” сонины 2019 оны бүх дугаарыг шүүж 1783 өгүүллийн номзүйн мэдээ - “Өдрийн сонин”-ы 2017 оны 1-7 дугаар сарын 1095 өгүүлэл, 2018 оны 1 дүгээр сарын дугаарыг шүүж 223 өгүүллийн номзүйн мэдээ - “Өдрийн сонин”-ы 2018 оны 1-9 дүгээр сарын 1979 өгүүллийн номзүйн мэдээ	**98**	
4.6. Уншигч, хэрэглэгчдийн аман болон бичгийн лавлагааг номзүйн лавлагааны аппарат ашиглан өгч үйлчлэх;	Уншигч, хэрэглэгчдээс ирсэн аман лавлагаа”-г нийт 200 хүнд номзүйн лавлагааны аппарат ашиглан, биечлэн болон утсаар лавлагаа өгч үйлчилсэн байна. Сэдэвчилсэн бичгийн лавлагааг 15-20 удаа бэлтгэж өгнө.	- “Уншигч, хэрэглэгчдээс хүссэн аман лавлагаа”-г нийт 254 хүнд номзүйн лавлагааны аппарат ашиглан өгч үйлчилсэн байна. Мөн өдөр тутам утсаар лавлагаа өгөв - Албан байгууллага болон хувь хүмүүсийн хүссэн бичгийн лавлагаа 18 удаа бэлтгэн өгөв.	**100**	
4.7. Виртуаль лавлагаанд	Номын сангийн вэб сайтаар	Виртуаль лавлагааны албаар 156	**96**	

хариулт өгөх, хяналт тавих;	дамжуулан виртуаль лавлагааны албаар 100 гаруй хэрэглэгчдэд лавлагаа өгч, өгөгдсөн лавлагааны бүртгэлд судалгаа хийгдэнэ.	хэрэглэгчид лавлагаа өгч үйлчлэн, өгөгдсөн лавлагаанд хяналт тавьж ажиллав.		
4.8. Түүхэн ойд зориулсан сэдэвчилсэн номзүйн бүртгэлийг уншигч, судлаачдын хүртээл болгох;	“Халх голын түүхт ялалтын 80 жилийн ой”-д зориулсан номзүйн бүртгэл эмхэтгэн, хэвлүүлсэн байна.	Халх голын байлдааны ялалтын 80 жилийн ойд зориулан “Халхын голын түүхэн ялалтын тухай бүртгэн мэдээлэх нь: Санамж өгөх номзүй” номзүйн бүртгэлийг бэлтгэн, БСШУСЯ-ны санхүүжилтээр 800 ширхэг хэвлүүлж, хуваарийн дагуу тарааж байна (11х/х)	**100**	
Тав. “Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр”-ийн зорилтыг захиргааны аргаар хэрэгжүүлэхэд чиглэсэн ажил, үйлчилгээ				
Хосгүй, үнэт ховор, гар бичмэл ном судрыг судлах, сурталчлах; 5.1. ЮНЕСКО-гийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн Үндэсний хорооны ажил үүргийн хүрээнд бүртгэгдсэн өвийг судлах, сурталчлах;	- “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн Үндэсний комиссын ажлын төлөвлөгөө гаргаж салбар хуралдаанаар хэлэлцүүлж, үйл ажиллагааг сурталчлах, - “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн “Дэлхийн өв”-д нэр дэвшүүлсэн “Үйсэн дээр бичсэн Хууль цаазын бичиг” номын нэмэлт болон холбогдох мэдээллийг бэлтгэнэ.	- “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн ажлын төлөвлөгөөг гаргаж салбар хуралдаанаар хэлэлцүүлэн, Үндэсний комиссын ажлыг сурталчлах ажилд зориулж www.nationglheritage.mn бүртгэлийн программд шинэчлэл хийв. - Дэлхийн дурсамж хөтөлбөрт бүртгүүлэхээр "Үйсэн ном"-ын тодорхойлолтыг хийв. - Үндэсний баримтат өвийн нэгдсэн мэдээллийн санд үнэт болон хосгүй үнэт өвүүдийг бүртгэж сурталчилснаас гадна хот, орон нутгийн номын санчдад зориулсан сургалтын хөтөлбөрт тухай бүр хамрагдан оролцов.	**95**	

5.2. Үндэсний баримтат өвийг судлах, сурталчлах; 5.2.1. Сан хөмрөгүүдэд буй үндэсний баримтат өвийг судлах, сурталчилах,	МУҮНС-гийн үнэт ховор номын “Эрдэнэсийн сан” цуврал-II цомогийг бэлтгэн хэвлүүлэх,	- Донторын бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэхээр 200 донтор скайнердан, бичвэрийг нь хуулж, галиглан бичээд байна. Үүнээс “Эрдэнэсийн сан-II” цувралд 80 донторыг сонгон хэлэлцүүлэхээр бэлдээд байна. - Үндэсний номын сангийн сан хөмрөгт 2 сурвалж /Монгол бичмэл Ганжуурын 1 боть, Үйсэн номын цуглуулга/ -ийг худалдан авах саналыг ЗГХА, СУГ-т илгээн, сан хөмрөгт худалдан авах гэрээ хийх, ажлын хэсэг хүлээн авах ажиллагааг зохион байгуулж байна.	**96**	
5.2.2. Үнэт ховор номын олон нийтэд сурталчлах ажлыг өргөжүүлэх;	Хосгүй үнэт өв, дэлхийн болон бүс нутгийн өвүүдийн нэгдсэн танилцуулга бэлтгэн сурталчилсан байна.	- Монгол шуудан ХК-д хосгүй үнэт өвүүдээр блок марк хийлгэх саналаа өгч хосгүй үнэт 6 өвийн тодорхойлолтыг хийж, албан бичгийн хамт явуулав. - Үнэт ховор номын үзэсгэлэнгийн танилцуулга дахин хэвлэж, сонирхогч, зочид төлөөлөгчдөд өгч, сурталчилсан.	**100**	
5.2.3. “Музейн боловсрол” аяны хүрээнд өсвөр үе, оюутан залуучуудад бичиг, үсгийн дурсгал, ном хэвлэл, баримтат өвийг сурталчлах;	Үнэт ховор ном судар болон үндэсний баримтат өвийг сурталчлах ажлыг Үндэсний бичиг үсгийн баяр, Номын баяр зэрэг арга хэмжээний үеэр, хүүхэд багачуудад үнэ төлбөргүйгээр, гадаад дотоодын зочид, олон нийт, оюутануудад үзүүлж 1000 гаруй хүнд сурталчилна.	- Үндэсний бичиг үсгийн баяр 2019 арга хэмжээний хүрээнд Үнэт ховор номын музейн танилцуулгыг дахин хэвлүүлсэн. - "Торго даавуун дээр бичигдсэн өвүүд: Номын донторын үзэсгэлэн”, “Их Монгол Улсын соёлын өв, нагиад соёл иргэншлийн ул мөр” үзэсгэлэн, ""Монголын эзэнт гүрний их хаадын захидлууд болон овгийн тамгууд" бие	**100**	

		даасан үзэсгэлэн, "Дэлхийн номын сангууд дахь сурвалж бичгийн өв" ОУЭШХ-д зориулсан үзэсгэлэн, "Монголын төрт ёсон ба бичиг соёлын өв" зэрэг үзэсгэлэн зохион байгуулсан. - Үнэт ховор номын музей болон бусад түүхэн тэмдэглэлт өдөрт зориулсан үзэсгэлэнг нийт 3000-аад байгууллага, хамт олон, хувь хүн, хүүхэд багачуудад танилцуулан сурталчилж, 2019 онд 1.247.000 төгрөгийн орлого оруулав. - Дэлхийн ном ба зохиогчийн эрхийг хамгаалах өдөр, Үндэсний бичиг үсгийн баяр, Соёл урлагийн салбарын байгууллагуудын нээлттэй хаалганы өдөр, БСШУС-ын яамны "Нээлттэй өдөрлөг" зэрэг арга хэмжээнүүдэд үнэ төлбөргүй сурталчилсан.		
5.3. Улсын хэмжээний соёлын баримтат өвийн мэдээллийн санг баяжуулах; 5.3.1.Үндэсний баримтат өвийн бүртгэл мэдээллийн сан /www.nationalheritage.mn/-д шинээр орон нутгаас оруулсан бүртгэгдсэн өвүүдийг мэдээллийн санд бүртгэх, судалгаа хийх;	ЗГХА, Соёл урлагийн газартай хамтран Үндэсний баримтат өвийн бүртгэл мэдээллийн сан /www.nationalheritage.mn/-д шинээр орон нутгаас оруулсан бүртгэгдсэн өвүүдийн мэдээллийн баазад нэмэлт мэдээллийг оруулах, архивлах, хяналт тавих, судалгаа хийж, олон нийтэд сурталчилна.	- Үндэсний баримтат өвийн бүртгэл мэдээллийн сан /www.nationalheritage.mn/-д бүртгэгдсэн өвүүдийн мэдээллийн баазад нэмэлт мэдээллийг оруулах, архивлах, хяналт тавих, судалгаа хийж, олон нийтэд сурталчилж байна. - Үндэсний комиссын ажлыг сурталчлах ажилд зориулж www.nationgIheritage.mn бүртгэлийн программд шинэчлэл хийв.	**96**	
5.3.2. Соёлын баримтат өвийн төрөл зүйлийн судалгаа хийх, сурталчлах;	Номын донторын мэдээллийн сан үүсгэх, тайлбар судалгааг хийж, үзэсгэлэн гаргаж сурталчилна.	- Донторын бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэхээр 200 донтор скайнердаж, бичвэрийг нь хуулж, галиглан бичээд байна.	**100**	

5.4. Хосгүй үнэт, ховор, гар бичмэл ном судрын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, сурталчлах, 5.4.1. Соёлын баримтат өвийг хадгалалт хамгаалалтыг сайжруулах;	Үнэт ховор номын музейн тохижилт, үзмэрийн шинээр хийлгэсэн шилэн хоргонд үзмэр дэглэлтийг зохион байгуулж, баримтат өвийг эрсдэлээс хамгаална.	- ЗГХА, Соёл урлагийн газраас Соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор ҮНС-гийн Үнэт ховор номын музейн шаардлага хангахгүй болсон үзмэрийн хорго шинэчлэх ажлын санхүүжилтээр , босоо 8 тавиур, хэвтээ 2 шилэн хорго хийлгэж, үзмэрийн дэглэлт, хадгалалт хамгаалалтыг сайжруулсан. - ЗГХА, Соёл урлагийн газар "Үндсний номын сангийн сан хөмөгт хадгалагдаж буй даавуун өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах" төсөл бичиж, нийт 13,200,000 төгрөгийн гэрээ байгуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулж, даавуун болон хуйлмал баримтат өвийн хадгалалтыг сайжруулж 5 шүүгээ бүхий 6 ш тавиур, урт форматтай цаасан хайрцаг, савтай өвийн 1 тавиур, цаасан крафт хоолой буюу сав 100 ш, мөн сэргээн засварлах зориулалтын муутуу цаас /60 ширхэгтэй/ 100 боодол авч даавуун, дэлгэмэл, хуйлмал өвийн хадгалалтыг сайжрууллаа.	**100**	
5.4.2. Гар бичмэл, барын ном судын эх хувийн бүрэн бүтэн байдлыг сайжруулж, сэргээн засварлах;	Гар бичмэл, барын ном судраас 400 нүүр сэргээн засварлаж, технологийн картжуулалт хөтлөх, хадгалалт хамгааллатыг сайжруулах,	- “Нэгэн сургаал Итгэлтийн хөтөлбөр”, “Сургаал үлгэр”, “Дөрвөн зүйлийн үсэг хавсарсан толь бичиг”, “Жанжаа хутагтын зохиосон Төвд монгол дохионы бичиг” “Чойжид дагины тууж” зэрэг 5 номын 366 хуудсыг сэргээн засварлав. - Сэргээн засварласан номонд	**9089**	

		технологийн картжуулалт хөтөлж, тохирох хайрцаг, дугтуй хийж хүлээлгэн өгөв. - 576 хуудас бүхий гар бичмэл дэвтэрчилсэн номыг цахим сан бүрдүүлэгчээс хүлээн авч засварлан, бүртгэл хөтөлж хүлээлгэн өгөв.		
Зургаа. “Хүний нөөцийн хөгжил, төлөвшлийг хангах" үндсэн зорилт, “Хүний нөөцийн удирдлагыг боловсронгуй болгож, чадварлаг бүтээлч хамт олон бүрдүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ				
6.1.1. Байгууллагын дотоод хяналт, үнэлгээг сайжруулах, хүний нөөцийн хангамж, ашиглалтыг боловсронгуй болгох;	Байгууллагын дотоод хяналтын комиссын төлөвлөгөөний дагуу ажлын байрны тодорхойлолт, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт хийж, хяналт тавьж ажиллана.	Байгууллагын дотоод хяналтын комисс нь Ажлын байрны шинжилгээг хийх ажлын хэсэг байгуулан, удирдамж, төлөвлөгөөг боловсруулж Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолын дагуу ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Байгууллагын хууль, эрх зүйн акт, нийт 65 ажилтны Ажлын байрны тодорхойлолтод дүн шинжилгээ хийж, асуулгын аргаар мэдээлэл цуглуулан, Албан тушаалын тодорхойлолт бүрт хяналтын хуудас бичиж, тайлан гаргаж, АТТ-ыг шинэчилсэн.	**89**	
6.1.2. Хүний нөөцийн судалгаа гаргах;	Холбогдох газруудад хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгаа болон бусад холбогдох судалгааг тогтоосон хугацаанд явуулж, зохих арга хэмжээ авна.	- Монгол улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 128 дугаар зарлигийн хүрээнд баталсан "Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-ний тайлан, Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн улирал бүр тайланг батлагдсан маягтын	**100**	

		дагуу гаргаж харьяалах төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн. - Төрийн албаны зөвлөлөөс Төрийн албан хаагчийн анкет өөрчилсөнтэй холбогдуулан ажилчдын Төрийн албан хаагчийн анкет, хувь хүний намтарыг шинээр авч, ажилчдын хувийн хэргийг баяжуулсан. - Шинээр ажилд орсон болон ажлын байр нь өөрчлөгдсөн ажилчдийн хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтыг тухай бүр нь шинэчлэн батлуулсан. - Монгол улсын Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн албан бичгийн дагуу 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших мэдээллийг Хүний нөөцийн системд /www.hr.csc.gov.mn/ шинэчлэн бүртгэсэн ба шинээр ажилд орсон буюу ажлаас чөлөөлөгдсөн ажиллагсад, шилжилт хөдөлгөөн хийсэн ажилтнуудын мэдээллийг шинэчлэн оруулсан. - Засгийн газрын хэрэг эрхлэх газар Соёл Урлагын газарт СУ маягтыг батлагдсан загварын дагуу гаргаж хүргүүлсэн. - Байгууллагаас 2020 онд тэтгэвэрт гарах ажилчдын судалгааг гаргаж, БСШУСЯамны		

		холбогдох мэргэжилтэнд өгсөн.		
6.1.3. Төрийн албанд сахилга хариуцлагыг чангатгах тухай гарсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах;	Төрийн албанд сахилга хариуцлагыг чангатгах тухай гарсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах хүрээнд Үндэсний номын сангийн Захирлын 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/78 тоот тушаалаар батлагдсан “Сахилга хариуцлагыг сайжруулах жил”-ийн ажлыг 2019 онд үргэлжлүүлж, зөрчилгүй хамт олон болно.	- “Сахилга хариуцлагыг сайжруулах жил”-ийн ажлыг 2019 онд үргэлжлүүлж, хийх ажлын төлөвлөгөө гарган, ажилтнуудын цаг ашиглалт, байгууллагын Дотоод журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, ажилтнууд болон харилцагчид, уншигчдын өргөдөл гомдлыг шийдвэрлэн ажиллаж байна. Иргэд, үйлчлүүлэгчдээс ил тод байршуулсан 2 саналын хайрцаг, цахим хуудас /http://nationallibrary.mn/mn/complaint.html/, суурин утсаар санал, хүсэлт авч байна. - Тайлангийн хугацаанд ажилтнуудаас ирсэн 46 өргөдөл, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.	**100**	
6.1.4. Нийгмийн хариуцлагын хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх нөхцлөөр хангах;	Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй 5 ажилтнуудын мэдлэг боловсролоо дээшлүүлэх, эмнэлэгийн үйлчилгээнд хамтрагдах боломжийг бүрдүүлж ажиллана.	- Ерөнхийлөгчийн 2018 оны 128 дугаар зарлигийн дагуу “Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г тус тус батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн төслийг хүргүүлсэн. - Хөгжлийн бэрхшээлтэй 5 ажилтнуудын мэдлэг боловсролоо дээшлүүлэх, эмнэлэгийн	**100**	

		үйлчилгээнд хамтрагдах боломжийг бүрдүүлж ажиллаж байна. - Сэлбэн засагч Б.Энхтөрийн БНСУ-д оношлуулах, эмчлүүлэх хүсэлтийг хүлээн авч, 2 сарын хугацаатай чөлөө олгосон.		
6.2. Архивын тухай хууль болон албан хэрэг хөтлөлтийн дүрэм журмыг хэрэгжүүлэх. 6.2.1. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг бүрдүүлэх;	Албан хэрэг хөтлөлтөд тавигдах шаардлагыг хангаж, байгууллагын баримт бичгийн архивыг эмхэлж, бүрдүүлсэн байна. Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх	- Үндэсний номын сангийн захирал Төсвийн тухай хуулийн 16.5.3 дахь хэсэг дэх батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох; 16.5.5.дахь хэсэгт заасан батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах заалтыг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд захирал болон захиргааны зөвлөлийн удирдах албан тушаалтан болох 5 хэлтсийн дарга байгууллагын үйл ажиллагаандаа Монгол улсын Архивын тухай хууль, Төрийн албан ёсны хэлний тухай хууль, Баримт бичгийн цуврал стандарт, албан хэрэг хөтлөлтийн менежментийн олон улсын стандарт, холбогдох бусад эрх зүйн акт болон Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын албан хэрэг хөтлөлт, дүрэм, журам, албан бичиг, улирал, жилийн тайлангуудыг боловсруулж, төлөвлөгөө, хуваарийн дагуу архивт өгч ажилладаг. - Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх	**95** **95**	

		Байгууллагын комисс нь улсын үзлэг зохион байгуулах төв комиссын даргын баталсан "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг"-ийн дүгнэх үзүүлэлт, аргачлалын дагуу төлөвлөгөө боловсруулж, үзүүлэлт бүрээр өөрийн үнэлгээ өгч, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, БСШУСЯ-ны Ажлын хэсэгт тайлан мэдээ, архив, албан хэрэг хөтлөлтийн байдлыг танилцуулсан. - Зочид төлөөлөгч хүлээн авах журмыг боловсруулан захирлын тушаалаар батлуулсан.		
6.2.2. Номын сангийн архивын баримтуудыг шилжүүлэх;	Архивын ерөнхий газарт шилжүүлэх шаардлагатай номын сангийн архивын баримтуудаас зохих журмын дагуу шилжүүлнэ.	- Архивын өмнөх онуудын түр, байнга, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжүүдийг эмхлэн цэгцэлсэн. - Монгол Улсын Үндэсний номын сангийн архивын материалуудыг скайнердаж, товьёог шивж “Архивын баримтын эмхтгэл”-ын эхийг бэлсэн. 2019 оны 3 сард Архивын ерөнхий газраас нэмэлтээр номын санд холбогдох баримтуудыг цахим хэлбэрээр хүлээн авч эх бэлтгэл хийсэн. - МУҮНС-ийн 1931-1991, 1992-2016 оны байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжүүдийг бүртгэлийн дагуу тулган цэгцэлж, архивын хадгаламжийн сангийн тавиурт заагчуудыг хийж байрлуулсан.	**100**	

		- МУҮНС-ийн 1931-2011 оны архивын баримт бичиг болох 446 байнгын хадгаламжийн нэгжүүдийг Архивын ерөнхий газрын Үндэсний төв архивын 612 дугаар хөмрөгт нөхөн бүрдүүлэлтээр хүлээлгэн өгсөн.		
6.3. Соёлын салбарын хүний нөөцийн хөтөлбөр /2019-2023/ -ийн хүрээнд хэрэгжүүлэх: 6.3.1. Номын санчид, ажилтан албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх, мэдлэг чадварыг сайжруулах;	Номын сангийн ажилтнуудын мэдлэг чадвараа дээшлүүлэхэд анхаарч, номын сангийн мэргэжлээр гүнзгийрэн суралцах боломжийг бүрдүүлж, БСШУСЯ, ЗГХА СУГ-ын болон Соёлын сургууль, МНСК, Хэвлэлийн хүрээлэн зэрэг байгууллагын сургалт, арга хэмжээнд 30-аас дээш номын санчийг хамруулна.	- МУИС-ийн номын сангаас зохион байгуулсан "Үнэт ховор ном, гар бичмэл үзэсгэлэн семинар"-т "МУҮНС-д хадгалагдаж буй баримтат өв, Үндэсний бүртгэл мэдээллийн сан" сэдвээр 35 соёлын ажилтанд; /оролцсон 2 арга зүйч/ - БСШУСЯ-наас зохион байгуулсан "Соёл урлагийн байгууллага тогтвортой хөгжил - удирдахуйн шинэлэг хандлага" сэдэвт 2 удаагийн сургалтанд -3 хүн - МНСК-аас сар бүрийн сургалт, "LIbrarya update 2019", "Манлайлагчдын замналаас суралцахуй" зэрэг арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 25 номын санчдыг хамруулсан. - ЗГХА, СУГ-аас зохион байгуулсан Соёлын өвийн сэргээн засварлалх, хадгалалт хамгаалалтын талаар зохион байгуулсан 2 удаагийн лекц, семинарт 10 ажилтанг хамруулсан. - Дэлхийн номын өдөрт зориулсан Монголын хүүхдийн зохиолч, уран бүтээлч, ном бүтээгчдийн өдөрлөгт 2 хүн оролцов. /Улаанбаатар дахь Оросын Шинжлэх Ухаан, Соёлын төв РЦНК-д 2019.04.22-23.	**100**	

		- Дээд боловсролын салбарын цахим нэгдсэн номын сангийн төсөл”- сургалт - 3 зохион байгуулж, санал асуулгын судалгааны 24 хүний хариултыг дүгнэж дүн мэдээг гаргаж тайланг бичив. - “Үндэсний бичиг үсэг-судалгаа, сургалт, хэрэглээ” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд оролцов. /2019.05.07 төв номын сан /3 хүн оролцов/ - Олон улсын мэдэх эрхийн өдрийг тохиолдуулан ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комиссоос зохион байгуулсан "Мэдээлэл авах эрх" сургалтанд номын сан мэдээллийн аижлтан Ц.Мөнх хамрагдсан /2019.09.05-06/ - СУИС, СУСХ-ээс зохион байгуулсан "Соёлын үйлчилгээний хүртээмж" ЭШБХ-д /2019.10.02/ - “Баримтат өвийн хадгалалт хамгаалалт, түүний хүртээмж” сэдэвт сургалт /2019. 11 сарын 18-19 өдөрт / - "Тэргүүн сайд, түшээ засаг, хошой чин ван Гадинбалын Чагдаржав-150 жил" ЭШ-ний хуралд -2 /2019.11.29/ - "Соёл, урлагийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлэлт, нэмэгдүүлэх арга зам" сэдэвт сургалтад -2 Нийт давхардсан тоогоор 76 мэргэжилтнийг хамруулсан.		
6.3.2. Номын санчид, ажилчдын мэдлэг чадвар,	Ажилтан албан хаагчдын дунд боловсон хүчний	Нийт 8 сургалт, лекц, семинар: 1. "Байгууллагын соёл" /Удирдлагын	**100**	

нийгмийн идэвхи, хувь хүний хөгжлийг дэмжих;	чадавхийг дээшлүүлж сургалт, лекц, семинарын хөтөлбөрийг шинэчлэн улиралд 1-2 удаа жилдээ зохион байгуулна.	академийн багш Доктор профессор Д.Ганбаатар/ 2. "Суралцагч байгууллага болох нь /Хүний нөөцийн мэргэжилтэн Х.Отгобаяр, Маркетингийн менежер Г.Гүнжинлхам/ 3. "Хувь хүний хөгжил, ажлын байран дахь эерэг хандлага, цахилгаан соронзон долгионы нөлөө" /НЭМ, Хүний хөгжлийн институтын сургагч багш Алтансэлэм/ 4. "Шинэ зууны өнгө төрх" /Хүний нөөцийн мэргэжилтэн Х.Отгобаяр, Маркетингийн менежер Г.Гүнжинлхам/ 5. "Цагийн менежмент" /Хүний нөөцийн мэргэжилтэн Х.Отгобаяр/ 6. "Бүтээмж дээшлүүлэх 5S" /Хүний нөөцийн мэргэжилтэн Х.Отгобаяр/ 7. "Хорт хавдраас урьдчилан сэргийлэх нь" /АУ-ны Докторант, Клиникийн профессор, Тэргүүлэх зэрэгтэй эмч Г.Саранцэцэг/ 8. “Эерэг хандлага-Харах өнцөг” /Гэр бүл, сэтгэл судлалын ухааны доктор, сэтгэлзүйч Г.Наранбаатар/ "Хандлагаа өөрчилж- Хамтдаа хөгжье" аяныг 10 дугаар сарын 10-наас 12 дугаар сарын 10-ны хооронд 2 сарын хугацаатай зохион байгуулсан. Энэ аяны хүрээнд: - Байгууллагын соёлын талаар 62 ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авсан. - "Хувь хүний хөгжил байгууллагын хөгжилд нөлөөлөх нь" эссэ		

		бичлэгийн уралдаан - Эерэг хандлагатай хэлтэс, удирдлага, ажилтан"-ыг, шалгаруулсан. - Уншигчдын сэтгэл ханамжийн судалгаа /2016-2018/ - "Шилдэг уншигч", "Хамгийн их уншигдсан судалгааны бүтээл" зэргийг шалгаруулан уншигчдыг өргөмжлөл, номын сангийн дурсгалын зүйлээр урамшуулав.		
6.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтыг сайжруулах. 6.4.1. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хангах,	Ажлын байранд мөрдөх Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулан мөрдүүлж, хяналт тавина.	- Ажлын байранд мөрдөх Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулан мөрдүүлж, хяналт тавьж, шинээр орсон ажилтнуудад зааварчилгааг өгч ажилласан. - Ажлын орчин нөхцөл, ажлын байрны стандарт, сан хөмрөгийн дулаан, чийгшилтийг тогтмол хэмжилт хийж, хяналт тавьж ажилладаг.	**95**	
6.4.2. Ажилтануудын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах арга хэмжээ	ХАБЭА-н мэргэжилтэн холбогдох эрх зүйн баримт бичиг, зааварчилгааг сурталчилсан самбар гарган ажилтнуудад 1-2 удаа сургалт, зааварчилгаа зохион байгуулна.	- ХАБЭА-н мэргэжилтэн холбогдох эрх зүйн баримт бичиг, зааварчилгааг судалж, ажилтнуудад сурталчилж, зааварчилгаа өгч ажиллаж байна. - Сан хөмрөгийн хэлтсийн ажилтнууд, гэрээт ажилтнуудад 2 удаа зөвлөмж, зааварчилгаа өгсөн. - “Гоо ертөнц” клубтэй хамтран “Эрүүл Монгол хөтөлбөр” хэрэгжүүлж, хөтөлбөрийн хүрээнд “Эрүүлээр галбиржуулах” урамшуулалт аяныг ачаалал ихтэй,	**95**	

		хөдөлгөөн багатай, жингээ зохицуулах, зөв галбиржихийг хүссэн ажилтан, албан хаагчдад зориулан байгууллага дээрээ 80%-ийн хөнгөлөлттэй доорхи сэдвээр практик сургалт, дасгалуудыг явуулж байна. Үүнд: - Хоолоор эрүүлжихүй - Хөдөлгөөнөөр эрүүлжихүй - Сэтгэлээр эрүүлжихүй Вэлнэс бүжиг, фитнесс галбиржуулах, эрүүл зохистой хоол, нүүрний иога гэсэн 4 төрлийн үндсэн сургалтыг зохион байгуулж байна.		
6.5. Гамшиг, гэнэтийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор ажилтнуудад аюулгүй ажиллагааны сургалт зөвлөгөө, мэдээлэл өгөх;	Холбогдох хууль, хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам, төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг ханган ажиллана. Гамшиг, гэнэтийн болзошгүй аюул, галын аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх сургалтанд ОБЕГ-ын сургалтын төв дээр 45 хүнийг хамруулна.	- Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө, Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө, Гамшиг ослын үед нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө болон Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг шинэчилж, бүтэц зохион байгуулалт, ажил үүргийн хуваарь, зарлан мэдээлэх, мэдээлэл дамжуулах бүдүүвчийг батлуулсан. - Гамшгаас урьдчилан сэргийлэх, байгууллагын галын аюулгүй байдлыг хангах чиглэлээр Галын аюулгүй байдлыг хангах комисс болон галын байцаагч Н.Ганбаатар нийт ажилтан, албан хаагчдын дунд СБД-ийн ОБХ-тэй хамтарч “Гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх” сургалт явуулж, галын аюулгүй байдлын тухай хуулийн заалтууд, гал	**100**	

		түймрийн өнөөгийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх, гал гарсан үеийн анхан шатны мэдлэг олгох, галын багаж хэрэгсэлийг ашиглах талаар ойлголтуудыг өгсөн. - Галын гарцын таних тэмдгүүдийг зохих байршлуудад нэмж байрлуулсан. - ОБЕГ-ын сургалтын төв дээр нийт 46 ажилтныг дадлага, сургуулилтанд хамруулсан.		
Долоо. “Мэргэжлийн хүрээнд гадаад дотоодын байгууллагуудтай стратегийн түншлэл байгуулж, харилцан ашигтай ажиллах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ				
7. Гадаад, дотоод хамтын ажиллагааг харилцан ашигтай өргөжүүлэх; 7.1.1 Олон улсын номын сангийн холбоо, Үндэсний номын сангуудтай хамтран ажиллах;	Олон улсын номын сангийн холбоо /IFLA/, ОХУ, БНХАУ, БНСУ, Тайвань, Белорусь зэрэг улсын Үндэсний номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудтай байгуулсан гэрээ, санамж бичгийн хүрээнд дагуу хамтран ажиллана.	Олон улс, гадаадын номын сан, байгууллагуудтай хамтын аижллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд: - IFLA болон CDNLAO (Зүүн Өмнөд Ази Номхон далайн орнуудын номын сангийн холбоо)-нд МҮҮНС-н 2018 оны жилийн тайланг тус бүр бичиж илгээсэн. - IFLA -н байнгын хорооны гишүүдийн сонгуульд оролцох Захирлын сонгуулийн хуудсыг боловсруулж илгээсэн. - Тогтмол хэвлэлийн ISSN ОУ-ын дугаар Монгол улс дахь ЮНЕСКО-ийн төлөөлөгчийн газар мөн Гадаад хэргийн сайдын ЮНЕСКО-ийнн Ерөнхий захиралд хаягласан захидлын тайлбарыг бичиж илгээсэн. - АНУ-ын Конгрессын номын сантай ном солилцооны ажлыг эхлүүлсэн. /2019 оны 5-р сар/	**100**	

		- Германы ЭСЯ-нд хандан албан захидал хүргүүлснээр Бонны Их сургуульд "Хар бухын балгасын үйсэн дээрх бичиг" 2 ширхэг номыг илгээсэн. - БНЭУ-ын Элчин сайд Сингх хамтын ажиллагааг эхлүүлэн, 50 ширхэг ном хандивласан ба дижиталчлах ажил болон номын санчдыг сургах талаар дэмжинэ гэдгээ илэрхийлсэн. - Монгол улсад суугаа АНУ, ОХУ, Казахстан, Унгар, БНХАУ, Белорусь зэрэг улсын Элчин сайдын яамдуудтай зохион байгуулсан үйл ажиллагаа, арга хэмжээнд хамтран ажиллалаа.		
7.1.2. Монгол судлал, бичиг үсэг, баримтат өвийн судалгаа, сурталчилгаа хийх;	Гадаад орны соёл, шинжлэх ухааны байгууллагууд, номын сантай хамтран соёлын хамтын ажиллагааны хүрээнд хурал, Соёлын баримтат өвийг сурталчилсан үзэсгэлэн зохион байгуулах ажлын хүрээнд Тайванийн Үндэсний номын сантай хамтран 9 сард Дөрвөлжин үсгийн 750 жилийн ойд зориулсан үзэсгэлэн зохион байгуулна.	- Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байрны үзэсгэлэнгийн танхимд Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн санаачлагаар нээгдсэн "Mongolian Heritage - Mongolian script" монгол бичгээр хэвлэгдсэн орчин үеийн номын үзэсгэлэнг 5 дугаар сарын 15-20 -ны өдрүүдэд зохион байгуулж, Үндэсний Номын Сангийн бэлтгэл, солилцоогоор болон хувь хүмүүсээс цуглуулсан монгол бичгийн номуудыг НҮБ- ын гишүүн орнуудын элчин сайд нар, зочид, төлөөлөгчдөд сурталчиллаа. - "Дэлхийн номын сангууд дахь сурвалж бичгийн өв" хурлыг МУИС-ийн номын сан, МУИС-ын Монгол судлалын хүрээлэнтэй хамтран 8 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд	**100**	

		оролцсонзохион байгуулсан ба хуралд гадаадын 22 эрдэмтэн, нийт 32 илтгэгч оролцлоо. - БНХАУ-ын Тайванийн Үндэсний номын сантай хамтран Пагба ламын зохиосон Дөрвөлжин үсэг зохиогдсоны 750 жилийн ойд зориулсан "Их Монгол Улсын соёлын өв, Нангиад иргэншлийн ул мөр" үзэсгэлэнг 9 дүгээр сарын 09-нөөс 11 дүгээр сарын 09-ний өдрүүдэд 2 сарын турш амжилттай зохион байгуулсан. Үзэсгэлэнд дэглэн үзүүлсэн Монголын түүхийн тулгар бичгүүд болох "Монголын нууц товчоо", "Богд баатар биеэр дайлсан түүх", "Хар татаарын түүхэн тэмдэглэл", Саган сэцэний "Эрдэнийн товч" зэрэг 27 нэрийн 44 боть ном, дөрвөлжин үсгээр бичигдсэн 31 пайлуур хөшөөний дардас, 8 их хаадын хөргийн хуулбаруудаар МУҮНС-гийн сан хөмрөгийг баяжуулж байгаа нь монголын түүх, соёлын судалгаанд нэн чухал хэрэглэгдэхүүн болох юм. - Тайванийн Үндэсний номын сангийн захирал Цэн Шүшэний урилгаар 2019 оны 12 сарын 16-20-ны өдрүүдэд Тайванийн Үндэсний номын санд айлчлан, "МУҮНС-гийн танилцуулга, сурвалж бичгийн судалгаа" илтгэл тавьж, Хархорин хотын ойн хүрээнд мөн дээрхтэй адил монголын түүх, соёлын судалгааны эх сурвалжийн хуулбарыг сан хөмрөгтөө авах		

		хамтран ажиллах талаар санал солилцох ажлыг хийнэ. - Богд хааны ордон музейтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулан, 8-р Богдын сурвалж, төрөл үеийн хийгээд төр, шашны үйл хэргийн талаарх судалгааны сурвалжийн мэдээлэл, жагсаалт, судалгааг хамтран хийсэн. - Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албатай гэрээ байгуулан хамтран ажиллаж, ийн Богд хааны мэндэлсний 150 жилийн ойд зориулан "ДЭЭРХИЙН УГ ЭХ ОРШИВОЙ. МОНГОЛЫН БОГДУУД" есөн боть бүтээлийг эрхлэн хэвлэснийг эрдэмтэн судлаачиддаа 7 дугаар сарын 8-ны өдөр өргөн барив. - "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн хүрээнд ШШГЕГ-ын харьяа нээлттэй хаалттай хорих 407-р ангид зохион байгуулсан "Эх үрийн нандин хайр" өдөрлөгт хүмүүжигч ээжүүдийг ар гэрийхэнтэй нь, хүүхдүүдтэй нь уулзуулдаг сайн дурын арга хэмжээнд Монгол Улсын Үндэсний номын сангийн хамт олноос 30 нэр төрлийн ном хандивлаж, хүүхдүүдэд үлгэрийн номоор бэлэг барилаа.		
7.1.3. Номын санчдыг гадаадад мэргэжил дээшлүүлэх болон туршлага судлах, олон улсын хурал, зөвлөгөөнд оролцох боломжийг	Олон улсын номын сангуудын холбоо, харилцаат номын сантай хамтран номын санчдын мэдлэг, мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах чиглэлээр 2-3 мэргэжилтэн	- IFLA болон CDNLAO (Зүүн Өмнөд Ази Номхон далайн орнуудын номын сангийн холбоо)-ны улирал бүрийн мэдээлэл, тайланг хүлээн авч, Мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд илгээж байна.	**100**	

судлах;	хамруулах хүсэлтийг илгээсэн байна. Гадаад харилцааны мэргэжилтэнг Сингапур улсад зохион байгуулсан Ази номхон далайн орнуудын номын сангийн захирлуудын хуралд оролцуулна.	- БНСУ-ын Үндэсний номын сангийн CPI хөтөлбөрийн сургалтанд 1 арга зүйчийн анкет, шаардлагатай материал, баримт бичгийг илгээсэн. - Грек улсын нийслэл Афин хотноо зохион байгуулагдах IFLA-н 85 дугаар удаагийн чуулганд 2019 оны 8 сарын 24-ны өдрөөс 30 хүртэл оролцохоор МУҮНС-н захирал Б. Ичинхорлоогийн нэрийг мэдүүлсэн. - Гадаад харилцааны мэргэжилтэн Б.Нямдорж 2 сарын 21 –нд Сингапур хотноо болсон “Silk Road” олон улсын номын сангуудын холбоо, Зүүн өмнөд ази, Номхон далайн орны номын сангийн захирлуудын чуулганд оролцсон - БНХАУ-ын Чанчунг хотод зохион байгуулсан Мэдлэгийн инновацийн үйлчилгээний салбарын хөгжил, дижитал хэвлэл, дижитал номын сангийн нэгдсэн хөгжлийн олон улсын хурал (CDPDL)-д 2 хүн оролцсон. /8 дугаар сарын 7-12-ны өдөр/ - Олон Улсын Монгол судлалын холбооны Азийн 3-р хурал Солонгосын Үндэсний музейд 2019 оны 11 дүгээр сарын 8-наас 11-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, Монгол судлал сайн хөгжсөн дэлхийн 10 гаруй орны 69 судлаач 6 салбар илтгэл хэлэлцүүлсэн. Уг хуралд захирал Б.Ичинхорлоо "Монголын Үндэсний Номын Сангийн сан хөмрөг" илтгэлийг танилцуулаа. - Хятад Монголын судлал, соёлын		

		хамтын ажиллагаа, орчуулгын нийгэмлэг /CCTSS/-ээс 2019 оны 10-р сарын 29-ний өдөр Бээжин хотноо зохион байгуулсан “Монголын хятад судлал болон Хятад Монголын сонгодог бүтээлийг харилцан орчуулах нь” сэдэвт форум захирал Б.Ичинхорлоо урилгаар оролцсон. - Төвөд номыг дижиталчлах төслийн ахлах Б.Сайнбилэг 2019 оны 11 сарын 4-өөс 8-ны хооронд Солонгос улсын Гуанжу хотод болсон ЮНЕСКО-ийн Ази, Латин Америк, Карибын орнуудын нэгдсэн уулзалтанданд оролцсон. Цахим өвийг хэрхэн хадгалах хамгаалах шаардлагатай талаар туршлага судалсан. - ӨМӨЗО-ны Хөлөн буйр аймгийн Хайлаар, Манжуур хотын номын сангуудтай танилцах, хамтын ажиллагаа эхлүүлэх зорилгоор БСШУСЯ-ны мэргэжилтэн Б.Баяраа, МУИС-ийн номын сангийн захирал Г.Цэрэн, УБХТНС-ийн захирал Д.Индра, Дорнод аймгийн ТНС-ийн Ж.Цагаан, Б.Майцэцэг нарын төлөөлөлтэй хамт МУҮНС-гийн захирал Б.Ичинхорлоо, Т.Баярлах, Э.Энхзул нар 4 номын сантай танилцаж, туршлага судалж, хамтын ажиллагааны уулзалтууд хийлээ		
7.1.4. Төвөд ном судрыг каталогт оруулах, дижиталчлах төслийг	Төвөд ном судрыг каталогт оруулах, дижиталчлах АНУ-ын Олон улсын байгууллага	ACIP-ийн төсөл 10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. 1. Ердийн каталогич 2 хүн (Normalized	**100**	

хэрэгжүүлэх;	ACIP /Asian Classics Input Project/ -тай Хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд 14000 гарчиг номыг каталогт бүртгэн оруулж, дижиталчлах каталогич нар 10500 боть судар бүртгэн. 400000 орчим хуудас цахим хэлбэрт оруулж, BDRC вебсайтад болон 2-р улирлаас өөрийн вебсайтад туршилтын байдлаар холбож байршуулан, судлаачдын хүртээл болгоно.	cataloger) 2. ACIP-ийн каталогич 3 хүн (ACIP cataloger) 3. Сканнерын ажилтан 4 хүн (Scanning technician) 4. Ахлах 1 хүн (Senior operator) 2019 онд ердийн каталогич нар 2494 судар багцаар (баринтаг) оруулсан. ACIP-ийн каталогичид нийт 14950 гарчиг бүртгэлд оруулаад байна. Түүнээс 1058 багц судрын 313720 хуудас цахим хэлбэрт орсон бөгөөд 602 багц судар 910 багц судар зургийн боловсруулалтанд орж бүрэн дууссан бөгөөд BDRC вебсайтад байршаад байна. Цахим хэлбэрт орсон судрууд шинэ баринтаг донтортойгоор фондод буцаан байрлуулсан ба бүртгэлийн систем болон архивлан хадгалах үйл ажиллагааг хянаж аюулгүй байдлыг хангаж ажилласан. Төслийн мэдээлэл, бүртгэсэн болон цахим номын мэдээлэл (http://nlm.asianclassics.org/en) цонх МУҮНС-ийн цахим хуудсанд байршсан. 2018 оноос эхлэн хэрэгжсэн ACIP-ийн төслийн анхны үр дүн болох 2 ширхэг 8 ТВ хардрайвыг МУҮНС-д хүлээлгэн өгч, архивлуулсан.		

7.2. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай ном хэвлэл, үндэсний соёл уламжлалыг сурталчлах ажлыг хамтран зохион байгуулах;	Хамтын ажиллагаа өргөжиж, ном хэвлэлийг сурталчлах олон төрлийн ажлыг хамтран зохион байгуулна. Авто тээврийн үндэсний төв, “Номын гэгээ” багтай хамтран орон нутгийн үйлчилгээний автобусанд 1-2 чиглэлд зөөврийн номын сангийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. ."JCI капитал" ТББ-тай хамтран "Түүхээ хадгалъя" төслийн хүрээнд “Номын элч” төслийг хэрэгжүүлж, гадаад оронд хэвлэгдсэн монгол судлалын болон ховор номыг гадаад амьдардаг монголчууд болон эрдэмтэн судлаачдын идэвх, санаачлагыг өрнүүлэн хандив, дэмжлэгээр бүрдүүлнэ.	Авто тээврийн үндэсний төв, “Номын гэгээ” багтай хамтран орон нутгийн үйлчилгээний автобусанд Өвөрхангай, Баян-Өлгий, Дорнод, Хөвсгөл, Увс, Завхан зэрэг аймгийн 6 чиглэлд 16 автобусанд 35-40 ширхэг номоор зөөврийн номын сангийн үйлчилгээг үзүүлж, нийтдээ 22060 хүнд үйлчилсэн байна. . "JCI капитал" ТББ-тай хамтран "Түүхээ хадгалъя" төслийн хүрээнд “Номын элч” төслийг хэрэгжүүлэх хүрээнд ГХЯ болон Ахмад Дипломтчдын клуб, Хилийн чанад дахь монголчуудын зөвлөл зэрэг байгууллагууд дэмжин гадаад оронд хэвлэгдсэн монгол судлалын болон ховор номыг бүрдүүлэх ажил хийгдэж байна. Судлаач, доктор Ш.Баатар Үндэсний номын санд ном хандивлах НОМЫН ЭЛЧ аянд хамрагдаж, өнгөрсөн зун нутагт амрахдаа хоёр хайрцаг буюу 140 ширхэг ном хандивласан. Одоо дөрвөн хайрцаг буюу 284 ширхэг ном явуулахад бэлэн боллоо. Эдгээр номын ихэнх нь өнгөрсөн 10 гаруй жил уншиж цуглуулсан дэлхийн соёл иргэншил, угсаатны зүй, түүх газарзүй, мөн манай мөнхийн хоёр хөршийн тухай номууд болно. Тээвэрлэх асуудлыг ."JCI капитал" ТББ хариуцан, Бид Монгол ачаа тээврийн компани дэмжин ажиллаж байна. • Монголын Бурхан Шашинтны Төв	**96**	

		Гандантэгчэнлин хийдийн тэргүүн их хамба лам, гавж Д. Чойжамцын хүсэлтээр БСШУСЯ-ны 2019 оны 04-р сарын 18 өдрийн 7/3133 тоот албан бичгийн дагуу Соёл Урлагийн Бодлогын Газрын даргын үүрэг гүйцэтгэгч Б. Сэргэлэнгийн зөвшөөрлөөр 8 нэрийн 9 эх бичвэрийн хуулбарыг өгөх Гэрээг боловсруулан байгуулж хамтран ажиллав. /2019.04. 25/ • Монголын Үндэсний номын сангийн хүсэлтээр БСШУСЯ-ны 2019 оны 04-р сарын 18 өдрийн 7/3134 тоот албан бичгийн дагуу Соёл Урлагийн Бодлогын Газрын даргын үүрэг гүйцэтгэгч Б. Сэргэлэнгийн зөвшөөрлөөр Богд Жавзандамба хутагтын бүтээлийн эмхэтгэл 1 боть судрыг эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах зорилгоор түүвэрлэн орчуулж хэвлүүлэхэд номын хэвлүүлэх зардлыг гаргасан Монголын Бурхан Шашны Данбадаржайлин Хийдийн Эрдэм соёлын хүрээлэнгийн эрхлэгч С. Баасандоржтой гэрээ хийж хамтарч ажиллав. /2019.04.29/ • “Непко” хэвлэлийн газрын “Түүхэн эрхэмүүдийн цадиг” бүтээлийн цувралд оруулж хэвлэн нийтлэх “ Автономит Монголын засгийн газрын бичиг” “ Автономит засгийг устгах цагийн бичгүүдийн хуулбар” нэртэй 2		

		Гар бичмэл номын хуулбарыг авах гэрээг боловсруулан байгуулж хамтран ажиллав. • Монголын Бурхан Шашинтны Төв Гандантэгчэнлин хийдийн хурлын лам Б. Жамьянсанжаагийн хүсэлтээр БСШУСЯ-ны 2019 оны 01-р сарын 25 ны өдрийн 7/ 658 тоот албан бичгийн дагуу Соёл, Урлагийн Бодлогын Газрын даргын үүрэг гүйцэтгэгч Б. Сэргэлэнгийн зөвшөөрлөөр 3 эх бичвэрийн хуулбарыг өгөх Гэрээг боловсруулан байгуулж хамтран ажиллав. /2019.11.30/ • БСШУС-ын сайдын 2019.10.31 өдрийн 1а/9558 тоот албан зөвшөөрөл, Номын сангийн захирлын үүрэг болгосны дагуу “Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт эрдэнэс” каталоги хэвлүүлэхэд оруулах 25 номын хуулбарыг гэрэл зургаар авах гэрээг боловсруулан байгуулж хамтран ажиллав. /2019.12.04/		
Найм. “Төсөв санхүү, бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ				
8.1. Төсвийг оновчтой хуваарилах, санхүүгийн тайлан мэдээ, бүртгэлийг сайжруулах;	Төсвийг үр ашигтай зөв зарцуулснаар НББ-ийн стандарт, Шилэн дансны хууль хэрэгжинэ. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, НББ-ийн стандарт, “Шилэн данс”- ны	- Нягтлан бодох бүртгэлийн стандарт, заавар журмын дагуу санхүүгийн тайлан тооцоог хугацаанд нь гаргаж, шилэн дансыг тогтмол мэдээллээр хангаж байна. - Ажиллагсадын Нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог даатгалын дэвтэрүүдэд нь бичиж, Сүхбаатар	**99**	

	хуулийн заалтуудыг мөрдөж, тайлан мэдээг хугацаанд нь гаргана.	дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэстэй тооцоо нийлж, баталгаажуулж байна. - 2018 оны Санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитыг Эс Жи Эм Ди аудитын компаниар хийлгэж, стандарт дүгнэлт авсан.		
8.2. Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглаж, хадгалалт хамгаалалтыг сайжруулах;	Үндсэн хөрөнгийн тооллого, бүртгэл тооцоо хугацаандаа хийгдсэн байна. Эд хөрөнгийн бүртгэл, тооллогыг жилд 2 удаа хийж, ашиглалтанд хяналт тавин элэгдэл хорогдол ихтэй хөрөнгийг актлуулна.	- Тус байгууллагад ажиллагсдын албан тушаалын өөрчлөлтэй уялдуулан, эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг шинэчлэн хөтөлж,хөрөнгийг тухайн эд хариуцагчийн картын бүртгэлээс хасаж, шилжүүлсэн хүний нэр дээр бүртгэл хөтөлж 2 хувь хэвлэн, хүн тус бүрийн гарын үсгээр баталгаажуулж 1 хувийг нь олгосон.	**99**	
Есөн. "Номын сангийн орчин нөхцлийг сайжруулах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ				
9.1. Номын сангийн орчин нөхцөл, үйлчилгээний тав тухтай орчин бий болгох;	- Номын сангийн шинэ барилгын ажлын явцад хяналт тавьж ажиллана.	- "Дэлхийн ном ба зохиогчийн эрхийг хамгаалах өдөр" МУ-ын Ерөнхий сайд, БСШУС-ын сайд, Нийслэлийн Засаг дарга болон Засгийн газрын зарим гишүүд, яамны төлөөлөлд байгууллагын үйл ажиллагаа, шинэ номын сангийн барилгын ажлыг танилцуулав. - 2020 оны төсвийн төсөлд шинэ барилгын нэмэлт зардал, тавилга, тоног төхөөрөөмж, тохижилтын хөрөнгө оруулалтын төсвийг	**100**	

	- Номын сангийн барилгын засварын ажлыг шаардлагатай газруудад хэсэгчилж хийнэ. - Байгууллагын дулаан, сантехник, цахилгааны аюулгүй ажиллагааг хангаж, хэсэгчилсэн засвар үйлчилгээг тогтмол хийнэ.	гаргасан. - МУ-ын ЗГ-ын үйл ажиллагаа, бүтээн байгуулалтыг олон нийтэд сурталчлах нээлттэй өдөрлөгийн хүрээнд шинээр баригдаж байгаа барилга болон одоогийн барилгын танилцуулга хийсэн. /2019.09.16-27/ - "Соёлын шинэчлэлийг дэмжье" СУ-ын байгууллагуудын барилгын асуудлаар хийсэн Хэвлэлийн бага хуралд танилцуулга бэлтгэж оролцсон ба хэвлэл мэдээллийн болон холбогдох гадаад, дотоодын мэргэжилтэн, албан тушаалтнуудад мэдээллийг өгсөн. - ЗГ-ын тогтоолын дагуу Үндэсний номын сангийн барилгыг шинэчлэн барих зураг төсөл хий ажлын хүрээнд зургийн даалгаврыг боловсруулан өгсөн ба "Барилга байгууламж" ХХК-тай зураг төслийн шинэчлэлийн судалгааг хамтран хийсэн. - Номын сангийн барилгын засварын ажлыг шаардлагатай 12 танхим, газруудад хэсэгчилж хийсэн. - Ээлжийн слесариуд дулаан халаалтад байнга хяналт тавьж тохируулга хийх болон усны даралт, температурын талаар тогтмол тэмдэглэл хөтлөн хүлээлцэж, подваль, ариун цэврийн өрөөнүүдийн шаардлагатай засвар үйлчилгээг хийж байна.		

9.2. Камерын системийг тогтвортой ажиллуулах, хяналтыг сайжруулах;	Камерын системийг тогтвортой ажиллуулахад анхаарч, сан хөмрөгийн болон үйл ажиллагаа, үйлчилгээний хяналт тогтмол хийгдэнэ.	Байгууллагын аюулгүй байдал, хадгалалт хамгаалалт, хяналтын системийн тогвортой ажиллагааг хангахад: - Аюулгүй ажиллагааны заавар, дүрэм журмын дагуу ажиллах; Холболтын кабель, утсыг цэгцлэх, далдлах ажлыг 4 байршилд гүйцэтгэв. Цахилгаан дахин холбогдсоны дараа серверийн өрөөн дахь хөргөлтийн төхөөрөмж дахь темпратурын тохиргоог 19 удаа дахин тааруулав. Хяналтын систем, камерын тогтвортой ажиллагаа, гэмтэл саатлыг шийдвэрлэх; - Камерын тэжээлийн блок солих, тохиргоо хийх болон дахин ачаалалтыг нийт 13 удаа хийснээс 7 удаа бичлэг сэргээн гаргаж үзүүлэв.	**90**	
Арав.“Ажилтнуудын нийгмийн асуудалд анхаарч, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ				
10.1. Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг хангах;	Төрийн үйлчилгээний албан хаагчдын нийгмийн баталгаа, ажилтнуудын нийгмийн асуудалд бодит тусламж, дэмжлэгүүдийг үзүүлсэн байна. - Ажиллагсдад зохих журмын дагуу нийгмийн халамж үйлчилгээг үзүүлнэ.	2019 онд дотоод журмын дагуу 18 хүнд 3,109,704 төгрөг буцалтгүй тусламж үзүүлсэн.	**100**	
10.2. Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах;	Нийт ажилтнуудыг 100% эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна. /10-12-р	- 4-р сард Элэгний В, С вирусын шинжилгээнд хамрагдаагүй ажилчдыг шинжилгээнд хамрагдах	**100**	

	сард/	ажлыг зохион байгуулсан. Тус шинжилгээнд 38 ажилтан хамрагдсан. - Ажилтан албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах гэрээг Улаанбаатар Сонгдо эмнэлэгтэй байгуулж, нийт 84 ажилтанд тус бүр 120,000 төгрөгөөр тооцож, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах эрхийн бичиг олгож, нийт 10,080,000 төгрөг зарцуулсан.		
10.3. Ахмад номын санч, ажилтнуудад нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэх;	Байгууллагаас тэтгэвэрт гарсан ахмадуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлнэ. /жилд 1 удаа/	- Байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадууд болон нийт ажилчдын сар шинийн баярын золголтыг зохион байгуулсан. Золголтын арга хэмжээнд нийт 36 өндөр настанг хамруулж, хүндэтгэл үзүүлэв.	**100**	
10.4. Ажиллагсдад зохих журмын дагуу урамшуулал, бусад нэмэгдлийг олгох;	Ажиллагсдын гаргасан амжилт, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр санаачиллагыг дэмжин, хөдөлмөрийн бүтээмж дээшлүүлэх зорилгоор зохих журмын дагуу урамшуулна.	Ажиллагсдын гаргасан амжилт, санаачлагыг дэмжин мөнгөн урамшуулал 11 хүнд 1,557.304. төгрөг, үр дүнгийн урамшуулал 78 ажилтанд 45,541.970 төгрөг олгосон байна.	**100**	
Б.ТУСГАЙ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ				
1. Хадгалагдаж буй сан хөмрөгөөс сонголттойгоор тоон хэлбэрт шилжүүлж, Цахим санг бүрдүүлж, уншигчдад үйлчлэх,	Номын фондуудаас “Scan Robot 2.0 MDS” сканнераар хэвлэмэл ном, диссертац, тогтмол хэвлэлийг тоон хэлбэрт оруулна.	Цахим сан бүрдүүлэгчийн ажлын байранд 1 ажилтан нэмж ажиллуулж сан хөмрөгийн ном, хэвлэлийг цахимд шилжүүлэх, үйлчлэхэд анхаарч ажиллалаа.		

		- Монгол судлалын сан хөмрөгөөс 219 диссертацийн 45475 хуудас, албан хэрэгцээний 35 хуудас нийт 56831 хуудас материал тоон хэлбэрт оруулав. Сканнердсан тогтмол хэвлэлийн цахим хувилбарын засвар хийгдэж байна. - Шинээр 16 CD дэх диссертацийг архивт хуулав. /Монгол гар бичмэл болон төвөд ном судрыг тоон хэлбэрт /цахим/ оруулах ажлууд тус тусын төлөвлөгөөний дагуу хийгдсэн/		
2. Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэл гаргах,	“Сонин,сэтгүүлийн өгүүллийн номзүй”-н бүртгэлийн I-IV ботийг бэлтгэснийг хянах, хэвлүүлэх; /1988-1992/ /1993-1997/, /1998-2002/, /2003-2007/	“Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэл:1988-2007”-ийг 4 ботиор эрхлэн, 92” (42,3х/х) “Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэлийг хянаж хэвлүүлэв. Үүнд: 1. “Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэл:1988-1992" 2. “Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэл:1993-1997” 3. “Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэл:1998-2002” 4. “Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэл:2003-2007”		
Арван нэг. Төрийн байгууллагын удирдах ажилтны манлайллын зорилтын хэрэгжилт /ҮДГэрээн 1.3.-т тусгагдсан 3 зорилт/				
1. Хууль тогтоомжийг мөрдөж, үйлчлүүлэгчийг дээдлэх				

1) Байгууллагын үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Хөдөлмөрийн тухай хуулийг чанд мөрдөх; 2) Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль зэрэг эрх зүйн болон бусад дүрэм, журам баримт бичгийг сайтар судлан эзэмших; 3) Төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүргээ гүйцэтгэж, үйлчлүүлэгчдийн нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх;	1) Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 21.1.2, 48.3.2 заалт мөн Төрийн албаны тухай хуулийн 5, 7 дугаар зүйл, 54.1 дэх хэсгийг хэрэгжүүлж ажиллана. (Жилийн турш) 2) Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын хууль, яамнаас баталсан шийдвэр, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг мэргэшлийн түвшинд сайтар судлан боловсруулж, хэрэгжүүлнэ. (Жилийн турш) 3) Төрийн үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ. (Жилийн турш)	1) Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, шинээр батлагдсан Төрийн албаны тухай хуулийн 2019, 2020 оноос хэрэгжиж буй журмын хэрэгжлтийг ханган ажиллаж Төрийн албан хаагчийн анкет, хувийн хэргийн бүрдлийг шинээр бүрдүүлэх, АТТ-ыг боловсруулж, шинэчилсэн. 2) Монгол Улсын Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах хууль, Номын сангийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль зэрэг хууль эрх зүйн баримт бичиг, БСШУС-ын яамны тушаал, шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг судлан боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан. 3) Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”, Үндэсний номын сангийн захиргааны зүгээс төрийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй, түргэн шуурхай, ил тод, нээлттэй хүргэх, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, талаар санал хүсэлтийг сонсож , номын сангийн үйлчилгээнд Олон улсын чанарын стандартыг судлан хийх ажилдаа тусгах тал дээр анхаарч ажилладаг.	**100** **100** **100**	

		- Номын сангийн үйлчлүүлэгч, уншигчдад болон харилцагч, хамтран ажилладаг байгууллагуудтай харилцахдаа х үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр зохих дүрэм, журмын дагуу цаг алдалгүй, ил тод, хөнгөн шуурхай хүргэж ажилласан.		
2. Санхүүгийн сахилга батыг сахих, аливаа зөрчил дутагдал гаргахгүй ажиллах; 1) Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн тогтовортой, иж бүрэн, үнэн зөв байдлыг хангаң, санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхдээ ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлах; 2) Төрийн байгууллагын төсвийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтыг төсвийн тухай болон төрийн аудитын тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэгжүүлнэ. 3) Албаны бус зорилгод байгууллагын эд	1) Хууль, дүрэм, журмаар тогтоосон хугацаанд нь гүйцэтгэлийг тайлагнаж, санхүүгийн сахилга батыг сахин ажиллана. 2) Төсвийн тухай болон төрийн аудитын тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийг үр ашигтай зөв зарцуулснаар НББ-ийн стандарт, “Шилэн данс”-ны хуулийг хэрэгжүүлнэ. 3) Үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин	1) Үндэсний номын сангийн захирал Төсвийн тухай хуулийн 16.5.3 дахь хэсэг заасан батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох; 16.5.5.дахь хэсэгт заасан батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2) Төсвийн тухай болон төрийн аудитын тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийг үр ашигтай зарцуулж, 2018 оны санхүүгийн тайлан, байгууллагын үйл ажиллагааг аудитын шалгалтаар стандарт үнэлгээтэй дүгнүүлсэн. 3) Үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж,	**100** **100** **100**	

хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завшихгүй байх;	үнэнчээр зүтгэж, ил тод байж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, захирах захирагдах ёсыг баримтална.	Монгол хэл соёлоо дээдлэн, монгол судлалыг хөшжүүлэхэд номын сангийн үүргийг тодорхойлон эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ болон хамтран ажиллах чиглэлийн хүрээнд эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн арга хэмжээг хууль тогтоомжинд нийцүүлэн хэрэгжүүлж байна.		
3. Удирдах ажилтны мэдлэг, ур чадвар, ёсзүйгээрээ хамт олноо манлайлах ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллана. 1) Байгууллагын ажилтан, албан хаагчтай мэргэжлийн түвшинд, удирдах ажилтны ёс зүйг баримтлан харьцах, 2) Байгууллагын хэмжээнд ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлж, сурталчилах. 3) Байгууллагын ашиг сонирхлын зөрчлөөс	1) Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журмыг хамт олонд танилцуулна. 2) Захиргааны зөвлөл, хэлтэс тус бүрийн үйл ажиллагаанд номын санчийн мөрдөх хэм хэмжээ, ёс зүйн дүрмийг батлан хэрэгжилтийг хянана.	1) Ажилтан, албан хаагчидтайгаа удирдах ажилтны ёс зүйг баримтлан ажилладаг. Албан хаагчтай ялгаварлахгүйгээр жигд, эрх тэгш харилцах, удирдлагаар хангах, харилцааны эелдэг хүндэтгэлтэй, ажил хэрэгч байдлыг хангах, ажилтнаа сонсох, ойлгох чадвартай үлгэр жишээ байхыг эрмэлздэг. 2) Захиргааны зөвлөл, хэлтэс тус бүрийн үйл ажиллагаанд номын санчийн мөрдөх хэм хэмжээ, ёс зүйн дүрмийг батлан хэрэгжилтийг хянана. 3) Төрийн албаны ёс зүйг эрхэмлэн, үнэнч байж, эх орон, ард түмнийхээ эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг	**100** **100** **100**	

урьдчилан сэргийлэх журам боловсруулж мөрдөх, 4) Манлайлал, удирдах ур чадвараа тасралтгүй сайжруулах чиглэлээр бие даан суралцах, чадвараа дээшлүүлэх	3) Албан хаагч, удирдлагын ёс зүйн асуудлаар ирсэн санал гомдлыг журмын дагуу хүлээн авч, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журам боловсруулж, асуудлыг шийдвэрлэнэ. 4) Төрийн албаны шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлэх, Төрийн албаны тухай хуулиар тодорхойлсон чиг үүргээ мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавхийг хөгжүүлэхэд анхааран ажиллана. Хөрөнгө орлогын мэдүүлгээ жил бүрийн тогтоосон хугацаанд үнэн зөв мэдүүлсэн.	сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах чадвартай. 4) Төрийн албаны тухай хуулийн 2019, 2020 оноос хэрэгжиж буй журмын хэрэгжлтийг ханган ажиллаж Төрийн албан хаагчийн анкет, хувийн хэргийн бүрдлийг шинээр бүрдүүлж өгсөн. Хөрөнгө орлогын мэдүүлгээ тогтоосон хугацаанд үнэн зөв мэдүүлсэн. - БСШУС-ын яамны “Түүх соёлын дурсгалт зүйлсийн үнэлгээ, зэрэглэл тогтоох комисс”-ийн гишүүний хувьд үйл ажиллагаанд тогтмол, идэвхитэй оролцож, шийдвэр гаргахад хувь нэмрээ оруулсан.	**100**	
4. Үр бүтээлтэй санал санаачлагыг дэмжих 1) Номын сангийн хөгжлийн чиг хандлага, судалгааны болон тулгамдсан асуудлаар төсөл хөтөлбөр боловсруулах,	1) Байгууллагын үйлчилгээ, мэргэжил арга зүйн ажлыг сайжруулах чиглэлээр гаргаж хэрэгжүүлсэн хэлтэс бүрээс 2 шинэлэг ажил, санал, санаачлагыг хэрэгжүүлнэ.	1.1) Номын санг хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх; Үндэсний номын сангийн хэтийн болон ойрын бодлогыг тодорхойлох, төлөвлөх; гэрээний хэрэгжилтийг зохих журам, дүрэм, зааврын дагуу чанартай, үнэн зөв, бодитой, шуурхай боловсруулах ажлыг биечлэн гүйцэтгэсэн.	**100** **100**	

дэвшилтэт санал санаачлагыг дэмжин ажиллах		1.2) ҮНС-гийн Мэргэжлийн зөвлөлийн гишүүд холбогдох мэргэжилтнүүдийг ажлын хэсэгт зохион байгуулж, баригдаж буй шинэ номын сангийн төсөв, төсөөллийг боловсруулах, судалгаа хийлгэн, зураг төсөлд оруулах нэмэлт өөрчлөлт, шаардлагатай хөрөнгө оруулалтын санал бэлтгэлээ. 1.3) Засгийн газрын “Монгол судлалыг хөгжүүлэх хөтөлбөр”, “Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр”-ийнн хэрэгжилтийг хангах үүднээс ШУА, Түүх Археологийн хүрээлэн, Олон улсын Монгол судлалын холбоо, Монгол судлалын хүрээлэн зэрэг байгууллагуудтай хамтран МУҮНС-гийн сан хөмрөг, сурвалж бичгийн талаар танилцуулга, илтгэл 2 удаа тавьсан бөгөөд “Дэлхийн номын сангууд дахь монгол сурвалж бичгийн өв” Олонулсын эрдэм шинжилгээний хурлыг санаачлан амжилттай зохион байгуулсан.	**100**	
5. Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар үе шаттай тодорхой				

арга хэмжээ авч, сэтгэл ханамжийн судалгааг зохион байгуулж хэвшинэ. 1) Байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, нээлттэй хаалганы өдөрлөг, санал хүсэлтийн хайрцаг ажиллуулах 2) Иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх 3) Үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгааг жилд 2 удаа авч дүгнэх	1) Цахим хуудасны мэдээллийн шинэлэг тогтвортой бодит байдлыг чухалчлан, мэдээллийн самбарт сурталчилсан мэдээ мэдээллийн сард 1 удаа шинэчлэх, мэдээ, мэдээллийг 800-1000 хүнд тогтмол сурталчилана. 2) Санал хүсэлтийг авах журмын хүрээнд сард 1 удаа танилцан, хүний нөөцийн мэргэжилтний гаргасан дүгнэлт, ирсэн саналыг үндэслэн шийдвэрлэж, цаашид авах арга хэмжээнд тусгана. 3) Сэтгэл ханамжийн судалгааг номын сангийн орчин нөхцөл, үйлчилгээний чанарын хүрээнд	a. Цахим хуудасны мэдээллийн шинэлэг тогтвортой бодит байдлыг чухалчлан, мэдээллийн самбарт сурталчилсан мэдээ мэдээллийн сард 1 удаа шинэчлэх, мэдээ, мэдээллийг 2000 гаруй хүнд сурталчилсан. b. Уншигч, үйлчлүүлэгч, иргэйин санал, хүсэлтийг хүлээн авч, журмын хүрээнд 14 санал, хүсэлт, өргөдлийг хүлээн авч холбогдох арга хэмжээ, тусламж үйлчилгээг шийдвэрлэж ажилласан. c. Сэтгэл ханамжийн судалгааг номын сангийн орчин нөхцөл, үйлчилгээний чанарын хүрээнд голчлон авахаар жилд 2 удаа авсан. Боломжтой шийдвэрлэх асуудал, тохижилт үйлчилгээний чанарыг сайжруулах	**100** **100** **100**	

	голчлон авахаар жилд 2 удаа зохион байгуулж, байгууллагын орчин нөхцөл, засвар үйлчилгээ, номын санчдын харилцааны соёлд үнэлэлт, дүгэлт өгч, урамшуулах, хариуцлага тооцох арга хэмжээг авна.	үүднээс Нийтийн уншлагын танхимын уншигчдын амрах хэсгийг засаж, тохижуулсан, эхний ээлжинд үйлчилгээний номын санчдыг /УҮХ-ийн 14 хүн/ ажлын хувцастай болгосон. - "Хандлагаа өөрчилж, хамтдаа хөгжье" 2 сарын аяныг хамт олны дунд зохион байгуулж, байгууллагын ажилтнуудын харилцааны соёл, ажилдаа хандах хандлагыг өөрчлөх 8 удаагийн сургалтыг дэмжин явуулж, өөрөө хамрагдсан. Аяны үр дүнд эерэг хандлагатай хэлтэс, ажилтан, уншигч, судлаачдыг тус тус шалгаруулж, урамшуулсан ба хамт олноороо мэндлэх, хүндлэх ёсыг дээдлэх, ажлын байрны дасгалыг тогтмол хэвшүүлсэн.		
Арван хоёр. Мэргэжил ур чадвараа дээшлүүлэх зорилтын хэрэгжилт /ҮДГэрээнд 1.4.-т тусгагдсан 3 зорилт/				
1. Гадаад хэлний мэдлэг, чадвараа сайжруулах 1) Сургалтанд хамрагдах, бие даан суралцах замаар гадаад хэлний мэдлэг чадварын төвшингөө ахиулна	1) Англи хэлний мэдлэгээ бие даан дээшлүүлж, гадаадын номын сан, эрдэм шинжилгээний байгууллагын талаар веб сайт болон танилцуулга, материалуудыг судлан мэдлэг чадвараа ахиулна.	Англи хэлний мэдлэгээ бие даан дээшлүүлж, гадаад харилцаагаа өргөжүүлэн 2019 оны 5-р сарын 14-16-ны өдрүүдэд Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байрны үзэсгэлэнгийн танхимд Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн санаачлагаар МОНГОЛ бичгээр хэвлэгдсэн орчин үеийн номын үзэсгэлэн 3 хоног гаргасан ба Үндэсний Номын Сангийн бэлтгэл, солилцоогоор болон хувь хүмүүсээс цуглуулсан монгол бичгийн номууд НҮБ- ийн гишүүн орнуудын элчин сайд нар, төлөөлөгчдөд сурталчилсан. - БНСУ болсон ОУМСХолбооны их хуралд, БНХАУ-ын Тайванийн	**100**	

		Үндэсний номын сангийн зохион байгуулсан хурлуудад англи хэлээр илтгэл тавьсан.		
2. Салбарын бодлого, төлөвлөлт, төрийн алба, төрийн албан хаагчтай хууль тогтоомж, журмыг судлах, ашиглах **1)** Шинээр батлагдсан салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журмын мэдээллийн сан үүсгэх, албан хэрэгцээнд ашиглах	1) Монгол Улсын Үндсэн хууль, салбарын хууль, бодлогын баримт бичиг, дүрэм журмын мэдээллийн сан үүсгэх ба байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг зөвхөн албан хэрэгцээнд ашиглана.	1) Хууль эрх зүйн баримт бичгийн судлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, Үндэсний номын сангийн шинээр болон шинэчлэн найруулж буй журмын төсөл, саналуудыг боловсруулах, судлан санал, зөвлөмжийг өгч ажилласан ба ажлын дадал чадвараа сайжруулсан. - Соёл урлагийн байгууллагуудын удирдлагын болон салбарын хэлэлцүүлэг, зөвлөгөөнд танилцуулга, мэдээллийг номын сангийн асуудлуудаар судлагаатай хийж танилцуулсан. - Байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн болон төрийн байгууллагын мэдээллийг албан хэрэгцээнд ашиглаж ирсэн.	**100**	
Нийт дундаж үнэлгээ			**98,9%**	

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд олон нийтэд мэдээ мэдээллийг түгээх, тэдэнд зориулсан соёл танин мэдэхүй, соён гэгээрүүлэх чиглэлийн ажлуудыг дараах байдлаар зохион байгуулан ажиллав.

3.2.1 Нийслэлийн суурьшлын бүсийн хөрсний доройтол, бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх, суурь судалгааг оновчтой хийж, олон нийтэд хөрсний бохирдлын талаар ойлголт, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулна.

Олон нийтэд хөрсний бохирдлын талаар ойлголт, мэдээлэл өгөх ажлын хүрээнд: **“Их хотын иргэдийн экологийн боловсролд**”, **“Аз жаргалтай, утаагүй Улаанбаатар**” сэдэвтэй
“Агаар ба хөрсний бохирдол”сэдэвчилсэн үзэсгэлэн,
“Ус хамгийн чухал хэрэглээ” мэдээллийн үзэсгэлэн
“Монгол орон дахь уур амьсгалын өөрчлөлт”
“Ногоон хөгжилд иргэдийн оролцоо”сэдэвчилсэн үзэсгэлэн
“Экологи” сэдэвчилсэн үзэсгэлэн
“Ус чандмань эрдэнэ” мэдээллийн үзэсгэлэн
“Аялахад тохиромжтой монголын үзэсгэлэнт газрууд”
“Агаарын бохирдол бидний эрүүл мэндэд”
“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”
“Ногоон хувьсгал” сэдэвчилсэн үзэсгэлэн
“Экологи,эрүүл мэнд” сэдэвт байнгын үзэсгэлэнгүүдийг тус тус гарган сурталчилсан ба нийт 920 гаруй уншигч, үйлчлүүлэгч үзсэн байна.

Мөн “Утааны хор уршгийн тухай, маскны хэрэглээ”, “Ногоон Улаанбаатар”, “Хөрсний бохирдол”, “Ногоон орчин-Бидний ирээдүй”, “Ногоон орчин байгал эх дэлхийгээ хайрлая”, “Дэлхийн тамхигүй өдөр”, “Хүнсний аюулгүй байдал-эрүүл мэнд” зэрэг сэдвээр нийт 51 ширхэг хэвлэмэл хуудсаар тус тус мэдээлэл гаргаж сурталчлав.

4.1.17. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Эрдмийн аялал” аян зохион байгуулж, Шинжлэх ухааны Академийн харьяа хүрээлэн, номын сан, музей, түүхийн дурсгалт газар, орон нутгийн байгууллага, үндэсний үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах аяллыг тогтмол зохион байгуулна.

“Эрдмийн аялал” аяны хүрээнд:

- 27, 40, 41, 46, 65, 67, 72, 101, 104, 112, 120, 214, 243, 252, 261-р цэцэрлэгийн Бэлтгэл А, Б, В, Г бүлгийн 490 орчим хүүхэд багачуудад
- Ерөнхий боловсролын 1, 5, 11, 18, 23, 31,33, 52, 62, 85-р дунд сургууль,
- Харааны бэрхшээлтэй 116-р сургуулийн 1-5-р ангиуд, Номт наран сургуулийн 1-р анги, Шилдэг дунд сургууль, Ирээдүй цогцолбор 2-р бага сургуулийн 4д, 6д, Атланта сургууль, ОУ-ын Улаанбаатар дунд сургуулийн 7 дугаар анги, Эрхэт эрдэм ерөнхий боловсролын сургуулийн 2-р анги
- Булган аймгийн Баян-Агт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12-р анги, Төв аймгийн Борнуур сумын ЕБС, Хэнтий аймгийн Р. Чойномын нэрэмжит номын сангийн идэвхтэй уншигчид "Өсвөрийн сэтгүүлч" клубын хүүхдүүд
- Шинэ иргэншил дээд сургуулийн МСҮТ, Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн 20, Ач АУИС-ийн оюутан нийт 1402 оюутан, сурагч, иргэдийг төв болон салбар үйл ажиллагааг танилцуулж, уншигчаар бүртгэн, уншсан номынхоо талаар саналаа солилцож тэмдэглэл хөтлөх арга ажиллагааны талаар тойм яриа зохион явууллаа.

4.3. Соёл, урлаг

4.3.1. Бүх шатны боловсрол, соёлын байгууллагууд болон олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох “Иргэдийн оролцоотой Хотын соёл” олон нийтийн аяныг өрнүүлнэ.

Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор НЭГ ХОРОМ, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө сэдвүүдээр Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Прокурорын газрын Хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хяналтын прокурор Т.Жавхлантөгстэй уулзалт хийлээ. Уулзалтанд 31-р сургуулийн 4б ангийн 21 сурагчид оролцлоо.

Хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх, бусдаас суралцах арга барилыг эзэмшүүлэх зорилгоор Зохиолч Луужир Жиймийгийн “Намайг өөрчилсөн 85 эмэгтэй” номын хэлэлцүүлэг, уулзалтыг зохион явуууллаа. Уулзалтад 24 уншигч, бүсгүйчүүд хамрагдлаа.

Улаанбаатар хотын музейн эрдэм шинжилгээний ажилтан Г. Очбаяраар бяцхан уншигч, нийслэлчүүддээ Улаанбаатар хотын түүх, соёлын талаар “Бид ямар хотод аж төрөн амьдардаг вэ?” сэдвийн хүрээнд лекц уншуулж, харилцан яриа хийлээ. Уулзалтад 31 дүгээр сургуулийн 30 гаруй сурагч хамрагдлаа.

Нийслэлийн 380 жилийн ойг угтаж “Хотын соёл- Номноос эхлэнэ” уулзалтыг Хүүхдийн зохиолч О.Сундуйтай БЗД-н Гачуурт тосгоны 85 сургуулийн 5б ангийн Н.Сувдаа багштай ангийн сурагчдын дунд номын санч Д.Дэлгэрсайхан, ном

зүйч О.Долгорсүрэн нартай хамтран зохион байгуулж ажилласан. Уг арга хэмжээнд нийт 135 сурагчид хамрагдсан.

4.3.2. Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн үйлчилгээг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн цахим хэлбэрт шилжүүлж, алслагдсан дүүргийн соёлын ордны номын сангийн хүртээмжийг хоёр дахин нэмэгдүүлнэ. Тус заалтын хүрээнд:

1. Коха програмд ном каталогжуулж оруулах ажлын явц тайлант хугацааны байдлаар:

- Багануур дүүргийн соёлын ордны номын сан 9655 ш – 74,8%
- Багахангай дүүргийн соёлын ордны номын сан 1619 ш – 79%
- Жаргалант дүүргийн соёлын ордны номын сан 418 ш – 15.9%
- Налайх дүүргийн соёлын ордны номын сан 2599 ш – 23,6% номуудыг тус тус оруулаад байна.

2. Төв болон салбар номын сангийн үйлчилгээнд RFID технологийг нэвтрүүлэхэд шаардлагатай үлдэгдэл тоног төхөөрөмжийн судалгаа гарган 2019 оны 04 дүгээр сард Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт тендерийн материалыг хүргүүлсэн. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдөр тендер зарлагдан “Ай Ти Зон” ХХК шалгарсан.

Нийслэлийн Засаг даргын тамгын газар “Ай Ти Зон” ХХК-тай 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдөр “Төв болон салбар номын санд RFID системийн компьютер, бусад тоног төхөөрөмж нийлүүлэх” гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр эхний ээлжийн тоног төхөөрөмжүүдийг хүлээн авсан. Тус компани БНХАУ руу барааны захиалгыг хийсэн ба VC-420T RFID EAS GATES хаалганы үйлдвэрлэх процесс удааширсны улмаас гэрээнд заасан хугацаандаа ирж амжихгүй болсон тул тухайн гэрээг 12 дугаар сарын 09-ний өдөр хүртэл сунгасан.

“Ай Ти Зон” ХХК-иас 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдөр дараах нэр төрлийн тоног төхөөрөмжүүдийг хүлээн авсан.

№	Загвар	Нэр	Тоо ширхэг
1	VC-420T	RFID хаалга	6
2	LA-86B	RFID чип	174000
3	R-0407	RFID чип хэвлэх принтер	1
4		RFID чип хэвлэх принтерийн хор	40
5	VD-67	RFID чип уншигч	15
6	VH-71T	RFID гар тоологч	4
7	VD-68	RFID уншигчийн карт уншигч	11
8	Zebra p330	RFID уншигчийн карт хэвлэх принтер	4
9	VT-80	RFID уншигчийн картын бэлдэц	18400
10		RFID уншигчийн карт хэвлэх принтерийн хор	40
11	CCR1009-7G-1C-1s	Роутер	4
12	TP-link	Свич	4
13	Dell inspiron 15 3555	Нөүтбүүк	1
14	Dell optiplex 3050	Компьютер	15
15	Dell PowerEdge R740	Сервер компьютер	1

3. Төв номын сангийн засварын зураг төслийг “Уранстийл Воркс” ХХК-иар хийлгэн 2019 оны 08 дугаар сард Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар

хүргүүлсэн. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр тендер зарлагдан “Цагаан Удам” ХХК шалгарсан. Одоогийн байдлаар дотор засварын ажил хийгдэж байгаа ба 60%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

4.5. ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ:

4.5.7. Нийслэлд “Гэр бүлийн өдөр”-ийг тэмдэглэхийг хэвшүүлж, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бий болгож, тогтвортой харилцааг төлөвшүүлнэ.

Чингэлтэй дүүргийн алслагдсан Ерөнхий боловсролын 58 дугаар бүрэн дунд сургуулийн номын өргөөтэй хамтран гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ. Тус өдөрт зориулан нийтийн уншлагын танхимаас Монголын сурагчдын холбооны сэтгэл зүйч Б. Тэгшжаргалыг урин "Гэр бүлийн үнэ цэнэ" сэдэвт уулзалт ярилцлага зохион байгуулж 70 сурагч хамрагдсан байна.

Мөн Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сангийн хүүхдийн уншлагын танхимаас "Гэр бүл өнөөдөр" сэдэвт эсээ бичлэгийн уралдаан явуулж эхний 5 байрыг шалгаруулан шагнаж урамшууллаа. Нийтийн уншлагын танхимын номын санчид 2019-2020 оны хичээлийн жилд тус сургуулийн номын өргөөтэй хамтран номын клуб байгуулан хамтарч ажиллаж, хүүхдийн уншлагын танхим тус сургуулийн 2-3 ангийн хүүхдүүдийг уншигчаар бүртгэн зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүллээ.

Сүхбаатар дүүргийн 45-р сургуулийн 4а, 4б, 4в, 4г бүлгийн 160 сурагчдад "Цахим хэрэгслийг хэтрүүлэн хэрэглэсний хор нөлөө буюу зохистой хэрэглэсний ач холбогдол" сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Байгууллагын page хуудсаар дамжуулан эцэг эх, хүүхэд багачуудад зориулсан “Хүүхдэдээ ном уншиж өгөөрэй”, “Гэр бүлийн харилцааг эрхэмлээрэй” сэдэвт зурагт мэдээлэл зөвлөмжийг тогтмол оруулж 60 хүн хандсан байна.

Дээлтэй монгол наадамд зориулан нүүдэлчдийн соёлын чухал хэсэг болсон “Монгол үндэстэн ястны дээл, гоёл чимэглэлийн тухай 12 ширхэг хэвлэмэл хуудсаар үзэсгэлэн гаргаж сурталчлав. Монголын ирээдүй болсон хүүхэд, залууст түүх, соёл өв уламжлалаараа бахархах ухамсрыг төлөвшүүлэх, таниулахад оршино.

АНУ-ын ЭСЯ-тай хамтран Бүтээлч иргэнийг төлөвшүүлэх, дэмжих зорилгоор МэйкерСпейс танхимыг 60 сая төгрөгөөр засварлан тохижуулж, 70 гаруй сая төгрөгөөр тоног төхөөрөмж, суралцагчдын ашиглах хэрэглэгдэхүүн авч үйл ажиллагааг эхлүүлээд байна. Ингэснээр тус танхимд Лего тоглоомын хөтөлбөр, 3D принтер ажиллуулах, Ардиуно хийх сургалт, Хувцас загвар, оёдол дизайны сургалтууд явагдаж байна. 2019 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр нээгдсэн ба одоогийн байдлаар 189 уншигч, үйлчлүүлэгч сургалт, хөтөлбөрт хамрагдаад байна.

Хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилго бүхий Лего тоглоомын хөтөлбөрийн зарыг олон нийтэд Фэйсбүүк хуудсаараа дамжуулан хүргэж байна. Уг хөтөлбөрт хамрагдахын тулд урьдчилан цагаа бүртгүүлэн тоглох журмаар явагдаж байгаа бөгөөд 7 хоногийн 6 өдөр 09:00-18.00 цаг хүртэл эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хамтдаа ирж тоглох боломжтой хөтөлбөр юм. Нийтдээ 21 хүүхэд, 6 насанд хүрэгч шинээр карт нээлгэн тус хөтөлбөрт хамрагдаж байна.

Хүүхдүүдэд зориулсан картын тоглоомын хөтөлбөр нь Мягмар гараг бүрийн 14.00 цагаас явагддаг ба нийтдээ 3 удаа удаагийн хичээлд 22 хүүхэд хамрагдсан

байна. Энэхүү тоглоомын цагаар англи хэлний үгийн сангаа баяжуулах, дүрмийн мэдлэгээ дээшлүүлэх мөн байгалийн ухаан болон инженерчлэлийн сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой 14 төрлийн тоглоомыг багаар болон ганцаарчлан тоглох боломжтой юм.

2019 оны 06 дугаар сарын 19-өөс 10 дугаар сарын 02-ныг дуустал 3D загварчлал, Ардиуно төслийн сургалтын 5 удаа зохион байгууллаа. Уг сургалтад нийт 211 сурагч хамрагдах хүсэлтээ ирүүлсэн бөгөөд сонгон шалгаруулалт болон танхимын багтаамжаас шалтгаалан 68 сурагчийг сургаж, төгсгөлөө. Сургалтаар электроникийн онол, дадлага, 3Ди принтер загварчлал, багийн ажиллагааны хичээлүүдийг мэргэжлийн багш нараар заалгаж байлаа. Тус сургалтын төгсөгчид Super Cleaner/Супер цэвэрлэгч/, Jarvis /Бяцхан өргөгч/, Switcher /Гэрэл мэдэрч ажилладаг машин/, Өглөөний гайхамшиг/Сэрүүлэг/, Дохиоллын систем, Ухаалаг гудамжны гэрэлтүүлэг, Ухаалаг авто зогсоол, Халуун мэдэрч асдаг гэрэл зэрэг бүтээлүүдийг хийж, олон нийтэд дэлгэн үзүүллээ. Лего тоглоомоор робот угсрах, шинээр програмчилах сургалт 11 удаа зохион байгуулж нийтдээ 84 уншигч хамрагдаж номын сангийн уншигчаар бүртгүүлсэн. Лего тоглоом угсрах сургалтыг урьдчилан цаг захиалан бүртгүүлдэг бөгөөд өөрийн хүчин чадлын боломжоор нэг удаад 3 сурагч тоглох боломжтой байсан ба АНУ-ын ЭСЯ-ны ОНХА-нд хүсэлт гаргаж шинээр 1100 ам.долларын легомайндстор тоглоом авсан. Мөн тус сургалтын үр дүнд сургагч бэлтгэгдэж сайн дурын сурагчдын "Монголиан майднсторм клуб" нээж 2 удаагийн тэмцээнд амжилттай оролцсон амжилт үзүүлсэн байна.

Арабын Нэгдсэн Эмират Улсын Элчин сайдын яамны буцалтгүй тусламжийн 55 сая төгрөгөөр Хүүхдийн уншлагын танхимдаа бүрэн засвар, тохижилтын ажлыг хийлээ. Хүүхдийн уншлагын танхимд сурагчдын өвлийн амралтад зориулан чөлөөт цагийг нь зөв боловсон өнгөрүүлэхэд нь туслах, номын санд уншигч татах зорилгоор "My first English" Англи хэлний анхан шатны сургалтыг 2, 3, 4 ,5-р ангийн сурагчдад 7 хоногт 1 удаа зохион байгуулж нийт 22 удаа бага ангийн 316 сурагчийг хамруулжээ.

Хүүхдийн эрхийн хамгаалах өдөрт зориулан 1950-1980 оны хоорондох хүүхдийн ном зохиолуудаар /34 ширхэг / үзэсгэлэн гаргалаа.

“Миний дуртай ном” номын танилцуулгыг 3 удаа хийж 23 сурагчийг хамруууллаа. Уг танилцуулгаар “Таши” цуврал, Барак Обамагийн “Охиддоо бичсэн захидал” номуудын танилцууллаа.

“Зуны Амралт Ба Ном” хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн Йогийн хичээлийг 3 удаа зохион байгуулж 21 хүүхдийг хамруууллаа. Сургалтыг "Sunderia Yoga" төвийн сургагч багш Н. Сүндэръяа багш удирдан явууллаа.

“Let’s speak” номын хэлэлцүүлгийг 3, 4, 5 дугаар ангийн сурагчдад 3 удаа зохион явуулж 18 хүүхдийг хамруууллаа.

Сургагч багш С. Оюунгэрэлтэй хамтран "Номын сантай танилцъя" хөтөлбөрийн хүрээнд "Оюун ухааны клуб"-ын сурагч

хүүхдүүдэд номын сангаа танилцуулан “Ном уншихын ач тус”, “Номтой нөхөрлөхийн гавъяа” сэдвүүдээр ярилцлага хийв.

Монсудар хэвлэлийн газартай хамтран эцэг эхчүүдэд зориулсан “Зурагт ном яагаад чухал вэ?” цуврал уулзалт ярилцлагыг зохион байгууллаа. Уг уулзалтаар Бумбардай номыг ярилцсан юм. Уулзалтыг нийгмийн сүлжээгээр лайв буюу шууд дамжуулан үзүүлсэн бөгөөд одоогийн байдлаар 1000 гаруй удаа үзэгдээд байна.

2019 оны 04 дүгээр сарын 26-нд “Газар дэлхий-Бидний гэр” Олон улсын хүүхэд залуучуудын хөгжмийн XVII их наадмын өдөрт зориулж Гитарчин Д.Энхболдтой уулзалт ярилцлага хийлээ. Уулзалт ярилцлагад нийт 55 оюутан, залуус хамрагдлаа.

“Би хариуцлагатай аав ээж” аяны хүрээнд 31-р сургуулийн 4-ангийн сурагчдад “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийлэл гэж юу вэ? Урьдчилан сэргийлэх арга зам” сэдвээр лекц хийж, хүчирхийллийн эсрэг боршур тараалаа.

Нийслэлийн Хүүхэд Гэр Бүл Хөгжлийн Газар, Нийслэлийн 152 хороонд зохион байгуулсан “Би хариуцлагатай-ААВ, ЭЭЖ” аяны хүрээнд 31 дүгээр сургуулийн 6 дугаар ангийн сурагчдын дунд “Эцэг эх хүүхдийн үүрэг хариуцлага” семинар зохион явуулав. Семинарт 53 сурагч хамрагдлаа.

“Соёмбо пресс” хэвлэлийн компанитай хамтран Кембрижийн сургалттай “Шинэ эхлэл” 8-р сангийн 30 сурагчдад “Дэлхийн шилмэл зохиолын дээжис 191 боть” ном бэлэглэв. Энэ үеэр зохиолч, сэтгүүлч А. Амарсайхан “Номын тэмдэглэл хэрхэн тухай”, номын санч Ж. Рая “Би яагаад номын санч мэргэжлийг сонгох болов” сэдвээр яриа хийлээ.

“Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, урьдчилан сэргийлэх талаар Нийслэлийн Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн Цагдаагийн хошууч Э.Баярбаясгалантай уулзалт ярилцлага зохион байгуулж өргөн хүрээтэй болж 60 гаруй

уншигч сурагчид оролцлоо.

Хоёр. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жил бүр улс орон даяар уламжлагдан зохион байгуулагддаг “Үндэсний бичиг үсгийн баярын өдөр”-үүдээр дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:

<u>Уралдаан, тэмцээн</u>

Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сан "Эх хэлээ дээдэлье" уран илтгэлийн уралдааныг уламжлал болгон зарлаж байгаа бөгөөд анхны жилдээ зохион байгуулж шилдэг уран илтгэгчийг шалгаруулаа.

ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫ ЗОРИЛГО Оюутан, сурагчдыг өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, эх болсон Монгол хэлээрээ уран яруу, зөв ярих дадал олгох, эх хэлээ дээдлэх ухамсар олгох, эерэг өөрчлөлтийг бий болгож соён гэгээрүүлэхэд оршино. Шалгарч үлдсэн хүүхдүүд

Уран илтгэлийн уралдаанд Их сургуулийн бакалаврын төвшний оюутнууд, ЕБС-ийн 10-12 ангийн сурагчид оролцлоо. “Эх хэлээ дээдэлье”, “Эх хэлээ хайрлая”, “Эх хэлээ эвдэхгүй юмсан” гэсэн сэдвийн хүрээнд 2019 оны 05 дугаар сарын 10–ны өдрийн 15 цагт Горькийн нэрэмжит салбар номын санд зохион байгуулагдлаа. Гадаад үг хэллэг оруулахгүй, Монгол хэлээрээ цэгцтэй, ойлгомжтой ярьж бичих гэсэн ерөнхий шаардлага хангасан 36 оюутан, сурагчдаас шилдэг 8 сурагч, оюутныг сонгон илтгэлийг яриулан шилдэг 3 илтгэгчийг шалгаруулж өргөмжлөл, ном, тусгай байрын шагналаар шагнаж урамшууллаа.

Шилдэг илтгэгчид

Хамтран ажилласан Идэр Их сургууль, ИЗИС, ЕБ 111,16-р сургуулийн сурагч, оюутан, багш нар 70 хүн оролцлоо.

Хамтран ажилласан ИИС-ийн багш ажилчид

"Алтан үсгийн цоморлиг" уралдаан

"АЛТАН ҮСГИЙН ЦОМОРЛИГ-2019" оны уралдаанд 15 бүтээл ирснээс тэргүүн байранд ШУТИС График дизайн 1-р курсын оюутан Б. Өсөх-Эрдэнэ, дэд байранд Санхүү эдийн засгийн их сургууль 3-р курсын оюутан М.Данзанпэрэнлэй, гутгаар байранд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Ерөнхий Боловсролын сургуулийн 11А ангийн сурагч Б.Гийхнаран шалгарлаа.

<u>Уулзалт, лекц</u>

“Монгол өв соёл,үнэ цэн” лекцийг Урлаг судлалын магистр Х.Эрдэнэбаяр оюутан сурагчдад өсөхөөс төрсөн үндэсний хэл мартаж болшгүй соёлын сайхныг мэдрүүлсэн, монгол хэл соёлоороо бахархах, ном эрдмийг эрхэмлэх, монгол бичгийн уран бичлэгийн тухай ярьж, үндэсний эх хэл бичгээрээ бахархаж явахын үнэ цэнийг уншигчдад ойлгуулан таниулсан сонирхолтой лекцийг хийлээ.

"Бичиг үсгийн соёл" сэдэвт уулзалтыг Монгол улсын зөвлөх багш, Ертөнц бүрэн дунд сургуулийн Монгол хэл уран зохиолын багш А.Цэнгэлтэй хийлээ. Уулзалтанд 50-р сургуулийн 9в ангийн 46 сурагч оролцлоо. Үндэсний бичиг үсгийн баяраар Идэр их сургуулийн монгол хэл, уран зохиолын багш, хэл судлалын магистр Д. Уянга, эх хэлээ эрхэмлэн дээдэлж, бичиг соёлын дурсгалаа сурталчилах зорилгоор ХУД-ийн ЕБС-ийн 9-12 ангийн нийт сурагчдад “Яагаад бидэнд Монгол бичиг хэрэгтэй вэ?” сэдвээр сургалт хийлээ. Уулзалт сургалтад 139 сурагч хамрагдлаа.

Үзэсгэлэн

Мөн МУ-ын УГЗ, Төрийн шагналт асан МУ-ын төрийн сүлд бүтээгч.Ц.Ойдовын уйгаржин монгол бичгээр бичсэн уран бичлэгийн 14 ширхэг бүтээлээр үзэсгэлэн гаргаж сурталчлав.

Зураач О.Андимана “Монгол бичиг мину” уйгаржин монгол бичиг, таталган бичиг, бийрэн бичлэгийн талаар каллиграфийн хичээлийг оюутан сурагчдаар муутуун цаасан дээр бичүүлж,цэвэрхэн зөв бичсэн 5 уншигчийг шалгаруулж дурсгалын зүйл гардуулав.

ЕБС-ийн СБД-ийн 16-р сургуулийн нарийн бичгийн дарга А.Бямбасүрэнгээр ахлуулсан 11-р ангийн 50 сурагч, нийт 65 хүн хамрагдлаа.

"Эх хэлний тань мэдлэгт", мөн "Монгол бичгийн түүхээс "үзэсгэлэнг 10 ш ном, 10 ш хэв 14 ш бүтээлээр гаргаж сурталчилсан.

Уйгаржин монгол бичгээр 20 ширхэг номоор, Монголчуудын бичиг үсгийн түүхийг 10 ширхэг хэвлэмэл хуудсаар сурталчилав. Үүнд: Монгол бичиг, Соёмбо үсэг, Дөрвөлжин үсгийн гарал үүслийг тухай мэдээлэл гаргав.

Үндэсний бичиг үсгийн баяр арга хэмжээнд нийт 28 ш бүтээл, 30ш ном, 20ш хэвлэмэл хуудсаар үзэсгэлэн гаргаж, 2 удаагийн уралдаан тэмцээнд 41 оюутан сурагчид оролцож, ЕБ-ын 16, 50, 111-р сургуулийн 9-12 ангийн 96 сурагч, ИЗИС-Идэр ИС-ийн 66 оюутан оролцлоо. Нийт 181 хүн хамрагдлаа.

<u>Эрдмийн аялал</u>

ХУД-ийн 67-р цэцэрлэгийн х. Ундармаа багштай бэлтгэл А бүлгийн 52 хүүхэд, х. Юмчигмаа багштай бэлтгэл Б бүлгийн 40 хүүхэд, х. Даваасүрэн багштай бэлтгэл В бүлгийн 53 хүүхэд, нийт 145 хүүхэд, “Шилдэг” дунд сургууль, 48, 33-р сургуулийн нийт 110 хүүхэд тус тус оролцож номын сантай танилцан, үлгэрийн цаг гарган харилцан ярилцаж, үлгэрийн кино үзүүлэв.

2. Нийслэлийн Засаг даргын 2012 он “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/606 дугаар захирамж

Тайлангийн хугацаанд иргэдэд мэдээллийг ил тод, шуурхай хүргэх ажлын хүрээнд твиттерт 1488 жиргээ илгээгдэж, 443 дагагчтай, байгууллагын фейсбүүк хуудас 38489, үүнээс гадна АСМТ 17971 дэмжигчтэйгээр нийгмийн сүлжээгээр мэдээллийг түгээж байна.

3. Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Мэдээллийн аюулгүй байдлын журам” А/477 дугаар захирамж

Мэдээллийн системийг холбогдох стандартын дагуу зохион байгуулж ажилладаг бөгөөд номын сангийн үйл ажиллагаа, цаг үеийн шинжтэй мэдээлэл, шилэн дансны мэдээллийг нийтэд ub.pl.gov.mn, UB Public Library.Facebook цахим хуудсанд тухай бүрт байршуулж байна.

Байгууллага дотооддоо захирлын тушаал, үүрэг даалгавар, ажилтан, албан хаагчдын хувийн хэрэг, өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллүүдийг ажилчдын дотоод Facebook page болон дотоод сүлжээгээр мэдээллэдэг.

Номын сангийн нийт байр талбайн 10 хүртэлх хувь буюу үндсэн фонд болон Серверийн өрөө хаалттай бүсэд тооцогддог. Үндсэн номын фонд, серверийн өрөөнд зөвхөн эрх бүхий албан тушаалтан нэвтрэх эрхтэй бөгөөд аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж ажилладаг.

Ашиглагдаж байгаа бүх компьютер техник хэрэгслийг мэдээллийн ажилтнууд бүртгэлжүүлж, засвар үйлчилгээ, шинэ програм хангамж нэмэгдэх бүрт програмист болон хариуцагч ажилтан нар гарын үсэг зурж баталгаажуулдаг.

Мэдээллийн системийг хууль бус халдлагаас хамгаалах галт хана ашиглаж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтрэх оролдлогыг таслан зогсоох, илрүүлэх зориулалтаар хамгаалалт, хяналтын техникийн систем, зориулалтын програм хангамжид байнга хяналт тавьж ажиллаж байна.

**4. Нийслэлийн Засаг даргын 2014 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх тухай батлах тухай” А/718 дугаар захирамж

http://koha.pl.ub.gov.mn - ийг Google Analytics тусламжтайгаар каталогт мэдээлэл хайж байгаа үзүүлэлт 2018 оны 12 дугаар сарын 25-аас 2019 оны 12 дугаар сарын 30-ныг хүртэлх хугацаанд 87178 хэрэглэгч зочилж /visits/, 279314 хуудасны мэдээллийг үзжээ. Нийт электрон каталогийн хэрэглэгчдийн 85,3% нь шинээр орж байгаа хэрэглэгчид үлдсэн 14,7% нь хуучин хэрэглэгчид тайлангийн хугацаанд холбогдсон байна.



Тайлангийн хугацаанд сайтад зочилсон хэрэглэгчдийг эхний 10 улс орноор харуулав.



	Country	Users	% Users
1.	Mongolia	43,687	88.76%
2.	United States	2,676	5.44%
3.	(not set)	878	1.78%
4.	South Korea	404	0.82%
5.	Japan	277	0.56%
6.	Russia	250	0.51%
7.	China	143	0.29%
8.	Germany	97	0.20%
9.	United Kingdom	85	0.17%
10.	Australia	57	0.12%

5. Нийслэлийн Засаг даргын 2015 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журам батлах тухай” А/633 дугаар захирамж

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журмын дагуу ажлаас чөлөөлөгдсөн 4, шинээр болон эгүүлэн томилогдсон 10, шилжин ажилласан 4 ажилтнуудын ажил хүлээлцэх комиссын гишүүдийг томилж, уг журмын хавсралт ажил хүлээлцэх маягтын дагуу цахим болон цаасан баримт, эд хөрөнгийг хүлээлцүүлэн тус бүр 3 хувь үйлдсэн.

6. Нийслэлийн Засаг даргын 2017 оны “Нийслэлийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөх албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам батлах тухай” А/252 дугаар захирамж

Тайлант хугацаанд Edoc системд нийт ирсэн 185 албан бичиг бүртгэгдсэнээс цахимаар 182, цаасан суурьтай 3 албан бичиг ирснийг бүртгэсэн. 179 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн хаасан, 3 албан бичгийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж, 3 албан бичиг судалж буй төлөвтэй байна.

Мөн Edoc системээр нийт явуулсан 127 албан бичгийг бүртгэж илгээсэн ба үүнээс албан хэрэг хөтлөлтийн систем ашигладаг 87, систем ашиглагдаггүй 40 байгууллага руу албан бичиг бүртгэн хугацаанд нь шилжүүлж шийдвэрлүүлсэн. Системийн боловсруулалт цэсийг ашиглан 8 албан бичиг илгээсэн.

Систем ашиглалтын зөрчилтэй 5, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 3, шийдвэрлэлтийн зөрчилтэй 8 албан тоот илэрснийг холбогдох ажилтнуудад мэдэгдэж дахин зөрчил гаргалгүй ажиллах тал дээр зааварчилгаа, зөвлөгөө өгсөн.

Хариутай бичгийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг сард 2 удаа гаргаж, удирдлагад 24 удаа танилцуулж ажилласан.

Улсын үзлэгт бэлдэх комисс 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр Захирлын 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/28 дугаар тушаалаар батлагдаж, үзлэгт бэлтгэсэн. Үзлэгт бэлдэх 21 ажил бүхий тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан бөгөөд Нийслэлийн салбар комисст ажлаа шалгуулж Төрийн ажлын зохион байгуулалт 84.3%, Албан хэрэг хөтлөлт 84.4%, Байгууллагын архив 91.4%, Мэдээллийн технологи 93.1%, Дундаж үнэлгээгээрээ **88,3% “B”** үнэлэгдсэн.

2018 оны баримтаар нөхөн бүрдүүлэлт хийх ажлыг Нөхөн бүрдүүлэлтийн хуваарийн дагуу хийлээ. ХХНЖ-ын дагуу 2018 оны Байнга хадгалах-23, 70 жил хадгалах-4, Түр хадгалах – 28, Цахим баримт- 2, нийт 57 баримтаар байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийж, данс бүртгэлийг үйлдэн ББНШК-ын хурлаар хэлэлцүүлэн баталсан.

Байгууллагын “Албан хэрэг хөтлөлтийн журам”, “Архивын ажиллах журам”-ыг ажиллагсдад тараан, журам танилцуулах сургалтыг нэгж тус бүрт 1, нийт 5 удаа Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан, төв салбар номын сангууд гэх мэтээр тухайн ажлын байранд нь хүрч хийсэн нь ихээхэн үр дүнтэй, ажиллагсдын талархлыг хүлээсэн сургалт болсон.

Гурав. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1. Уншлага үйлчилгээ

Номын сангийн хэмжээнд тайлант хугацаанд бүтээгдэхүүн нийлүүлэлтийг “хүснэгт 1”-ээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1

д/д	Бүтээгдэхүүний нэр	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Бүртгэлтэй уншигч	19300	14728	76,3%
2	Ирэгсэд	119700	101400	84,7%
3	Ном олголт	299250	241957	80,8%
4	**НИЙТ ДҮН**	**438250**	**358085**	**81,7%**

Уншлага үйлчилгээний төлөвлөгөөт үзүүлэлтүүд 76-84%-ийн биелэлттэй байгаа бөгөөд тайлант хугацааны төлөвлөгөөт үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Хүснэгт 2

Он		2018			2019		
№	Үйлчилгээ нэр	Төлөв-лөгөө	**Биелэлт**	**Хувь**	Төлөв-лөгөө	**Биелэлт**	**Хувь**
1	Бүртгэлтэй уншигч	19300	**14349**	74,3%	19300	14728	76,3%
2	Ирэгсэд	119700	**106076**	88,6%	119700	101400	84,7%
3	Ном олголт	299250	**235299**	78,6%	299250	241957	80,8%

2019 оны уншигчийн төлөвлөгөө 76,3%-ийн биелэлттэй байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийн биелэлттэй харьцуулахад **2%-**иар өссөн байна.

3.2. Гэрээр ном олгох үйлчилгээ

Тайлант хугацаанд уншигч хэрэглэгчдэд **241957** ном хэвлэл олгож үйлчилснээс 12,3% буюу **29799** ширхэг номыг гэрээр олгож үйлчилсэн байна.



Тайлант хугацаанд ном олгох үйлчилгээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Он		2018			2019		
№	Үйлчилгээ нэр	Төлөв-лөгөө	**Биелэлт**	**Хувь**	Төлөв-лөгөө	**Биелэлт**	**Хувь**
1	Ном олголт	40830	**40920**	100%	40830	**29799**	72,9%

Тайлант хугацаанд гэрээр ном олгох үйлчилгээ 72,9%-ийн биелэлттэй байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийн биелэлттэй харьцуулахад **27,1%-**иар буурсан үзүүлэлттэй байна.

<u>Тайлбар</u>

1. Тайлант хугацаанд төв болон салбар номын сангийн хэмжээнд ажил хүлээлцэх ээлжит бус 4 удаагийн тооллого /Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэг дэх салбар номын сан, төв номын сангийн уншлагын Б танхим/ хийгдсэн. Нийт ажлын 95 өдөр зарцуулсан.

2. Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сангуудад Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 2018 оны 09 дүгээр сараас их засварын ажил хийгдэж, номын сангийн стандарт шаардлагад нийцсэн тавилга эд хогшил, компьютер техник тоног төхөөрөмж суурилуулсан. Баянзүрх дүүрэг дэх салбар номын сан 2019 оны 02 дугаар 07, Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сан 2019 оны 03 дугаар 06-ны өдрөөс уншлага үйлчилгээгээ эхлүүлсэн. Мөн төв номын сангийн Хүүхдийн уншлагын танхимд Арабын нэгдсэн Эмират улсын дэмжлэгтэйгээр 2019 оны 09 дүгээр сараас эхлэн иж бүрэн засвар, тохижилтын ажил хийгдэж, 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр нээлтээ хийн үйлчлүүлэгчдээ хүлээн авсан.

3. Тус номын сангаар үйлчлүүлэгчдийн дийлэнх хувийг оюутнууд эзэлдэг. Сүүлийн жилүүдэд их дээд сургуулиуд шинэ барилга барьж, номын сан хөмрөгтөө анхаарах болсноор үйлчлүүлэгчдийн тоо буурахад хүрч байна. Номын сан барьсан ИДС-иудаас дурдвал, ШУТИС, МУБИС, МУИС, ЭМШУҮИС гэх мэт.

4. Төв номын сангийн чөлөөт сонголттой уншлагын А, Б танхимын 38000 номд RFID мэдээллийг оруулж, номын ялтас наасан. Нийт ажлын 64 өдөр зарцуулсан.

3.3. Солилцоо болон зөөврийн үйлчилгээ

Номын сангийн тухай хууль болон БСШУ-ы Сайдын 2010 оны 570 дугаар “Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал” тушаалын дагуу **32** удаа **2023** ширхэг номоор 2500 гаруй хүнд хүргэлээ.

- Багануур дүүргийн Соёлын ордны номын сантай 1 жилийн зөөврийн уншлага хийх гэрээтэй ажиллаж 74 нэрийн номоор нийт 2 удаа,

- Нийслэлийн 380 жилийн ойд зориулан алслагдсан дүүргийн Гачуурт тосгоны 85-р сургуулийн 4в ангийн сурагчдад АХА тэмцээн зохион байгуулахад зориулж, Нийслэлийн түүх соёлын тухай 20 нэрийн номоор 1 удаа,
- 429-р хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт 22 нэрийн номоор 1 удаа,
- Хууль зүйн үндэсний хүрээлэнд 14 нэрийн номоор 1 удаа,
- ШШГЕГ-ЫН харьяа хаалттай хорих 411-р ангид 100 ширхэг номыг 1 удаа,
- Иргэдийн амралт, аялалын цагаар Улаанбаатар- Сүхбаатар- Байгаль нуурын чиглэлд зохион байгуулагдсан аялалд “Зуны уншлага- 365” 100 ширхэг номоор 1-удаа
- *1* дүгээр сарын 4-5 нд “Оюунлаг төрийн албан хаагч” аянаар Улаанбаатар-Чойр өртөө хүртэл УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэгийн санаачилсан “Номтой галт тэрэг” төслийн хүрээнд зөөврийн номын сангийн үйлчилгээг УБТЗ-ын ажилтан албан хаагчид болон зорчигчдод дэлхийн болон монголын сонгодог яруу найргийн 36 ширхэг номоор 1 удаа,
- Хан-Уул дүүргийн 13-р хороонд байрлах Зэвсэгт хүчний 120 дугаар цэргийн ангийн 100 албан хаагч, байлдагчдад "Зөөврийн номын сан"-гийн үйлчилгээг 74 ширхэг номоор 2 удаа,
- Баянгол дүүрэг дэх “Вербист” хүүхдийн асрамжийн төвийн 35 хүүхдэд 30 ширхэг номоор 1 удаа,
- Хан-Уул дүүргийн 13-р хороонд байрлах Зэвсэгт хүчний 326 дугаар цэргийн ангийн 83 албан хаагч, байлдагчдад 50 ширхэг номоор,
- Идэр Их сургуульд 5 удаа 160 ширхэг номоор,
- Хан-Уул дүүргийн ЕБ-ын 10-р сургуульд 50 ширхэг номоор 1 удаа
- Ерөнхий боловсролын 58-р сургуульд 40
- Сүхбаатар дүүргийн 1-р сургуульд 45 ширхэг номоор гэх мэт номоор,

Номын сан хоорондын ном солилцоогоор:

14 удаа **935** номоор номын сан хооронд түр солилцоо хийжээ.

- Их засаг Олон улсын их сургуулийн номын сантай хамтран 30 ширхэг номоор,
- Идэр дээд сургуулийн номын сантай 58 ширхэг номоор,
- Шинэ Иргэншил дээд сургуулийн МСҮТ-д 30 ширхэг номоор,
- Отгонтэнгэр их сургуультай 32 ширхэг номоор,
- Улаанбаатар хотын музейтэй 4 ширхэг номоор,

- Алслагдсан дүүрэг Багахангай дүүргийн Соёлын ордны нийтийн номын сантай 2 дахь жилдээ 24 номоор
- Өргөө амаржих газрын номын сантай 35 ширхэг номоор
- Ач АУДСургуулийн номын сантай 110 ширхэг номоор,
- Зохиомж дээд сургуулийн номын сантай 40 ширхэг номоор,
- Шилдэг дунд сургуулийн номын сантай 35 ширхэг номоор,
- СУИС-ийн Театр урлагийн сургуулийн номын сантай 21 ширхэг номоор,
- СХД-н Ерөнхий боловсролын 107 дугаар сургуульд 50 ширхэг номоор,
- СХД-н Ирээдүй цогцолбор 86 дугаар сургуульд 42 ширхэг боть номоор,
- СХД-н Ерөнхий боловсролын 81 дүгээр сургуульд 12 ширхэг номоор,
- "Хайрын билэг" хүүхдийн зусланд 20 ширхэг боть ном гэх мэт.

3.4. Интернет үйлчилгээ

Төв номын сан, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгино-Хайрхан дүүргүүдэд тус бүрт уншигч нарт зориулсан WiFi утасгүй интернетийн үйлчилгээг үнэ төлбөргүй, харааны бэрхшээлтэй иргэд болон олон нийтэд зориулсан 33 ш компьютерийг өдөрт 1 цаг үнэ төлбөргүйгээр ашиглах боломжийг олгосон. ЧД, БЗД, СХД дэх салбар номын сангуудын интернетийг Ситинэт ХХК-ны 2Mbps dedicated хурдаар шилэн кабелийн гэрээ байгуулсан.

БЗД, СХД дэх салбар номын сангуудад засвар орсон тул шинээр байгууллагын сүлжээ зохион байгуулсан.

Үндсэн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернетийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 71.82 Mbps, дунджаар 3.38 Mbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 64.45 Mbps, дунджаар 374.13 Kbps хүрсэн байна. Тайлангийн хугацаанд суурин интернетийг 17443 хэрэглэгч, утасгүй интернетийг 7261 хэрэглэгч ашиглаж, нийт 24684 хэрэглэгчид интернетийн үнэгүй үйлчилгээ үзүүлсэн. Төв болон салбар номын сангуудын интернет үйлчилгээ хэвийн жигд явагдаж байна.

3.5. Фондын бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалтын талаар

2019 оны жилийн эцсийн байдлаар 663 нэрийн 1600ш 32,552,267.08 төгрөгийн тендерийн шинэ ном, 83 нэрийн 289ш 5,575,700 төгрөгийн хандивын ном, 154 нэрийн 175ш 2,221.150 төгрөгийн төслийн ном, 59 нэрийн 59ш 570,500 төгрөгийн төлбөрийн ном, 36 нэрийн 185ш 4,613,000 төгрөгийн номыг худалдаагаар тус тус бүрдүүлэн авч, АСМТ-ийн 76 нэрийн 101 ширхэг гадаад ном, нийтдээ 2464 ш номонд техник ажиллагаа хийж, 1126 нэрийн 2464ш номын мэдээллийг электрон каталогт оруулан, 2464ш баркод хэвлэсэн байна. Бүрдүүлэлтээр авсан бүх номыг Олон нийтэд үйлчлэх тасаг, салбар номын сангуудад хүлээлгэн өгч уншлагад шилжүүллээ.

Хараны бэрхшээлтэй иргэдэд зориулан БСШУСЯ-ны албан ёсны эрхтэйгээр ЕБС-ийн 1-9-р ангийн 50 нэрийн сурах бичиг, 5 нэрийн бусад шинжлэх ухааны, нийтдээ 55 нэрийн 6,565,000 төгрөгийн номыг E-PUB хүртээмжтэй форматаар тусгай хэрэгцээт боловсролын шаардлагад тохируулан бүтээж

бүрдүүллээ.

“Хүртээмжтэй форматын E-PUB цахим ном бүтээх чадавхийг нэмэгдүүлэх” олон улсын 4 өдрийн сургалтыг амжилттай зохион байгуулсан. Сургалтанд МУҮНС, Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Хараагүй хүмүүсийн Инноваци хөгжлийн төв, МУИС, МУБИС, СУИС-ийн номын сан, МХҮХ, ХБ-тэй хүүхдийн 116-р сургууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Дорнод аймгийн нийтийн номын сан, Сүхбаатар аймгийн Хараагүйчүүдийн холбооны салбар зөвлөлийн төлөөллүүд болох нийт 24 хүн оролцлоо.

Дээрх сургалтыг өргөжүүлэн дотооддоо E-PUB хүртээмжтэй форматын ном бүтээх цуврал сургалтуудыг 3 удаа Сүхбаатар аймгийн нийтийн номын сан, СУИС-ийн Соёлын сургуулийн оюутнууд, Хан-Уул дүүрэг дэх салбар номын сан дээр нийт 56 хүн хамруулан зохион байгуулж, холбогдох гарын авлагыг боловсруулсан.

Дэлхийн олон оронд хараагүй хүмүүсийн өргөн хэрэглэдэг “NYDA” компьютерийн дэлгэц уншигч програм хангамжийн монгол хувилбарын нээлтийн үйл ажиллагааг 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдөр зохион байгууллаа.

"NVDA" програмыг компьютер, таблет зэрэгт суулгаж ашигласнаар Microsoft Office, Firefox, Google Chrome, Web Browser, mail, Social media, онлайн банк, интернет, телевиз, онлайн худалдаа гэх мэт бид бүгдийн түгээмэл хэрэглэдэг аппликэшнүүдийг саадгүй ажиллуулах боломжтой юм.

2019 оны 10 дугаар сараас “Хүртээмжтэй технологиор дамжуулан хараагүй хүмүүсийн мэдээлэл хүртэх боломжийг нэмэгдүүлэх” зорилт бүхий CANADA сан, Хараагүй хүмүүсийн инноваци хөгжлийн төв ТББ, Улаанбаатар хотын нийтийн төв номын сантай хамтран “Харааны бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл харилцааны шинэ технологиор дамжуулан чадавхжуулах нь төсөл “- ийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн нийтийн номын сан, ХУД дэх салбар номын санд харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйлчилгээг шинээр нээж, нийтдээ иж бүрэн компьютер 4ш, цахим брайль төхөөрөмж 4ш, дэйзи цахим ном тоглуулагч 4ш, скайнер 2ш, утасгүй интернетийн төхөөрөмж 2ш, чихэвч 4ш, PC яригч 4ш, ширээ 4ш, сандал 4ш зэрэг эд хөрөнгийг хүлээлгэн өгсөн. Мөн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой технологийн сургалтуудыг номын санч нарт болон

харааны бэрхшээлтэй иргэдэд тус тус зохион байгуулсан.

Тогтмол хэвлэлийн захиалгыг чанартай хийж, дугаар ирэлт, хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж, энэ онд төвлөрсөн номын сангийн хэмжээнд 25 нэр төрлийн 4,265,700 төгрөгийн хэвлэл захиалан уншигчдад үйлчилж байна.

Коха програм руу хөрвөсөн үндсэн фондны болон А танхимын 752 нэрийн 4837 ширхэг номын каталогийн мэдээлэлд засвар хийсэн. 2017 онд фондноос хасахаар НӨХГ-аас шийдвэр нь гарсан 5900 гаруй ном хэвлэлийг данс бүртгэл болон каталогоос хаслаа.

МХҮХ-той брайль болон цахим ном нийлүүлэх гэрээ байгуулах гэрээг байгуулж, энэ онд 50 нэрийн дэйзи номыг гэрээгээр хүлээж авлаа.

2018 оны судрын тооллогоор дутагдсан 196 ширхэг судар номыг үнэлэх ажлыг холбогдох газруудаар явж судалгаа хийсний үндсэн дээр үнэлж дүнг гаргасан.

Лавлагаа, номзүйн үйлчилгээ

Мэдээлэл, ном зүйн үйлчилгээний хүрээнд тайлангийн хугацаанд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номын сангийн лавлагааны цахим болон утсаар, амаар нийт **4935** удаа лавлагаа өгсөн байна.



Номзүй

- Дорнын их яруу найрагч Б.Явуухулангийн 90-н жилийн ойд зориулсан намтар ном зүйн гарын авлага,
- С.Буяннэмэхийн зохиол бүтээлээр,
- “Үндсэн хууль”-ийн 95 жилийн ойд зориулсан санамж өгөх ном зүй,
- Монгол-Зөвлөлтийн цэрэг дайчид Халх голын дайнд ялалт байгуулсны 80 жилийн ойд,
- Монголын тамирчид Олимпод оролцож эхэлсний 55 жилийн ойд,
- Нийгэм улс төрийн холбогдолтой нийт 6 нэрийн санамж өгөх ном зүйн бүртгэлийг эмхэтгэн гаргалаа.

Ном зүйн гарын авлагыг хийхээс гадна 2008-2018 оны тогтмол хэвлэлийг өгүүллийн нэгдсэн санд оруулах ажлыг үргэлжлүүлэн хийж байна. Одоогийн байдлаар Улаанбаатар таймс сонинг Үндэсний тогтмол хэвлэлийн мэдээллийн санд оруулж байна.



3.1.6. Ном хэвлэл сэлбэн засах

Урагдаж гэмтсэн нийт **1966 ш** номыг хэвлэлтийн анхны жинхэнэ хэлбэр байдлыг алдагдуулахгүйгээр сэлбэн зассан байна. Үүнд:

- Сэлбэн засагч 670 ш ном
- Төв номын сан 933 ш ном
- ЧД дэх салбар номын сан 80 ш ном
- ХУД дэх салбар номын сан 138 ш ном
- БЗД дэх салбар номын сан 83 ш ном
- СХД дэх салбар номын сан 142 ш ном тус тус сэлбэн зассан байна.

Төв болон салбар номын сангуудын тогтмол хэвлэлүүдийг нийт 310 нэгж, жижүүрийн дэвтэрийг 36 нэгж болгон тус тус хавтасласан байна.

3.1.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд /ХБИ/-ийн мэдээллийн үйлчилгээ

Ярьдаг номын сангийн уншлага, үйлчилгээ

Тайлант хугацаанд 1177 ирцэд 1483 ном олгож үйлчилсний 392 номыг танхимаар, 965 номыг гэрээр, 39 номыг солилцоогоор, 87 номыг зөөврөөр тус тус олгож үйлчилсэн байна.

Харааны бэрхшээлтэй иргэдэд 235 удаа лавлагаа өгсөн. Үүнд: Амаар 159, утсаар 75, мессенжерээр 1 удаа тус тус

өгсөн байна.

Koica олон улсын байгууллагаас зохион явуулдаг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих сургалтын 50 ширхэг гарын авлагыг брайль бичигт хөрвүүлж холбогдох байгууллагуудаар тарааж хэрэглэгчдийн хүртээл болгосон.

“Номын далайд хамтдаа аялъя” уулзалт, чөлөөт ярилцлагыг 4 удаа зохион явууллаа. Үүнд:

“Тархи цэнэглэгч” номын клубыг үндэслэгч Ч.Идэрболд - 20 уншигч

116-р сургуулийн 5”А” ангийн сурагч М.Сод-Эрдэмтэй “Английн алдарт зохиолч Жек Лондоны уран бүтээл” - 3-5-р бүлгийн 20 сурагчид

Идэвхтэн уншигч С.Отгонбаатартай “Номын далайд хамтдаа аялъя” уулзалт, чөлөөт ярилцлагыг “Алтан товч” номоор зохион явууллаа. Уулзалтанд 11 уншигч хэрэглэгч оролцлоо.

МУБИС-ийн нийгэм хүмүүнлэгийн ухааны их сургуулийн, түүх нийгмийн ухааны багшийн 2-р дамжааны оюутан Т. Эрхэстэй “Г.Сүхбаатар Монголын эртний өвөг” номоор чөлөөт ярилцлагыг зохион явууллаа. Нийт 15 уншигч хэрэглэгч оролцлоо.

UB comedy клубыг үндэслэгч Б.Батбилэгтэй уулзалт зохион байгуулсан. Уулзалтанд 15 уншигч хэрэглэгч оролцсон байна.

Нийслэлийн 380 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар музейн эрдэм шинжилгээний ажилтан Э.Очбаяртай уулзалт зохион байгууллаа. Нийт 10 уншигч оролцсон.

LEC төвийн багш С.Ариунтуяатай “Уламжлалт аргаас татгалзаж, англи хэл сурах, бие хүний хөгжлийн талаарх” зөвлөгөө уулзалт зохиосон. Нийт 10 уншигч хэрэглэгч оролцсон.

Уншигч хэрэглэгчдийн хэрэгцээнд тулгуурлан “Англи хэлний ярианы клуб”-ын хичээлийг 10 удаа зохион явуулж, 55 уншигч хэрэглэгч оролцсон байна. Сургагч багш англи хэлний багшаар Л. Уртнасан ажилласан.

Улаанбаатар хотын 380 жилийн ойд зориулсан АХА тэмцээнийг уншигч залуусын дунд явуулж, 1-р байрт идэвхтэн уншигч МСҮС оюутан Тэмүүжин, 2-р байрыг МСҮС-ийн багш Ариун-Эрдэнэ нар эзэлсэн байна.

Хүүхдийн зохиолч О.Сундуйтай уран бүтээлийн уулзалт зохион явуулсан. 116-р сургуулийн бага бүлгийн сурагчдад нийт 70 хүүхэд багачууд оролцсон

байна.

“Эссэ хэрхэн бичих” талаар сургалт зохион явууллаа. Нийт 15 уншигч хэрэглэгч оролцлоо. Сургагч багш Г. Гончигдорж.

Уншигч хэрэглэгчийн хэрэгцээнд тулгуурлан компьютерын ганцаарчилсан сургалтыг зохион явуулсан байна. Сургагч багш Гончигдорж суралцагч Гандрист нийт 40 удаагийн сургалт явагдсан байна.

“Улаанбаатарчууд уншиж байна” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан Дэлхийн номын баярын хүрээнд брайль номын үзэсгэлэнг 45 номоор, цахим номын үзэсгэлэнг 50 номоор тус тус гарган сурталчилсан.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 2 удаа 42 брайль болон цахим номоор гаргаж

сурталчлав.

Тэргүүний уншигч шалгаруулах “Д.Нацагдорж тэмдэг”-ийн болзолыг ХБ-тэй хүүхдийн 116-р сургуулийн 5”А” ангийн сурагч Б.Сод-Эрдэм хангаж, тэргүүний уншигчийн тэмдэг үнэмлэхээ гардан авлаа.

Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэр дээр 11 удаа 57 хүнд 84 номоор зөөвөр уншлага, Налайх дүүргийн СО-ны номын сантай 10 удаа 31 брайль номоор солилцоо хийж хамтарч ажиллалаа.

Хүртээмжтэй хэлбэрийн 50 нэрийн цахим номын цаасан каталогийг брайль болон томруулсан форматаар хэвлэж үйл ажиллагаандаа ашиглаж байна. МУ-ын Газрын зурагт брайль тэмдэглэгээ хийж уншигч хүүхэд багачуудын хүртээл болголоо.

ХБИ-ийн фэйж хуудсуудаар дамжуулан уншигчдын эрэлт хэрэгцээг тогтмол судлан номын сангийн үйл ажиллагааг сурталчлан 5 удаа мэдээлэл оруулсан.

Хараны бэрхшээлтэй хүмүүст зориулсан DAISY төв

Монгол хэлний ярьдаг програм суулгах, тохируулах 22 удаагийн заавар зөвлөлгөө, NVDA дэлгэц уншигч компьютерийн програм ашиглах зааврын талаар 19 удаагийн
зөвлөмж, цахим брайль төхөөрөмж ашиглах 14 удаагийн зөвлөмж, цахим ном тоглуулагчийг ашиглах 10 удаагийн зөвлөмж буюу 2019 онд нийт 65 удаагийн мэдээлэл харилцааны технологийн зөвлөмж өгч үйлчилсэн.

"Туслагч технологийн сургалт"-ыг 5 удаа зохион байгуулж, нийт 210 хүн хамрагдсан. Үүнд:

- Дэлхийн брайлийн өдөрт зориулсан үйл ажиллагааны хүрээнд цахим брайль төхөөрөмж танилцуулах сургалт - 80 хүн
- Дэлхийн номын өдөрт зориулсан үйл ажиллагааны хүрээнд DAISY ном тоглуулагч төхөөрөмж, цахим брайль төхөөрөмж танилцуулах сургалт - 116-р сургуулийн 30 гаруй хүүхдүүд эцэг эхийн хамт
- ХБ-тэй хүүхдийн 116-р сургуулийн 1-5-р ангийн сурагчдад зориулан DAISY цахим ном тоглуулагчийн сургалт - 70 гаруй хүүхдүүд багш нарын хамт
- ХБ-тэй хүүхдийн 116-р сургуулийн 6-12-р ангийн сурагчдад зориулсан сургалт – 30 хүүхэд
- Сүхбаатар аймгийн нийтийн номын сан дээр хүртээмжтэй технологийн сургалт – 42 хүн
- Хан-Уул дүүрэг дэх салбар номын сан - 3 номын санч

“Туслагч технологийн сургалт”-ыг ганцаарчилсан байдлаар Б.Мөнгөнтүшиг, М.Сандуйжав, М.Сод-Эрдэм, Э.Дөлгөөн нарын хүүхдүүдэд тус тус 11 удаа, нийт 36 удаа зохион явуулсан.

Уншлага үйлчилгээнд ашиглагдаж байгаа компьютер, DAISY ном тоглуулагч брайль принтер болон бусад техник хэрэгсэлүүдийн нийт 4 удаагийн саатал доголдлыг тухайн цаг бүрт нь засварлаж ажилласан.

2019 оны 2-р улирлаас эхлэн уншлага үйлчилгээний цахим ном уншигч төхөөрөмжийн тоо ширхэгийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 5 тоглуулагч үйлчилг ээнд оруулах бэлтгэл ажил эхэлсэн бөгөөд шинэ төхөөрөмжинд монгол хэлний ярьдаг

програм суулгаж тохируулах, гарын авлага орчуулах зэрэг ажлууд 100% хийгдэж д уусcан.

Монгол хэлний ярьдаг програмын 3 удаагийн шинэчлэл, NVDA дэлгэц уншигч програмын 4 удаагийн шинэчлэлт, компьютер форматлах, шинээр програм хангамжийг суулгаж тохируулах 14 удаагийн ажил тус тус хийгдсэн.

“Хараaны бэрхшээлтэй иргэдийн брайль болон цахим номын сангийн үйлчилгээний албан ёсны facebook хуудсанд 30 удаагийн мэдээ мэдээлэл оруулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний мэдээллийн “youtube” сувагт 40 удаагийн дүрстэй мэдээлэл оруулсан.

3.1.8. Мэргэжил аргазүйн үйлчилгээ

Зэвсэгт хүчний жанжин штабын Иргэн-цэргийн харилцааны хэлтэс, Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газартай хамтран “Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын номын санч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэдлэг мэдээллээр хангах, номын сангийн үйл ажиллагааны заавар”-ыг хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий сургалтыг нийт 38 номын санчдын дунд 2019 оны 02 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтанд тасгийн эрхлэгч З.Төгсжаргал “Номын сангийн фонд буюу сан хөмрөгийн тухай ойлголт”, “Номын сангийн ангилал” сэдвээр, каталогич Н.Одхүү “Номын сангийн каталог” сэдвээр онолын хичээл, ном ажиллагч М.Мөнхзаяа

“Номын техник ажиллагаа”-ны, ном сэлбэн засагч Ц.Одсүрэн “Ном сэлбэн засах арга, ажиллагаа” чиглэлээр тус тус дадлага хичээлийг заалаа.

“Туслагч технологийн сургалт”-ыг ганцаарчилсан байдлаар харааны бэрхшээлтэй Б.Мөнгөнтүшиг, М.Сандуйжав, М.Сод-Эрдэм, Э.Дөлгөөн нарын хүүхдүүдэд тус тус 7 удаа нийтдээ 28 удаа зохион явуулсан.

“Номоо өөрсдөө сэлбэн засацгаая” сэдэвт ном сэлбэн засах анхан шатны сургалтыг хүүхдүүд болон сургалт авахыг хүссэн хэн бүхэнд нээлттэйгээр зохион байгуулсан.

Нийслэлийн алслагдсан дүүрэг болох Налайх дүүргийн соёлын ордны номын санч Булганд номын данс бүртгэл, ном ангилах арга зүй, каталогжуулалт, техник ажиллагаа сэдвээр тус тус арга зүйн зөвлөгөөг өгч ажиллалаа.

2019 оны 03 дугаар сар 13-ны өдөр Сүхбаатар аймгийн Нийтийн номын сангийн номын санчид тус тасгийн үйл ажиллагаатай танилцаж, цахим үйлчилгээний талаар шинэлэг мэдээлэлүүдийг авч харилцан санал бодлоо чөлөөтэй солилцлоо.



Монгол Улсын Төрийн гурван удаагийн шагналт, Ардын уран зохиолч, XX зууны манлай соён гэгээрүүлэгч Цэндийн Дамдинсүрэнгийн нэрэмжит Дорнод аймгийн төв номын санд “НОМЫН САНЧДЫН БҮТЭЭЛЧ ХАНДЛАГА” сэдэвт сургалтыг 2019 оны 05 дугаарын сарын 21, 22-ны өдрүүдэд зохион явууллаа.

Сургалтанд Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн НБТҮТ-гийн эрхлэгч З.Төгсжаргал "Цахим номын E-Pub формат", "Номын сангийн ББК ангилал, ном ангилах арга зүй", “Зохиогчийн эрхийн хууль”-нд шинээр орсон нэмэлт өөрчлөлт сэдвээр хичээл заалаа.

Сургалтанд аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын сургууль, Сумдын нийтийн номын сан болон сургуулийн номын сан, Дорнод Их сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ХЦ-ийн 0132-р анги зэрэг нийт 40 гаруй номын санчид хамрагдав.

Дэлхийн номын баярын өдрийг тохиолдуулан ОНҮТ, НБТҮТ-аас нийслэлийн алслагдсан дүүрэг болох Багахангай, Багануур дүүргийн соёлын ордны номын сан болон Багануур дүүргийн 5-р хорооны "Номын өргөө" - Иргэний танхимын номын сан, "Оюуны эрин" цогцолбор сургуулийн номын сангуудад 2019 оны 4-р сарын 19, 20-ны өдрүүдэд очиж ажиллалаа. Дээрх номын сангуудад зөөврийн номын сан ажиллуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Мөн Багануур дүүргийн 5-р хорооны "Номын өргөө -Иргэний танхим"-ын номын санд 200 гаруй ном хандивлалаа. Энэ арга хэмжээнд НБТҮТ-ийн эрхлэгч З.Төгсжаргал, ном зүйч О.Долгорсүрэн, номын санч Г.Баяржаргал, Д.Дэлгэрсайхан нар хамтран ажиллалаа.



СУИС-ийн Соёлын сургуулийн Номын сан судлалын ангийн эчнээ зайн сургалтын болон 2,3-р курсын 6 оюутны “Үйлдвэрлэлийн дадлага”-аар Номын нэгдсэн болон нэгбүрчилсэн бүртгэлүүдийн хөтлөлт, номын каталогжуулалт, ном ангилах арга зүй, номын техник ажиллагаа, ном бүрдүүлэлт, ном сэлбэн засах чиглэлээр сургалтуудыг өгч ажиллалаа.

3.2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар

3.2.1. Сар бүрийн сүүлийн 7 хоногийн Мягмар гараг бүрийн Дотоод ажлын өдрүүдэд номын сангийн ажилтнууддаа зориулсан сургалт, уулзалт, тэмцээн зохион байгуулж ажилласан. Тухайлбал:

- Захирал Д.Индра “Харилцааны ёс зүй” сэдвээр
- Олон нийтэд үйлчлэх тасгийн эрхлэгч В.Түвшинтогтох “Сэтгэлгээний онцлогоо тодорхойлон суралцах арга барилаа сонгох нь” гэсэн сэдэвт онол, практик хослосон сургалт
- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн сургагч багш Оюун-Эрдэнэ “Төрийн албаны тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль” сэдэвт сургалт
- “Багийн бүтээлч ажиллагаа, Хэрхэн хандлагаа зөв удирдах вэ?” сэдэвт 1 сая төгрөгийн өртөг бүхий сургалтыг Иргэний нийгмийн байгууллагатай хамтран, үнэ төлбөргүйгээр зохион байгууллаа.
- Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд Монголын Үндэсний Номын Сангаас зохион явуулсан "Номын сангийн үйл ажиллагааны тайлан боловсруулах арга зүйн зөвлөмж" сэдэвт сургалтанд номзүйч О.Долгорсүрэн, ахлах номын санч Г.Баяржаргал нарыг хамрууллаа.

- БСШУСЯ-ны хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газар, Богд хааны ордон музей хамтран зохион байгуулсан “Сэргээн засварлалтын түүх, хөгжил, орчин үеийн сэргээн засварлалтад ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжүүд”, “Тайваны үндэсний хааны ордон музейд ашиглагдаж буй сэргээн засварлалтын тоног, төхөөрөмжүүд” гэсэн сэдэвт сургалтад номзүйч О.Долгорсүрэнг хамруууллаа. Сургалтыг Тайваны үндэсний хааны ордон музейн Бүртгэл, сэргээн засварлалтын хэлтсийн ахлах сэргээн засварлагч Chen po удирдан явууллаа.
- Монголын Улсын Хөдөлмөрийн Яамнаас зохион явуулсан МСҮТ-ийн номын санчдад зориулсан сургалтад тасгийн эрхлэгч В.Түвшинтогтох “Номын санчийн бүтээлч хандлага”, “Номын сангийн мэдээллийн сан”, “Судлаач номын санч” сэдвүүдээр сургалт зохион байгууллаа. Мөн Багшийн мэргэжил дээшлүүлэх Институтээс анхны жилдээ ажиллаж буй ЕБС-ийн номын санчдад зориулан “Номын сангийн каталог зохион байгуулалт” сэдвээр сургалт хийлээ.
- БСШУСЯамны хэрэгжүүлэгч агентлаг Соёл, Урлагийн Газрын захиалгаар Монголын Номын Сангуудын Консорциумаас зохион явуулсан "Мэдээллийн технологи ба номын сан" сэдэвт 14 хоногийн сургалтыг Улаанбаатар хотын нийтийн төв номын санд зохион байгуулж “Цахим мэдээллийн бүрдүүлэлт, зохион байгуулалт, хадгалалт” сэдвээр тасгийн эрхлэгч В.Түвшинтогтох хичээл заасан.
- Номын санч Б.Шүрэнбагана, Номзүйч О.Долгорсүрэн нар Сүхбаатар аймагт “Номын сангийн шинэлэг үйлчилгээ, түүнийг хэрэгжүүлэх нь” сэдвийн хүрээнд сургалт зохион байгууллаа. Мөн Дорнод аймгийн номын санчдад "Номын санчдын бүтээлч хандлага" сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Эдгээр сургалтуудад нийт 60 гаруй номын санч хамрагдлаа.

3.2.2. Номын сангийн менежер карьер институт Доржи Банзаровын нэрэмжит Буриадын их сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд 2 дахь жилдээ зохион байгуулж буй Байгалийн олон улсын зуны сургалтанд боловсон хүчний менежмент сургалтад номын санч Х.Сарантуяа, Б.Шүрэнбагана нар хамрагдаж тус сургуулийн номын сангийн үйл явцтай танилцаж, туршлага судлаад ирсэн. Мөн АНУ-ын элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр Австрали улсын Вена хотод Америк Соёл мэдээллийн төвийн чиглэлээр Б.Шүрэнбагана, Ц.Байгалмаа нар 10 хоног сургалтад хамрагдсан.

3.2.3. Тус номын санд 3-аас дээш жил ажилласан, мэргэжил шаардсан 37 албан тушаалд одоо ажиллаж байгаа ажиллагсдын 36 нь буюу 97,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа.

3.2.4. 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийслэл, Соёл, урлагийн газар болон бусад байгууллагуудын шагналд нийт 23 ажилтнуудыг тодорхойлж нэр дэвшүүлэн холбогдох байгууллагад хүргүүлсэн. Үүнээс 14 ажилтан холбогдох шагнал хүртсэн.

3.2.5. Одоо ажиллаж байгаа ажиллагсдын 52% буюу 33 ажилтанд ур чадварын нэмэгдэл олгож, 5 ажилтны цалингийн шатлалыг ахиулсан. Ажилтан бүрт сар бүр хоол унааны мөнгө 60.000 төгрөг олгодог.

3.2.4. Захиргаа, ҮЭ-ийн хорооны хооронд байгуулсан Хамтын гэрээний дагуу байгууллагын 55 ажилтныг Хавдар судлалын үндэсний төвийн эмнэлэгт урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Мөн нийт албан хаагчийг томуу, томуу төст өвчлөл, тоосны харшлаас сэргийлэх, дархлаажуулах зорилгоор витаминжуулалтын аянг зохион байгууллаа.

3.3. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Тайлант хугацаанд 22 өргөдөл ирснийг бүртгэлийн дэвтрээр болон www.erp.ulaanbaatar.mn цахим системд бүртгэн 100 хувь барагдуулж ажилласан. Хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн 1 өргөдөл байна.

Нийт өргөдлийг агуулгаар нь авч үзвэл:

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног 22 цаг 14 минут байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацааг 2018 оныхтой харьцуулахад /2018 оны 11 хоног 19 цаг 50 минут/ 4 хоног 9 цаг 30 минутаар буурсан байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал тутам буюу 4 удаа гаргаж НЗДТГазар руу хүргүүлж ажилласан. Байгууллагын удирдлага иргэдтэй хийсэн уулзалт байхгүй байна

Дөрөв. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1. Үйл ажиллагааны ил тод байдал:

Тус номын сангаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, уншигчаар бүртгүүлэх, гэрээр ном авахад шаардлагатай баримт бичиг, ажлын цагийн хуваарь, үйлчилгээний журам, дотоод журам, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, арга хэмжээний зар мэдээ зэрэг иргэдэд зайлшгүй шаардлагатай **47** холбогдох мэдээ, мэдээллийг www.pl.ub.gov.mn цахим хуудсаараа мэдээлсэн.



Номын сангийн захирлын 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн “Төлбөрт үйлчилгээний үнийг шинэчлэх батлах тухай” А/01 дүгээр тушаалыг, үйлчилгээ авахад шаардах баримт бичгийн жагсаалт болон холбогдох мэдээллийг хамт ойлгомжтой байдлаар цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулсан байгаа. Номын сангийн тухай хууль, Номын сангийн үйлчилгээний журмыг уншигчдад ойлгомжтой байдлаар зурган болон видео бичлэгээр хийж вэб сайт, мэдээллийн самбар, нийгмийн сүлжээ, номын сангийн үүдэнд байрлах дэлгэцээр тус тус сурталчиллаа.

Номын сангийн эрхлэгч нарын овог нэр, албан тушаал, харилцах утас, ажиллах цагийн хуваарийн хамт цахим хуудсанд болон мэдээллийн самбартаа байршуулсан.

Номын сангаас зохион явуулж буй үйл ажиллагааны талаар ТВ9, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевиз, Гэр бүлийн радио, МОНЦАМЭ агентлаг зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудад ярилцлага, хэвлэлийн мэдээг өгч ажиллалаа.

Нийгмийн сүлжээг ашиглан номын сангаас зохион явуулж буй үйл ажиллагааны талаар шууд дамжуулалт буюу live-ийг 2 удаа зохион байгууллаа.

Соёл урлагийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож номын сангаас зохион явуулж буй үйл ажиллагааны талаарх 450 гаруй танилцуулга, мэдээллийг уншигчдад түгээлээ.

MakerSpace төвийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах, сурталчилгааг олон нийтэд хүргэх үүднээс сошиал медиа ашиглан Фэйсбүүк хуудас шинээр нээсэн https://www.facebook.com/makeuspacemongolia/ хуудсаар нийтдээ 316 удаагийн пост оруулж хамгийн шилдэг пост 11594 үзэгчтэй 169 реакци, 77 таалагдсан санал авсан тус постыг оруулсан. Тус хуудас органикаар 1453 дагагчтай, 1404 лайктай байна.

4.2. Хүний нөөцийн ил тод байдал:

Номын сангийн цахим хуудасны нээлттэй ажлын байр цэсэнд сул орон тооны зарыг 10 удаа байршуулан тухай бүр шинэчилж байгаа. Үүнд: номын санч 1, үйлчлэгч 6, жижүүр 3.

Тав. БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1. Соёл, олон нийтийн ажлын талаар

Төв болон салбар номын сангуудын хэмжээнд соёл, танин мэдэхүйн ажлуудаа Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн дагуу төлөвлөн явуулахын зэрэгцээ өсвөр үе, залуучуудыг соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдлэг мэдээллээр хангахад чиглүүлэн дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Тайлант хугацаанд:

№	Үйл ажиллагааны нэр	2019	
		Давтамж	Хамрагдсан хүний тоо
1	Уулзалт лекц	78	4651
2	Уралдаан, тэмцээн	51	1598
3	Сургалт	81	3346
4	Чанга уншлага	31	944
5	Кино үдэш хөтөлбөр	33	530
6	Мультимедиа лаб үйлчилгээ		331
7	Ганцаарчилсан кино үйлчилгээ	73	325
8	Номын нээлт, хэлэлцүүлэг	17	916
9	Номын үзэсгэлэн	341	1927
10	Зөвлөмж яриа	37	487
11	Тойм яриа	22	598
	Нийт	**764**	**15653**

Эдгээрээс тоймлон үзвэл:

Уулзалт, лекцийн чиглэлээр:

- Улаанбаатар хотын хотын нийтийн төв номын сангаас сар бүр Д.Нацагдоржийн шагналт зохиолчидтой “Уулзалт, өдөрлөг” зохион байгуулдаг бөгөөд 2019 оны 1-сарын 15 ны өдөр Д.Нацагдоржийн шагналт зохиолч, яруу найрагч П.Нямлхагватай уулзалт хийсэн юм. Уулзалтын үеэр “Сэлүүн тэргэл”, “Тэнүүн дэлгэр” романы нээлтэнд зохиолчийн зохиол бүтээлүүдийн хямдралтай, гарын үсэгтэй номын худалдаа явагдлаа. Уулзалтанд 50 хүн хамрагдлаа.
- Дэлхийн яруу найргийн өдрөөр Номын сангаас зохион байгуулсан МЗЭ-ийн шагналт яруу найрагч Л.Мягмарсүрэнтэй хийсэн уулзалтанд МЗЭ-ийн зохиолч, яруу найрагчид, Соёл урлагийн их сургуулийн жүжигчний 2-р дамжааны оюутнууд болон БШУЯ-ны харъяа лаборатори 23 дугаар сургуулийн 65 сурагчид оролцлоо.

- 976 Арт Галлери-тэй хамтран 1-р сургуулийн 11, 12-р ангийн сурагчдад “Уран зургийн түүх ба ойлголт хөгжлийн үе шат” сэдвээр лекц явуулав. Нийт **250** хүүхэд оролцсон.
- БЗД-ийн 20-р хороо Гачуурт тосгоны 85-р сургуулийн 4-р ангийн сурагчдын дунд Д.Нацагдорж тэмдэгийн болзлыг танилцуулаад нэг жилийн хугацаанд хамгийн их ном уншсан сурагчдын номын тэмдэглэлтэй танилцаж, урамшуулж “**Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн”** шагналыг 3 хүүхдэд гардуулан өгч хүүхдүүдэд ном уншихын ашиг тусыг танилцууллаа.



- “Алаш Монголиа” ТББ-тай хамтран Яруу найрагч Х. Байыттай казак оюутан залуустай ярилцлага хийв. Уулзалтад 45 оюутан, залуус хамрагдлаа.
- Дэлхийн номын баярын өдрийг тохиолдуулан Хараагүй иргэдэд үйлчилдэг уншлагын танхимаас Хүүхдийн зохиолч О.Сундуйтай уулзалт өдөрлөгийг зохион байгуулсан ба 116-р тусгай сургуулийн сурагчид оролцсон .Тус өдөрлөгт 60 хүүхэд хамрагдсан.

- Газар дэлхий Бидний гэр Олон улсын хүүхэд залуучуудын 17-р их наадмын өдөрт зориулж Хөгжимчин Д.Энхболдтой уулзалт өдөрлөгийг хийсэн ба тус уулзалтанд 55 хүн оролцсон.

- АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр Монгол улсад ардчиллыг бэхжүүлэх манлайгчдын шинэ үеийг бэлтгэхэд чиглэсэн LEAD Mongolia 2019 хөтөлбөрийн танилцуулга лекц 1 удаа явагдаж 60 хүн хамрагдсан.
- Хариуцлагатай аялцгаая аяны хүрээнд Дэлхийгээр аялцгаая групын хамт олонтой хамтран “Хариуцлагатай аялцгаая” аяны цар хүрээг өргөжүүлэх, гадаадад зорчих иргэдэд албан ёсны мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг түгээх зорилгоор АНУ-н ЭСЯамны Консулын Албаны дэд дарга Jeniffer Upton-тай нээлттэй уулзалтыг зохион байгуулсан ба тус уулзалтад 108 хүн оролцсон.

- Дэлхийгээр Аялагчид Клубийн Уулзалт #18-аар Их зохиолч Д.Нацагдоржийн алс газар сурахаар одсон мөрийг мөшгөсөн **"Найрагчийн мөрөөр" аялал**ын багийнхантай уулзалт зохион байгууллаа. Тус багийн хамт олон аялалд гарахынхаа өмнө Улаанбаатар хотын нийтийн төв номын сангаас их зохиолч Д.Нацагдоржийн намтар, уран бүтээлтэй холбоотой ном, материалуудыг авч ашиглан, заримыг нь аялалынхаа турш ашиглаж байсан юм.

- Монголын номын санчдын **Librarian Update-2019 зөвлөгөөн**ийг Mongolian Libraries Consortium - Монголын Номын Сангуудын Консорциум, Соёл урлагийн их сургууль, UB Public Library - Хотын Төв Номын Сан, German Mongolian Institute for Resources and Technology - GMIT зэрэг байгууллагууд хамтран зохион байгууллаа. Зөвлөгөөнд 70 гаруй байгууллагын 110 гаруй номын санч мэдээллийн ажилтан хамрагдлаа.

- **Америкийн тухай цуврал лекцүүд:** Америк гэр бүл, мужууд, өмнөд зүгийн гар урлал, амралт чөлөөт цагийн талаар цуврал лекцүүд явагдлаа. Мөн 1973 онд Монгол, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох оролдлогыг тухай лекцүүд зохион байгуулагдлаа.

Уралдаан, тэмцээн:

- Нийтийн уншлагын "А" танхимын ахлах номын санч Г.Баяржаргал, номын санч Д.Дэлгэрсайхан нар Баянзүрх дүүргийн 85 дугаар сургуулийн н.Сувдаа багштай 4 б ангийн 31 сурагчдын дунд "Улаанбаатар хотын 380 жилийн ойд" зориулж "АХА" тэмцээн зохион байгууллаа.

- Үндэсний бичиг үсгийн баярыг угтан "Алтан үсгийн цоморлог-2019" уралдааныг 3 дахь жилдээ зохион байгуулж 10 гаруй материал хүлээн авч, эхний дөрвөн байрыг шалгаруулаа. Уг уралдааныг номын санч Х.Сарантуяа, Ж.Мөнхжаргал нар амжилттай зохион байгуулж байна.

- 4в ангийн 31 сурагчдад Д.Нацагдорж тэмдэгийн болзлыг танилцуулаад 1 жил болж байна. Энэ нэг жилийн хугацаанд хамгийн их ном уншсан сурагчдын номын тэмдэглэлтэй танилцаж, урамшуулж “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн” шагналыг 3 хүүхдэд гардуулан өгч хүүхдүүдэд ном уншихын ашиг тусыг танилцууллаа.
- Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан фэйсбүүк буюу нийгмийн сүлжээний “Үндэсний бичиг үсгийн баяр” хуудсаар шууд дамжуулан үзүүлсэн лайвыг хамгийн олон шэйр хийсэн, асуулт асуусан хүнийг номоор шагнах уралдааныг зарлаж, шалгаруууллаа.
- МУИС-ийн дэргэдэх Утга зохиолын нэгдэлтэй хамтран "Чөлөөт сэтгэлгээний дуулал-2019" яруу найргийн наадмыг зохион байгууллаа. Наадамд 80 гаруй хүн хамрагдлаа. Идэр дээд сургуультай хамтран “Шинэ толь-2” улсын уралдааныг хоёр дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Уралдааныг Монголын Үндэсний номын сан, ИИС-ийн Номын сан, Монгол уламжлал академийн хамтран зохион байгууллаа. Энэхүү уралдаан нь “уран бичлэг”, “яруу найргийн” гэсэн хоёр төрлөөр явагддаг бөгөөд 2019 оны 5 дугаар сарын 17-нд МУҮНС-ийн МУ-ын Ерөнхийлөгчийн нэрэмжит танхимд боллоо.
- “BOOK QUIZ” -номын таавар хөгжөөнт уралдаан тэмцээн уншигчдын зохион байгуулсан. Нийт 6 баг 17 уншигч оролцсон. Тэргүүн

Маргад Д.Зөнбилэг, Х. Нинжин нар тэргүүллээ.

- Англи хэлний илтгэлийн клуб 7 удаа сургалт зохион байгуулж, сургалтын эцсээр уралдаан явуулж дүнгээ гаргалаа. Сургалт, уралдаанд нийт 109 хүн хамрагдсан байна.
- Ач АУИС-ийн 60 гаруй оюутан, 11-р сургуулийн 100 гаруй сурагчдын дунд АХА тэмцээн зохион байгууллаа.

Сургалт:

- **“3D принтер ажиллуулах, Arduino төсөл хийх” сургалт**: Энэхүү сургалтыг 2 удаа зохион байгуулсан бөгөөд сургалтын зарыг олон нийтэд нээлттэй явуулснаас анхны сургалтанд 48 хүний материал ирснээс 2-р шатанд 28 сурагчийг ярилцлаганд оруулан анкетын аргаар судалгаа хийж сүүлийн шатанд 16 сурагчийг шалгаруулан сургалт амжилттай зохион байгулсан. 2 дахь удаагийн сургалтыг дээрх журмаар явуулж танхимын хучин чадалтай холбогдуулан нийтдээ 12 хүүхдийг шалгаруулсан. Сургалт 2019.04.17-нд эхлэж сурагчид маань төгсөлтөндөө бэлтгэж өөрсдийн сургалтаас авсан мэдлэг чадвар дээр тулгуурлан шинэ бүтээлүүдээ хийж байна. Тус сургалтанд ЕБС-ын 7-12-р ангийн 13-16 насны сурагчид 7 хоногт 6 цагаар 8 долоо хоногийн Электроник, 3D загварчлал, Багийн ажиллагаа гэсэн сэдвүүдээр эрчимжүүлсэн сургалтанд хамрагдаж нийтдээ 27 хүүхэд амжилттай төгсөн сертификат гардан авсан. Эхний төгсөлтийн арга хэмжээ 2019.04.12-нд Хөтөлбөрийн танхимд явагдсан. Тус арга хэмжээнд АНУ-аас МУ-д суугаа элчин сайд Майкл Клечески, ХТНС-ын захирал Д.Индра нар оролцон төгсөгчдөд сертификат гардуулсан. Мөн арга хэмжээний МейкЮспэйс танхимын албан ёсны нээлтийг хийж нийт 60 гаруй хүн хамрагдсан байна.

- “My first English” англи хэлний анхан шатны сургалт 7 хоногт нэг удаа явуулж байна. Нийт 18 удаа бага ангийн **278** сурагчийг хамруулжээ.
- 3 дугаар сарын 13-нд Номын сан танилцуулах хэсэгчилсэн сургалтаар Сүхбаатар аймгийн нийтийн номын сангийн **7** номын санчид ажлын туршлага солилцох хөтөлбөрийн хүрээнд номын сангийнхаа тасаг нэгжүүдийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй танилцуулж ажилласан.

- Англи хэлний багш нарт зориулагдсан англи хэлний заах арга зүйн сургалт 13 удаа явагдаж 249 хүн хамрагдсан.
- Англи хэлний илтгэлийн клуб 11 удаа зохион байгуулагдаж 393 хүн хамрагдсан.

- Хүүхдийг хамгаалах сангаас ЕБС-н сурагчдын дунд зохион байгуулсан Дэлхий залуу энтрепренер хэрхэн болох? Сургалт 1 удаа явагдаж тус сургалтанд 9 сургуулийн 65 сурагч хамрагдсан.
- Зориг сан Америкт Сургууль Төгсөгчдын Холбоотой хамтран “Сошиал Энтрепренер” сургалтыг нийгмийн салбар бүрийн идэвхитэй залуусыг хамруулан хийсэн ба тус сургалт 4 удаа зохион байгуулагдан 21 оролцогч хамрагдсан.
- Зориг сангаас Орон нутгийн байгаль орчны манлайлал хөтөлбөрийн хүрээнд нийслэл, орон нутгаас шалгарсан 21 оролцогч хамрагдсан тус сургалт 2 удаа явагдсан.

- Монголын 4 навч ТББ–с Аксес хөтөлбөрийн сурагчдад зориулан гарааны бизнесийн талаар болон , хэрхэн бизнес эрхлэх бизнесийн үнэ цэнэ гэж юу болох,бизнесийн ерөнхий ойлголтын талаарх сургалтыг Эерэг Нөлөө ТББ тай хамтран зохион байгуулсан. Уулзалт 1 удаа зохион байгуулагдаж 24 хүүхэдийг хамруулаад байна.

- ЕБС-н сурагчдад зориулсан Тоглоомын өдөр хөтөлбөр 2 удаа зохион явагдаж 56 хүүхэд хамрагдсан.
- ЕБС-н сурагчдад зориулсан Англи хэлний клубын хөтөлбөр 2 удаа явагдаж 77 хүүхэд хамрагдсан.
- Англи хэлний багш нарт зориулагдсан заах арга зүйн сургалт 2 удаа 75 оролцогч
- Англи хэлний туслах багш нарын сургалт 1 удаа 40 багш
- Англи хэлний илтгэлийн клуб 7 удаа зохион байгуулагдаж 109 хүн хамрагдсан.
- Монголын 4 навч ТББ–с Аксес хөтөлбөрийн сурагчидийн сургалт 1 удаа явагдаж 28 хүүхэд
- АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр Монгол улсад ардчиллыг бэхжүүлэх манлайгчдын шинэ үеийг бэлтгэхэд чиглэсэн LEAD Mongolia 2019 хөтөлбөрийн сургалт үйл ажилллагаа 4 удаа явагдаж 125 хүн
- Америкийн Монгол Судлалын Төвөөс зохион байгуулсан Хээрийн сургууль 2019 хөтөлбөрийн оролцогчидод зориулсан танилцуулга 2 удаа явагдаж 120 оролцогч

Байгаль орчинд ээлтэй дахин загварчлах, хуучин хувцас сэргээх, шинээр өөр хэрэгцээт зүйлсээ хийж сурах зорилготой оёдлын сургалтыг загвар зохион бүтээгч И.Урангоотой хамтран нийтдээ 17 удаа зохион байгуулж 141 хүн хамрагдсан байна. Сургалтын зарыг олон нийтийн сүлжээгээр мэдээлж, арга хэмжээний хүрдэнд эвент үүсгэх, олон хэрэглэгчийг татахад анхаарч мөн үр дүнг олон нийтэд нээлттэй сурталчилсан. Мөн Нийслэл гайд сэтгүүлд мэдээлэл өгч ажиллалаа. Сургалтаар Даавууны өөдсөөр эко тор хийх, Бэлэг дурсгалын зүйл, Шил

Re-Designed
Насны ангилал: 3+
Сургалтын чиглэл: Даавууны өөдсөөр хүүхэлдэй, дэр, цүнх хийх, хуучин хувцсыг засварлан загвар өөрчлөх

Тэд хуучин хувцсыг дахин сэргээх, шинэлэг хэв шинжтэй болгох, материалыг үлдэгдэлгүй ашиглах, эдийн засгаа хэмнэхийн сацуу байгальд ээлтэй зөв амьдрах хэв маягийг түгээхийг зорилгоо болгодог. Нийгмийн хариуцлагатай, бүтээлч хандлагыг бий болгохыг уриалдаг тэдний хаалга өөрийгөө дайчлан юмханаар юм хийж, шинэлэг сэтгэхийг хүссэн хүн бүрийн өмнө нээлттэй. Та урьдчилан цаг авч бүртгүүлээд үнэ төлбөргүй хамрагдаарай.

Нацагдоржийн номын сангийн I давхарт

чимэглэх, Номын хавтас, Хуучин хувцасны загвараа өөрчлөх, Хувцас чимэглэх зэрэг хичээл орсон.

Чанга уншлага:

- “Ухаалаг Монгол Хүүхэд” уншлагыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 149-цэцэрлэгийн дунд бүлгийн хүүхдүүдэд “Бумбардай” комик номоор чанга уншлага хийв.

- Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Сүхбаатар дүүргийн 214 цэцрлэгийн бэлтгэл бүлгийн 40 хүүхдэд “Унших дуртай болмоор байна” сэдвээр чөлөөт ярилцлага хийж номын сангаар хэрхэн үйлчлүүлэх тухай заавар, зөвөлгөө өгч, Х.К. Андерсоны үлгэрүүдээр чанга уншлага хийв.
- Хан-Уул дүүргийн 10-р сургуулийн н.Энхболор болон н.Чимэдмаа багштай $2^{б,в}$ ангийн сурагчид, “Ана кушагы” өдөр өнжүүлэхэд “7 ишиг” үлгэрээр үлгэрчилсэн тоглолт болон чанга уншлага тус тус хийв.
- Нийслэлийн 40-р цэцэрлэгийн С. Цэцэгмаа багштай бэлтгэл бүлэгт “Номын сантай танилцья” уулзалт болон “Миний дуртай үлгэрийн баатар” сэдвийн дагуу 40 хүүхэд чанга уншлага хийв. Чанга уншлагыг хүүхдийн уншлагын танхимын номын санч Ж.Рая амжилттай зохион байгуулж байна.

Кино үдэш хөтөлбөр

1. Америкийн түүхэн сард зориулан гаргасан кино:
   - Morris From
   - The Butler
   - Malcolm X
2. Эмэгтэйчүүдийн түүхэн сард зориулан гаргасан кино:
   - Hidden Figures
   - Dark Girls
   - Pritty Woman

3. Дэлхийн өдөрт зориулан гаргасан кино:
   - Avatar
   - The 11th Hour
   - Finding Nemo
   - Good Will Hunting
4. Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг угтан гаргасан кино:
   - Mele Murals
   - The Legends of Jazz with
   - Forest Gump
   - The Lorax

Номын нээлт, хэлэлцүүлэг

- П.Нямлхагвын “Сэлүүн тэргэл”, “Тэнүүн дэлгэр”,
- Т.Мягмартогтохын “Дээд айл”,
- Б.Галаарид “Урианхай өргөжин тэлсэн түүх”,
- Д.Даваадулам “Оргил өөд”,
- Ш.Солонго “Хагацсан нутаг”,
- Л.Ганчимэг “Намайг өөрчилсөн 85 эмэгтэй”,
- А.Цэрэнчулуун “Цагаан сарнай”,
- Б.Баясгалан “Дур булаам”
- Н.Ваня “Мөнгөн өвс”,
- Я.Отгонбаяр “Гуч хүрсэн бүсгүй”,
- Г.Лхагвадорж “Сэтгэл бид хоёр”
- Вольф Дурианы “Хайрцагнаас гарч ирсэн Кай хүү”,
- Ж.Нарангарав “Тэнгэрийн хүлэг тахь”,
- Г.Отгонсүрэн “Аав орчлон” гэх мэт.



Номын үзэсгэлэн

- Ховор номын үзэсгэлэн/15 ширхэг судар, Монгол бичгийн 6 ширхэг номоор/,
- Д.Сүхбаатарын мэндэлсэний 126 жилийн ойд 15 ном, өнгөт 28 зураг,
- Валентины өдөрт 28 ном,
- Март-8 Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалаах өдөр 31 ном,
- Наурызын баяр 33 ном,
- Ардын уран зохиолчдын зохиол бүтээлүүд 98 ном,
- Ю.А.Гагарины 85 жилийн ойд зориулан 28 номоор үзэсгэлэн,
- Дэлхийн номын баярын өдөрт зориулан 140-1960 аад оны хуучны мартагдсан 57ш номоор,
- Хүүхдийн эрхийн хамгаалах өдөрт зориулан 1950-1980 оны хүүхдийн 34 номоор,
- Дэлхийн тамхигүй өдөрт /5-р сарын 31/ зориулан хэв мат, болон 12 номоор,
- “Монгол Улсын үндсэн хуулийн өдөр”-т зориулан 15 ширхэг номоор,
- “Цагаан сар” үзэсгэлэн 18 ширхэг ном, 12 ширхэг хэвлэмэл материалаар,
- “Номын санч” сэдэвт үзэсгэлэн 25 ширхэг номоор,
- “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-т 19 ширхэг номоор,
- “Эх ороночдын өдөрт” зориулсан үзэсгэлэн 18 ширхэг номоор,
- “Монгол цэргийн өдөр”-т зориулан үзэсгэлэн 20 ширхэг номоор,
- “Олон улсын сансрын нисгэгчдийн өдөр”-т 22 ширхэг номоор,
- “Түүхийн эх сурвалж” сэдэвт байнгын үзэсгэлэн 54 ширхэг номоор,
- “Ногоон хувьсгал” сэдэвчилсэн үзэсгэлэнг 22 ширхэг номоор,
- “Ном солилцоо”-ны 21 ширхэг номоор,
- “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр”-т зориулан 15 ширхэг номоор,
- “Аугаа их эх орны дайны ялалтын ойд”-т зориулан 21 ширхэг номоор,
- “Үндэсний бичиг үсэг-2019” өдөрт зориулан 20 ширхэг номоор,
- “Олон улсын гэр бүлийн өдөр”-т зориулан гэр бүлийн боловсрол сэдвээр 25 ширхэг номоор тус тус үзэсгэлэн гаргалаа.
- Mongolian Library Update-2019 улсын VI дахь удаагийн зөвлөгөөнд “НОМЫН САН СУДЛАЛ” мэдээлэл сэдэвчилсэн үзэсгэлэнг 38 ширхэг номоор,
- Хүүхдийн зохиолч О.Сундуйн номын үзэсгэлэн 12 ширхэг номоор,
- Хүүхдийн хөгжилд туслах танин мэдэхүйн АПП-ууд үзэсгэлэнг 4 ширхэг хэвлэмэл материалаар,
- Ногоон орчин байгаль эх дэлхийгээ хайрлая үзэсгэлэнг 4 ширхэг хэвлэмэл материалаар,
- Цэвэр агаар-Цэнгэг ус 11 ширхэг хэвлэмэл материалаар,
- Элсэлтийн ерөнхий шалгалт 9 ширхэг хэвлэмэл материалаар,
- Зохиолч Д.Жамъяаны 9 ширхэг номоор,
- Халх голын 80 жилийн ойд зориулан “Бид мартахгүй 1939 он” 12 ширхэг номоор
- Үндэсний номын баярт зориулан “Номтой нөхөрлөе” 20 ширхэг номоор
- Барилгачидын баярт зориулан 13 ширхэг номоор,

- Философийн өдрийг тохиолдуулан философийн номын үзэсгэлэнг 46 ширхэг номоор,
- “Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолын өдөрт-6ш ном,15 ш хэвлэмэл хуудас
- “Цагаан сар,ёс заншил” 3ш ном,18 ш хэвлэмэл материал
- Д.Сүхбаатарын мэндэлсний 126 жилийн ойд “Д.Сүхбаатарын намтар 17ш ном,11ш хэвлэмэл хуудас,12ширхэг зурагт хуудсаар,
- Олон улсын эх хэлний өдөрт 16ширхэг номоор
- Гэгээн хайрын өдөр буюу Валентины өдөрт 9ширхэг ном, 4ширхэг хэвлэмэл хуудас
- А.М.Горькийн мэндэлсний 150 жилийн ойд зориулан “А.М.Горькийн намтар уран бүтээлийн тухай “-15 ш ном, 4ш хэвлэмэл хуудсаар
- Дэлхийн яруу найргийн өдөрт 24ш номоор
- “Марта 8” үзэсгэлэнг 6ш ном, 6ш захидал
- “Иргэний нийгмийн өдөр” үзэсгэлэн 8ш ном
- “Цэргийн баяр”т зориулж эрчүүд уран зохиол үзэсгэлэнг 10ш ном
- “Дэлхийн усны өдөр”-т зориулж 9ш хэвлэмэл 2ш ном,
- Олон улсын инээдмийн баяр(4-р сарын 1)-ны өдөрт зориулан 30 ш ном, 2ширхэг хэвлэмэл хуудас,
- Дэлхийн эрүүл мэндийн өдөрт зориулан “Монголчуудын эрүүл амьдрах ухаан,Эрүүлжих ухааны талаарх 18 ширхэг номоор сэдэвчилсэн үзэсгэлэн гаргав. Мөн эрүүл мэндэд хэрэгтэй 15 зөвлөмжийг хэвлэмэл материал,
- Мод тарих үндэсний өдөрт зориулан "Мод бол хүчилтөрөгч үйлдвэрлэгч" сэдэвт үзэсгэлэнг 10ш хэвлэмэл материал,
- Номын сангийн уншигч хүүхдүүдийнхээ танин мэдэхүйн мэдлэгийг өргөжүүлэх зорилгын хүрээнд " Хүүхэд бүрийн гарын ном" сэдэвт үзэсгэлэнг лавлагааны 9ш ном,
- Дэлхийн номын өдөрт зориулан "Орос ардын үлгэрүүд" (1960-2004) 20ш ном, "Дэлхийн шилдэг үлгэрүүд" 36ш ном,
- Хүүхдийн зохиолч Ш.Энхбаярын уран бүтээл 27ш ном,
- Үндэсний бичиг үсгийн баяр тохиолдуулан "Эх хэлний тань мэдлэгт", мөн "Монгол бичгийн түүхээс "үзэсгэлэнг 10 ш ном,10 ш хэвлэмэл хуудас 14 ш бүтээл, уйгаржин Монгол бичгээр 20 ширхэг ном, Монголчуудын бичиг үсгийн түүхийг 10 ширхэг хэвлэмэл хуудас,
- Бага насны уншигчид даа зориулан "Танин мэдэхүй"-н холбогдолтой 25ш ном,
- Аугаа эх орны дайны ялалтын 74 жилийн ойд зориулан 1941-1945 оны дайнд баатарлагаар тулалдаж эх орноо хамгаалж, амь насаа алдсан зөвлөлтийн эх орны баатрууд, алдарт жанжнуудын тухай 16ширхэг ном,
- Дэлхийн Сувилагч нарын өдөрт зориулан 12ш ном,
- “Олон улсын музейн өдөрт зориулан нийслэл Улаанбаатар хотод байдаг Монголын үндэсний музей,Монголын дүрслэх урлагын музей, Чойжин сүм ламын музей,Богд хааны музейн түүхийг товч дурдсан 8ширхэг хэвлэмэл хуудас,
- ЭЕШ-д бэлтгэгчдэд зориулан 13ш гарын авлага,
- Уран зохиолын тань мэдлэгт 10ш ном,
- Дэлхийн тамхигүй өдөрт зориулан тамхины хор уршгийн тухай 10ш хэвлэмэл материал,
- Хүүхдийн баярт зориулан "Хүүхдийн инээд_бидний аз жаргал" үзэсгэлэн 9ш ном,
- Багш нарын баярт зориулан ”Багшийн мэргэжил заах арга зүйн” талаарх 13 ширхэг ном,
- ”Ухаан далай номоос эхтэй” номын үзэсгэлэнг нийт 11 ш ном, ”Ном унших арга,уншлагын соёлын талаар 2 ш хэвлэмэл хуудас,
- ”Олон улсын охидын эрхийг хамгаалах өдөрт зориулан 11 ш ном,
- ”Мод тарих үндэсний өдөрт зориулан “Тасалгааны ургамал, цэцэг ургуулах, Тасалгаанд тариалах жимсний модны талаарх 9 ш ном,

- “Улаанбаатар хотын түүхэн замналаас” 3ш ном, 9 ш хэвлэмэл хуудас,
- "Зөв хооллолт эрүүл амьдралын үндэс" 9ш ном, 6 ш хэвлэмэл хуудас,
- Улаанбаатар хотын түүх,Нийслэлийн өв соёл, хүрээ хийд,УБ хотын хүн амын тухай холбогдох 29ш ном болон 7ш материал,
- “Үлгэрийн ертөнцөөр аялцгаая” сэдэвт монгол ардын үлгэрийн 16 ш ном,
- Их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсний 113 жилийн ойд зориулан 14ш ном, 7ш бусад материал зэргээр тус тус үзэсгэлэн гаргалаа.

Үзэсгэлэн худалдаа:

- Дэлхийн номын өдөр: Номын худалдаа эрхэлдэг 13, хувь уран бүтээлч 19 оролцогчтой номын хямдралтай, үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагаанд 500 гаруй иргэд хамрагдлаа.

- Цагаан сараар ном бэлэглэе. Номын худалдаа эрхэлдэг 15, хувь уран бүтээлч 22 оролцогчтой номын хямдралтай, үзэсгэлэн худалдааг Цагаан сарын баярыг тохиолдуулан зохион байгууллаа. Уг үзэсгэлэн худалдаанд 700 гаруй иргэд хамрагдсан юм.

- Бяцхан хайгуулч номын өдөрлөг

Хүүхдийн баярыг угтан үр хүүхэддээ чихэр биш дуртай номыг нь авч бэлэглэхийг уриалан, зохиолчийн гарын үсэгтэй хямдралтай номын худалдааг зохион байгуулсан.

Тус арга хэмжээ нь 2019.05.31-ний 10:00-18:00 цагийн хооронд "Улаанбаатар хотын номын сан"-гийн гадна талбайд болсон бөгөөд өдөрлөгийн үеэр урлагийн үзүүлбэрүүд, гэр бүлийн хөгжөөнт уралдаан, тэмцээнүүд явагдсан.

Өдөрлөгт хүүхдийн зохиолч Д.Давааням, Н.Мандал, О.Сундуй, Ш.Энхбаяр, Д.Далхжав, З.Ядмаа Э.Амарзаяа, зохиолч Э.Эрдэнэцэцэг нар арга хэмжээнд маань зочноор ирж, "Интерном", "Монсудар", "Азхур", "Мажестик", "Сэлэнгэ пресс", "Мирном", "Book zone kids", "Ganuna publishing", "empathy" зэрэг ном хэвлэлийн салбарын тэргүүлэгчид цугларч, хямдралтай номын худалдаанд оролцсон.

5.2.

Цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт. Үүнд:

- Номын санд жилдээ ном бүрдүүлэлтэд 21 сая төгрөг төсөвлөгддөг. Үүнээс 4,5 сая нь хэвлэл захиалгад, үлдсэн нь ном бүрдүүлэлт. Уншигч, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээтэй номуудыг худалдан авахад 35%-ийг л хангаж байна. Энэ нь номын сангийн нийт зардлын 3 хүрэхгүй хувийн эзэлдэг. Иймд уншигчдын эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн номуудаар номын бүрдүүлэлт хийхэд төсөв мөнгөний хувьд хангалтгүй, хүрэлцээ муутай байна.

- Нийслэлийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн "Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" А/920 дугаар захирамжаар 80 хүний орон тоотой баталсан. Батлагдсан цалингийн төсвөөр 68 ажилтан ажиллахаар төсөвлөгдсөн байна. Цалингийн төсөв хүрэлцэхгүй ирсний улмаас өвчтэй, чөлөөтэй, хүүхэд асрах чөлөөтэй ажилтны оронд шинээр ажилтан авч ажиллуулахгүй явсаар ирсэн. 2019 оны 02 дугаар сараас эхлэн хүүхэд асрах чөлөөтэй болон өвчтэй, чөлөөтэй байсан ажилтнууд эргэн ажилдаа орох, мөн ажлын зайлшгүй шаардлагаар нэмж шинээр ажилтан авч ажиллуулж байна. Иймээс номын сангийн цалингийн төсвийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ХҮҮХДИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ЗАХИРАЛ ДАМДИНСҮРЭНГИЙН ОЮУНБИЛЭГИЙН 2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
(Илтгэх хуудас)

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт хэрэгжүүлэх арга хэмжээ	*Арга хэмжээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт / тоо, чанар, хугацаа/*	*Хэрэгжилтийн тайлан*	*Өөрийн үнэлгээ*	*Үнэлгээний багийн үнэлгээ*
1		2	3	4
А.НИЙТ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ				
Нэг. “Үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил үйлчилгээ				
1.1.1 Номын худалдаа, нөхөн бүрдүүлэлтээр төсөвлөсөн төсөвт багтаан уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн ном авна	Фондуудад 800нэр төрлийн 2500 номоор бүрдүүлэлт хийх	Энэ жилд 948 нэрийн 3044 ш ном , 41 ш CD, 26 ш DVD нийт 3111 ширхэг 37 сая 842 мянган 300 төгрөгний ном, сонин, сэтгүүл бүрдүүллээ. Үүнээс: -Улсын төсөвөөр 26 сая 357 мянга 110 төгрөгийн ном хэвлэл -Зохиолч хэвлэлийн газруудаас бэлгээр 11 сая 485 мянга 300 төгрөг, 6500 еврогийн ном хэвлэл, хэвлэмэл бус материал бүрдүүлэв.	100	
1.1.2 Гёте Институт, Тайваний Үндэсний номын сангаас ном авч фондын баяжилтыг сайжруулна.	Фондын бүрдүүлэлтийг бэлгийн ном хэвлэлээр баяжуулах	Нийт 6500 еврогийн санхүүжилтээр Ханс-Зайделийн Сангаас 6 ш ном, Гетё-Институтээс 324 ном, 179 CD, 26 DVD, 145 ш тогтмол хэвлэлийн баяжилт хийгдсэн. Тайваний Үндэсний номын сангаас 136 номыг шинээр бэлэглэсэн.	100	
1.1.3 Бүрдүүлэлтээр авсан шинэ номыг шинжлэх ухааны төрөл салбараар ангилан	Бүрдүүлэлтээр орж ирсэн 2500 номыг ангилах	65 баримтын 2582 ширхэг ном, 64 ширхэг CD-ийг шинээр ангилж дансалсан.	100	

уншигчдын хэрэгцээнд нийлүүлнэ.				
1.1.4 Бүрдүүлэн авсан шинэ номонд тэмдэг дарж, шифрлэн данс бүртгэлд тусгана.	Шинээр авсан 2500 номонд техник ажиллагаа хийнэ	Нэгдсэн бүртгэлийн 901-955 дугаар хэсэгт 55 фактурын 781 нэр төрлийн 2581 ширхэг ном, 18 төрлийн 46 ширхэг CD-г бүртгэсэн. Техник ажиллагаанд дээрх ном хэвлэлийг ангилж данслан уншлагын танхимуудад хүлээлгэн өгсөн.	100	
1.1.5 Бүрдүүлэлтээр орж ирсэн номыг шинээр каталогжуулан уншигчдад цаг тухай бүр нь хүргэнэ.	Бүрдүүлэлтээр орж ирсэн номонд карт бичих	2019 онд нийт 826нэр төрлийн 2644ш номонд номзүйн бичилт хийж электрон каталогт оруууллаа.	100	
1.1.6 Холбогдох каталогуудад цаг тухайд нь байрлуулна.	800 нэрийн 5000 карт байрлуулах	1297 картыг хэвлэн гаргасан. Бүгд 2434ш картыг мэдээллийн баазаас хэвлэн гаргасан байна. Төрөл болон үсэг дарааллын каталогт нийт 2434ш картыг ламинатордан байрлууллаа. Нийт 6165.	100	
1.1.7 Каталогт байнгын хяналт тавих	20000 картанд редакци хийх	Каталогчид нийт 21000ш картанд редакц хийж элэгдэж урагдсан 99ш картыг ялгаж авсан. Цаасан карт хэвлэхийн өмнө электрон каталогт шинээр оруулсан 826 нэр төрлийн номын бичлэгийг шалгаж алдааг тухай бүрд нь засаж редакци хийв. Электрон каталогийн баазаас нийт 700 ш картыг хэвлэн гаргав. Төрөл анги болон үсэг дарааллын каталогоос давхардсан нийт 41ш картыг хасалт хийсэн. Каталогчид нийт 171 удаа жижүүрт гарч аман ба бичгийн лавлагаа өгч ажилласан.	100	
1.1.8 37000 номыг шинээр ба буцааж байрлуулан номын хадгалалт хамгаалалтыг сайжруулна.	Фондуудад ном байрлуулах	37216 ном уншигчдад олгож, 38143 номыг буцааж журмын дагуу эмх цэгцтэй байрлуулан хадгалалт хамгаалалтыг сайжруулан ажиллаж байна.	100	
11.1.9 Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007оны 11-р сарын 8-ны өдрийн 415 дугаар	Номын хадгалалт хамгаалалтыг сайжруулах	Танхимуудын тооллогоор дутсан болон уншигчдын үрэгдүүлсэн 25 ш номыг номоор нь төлж барагдуулсан. Үүнд: - Архивын сан хөмрөг 3 ном - Монгол номын сан хөмрөгт ном 3	100	

тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Алдагдсан буюу гэмтээгдсэн ном, хэвлэлийг төлүүлэх журам”-ын дагуу анхааран ажиллах		- Мөрөөдөл танхимд 17 - Их мэдэх танхимд 1 - Өрнө дахины танхимд 1 Уншигчдын хэрэгцээ шаардлага хангахгүй болсон олон хувьтай сурах бичиг 2513 ширхэг 7,392,181 төгрөгийн номыг Төрийн өмчийн хорооны зөвшөөрөлөөр хасахаар болсон.		
1.2. Уншигчдад ном хэвлэлээр үйлчлэх үйлчилгээ				
1.2.1 Фондуудаас уншлагын танхимуудад захиалгын дагуу ном гаргаж өгөх	Монгол фондын номыг дотоод сүлжээгээр бусад фондын номыг захиалгын хуудсын дагуу номыг танхимуудад гаргаж үйлчилнэ.	Монгол номын фонд нь 37216 ном, бусад танхимууд 57879 нийт 95095 номыг захиалгын дагуу гаргаж үйлчилсэн байна.	100	
1.2.2 Уншигчдад үйлчлэх	2019 онд зохион байгуулах соёл, олон нийтийн ажлыг БСШУСЯ-ны төлөвлөгөөнд тусгагдсан “Хүүхэд залуучуудын уншлагыг дэмжих аян”-ны хүрээнд хийнэ. 3400 уншигчдад шинээр үнэмлэх нээнэ. ”Боловсрол хөгжил” танхим 26000 ирцэд 37000 ном олгоно. “Их мэдэх” танхим 4260 ирцэд 6000 ном олгоно. “Мөрөөдөл” танхим 13000 ирцэд 24000 ном олгоно. ”ГМНС” 4500 ирцэд 8000 ном олгоно. ”Өрнө дахин” танхим “ 3850 ирцэд 5600 ном олгоно. “Дорно дахин” танхим 1300 ирцэд 4330 ном олгож үйлчилнэ. Зөөврийн номын сангаар 4000 ирцэд 3000 ном олгоно. Нийт 3400 шинэ уншигчдад үнэмлэх нээж, 56910 ирцэд 87930 ном олгож уншигчдад үйлчилнэ. Зөөврийн номын сангийн	2019 онд зохион байгуулсан ажил нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, номоор дамжуулан нийгэмд соён гэгээрүүлэх ажил хийх, БСШУСЯ-ны төлөвлөгөөнд тусгагдсан”Хүүхэд залуучуудын уншлагыг дэмжих аян”-ны үйл ажиллагааг хийхэд чиглэгдсэн. Нийт 4263 уншигчдад үнэмлэх нээж,орлогыг санхүүд тушаасан. ”Боловсрол хөгжил” танхим 18507 ирцэд үйлчилсэн. - “Их мэдэх” танхим 3990 ирцэд 3995 ном олгосон. - “Мөрөөдөл” танхим 16000 ирцэд 24300 ном олгосон. - ”ГМНС” 6825 ирцэд 10752 ном олгосон. - ”Өрнө дахин” танхим “ 3871 ирцэд 5780 ном олгосон. - “Дорно дахин” танхим 1397 ирцэд 4733 ном олгосон. - Зөөврийн номын сангаар 9893 ирцэд 10390 ном олгосон. - Монгол номын фонд 37216 ном олгожээ. Нийт 4263 шинэ уншигчдад үнэмлэх нээж, 62385	100	

	үйлчилгээг өргөтгөн ажиллана.	ирцэд 100211 ном олгож уншигчдад үйлчилсэн. Зөөврийн номын сангийн үйлчилгээний дэлгэрэнгүй тайлан Хавсралт №1		
2.3 Номын сангаас зохиох соёл олон нийтийн ажлыг " Хүүхэд залуучуудын уншлагыг дэмжих аян"-ны хүрээнд зохион байгуулна.	-"Хүүхэд залуучуудын уншлагыг дэмжих аян" зохион байгуулна. - Шинэ номын үзэсгэлэн -12 удаа - Сэдэвчилсэн номын үзэсгэлэн-12 удаа - Зохиогч уншигчдын уулзалт 6 удаа - Үлгэрийн цаг – 8 удаа - Клубын уулзалт -4 удаа - Уулзалт ярилцлага -1 - Уншигчдад зориулсан лекц-2 удаа - Уншлагын үдэш- 2 удаа - Охид хөвгүүдэд зориулсан мэргэжлийн эмчийн зөвлөгөө -2 удаа - Зуны зугаатай уншлага - Эцэг эхэд зориулсан "Хүүхдийн уншлагыг дэмжих" ярилцлага - МЗЭ-ийн 90 жилийн ойд зориулан үзэсгэлэн гаргах - Монгол бахархал- цагаан сар танин мэдэхүйн уралдаан - С. Надмидын нэрэмжит "Номын амт" массын шүлгийн уралдаан - "Ээждээ бичих ил захидал"-ын уралдаан - Гадаад багштай хийх уулзалт - Дэлхийн яруу найргийн өдөрт "Сонгодог урлаг –яруу найраг" Ардын уран зохиолч Б.	Тайлант хугацаанд 13 нэрийн 214 удаагийн соёл танин мэдэхүйн ажил зохион байгуулсан. Соёлын ажлын тайланг хавсаргав. Хавсралт № 2 -Шинэ номын үзэсгэлэн 33 удаа 539 ширхэг ном болон аудио болон видео материалаар үзэсгэлэн -Сэдэвчилсэн номын үзэсгэлэн 35 удаа 802 ш ном болон аудио болон видео материалаар., -Гэрэл зургийн үзэсгэлэн 2 удаа -Зохиогч уншигчдын уулзалт 10 удаа - Үлгэрийн цаг -24 удаа - Чанга уншлага -44 удаа - Уншлагын аялал-1 удаа - Уулзалт ярилцлага-2 - Уншигчдад зориулсан лекц-8 удаа - Уншлагын үдэш- 2 удаа - С.Надмидын богино өгүүлэгийн наадам - "Ээждээ бичих ил захидал"-ын уралдаан - Бумбардай зохиолын зохиолч Э. Эрдэнэбаяртай хийх уулзалт - Охид хөвгүүдэд зориулсан мэргэжлийн эмчийн зөвлөгөө -2 удаа - Эрдэм шинжилгээний хурал -3 - Шинэ номын нээлт 5 - Эцэг эхэд зориулсан "Хүүхдийн уншлагыг дэмжих" ярилцлага- 2 - Монгол бахархал-цагаан сар - Үндэсний өв соёлоо дээдлэхүй "Хөхөө Намжилийн домог" , "Яриг цагаан ингэний цариг цагаан ботго" домгийг хөөмийч МУСТА Б.Хосбаяртай хамтран зохион байгуулсан. - Үндэсний бичиг үсгийн баяр	100	

	Явуухулан мэндэлсэний 80 жилийн ойд зориулан уран бүтээл сурталчлах - Олон улсын хүүхдийн номын баяр- - Үндэсний өв соёлоо дээдлэхүй “Хөхөө Намжилийн домог” - “Үндэсний бичиг минү” улсын 14-р уралдаан - Төрөлх монгол хэл” - Бумбардай зохиолын зохиолч Э. Эрдэнэбаяртай хийх уулзалт - “Үндэсний Номын баяр” - “Зохиолд задлал хийх” - “Шидэт номын найзууд” - Засгийн газрын тэтгэлгээр гадаадад суралцах боломж танилцуулга, зөвлөгөө, мэдээлэл - Төрийн шагналт, АУЗ С. Эрдэний мэндэлсэний 90жилийн ойд “С. Эрдэнийг хэн сайн мэдэх вэ?” сэдэвт “Алтан хонх” тэмцээн - Шилдэг уншигчийн “Сүлд модны наадам” - Ардын уран зохиолч Д. Цоодолын 75насны ой , Ш. Цэнд-Аюушийн насны ой ,Ш. Гаадамба 95жил Ө. Баасанжавын 95жил, Төрийн шагналт, Ардын уран зохиолч С. Эрдэнийн 90 жил, Төрийн шагналт, СГЗ Б. Явуухулангийн 90 жил, С. Надмидын 85жил, Төрийн шагналт, СГЗ До. Нямаагийн 80 жилийн ой зэрэг үйл ажиллагаанд зориулан зохиолчдын бүтээлийг сурталчлах	- Төрөлх Монгол хэл - Олон улсын хүүхдийн номын өдөр - Дэлхийн номын өдөр - Гадаад багштай хийсэн уулзалт ярилцлага -2 удаа - Клубын уулзалт ярилцлага 12 удаа - Астрид Линдгренийг хэн сайн мэдэх вэ? жүжигчилсэн тоглолтын уралдаан - “Зохиолд задлал хийх”, “Шидэт номын найзууд” үйл ажиллагааг хүүхдийн зохиолчдын “Эвт үзэг төв”-тэй хамтран 12 сарын 13,14 –нд байгуулахаар болоод байна. -Төрийн шагналт, АУЗ С. Эрдэний мэндэлсэний 90жилийн ойд “С. Эрдэнийг хэн сайн мэдэх вэ?” сэдэвт “Алтан хонх” тэмцээн - Засгийн газрын тэтгэлгээр гадаадад суралцах боломж танилцуулга, зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлын хүрээнд “Кунзийн институтийн Монгол талын захирал М.Чимэдцэеэ хүүхдүүдэд “Хятадын тэтгэлэгт хөтөлбөрт хэрхэн хамрагдах” талаар ярилцаж шаардлагатай мэдээлэл өгсөн. - Ардын уран зохиолч Д. Цоодолын 75насны ой , Ш. Цэнд-Аюушийн насны ой ,Ш. Гаадамба 95жил Ө. Баасанжавын 95жил, Төрийн шагналт, Ардын уран зохиолч С. Эрдэнийн 90 жил, Төрийн шагналт, СГЗ Б. Явуухулангийн 90 жил, С. Надмидын 85жил, Төрийн шагналт, СГЗ До. Нямаагийн 80 жилийн ой зэрэг үйл ажиллагаанд зориулан зохиолчдын бүтээлийг сурталчлах ажлыг хийж “Номын баяр”-ын үйл ажиллагааны хүрээнд зохиолчдын номын үзэсгэлэн гаргах банер хийн таниулсан. - ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Улаанбаатар Их Сургуультай хамтран “Ц.Гайтав-90”, “С.Эрдэнэ-90”, “Б.Явуухулан -90” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан.		
1.3.Ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах				

1.3.1 Ном хэвлэл сэлбэн засах 500 ном, 80 хавтас сонин	Ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах	Уншлагын танхимуудад уншигчдын хэрэгцээ шаардлага хангагүй гэмтэж урагдсан 562 ш ном, 81 хавтас сонин сэлбэн засварлаж хүлээлгэж өгсөн.	100	
1.3.2 Ном хэвлэлийн сэргээн засварлалтын талаар сургалтыг хүүхдүүдэд заах	“Номын сангийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийг мөрдлөг болгох	Нийслэлийн 92-р дунд сургуулийн идэвхтэн уншигч хүүхдүүдэд гэмтсэн номыг сэргээн засварлах талаар анхан шатны сургалт зохион байгуулсан. Азийн хөгжлийн банкны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн хүрээнд “Ном хэвлэлийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт ба Ажил мэргэжлийн чиг баримжаа” төсөл хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд нийслэлийн ЕБС-ийн 40 сургуулийн номын санчдыг 40 цагийн сургалтад хамруулж сургууль тус бүрд 294600 төгрөгийн үнэ бүхий ном сэлбэн засварлах багаж хэрэгслийн иж бүрдлийг гардуулсан.	100	
1.4. Номын сангийн гадаад хамтын ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх				
1.4.1 Гадаад харилцааг өргөтгөн Олон улсын номын сангийн холбооны үйл ажиллагаанд идэвхитэй оролцох	Монгол Улсын Их хурлын 2011 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ыг ажилд мөрдлөг болгон ажиллах	1.Олон улсын номын сангийн холбооноос гаргасан мэдээллийг цаг тухайд нь авч орчуулан сургалт, байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэж байна. 2. Хятадын Манжуур, Хайлаар хотын номын сангийн захирал, номын сангийн холбооны гишүүдийг өөрийн номын сантай танилцуулж хамтран ажиллах талаар санал солилцов. 3. Монгол Швед хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойн хүрээнд Шведийн ЭСЯ-тай хамтран “Астрид Линдгренийг хэн сайн мэдэх вэ” жүжигчилсэн тоглолтын уралдаан зохион байгуулсан. Тус уралдаанд нийт 240 хүүхэд багачууд оролцож өөрсдийн бэлдсэн тоглолтыг хүүхдийн зохиолчид болон Шведийн элчин сайд, ЭСЯ –ны ажилтнуудад тоглож үзүүлсэн. Мөн Шведийн ЭСЯ-тай хамтран Стокольмийн их сургуулийн хүүхдийн уран зохиолын багш Елена Друкерийг урьж “Шведийн хүүхдийн уран зохиолын уламжлал, шинэчлэл” сэдэвт 2 хоногийн сургалт зохион байгуулсан. Сургалтад хүүхдийн зохиолч, номын санч, оюутан нийт 80 хүн хамрагдсан.	100	

		4. 9 сарын 10-нд Тайваний Үндэсний номын сангийн захирал Хүүхдийн Төв номын сангийн үйл ажиллагаатай танилцаж хүүхдийн уран зохиолын 136 ном бэлэглэсэн. 5. Монгол-Хятад хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд "Нахиа" хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн номын үзэсгэлэн, шинэ ном гардуулах ёслол зохион байгуулсан. 6. Хятад улсын Өвөр Монголын Өөртөө засах орны ном хэвлэлийн хорооны хамт олонтой харилцан ярилцлага зохион байгуулсан бөгөөд хамтын ажиллагааны хүрээнд уйгаржин монгол хэл дээр хэвлэгдсэн дэлхийн болон хятадын сонгодог уран зохиол, танин мэдэхүйн холбогдолтой 300 ширхэг ном, хятад хэл дээрх 519 номыг бэлгээр өгсөн.		
1.4.2 Гадаад харилцааг тогтмолжуулах	Гетё институт, Улаанбаатар дахь Тайваний Худалдааны Төлөөлөгчийн газар, Тайваний Үндэсний номын сан, Германы элчин сайдын яам зэрэг байгууллагуудтай харилцаатай ажиллаж төвийн үйл ажиллагааг тогтмолжуулах	Ханс-Зайделийн Сангаас 6 ш ном, Гетё-Институтээс 321 ном, 179 CD, 26 DVD, 145 ш тогтмол хэвлэлийн баяжилт хийгдсэн. Тайваний Үндэсний номын сантай байнгын захидлаар харилцаж байгаа бөгөөд тус номын сангийн захирал гэрээний биелэлттэй энэ оны 9 сард ирж танилцаж 136 хүүхдийн уран зохиолын ном бэлэглэсэн.	100	
1.4.3 Монголд ажиллаж байгаа олон улсын байгууллагатай хамтран ажиллах	Тайваний Худалдааны Төлөөлөгчийн газар ба бусад	Хамтран ажилладаг байгууллагуудтай байнгын түншлэлийг бий болгон ажиллаж байна. Хятадын ЭСЯ, Өвөрмонголын өөртөө засах орны хэвлэлийн хороо, Соёл урлагийн газартай хамтран хэрэгжүүлж байгаа "Нахиа " хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж бэлгээр ирсэн номыг нийтийн болон ЕБС-ийн номын санд түгээх үйл ажиллагааг хийж байна. Японы иргэн Сэкигүчи Такаши i5 үзүүлэлттэй хуучин 3 ширхэг зөөврийн компьютер хандиваар өгснийг уншлагын танхимаар уншигчдад түр зээлдүүлэн хэрэглүүлж байна.	100	
1.4.4 "Баярлалаа Бяцхан номын сан" төслийн бэлтгэл ажлыг хангаж ажиллах	Шаардлагатай бичиг баримтыг цаг тухайд нь бэлтгэн боловсруулж өгөх	Солонгосын Соёлын яамнаас хэрэгжүүлж байгаа "Баярлалаа бяцхан номын сан" төсөлд шаардлагатай материалуудыг 5 удаа бэлдэж өгсөн. Төсөл хэрэгжүүлэх багийн гишүүдийг хүлээн	100	

		авч номын сангийн үйл ажиллагаатай танилцуулсан.		
1.5. “Номын сангийн орчныг сайжруулах”үйлчилгээ				
1.5.1 Нэг уншлагын танхимын шалыг шинээр паркетлана	Ажилтан албан хаагчид болон номын сангаар үйлчлүүлэгчдийн ажиллах орчинг сайжруулна.	Ус алдах онцгой нөхцөл үүссэн тул төлөвлөгдсөн хөрөнгөөр ариун цэврийн өрөөний 2 угаалтуур, 9 суултуурыг шинээр авч тавьсан.	100	
1.5.2. Хүүхдийн Төв Номын Сангийн “Утгын оньс” танхимд зохиолчдын гар бичмэлээр баяжуулалт хийх	Хүүхдийн зохиолчдын мэдээллийн сангийн нөөцийг нэмэгдүүлэх	Энэ жилд хүүхдийн зохиолч Ж.Дашдондог, Л.Түдэв, С.Надмид нарын 40 зохиолчийн гар бичмэлийг төрөлжүүлэн товъёог хийж архивын фондонд шилжүүллээ. 1965-1995 оны хугацаанд нийтлэгдсэн “Хүүхдийн уран зохиол”-ын материалаар мэдээллийн цахим нөөц үүсгэсэн. Зохиолч Д.Содномдоржид уншигч хүүхдүүдээс ирүүлсэн 500 захидлууд, С.Надмидын “Уралдаан” 1965, бичгийн машинаар бичигдсэн гараар засвар хийгдсэн 15 хуудас материал, Гар бичмэл 5 хуудас нийт 565 хуудас материалаар баяжуулалт хийгдлээ.	100	
1.5.3 Зөөлөн эдлэл худалдаж авах	Хөдөлмөр хөнгөвчлөх, ажиллах орчинг сайжруулахад анхааран ажиллах	Төсөвлөгдсөн хөрөнгөд зохицуулан зарим ажилтан албан хаагчдыг нормын хувцсаар хангасан.	100	
Хоёр:” Номын сангийн автоматжуулалтын ажил, Улсын хэмжээний ЕБС-ийн номын сангуудыг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангах”гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил үйлчилгээ				
2.1. Мэдээллийн хангамжийг сайжруулах				
2.1.1 Хүүхдийн Төв номын сангийн веб хуудсыг өргөтгөн сайжруулж, мэдээ мэдээллээр баяжуулахад оролцож, мэдээлэл бүрдүүлэлтэнд ажиллагсдыг сургаж дадлагажуулна.	ХТНС-ны веб хуудсыг сайжруулан мэдээ мэдээллээр баяжуулах -Вэбэд шинэ үйлчилгээнүүдийг бий болгоно. -Вэбэд тавигдсан материалуудаар нөөц үүсгэнэ.	Энэ хугацаанд номын сан дээр зохиогдсон ажил үйлчилгээний талаар 167 мэдээ мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан сурталчилсан. Олон нийтийн радио телевизээр 25 удаагийн ярилцлага нийтлэл өгсөн.	100	
2.1.2 Мэдээллийн үйлчилгээг сайжруулах.	“Шинэ номын мэдээлэл”товхимолыг PDF	1-р сарын 03-нд Аудит-д өгөх бичиг баримтыг PDF файл болгон бэлтгэсэн.		

	файлаар байгууллагын вэб, фэйсбүүк хуудсанд байршуулах	3-6 сард байгууллагын 2005-2017 оны материалыг Үндэсний архивт хүлээлгэн өгөх үйл ажиллагаанд бэлтгэж бичиг баримтыг PDF файл болгон бэлтгэх үйл ажиллагааг хийх багт орж ажилласан. “Шинэ номын мэдээлэл” болон байгууллагын зарим шаардлагатай материалыг байгууллагын вэб, фэйсбүүк хуудсанд байршуулж байна. График дизайны хүрээнд: 4-р сарын 06-нд Байгууллагын түүхийн номтой холбоотойгоор шаардагдах зургуудыг компьютерт ялгаж ангилсан 7-р сарын 8-нд Уншлагыг дэмжих жилийн хүрээнд хийгдсэн “Зуны зугаатай уншлага” аяны анонсыг хийж гүйцэтгэв. 8-р сарын 13-нд Боловсрол соёл шинжлэх ухааны яамны нээлттэй өдөрлөгт зориулж байгууллагын баруун аймгуудаар аялсантай холбоотой тайланг номын хэлбэрт шилжүүлж бэлтгэж хэвлэсэн. 9-р сарын 02-нд “Нахиа” хөтөлбөрт зориулагдсан анос баннеруудыг эхийг бэлтгэсэн. 09-р сарын 27-нд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т зориулж 7 ширхэг баннерийн эхийг бэлтгэсэн. 10-р сарын 30-нд Шведийн зохиолч Астрид Линдгрений 115 насны ойд зориулсан анонс баннерын эхийг бэлтгэсэн. 11-р сарын 14-нд Хүүхдийн элч, хөгжмийн зохиолч С.Батболдын "Монголын хүүхдийн дууны үүсэл хөгжил, уламжлал шинэчлэл" лекцийн урилгын загварын эхийг бэлтгэсэн. 12-р сарын 4-нд “Ном хэвлэлийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалт сургалтын “Батламж”, “Гэрчилгээний” загварыг гаргаж хэвлэлийн эхийг бэлтгэсэн.	100	
2.1.3 Хүүхдийн Төв номын сангийн сүлжээний дотоод үйл ажиллагааг найдвартай байлгах -Номын сангийн хамгаалалтын системийн сүлжээний ашиглалтыг	Дотоод болон интернэтийн сүлжээг сааталгүй найдвартай ажиллагаатай байлгах	2-р сарын 13нд каталогийн сүлжээг дахин тавьж доголдсон үйл ажиллагааг хэвийн байдалд оруулсан 5-р сарын 12-нд байгууллагын тасалдсан дотоод сүлжээг засварласан. - 7-р сарын 12-нд байгууллагын тасалдсан дотоод сүлжээг зассан. 9-р сарын 30-нд Герман уншлагын танхимын WIFI-г засаж хэвийн ажиллагаанд оруулсан	100	

нэмэгдүүлэх		11-р сарын-3нд байгууллагын тасалдсан дотоод сүлжээг зассан.		
2.1.4 Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, техник тоног төхөөрөмжийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах	Компьютер болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангаж ажиллахдаа техникийн ба програм хангамжийн засвар үйлчилгээг хийх	Дараах уншлагын танхимын болон ажилтнуудын компьютерийг форматлаж Lib.4U.net номын сангийн програмыг суулгаж хэвийн ажиллагаанд оруулах, засвар болон техникийн бусад үйл ажиллагааг хийсэн. 2-р сарын 14-нд Боловсрол танхимын 3 үйлдэлт принтерийг ажиллагаанд оруулсан 3-р сарын 27-нд үнэмлэх нээлтийн компьютерийг форматлаж шинээр үйлдлийн систем суулгасан 4-р сарын 5-нд Дорно дахины танхимын компьютерт вирусны хамгаалалт суулгаж өгсөн 5-р сарын 20-нд Боловсрол танхимын компьютерийг үйлдлийн систем болон програмуудыг шинээр суулгасан 6-р сарын 13-нд ажилтнуудын бүх компьютер-ийн virus-ны хамгаалалт болон нэвтрэх нууц үг байгаа эсэхийгг шалгаж шаардлагатай арга хэмжээ авсан 6-р сарын 19-нд ангилагч ажиллагчийн компьютерт usb card суулгасан7-р сарын 03-нд Аудит-д өгөх бичиг баримтыг PDF файл болгон бэлтгэх үйл ажиллагаанд оролцсон 8-р сарын 22нд Боловсрол танхимын терминал сүлжээтэй компьютеруудыг үйл ажиллагаанд оруулсан. 8-р сарын 23нд каталогийн сүлжээг ахин тавьж доголдсон үйл ажиллагааг хэвийн байдалд оруулсан 11-р сарын 3-нд ажиллахгүй болсон 3ш “Lan”-гийн толгойг сольж ажиллагаанд оруулсан.	100	
2.1.5 Номын сан хоорондын мэдээлэл солилцох ажлыг сайжруулах	Хүүхдийн тогтмол хэвлэлээс мэдээллийн сан үүсгэх	Номын сангуудын хооронд мэдээлэл солилцох үйл ажиллагааг дэмжих гэрээний дагуу Zotero програмд Цох, Сурагчийн мэдээ, Бяцхан цох, 2018,2019 оны хүүхдийн сэтгүүлээс 369 мэдээ мэдээллээр электрон нөөц сан үүсгэсэн.	100	
2.1.6“LIBU4” програмын дагуу номыг электрон каталогт оруулах	2.1.6 .Электрон мэдээллийн нөөцийг нэмэгдүүлэн 4900 номыг электрон каталогт оруулах	“LIBU4” програмын дагуу нийт 6411 ширхэг шинэ номыг электрон каталогт оруулլаа.	100	
2.1.7 Хуруу бүртгэлийн системийг нэвтрүүлж хэвшүүлэх	Ажилтан албан хаагчдын цаг ашиглалтыг сайжруулах	Хуруу бүртгэлийн системийг нэвтрүүлж хэвшсэн.	100	
2.1.8 Номын сангийн	Номын хадгалалт хамгаалалтыг	Өөрөө бичигч NVR төхөөрөмж суурилуулж, бичлэг	100	

камержуулалтыг сайжруулах	сайжруулах	хурааж гаднаас хандалт хийж 3 камер холбосон.		
2.2 Удирдлагын үйлчилгээ				
2.2.1 Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохих байгууллагуудад хандаж хөөцөлдөж тодорхой үр дүнд хүрэх Байгууллагын дотоод журам бусад хууль эрхийн актын хэрэгжилтэнд хяналт тавих	Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан “Хүүхдийн номын ордон барих” гэсэн заалтыг хэрэгжүүлэх “Мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийг мөрдлөг болгох	Хүүхдийн Төв номын сангийн барилга, газрын асуудлаар БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг, Соёл урлагийн бодлогын газрын дарга Б.Сэргэлэн нарт танилцуулж шаардлагатай бичиг баримтыг танилцуулсан. “Төрийн албаны тухай хууль” шинэчлэгдсэнтэй холбогдуулан ажилтан албан хаагчдын хувийн хэрэг, албан тушаалын тодорхойлолт зэрэг материалуудыг дахин боловсруулж баталгаажуулсан.	100	
2.2.3 УИХ, Засгийн Газрын шийдвэр, БСШУССайдын тушаалын хэрэгжилтийг биелүүлэх ажлыг зохион байгуулах	“Шилэн дансны тухай хууль”-ийг дагаж мөрдөх	“Шилэн дансны тухай хууль”-ийг мөрдөн ажиллаж цахим хуудсанд байршуулан ажиллаж байна. -Байгууллагын дотоод хяналт шалгалт зохион байгуулах” журмыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.	100	
2.3 Арга зүйн ажил				
2.3.1 ЕБС-ийн номын сангуудад арга зүйн зөвлөгөөг биечлэн өгөх	“Хүүхдийн төв номын сангийн дүрэм, бүтэц”-ийн 2.1.5 заалтыг хэрэгжүүлэх	Арга зүйч Л.Батболор 55, номзүйч С.Тунгалаг 35 Д.Оюунбилэг 12 удаа нийт 102 удаа мэргэжил арга зүйн зөвлөгөөг ЕБС болон ТББ-ын номын санчдад өгсөн байна.	100	
2.3.2 ЕБС-ийн номын санчдад шаардлагатай 2 аргачлал боловсруулах	“Хүүхдийн төв номын сангийн дүрэм, бүтэц”-ийн 2.1.5 заалтыг хэрэгжүүлэх	Нийт 21 аргачлал,албан бичиг 9 лекц боловсруулсан. - Хэлтсийн эрхлэгч Г.Буянцэцэг Уншлагыг дэмжих жил”-ийн хүрээнд “2 хэлний уншлага” зохион байгуулах аргачлал, - Номзүйч С.Тунгалаг “Зохиолд задлал хийх” аргачлалыг тус тус боловсруулсан.	100	
2.3.3 Сургалт семинар зохион байгуулах	Номын санчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх	15 удаа сургалт семинар зохион байгуулж нийт 460 номыг санчид хамрагдсан байна. Сургалтын тухай дэлгэрэнгүй материалыг хавсралт №2	100	
2.3.4 Шинэ номын мэдээ	Номын санд ирсэн ном хэвлэлийг	Шинэ номын мэдээлэл товхимлыг улирал бүр		

гаргах	цаг хугацаанд нь уншигчдад мэдээлэх	гаргаж, Их мэдэх танхимын 2018 онд авсан 46, 2019 онд 352 номын мэдээллийг тусган Хүүхдийн ТНС-гийн вэб сайтад байршуулсан.	100	
2.3.5 “Номын санч” сэтгүүлд 2-оос доошгүй материал нийтлүүлэх	Номын санч сэтгүүлийн мэдээллийн чанарыг өргөжүүлэх	Арга зүйч Л.Батболор “Чингэлтэй дүүргийн номын санчдын уншигчидтай ажиллах арга ажиллагаа”, “Номын сангийн соёл танин мэдэхүйн ажил” 2 мэдээлэл,Хэлтсийн эрхлэгч Г.Буянцэцэг “2 хэлний уншлага” зохион байгуулах аргачлалыг захирлаар батлуулж албажуулан сэтгүүлийн 2019 оны №1-т хэвлүүлсэн.	100	
Гурав. “Хүний нөөцийн хөгжил, тогтвортой байдлыг хангах" үндсэн зорилтын хүрээнд:				
3.1.1 Номын санчдын мэргэжлийг дээшлүүлэх давтан сургалтанд хамруулах, ажлын байранд болон эрхэлсэн ажлын чиглэлээр сурах, давтан сурахад дэмжлэг үзүүлэх	Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх, ажилтан албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх	Энэ жил Б.Бямбарагчаа Соёлын сургуулийн номын сангийн ангийг, Э.Доржханд МУИС-ийн герман хэлний ангийг тус тус суралцаж төгссөн. Номын санч Б.Бямбарагчаа, Б.Бямбадулам нар орос хэл, номын санч Сувдмаа герман хэлний сургалтанд хамрагдсан. БСШУСЯ, Монголын номын сангуудын консерциум болон бусад байгууллагаас зохион байгуулсан 8 сургалтанд 20 ажилтан хамрагдсан байна.	100	
3.1.2 Ажилтан албан хаагчдад зориулсан үйлчилгээний соёлын талаар лекц уншуулах, ярилцлага зохион байгуулах	Томилолтын ажлын үр дүнг сайжруулах,	Бүх ажилтан албан хаагчдад 4-р сард захирал Д.Оюунбилэг АНУ-ын номын сангуудын үйл ажиллагааны талаар 5-р сард хэлтсийн эрхлэгч Г.Буянцэцэг Герман улсын Мюнхэн хотын төв номын сан, Белги улсын Гент хотын Крook номын сангуудын үйл ажиллагааны талаар байгууллагынхаа номын санчдад үзүүлэн бэлтгэж сургалт хийсэн. Номын санч Э. Ариунсанаа “ Хэвлэл мэдээллийн суурь боловсрол” сэдэв сургалт хийсэн. - Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг соёл урлагийн газар, Монголын номын сангийн холбоо, Америкийн монгол судлалын төвөөс зохион байгуулсан “OCLC World Cat- Дэлхийн номын сангуудын нэгдсэн электрон каталог” сэдэвт номын санч мэргэжилтнүүдийн зөвлөгөөнд Л.Батболор, Т.Билэгбаяр нар оролцлоо. -9-р сарын 27-нд Номын сангийн консерциумаас	100	

		зохион байгуулсан “Library Update-2019” номын санч-мэдээллийн ажилтны улсын 6-р зөвлөгөөнд хэлтсийн эрхлэгч Г.Буянцэцэг, арга зүйч Л.Батболор нар оролцлоо. Хэлтсийн эрхлэгч Г.Буянцэцэг байгууллагын онцлох үйл ажиллагаа болон уншлагыг дэмжих жилд гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээллийг зөвлөгөөнд оролцогчдод илтгэлээ. 11 сард Эерэг Энхбаатар болон Уншлага үйлчилгээний хэлтсийн эрхлэгч Дарьсүрэн нарын хийсэн хандлага, харилцааны талаарх лекцэнд нийт ажилтнууд хамрагдлаа.		
Дөрөв. “Санхүүгийн үйлчилгээ” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил үйлчилгээ				
4.1.1 Төсвийг оновчтой зарцуулах	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу цаг тухайд нь зарцуулж байна. 2018 оны жилийн санхүүгийн баримтанд “Од бүртгэл-Аудит” компани шалгалт хийж зөрчилгүй дүгнэгдсэн.	100	
4.1.2 Санхүүгийн тайлан мэдээ гаргах	Нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам зааврыг чанд мөрдөн санхүүгийн тайлан холбогдох мэдээг үнэн зөв, хугацаанд нь гаргах	2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргаж БСШУСЯ-нд өгч баталгаажуулсан.	100	
4.1.3 Үндсэн хөрөнгийн ашиглалт Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, эд хөрөнгийн тооллого тооцоо бүртгэлийг үнэн зөв хийх.	Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах	Байгууллагын 2005-2019 оны санхүүгийн архивын материалыг цаасан болон цахим хэлбэрээр байгууллагын архивт хүлээлгэн өгсөн. 2019 онд худалдаа болон бэлгээр орж ирсэн номыг санхүүгийн программд шивж үндсэн хөрөнгөд тусгасан.	100	
1.4 Архив бичиг хэргийн баримтуудыг цахимд оруулах	Байгууллагын архив , албан хэрэг хөтлөлтийн эмх цэгцийг сайжруулах ,	Байгууллагын 2005-2016 оны материалуудыг Үндэсний архивт шилжүүлэх ажлын хэсэг гарган ажиллаж бүх материалуудыг стандартын шаардлагын дагуу цаасан болон цахим хэлбэрээр 100 хувь хийж гүйцэтгэсэн. БСШУСЯ –ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А|124 тушаалын дагуу 2017-2019 оны эхний хагас жилийн байгууллагын бичиг баримтыг архивын стандартын дагуу эмхэлж цэгцэлсэн.	100	

Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглаж, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.	a) Эд хөрөнгийн тооллогын эхний хагас жилд хийж ашиглалтанд хяналт тавих b) Өмч хөрөнгийн бүртгэлийг цахимжуулах, өмч эзэмшигчийн картыг шинэчлэх ажлыг зохион байгуулах.	2019 оны эд хөрөнгийн тооллогыг хийж ажилтан тус бүрийн карттай тулган бичилт хийж нэгтгэл хийсэн.	100	
Тав: Ажилтан албан хаагчдын нийгмийн асуудал" гэсэн байгууллагын зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ				
5.1.1 Нийгмийн халамж үйлчилгээ	"Соёлын тухай хууль"-ийн 22 дугаар зүйлийг үндэслэл болгон ажиллах	Ажилтан албан хаагчдад ажлын үр дүнг тооцож давхардсан тоогоор 47 хүнд ур чадварын нэмэгдэл олгож байна. Байгууллагын хамт олны спорт биеийн тамираар хичээллэх үйл ажиллагааг дэмжин хамтран ажилладаг Улаанбаатар Их сургуулийн заалын зохицуулалт хийж байна.	100	
Б.ТУСГАЙ АЖИЛ: "ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН УНШЛАГЫГ ДЭМЖИХ"АЯН ЗОХИОН БАЙГУУЛАХ (Дэлгэрэнгүй тайланг хавсралт №3)				
2019 онд зохион байгуулах соёл, олон нийтийн ажлыг БСШУСЯ-ны төлөвлөгөөнд тусгагдсан "Хүүхэд залуучуудын уншлагыг дэмжих аян"-ны хүрээнд хийнэ. - Хүүхэд залууст монгол ахуй, өв соёлыг өвлүүлэх дархлаа суулгах, Монголын болон дэлхийн сонгодог бүтээлүүдтэй танилцах, эх хэлний уран тансаг байдлыг мэдрүүлнэ - Ном тойрсон олон талт ажлыг 7 хоногийн турш зохион байгуулж нийгмийн нийтийн	2019 онд зохион байгуулах соёл, олон нийтийн ажлыг БСШУСЯ-ны төлөвлөгөөнд тусгагдсан "Хүүхэд залуучуудын уншлагыг дэмжих аян"-ны хүрээнд хийнэ. -Хүүхэд залууст монгол ахуй, өв соёлыг өвлүүлэх дархлаа суулгах, Монголын болон дэлхийн сонгодог бүтээлүүдтэй танилцах, эх хэлний уран тансаг байдлыг мэдрүүлнэ -Ном тойрсон олон талт ажлыг 7 хоногийн турш зохион байгуулж нийгмийн нийтийн уншлагад татан оролцуулна -Зохиолч, яруу найрагч, хүүхдийн дууны ая зохиогч, номын	Монгол улсын засгийн газрын бодлого "ард түмнийг соён гэгээрүүлэх, номын засаглалын бодлого хэргэжүүлэх үйл ажиллагаа", БСШУСЯ-ны төлөвлөгөөнд тусгагдсан "Хүүхэд залуучуудын уншлагыг дэмжих аян"-ныг эрчимжүүлэх зорилгоор 3-р сараас эхлэн Хүүхдийн Төв Номын Сангийн бүх ажилтнууд багийн зохион байгуулалтанд орж хүүхэд багачуудыг ном, номын санд татах, байгууллагаа сурталчилан нийт 86 бүлгийн 5274 хүүхдийг номын сангийн үйл ажиллагаатай танилцуулан олон талт соёлын үйл ажиллагааг явуулсан байна. Хавсралт №5 Хүүхэд залуучуудыг номтой нөхөрлүүлэхэд анхааран ажиллаж 214 удаагийн соёл танин мэдэхүй, соён гэгээрүүлэх ажлыг хийсэн байна. Үүнд: -Сэдэвчилсэн номын үзэсгэлэн -35 -Шинэ номын үзэсгэлэн -34 - Гэрэл зургийн үзэсгэлэн- 2 - Зохиолч уншигчийн уулзалт-10	100	

уншлагад татан оролцуулна - Зохиолч, яруу найрагч, хүүхдийн дууны ая зохиогч, номын санчдаас бүрдсэн баг хөдөө орон нутагт аялж уншигчидтайгаа уулзах, тэдний санал сэтгэгдлийг сонсох, номын санчдад сургалт явуулна. - Монгол бичиг соёлыг хойч үедээ өвлүүлэн үлдээнэ - Хүүхдийн уран бүтээлийг дэмжих ажлын хүрээнд хийнэ. - Хавдрын болон цусны өвчтэй хүүхдүүдэд ном хүргэж өгөх, үлгэр, өгүүллэг ярьж номоор эмчлэх үйлчилгээг хүргэнэ - Тэдэнд шаардлагатай ном хэвлэлээр үйлчлээд зогсохгүй соёлын олон талт үйл ажиллагааг хийж тэгш хүртээмжтэй мэдээлэл хүргэж чадна - Зун амарч байгаа хүүхдүүдэд зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэнэ.	санчдаас бүрдсэн баг хөдөө орон нутагт аялж уншигчидтайгаа уулзах, тэдний санал сэтгэгдлийг сонсох, номын санчдад сургалт явуулна. - Монгол бичиг соёлыг хойч үедээ өвлүүлэн үлдээнэ -Хүүхдийн уран бүтээлийг дэмжих ажлын хүрээнд хийнэ. -Хавдрын болон цусны өвчтэй хүүхдүүдэд ном хүргэж өгөх, үлгэр, өгүүллэг ярьж номоор эмчлэх үйлчилгээг хүргэнэ -Тэдэнд шаардлагатай ном хэвлэлээр үйлчлээд зогсохгүй соёлын олон талт үйл ажиллагааг хийж тэгш хүртээмжтэй мэдээлэл хүргэж чадна Зун амарч байгаа хүүхдүүдэд зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэнэ.	-Гадаад багштай хийх уулзалт-1 - Клубын үйл ажиллагаа- 22 -Чанга уншлага-44 - Үлгэрийн цаг – 22 - Хоёр хэлний уншлага-2 - Зуны зугаатай уншлага аяны хүрээнд 7 аймагт очиж ажилласан. - Уншлагын үдэш -2 -Уралдаан тэмцээн -10 -Зөвлөгөө сургалт, лекц- 10 - Эрдэм шинжилгээний хурал -3 - Номын баяр -4 -Шинэ номын нээлт -6 Алслагдсан дүүрэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хүүхэд асрамжийн газар, цусны хавдартай хүүхдүүд, хүүхдийн хорих анги зэрэг газруудад мэдээллийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор 10390 уншигчдад хүрч үйлчиллээ. Хавсралт "Хүүхэд залуучуудын уншлагыг дэмжих аян"-ыг БСШУСЯ-ны Соёл урлагийн газраас дэмжин санхүүжилт олгосоны үндсэн дээр хөдөө орон нутгийн хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Завхан,Увс, Хэнтий, Сүхбаатар аймгийн хүүхдүүдэд номын сангийн үйлчилгээг үзүүлсэн.		
Тав. Төрийн байгууллагын удирдах ажилтны манлайллын зорилтын хэрэгжилт /ҮДГэрээнд тусгагдсан 3 зорилт/				
		Засгийн газрын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд: 3.2.48 заалт: Музей номын сангийн стандартыг шинэчлэн		

Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын хууль, яамнаас баталсан шийдвэр, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг болон сайд, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай, мэргэшлийн түвшинд сайтар судлан боловсруулж хэрэгжүүлэх	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх	батлуулах ажлын хүрээнд номын сангийн стандарт шинэчлэх ажлын хэсэгт орж ажиллаж "Мэдээлэл ба баримтжуулалт. Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлага" ISO:11799, "Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага" MNS:5742 баримт бичгүүдийг Стандарт хэмжил зүйн газрын техникийн хороогоор хэлэлцүүлж батлагдахаар болсон. 3.2.49.4 заалт: Алслагдсан дүүрэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хүүхэд асрамжийн газар, цусны хавдартай хүүхдүүд, эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд, хүүхдийн хорих анги зэрэг газруудад мэдээллийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор 9893 уншигчдад хүрч үйлчиллээ. 3.2.45.3 заалт: Хүүхэд залуучуудад монгол ахуй, монгол өв соёлын дархлааг бий болгох зорилгоор "Содномун" ТББ-тай хамтран "Үндэсний бичиг үсэг мину" улсын 14 дэх жилдээ улсын уралдааныг зохион байгуулсан. Тус уралдаанд 11 аймаг, Улаанбаатар хотын 5 дүүргээс шалгарсан 200 гаруй хүүхэд оролцсон. Мөн яруу найрагч Хэнтийн Батхүүтэй хамтран 4 дэх жилдээ "Төрөлх монгол бичиг" улсын уралдаан зохион байгуулж 40 хүүхэд залуучууд оролцлоо. 5-6 сарын турш уран бичээч Ганзоригийн уран бичлэгийн үзэсгэлэн Боловсрол хөгжил танхимд дэлгэгдсэн. Хүүхэд багачуудад монгол ахуйг мэдүүлэх зорилгоор сэтгүүлч Оюунжаргалтай хамтран "Монгол мэдлэгийн танхим" ажиллаж байна. *БСШУСЯ-наас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд:* Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын 2019 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/229 дүгээр тушаалаар байгуулагдсан комиссын бүрэлдэхүүнд орж ажиллаж "Дээд боловсролын сургалтын байгууллагад тавигдах нийтлэг шаардлага"-ын болон их сургуулийн нэмэлт шалгуур үзүүлэлтийн дагуу 7 их, дээд сургуулийн номын сангийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн. БСШУСЯ –ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А|124 тушаалын дагуу 2017-2019 оны эхний хагас жилийн байгууллагын бичиг баримтыг архивын стандартын дагуу эмхэлж цэгцэлсэн. БСШУСЯ-ны газар, хэлтсээс ирсэн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж байсан.	100	

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гэрээний хэрэгжилтийг зохих журам, зааврын дагуу чанартай, үнэн зөв, бодитой шуурхай боловсруулах ажлыг биечлэн өөрөө гүйцэтгэх	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах	Хүүхдийн Төв номын сангийн үйл ажиллагааны төлөвлөгөө тайланг тухай бүрд нь захиргааны зөвлөлтэй хамтран боловсруулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна. “Төрийн албаны хууль”-ийн дагуу ажилтан албан хаагч бүрийн ажлын байрны тодорхойлолт, Төрийн албан хаагчийн хувийн хэрэг бүрдэлтийг шинэчлэн баталгаажуулсан. Ажилтан албан хаагчидтай 2019 оны “Хөдөлмөрийн гэрээ” баталгаажуулсан.	100	
Албан хэрэг хөтлөлтийн журам, дүрмийг үйл ажиллагаанд чанд мөрдөн баримт бичиг боловсруулах өөрийн чадвараа эрс сайжруулах	Албан хэрэг хөтлөлтийг сайжруулах	Засгийн газрын 2019 оны “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 150 дугаар тогтоол, БСШУС-ын сайдын 2019 оны А\346 тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор комисс томилон Хүүхдийн Төв номын сангийн баримт бичгийг архивын стандарт шаардлагын хэмжээнд хийж гүйцэтгэсэн.	100	
Зургаа. Мэргэжил ур чадвараа дээшлүүлэх зорилтын хэрэгжилт /ҮДГэрээнд тусгагдсан 3 зорилт/				
Гадаад хэлний зохих түвшний чадвартай болох	Сургалтанд хамрагдах, бие даан суралцах замаар гадаад хэлний мэдлэг чадварын төвшингөө ахиулна	Номын сангийн салбарын холбогдолтой 90 хуудас материалыг орос хэлнээс орчуулан сургалтанд ашигласан. Олон улсад болж буй салбарын шинэ хэрэгцээт мэдээллийг интернэтээс уншиж хэлний мэдлэг болон мэргэжлийн боловсролоо ахиулж байна.	100	
Салбарын бодлого, төлөвлөлт, төрийн алба, төрийн албан хаагчтай хууль тогтоомж, журмыг судлах, ашиглах	Шинээр батлагдсан салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журмын мэдээллийн сан үүсгэх, албан хэрэгцээнд ашиглах	Шаардлагатай баримт бичгийн мэдээллийн сан үүсгэх, гарын авлагыг бүрдүүлэн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэж байна. БСШУСЯ-ны зохион байгуулсан “Соёл урлагийн байгууллагын тогтвортой хөгжил-удирдахуйн шинэлэг хандлага-IV” сургалт болон бусад сургалт семинарт оролцож сургалтаас олж авсан мэдлэг мэдээллийг өдөр дутмын үйл ажиллагаандаа хэрэглэж байна.	100	
Нийт дундаж үнэлгээ			100	

АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2019 ОНД

ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

АГУУЛГА:

1. Ерөнхий мэдээлэл
- 1.1. Эрхэм зорилго
- 1.2. Нийтийн номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл

2. Сан хөмрөг, Каталог
- 2.1. Сан хөмрөгийн өнөөгийн байдал
- 2.2. Сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт
- 2.3. Каталоги зохион байгуулалт

3. Үйлчилгээ
- 3.1. Уншлагын танхим
- 3.2. “Их мэдэх” танхим
- 3.3. “Эко” уншлагын танхим
- 3.4. Ангийн уншлага
- 3.5. “Боролдой үлгэр унших” цаг
- 3.6. Номын үзэсгэлэн
- 3.7. Лавлагаа мэдээлэл
- 3.8. Мэргэжил арга зүйн ажил

4.Соёл олон нийтийн ажил

5. Хүний нөөц

6.Технологи

7.Төсөв, Орлого, Зардал

8.Бусад ажил

Тайлбар:

Архангай аймгийн нийтийн номын сангийн 2019 оны тайланг дээрх 8 бүлэгт хуваан тайлагнасан болно.

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Эрхэм зорилго

Аймгийн нийт иргэдийг мэдээллээр хангах соёлын үнэт зүйл болох ном хэвлэлийг хадгалах, хамгаалах, уламжлалт өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчилах, дэлхий нийтийн жишигт нийцсэн орчин үеийн мэдээллийн технологитой "Олон нийтийн мэдээллийн төв"-ийг бий болгож орчин үеийн үйлчилгээг ашиглан мэдээллийн чөлөөт урсгалыг хөгжүүлэн хүн амын ном, хэвлэл, мэдээллийн хангамжийг сайжруулах нь манай номын сангийн эрхэм зорилго юм.

1.2 Нийтийн номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл:

Аймгийн нийтийн номын сан нь 1945 онд , Хүүхдийн номын сан нь 1987 онд тус тус байгуулагдсан бөгөөд шинээр Хүүхдийн номын ордоны барилга нь 2013 онд, нийтийн номын сангийн барилга нь 2017 онд тус тус ашиглалтанд орсон. Нийтийн номын сан нь нийт 348 м2 талбайтай, Хүүхдийн номын ордон нь 648 м2 талбайтай, орон тооны 9 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийтийн номын сан нь:

- Захирлын өрөө
- VIP өрөө
- Үндсэн фонд
- Тогтмол хэвлэлийн фонд
- Лавлагаа номзүйн фонд
- Нийтийн уншлагын танхим 1
- Нийтийн уншлагын танхим 2
- Ажилчдын гал тогоо
- Жижүүрийн өрөө

Хүүхдийн номын ордон нь:

- Хүүхдийн уншлагын танхим
- Хүүхдийн уншлагын танхимын фонд
- Гэр бүлийн танхим
- "Их мэдэх" танхим /бага насны хүүхэд зориулсан/
- Монгол бичгийн болон Англи номын фонд /танхим /
- Эко танхим
- Интернет танхим гэсэн танхимуудаас бүрдэлтэй
- Нягтлан бодогчийн өрөө
- Архивын өрөө

Цахим хаягууд: library.ar.gov.mn вэб сайт болон Архангай –Нийтийн номын сан facebook page, ar.library@yahoo.com имайл хаяг, arkhangai.lib4u.net гэсэн нийтийн номын сангийн электрон каталогийн хаяг .

Цагийн хуваарь: Даваа-Баасан гаригт ,Өглөө 9:00-13:00, 14:00-19:00 цаг

Байгуулагын утасны дугаар : 70333248 **Номын сангийн захирал:** О.Мөнхтуяа

ХОЁР. САН ХӨМРӨГ , КАТАЛОГ

2.1 Сан хөмрөгийн өнөөгийн байдал:

Тус номын сан нь орон нутгийн онцлог, уншигчдын эрэлт хэрэгцээ шаардлагыг үндэслэн төсвийн болон хандивын журмаар фондоо бүрдүүлж байна.

2019 онд Нийтийн номын санд 4,100.0 төгрөгөөр ном тогтмол хэвлэлийн бүтээгдэхүүн худалдан авахаар төсөвлөснөөс 97 нэр төрлийн 187 ширхэг ном, 11 нэр төрлийн 632 ширхэг сонин, 6 нэр төрлийн 53 ширхэг сэтгүүл, хандиваар 44-н нэр төрлийн 233 ширхэг 4,074.720 төгрөгний номоор фондын баяжилт хийж, номын сангийн төрөлжсөн танхимуудад хуваарилан, техник ажиллагааг хийж, электрон каталогт оруулах ажлыг хийж гүйцэтгэж байна.
МҮНС-гаас сумдын номын сангуудад 7-н нэр төрлийн 152 ширхэг 4,460.440 төгрөгний ном хандивласныг нь соёлын төвийн номын сангуудад хүлээлгэн өгсөн.

2.2 САН ХӨМРӨГИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

1. Урагдаж гэмтсэн нийт 250 ширхэг сэтгүүл, 985 ширхэг номыг үдэж хавтаслаж, хаяг ялгагчийг шинээр хийж сэлбэн засаж, уншлаганд гаргахад бэлэн болгов.

2. 2019 онд захиалсан 27 нэгж сонин 11 нэгж сэтгүүлийг үдэж хавтаслан тогтмол хэвлэлийн фондод шилжүүллээ.

3. Үндсэн фондын номын дансыг шинээр хуулж номын ангилалыг шинэчилнэ ангилж, дансыг шинээр хуулах ажлыг Фондын номын санч Л.Өсөхбаяр хийж гүйцэтгэж байна.

2.3 КАТАЛОГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Номын сангийн цогц програм болох LIB4U.net/*Электрон каталог, Номын бүртгэлийн модуль, Үйлчилгээний модуль, Тооллогын модуль, Тайлангийн модуль(Дагалдах: Номын санчийн эрх тохируулах бүртгэлийн модуль ашиглах эрх; Зураасан код, формуляр хэвлэх эрх; Уншигчийн бүртгэлийн модуль ашиглах, үнэмлэх хэвлэх эрх; Материалын агуулгын бүлэг тохируулах эрх; Нэг бүрчилсэн бүртгэлийн данс тохируулах эрх; дансны баримт өөрчлөх эрх; Ангилал, Хэл, Хот, Хэвлэлийн газрын бүртгэлийн модуль ашиглах эрх; Цаасан каталогийн модуль ашиглах эрх) Тогтмол хэвлэлийн программ; /Тогтмол хэвлэлийн бүртгэлийн модуль ашиглах эрх/Уншигч гэрээр авсан материалынхаа буцааж өгөх хугацааг сунгах хүсэлтийг онлайнаар илгээх түүнд номын санч хариулах эрх*/ худалдан авч суурьлуулан үйлчилгээндээ нэвтрүүлж байна.
2.4. Нийтийн уншлагын танхим 3992 нэр төрлийн 4146 ширхэг ном Хүүхдийн уншлагын танхим нь 3551 нэр төрлийн 3831 ширхэг ном, Үндсэн фондын 382 нэр төрлийн 1146 номыг элекрон каталогт шивж оруулан, тогтмол хэвлэлийн фондын 195 нэр төрлийн 2187 ширхэг сонин, сэтгүүлийг шивж, бар кодыг нааж тавиурт байрлуулав.

ГУРАВ.ҮЙЛЧИЛГЭЭ.

3.1. Уншлагын танхим

Нийтийн номын сан нь 2019 онд 1935 уншигч шинээр бүртгэж, 58534 иргэсдэд 72864 ном, 377 сэтгүүл,1040 сонин хэвлэлээр үйлчилсэн байна. Үүнээс:
1. **Нийтийн уншлагын танхимд:** Нийт 980 уншигч шинээр бүртгэж 16675 иргэсдэд 28320 ном,331 сэтгүүл, 1213 сонин хэвлэлээр үйлчилсэн байна.
2. **Хүүхдийн уншлагын танхимд:** Нийт 625 уншигч шинээр бүртгэж 27822 иргэсдэд 33300 номоор үйлчилсэн байна.
3. **Интернет танхимд:** Интернет танхимаар 14-өөс дээш насны 70 хүүхэд, оюутнуудад цахим мэдээ мэдээллийн үйлчилгээг үзүүллээ.

-Нийтийн номын сангийн уншигч ном олголт нь сүүлийн 4-н жилийн дундажаас үзэхэд өссөн үзүүлэлттэй байна.

4. **Зөөврийн номын санд:** Иргэд, олон нийтэд номын сангийн үйлчилгээг тэгш хүргэж, хүртээмжийг нэмэгдүүлэх, номын сангаас гадуурх уншигч, хэрэглэгчдийн хүрээг өргөжүүлэх зорилгоор тусгайд нь зөөврийн номын санч ажиллуулан аймгийн ЗДТГ, Эрдэнэбулган сумын ЗДТГ, БСУГ, Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Газар, Татварын Хэлтэс, Мэргэжлийн Хяналтын Газар, Онцгой Байдлын Газар, Цагдаагийн Газар, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Газар, Шүүхийн Тамгийн Газар, Ахмадын Хороо, Статистикийн Газар, Төрийн сангийн хэлтэс, "Ард" даатгал, БОАЖГ, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, "Тана Арцат" эмнэлэг, Олон нийтийн өмчийн газар, ГХБХБГ зэрэг 23 байгууллагад зөөврийн номын сангийн гэрээний дагуу үйлчилгээ хүргэн ажиллаж нийт 358 уншигч шинээр бүртгэж 1609 уншигчид /давхардсан тоогоор/ 3271 ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр үйлчиллээ.

5.**Гэрээр ном олголт:** 3000 ирэгсдэд /давхардсан тоогоор/ 4372 ном, 923 сонин хэвлэл, 96 сэтгүүлээр үйлчилсэн байна.

6.**Явуулын номын сан**

Насан туршын боловсролын төв, үндэсний тоглоомын өвлөн уламжлагч Хасбазарын Батбаяртай хамтран, төвөөс алслагдсан сумын иргэдэд шинэлэг мэдээ мэдээллийг хүргэх,шинэ номоор үйлчилгээ үзүүлэх, нутаг орны онцлог, түүх, түүхэн хүмүүсийн намтар, газар усны нэршлийг таниулах зорилгоор, Өндөр-Улаан сумын төв, Тариат сумын Мөрөн багийн төв дээр 04-р сарын 21-ээс, 04-р сарын 22-ны өдрүүдэд "Явуулын номын сан"-ын үйлчилгээг 500 гаруй иргэнд хүргэлээ.

Цахим ертөнцийн зохистой хэрэглээг бий болгож, иргэдийг номтой нөхөрлүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх , ном унших соёлыг дэлгэрүүлэх, номыг бүтээлчээр унших арга зүйг түгээх, *эх оронч оюунлаг, иргэн хүн болгон төлөвшүүлэх.зорилгоор*"Facebook-д зарцуулдаг цагаа ном уншихад зориулъя аян"-ыг эхлүүлэн, аяны хүрээнд 07-р сарын 06-нд Хүүхдийн "Тамир"

зусланд, 07-р сарын 18, 19-нд Жамганы булаг, Булган уулын өвөр, 2-р багийн Арслан цохионд байх тоглоомын талбайн орчим, бурхан багшийн гэгээрлийн хаалганы урд талбайд байрлаж, явуулын номын сангийн үйлчилгээг 100 орчим уншигчид хүргэсэн байна.

3.2. “ИХ МЭДЭХ” ТАНХИМ

“Их мэдэх” танхимаар Эрдэнэбулган сумын 4,5,6,9,12,13-р цэцэрлэгийн дунд, ахлах, бэлтгэл бүлгийн нийт 1580 хүүхэд Хүүхдийн номын ордны үйл ажиллагаатай танилцаж, “Үлгэрийн цаг”-т хамрагдан, үлгэрийн болон, танин мэдэхүйн 3200 гаруй номоор үйлчлүүллээ.

3.3.“ЭКО” УНШЛАГЫН ТАНХИМ

БСШУСЯ-ны СУХС-ийн төслийн дэмжлэгтэйгээр хүүхэд, багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эх орон, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах чинь хүсэл эрмэлзэлтэй, эх оронч, монгол иргэнийг төлөвшүүлэх зорилгоор байгальд ээлтэй "Эко" танхимыг Хүүхдийн номын ордонд шинээр нээж, нээлтийн үйл ажиллагааг 10-р сарын 24-ний өдөр зохион байгууллаа. “Эко” танхимын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан таниулах, экологийн боловсрол олгох

зорилгоор урилгат үйлчилгээг зохион байгуулж, өдөртөө 100-150 гаруй хүүхэд багачууд эцэг, эх, багш, иргэдэд үйлчилж байна. Аймгийн БОАЖГ-тай хамтран байгаль хамгааллын талаар бэлтгэсэн гарын авлага, зурагт хуудсыг үйлчлүүлэгч бүрт түгээх, мэдлэг олгох ажлыг зохион байгуулж байна.

Байгалийн шинжлэх ухааны номоор үзэсгэлэн гаргаж, уншлага зохион байгуулахын зэрэгцээ байгаль, эх дэлхий, ургамал, ан амьтнаа хайрлан хамгаалахад хүүхэд бүрийн оролцоог чухалчлан, танин мэдэхүйн мэдлэг олгох богино хэмжээний сургалт зохион байгуулж байна Цаашид “Эко” танхимын үйл ажиллагааг чанаржуулах зорилгын хүрээнд аймгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүд бусад сонирхогч иргэдтэй хамтран цэцэг үрслүүлэх, тарих, гэрийн тэжээвэр амьтдыг тэжээх, арчлах талаар сургалтуудыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Одоогийн байдлаар тус танхимаар цэцэрлэгийн насны 350 хүүхэд, ЕБС-ийн бага, дунд бүлгийн сурагчид болон бусад 470 гаруй уншигчид үйлчлүүлсэн байна.

“АНГИЙН УНШЛАГА”

Эрдэнэбулган сумын 1,2,3,4-р сургууль, “Ирээдүй”сургууль-цэцэрлэгийн цогцолбор, Спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын “Эрдэм” ахлах сургуулийн 6а, 7а, 8а бүлэг, 3-р сургуулийн Б. Банзрагч багштай 9б анги, 7г, 7а, анги, Лаборатори 1-р сургуулийн Одгэрэл багштай 7в анги 2-р сургуулийн 8а 5000 гаруй сурагч ангийн хуваарьт уншлагат хамрагдаж 6000 номоор үйлчилгээ авч, номын тэмдэглэл хөтөллөө.

Урилгат “Чанга уншлага”:

2019 оны 3 - сарын 1-ээс бага бүлгийн сурагчдын унших чадварыг нэмэгдүүлэх, номонд дуртай болгох зорилгоор хүүхдийн уншлагын нэг хэлбэр болох “Чанга уншлага”-ыг ЕБС-иудын 1,2-р ангийн сурагчдын дунд зохион байгуулж эхэллээ. Чанга уншлагат Эрдэнэбулган сумын 3-р сургуулийн Ё.Байгалмаа багштай 2а ангийн 43 сурагч , 3-р сургуулийн П. Наранцэцэг багштай 1б ангийн 29 сурагч, 3-р сургуулийн Бямбажав багштай 1а ангийн 30 сурагчид , 3-р сургуулийн П. Наранцэцэг багштай 1б ангийн 32 хүүхэд, СТС-тай ЕБС-ийн Б. Золжаргал багштай 2а бүлгийн 31 сурагч, дотуур байрны Ё. Оюун-Эрдэнэ багштай бага, дунд ангийн 21 сурагч, Лаборатори 1-р сургуулийн С.Энхцэцэг багштай 2а ангийн 37 сурагч , 4-р сургуулийн П. Оюунчимэг багштай 2б ангийн 33 хүүхэд, давтагдсан тоогоор нийт 408 ирэгсэд, 1224 номоор үйлчлүүлсэн

3.3. “БОРОЛДОЙ” ҮЛГЭР УНШИХ ЦАГ

БСШУС-ын сайд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч болон Архангай аймгийн Засаг даргын хооронд 2017 онд засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний “Үлгэрийн цаг” үлгэр унших тогтмол цагтай болгох гэрээний заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Хүүхдийн уншлагын танхим нь “Их мэдэх” танхимаар үйлчлүүлсэ

н болон сонирхсон хүүхдүүдтэй "Боролдой" үлгэр уншлагыг 13 удаа зохион байгуулж 1300 гаруй байнгын уншигчдийг хамруулаад байна.

3.4. НОМЫН ҮЗЭСГЭЛЭН

2019 онд нийт 21 удаагийн шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг эдийн засаг, анагаах ухаан, техникийн шинжлэх ухаан, монголын уран зохиол, гадаадын уран зохиол, байгаль экологи, түүхэн ном болон бусад сэдвийн 1411 ш номоор гаргасан байна.

Нийтийн уншлагын танхимд: 6 удаагийн сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 490 номоор гаргаж уншигчдад сурталчилан таницуулсан. Үүнд:

1. Шинэ номын үзэсгэлэн /60ном/ 2 удаа
2. "Үндэсний бичиг үсгийн баяр-2018" арга хэмжээнд зориулан номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа монгол бичгээр хэвлэгдсэн номын үзэсгэлэн /50 ширхэг ном/
3. МУ-ын түүх, соёл, ёс заншлын 90 ш ном
4. Тулгар төрийн 2226 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 811, Ардын хувьсгалын 96 жилийн ой, үндэсний их баяр наадмыг тохиолдуулан үндэсний бөхийн тухай 20ш, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын Уран Зохиолч, СГЗ, Төрийн шагналт, доктор, УБИС-ийн хүндэт профессор, ХХ зууны манлай сэтгүүлч Л.Түдэвийн Бүтээлийн 30 боть чуулган цуврал номоор "Монгол бахархал" сэдэвт номын үзэсгэлэн
5. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас зарласан " Уламжлал-Ирээдүй" аяны хүрээнд "Өв соёл" сэдэвт 86 ширхэг ном
6. МУ-ын түүх, соёл, ёс заншлын 90 номоор үзэсгэлэн гаргаж, чөлөөт сонголтоор уншигчдын хүртээл болголоо.

Хүүхдийн уншлагын танхимд: 11 удаагийн шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг нийт 671 ширхэг номоор гаргаж уншигчдад сурталчилан танилцууллаа. Үүнд:

1. "Өвөр Монголын кирилл, монгол бичгээр хавсран хэвлэгдсэн хүүхдэд зориулсан үлгэрийн шинэ номын үзэсгэлэн /100ш ном/
2. ЕБС-ийн сурагчдад зориулан улсын шалгалтанд бэлтгэх хичээлийн нэмэлт гарын авлага, сурах бичгийн үзэсгэлэн /50 ширхэг ном/

3. Шинэ номын үзэсгэлэн гарган уншигчдад сурталчилж, тэдний хүртээл болголоо. / 75 ном /

4. МУ-ын СГЗ, орчуулагч, зохиолч Ж.Гэндэндарамын монгол хэлэнд орчуулсан эртний Энэтхэгийн соёлын "Алтан үеийн" алдарт бүтээлүүд болох 21 боть номын үзэсгэлэн /21 боть ном/

5. Хүүхдийн уншлагын танхимд "Яагаад?" танин мэдэхүйн цуврал, 1-р ангийн сурагчдын унших чадварыг дээшлүүлэхэд зориулсан "Үелж унших ном" цуврал, "Охидын үлгэр", "Хөвгүүдийн үлгэр" цуврал 55ш ном

6. Шинэ номын үзэсгэлэн / 65ш ном /

7.Хүүхдийн уншлагын танхимд сурагчдын амралт, чөлөөт цагийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн монголын хүүхдийн уран зохиол, аман зохиол, танин мэдэхүйн чиглэлийн номын үзэсгэлэн / 60 ширхэг ном /

8. Хичээлийн шинэ жилийн нээлтэнд зориулан сурах бичиг, гарын авлага, танин мэдэхүйн чиглэлийн /75 ширхэг ном/

9. Номын баяр-2019" арга хэмжээнд зориулан "Үлгэрийн ертөнцөөр аялацгаая" сэдэвт дэлхийн болон монгол үлгэрийн 50 ширхэг.

10. "Эко" танхимын нээлтэнд зориулан байгаль шинжлэлийн 20 ширхэг номын үзэсгэлэн гаргаж, уншигчдад нээлттэй сурталчиллаа.

11. Шинэ номын үзэсгэлэн / 100ш ном / номын үзэсгэлэнг тус тус гарган, чөлөөт сонголтоор уншлага зохион байгуулж, гэрээр олгон үйлчиллээ

Үндсэн фондод: 5 удаагийн нийт 260 ш номоор үзэсгэлэнг гаргаж иргэд олон нийтэд сурталчилсан.**Үүнд:**

1"Үндэсний бичиг үсгийн баяр-2018" арга хэмжээг тохиолдуулан 28 ш үнэт ховор номын үзэсгэлэнг гаргаж иргэд олон нийтэд сурталчилсан.

2. Их жанжин Д Сүхбаатарын мэндэлсэний 126жилийн ойд зориулан, Түүхэн номын үзэсгэлэн /50 ширхэг номоор/

3. Үндсэн хууль, улс тунхагласны баярт зориулсан номын үзэсгэлэн /30 ном/

4.Тусгаар тогтнолын өдөрт зориулсан номын үзэсгэлэн /70ш ном/

5. Шинэ номын үзэсгэлэн /90ш ном/

-2019 оны байдлаар номын үзэсгэлэн гаргасан болон үзсэн үйлчлүүлэгчийн тоо өмнөх онуудтай харьцуулахад өссөн үзүүлэлтэй байна.

a. ЛАВЛАГАА , МЭДЭЭЛЭЛ

"Хүмүүн бичиг" сонины 2011-2017 он, Архангайн амьдрал сонины 2008-2018 он, Монголын үнэн сонины 2018 он, Зууны мэдээ сонины 2017-2018 он, Архангай үнэн сонины 1968-1996он, Өдрийн сонин 2016-2018 он, Төрийн мэдээллэл, Боловсрол судлал, зэрэг нийт 120 нэгж сонин сэтгүүлээс уншигч хэрэглэгчдэд хууль эрх зүйн болон бусад хэрэгцээт мэдээллийг шүүж, лавлагаа мэдээллийн үйлчилгээ хүргэн ажиллаа.

3.7. МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН АЖИЛ

2. Өндөр- Улаан сумын Соёлын төвийн номын санч Х.Мөнхбаяр, Чулуут сумын Соёлын төвийн номын санч Н.Батбаяр, Жаргалант сумын номын санч Р. Энхцэцэг, Цахир сумын номын санч Э.Нямсүрэн нарт номын санд хөтлөгдөх анхан шатны бүртгэлүүдийг хөтлөх, номын техник ажиллагааг гүйцэтгэх, фондын зохион байгуулалтын талаар, Эрдэнэбулган сумын 2-р сургуулийн номын санч Дуламаад Monbiblio номын сангийн цахим программд ном шивэх талаар номын санч А.Ундармаа мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Мөн сумдын соёлын төвийн номын санчдад "Соёл урлагийн байгууллагын ажилтны тогтвортой хөгжил, чадварлаг ажилтан" 1 өдрийн сургалтыг зохион байгуулж 25 хүн хамрагдлаа.

ДӨРӨВ. СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

1. Их жанжин Д Сүхбаатарын мэндэлсэний 127 жилийн ойд зориулан "Түүхэн номууд" /48 ширхэг ном/ , Их жанжин Д.Сүхбаатартай холбоотой мэдээллүүдийг нийтэлсэн 5 нэгж сонингоор тус тус үзэсгэлэн гаргаж, Эрдэнэбулган сумын иргэдийн дунд АХА тэмцээнийг зохион байгууллаа./60-н уншигч хамрагдлаа.

2. ЭЭЖДЭЭ ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ захидлын уралдаан.

Захидлын уралдааныг аймгийн ИТХ-ын ажлын алба, , аймгийн ХДТ-тай хамтран аймгийн Нийтийн номын сан, "Архангайн толь" сониноос 6 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

Тус уралдааныг хүүхэд, насанд хүрэгчид гэсэн 2 ангиллаар зохион байгуулж, нийт 300 гаруй захидлыг хүлээн авч, шилдгүүдийг шалгарууллаа.

Хүүхдийн ангилалд: Тэргүүн байрыг Спортын төрөлжсөн сургалттай ЕБС-ийн 12а ангийн сурагч М.Бадамханд, дэд байрыг

Лаборатори 1-р сургуулийн 10в ангийн сурагч Т.Баасанжаргал, гутгаар байрыг Эрдэнэмандал сумын ЕБС-ийн 6а ангийн Б. Эрдэнэбаатар, “Онцлох захидлын эзэн”-ээр Төвшрүүлэх сумын ЕБС-ийн 9а ангийн сурагч Э. Анхбаяр, Лаборатори 1-р сургуулийн 6а ангийн сурагч М. Мичидмаа, 11в ангийн сурагч М. Ариунжаргал нар, тусгай байрыг Эрдэм ахлах сургуулийн 11а ангийн сурагч Тэрбиш, 8а ангийн сурагч М. Хунцэнгэл, Булган сумын ЕБС-ийн 7а ангийн сурагч Номин, Лаборатори 1-р сургуулийн 11г ангийн сурагч Б. Жавзандулам, 3-р сургуулийн 12б ангийн сурагч Х. Ууганзаяа, Хотонт сумын ЕБС-ийн 11а ангийн сурагч Б.Энхтуяа, Эрдэнэмандал сумын ЕБС-ийн 6а ангийн сурагч А. Алтаншагай, Эрдэнэбулган сумын 4-р сургуулийн 11а ангийн сурагч Н. Эрдэнэчулуун нар тус бүр шалгарсан байна.

Насанд хүрэгчдийн ангилалд: Тэргүүн байрыг Эрдэнэмандал сумын ЕБС-ийн монгол хэл-уран зохиолын багш Анхцэцэг, дэд байрыг “АВ” телевизийн сэтгүүлч Б. Мандуул, гутгаар байрыг Чулуут сумын ЕБС-ийн багш Г. Нансалмаа, тусгай байрыг Эрдэнэбулган сумын 11-р цэцэрлэгийн багш Д. Эрдэнэхишиг, Эрдэнэбулган сумын иргэн, Б. Тунгалаг, Мөнх-Эрдэнэ нар тус бүр шалгарлаа.

“Ээждээ захидал бичээрэй-2019” уралдааныг аймгийн ИТХ-ын ажлын алба, “Ээждээ захидал бичээрэй-2018” уралдааны тэргүүн байрын шагналт аймгийн Аудитын газрын дарга Уламбаяр, Мон-Ца-Мэ агентлагийн Архангай дахь сурвалжлагч Б. Гэрэлт-Од, “Улам баяжихуй” ХХК, Ундрам төв, Фаберлик компаний Архангай дахь салбар, “Тэнгэрлэг ертөнц” ТББ тус бүр ивээн тэтгэн оролцлоо.

3.ААВДАА ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ-2019 захидлын уралдаан.

03.17. Аймгийн Нийтийн номын сан, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Архангай салбар хамтран “ААВДАА ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ“ захидлын уралдааныг 2018 оноос анхлан санаачилж зохион байгуулж ирсэн бөгөөд 2019 оны захидлын уралдааныг аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Шүүхийн тамгын газар, “Архангай толь” сонины редакци зэрэг байгууллагууд ивээн тэтгэгчээр оролцож, хамтран зохион байгууллаа. Захидлын уралдаанд насанд хүрэгчид, хүүхдийн ангилалд нийт 280 гаруй захидал ирснээс 30 захидал шалгаруулж 16-н шагналт байрыг тодоруулав.

Насанд хүрэгчдийн ангилалд: Тэргүүн байрыг МУБИС-ийн Архангай дахь Багшийн сургуулийн монгол хэл-уран зохиолын 4а ангийн оюутан Б.Батбаяр, дэд байрыг ШШГГ-ын хүмүүжигч Э.Мөнх-очир, гутгаар байрыг Цэцэрлэг Сумын ЕБС-ийн багш Г.Цогцолмаа, тусгай байрыг Архангай аймаг дахь ШШГГ-ын хүмүүжигч,Л.Мөнхбат Б.Ганболд нар

Хүүхдийн ангилалд тэргүүн байрыг Эрдэнэмандал сумын ЕБС-ийн 6а ангийн сурагч А.Эмүжин, дэд байрыг Эрдэнэмандал сумын ЕБС-ийн сурагч

А.Аззаяа, гутгаар байрыг Лаборатори 1-р сургуулийн 11г ангийн сурагч Б.Хосбаяр , дөтгөөр байрыг Лаборатори 1-р сургуулийн 6г ангийн сурагч М.Янжинлхам Тусгай байранд Лаборатори 1-р сургуулийн 10в ангийн сурагч Н.Азжаргал,Э. Ундрах, Г.Мөнхтамир, 9д ангийн сурагч Б.Бат-Эрдэнэ, Т. Мишээл-Хан, Эрдэнэмандал сумын ЕБС-ийн 6а ангийн сурагч Б.Эрдэнэ-Баатар, Эрдэнэмандал сум ЕБС-ийн 9а ангийн сурагч Г.Намуунаа нар тус бүр шалгарч, өргөмжлөл, дурсгалын зүйл, мөнгөн шагналаар урамшууллаа.

4.“АВТОБУСТАЙ УНШЛАГА”-2019

04.23-ны өдөр. "Дэлхийн номын өдөр"- ийг тохиолдуулан аймгийн Нийтийн номын сангаас жил бүр зохион байгуулдаг "Автобустай уншлага - 2019" арга хэмжээнд Булган сумын ЕБС-ийн 8-9-р ангийн 46 сурагч, номын санч, багш нар хамрагдлаа.

Тус арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг дарга Ц.Мөнхнасантай уулзалт зохион байгуулан, аймгийн ХГБЗХГ-ийн үйл ажиллагаатай танилцан, “Тамир” кино театрт “Ээжээ таньдаа хайртай” богино хэмжээний баримтат кино, аймгийн Музей үзэх, Нийтийн номын сангийн үйл ажиллагаа, танхимуудтай танилцах, “Миний Архангай” танин мэдэхүйн номын агуулгын хүрээнд уралдаант АХА тэмцээн зохион байгуулах, Насан Туршийн Боловсролын Төвийн захирал Х.Отгонцэцэгийн “Нийгэмд эерэг харилцааг бүтээцгээе” сургалт зэрэг арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгууллаа.

АХА тэмцээнд тэргүүн байрыг Булган сумын ЕБС-ийн 9а ангийн сурагч Ж.Дэлгэржаргал, дэд байрыг 9а ангийн сурагч Э. Долгорсүрэн, гутаар байрыг 8а ангийн сурагч О.Цогт-Очир нар тус бүр эзэллээ.

“Автобустай уншлага-2019” арга хэмжээг Булган сумын ЗДТГ, ЕБС-ийн захиргаа, аймгийн ХГБЗХГ, Музей, НТБТ зэрэг байгууллагууд дэмжин, хамтран ажиллаа.

5. ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР-2019

МУ-ын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 тоот зарлигийг хэрэгжүүлэх, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, үндэсний бичиг соёлоороо бахархах үзэл, ухамсарыг олон түмний оюун санаанд төлөвшүүлэх, сурах, судлах эрмэлзэл төрүүлэх өв уламжлалыг сэргээх, сурталчилан таниулах, эх оронч, хүмүүнлэг үзлийг

Төлөвшүүлэх зорилгоор “Үндэсний бичиг үсгийн баяр-2019” арга хэмжээ, “Жаямъянгарав ба утга зохиол” эрдэм шинжилгээний бага хурлыг 2019 оны 05 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд Аймгийн Засаг даргын тамгийн газар, БСУГ, ХБХЗХГ, Архангай аймгийн багшийн сургуультай хамтран Нийтийн номын сан дээр зохион байгууллаа.

Насанд хүрэгчид, ЕБС-ийн ахлах, дунд бүлгийн сурагчдын дунд “”Зөв сайхан бичигтэн”, “Түргэн уншлага”-ын уралдааныг тус бүр зохион байгуулж, шилдэгүүдийг тодрууллаа. “Зөв сайхан бичигтэн” уралдааны насанд хүрэгчдийн ангилалд тэргүүн байрыг Жаргалант сумын ЕБС-ийн түүх-нийгмийн ухааны багш Б.Баасансүрэн, дэд байрыг Өндөр-Улаан сумын ЕБС-ийн англи хэлний багш Б.Пүрэвдулам, ахлах насны ангилалд тэргүүн байрыг Хайрхан сумын ЕБС-ийн сурагч Г.Анударь, дэд байрыг 4-р сургуулийн 11а ангийн сурагч Энхмандах, гутгаар байрыг Төвшрүүлэх сумын ЕБС-ын 11а ангийн сурагч М. Золмаа,Тусгай байрыг Хайрхан сумын ЕБС-ын 10а ангийн сурагч Энхчимэг, ЕБС-ийн дунд насны ангилалд тэргүүн байрыг Эрдэнэбулган сумын Лаборатори 1-р сургуулийн 9а ангийн сурагч Н.Маралмаа, дэд байрыг Хайрхан сумын ЕБС-ийн 8б ангийн сурагч М. Ану, гутгаар байрт Тариат сумын ЕБС-ийн 9б ангийн сурагч Г.Даваадулам нар тус бүр шалгарсаныг, өргөмжлөл хадгалуулж мөнгөн шагналаар урамшуулав.

“Тод, Зөв, Түргэн” уншлагын уралдааны насан хүрэгчдийн ангилалд тэргүүн байрыг ГБХЗХГ-ын мэргэжилтэн Д.Орхонтуул, дэд байрыг 4-р сургуулийн бага ангийн багш Б. Урантөгс, гутгаар байрт Хайрхан сумын ЕБС-ийн Түүх Нийгмийн ухааны багш Чулуунбаатар нар шалгарсаныг мөнгөн шагналаар урамшуулж өргөмжлөл хадгалуулав. ЕБС-ийн ахлах насны ангилалд тэргүүн байрыг 4-р сургуулийн 10а ангийн сурагч Э.Энхмандах, дэд байрыг Хайрхан сумын ЕБС-ийн 11а ангийн сурагч П. Одончимэг, гутгаар байрыг Хайрхан сумын ЕБС-ийн 11а ангийн сурагч Г.Анударь, тусгай байрыг Ихтамир сумын ЕБС-ийн 11а ангийн сурагч Б. Отгонзаяа нар тус бүр

байр эзэлж медаль, өргөмжлөл хадгалуулж мөнгөн шагналаар шагнав. ЕБС-ийн дунд насны ангилалд тэргүүн байрыг Эрдэнэбулган сумын Лаборатори 1-р сургуулийн 9б ангийн сурагч Т.Хонгорзул, дэд байрыг Хайрхан сумын ЕБС-ийн 9а ангийн сурагч М. Солонго, гутгаар байрыг 3-р сургуулийн 8а ангийн сурагч Э. Энхжин, тусгай байрыг 4-р сургуулийн 8а ангийн сурагч Оюун-Эрдэнэ нар тус бүр эзэлсэнийг өргөмжлөл хадгалуулж, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

Иргэд, олон нийтэд монгол үндэсний бичгийн өв соёл, уламжлал, өнөөгийн хөгжлийн чиг хандлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчилан таниулах зорилгоор тэнгэрийн бичиг-2019" уран бичлэгийн үзэсгэлэнг Аймгийн Нийтийн номын санд

зохион байгууллаа.Үзэсгэлэнд өөрийн бүтээлээрээ амжилттай оролцсон СТСЕБС-ийн Монгол хэл уран зохиолын багш О.Баасанд өргөмжлөл хадгалуулж, мөнгөн шагналаар урамшууллаа.

Нийтийн номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй үнэт ховор эртний судар, монгол бичгээр хэвлэгдсэн номын үзэсгэлэн, Номын сангийн үзэсгэлэнгийн танхимд "Тэнгэрийн бичиг-2019" уран бичлэгийн үзэсгэлэн гаргаж уншигчдад сурталчилах ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус үзэсгэлэнг 100 гаруй хүн

үзэж сонирхлоо. "Үндэсний бичиг үсгийн баяр-2019" арга хэмжээний уралдааны 3 насны ангилалд Ихтамир, Цэнхэр, Хайрхан, Өндөр-Улаан, Хашаат, Өлзийт, Хотонт, Тариат, Эрдэнэбулган зэрэг 10 гаруй сумаас 250 гаруй хүн оролцогчоор, 100 гаруй хүн сонирхогчоор, нийт 350 гаруй хүн хамрагдсан байна.

МУСГ-т зүтгэлтэн, зохиолч Монгол уламжлал акедемийн тэргүүн Доктор Профессер Л.Дашням,
МЗЭ-ийн шагналт зохиолч Хан тамир утга зохиолын төвийн тэргүүн, Минжинсайхан
МЗЭ-ийн шагналт зохиолч Хан тамир төвийн гүйцэтгэх захирал Б.Урангоо
МЗЭ-ийн гишүүн "гайхамшигт амьдрал" сэтгүүлийн эрхлэгч - Д.Хишигжаргал нар уншигч, яруу найраг сонирхогчидтой уулзаж санал бодлоо солилцон өөрсдийн зохиол бүтээлээс уншиж сонирхууллаа. Дуу, шүлэг, яруу найргын авьяасаа зохиолч уншигчиддаа сонирхуулсан 10 орчим уншигчид гарын бэлгээ гардууллаа. Уншигч зохиолчдын уулзалтанд 60 гаруй хүн хамрагдлаа.

"Жаямъянгарав ба утга зохиол" эрдэм шинжилгээний бага хуралд

-Хэл бичгийн ухааны доктор (PhD), дэд профессор Д.Ганболд
"Бат сүжигт, Бандида хамбо Жамъянгаравын сүмбүмд дурдсан бүтээлүүдийн тухайд"

- Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн доктор, профессор Л.Дашням.
"Утга зохиолоор дамжуулан монголчуудыг соён гэгээрүүлж ирсэн тоймоос"

- МУБИС-ийн Архангай багшийн сургуулийн багш Д.Чимэгбаатар, П.Алтанзул "Утга зохиолын онолын хөгжлийн асуудалд"
- Сурган хүмүүжүүлэх ухааны шинжлэх ухааны доктор (SnD),профессор Ч.Пүрэвдорж, "Жамъянгарав гэгээнтний үйл бүтээлээс улбаалан бурханы шашны гүн ухааныг төсөөлөх төдий өчүүхэн санаа" –
- Доктор PhD Ц.Наранцэцэг, Анагаах ухааны магистр Б. Батхуяг
"Хувилгаан дагшинт Жамъянгарав алдартны төрөл үеийн магтаал товч хураангуйн тухайд"сэдэвт илтгэл, эрдэмшинжилгээний бүтээлүүдээ хэлэлцүүллээ.

6."ГЭГЭЭ" НОМ СОНИРХОГЧДЫН КЛУБ

Архангай аймгийн Нийтийн номын сангийн дэргэдэх "Гэгээ" ном сонирхогчдын клуб байгуулагдан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж 4 удаагийн арга хэмжээнд 60 орчим уншигч ном сонирхогчид хамрагдлаа.

7.“УНШЛАГЫГ ДЭМЖЬЕ" УРИАТАЙ НОМЫН БАЯР-2019 АРГА ХЭМЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлж, орон нутагт ном унших хөдөлгөөнийг өрнүүлэх, ард иргэд хүүхэд залуусын ном унших хүсэл сонирхолыг хөхиүлэн дэмжиж зөв, оюунлаг,эх оронч үзэл санаатай монгол иргэнийг төлөвшихөд нь дэмжлэг болох зорилгоор " Уншлагыг дэмжье" уриатай номын баяр-2019 арга хэмээг 2019 оны 10-р сарын 18, 19ны өдрүүдэд Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран таван төрлөөр амжилттай зохион байгууллаа.

1. Цэцэрлэгийн насныханы дунд "Ном" сэдэвт дүрийн тоглолтонд 13 цэцэрлэг авьяас чадвараа сорьсоноос: Тэргүүн байранд Эрдэнэбулган сумын 2-р цэцэрлэг, дэд байранд 13-р цэцэрлэг, гутгаар байранд 3-р цэцэрлэг, тусгай байранд 6-р цэцэрлэг шалгарлаа.

2. 2-5-р ангийн сурагчдын дунд "Би уншсан номоо зурах дуртай" гар зургийн уралдаанд 200 гаруй оролцогч бүтээлээ ирүүлсэнээс: тэргүүн байранд Эрдэнэбулган сумын 4-р сургуулийн 5а ангийн сурагч М.Анхбаяр, дэд байранд Цэнхэр сумын ЕБС-ийн 5а ангийн сурагч О. Даваaням, 3-р байранд ЭБ сумын 5-

р сургуулийн 3а ангийн сурагч Б. Мөнхцэцэг, 2а ангийн сурагч Б. Нямзаяа нарын бүтээлүүд шалгарсан байна.

3. 6-9-р ангийн сурагчдын дунд "Номонд бичсэн захидал" захидлын уралдаанд 250 гаруй оролцогч захидал бичиж ирүүлсэнээс:
Тэргүүн байранд Эрдэнэбулган сумын Лаборатори 1-р сургуулийн Р.Баасаанхүү, дэд байранд Эрдэнэбулган сумын Лаборатори 1-р сургуулийн 7г ангийн сурагч

М. Мишээл гутгаар байранд ЭБ сумын 3-р сургуулийн 8в ангийн сурагч С. Хонгорзул тусгай байранд ЭБ сумын 3-р сургуулийн 8 а анийн сурагч Л. Хүсэлбаяр тус тус шалгарсан байна.
4. 10-12-р ангийн сурагдчдын дунд "Ном дотор зам бий" сэдэвт Эссэ бичлэгийн

уралдаанд 40 гаруй оролцогч эссэгээ бичин ирүүлсэнээс: Тэргүүн байранд Эрдэнэбулган сумын Лаборатори 1-р сургуулийн 10а ангийн сурагч Б.Энхчимэг, дэд байранд Төвшрүүлэх сумын Хуушааны нэрэмжит бүрэн дунд сургуулийн 12а ангийн сурагч Б. Шинэтуяа гутгаар байранд Эрдэнэбулган сумын лаборатори 1-р сургуулийн 12б ангийн сурагч Б.Мөнгөншагай тусгай байранд Эрдэнэбулган сумын Лаборатори 1-р сургуулийн 10а ангийн сурагч Б. Цэндсүрэн нар шалгарч өөрсдийн бичсэн эссэгээ нийт оролцогч, сонирхогчиддоо уншиж сонирхууллаа.

5. Аж ахуйн нэгж, албан байгууллагуудын дунд үлгэрийн баатрууд амилсан нь "Маск парад"-д 8 байгууллага оролцсоноос:Тэргүүн байранд Эрдэнэбулган сумын

4-р цэцэрлэг, Дэд байранд Эрдэнэбулган сумын 2-р цэцэрлэг, гутгаар байранд Эрдэнэбулган сумын 6-р цэцэрлэг, тусгай байранд Төвшрүүлэх сумын ЕБС тус тус шалгарлаа. Төрөл тус бүрт амжилттай оролцож бусдыгаа хошуучилж 1-4-р байрт шалгарсан оролцогчидод дурсамж хадгалуулж мөнгөн шагналаар шагналаа.

“Уншлагыг дэмжье" уриатай номын баяр-2019 арга хэмээг тохиолдуулан Аймгийн номын сангийн идэвхтэн уншигч Монгол улсын гавъяат багш М. Шагдарсүрэн, өндөр настан Н.Данинов, өндөр настан С.Очирпүрэв, ШШГГ-ын нярав Д.Алтанцэцэг, Аймгийн цагдаагийн газрын ажилтан Н.Нэргүйбаатар нарт

дурсамж хадгалуулж мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 11 сурагчид “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн” үнэмлэх тэмдгийг гардууллаа./2000 уншигч үйлчлүүлэгчид хамрагдсан./

8.АРХАНГАЙН УРЧУУД -2019” ҮЗЭСГЭЛЭН

11 сарын 28-аас 11 сарын 30-ныг дуустал Архангай аймгийн Зураач урчуудын хороотой хамтран уран зураг, гэрэл зураг, арьсан урлал, модон сийлбэр, баримал, хөрөг зураг, уламжлалт тоглоом наадгай, уран дархны бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж Архангай аймгийн иргэд олон нийтэд сурталчиллаа. Тус үзэсгэлэнг үзэж сонирхсон хүмүүсээс санал авч шилдэг бүтээл, шилдэг бүтээлчийг шалгаруулсан. Үзэсгэлэн 3 хоногийн хугацаанд Нийтийн номын сангийн байранд гарсан бөгөөд нийт 670 гаруй уншигч үзэж сонирохлоо.

9.”Тусгаар тогтнолын үнэ цэн” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан

Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 108-н жилийн ойд зориулан зохион байгуулсан “Тусгаар тогтнолын үнэ цэн” сэдэвт эссэ бичлэгийн уралдаанд нийт 29-н оролцогч оролцсоноос Насанд хүрэгчдийн 2 байр, ЕБС-ийн Ахлах ангийн сурагчдын 3-н байрыг тус тус шалгарууллаа.

Үүнд: 1-р байранд Лобартори 1-р сургуулийн 10а ангийн сурагч Б. Энхчимэг

2-р байранд 10а ангийн сурагч Н.Улам-Оргих

3-р байранд Лобартори 1-р сургуулийн 12Б ангийн сурагч Мөнгөншагай нар тус тус байр эзлэлээ.

Насанд хүрэгчдийн ангилалд: 1-р байранд Лобартори 1-р сургуулийн багш Буян-нэмэх

2-р байранд ОБГ-ын эрэн хайх, аврах 3-р бүлгийн эмнэлгийн зааварлагч дэд ахлагч Цэрэндэжид тус тус шалгарлаа.

-Соёл олон түмний ажлыг өмнөх жилүүдийн дундажаас харахад 2019 онд өссөн үзүүлэлттэй байна.



НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ

04-р сарын 25-ны өдөр аймгийн ЗДТГ-аас “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд Г. Дэмидийн талбайд зохион байгуулсан төрийн

байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож, насанд хүрэгчид, хүүхдэд зориулсан 42 ширхэг шинэ номын үзэсгэлэн гаргаж, олон нийтэд сурталчилаа. Нийтийн номын сангийн үйл ажиллагааг таниулан сурталчилж, 24 шинэ уншигч бүртгэлээ.

ТАВ. ХҮНИЙ НӨӨЦ:

Сургалт, семинарт хамрагдсан байдал

1. 3-р сард Үндэсний Статистикийн Хорооноос төрийн албан хаагчдын дунд зохион байгуулсан “СУ” мэдээ гаргах шинэ программын сургалтанд мэдээлэл-технологийн ажилтан Б.Ариунзаяа, номзүйч-каталогч Э.Энхнаран нар хамрагдлаа.

2. МУБИС-ийн номын сангийн захирал Ж Баатарсүрэнгийн “Цахим орчин дахь номын сан” сургалтанд хамт олноороо хамрагдлаа.

3. 05 дугаар сарын 17-ны өдөр “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлт” сургалтанд ном зүйч-каталогч Э.Энхнаран хамрагдсан.
4.ЭМГ-аас зохион байгуулсан “өдөр тутамын дасгал хөдөлгөөн”-ий сургалтанд хүүхдийн номын санч А. Ундармаа хамрагдаж сургагч багшаар бэлтгэгдсэн.
5.Соёл урлагийн их сургуулийн номын сан судлал хөтөлбөрийн зайн сургалтанд 2018 оноос эхлэн номын санч Б.Шинэхорго суралцаж байна.
6.”Хяналт үнэлгээ шинжилгээний уялдаа холбоо” төвийн болон хангайн бүсийн сургалтанд Номын санч Б.Шинэхорго, Ном зүйч, каталогч Э.Энхнаран нар хамрагдлаа.
7.СУИС-ийн номын сан судлалын тэнхимийн эрхлэгч Т. Хайдав, Улаанбаатар хотын төв номын сангийн Олон нийтэд үйлчлэх тасгийн эрхлэгч В. Түвшинтогтох нарын “Номын сангийн стратеги боловсруулахад анхаарах зүйлс” сэдэвт 2 өдрийн сургалтанд хамт олноороо хамрагдлаа.
8. 09.15. Соёл, урлагийн ажилтнуудын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан соёл урлагийн ажилтныг чадавхижуулах “Соёл, урлагийн байгууллагын тогтвортой хөгжил, чадварлаг ажилтан” сэдэвт сургалтанд хамт олноороо хамрагдсан.
9.08.21-23 нд. Монгол дахь Америкийн төвүүдийн нэгдсэн сургалтанд номын санч Б. Шинэхорго, номзүйч- каталогч Э.Энхнаран нар хамрагдсан.
10. 09.10. Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан тушаалын тодорхойлолт боловсруулах нь” сургалтанд номын санч Б. Шинэхорго, номзүйч- каталогч Э.Энхнаран нар хамрагдсан.
11.09.16. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “МУ-ын Төрийн албаны шинэтгэл” сургалтанд захирал О. Мөнхтуяа, номын санч Б. Шинэхорго, ном зүйч-каталогч Э.Энхнаран нар хамрагдсан.

12.09.16-27-ны өдрүүдэд Улаанбаатар хотод СУИС-ийн Соёлын сургуулиас зохион байгуулсан номын сангийн мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд номын санч Н. Баяртүвшин хамрагдсан.

13. 2019 оны 9 сарын 27-ны өдөр Монголын номын сангуудын консорциумаас Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Соёл урлагийн их сургууль, Герман, Монголын хамтарсан ашигт малтмалын дээд сургууль (GMIT)-тай хамтран зохион

байгуулсан “Mongolian Library Updete” улсын зөвлөгөөнд номын санч Н. Баяртүвшин, ном зүйч-каталогч Э.Энхнаран нар хамрагдсан.

14.Аймгийн Онцгой Байдлын Газраас “Гал түймрийн тархалтын үед авран хамгаалах” үзүүлэх сургалтыг Нийтийн номын сан дээр зохион байгуулахад хамт олноороо идэвхитэй оролцлоо.
15.Эрдэнэс таван толгой компаний хуримтлалтай хувьцаатай иргэн сургалтанд Номын санч Б. Шинэхорго , Н. Баяртүвшин, Э. Энхнаран нар хамрагдлаа.

16. Аймгийн эрүүл мэндийн газар, Амеркийн Цэрэг- Иргэний харилцаа төвөөс зхион байгуулсан сургалтанд Номын санч Б. Шинэхорго хамрагдсан.

ЗУРГАА.ТЕХНОЛОГИ

6.1. Электрон каталог: Номын сангийн цогц програм болох LIB4U.net программыг худалдан авч суурилуулан чөлөөт сонголттой уншлага үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Одоогийн байдлаар нийт 8000 нэр төрлийн 11310 ширхэг номыг электрон каталогит шивж оруулсан.

2. Мөн Нийтийн болон хүүхдийн уншлагын танхимд дохиолол хамгааллын хаалга суурилуулан чөлөөт сонголттой уншлага үйлчилгээг үзүүлэхэд бэлтгэн бүх номыг электрон каталогит оруулах ажлыг хийж гүйцэтгэж байна.

6.2. Цахим мэдээлэл: Аймгийн Нийтийн номын сангийн library.ar.gov.mn сайт болон **Архангай-Нийтийн номын сан** Facebook page хуудсуудад үйл ажиллагаанийхаа талаар тогтмол шинэчлэн байрлуулж иргэд олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэн ажиллалаа. Үүнд:

1.Их жанжин Д Сүхбаатарын мэндэлсэний 127 жилийн ойд
2. “Ээждээ захидал бичээрэй” захидлын уралдаан
3. “Аавдаа захидал бичээрэй” захидлын уралдаан
4. Уламжлалт бичиг үсгийн баяр.
5. Бичиг үсгийн баярын удирдамж гарлаа.
6. Автобустай уншлага
7. Үндэсний бичиг үсгийн баяр-2018
8. Явуулын номын сангийн үйлчилгээ
9.Зөөврийн номын сангийн үйлчилгээ
10.Аймгийн Нийтийн номын сангийн дэргэдэх “Гэгээ”номын клуб /4удаа/
11.Уншлагыг дэмжье уриатай номын баяр-2019 арга хэмжээ
12. “Эко”уншлагын танхим
13.” Тусгаар тогтнолын үнэ цэнэ” Эссэ бичлэгийн уралдаан

6.3. Байгууллагын аюулгүй байдал: Аймгийн Нийтийн номын сан нь 24 цагийн 2 харуул хамгаалалтын ажилтантай үйл ажиллагаа явуулдаг бөгөөд галын дохиолол, дотор гадна хяналтын камер, хөдөлгөөн мэдрэгч дохиолол байрлуулж байгууллагын гадна талбайд гэрэлтүүлэг хийж аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Мөн 2 уншлагын танхимд соронзон долгионоор мэдрэгч дохиолол хамгааллын төхөөрөмж байрлуулан чөлөөт сонголттой уншлага явуулахад ном алдагдахаас сэргийлэн ажиллаж байна.

Аймгийн Онцгой Байдлын Газраас “Гал түймрийн тархалтын үед авран хамгаалах” үзүүлэх сургалтыг Нийтийн номын сан дээр зохион байгуулахад хамт олноороо идэвхитэй оролцлоо.

Долоо. ТӨСӨВ, ОРЛОГО, ЗАРДАЛ:

2019 оны жилийн эцсийн байдлаар 196,209.1196,209.1 мянган төгрөг батлагдсанаас цалин нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, 108,686.3 мянган төгрөг, тогтмол зардалд 76,167.0 мянган төгрөг, ном хэвлэлийн бүтээгдэхүүн худалдан авахад 4,100.0 мян. төг бусад зардалд 7,255.8 мянган төгрөг /бичиг хэрэг, шуудан холбоо, тээвэр шатахуун, эд хогшил, урсгал засвар, томилолт тэтгэмж, урамшуулал/ зарцуулахаар төсөвлөсөн бөгөөд батлагдсан төсөвт багтаан өр авлага үүсгэлгүй үйл ажиллагаагаа явуулж байна.

Найм. БУСАД АЖИЛ:

1. 2019 оны номын сангийн нэгдсэн ажлын төлөвлөгөө болон бусад тайлангуудыг цаг тухай бүрт тайлагнав.
2. Байгууллагын гадаад орчны өнгө үзэмж, тохижилтыг сайжруулах зорилгоор цэцэг тарьж цэцгийн мандал хийсэн.
3. Байгууллагын сүүлийн 5 жилийн бүх бичиг баримтыг үдэж хавтаслан архивт байрлуулсан.
4. Хүүхдийн номын ордонд “Эко” уншлагын танхимыг нээсэн.
5. Хүүхдийн номын ордны номыг тоолж ,дутсан номын нөхөн бүрдүүлэлтийг хийсэн.

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Эрхэм зорилго:

Номын сангийн уламжлалт үйлчилгээг орчин үеийн техник технологитой хослуулан цахим номын сангийн үйлчилгээг өргөжүүлэн, түүх соёлын үнэт, өв, ном товхимолыг өсвөр хойч үедээ өвлүүлэн үлдээх, нийгэмд мэдээлэлд тулгуурласан мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэх **“Мэдээллийн нээлттэй төв ”** болох.

1.2. Номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл:

Тус номын сан 1949 онд байгуулагдсан. Нэг ээлжинд 180 хүнийг хүлээн авч ном уншуулах чадвартай 5 уншлагын танхимтай. Насанд хүрэгчдийн танхим, Гэрээр ном олгох танхим, Хүүхдийн уншлагын 1-р танхим/1-4 анги/, хүүхдийн уншлагын 2-р танхим /5-7 анги/, бяцхан уншигчдын танхим /цэцэрлэгийн хүүхдүүдэд зориулагдсан/. Танхимууд бүгд чөлөөт сонголттой. Нийт 15 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Баян-Өлгий аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 03-р сарын 09-ний өдрийн 37 тоот тогтоолоор аймгийн нийтийн номын санг зохиолч, яруу найрагч Б.Ахтаны нэрэмжит болгов. Өлгий сумын бүх БДС-ийн захиралаар гэрээ байгуулж, 5 хоногийн график гарган, сурагчдыг номын санд бүрэн хамруулж байна.

Вэб хаяг:www.Library.bo.gov.mn.
Цахим хаяг. Б.Ахтаны нэрэмжит төв номын сан
Өвлийн цагийн хуваарь: Даваа-Баасан гаригт,Өглөө 8:00-12:00, Орой 13:00-19:00 цаг
Бямба 10.00-15.00 цаг
Зуны цагийн хуваарь: Даваа-Баасан гаригт,Өглөө 9:00-12:00, Орой 13:00-17:00 цаг
Байгуулллагын утасны дугаар: 70422504
Номын сангийн захриал Д.Алтангүл

2. Номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт, зохион байгуулалт, хадгалалт хамгаалалт

2.1.Номын сангийн хөмрөгийн бүрдүүлэлт, бүтэц зохион байгуулалт

2019 онд 240ш 3129850 төгрөгийн номыг худалдаагаар, 934ш 6954880 төгрөгийн бэлэг хандивын номыг тус тус бүрдүүлэн авч нийт 774 нэрийн 1174ш номыг мэдээллийн электрон каталогт оруулан, 1174ш баркод хэвлэсэн байна.

Бүрдүүлэлтээр авсан бүх номыг нэгдсэн болон нэгбүрчилсэн бүртгэлд авч, уншлагын танхимуудад хүлээлгэн өгч уншлаганд шилжүүллээ. Тогтмол хэвлэлийн захиалгыг чанартай хийж, дугаар ирэлтэнд ,хяналт тавьж 2019 онд номын сангийн хэмжээнд 19 нэр төрлийн 1346ш 764500 төгрөгийн тогтмол хэвлэл захиалан уншигчдад үйлчилж байна. БСШУСЯ-ны "Соёл урлаг хөгжүүлэх сан"-гаас шалгарсан төслийн хүрээнд "Улирал ба Зохиолч" сэтгүүлийг Алтай, Дэлүүн, Сагсай, Цэнгэл, Ногооннуур, Цагааннуур сумуудын соёлын төвийн номын санд жагсаалт үйлдэн хүргүүлээд байна.

Сан хөмрөгийн төрөл	Тоо ширхэг	Үнэ
Сан хөмрөг нийт	67476	154016289
Хэвлэмэл ном	65112	145690539
Сонин сэтгүүл	2364	8325750

Бүрдүүлэлт	Тоо ширхэг	Үнэ
Шинээр нэмэгдсэн нийт	2463	10849230
Шинээр нэмэгдсэн ном	1174	10084730
Шинээр нэмэгдсэн сонин сэтгүүл	1346	764500

Хийгдсэн ажил	Тоо
Электрон каталогт бүртгэгдсэн ном	65112
Электрон каталогт шинээр нэмэгдсэн ном	1174

2.2.2019 оны фонд бүрдүүлэлтэд судалгаа хийж, фондын эргэлтэй харьцуулан судалсан. Энэхүү судалгаагаар шинээр худалдан авсан ном хэвлэл нь, уншигч, хэрэглэгчдийн аман болон бичгээр лавласан,татгалзалд бүртгэгдсэн ном хэвлэлээр сан хөмрөг баяжигдаж, оновчтойгоор бүрдүүлэлт хийгдэв.

2.3.Сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал, тооллого хийсэн байдал.

Номын сангийн орчны стандартыг мөрдлөг болгон номын фондын байрны дулаан, чийгшлийг фондын номын санчид өдөр бүр хянаж, тэмдэглэл хөтөлж байна. Мөн фондын номын дулаан чийгшлийг хэмжэх төхөөрөмжийг СХЗГазарт шалгуулж, баталгаажуулалт хийлгэн ажиллаж байна.

1-р улиралдчийгшил 18%, дулаан18,0

2-р улиралд чийгшил 20,6%, дулаан 20,0

3-р улиралд чийгшил 22,4%,дулаан21,80

4-рулиралдчийгшил 20,1%, дулаан 20,3 байгаа нь номын сангийн фондын хадгалалтын дулаан хэвийн, харьцангуй чийгшил нь бага байна.

2019 оны эхний хагас жилд "Үндсэн фонд", "Хүүхдийн танхим 1" танхимуудад ээлжит болон ажил хүлээлцэх тооллогыг хийж гүйцэтгэсэн.

2019 оны 5-р сард "Үндсэн фонд"-ын тооллого хийсэн. Тооллогоор ширхэгхэвлэмэл бүтээгдэхүүн байхаас ширхэг хэвлэлийн бүтээгдэхүүн тоологдож, ширхэг ном тоологдоогүй дутсан. Тооллогыг нэгбүрчилсэн дансаар монгол номын 35 данс, казак номын 20 данс, гадаад номын данс 6 нийт 61 дансанд шувуу "Тооллого" нүдэнд тэмдэглэсэн.Тооллогын тайланг захиргааны зөвлөлд илтгэж тайлагнасан. Захиргааны зөвлөл тооллогын комиссынэцсийн дүгнэлтийг үндэслэн энэ ондоо багтаан тооллогоор дутсан номуудыг төлж барагдуулах үүрэг өгсний дагуу тооллогоор дутсан 142 номноос 92ширхэг номыг орлуулж, 50 номыг номоор нь төлүүлж авч, ширхэг ном үлдсэн.

2019 оны 6 сард "Хүүхдийн 1-р танхим"-ын ажил хүлээлцүүлэх тооллого хийсэн. Тооллогоор ширхэг 2108 ном байхаас 2021 ширхэг ном тоологдож 87 ширхэг ном тоологдоогүй дутсан. Тооллогыг мөн дансаар монгол 1, казак номын 1 данс "Тооллого" нүдэнд тэмдэглэсэн. Тооллогын дүнг захиргааны хуралд танилцуулж, дутсан 87 ш номын 15ш номыг номоор нь 72ш номыг төлүүлж барагдуулав.

Сэлбэн засалт:

- Элэгдэж хуучирсан 510ш номыг сэлбэн засаж, орон нутгаас хэвлэгдэн гарсан “Өркендеу”, “Жана өмир” сонины 1965-1990 онуудыг сэргээн засварлан хавтаслав.

- “
Н
о
мын санч” сэтгүүлийн 01 дугаарт нийтлэгдсэн “Номын сан дахь хорхой шавьж, түүнтэй тэмцэх арга” сэдэвийг судалж, номын санчдад танилцуулав.
- Хүүхдийн 2-р танхимаас “Залуу номын санч” дугуйлангийн сурагчид Өлгий сумын 2-р БДС-ийн 5 “г” анги, 3-р БДС-ийн 6 “а” ангийн сурагчдад “Бяцхан ном хийх арга”, “Ном эмчлэх” сэдэвүүдээр сургалт явуулж, сэлбэн засалт, бяцхан номыг хийх аргыг зааж өглөө.

1. **НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.**

3.1 Уншлага үйчилгээ.

2019 оны байдлаар **9702**уншигчдад шинээр карт нээж, **34036**ирэгсэдэд нийт **43738** уншигчдад**64209** ном олгон уншуулж, уншигчдын эрэлт хэрэгцээг ханган үйлчилэв.

Танхимууд / Үзүүлэлт	Уншлагын танхим	Гэрээр ном олгох танхим	Хүүхдийн 1-ртанхим	Хүүхдийн 2-ртанхим	Зөөврөөр	Нийт
Уншигч	1884	1798	2495	2030	1495	**9702**
Ирэгсэд	6461	6795	8900	8680	3200	**34036**
Ном олголт	14606	13480	15580	14660	5883	**64209**

3.2. “Хүүхдийн уншлагыг дэмжин дэлгэрүүлье” сарын аяллыг алслагдсан хөдөө сумын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд номын ач тусыг мэдрүүлэх, танин мэдэхүйн чиглэлээр мэдээлэл хүргэх, багийн төвийн хүүхдүүдэд

зөөврийн номын сан ажиллуулж уншлагыг дэмжих, хүүхдүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдүүдэд хүрч ажиллах, хүүхдүүдийн сайн сайханы төлөө номын сангийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор ДЗОУБ-ын дэмжлэгээр 2019 оны 2-р сарын 11 нээс 11 хоног нийт 8 сум 3 багаар тойрон аялав. Цэцэрлэгийн хүүхдүүдэд хөдөлгөөнт ном, ярьдаг ном, үзгээр уншдаг номуудыг үзүүлж, үлгэрийн баатарын дүр гарган үлгэр ярьж өгч, LCD-гээр үлгэр, хүүхдүүдийн дуу, “Хожанасырдын алтын асыгы” сэдэвт үлгэрийн дүрийн тоглолт хийж сонирхуулав.
Сумдын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад болон дотуур байрны хүүхдүүдэд зөөврийн номын сан ажиллуулан, номын ач тусыг мэдрүүлэх, номтой нөхөрлүүлэх, ном уншуулах ажлыг өрнүүлж, шинэ номын үзэсгэлэн гаргав. Мөн 5,6,7 ангиудын дунд танин мэдэхүйн сэдэвээр АХА тэмцээн явуулж эхний байр эзэлсэн сурагчдыг шагнан урамшуулав. Аялалд нийт 2600 хүүхэд хамрагдав.

- Өлгий сумын 2,3,5,9,17 цэцэрлэгүүдэд **“Хүүхдийн уншлагыг дэмжин дэлгэрүүлье”** аяныг үргэлжлүүлэн ажиллаж, хүүхдүүдэд ярьдаг ном,

хөдөлгөөнт ном, үлгэрийн номоор чанга уншлага, үлгэрийн баатрын дүрийн тоглолт хийж сонирхуулав.

- Өлгий сумын БДС-ийн сурагчдын дунд "Уншигчдын клуб"-ыг сургуулийн номын санчтай хамтран байгуулан жилийн төлөвлөгөөний дагуу нийт 6 төрлийн СОНА ажил явуулж нийт 145 гаруй сурагчид хамрагдав.
- Хүүхдийн уншлагын 1,2 танхимуудын дэргэдэх "Тогыз хумалак", Залуу номын санч" дугуйлан ажиллуулж, дугуйлан тус бүр 30 сурагчид хамрагдаж, сард 2 удаа цугларч байна.
- 2019 оны 11-р сарын 01 өдрөөс эхэлж уншигчдын хүсэлтийн дагуу номын сангийн цагийн хуваарыг уртгсгаж, өглөө 8.00-12.00 үдээс 13.00-21.00 хүртэл ажиллаж, бямба гаригт 11.00-15.00 цаг хүртэл ажиллаж байна.

Үлгэрийн цаг:

- Цэцэрлэгийн хүүхдүүдийг хуваарийн дагуу "Бяцхан уншлагын танхимд" тогтмол хамруулж "Үлгэрийн цаг" хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр Өлгий сумын 13 цэцэрлэгийн 400 гаруй хүүхдийг хамруулав. Үлгэрийнцагаар үлгэр, ардын аман зохиол, хүүхдүүдэд үлгэр дууриалал болох ном зохиолтой танилцуулж, зохиолын талаар харилцан ярилцаж, бүтээл хийж, хөгжөөнт тоглоом тоглуулан, багаар ажиллууллаа.

3.2. Соёл олон нийтийн ажил

Манай номын сан нь номзүйн мэдээллийг боловсронгуй болгох үүднээс 34 удаа **1101**ш номоор шинэ болон сэдэвчилсэн үзэсгэлэн гаргаж, **1576** уншигч, иргэдийг уншлаганд хамруулж, 31 төрлийн соёл олон нийтийн ажлуудыг тогтмол зохион байгуулж байна.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэн

Үзэсгэлэнгийн нэр	Үзэсгэлэнд дэлгэгдсэн номын тоо	Хамрагдсан хүүхэд, ард иргэд
Монголын ёс заншил	30	80
Монгол ёс	24	53
Би ээждээ хайртай	25	25
Ана өмир шуагы	20	50
Ээжийн хайр	24	55
Эр цэргийн баяр	35	80
Наурыз жыл басы	50	50
Интернет хүүхдийн эрүүл мэндэд...	31	300
Хууль зүйн булан	66	81
Хүүхдийн номын өдөр	25	87
Инээцгээ хүүхдүүд ээ инээцгээ	22	27
Хүүхдийн баярын өдөр	60	45
Шашны ном	17	32
Шинэ номын үзэсгэлэн 16 удаа	490	350

Уншигч Пандагийн булан	57	68
Эх сайхан монгол хэл	45	75
70 жилийн ойн баярт зориулсан Өлгийн зохиолчдын номын үзэсгэлэн	60	118
Нийт	**1101**	**1576**

- Цагаан сарын баярыг угтаж 2-р БДСийн сурагчдын дунд “Өв соёл, зан заншил” сэдэвт АХА тэмцээн, “Хөдөө нутаг сайхан” сэдэвт 5-6 ангийн сурагчдын дунд гар зургийн уралдаан явуулав. 6-р ангийн сурагчдын дунд урианхай ардын **“Хорол, үүшүүр”** тоглоомын уралдаан, монголын ёс заншилтай холбогдолтой номын үзэсгэлэн, “Зохиолч ба зохиол” самбарт цагаан сарын тухай үйл ажиллагааг сурталчилав. Мөн МҮСТ-д 1-р курсын оюутануудын дунд “Зан заншил” сэдэвт АХА тэмцээн явуулж 30 оюутан хамрагдав.

-

йрагч П.Муратын “Ел көшкенде” номноос “Уран уншлага”-ын уралдаан явуулав. Уралдаан 10-13, 14-18 насны ангилалаар явагдаж нийт 74 сурагч оролцов. 10-13 насны ангилалаар 1-р байрыг 4-р БДС-ийн 6-р ангийн сурагч Өмирбек овогтой Ибраһим, 2-р байрыг Бегжан овогтой Ахмарал, 3-р байрыг Талгат овогтой Гүлжанат, шагналт байрыг Икранбек Айтолхын нар эзэлж, 14-18 насны ангилалаар 1-р байрыг Улыхпан овогтой Жансерик, 2-р байрыг 5-р БДС-ийн 5-р ангийн сурагч Өркен овогтой Айнур, 3-р байрыг Бастама сургуулийн 8-р ангийн сурагч Хайрым овогтой Арайлым, шагналт байрыг Дарын сургуулийн Жанибек овогтой Журагат нар эзлэв.

- Эмэгтэйчүүдийн баярыг угтаж Ховд Их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль болон МҮСТ-ийн оюутануудын дунд “Кыздар сулу көринер кылыгымен” нэрт уралдаан явуулав. Уг уралдаанд 3 баг оролцож 1-р байрыг Ховд Их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургуулийн “ Шолпы” баг, 2-р байрыг МҮСТ-ийн “ Наурыз ” баг, 3-р байрыг “ Байшешек” багууд эзлэв.

- 1-р танхимд ОУЭ-ийн баярыг угтаж 2-р БДС-ийн Мөнх-Оргих багштай 2б ангийн эцэг эхчүүдийн дунд "Аав ,ээж,би" сэдэвт танин мэдэхгүйн хөгжөөнт тэмцээн явуулав.1-р байрыг "Цэцэг" багийн ахлагч Адилбиш 2-р байрыг

Жэри" багийн ахлагч Ганболд 3-р байрыг "Од"багийн ахлагч Володия нар эзлэв.

- **Гэрээр ном олгох танхимаас** 2019.03.18 буюу “ЭР ЦЭРГИЙН БАЯР”-ыг тохиолдуулан номын үзэсгэлэн гаргаж, “ЗОХИОЛЧ БА ЗОХИОЛ” самбарт дайны үеэр зохиол бичиж байсан баатарлаг зохиолчдыг эргэн дурсах зорилгоор бичсэн зохиолуудыг нь сурталчлав.

-

зохиолч Абай Хунанбаевийн яруу найрагаас **“Уран уншлага -2019”** уралдааны 6 дахь жилдээ зохион байгуулав. Уралдаанд аймгийн төвийн болон сумдын БДС –ийн нийт 34 сурагч 2 насны ангилалаар идэвхтэй оролцож, эхний байр эзэлсэн 8 сурагчыг мөнгөн шагнал болон хичээлийн хэрэглэгдэхүүнээр шагнан урамшуулав.

- Наурыз баярыг угтаж **“Наурыз бике-2019”** уралдааны аймгийн хэмжээнд зохион байгуулав. Казах түмний уламжлалт "Наурыз" баярыг тохиолдуулан авьяас чадвартай охид бүсгүйчүүдийг таниулах, үндэсний өв соёлыг сурталчлах хойч үедээ өвлүүлэн үлдээх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Баян-Өлгий аймгийн ЗДТГазартай хамтарч явуулав. Тус арга хэмжээнд 18-25 насны 20 гаруй охид бүсгүйчүүд оролцсоноос нэгдүгээр байрыг Рахатын Жанар, хоёрдугаар байрыг Биахметийн Еркегүл, гуравдугаар байрыг Алтай сумын Амантайн Нурсаулешагналт байрыг Дамысханы Мазира нар эзлэв.

“Хүүхэд бүр уншигч” аян

Хүүхэд багачуудын дунд ном унших хөдөлгөөн өрнүүлэх, хүүхэд бүрийг хөгжүүлэх, номоор дамжуулан хүүхдүүдийн ой тогтоолт, унших чадварыг дээшлүүлэх, сургалтын чанарт нөлөөлөх зорилгоор **“Хүүхэд бүр уншигч**” аян зохион байгуулав. Үүнд нийт 800 гаруй сурагчид хамрагдаж, 4 насны ангилалаар

нийт 15 ангийн 450 сурагчид болон 15 удирдагчыг 500 000 төгрөгний номоор шагнан урамшуулж ангийн номын санг номоор баяжуулав.

“Дэлхийн номын өдөр-2019”

- НҮБ-ын Соёл урлагын хорооноос жил бүрийн дөрөвдүгээр сарын 23-ныг **“Дэлхийн номын өдөр”** болгохоор 1995 онд албан ёсоор зарласан билээ. Энэхүү өдрийг тохиолдуулан Баян-Өлгий аймгийн Б.Ахтаны нэрэмжит төв номын сан нь дараах ажлуудыг зохион байгуулав. Үүнд:

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан цэцэрлэгийн хүүхдүүдэд “Хүүхдийн уншлагыг дэмжин дэлгэрүүлье” сэдэвт өдөрлөгийг 3, 5, 6,11,9-р цэцэрлэгүүдийн хүүхдүүдийн дунд зохион байгуулав. Өдөрлөгийн үеэр хүүхдүүдэд хөдөлгөөнт ном, ярьдаг ном, үзгээр уншдаг номуудыг үзүүлж сонирхуулав. Тус өдөрлөгт нийт 300 гаруй хүүхэд хамрагдав.

200 гаруй шинэ номын үзэсгэлэн гаргаж, номын худалдаа, ном солилцоо зохион байгуулав.
Өлгий сумын ЕБС-ийн 6-12-р ангийн сурагчдын дунд АХА тэмцээн явуулав. Тэмцээнд эхний 3 байрыг шагнан урамшуулав. Өлгий сумын ЕБС-ийн сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргаж , уншигчийн картыг үнэ төлбөргүй нээж, түүнчлэн тэргүүний уншигч хүүхдүүдийн урлагийн үзлэг, уран уншлага явагдав. Номын баярын арга хэмжээнд идэвхтэй оролцдог зарим сургуулийн анги хамт олны шагналыг гардуулав. Арга хэмжээнд нийт 150 гаруй уншигч ард иргэд хамрагдав.

“Үндэсний бичиг үсгийн баяр-2019”

“Үндэсний бичиг үсгийн баяр” –ыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээндӨлгий сумын БДС-ийн бүтээлийн үзэсгэлэн дэлгэгдэж, ”Сайхан бичигтэн” уралдаан, “Эх сайхан-Монгол хэл” зохион бичлэгийн уралдаан, “Бүтээлч багш”, “Бүтээлч сургууль”, “Бичиг үсэг соёл” АХА тэмцээний зохион байгуулав.

”Сайхан бичигтэн” уралдаанд
1-р байр Эмпати сургуулийн 10 ”а” ангийн сурагч Э.Болормаа

2-р байр Эмпати сургуулийн 10 ”б” ангийн сурагч Н.Үүрийнтуяа, 3-р БДС-ийн 10 “в” ангийн сурагч М.Нурдана
3-р байрыг Эмпати сургуулийн 10 ”а” ангийн сурагч Ц.Ану-Үжин, Эмпати сургуулийн 8 ”б” ангийн сурагч Б.Амин-Эрдэнэ

“Эх сайхан –Монгол хэл” сэдэвт зохион бичлэгийн уралдаанд
1-р байрыг 5-р БДС-ийн 7 “в” ангийн сурагч А.Рүстем
2-р байрыг Билге-Тегин БДС-ийн 8 “а” ангийн сурагч Б.Дана
3-р байрыг Дарын БДС-ийн 7 “а” ангийн сурагч М.Шындаулет

Үзэсгэлэнгийн төрөлд 3-р БДС-ийн багш Х.Жаныльган “Бүтээлч багш”, 3-р БДС-ийн хамт олон “Хүмүүн бичиг” сэдэвтэй үзэсгэлэнгээр “Бүтээлч сургууль”, мөн “Бичиг үсэг соёл” нэрт АХА тэмцээнд 1-р байрыг 2-р БДС-ийн номын санч Б.Саруул, 2-р байрыг 5-р БДС-ийн 7 “в” ангийн сурагч А.Рүстем нар тус-тус эзлэв.

Хүүхдийн баяр

Хүүхдийн баярын өдөр номын сангийн талбайд үлгэрийн болон зурагтай номын үзэсгэлэн гаргаж, АХА тэмцээн зохион байгуулав. Хамгийн бяцхан уншигчдад үлгэрийн ном бэлэглэв.

Номын нээлтүүд :

- Төкей Хуаны “Казак хандыгынын урпагы төрелер шежиреси”
- Хөгжмийн зохиолч, дрижер Х.Мусайпийн “Алтай-Ховдын казакуудын домбор болон үлээвэр хөгжимийн онцлог”
- Хазира багшид зориулсан “Аз ана-Айай тате” дурсамж ном
- Т.Кастёрын “Тарбие жане тагылым”
- Мухтар Шахановын “Туындылары”
- Б.Хурмет “Гүмыр гибраттары”,
- С.Айнагүл “Кайда кайда сол жылдар”.
- Номын сангийн 70 жилийн ойн баярт зориулж хэвлэгдсэн “Эрдэм номын өргөө”
- С.Хайса “Аялы мекен Алтайым”
- Төр нийгмийн зүтгэлтэн Жуанганы Ром агсны 95 жилийн ойг тохиолдуулан хэвлэгдэн гарсан “Қарадан шыққан қайраткерлер”
- Түүх судлалын доктор Б. Өмирбекийн “Баян-Өлгий аймгийн археологийн дурсгалууд
- БНКУлсын нэрт зохиолчид М.Шаханов, БНКУлс, БНХАУ-ын нэрт зохиолч Ж.Шакен манай номын санд зочилон уншигчидтай уулзаж, шинэ номын нээлт хийв.

Уран уншлага:

- Яруу найрагч Кашкынбайн Күлданы **“Кыз назы”** номноос уран уншлагын уралдааныг 2019 оны 11-р сарын 21 өдөр зохион байгуулав. Уралдааныг 10-13 насны, 14-18 насны ангилалаар явуулж, 10-13 насны ангиллаас 1-р байр Т.Аймөлдир, 2-р байр Х.Арман, 3-р байр А.Аманбол, 14-18 насны ангиллаас 1-р байр Х.Ахмарал, 2-р байр С.Сымбат, 3-р байр Х.Саттигүл нар тус тус байр эзлэв. Уралдаанд 120 гаруй сурагчид оролцов.

- Муратбекийн Жансаягийн **“Даланын кызымын”** номноос уран уншлагын уралдааныг аймгийн хэмжээнд 2019 оны 4-р сарын 24 нд Жансаягийн эгчтэй хамтарч 2 насны ангилалаар зохион байгуулав. Эхний байр эзэлсэн 6 сурагчдыг мөнгөн шагнан урамшуулав. Уралдаанд сумдын болон аймгийн БДС-ийн нийт 80 гаруй сурагчид идэвхтэй оролцлоо.

Уулзалт

- Номын сангийн зөвлөлийн зохион байгуулсан Баян-Өлгий аймагт байгаа казак түмний “Угийн бичиг” хөтөлдөг ахмадуудтай уулзалт хийж, дугуй ширээний ярилцлага явуулав. Номын сангийн захирлын тушаалаар Угийн бичиг хөтөлдөг зөвлөл байгуулав. Энэхүү арга хэмжээнд хөдөө сум болон аймгийн төвөөс нийт 17 угийн бичиг хөтөлдөг ахмадууд оролцов.
- “Ару жұлдыз” сэтгүүлийн редактор, Арулар холбооны тэргүүн С.Айнагүл уншигчидтай уулзалт зохион байгуулав. Уулзалтанд Арулар холбооны гишүүд, номын санчид болон уншигчид оролцож чөлөөт яриа өрнүүлэв.

3.3. Зөөврийн номын сангаар үйлчилгээ үзүүлсэн байдал.

- Номын сангийн үйлчилгээг хүртэж чадахгүй байгаа алслагдсан, тусгай байгууламжид байгаа иргэдэд номын сангийн үйлчилгээг хүргэх, сурталчлах, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоорзөөврийн номын сангийн үйлчилгээг Өлгий сумын ТГ, Цагдаагийн Газар, ШШГА, Нийгмийн даатгал, аймгийн Прокурор, Иргэний Бүртгэлийн Газар, Шүүх, Онцгой Байдал, Татварын Хэлтэс, Цэргийн 240-р анги, Цэргийн 165-р анги, ГХВХБГ, ГЕГ, Байгаль

орчин, Тагнуулын Газар, Нэгдсэн эмнэлэгийн дотрын тасаг, Нийгмийн датгал зэрэг 16 байгууллага болон алслагдсан хөдөө сум багуудын ард иргэд, сургууль, цэцэрлэгийн хүүхэд, багачуудад нийт 48 байгууллагад зөөврийн номын сангаар 1495 уншигчдад шинээр карт нээж, 3200 ирэгсэдэд 5883 ном уншуулж үйлчилэв.

- Зөөврийн номын сан ажиллуулахүед Иргэний бүртгэлийн албан хаагчдын дунд "АХА" тэмцээн, Татварын хэлтэсийн хамт олон, Нэгдсэн эмнэлгийн дотрын тасаг, Шүүх, Нийгмийн даатгалын хэлтэсийн хамт олонд "Хожаберген батыр", "Жаран цагаан хонь" номнуудын тухай тойм яриа хийж, асуулт хариулт явуулав.
- Аймгийн Цагдаагийн газрын эрүүлжүүлэх тасагт 65ш ном, Нэгдсэн эмнэлгийн дотрын тасагт 50ш номыг хандиваар өгч булан нээж ажииллаж байна.

Зөөврийн номын сан ажиллуулсан албан байгууллагууд

д/д	Хамтран ажиллах байгууллага	Хэдэн удаа хүргүүлсэн	Хүргүүлсэн номын тоо	Захиалсан номын тоо	Нийт уншсан номын тоо
1	Цагдаагийн газар	4	80	11	**233**
2	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	2	40	2	**69**
3	Нийгмийн даатгал	4	60	2	**96**
4	Байгаль орчин	4	75	3	**92**
5	Газрын харилцаа, хот байгуулалтын газар	4	70	0	**162**
6	Онцгой байдлын газар	4	45	0	**246**
7	Прокурор	3	45	0	**158**
8	Тагнуул	2	40	0	**143**
9	Шүүхийн тамгын газар	4	70	3	**165**
10	Гааль	3	60	0	**113**
11	Цэргийн 165-р анги	5	75	12	**214**
12	Барилгын цэргийн 360-р анги	4	60	5	**237**
13	Өлгий сум	4	60	19	**185**
14	Иргэний бүртгэл	5	75		**144**
15	Татварын хэлтэс	4	40	11	**150**
16	Нэгдсэн эмнэлгийн дотрын тасаг	2	30	0	**86**
18	Өлгий сумын 3,5,6,9,11 –р цэцэрлэгүүдийн “Бэлтгэл”, “Ахлах “Дунд” бүлэгүүдэд	5	310	0	**790**
19	**Нийт**				**2493**

3.4."ИНТЕРНЕТ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДЭД...”сэдэвт 7 хоногийн сургалтыг ЕБС-ийн сурагчдад өнөө үеийн тулгамдаж буй гол асуудлын нэг болох интернетийн болон гар утасны зохисгүй хэрэглээ мөн цахим гэмт хэргээс яаж урдьчилан сэргийлэх тухай, түүнчлэн чөлөөт цагаа хэрхэн зөв өнгөрүүлэхийг ойлгуулах зорилгоор зохион байгуулав. Уг сургалтыг Дэлхийн Зөн ОНБ-тай хамтарч зохион байгуулсан ба сургалтанд 300 гаад сурагч идэвхтэй оролцов.

- ЕБС-ийн охиудуудад зориулж “Охидын хүмүүжил” сэдэвт сургалтыг Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эрүүл мэнд хариуцсан ахлах эмч М.Салтанат, “Оюунлаг алхам” –ын хүүхдийн хүмүүжлэгч Х.Алиятай хамтарч зохион байгуулав. Сургалтад Өлгий сумын 1,3, 5-р БДС-ийн 11-12 –р ангийн 65 сурагчхамрагдав.



3.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байдал.

Өлгий сумын 3,4 багийн иргэдийн судалгаа гаргаж, 4-р багийн иргэн хоёр хөл нь төрөлхийн дутуу хөгжилтэй Иркитбай овогтой Лена, Өмирбек овогтой Ибрахим, 3-р багийн Ерлан овогтой Айгерим, 3-р багийн иргэн Талгат овогтой Олжас нарт ярьдаг ном, үлгэрийн ном, уран зохиолын номоор зөөврөөр гэрт биечлэн очиж, ном уншуулан үйлчилэв.

3.5. **“Гадны чөлөөт номын сан**”

6-р сарын 03 өдөр зуны улиралд хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа ном уншуулж, үр бүтээлтэй өнгөрүүлэхэд туслах зорилгоор**“Гадны чөлөөт номын сан**”-ийннээлтийн үйл ажиллагаазохион байгуулж, үйл ажиллагааг номын сангийн захирал нээж, ахмад уншигч болон хүүхдүүд оролцов. Арга хэмжээнд шүлэг уншиж, үлгэр ярьж өгсөн хүүхдүүдэд ном бэлэглэв. “Гадны чөлөөт номын сан”-г 6,7,8,9 сард ажилуулж, нийт 120 уншигч иргэсдэд 160 гаруй ном уншуулж үйлчилэв.

3.6. Гэрээр ном олгох танхимд “Уншигч пандагийн”, Х.Ханипагийн агсны нэрэмжит уншлагын танхимд “Хууль зүйн”, “Шашны холбогдолтой номын буланг байгуулан хамтран ажиллаж, 130 төрлийн 183 ном хэвлэлийг байршуулсан нь хүүхэд, оюутан залуусыг мэдээллээр хангах, үнэ төлбөргүй авах боломжтой юм
3.7. Гэрээр ном олгох танхим болон уншлагын танхим “Уншигч панда”, “Хууль зүйн”, “Шашны холбогдолтой” номын булангуудыг ажиллуулж байна. “Хууль зүйн” буланд аймгийн Шүүхийн ерөнхий шүүхч Өмирбек 120 ш номыг хандивлав.

ДӨРӨВ. ЛАВЛАГАА, НОМ ЗҮЙН АЖИЛ

- Мэдээлэл, ном зүйн үйлчилгээний хүрээнд тайлангийн хугацаанд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номынсангийн лавлагааныммессенжер,бичгээр, утсаар, амаар нийт465 удаа лавлагааөгсөн байна.
- Шинээр бүрдүүлсэн ном хэвлэлийг LIB-4U программын цахим каталогт бүртгэн нийт1174ширхэг карт шинээр бичиж, 750 ширхэгхэвлэн холбогдох каталогуудад байрлуулсан.
- Электрон каталогийн хайлтын компьютерийг ажиллахад бэлтгэх, каталогийн шоголуудыг цэгцлэх ажлыг өдөр бүр хийж гүйцэтгэв.
- Каталогийн лавлагаагуншигчдад өгч номынсангаархэрхэн үйлчлүүлэх, каталог ашиглах, захиалгын хуудас бичих, номоо хэрхэн хайх, номоо хэрхэн сонгох талаар мэдээлэл өгч,зарим номын шифрийг тодруулах,олдохгүй байгаа зохиолуудыг электрон каталогоос хайлт хийж өгч байсан.
- “Төрийн мэдээлэл”, “Хууль зүйн мэдээ” сэтгүүлийг тогтмол авч лавлагааны фондоо баяжуулан ажиллаж байна.
- Сэдэвчилсэн үзэсгэлэнгийн санамж өгөх номзүйг 8 сэдвээр нийт 980номын жагсаалтыг гаргаж, уншигчдад хүртээл болгов.
- Хүүхэд залуучуудад зориулсан монголын ёс заншил, казак ардын ёс заншилтай холбогдолтой номын ном зүйн жагсаалт, хуулийн булангийн ном зүйн жагсаалт, шинэ номын ном зүйн жагсаалт, “Уншигч пандагийн” булангийн ном зүйн жагсаалт зэрэг 7 номзүйн жагсаалтыг тус тус гаргаж уншигчдад сурталчилж байна.
- Тогтмол хэвлэлийн өгүүллийн төрөлжсөн картын санг “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2017-2019 он, “Жана дауир” сонины 2010-2019 оны бүх дугааруудыг шүүж, 120 өгүүллээр баяжуулан үйлчилж байна.

4.5. Номын сангийн 70 жилийн ойн баярыг тохиолдуулан “Эрдэм номын өргөө” номыг
4 бүлэгтэй 110 худастай гаргаж уншигчдын хүртээл болгов.

ЗУРГАА. МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИ

- Lib-4U праграммын PC VERION энгийн хувилварыг ашиглан дотоод сүлжээндээ холбогдон WiFi утасгүй интернетийгашиглан явуулж үйлчилж байна.
- БСШУЯ-ны сайд БСШУЯ-ны Сайд Ё.Батарбилэгт **“Цахим номын сан”** ажиллуулах 32 500000 төгрөгний төсөлийн санал оруулж, 2020 онд шийдэж өгөх тухай хариу авсан.
- Сумдын соёлын төвийн номын сангуудын цахим программын нэгдсэн тайлангийн мэдээ, нэгдсэн каталогийн мэдээ, нөөц бэлдэх аргачлалын талаар номын санчдад заавар зөвлөгөө өгч, Monbiblio цахим программд оруулсан нэгдсэн тайлан, нэгдсэн каталогийн мэдээ, мэдээллийн сангийн нөөцийг бэлдэж цаг хугацаанд нь БСШУЯ-д хүргүүлж, Вэб сайтын хөгжүүлэх тал дээр анхаарч ажилласан. Мөн Булган, Цагааннуур, Ногооннуур сумуудын компьютеруудыг форматлаж, хэвийн үйл ажиллагаанд оруулсан.

Номын сангийн бүх уншлагын танхимууд болон каридорд ном алдах эрсдэлээс хамгаалах зорилгоор камержуулалт хийгдэж хянах дэлгэцийг тогтмол ажиллуулж байна. Камерийн бичлэг хийх төхөөрөмжүүд 7 хоногийн бичлэг хадлагдан ажиллаж байна. Үүний үр дүнд 8 төрлийн гэмт хэргийг илэрүүллээ. Үүдэнд байрлуулсан соронзон хаалга нь хэвийн ажиллаж байна.

- Иргэдэд үйл ажиллагаагаа цахимаар хүргэх зорилгоор www.Library.bo.gov.mn. сайтыг тогтмол ажиллуулж 2019 оны байдлаар номын сангийн үйл ажиллагааны талаар нийт 48 удааг мэдээ, мэдээлэл тавьж сурталчилсан.
- Б.Ахтаны нэрэмжит төв номын сан нь Орон нутгийн радио, “Дербес” TV, “Саян” TV, TV-4 телевизтэй



хамтран үйл ажиллагаагаа сурталчлан 42 удаагийн мэдээ, мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэж байна.

ДОЛОО. АРГАЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.1. 2019 онд өгөгдсөн аргазүйн зөвлөгөөний бүртгэл хөтөлж, соёлын төвийн номын санч 13, сургуулийн номын санч 25, төв номын сангийн номын санч 5 нийт 43 номын санчдад арга зүйн зөвлөлгөө өгч ажиллав.

- ✓ Сумдын номын санчдын дунд зарласан **“Тэргүүний номын санч”** болзолт уралдааны аргачлал, “Фондын хадгалат, хамгаалат” сэдэвт зөвлөмж, **“Соёлын төв-чанартай үйлчилгээ-IV“**уралдаанд оролцоход номын санд зайлшгүй хийх ажлуудын зөвлөмжийг хийж соёлын төвийн номын санчдад хүргүүлэв.
- ✓ 2019 оны 11-р сарын 25 өдөр БСУГ-т соёлын төвийн эрхлэгч нарт зохион байгуулагдсан сургалтанд арга зүйч Ж.Жанар “Номын сангийн үйлчилгээ” сэдэвт 1 цагийн хичээл заасан.
- ✓ Уншигч, хэрэглэгчдийн сэтгэл ханамж, санал асуулгыг нийт 160 оролцогчдоос авч, судалгааны үр дүнг нэгтгэн, цаашид ололт, дутагдлыг судлах, хэрэгжүүлэх ажил, үйлчилгээг төлөвлөн ажиллаж байна.
- ✓ Жилийн эцэст сумын номын санчдын ажлыг дүгнэх аргачлалын дагуу үйл ажиллагааг дүгнэж аймгийн ЗДТГ-д хүргүүлэн, эхний 3 байр эзэлсэн номын санчдыг “Өргөмжлөл” болон номоор шагнан урамшуулав.
- ✓ 2019 оны 2-р сарын 11 нээс 2-р сарын 28 ний хүртэл Алтай, Буянт, Цэнгэл, Улаанхус, Сагсай, Толбо, Дэлүүн, Бугат сум, Ойгор, Хөхмойнах, Болашах багуудын нийт 8 сум 3 багийн соёлын төвийн номын сан болон сургуулийн номын санд биечлэн очиж, мэргэжлийн арга зүйн зөвлөлгөө өгч ажиллав.

- ✓ УБ хотын Үндэсний номын сангийн арга зүйч Сарандэлгэр хүрэлцэн ирж сум, сургуулийн номын санчдыг хамруулсан “Номын сангийн ажлын арга зүй” сэдэвт сургалтыг 04-р сарын 1-2 өдрүүдэд зохион байгууллаа.

Сургалтанд аймгийн төв номын сангийн номын санч 10, сумын соёлын төвийн номын санчид 13, сургуулийн номын санчид 19 нийт 42 номын санч хамрагдав. Сургалтаар номын санчдад номын сангийн анхан шатны бүртгэлүүдийн хөтлөлт, фондын зохион байгуулалт, каталог, картын сангийн зохион байгуулалт номын сангийн ажлын шинэчлэлт сэдэвүүдээр сургалт хийлээ. Сургалтын 2 дахь өдөр аймгийн төв номын сан, Толбо сумын соёлын төвийн номын сан, 3-р БДС-ийн номын сангуудын үйл ажиллагаатай танилцаж, мэргэжлийн арга зүйн зөвлөлгөө өгч ажиллаа.

- ✓ Улаанбаатар хотноо болсон “Соёл урлагийн байгууллагын тогтвортой хөгжил-удирдахуйн шинэлэг хандлага-III” сэдэвт 2 өдрийн сургалтанд номын сангийн захирал оролцов.

- ➢ АНУ, Пенсильван мужийн Питсбург хотын Нийтийн номын санд 14 жил ажиллаж байсан, одоо БНХАУ-ын Бээжин хот дахь яаманд гадаад харилцааны мэргэжлээр ажилладаг хатагтай Рита Бутс Питсбургийн нийтийн номын санд орчин үед хэрхэн үйлчилгээгээ явуулдаг мөн эмзэг бүлгийн (ахмад настан, ядуус, цагаачлагчид, мансууруулах бодис хэрэглэгчид, хөгжлийн бэрхшээлтэй г.м) хүмүүст яаж үйлчилгээ үзүүлдэг талаар бидэнтэй хуваалцаж сургалт явуулав.

- 2019 оны 10-р сарын 11, 12 өдрүүдэд Казакстан улсын Павлодар хотод дэлхийн 5 орон хамрагдсан “Номын сан –түүх судар, эрдэмийн төв мөн” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд номын сангийн захриал амжилттай оролцож ирлээ.

- 2019 оны 12 сарын 06 ны өдөр Монгол Улсын Үндэсний Номын сангаас зохион байгуулсан “Нийтийн номын сан аргазүйн төв болон нь” сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт номын сангийн захриал оролцов.

НАЙМ. ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

8.1 Номын сангийн хүний нөөцийн өнөөгийн байдал, хангалт

Тус номын санд 3-аас дээш жилажилласан,мэргэжил шаардсан 9 албан тушаалд одоо ажиллаж байгаа номын санчдын 8 нь буюу 97,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа. Номын сангийн 70 жилийн ойн баярыг тохиолдуулан нийт 16 ажилтнуудыг дээд шатны байгууллагын шагнал, НСУГ-ын шагнал, дотоод болон бусад шагналаар шагнуулахаар тодорхойлсон. Үүнээс номын сангийн Монголын номын сангуудын консорциумын “Тэргүүний номын санч” 3, Монгол улсын ЗГ-ын “Тэргүүний ажилтан” -1, БСШУЯ-ны “Жуух бичиг” 3, аймгийн хурлын “Жуух бичиг” 2, аймгийн ЗД-ын “Хүндэт тэмдэг” 2, ЗД-ын “Тэргүүний ажилтан” 2, ИТХ-ын өргөмжлөл 1, ЗД-ын “Өргөмжлөл” 2 тус-тус шагнагдаж зохих журмын дагуу урамшуулал олгосон. Одоо ажиллаж байгаа ажиллагсдын 50% буюу 33 ажилтанд ур чадварын нэмэгдэл олгож ажилтан бүрт сар бүр хоол унааны мөнгө 60.000 төгрөг олгодог.

8.2. Байгууллагын дотоод хяналт, үнэлгээг сайжруулах, маркетинг, менежмент, хүний нөөцийн хангамж, ашиглалтыг боловсронгуй болгох.

- Номын сангийн захиргааны зөвлөлийн хурлыг 7 хоногт 1 удаа, Номын сангийн зөвлөл сард 1 удаа, Арга зүйн зөвлөл улиралд нэг удаа хуралдаж, жилийн төлөвлөгөөнд тусгагдсан номын санчдын ур чадварын нэмэгдэл, амралт, гадаад, дотоодын сургалт семинарт хамруулах асуудалд дүн шинжилгээ хийж ажиллаж байна.
- Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах зорилгоор Аймгийн МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлтээр дунд эрсдэлтэй гарсантай холбоотой тусгай төлөвлөгөө гаргаж, 3 төрлийн дутагдалыг бүрэн арилгаж ажиллав.
- МУ-ын ЗГ-ын 01 даалгавар, МУ-ын ЗГ-ын 258 дугаар тогтоол, МУ-ын ЗГ-ын 2019 оны 1-р сарын 16-ны өдрийн 23-р тогтоол, 2019 оны 01-р сарын 30 ны өдрийн 59-р тогтоолуудыг биелүүлэх төлөвлөгөө гарган нийт ажилчдын ажлын байрны тодорхойлолтод заагдсан шаардлага, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, сахилга хариуцлага, ажлын цаг ашиглалт, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж захирлын тушаалаар захиргааны зөвлөлийн гишүүд хуваарийн дагуу улирал бүр дүгнэж байна.
- Хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгаа болон СУ-8-16 дугаар маягтын дагуу захиргааны статистикийн мэдээ судалгаануудыг гаргаж, ЗДТГ-ын хүний нөөц хариуцсан мэргэжилтэнд цаг хугацаанд хүргүүлээд байна.
- Номын сангийн дотоод үйл ажиллагаандаа баримтлах “Албан хэрэг хөтлөлтийн журам”, “Архивын журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан. Байгууллагын болон санхүүгийн тамга тэмдэг, албан бичгийн бланкийг стандартын дагуу захиалан хийлгэн ажиллаж байна.
- 2018 оны Захирлын тушаал, ирсэн, явуулсан бичиг, протокол дотоод товъёог үйлдэж архивласан.
- 2019 онд эд аж ахуй, техник тоног төхөөрөмжийн тооллогыг хийж, нэгтгэл хийж, картыг шинэчлэн ажилтнуудад хүлээлгэн өгсөн.

- Байгууллагын 70 жилийн ойн баярт зориулж, номын санчид болон үйлчлэгч, харуулын 2 ээлжийн дүрэмт хувцасыг шинээр хийлгэв.
- Байгууллагаас номын санчид, ажилтан албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх, мэдлэг чадварыг сайжруулах, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх зорлигоор сургалт, лекц семинар зохион байгуулж, суралцах боломжийг бүрдүүлэн 6 удаа нийт ажилтнуудад зохион байгуулсан нь хамт олныг чадавхижуулах ажил байсан.

8.3.Хүний нөөцийг чадавхжуулсан байдал /сургалт, семинар/

2019 оны 4-р сарын 10 -наас 4-р сарын 24 -ны хооронд Казахстан улсын Нур-Султан, Павлодар, Семей хотын номын сангуудтай танилцах, туршлага солилцох аялалд ЗДТГ-ын соёл хариуцсан мэргэжилтэн 1, төв номын сангаас номын сангийн захирал 1, номын санч 7, сумдын номын сангаас 1 номын санч тус-тус оролцов.
4-р сарын 12,13-ны өдрүүдэд Семей хотын Абайн нэрэмжит академийн төв номын сан, хотын төв номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, дугуй ширээний ярилцлага зохион байгуулагдав. Их зохиолч Абай Хунанбаевийн түүх, соёлын музейтэй танилцаж аялав.
4-сарын 14,15-ны өдрүүдэд Павлодар хотын С.Торайгыровын нэрэмжит төв номын сан, хараагүй иргэдийн номын сан, хотын төв номын сан үйл ажиллагаатай танилцав. Мөн Машһүр Жүсипын хотын төв музей, Павлодар хотын орон нутгийн музей, гэрэл зурагчин Г.Н.Потанины нэрэмжит Павлодар хотын орон нутгийн түүхийн музей, уран зургийн музейтэй танилцав.
4-р сарын 18,19 -нд Нур-Султан хотын Үндэсний академийн номын санд уулзалт, дугуй ширээний ярилцлага, уншлагын танхимуудад аялал зохион байгуулагдав.

- ❖ Аймгийн Онцгой байдлын газраас галтүймэрээс урьдчилан сэргийлэх хяналтын улсын байцаагч Ш.Еркебулан, сургалт сурталчилгаа урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн Х.Ургац нар Галын аюулгүй байдлын тухай хууль, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх хууль тогтоомжын талаар мэдээлэл хийв.
- ❖ Аймгийн Татварын газраас мэргэжилтэн С.Айбек, Бахытбек нар “Татварын тухай” хууль тогтоомж, НӨТ талаар сургалт явуулав.
- ❖ Аймгийн БСУГ-ын соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг хариуцсан мэргэжилтэнээр “Соёлын салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөр, түүнийг эрчимжүүлэх нь” сэдэвт 2 цагийн хичээл заалгав.
- ❖ Аймгийн Цагдаагийн хэлтэсийн хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн О.Асылбек “Гэмт хэргээс урьдчилан сэргийлье” сэдэвт сургалт явуулж, холбогдох хууль тогтоомжын талаар сургалт хийлээ.

- ➢ АТГ-ын албаны дарга, ахлах комиссар Т.Энхболдоор ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирж,“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах төрийн байгууллагуудын албан хаагчид болон эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан “Төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалт”-ыг зохион байгууллаа.АТГ-ын албаны дарга, ахлах

комиссар Т.Энхболд, АТГ-ын хэвлэл, олон нийттэй харилцах ажилтан комиссар Т.Энхтунгалаг нар манай номын сантай танилцаж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар ажилтан албан хаагчдаа зөвлөгөө өгч, АТГ-аас шинээр хэвлэгдэн гарсан хүүхдүүдэд зориулсан "Найзын яриа" ном, CD, "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" гарын авлага, "Төрийн албан хаагчийн ёс зүй" зэрэг номуудыг номын санд хандивлав.

ЕС. ТӨСӨВ. САНХҮҮГИЙН АСУУДАЛ

- 2019 оны батлагдсан төсвийг сар бүрийн хуваарийн дагуу үр ашигтай зарцуулсан. Шилэндансны хуулийн заалтуудыгмөрдөж санхүүгийн тайлан, мэдээ, балансыгцаг хугацаандн үнэн зөв гарган өгсөн.
- Шилэн дансыг сарбүр цахимаар шивэлт хийн хэвлэж гарган олонд харагдах байдлаар мэдээллийн самбарт байршуулсан
- Монгол улсын Ерөнхий аудиторын тушаалаар 2017, 2018 онысанхүүгийнтайлангийн зөрчилгүй санал дүгнэлт авч,өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж, Монгол улсын ерөнхий аудиторын "ИТГЭМЖЛЭЛ"хүртэв. Номын сангийн 70жилийн ойн арга хэмжээнд бэлэн болон бэлэн бусаар2 500 000₮ -ний хандив төвлөрч зарцуулав.

ИТГЭМЖЛЭЛ

"Баян-Өлгий аймгийн Нийтийн номын сан" -нд

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2015 оны 240 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам"-ын 2.2-т заасан шаардлагыг хангасан тул Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4, "Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам"-ын 10.7.2-т заасны дагуу 2019 оны санхүүгийн тайланд аудит хийлгүй итгэл үзүүлэхийг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/60 дугаар тушаалаар шийдвэрлэж ИТГЭМЖЛЭЛ олгов.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ЗАНДАНБАТ

Улаанбаатар хот
2019 он

Төсөв санхүүгийн талаар:

2019 онд 158.534.000 төсөв батлагдаж үүнээс:
Цалин- 109.683.400
Бичигхэрэг- 252.300
НДШ- 12.022.800
Тээвэр /шатахуун/- 165.400
Номхэвлэл- 3.894.400
Нормынхувцас- 387.100

АРАВ. БУСАД.

10.1. Б.Ахтаны нэрэмжит төв номын сангийн 70 жилийн ойн арга хэмжээ

Б.Ахтаны нэрэмжит төв номын сангийн 70 жилийн ой 2019 оны 09-р сарын 09,10 өдрүүдэд зохион байгууллаа. Тус ойн арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд аймгийн ЗД-ын орлогч Ш.Хабыл, ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэсийн дарга К.Бегжан, БСУГ-ын дарга Х.Зауре, Номын сангийн зөвлөлийн дарга Х.Муфти, Казахстан улсын Нурсултан хотын Үндэсний номын сангийн орлогч дарга Ж.Жархынбек, номын сангийн захиралаар ажиллаж байсан ахмадын төлөөлөл К.Зейнеп, сумдын номын санчдын төлөөлөл Бугат сумын соёлын төвийн номын санч Д.Миша болон зочид төлөөлөгчид нар хүрэлцэн ирж, аймгийн төв номын сангийн номын санчид 13 сумын соёлын төвийн номын санч , сум сургуулийн нийт 50 гаруй номын санч оролцов.

Ойн баярын арга хэмжээний үеэр:

- Номын сангийн Уншлагын танхимыг номын санд олон жил захирал хийж байсан Х.Ханипа агсаны нэрэмжит болгох нээлтийн үйл ажиллагаа болсон юм. Нээлтийн үйл ажиллагаанд агсаны хүүхдүүдэд, хамт ажиллаж байсан ахмадууд оролцож Ханипа агсаны дурсгалын самбар бэлэглэв.

- Соёлын гавьяат зүтгэлтэн, яруу найрагч Бабийн Ахтаны нэрэмжит **“Яруу найраг**”-ийн уралдааныг зохион байгуулав. Яруу найргийн уралдаан нийт 30 гаруй яруу найрагчид оролцож эхний байр эзэлсэн 6 яруу найргчийг шагнан урамшуулав.

- Казахстан улсын соёл, уран зохиолын төвийн нээлтийн үйл ажиллагаа болж Нурсултан хотын Үндэсний Академийн төв номын сангаас 300 гаруй ном бэлэглэв. Тус арга хэмжээнд Казахстан улсаас монгол улсад суугаа элчин сайдын хэлтэсийн дарга Шынар Жуматаев, Нурсултан хотын Үндэсний Академийн төв номын сангийн төлөөлөгч Жаркынбек Жумадилов, Талапбек Тынысбек, Байтан Асылбек нар хүрэлцэн ирж оролцов.

- Номын сангийн 70 жилийн ойн баярын үед гадаад, дотоодын зочид төлөөлөгчид болон номын санчдадгарын бэлэг болгож уут, энгэрийн тэмдэг, тэмдэглэлийн дэвтэр, байгууллагын зурагтай аяга, номын сангийн 70 жилийн түүхийн номуудыг хэвлүүлэн гаргав. Мөн номын сангийн гадны хаалга, гадна дотно талд засвар хийлгэж, үе үеийн захиралуудын зурагийг шинэчлэх зэрэг ажлуудыг хийллээ.

- Мөн Байгууллагын өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор урсгалзасварын ажлыг бүхажилчид өөрсдөөхийж гүйцэтгэсэн.

- Баян-Өлгий аймгийн ИТХ, ЗДТГ, Өлгий сумын ИТХ, ЗДТГын зохион байгуулсан **“Хоггүй Өлгий”** цэвэрлэгээний өдөр 2-р БДС –аас ХДТ хүртэлх замын хоёр талыг цэвэрлэв.

- Монгол УлсынЕрөнхийлэгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, аймгийн ЗД-ын 05-р сарын 09 ний өдрийн А/334 дугаар захирмжийн дагуу “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг 2019 оны 05-р сарын 12 өдөрзохион байгуулахтай холбогдуулан номын сангийн хамт олон гүүрийндээд талд 20ш мод тарьж, байгууллагын эзэмшилт газрыг цэвэрлэж, хогхаягдлыгшатааж цэвэрлэв.
- Ажилтнууд өрөө,танхимууддаа шинээр цэцэг үрслүүлж суулган, цэцэгжүүлэн, хамт олны самбар болон байгууллагын тэргүүний уншигчдын самбарт 2019 оны тэргүүний уншигчдын зургийг байрлуулан шинэчлэв.
- Ахмадын баярыг тохиолдуулан тэтгэвэрт гарсанахмад ажилтнуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.
- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр байгууллагын ажилчдын хүүхдүүдэд бэлэг гардуулан өгсөн.

БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

1.Номын сангийн үйлчилгээ

1.1. Лавлагаа арга зүй, ном зүйн ажил.

Лавлагаа арга зүйн танхимаас нийт 510 хүнд лавлагаа өгөв. Үүнээс: цахимаар 228 уншигчдад, амаар 215 уншигчдад, 67 уншигчдад утсаар лавлагаа өгч бүртгэлийг хөтлөн, 448 уншигчдад электрон каталог ашиглах заавар зөвлөгөө өгч, уншигчдаас хэрэгцээтэй байгаа номуудыг татгалзлаар бүртгэн, шинэ номын захиалгад нийт 21 номыг оруулснаас, 11 номыг нь худалдаж авсан.

Тогтмол хэвлэлийн Zotero программд "Өнөөгийн Баянхонгор" сонины 2008-2019 оны сонины 676 мэдээллийг шивж, тогтмол хэвлэлийн үндэсний нэгдсэн мэдээллийн санд орууллаа.

Орон нутгийн картын сан: 2017-2019 оны Баянхонгор аймгийн тогтмол хэвлэлийн ном зүйн гарын авлага хийж баяжуулсан.

Орон нутгийн ном зүйн бүртгэл: Баянхонгор аймгийн "Өнөөгийн Баянхонгор" тогтмол хэвлэлийн ном зүйн бүртгэл, Ардын уран зохиолч С.Эрдэнийн намтар уран бүтээлээр ном зүйн жагсаалт тус тус гаргаж сурталчилав.

Шинээр ирсэн номын картыг каталогт байрлуулах, редакц хийх: Электрон каталогийн 104 иргэн ашиглаж, орон нутгийн сонин сэтгүүлийн 98 ширхэг каталогийн картад, төрөл анги, үсэг дарааллын 110 ширхэг картад тус тус редакц хийсэн.

Арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд:

Арга зүйн зөвлөгөөг жилд 2 удаа аймгийн төвийн ЕБС-ийн 7 сургууль, Политехникийн коллеж, ХҮДСургууль, Баян-Овоо, Жаргалант, Баянлиг, Өлзийт, Бөмбөгөр, Заг, Баянбулаг, Гурванбулаг, Хүрээмарал, Бууцагаан сумдын нийтийн болон сургуулийн номын сангуудын ажил байдалтай танилцаж арга зүйн зөвлөгөөг өгч, үйл ажиллагаанд нь хяналт, шинжилгээ хийж арга зүйн удирдлагаар хангаж ажиллалаа.

Соого Сейкео сургуулийн номын санч Оюунцэцэгийг 11 сард номын сан дээр 2 өдрийн дадлага хийлгүүлж, дадлагажуулав.

<u>Уншигчдад зориулан гаргасан гарын авлага:</u> “Анли хэлний өдөр тутмын 200 өгүүлбэр”, “Англи хэлний түргэвчилсэн сургалт”, “Бүтээмж гэж юу вэ?”, “Багш нарт зориулсан Англи хэлний гарын авлага”, “Хүүхдийн эрх хамгаалал”, “Ном унших 10 шалтгаан”, “Авилга гэж юу вэ”, “Ухаалаг утасны хэрэглээ”, “Ном унших ач холбогдол”, “Сайхан арьстай болох зөвлөмж”, “Төрийн албан хаагчийн шинэчлэгдсэн ёс зүйн дүрэм” гэх зэрэг 12 гарын авлага гаргаж сурталчилсан.

1.2. Фондын үйлчилгээ: Фондоос цахим үйлчилгээгээр 636 номыг уншлагын танхимууд, гэрээр ном олгох тасгаар олгож, өдөр тутмын хэвлэлээр 40 уншигчдад үйлчиллээ.

<u>Фонд баяжилт</u>: 2019 онд худалдаагаар 195 нэр төрлийн 230 ширхэг 3975970 төгрөгийн номоор, хандив бэлгээр 187 нэр төрлийн 251 ширхэг 3352220 төгрөгийн номоор, нийт 382 нэр төрлийн, 481 ширхэг 7328190 төгрөгийн номоор фондыг баяжуулж, стандартын дагуу техник ажиллагаанд оруулж, уншигчдад үйлчлэн, өдөр тутмын хэвлэл “Зууны мэдээ”, ”Өдрийн сонин”, “Хүмүүн бичиг”, “Утга зохиол урлаг”, “Өнөөгийн Баянхонгор” сонин, ”Улирал ба зохиолч”, “Номын санч”, Like news, “Төрийн мэдээлэл” сэтгүүл гэх мэт 24 нэр төрлийн хэвлэлийг жилд 394.400 төгрөгөөр захиалж, 40 нэгж болгон, үдэж хавтаслалаа.

Урагдаж гэмтсэн **225** номыг сэргээн засварлан, бүртгэл хөтлөн, шинэ номын мэдээг 5 удаа номын товч анатацитайгаар гарган, фонд эргэлтийн судалгааг улирал бүр гаргаж дүгнэлт хийхэд 48491 ном олгож, сан хөмрөгийн эргэлт 100 хувьтай байгаагаас аман зохиол, уран зохиол, гүн ухааны номууд хэрэгцээ сайтай байна.

<u>Соёлын баримтат өвийн талаар:</u> Соёлын баримтат өв үндэсний хөтөлбөрийн хүрээнд: Бүртгэл мэдээллийн санд нийт 67 ном бүртгэлтэй байгаа цаашид баяжуулна. Урагдаж гэмтсэн номуудыг стандартын дагуу сэлбэн засах, нөхөн бүрдүүлэх ажлыг тогтмол хийж байна. "Даавуун артай соёлын баримтат өвийн өнөөгийн байдал” сэдэвт гарын авлага гаргаж сурталчлав.

<u>Номын сан хоорондын ном солилцоо:</u> 11 сум болон Номгон сургуулийн номын сантай ном солилцооны гэрээ байгуулж, 425 номоор солилцоо хийлээ.

<u>Нүүдлийн номын сангийн үйлчилгээг</u> Баян-Овоо сумд 1 удаа 20 номоор, Өлзийт сумд 1 удаа 80 номоор, Шийдвэр гүйцэтгэх газарт 13 удаа 321 номоор,

Ахмадын асрах төвд 1 удаа 5 номоор, 5-р цэцэрлэгт 2 удаа 16 номоор, Нийгмийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөгөөр Баганат талбайд 80 ном, Эх үрсийн баяраар 60 ном, Үндэсний их баяр наадмаар 100 номоор Дуурсахын хөндийд гэх мэт 21 удаа, 682 номоор 280 хүнд нүүдлийн номын сангийн үйлчилгээг хүргэлээ. Номын үзэсгэлэнг үзэж танилцсан хүний тоо 1480 орчим хүн байна.

<u>Номын үзэсгэлэн:</u> Шинэ номын үзэсгэлэнг 7 удаа 226 ном, сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 16 удаа 498 номоор гаргаж, уншигчдад сурталчилсан.

Хүүхдийн баяр болон Х.К.Андерсены зохиол бүтээлээр гаргасан номын үзэсгэлэн.

1.3. Уншлага үйлчилгээ: 2019 онд байнгын 3925 уншигчдад, 28997 ирцэд, 54473 ном олгож, электрон цахим үйлчилгээгээр хүүхдийн уншлагын танхим, интернет мэдээллийн танхимаас 10 удаа 584 хүүхдэд үйлчилсэн. Цахим ном, CD-ээр 20, интернетээр 50 хүнд үйлчилж, бүртгэл хөтөллөө.

Хүүхдийн уншлагын танхимаас бяцхан уншигчдад зориулж шинээр ирсэн 32 номоор зурагт каталогийг хийж, урилгат үйлчилгээг 9 дүгээр ангийн 4 бүлэг, Номгон сургуулийн 9 дүгээр ангийн 5 бүлэгт хүргүүлж, ном уншлагад 380 гаруй сурагч ирж хамрагдлаа.

“Үлгэрийн цаг” буюу цэцэрлэгийн бяцхан уншигчдад үлгэр үзүүлэх, үлгэр ярьж өгөх үйл ажиллагаанд аймгийн төвийн цэцэрлэгүүдийн хүүхдүүдийг хамрууллаа. Нийт 10 удаагийн “Үлгэрийн цаг” үйл ажиллагаанд 532 хүүхдийг хамруулжээ.

1.4. Дугуйлан:

Нийтийн уншлагын танхимын дэргэд “Хонгор нутгийн яруу эгшиглэн” дугуйланд 51 сурагч 7 хоногт 2 цагаар, “ELC” Англи хэлний дугуйланд 20 сурагч, Хүүхдийн уншлагын танхимы дэргэдэх даамны дугуйланд 32 сурагч суралцан хичээллэж байна. Нийт 3 төрлийн дугуйланд нийт 103 хүүхэд хамрагдаж байна.

1.5. Сургалт: <u>Уншигчдад зориулсан сургалт:</u> Аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулиуд болон Баян-Овоо сумын сургуулийн сурагчдад “Ном унших соёл” сургалтыг нийт 6 удаа явуулж, 227 сурагч хамрагдсан.

<u>Ажилтнуудын хамрагдсан сургалт:</u>

Боловсрол, соёл урлагийн газарт зохион байгуулагдсан “Хүүхдийг номоор хэрхэн хөгжүүлэх вэ?” сургалтад номын санч Ц.Сарантуяа, О.Наранцэцэг нар оролцов.

Номын сангийн Lib4u программыг шинэчлэн орчин үеийн үүлэн технологид суурилсан хувилбарыг нэвтрүүлэх сургалтанд 10 номын санч хамрагдсан.

Хууль эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан “Ил тод хариуцлагатай төрийн үйлчилгээ”, Төрийн албаны шинэчлэгдсэн хууль"-ийн талаар сургалтуудад хамт олноороо хамрагдсан байна.

“Төрийн болон байгууллагын архивын хөгжил, төлөвшилт” улсын үзүүлэх сургалт, зөвлөгөөн, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас зохион байгуулсан “Насанд хүрэгчдэд явуулах сургалтын онцлог” сэдэвт сургалтад ХАБЭА-н ажилтан О.Байгал оролцлоо.

Үндэсний номын сангаас зохион байгуулсан “Нийтийн номын сан арга зүйн төв болох нь” сургалтад ном зүйч Б.Должин оролцлоо.

<u>Орон нутгийн соёлын ажилтан, номын санчдад зохион байгуулсан сургалт:</u>

Үндэсний номын сан, аймгийн Боловсрол соёл урлагийн газартай хамтран аймаг, орон нутгийн номын санчдын дунд “Ажил мэргэжил, ур чадварын уралдаан”-ыг 5 сарын 21-нд зохион байгуулж, 31 номын санч, 3 төрлийн шалгуураар /номын санчдын мэдлэг шалгах тест, номзүйн бичилтээр ном тодорхойлох, өөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлж байгаа шинэлэг ажил/ оролцлоо. Номын санчдын ур чадварын уралдаанд тэргүүн байрыг Номгон ахлах сургуулийн номын санч Г.Эрдэнэчимэг, дэд байрыг Нийтийн номын сангийн хүүхдийн танхимын номын санч Ц.Сарантуяа, гутгаар байрыг Заг сумын номын санч

Н.Ариунаа, Тусгай байрт Эрдэнэмандал сургуулийн номын санч Ц.Болорчимэг, Эрдэнэцогт сумын сургуулийн номын санч Н.Даваацэцэг нар тус тус шалгаржээ.

Ламын гэгээн Лувсанданзанжанцаны мэлмий гийсний 380 жилийн ойг тохиолдуулан номын санчдын дунд “Ламын гэгээний нутгаар” сэдэвт илтгэлийн уралдаан зарлаж, тус уралдаанд 13 номын санч оролцов. Тэргүүн байрт Бөмбөгөр сумын сургуулийн номын санч Т.Содончимэг, дэд байрт Гурванбулаг сумын номын санч Д.Оюунжаргал, гутгаар байрт Өлзийт сумын номын санч Ц.Дэлгэрмаа нар шалгарч өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнагдлаа.

5 сарын 22-нд Монголын Үндэсний номын сангийн Мэргэжил арга зүй эрдэм шинжилгээний хэлтсийн арга зүйч Г.Гүнжинлхам, ном зүйч Х.Ундрах нар “Орчин үеийн хөгжлийн чиг хандлага, ном зүйн тодорхойлол” сэдвээр сургалт явуулж, 38 номын санч хамрагдав. Арга зүйч нар Нийтийн номын сангийн үйл ажиллагаа, 2015 онд өгч байсан арга зүй, үүрэг даалгаврын биелэлтийг шалгаж, цаашид хийх ажлын талаар зөвлөгөө өгч ажиллаа.

Ур чадварын уралдаан, илтгэлийн уралдаанд амжилттай оролцсон номын санчдыг өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа. Нийт шагналын санд 180000 төгрөг зарцуулсан.

2019 онд нийт 10 төрлийн сургалт явагдаж, 321 хүн хамрагдсан байна.

1.6. Соёл олон нийтийн ажил:

Уншигч, ард иргэдийн дунд “Үсэглэлийн хаад”, “Ээждээ бичих захидал”, “Аавдаа хэлэх чин сэтгэлийн үг” захидлын уралдаан, Дэлхийн яруу найргийн өдөрлөг, “Дэлхийн номын баяр” буюу Зохиолчдын эрхийг хамгаалах өдөр, “Ардын өв уламжлалыг залуу үеийнхэнд өвлүүлэх нь” уулзалт цэнгүүн, үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд зохион явуулсан “Монгол бичгээр хэн хурдан унших вэ?

хурдан унших уралдаан, “Монгол бичгийн сайхан бичигтэн” уралдаан, “50 номын хожил”, “Алтан хонх”, “АХА” асуулт хариултын тэмцээн, Хүүхдийн баяр, “Зуны зугаатай уншлага”, “Хүрэн морь” яруу найргийн наадам, “Номын баяр”, “Өсвөрийн яруу найрагч-бид” яруу найргийн уралдаан, “Найргийн чансаа” яруу найргийн анхдугаар наадам, Ном эрдэм аяны нээлт, тус аян хүрээнд зохион явуулдаг “Хурдан уншлагын олимпиад”, “Зохиолын дүрийн тоглолт”, “Ном эрдэм” аяны хаалт, тэргүүний уншигч “Нацагдорж дүр” тэмдэг олгох үйл ажиллагаа зэрэг 26 төрлийн соёл олон нийтийн ажил зохион байгуулж, 4158 хүн хамрагджээ. Төсөвт 10.836.820 төгрөг зарцуулсан байна.

Соёл, олон нийтийн ажлын хамрагдсан хүний тоог хүснэгтээр үзүүлбэл:

№	Соёл, олон нийтийн ажлын нэр /2019 он/	Хамрагдсан хүний тоо	Зарцуулсан төсөв /төгрөг/
1	“Үлгэрийн цаг” цэцэрлэгийн хүүхдүүдийн уншлага	174	
2	“Монгол ёс заншил” танин мэдэхүйн тэмцээн	18	25000
3	“Ээждээ бичих захидал” захидлын уралдаан	148	123000
4	“Аавдаа бичих чин сэтгэлийн үг” захидлын уралдаан	125	181200
5	Дэлхийн яруу найргийн өдөрлөг	140	
6	“Дэлхийн номын баяр” өдөрлөг	140	
7	“Ардын өв уламжлалыг залуу үеийнхэнд өвлүүлэх нь” уулзалт цэнгүүн	320	
8	Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд “Хонгор нутгийн сайхан бичигтэн”, “Монгол бичгээр хэн хурдан унших вэ? уралдаан	159	322500
9	Зуны зугаатай уншлага	23	21000
10	“Алтан хонх” асуулт хариултын тэмцээн	2 удаа 60 хүнд	
11	“50 номын хожил” танин мэдэхүйн уралдаан	24 удаа 90 хүнд	
12	“АХА” асуулт хариултын тэмцээн	1 удаа 80 хүнд	40.000
13	“Хүрэн морь” яруу найргийн наадам	43	3500000
14	“Номын баяр”	150	
15	“Өсвөрийн яруу найрагч-бид” яруу найргийн уралдаан	38	30.000
16	Ном эрдэм аяны нээлт	150	
17	Ном эрдэм аяны хүрээнд “Хурдан уншлагын олимпиад”	659	720000
18	Ном эрдэм аяны хүрээнд “Зохиолын шилдэг	336	840000

	дүр”-ийн тоглолт		
19	“Ахмадтай уулзах уулзалт” өдөрлөг	120	
20	Хүүхдийн номын баярын өдөрт зориулсан гар зургийн уралдаан	21	21000
21	Алтан агшин	140	
22	“Их богдын эгшиглэн” яруу найргийн наадам	300	2000000
23	“9 хайрханы цацал” наадам	150	1000000
24	“Унших эрдэм” уншлагын олимпиад	207	648000
25	“Найргийн чансаа” яруу найргийн уралдаан	17	50.000
26	Ном эрдэм аяны хаалт, тэргүүний уншигч шалгаруулан “Нацагдорж дүр” тэмдэг олгох үйл ажиллагаа	350	1435000
Нийт		4158	10.836.820

1.7. Угийн бичгийн талаар: Номундалай лаборатори сургуулийн биологийн багш, сургалтын менежер Б.Бүжинлхамтай хамтран “Угийн бичгийн аргачлал” сэдвээр Баян-Овоо сумын иргэд, хүүхэд багачуудад сургалт зохион явууллаа. Сургалтад 80 гаруй хүн оролцсон.

2. Мэдээллийн үйлчилгээ: Байгууллагын 14 компьютерын дотоод сүлжээ, LIB4U программийн хэвийн ажиллагааг хангаж, вирустсэн компьютерийг форматалж, цахим үйлчилгээ явуулан, facebook хуудсыг соёл олон нийтийн ажил, сургалт, бусад мэдээ мэдээллээр тухай бүр баяжуулж, иргэдэд мэдээлж ажиллаа.

Үндэсний номын сангийн вэб сайтад орон нутгийн номын сангуудын танилцуулга, нийтийн номын сангийн СУ /соёл урлагийн/ мэдээг бүрэн байршуулж дууссан. Байгууллагын үйл ажиллагаа, соёл олон нийтийн ажлын урилга, хөтөлбөр, өргөмжлөл, талархал зэрэг хэвлэлийн үйлчилгээг хийж байна.

Орон нутгийн номын сангийн цахим программын ашиглалтыг сайжруулан, хяналт тавьж арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. 11 сумын компьютерт гарсан гэмтлийг зассан.

3. Удирдлагын ажил: Төрөөс баримтлах соёлын бодлого Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, номын сангийн стандарт, холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллаа.

Байгууллагын болон ажилчдын сарын ажлын төлөвлөгөө, түүний биелэлт, тайлан, үүрэг даалгаврын биелэлтийг хянаж, хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулж ажиллаа. Байгууллагын хамт олны хурал 20 удаа хуралдлаа.

Ажилчдын албан тушаалын тодорхойлолтод дүн шинжилгээ хийж шинэчлэн боловсруулах ажлыг ажлын хэсгийн дарга, гишүүдийн хамт хийж гүйцэтгэлээ. Мэдээлэл цуглуулах хуудсаар ажилчдаас санал авч албан тушаалын тодорхойлолтод оруулж, тайланг аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргэв.

Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч, байгууллагын захиргаанаас 25-40 насны 7 ажилчдыг элэгний С вирусын шинжилгээнд хамруулсан.

Ажилтнуудыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэхэд спорт заалтай гэрээ байгуулан, заалны түрээсийн төлбөрт 200.000 төгрөг, сар шинийн баяраар байгууллагын 6 ахмадад хүндэтгэл үзүүлж байгууллагын захиргаанаас 240000 төгрөг, нягтлан бодогч Д.Баатархуягийн эхнэр төрсөн тул 50000 төгрөг, номын санч Ц.Сарантуяа шинэ байранд орсон тул 100000 төгрөг, сүлжээний ажилтан М.Дондовжамцын хүүхэд Улаанбаатар хотод эмчилгээ хийлгэж, хагалгаанд орох болсон тул 100000 төгрөг, ахмадын баярыг тохиолдуулан аймгийн Нийтийн номын сангийн ахмад настан П.Билэгт-Отгон, С.Цэдэндулам нарт тэтгэмж 60000 төгрөг, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр ажилчдын хүүхдүүдэд бэлэг бэлтгэн өгөхөд 180.000 төгрөг, харуулын ажилтан, ном зүйч нарын ар гэрт гачигдал гарахад хамтын сангаас тус бүр 50.000 гэх мэт нийт 1.030.000 төгрөг зарцуулсан байна.

Жаргалант сумтай хамтран ажиллах 7 байгууллагатай холбогдон, тус суманд малын тэжээл өгөх ажилд хандив өгч ажилласан.

Аймаг, хотын Нийтийн номын сан, сургуулийн номын санчдын дунд жил бүр зохион явуулдаг “Шилжин явах цом-2019” спортын тэмцээн Орхон аймагт 4 сарын 26-27-нд зохион байгуулагдсан. Гар бөмбөг, сагсан бөмбөг, усан поло, олс таталт, теннис, шатар гэсэн спортын 6 төрлөөр тэмцээн явагдаж, баг хамт олноор амжилттай оролцоод ирсэн.

Аймаг, хотын номын санчдын "Шилжин явах цом-2019" спортын тэмцээн, Орхон аймагт

Томилолтоор "Дэлхийн яруу найраг өдөр"-г тэмдэглэн зохион байгуулах ажлаар Баян-Овоо сумд, "Аймаг, хотын номын санчдын спортын тэмцээн"-д оролцохоор Эрдэнэт хотруу, "Номын баяр"-ын үйл ажиллагааг зохион явуулах ажлаар Өлзийт сумд, "Соёлын байгууллагын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих" ажлаар хангайн 7 сумд ажиллав. Томилолтоор явах үед автомашины аюулгүй, бүрэн бүтэн байдлыг хангаж ажилласан.

4. Архивын ажил: Ирсэн бичиг 111, явсан бичиг 93, тушаал 28, түр олгосон баримт 11 байна. i-office программыг үйл ажиллагаандаа ашиглаж, байгууллага хоорондоо харилцаж байна. Ирсэн 6 өргөдлийг тухай бүр шийдвэрлэн хариуг өгч, өргөдөл гомдлын мэдээг Боловсрол соёл урлагийн газарт хүргэж ажилласан.

Нийт ажилтнуудаас 2018 оны баримт бичгүүдийг байгууллагын архивт бүртгэлээр хүлээн авч, байнга хадгалах 46, түр 70 жил хадгалах 5, түр 10 жил хадгалах 71 хадгаламжийн нэгж үүсгэж баримтын бүртгэл гаргав.

Ажилчдаас ирүүлсэн санал болон өмнөх оны хөтлөх хэргийн жагсаалтын дагуу 2019 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан хэлэлцлээ.

"Цахим архив-Баянхонгор" хөтөлбөрийн хүрээнд байгууллагын байнга хадгалах 2015 оны 51, 2016 оны 42 хадгаламжийн нэгжийг иж бүрэн нягтлан шалгаж, цахим хэлбэрт оруулан, өгөгдлүүдийг шивж, 8 хувь дансны хамт Төрийн

архивын тасагт хугацаанд нь шилжүүллээ. Цахим мэдээллийг 3 хувь DVD-д хуулж, 1 хувийг байгууллагад авч хадгалав.

Байгууллагад хэрэглэгдэж буй 7 төрлийн тэмдэг, дардас, 4 төрлийн албан хэвлэмэл хуудасны тооллогыг ББНШК-той хамтран явууллаа. Ажилтнууд хариуцсан тэмдэг, дардсыг дүрэм журмын дагуу хэрэглэдэг, ашиглалт сайн, хадгалалт хамгаалалт сайн, цоожтой сав шүүгээнд хадгалж, хэрэглэж байна. Албан хэвлэмэл хуудасны тооллогыг 2018-2019 оныг хамруулан, одоо ашиглаж байгаа болон хүчингүй болсон хэвлэмэл хуудсыг тоолж, үрэгдүүлсэн 14 ш хэвлэмэл хуудсыг он тус бүрд жагсаалт үйлдэн буруутай ажилтнаар тухай бүр төлүүлж ажилласан.

Соёл урлагийн СУ мэдээг шинэ маягтаар гаргаж Боловсрол соёл урлагийн газарт хүргэж, бусад ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэлээ

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг шалгалтад бэлтгэн ажиллаа. Тус ажлын хүрээнд 2001-2018 оны баримтад тооллого явуулж, архивын баримтыг хамгаалалтын хайрцагт хийх, дүгнэх 4 үзүүлэлтийн биелэлт гаргах болон бусад бэлтгэл ажлуудыг хийж аймгийн салбар комисст тайланг хүргэлээ.

5. Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын хүрээнд: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах журмыг мөрдөн ажиллаж байна. Эрсдэлийн үнэлгээг фондоч, архив, бичиг хэргийн ажилтан, мэдээллийн ажилтны ажлын байранд хийж, байгууллага дээрх аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой зөрчил дутагдлыг “Аюулыг мэдээлэх хуудас” –аар илрүүлэн, арилгах арга хэмжээ авч ажилласан. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтнуудад явуулсан “Насанд хүрэгчдэд явуулах сургалтын онцлог” сэдэвт сургалтад оролцсон.

6. Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд: Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилган хариуг хугацаанд нь хүргүүлэв.

7. Авлигатай тэмцэх эрх бүхий ажилтан нь жилийн төлөвлөгөөг боловсруулан ажиллаж, тайлан биелэлтийг гаргаж ажиллав. “Авилга гэж юу вэ?” сэдвээр уншигчдад зориулсан гарын авлага гаргаж, сурталчилсан.

8. Хүүхэд хамгааллын ажлын хүрээнд: Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас эрхлэн гаргасан 6-12 нас, 13-18 насны хүүхдэд зориулсан аюулгүйн дүрэм, “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” эцэг, эхчүүдэд зориулсан гарын авлагыг хамт олонд танилцуулсан.

Боловсрол, соёл урлагийн газарт зохион байгуулагдсан “Хүүхдийг номоор хэрхэн хөгжүүлэх вэ?” сургалтад номын санч Ц.Сарантуяа, О.Наранцэцэг нар оролцов.

Цэвэрлэгээ үйлчилгээ, харуул хамгаалалтын ажил: Үйлчлэгч, харуулын албан тушаалын тодорхойлолт, цэвэрлэгээний хуваарийн дагуу ажлыг чанартай хийж гүйцэтгэсэн. Гадна орчны цэвэрлэгээ, зүлэг цэцгийн үр суулгаж арчлан ургуулах, цахилгаан, сантехникийн жижиг гэмтлүүдийг засаж, сэлбэн ажиллав.

Ээлж гараатай үед байгууллагын гадна, доторх үүдний хэсгийн шат довжоог цэвэрлэж, ажилчдын цагийг үнэн зөв бүртгэж ажилласан.

“Ажлын хэрэгцээний автомашин ашиглах, хэрэглэх” журмыг мөрдөн ажиллаж, нүүдлийн үйлчилгээ, хөдөө орон нутагт явах томилолтын үед автомашины аюулгүй байдлыг хангаж ажилласан.

Сум тойрсон ногоон зурвас газар, голын зах дагуух ойн зурвас дахь өөрийн байгууллагын хуваарьт хэсэгт 35 улиас нэмж тарьж, ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэж, усалгааг хийсэн.

9. Санхүү, бүртгэлийн ажил: Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хууль, Олон Улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, БСШУСЯ, Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан журам, шийдвэрийг хэрэгжүүлэн, тайлан балансыг цаг тухайд нь гаргаж, шилэн данс, төсвийн мэдээллийн самбараар дамжуулж иргэд, уншигчдад санхүүгийн ил тод байдлыг мэдээлж, 2018 оны санхүүгийн аудитын тайлангаар “Зөрчилгүй” дүгнэлт авсан.

Сангийн сайдын 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны баримтын маягтын дагуу 13 нэр төрлийн баримтыг шинэчлэн хөтөлж ажилласан.

Тод сод од ХХК, Д.Амгалан, Бүрд ээж ХХК, Монгол шуудан ХХК, Ник ХХК, Л.Амаржаргал ХХК, Смарт старт ХХК, Интерном ХХК, Б.Болормаа ХХК, Майхан цахир ХХК зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, бараа үйлчилгээ авч байна.

Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр явууллаа. Үүнд, тавилга эд хогшил-291 ширхэг 53.464.257, барилга-1 тэрбум 868 сая 941.351, бусад тоног төхөөрөмж 27 нэр төрлийн 28.364.050 төгрөг, программ хангамж 3 нэр төрлийн 4.835.200 төгрөг, түүх соёл дурсгалт зүйл-6.500.000 төгрөг, бусад хөрөнгө 3 нэр төрлийн 1.702.158, пургон автомашин 1 ширхэг 21.400.000.00 төгрөгийн эд хөрөнгийг ажилтан бүрийн эд хөрөнгийн карт, агуулахын бүртгэлээр тоолж, тооллогын комиссын тайлан гаргалаа.

10.Төлөвлөгөөнөөс бусад ажил:

Ламын гэгээний даншиг наадмыг угтаж аймгийн Зохиолчдын холбоо, БСУГ-тай хамтран "Их Богдын Эгшиглэн" яруу найргийн наадмыг хангай, говь, төвийн бүс гэсэн чиглэлээр 3 удаа зохион байгуулан, шилдгүүдийг тодруулан, дээрх ажлын үр дүнд "Их Богдын эгшиглэн-2" яруу найргийн номыг эмхэтгэн гаргасан.

Бөмбөгөр сумын соёлын төв, Тамгын газартай хамтран "Есөн хайрханы цацал" яруу найргийн наадмыг, аймгийн Зохиолчдын холбоотой хамтран "Найргийн чансаа" яруу найргийн наадмыг, "Ном эрдэм аян" ТББ-тай хамтран "Унших эрдэм" олимпиадыг СӨББ-уудын дунд 4 төрлөөр гэх мэтчилэн олон ажлуудыг төлөвлөгөөнөөс гадуур хийж хэрэгжүүллээ.

БСШУС-н дэд сайд Ганбаяр тэргүүтэй ажлын хэсэг боловсрол, соёлын байгууллагуудаар орж, үйл ажиллагаатай танилцах үеэр байгууллагаа танилцуулан, тулгамдаж буй асуудлаар ярилцсан.

10 сард Политехникийн коллежийн номын сан, “Эрчим хүч” ХК-ны шилдэг инженер Б.Батболд нартай хамтран тус коллежийн оюутан суралцагчдад мэргэжлийн үнэ цэнийг мэдүүлэх, эзэмшиж буй мэргэжлээрээ бахархах, ирээдүйд мэргэжлээрээ ажиллах сэдлийг төрүүлэх зорилгоор “Манай зочин“ уулзалт ярилцлагыг зохион явууллаа. Энэ үеэр шинэ номын болон техникийн цахилгааны номоор үзэсгэлэн гаргаж сурталчлав. Уулзалтад 100 гаруй оюутан оролцсон.

Тамхины хяналтын тухай хуулийг мөрдөн ажиллаж, “Тамхи татах цэг”-т хаягийг шинэчлэн, тайланг Хууль эрх зүйн хэлтэст хугацаанд нь гаргаж хүргэсэн.

Гадна талбайд тохижилт хийж, чулуун хавтанг сольж шинэчлэх, бүх нийтийн цэвэрлэгээ хийх, хайс будах, шарилж түүх зэрэг цаг үеийн ажлуудад тухай бүр хамт олноороо оролцлоо.

Хүүхэд гэр бүлийн хөгжлийн газраас зохион байгуулсан “Гэр бүл хүүхдийн хүмүүжлийн анхдагч орчин” сэдэвт сургалт зөвлөгөөн, “Алтан хонх” тэмцээнд хамт олноороо оролцсон.

Дүгнэлт:

Дутагдалтай зүйл. Байгууллагын төлөвлөсөн ажлуудаас соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, соёлын баримтат өвийг дэлгэрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх ажил удаашралтай байгаа зэрэг дутагдалтай зүйлүүд байлаа. Цаашид энэ ажлууд дээр анхаарч ажиллахыг ажил хариуцсан хүмүүст үүрэг болголоо.

Ололттой зүйл. Номын сангийн Lib4u программыг шинэчлэн орчин үеийн үүлэн технологид шилжүүлэв. Программын шинэчлэглийн талаар Волвэс компаний инженер Гантулга номын санчдад сургалт явуулж, программыг өдөр тумын уншлага үйлчилгээндээ нэвтрүүлээд байна.

Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн мэдээллийн санд “Өнөөгийн Баянхонгор” сонины 2008-2019 оны 676 мэдээллийг оруулав.

Цаашид хэрэгжилт дутуу ажлууд дээр хариуцлагатай ажиллаж төлөвлөгөөг 100% хэрэгжүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.

БУЛГАН АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

АГУУЛГА

1. УНШЛАГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТООН МЭДЭЭ
2. ЯВУУЛЫН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
3. САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭЛТ
4. ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ
5. ЛАВЛАГАА
6. ТАТГАЛЗАЛ
7. МЭРГЭЖИЛ АРГАЗҮЙ
8. НОМЗҮЙ
9. КАТАЛОГ
10. НОМЫН ҮЗЭСГЭЛЭН СУРТАЛЧИЛГАА
11. СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ
12. СОЁЛ ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ
13. ШИНЭЛЭГ АЖИЛ
14. ТӨСӨВ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
15. БУСАД АЖИЛ

1. УНШЛАГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТООН МЭДЭЭ

Уншигч: **3276**

Ирэгсэд: **21515**

Ном олголт: **27997** үүнээс ном-24246**,** хэвлэмэл бус материал, цахим ном-381, сонин-3173, сэтгүүл-197 байна.

Ном хангамж: 35555 : 3276 = 10.8

Ном уншилт: 27997 : 3276 = 8.5

Фондын эргэлт: 27997 : 35555 = 78.0 %

Уншигч, ирэгсэд заал танхим бүрээр дэлгэрэнгүйг дор хүснэгтээр харуулав.

2019 он уншигч, ирэгсэд																																
		Уншигчдын ангилал											Боловсрол						Насны ангилал						Хүйс						үүдэл, зөөв	
Он сар өдөр	Заал танхим ууд	Бүх уншигч	Ажилтан албан хаагч	Хувиараа хөдөлмөр	Бусад	Сургуулийн өмнөх нас	I-IV анги	V-VIII анги	IX-XI анги	Их дээд сургууль, коллеж	Мэргэжлийн боловсрол		Бага	Суурь	Бүрэн дунд	Тусгай дунд	Дээд		18 нас хүртэлх	18-24 насны	25-35 насны	36-50 насны	51-ээс дээш насны		Эмэгтэй	Эрэгтэй		Монгол	Гадаад	Ирэгсэд	Уншигч	Ирэгсэд
Бүтэн жилээр 2019.12.31	НУТ	426	7	3	1			218	188	4	5	426		216	190	8	12	426	406	14	2	3	1	426	249	177	426	426		7356	2	54
	ХУТ	1111				828	283					1111	1111					1111	1111					1111	581	530	1111	1111		6253	386	1156
	Салбар	1147	94			324	322	384	23			1147	1021	32	2	12	80	1147	1055	5	32	38	17	1147	613	534	1147	1147		4614	342	668
	ГНО	195	92	22	81							195	3		71	17	104	195		12	47	82	54	195	135	60	195	195		2625	4	163
	Фонд	397																												667	138	507
Дүн		3276	193	25	82	1152	605	602	211	4	5	2879	2135	248	263	37	196	2879	2572	31	81	123	72	2879	1578	1301	2879	2879		21515	872	2548

Ном олголтыг заал танхим бүрээр дэлгэрэнгүйг дор хүснэгтээр харуулав.

2019 он ном олголт																													
					Шинжлэх ухаанаар ангилсан байдал																			Хэлээр нь ангилсан			Тогтмол хэвлэл		
Он сар өдөр	Заал танхим	Бүх олгосон	Ном	Хэвлэмэл бус материал ба цахим ном	Байгалийн шинжлэл	Техник	Хөдөө аж ахуй	Анагаах ухаан	Социологи, статистик, хүн ам	Түүх	Эдийн засаг	Улс төр	Төр эрх, хууль цааз	Цэргийн ш/у	Соёл,ш/у, боловсрол	Хэл шинжлэл	Аман зохиол,утга зохиол судлал	Уран зохиол	Урлаг	Шашин	Гүн ухаан	Сэтгэл судлал	Лавлах хэвлэл	Монгол	Орос	Англи	Сонин	Сэтгүүл	Нүүдэл
Бүтэн жил 2019.12.31	НУТ	5507	4823	298	332	67	78	41	54	460	20	24	8	2	396	1096	397	1323	135	133	217	129	595	5507			311	75	70
	ХУТ	6037	5804	36	537					908					207		1901	1626	203		281		374	5882	59	96	75	122	161
	Салбар	8609	8523	30	37	45	35	106		467		1			56		4479	3078	105	28	109		7	8609			56		763
	ГНО	5843	3095	17				2		2	3				2726	1	688	2403	3	2	1	1	11	5843			2731		398
	Фонд	2001	2001																					2001					761
Дүн		27997	24246	381	906	112	113	149	54	1837	23	25	8	2	3385	1097	7465	8430	446	163	608	130	987	27842	59	96	3173	197	2153

Уншигч, ирэгсэд, ном олголт 2010-2019 оны харьцуулсан үзүүлэлтийг дор гарфикаар үзүүлэв.



2. ЯВУУЛЫН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

26 байгууллагад 62 удаа 872 уншигч, 2548 ирэгсэдэд, 2153 номоор үйлчилсэн байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр дор оруулав.

НҮҮДЭЛ ЗӨӨВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2019.12.31

№	Байгууллагын нэр	Нэгж салбар	Хамтран ажилласан	Он,сар, өдөр	Уншигч	Ирэгсэд	Ном олголт	Хариуцсан номын сан
1	439-р хорих анги		Мөнхбат	1.13		69	137	Д.Долгормаа Г.Эрдэнэбулган
2	Мэргэжлийн хяналтын газар		Б.Хишигсүрэн	2.13	8	18	82	Д.Долгормаа
3	1-р цэцэрлэг	Бага бүлэг	Б.Дулмаа	2.15	25	25	5	Д.Долгормаа
4		Дунд		2.15	20	20	5	Д.Долгормаа
5		Ахлах		2.15	18	18	5	Д.Долгормаа
6		Бэлтгэл А, Б		2.15	76	76	5	Д.Долгормаа
7	Эрүүл мэндийн газар		Урангаваа	2.22	20	42	65	Д.Долгормаа
8	7-р цэцэрлэг	Бага бүлэг	Арга зүйч	2.28	28	28	3	Б.Отгончимэг
9		Ахлах	Арга зүйч	2.28	32	32	3	Б.Отгончимэг
10		Бэлтгэл	Арга зүйч	2.28	27	27	3	Б.Отгончимэг
11	4-р цэцэрлэг	Бага бүлэг	Арга зүйч	3.14	25	25	3	Б.Отгончимэг
12		Дунд	Арга зүйч	3.14	31	31	3	Б.Отгончимэг
13		Ахлах	Арга зүйч	3.14	29	29	3	Б.Отгончимэг
14	7-р цэцэрлэг	Бага бүлэг	Арга зүйч	3.14		30	3	Б.Отгончимэг
15		Дунд	Арга зүйч	3.14	24	24	3	Б.Отгончимэг
16		Ахлах	Арга зүйч	3.14		32	3	Б.Отгончимэг
17		Бэлтгэл	Арга зүйч	3.14		31	3	Б.Отгончимэг
18	2-р цэцэрлэг	Бүх бүлэг	Арга зүйч	3.21	104	104	3	Б.Отгончимэг
19	Иргэний бүртгэл		Оюун-Эрдэнэ	3.22	13	26	41	Г.Эрдэнэбулган
20	6-р багийн иргэдийн хурал дээр явуулын номын сан		Багийн дарга	3.27	2	59	6	Д.Долгормаа, Г.Эрдэнэбулган
21	Хишиг-Өндөр сургуулийн номын сан		Ононтуул	3.29			15	Г.Эрдэнэбулган
22	4-р цэцэрлэг	Бага бүлэг	Арга зүйч	4.11		25	3	Б.Отгончимэг
23		Дунд	Арга зүйч	4.11		29	3	Б.Отгончимэг
24		Ахлах	Арга зүйч	4.11		30	3	Б.Отгончимэг
25	6-р цэцэрлэг	Бага бүлэг	Баярмаа	4.12	25	25	5	Д.Долгормаа
26		Дунд		4.12	22	22	5	Д.Долгормаа
27		Ахлах		4.12	29	29	5	Д.Долгормаа
28		Бэлтгэл А, Б		4.12	47	47	5	Д.Долгормаа
29	Шүүхийн Тамгын газар		Дөлгөөн	4.17	12	17	127	Г.Эрдэнэбулган, Д.Долгормаа
30	Мэргэжлийн хяналтын газар		Хишигсүрэн	4.18		6	30	Д.Долгормаа
31	7-р цэцэрлэг	Бага бүлэг		4.19		28	3	Б.Отгончимэг
32		Дунд		4.19		24	3	Б.Отгончимэг
33		Ахлах		4.19		32	3	Б.Отгончимэг
34		Бэлтгэл		4.19		27	3	Б.Отгончимэг
35	7-р цэцэрлэг	Ахлах		4.25		32	4	Б.Отгончимэг
36		Бэлтгэл		4.25		27	4	Б.Отгончимэг
37	ШШГүйцэтгэх алба		Алтан-Од	5.2		13	13	Г.Эрдэнэбулган
38	Татварын хэлтэс		Зэсмаа	5.2	6	10	20	Д.Долгормаа
39	ШШГүйцэтгэх алба		Алтан-Од	5,20		13	13	Г.Эрдэнэбулган
40	6-р багт явуулын номын сан			6.17-6.21		62	80	Б.Отгончимэг
41	2-р багт явуулын номын сан			6.17-6.22		25	102	Д.Долгормаа
42	ШШГүйцэтгэх алба			6.21		15	15	Г.Эрдэнэбулган
43	3-р багт явуулын номын сан			6.24-6.28		26	98	Д.Долгормаа
44	4-р багт явуулын номын сан			6.24-6.29	4	163	398	Г.Энхбилэг
45	5-р багт явуулын номын сан			6.24-6.30		110	163	Г.Эрдэнэбулган
46	1-р багт явуулын номын сан			6.24-6.31	2	54	70	Б.Эрдэнэцацралт
47	6-р баг явуулын номын сан			6.25	30	70	140	Г.Эрдэнэбулган
48	4-р цэцэрлэг /бага, дунд, ахлах/			9.12		75	5	Б.Отгончимэг
49	7-р цэцэрлэг /бага, ахлах, бэлтгэл/			9.26		87	5	Б.Отгончимэг
50	6-р цэцэрлэг			10.01		120	20	Д.Долгормаа
51	4-цэцэрлэг			10.24		89	3	Б.Отгончимэг
52	3-р цэцэрлэг			10.25	86	86	3	Б.Отгончимэг
53	ГХБХБГ			11.04	9	18	50	Д.Долгормаа
54	Шүүхийн шинжилгээний алба			11.06	7	9	20	Д.Долгормаа
55	3-р сургуулийн дотуур байр		Байрны багш	11.06	54	108	124	Г.Эрдэнэбулган
56	Булган сумын ЗДТГ			11.07	9	15	30	Д.Долгормаа
57	ХААМСҮТ-ийн дотуур байр		Байрны багш	11.08	34	79	102	Г.Эрдэнэбулган
58	ХААН банк			11.08	12	20	43	Д.Долгормаа
59	2-р цэцэрлэг багш ажиллагсад			11.19	2	20	12	Д.Долгормаа
60	ХААН банк			11.2		3	11	Д.Долгормаа
61	7-р цэцэрлэг			12.05		110	3	Б.Отгончимэг
62	Булган сумын ЗДТГ			12.14		2	5	Д.Долгормаа
	ДҮН				872	2548	2153	

3. САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭЛТ

2019 онд 292 нэр төрлийн 562 ширхэг 6,714,388 төгрөгний ном хэвлэлээр сан хөмрөг нэмэгдсэн. Үүнээс:

- Төсвөөс 149 нэр төрлийн 353 ширхэг 4,507,838 төгрөгний
- Бэлэг хандиваар 143 нэр төрлийн 209 ширхэг 2,206,550 төгрөгний ном хэвлэл

2020 оны 01 сарын 01-ны байдлаар нийтдээ манай сан хөмрөгт 18606 нэр төрлийн, 35555 ширхэг, 91.760.447 төгрөгний үнэ бүхий ном хэвлэлийн бүтээгдэхүүн байна. Ном хэвлэлийн үнэ байнга өсөн нэмэгдэж байгаатай холбогдон бүрдүүлэлтийн тоо ширхэг, нэр төрөл буурсан үзүүлэлт гарсан.

2019 онд солилцооны болон бэлтгэл фондыг шинээр бий болголоо. Жилийн эцэст солилцооны фондод 305 ширхэг 1.046.180 төгрөгний, бэлтгэл фондод 40 ширхэг 247.000 төгрөгний ном хэвлэл байна.

Фонд баяжилт шинжлэх ухаанаар олон жи..........



4. САН ХӨМРӨГИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

Оны эхэнд уншлагын танхимуудын ойрын фондын ном хэвлэлийн ээлжит бус тооллого хийж уншигчдын гар дээр удсан номыг татан авалтыг сайжруулах арга хэмжээ авч ажилласан.

Алдагдсан болон үрэгдүүлсэн номыг “Алдагдсан ном хэвлэлийг төлүүлэх журам”-ын мөрдөн ажиллаж ээлжит бус хяналтын тооллогыг жилд 1-ээс доошгүй удаа хийхээр төлөвлөн ажилласан.

Байгууллагын дотоод хяналт шалгалтын дагуу ойрын фондын ээлжит бус хяналтын тооллогыг жилд 2 удаа хийсэн.

Эрүүл мэндийн газрын ариутгал халдваргүйжүүлэлтээр хортон шавьжны устгал 6 сарын 21-нд бүх өрөө тасалгаанд хийлгэсэн.

Сэлбэн зассан ном:

Нийт 201 номыг сэлбэн зассан. Ихэнх номны нуруу, хуудаснууд шинээрээ салах, хуудас алга болох зэрэг гэмтлүүд маш их гарч өөрсдийн нөөц боломцоогоор засаж сайжруулж уншлага үйлчилгээнд гаргаж байна.

- Үндсэн фонд-63
- Нийтийн уншлагын танхим-17
- Хүүхдийн уншлагын танхим-21
- Гэрээр ном олгох танхим-48
- Салбар номын сан-52

5. ЛАВЛАГАА

Нийтдээ 1165 лавлагаа өгөгдсөн. Үүнээс амаар 517, бичгээр 121, утсаар 223 , цахимаар 304 байна. Лавлагаа заал танхим бүрээр дэлгэрэнгүйг дор харуулав.

- ✓ Хүүхдийн уншлагын танхим- 121 амаар 68, бичгээр 21, цахимаар 32
- ✓ Нийтийн уншлагын танхим- 115 амаар 80, цахимаар 35
- ✓ Гэрээр ном олгох танхим-121 амаар 30 , утсаар 21, цахимаар 70
- ✓ Үндсэн фонд-17 амаар 17
- ✓ Салбар номын сан-65, амаар 35, утсаар 30
- ✓ Арга зүйч-726 амаар 287, бичгээр 100, утсаар 172, цахимаар 167 лавлагаа өгөгдсөн байна.

6. ТАТГАЛЗАЛ:

Нийт 154 ном татгалзалд бүртгэгдсэн. Ном бүрдүүлэлтээс татгалзлын 25.6 %-ийг хариулсан байна.

- Хүүхдийн уншлагын танхим-36 хариулсан 29
- Нийтийн уншлагын танхим-33, хариулсан 13
- Гэрээр ном олгох танхим-24, хариулсан 9
- Үндсэн фонд-15
- Салбар номын сан- 32
- Арга зүйч-14, хариулсан 9

Жич: Хариулсан гэдэгт татгалзалд бүртгэгдсэн номыг бүрдүүлэлтээр авч уншигчдад хүргэсэн номыг оруулсан болно.

Татгалзалд хамгийн олон бүртгэгдсэн Жаран цагаан хонь, Өглөөний гайхамшиг, Вангийн нулимс, Харь хэлээр яригсад цувралууд, Алганы хээ, Могой боолт зэрэг Монголын сүүлийн үеийн уран зохиолын номнууд заал танхимуудад 1% болон цөөн байгаагаас хүрэлцээ муу татгалзал өндөр байна.

7. МЭРГЭЖИЛ АРГАЗҮЙ

Булган аймагт 16 сум 1 тосгонд АТНСан болон идэвхтэй ажиллаж байгаа сумын 17 сургуулийн 20 номын санд нийтдээ 38 номын санд 45 номын санч ажиллаж байгаагаас мэргэжлийн номын санч 12 мэргэжлийн бус номын санч 33 үүнээс мэргэжлээрээ эчнээд суралцаж байгаа 4 номын санч байна. Номын санчдын судалгааг шинэчлэн гаргасан тайлангийн ар Excel файлаар хавсаргасан.

2018 онд аймгийн БСУГ-тай хамтран сум, сургуулийн номын сангуудад мэргэжил арга зүйгээр зөвлөн туслахаар 13 сумын 25 номын санд ажилласан. Үүний үр дүнд орон нутгийн номын сангуудийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж анхан шатны бүртгэл хөтлөлтүүд хангалтгүй байгааг сайжруулах зорилгоор БСУГ-аас “Орон нутгийн бүртгэл хөтлөлтийг сайжруулах жил” болгон зарласан. 2019 оны эцэст бүртгэл хөтлөлтийг дүгнэж үнэлгээ хийсэн мэдээллийг дор оруулав. Дэлгэрэнгүйг тайлан хавсралтаар илгээлээ.

Сум, сургуулийн номын сангуудын 1 жил гаруйн хугацаанд бүртгэл хөтлөлтийг сайжруулсан:

1. Баян-Агт сумын номын сан
2. Баяннуур сумын номын сан /мэргэжлийн шинэ номын санч орсон/
3. Бүрэгхангай сумын номын сан
4. Гурванбулаг сумын номын сан
5. Дашинчилэн сургуулийн номын сан
6. Орхон сумын номын сан
7. Сайхан сумын номын сан

Бүртгэл хөтлөлтийг сайжруулах эхлэл төдий байгаа:

1. Баян-Агт сургуулийн номын сан
2. Дашинчилэн сумын номын сан
3. Могод сумын номын сан
4. Могод сургуулийн номын сан
5. Рашаант сургуулийн номын сан
6. Сайхан сургуулийн номын сан
7. Тэшиг сумын номын сан
8. Хангал сургуулийн номын сан
9. Хутаг-Өндөр сумын номын сан
10. Хутаг-Өндөр сургуулийн номын сан
11. ЭӨЦС-ийн номын сан
12. 1-р 12 жилийн сургуулийн номын сан
13. ХААМСҮТ-ийн номын сан

Өөрчлөлт гараагүй:

1. Баяннуур сургуулийн номын сан
2. Бугат сумын номын сан
3. Бугат сургуулийн номын сан
4. Бүрэгхангай сургуулийн номын сан /шинэ номын санч орсон/
5. Гурванбулаг сургуулийн номын сан
6. Орхон сургуулийн номын сан
7. Рашаант сумын номын сан
8. Сэлэнгэ сумын номын сан
9. Сэлэнгэ сумын номын сан
10. Хангал сумын номын сан
11. Булган сумын номын сан

Огт хөтлөөгүй:

1. Булган сумын 3-р 12 жилийн сургуулийн номын сан
2. Хялганат сургуулийн номын сан

3. Тэшиг сургуулийн номын сан

Дээрх бүртгэл хөтлөлтийн мэдээг өмнөх оныхтой харьцуулж бодит мэдээг гаргахын тулд ажлын 5 өдрийг бүтэн зарцуулсан.

Номын санч бүр рүү утсаар, цахимаар мэдээлэл авахын зэрэгцээ бүртгэл хөтлөх заавар, ач холбогдолыг нэг бүрчилсэн тайлбарлаж арга зүйн зөвөлгөө өгч ажиллаа. Цахимаар бүртгэлүүдийн зургийг авч буруу зөвийг хэлж өгч засварлах шаардлагатай газар дээр нь засуулах цаашид хэрхэн зөв бүрэн хөтлөх тухай хангалттай мэдээлэл өглөө.

Цаашид номын санчаар тууштай ажиллах, номын сангийн мэргэжилээр суралцах залуу номын санчдыг дэмжин 3-5 суманд АТНС-аас томилолтоор ажиллаж анхан шатны бүртгэлд нь ном хэвлэлийг нь бүрэн тусгаж өгөх ажлыг 2020 оны ажлын төлөвлөгөөнд оруулахаар боллоо.

Арга зүйчээс аймаг, орон нутгийн номын санчдад 411 лавлагаа өгөгдсөн байна. Өгөгдсөн лавлагаанд дүгнэлт хийхэд номын дахин үнэлгээ, алдагдсан, дутсан ном хэвлэл, номын шинжлэх ухааны ангилал, програм ашиглалтын талаар мэдээллүүд байна.

Google porms ашиглан номын сангийн уншигчдаас сэтгэл ханамжийн судалгаа авахаар нүүр номд байршуулсан.

8. НОМЗҮЙ

Номзүйч бүрдүүлэлт, каталогийг давхар хариуцдаг тул 2019 онд фонд баяжилт хийгдсэн 562 ширхэг ном хэвлэлийн данслах, техник ажиллагаа, каталогжуулалтыг бүрэн хийсэн.

2017, 2018 оны тогтмол хэвлэлийг дансалж электрон каталогт оруулж картыг хэвлэж цаасан каталогт байршуулсан.

2019 оны “Булганы мэдээ” сонины өгүүллийг МҮНС-ийн zotero програмд оруулсан

Шинэ номын мэдээг 4 удаа гаргасан. Цахимаар уншигчдад хүргэсэн.

“Булган” орон нутгийн фондод байгаа ном хэвлэлийн ангилал, он, тоо ширхэг бүхий 462 номын мэдээг хүснэгтээр гаргасан.



9. КАТАЛОГ

Манай электрон каталогт одоогоор 16.026 төрллийн 35548 ширхэг ном бүртгэгдсэн, 2010.08.13-с хойш 104,541 удаа хайлт хийсэн байна.

Шинээр нэмэгдсэн ном хэвлэлийг тухай бүр цаасан каталогт тусгаж 2 удаа редакц хийж ялгагчийн нэмсэн.

Програмд ажилласан байдлыг дор татаж харуулав.





10. НОМЫН ҮЗЭСГЭЛЭН, СУРТАЛЧИЛГАА

36 удаа 1262 номоор үзэсгэлэн гаргаж 6908 хүн үзсэн. Дэлгэрэнгүйг дор оруулав.

2019 онд гаргасан номын үзэсгэлэн						
2019.12.31						
№	Номын үзэсгэлэнгийн нэр	Үзэсгэлэн гаргасан номын тоо	Он сар өдөр	Хаана	Үзсэн хүний тоо	Хариуцах эзэн
1	Шинэ номын үзэсгэлэн	42	1.03	НУТ	324	Б.Эрдэнэцацралт
2	Номын үзэсгэлэн	70	1.13	Хорих 439-р анги	69	Д.Долгормаа
3	Үндсэн хуулийн өдөрт	27	1.30	НУТ	43	Г.Эрдэнэбулган Б.Эрдэнэцацралт
4	Үндсэн хуулийн өдөрт	5	1.7-1.25	Салбар номын сан	108	Д.Долгормаа
5	Жанжин Д.Сүхбаатарын мэндэлсэн өдөрт	25	2.02	НУТ	212	Г.Эрдэнэбулган Б.Эрдэнэцацралт
6	Үндэсний зан заншил	27	2.03	НУТ	17	Г.Эрдэнэбулган Б.Эрдэнэцацралт
7	Эх орончдын өдөрт	26	2.18	НУТ	161	Г.Эрдэнэбулган Б.Эрдэнэцацралт
8	Номын үзэсгэлэн	70	2.22	Эрүүл мэндийн газар	42	Д.Долгормаа
9	Эзэгтэйн гал тогоонд	25	3.05	НУТ	374	Б.Эрдэнэцацралт
10	СӨНасныханд зориулсан "Зурагт ном"-ын үзэсгэлэн	20	3.06	ХУТ	460	Б.Оттончимэг
11	Дэлхийн номын баярт	52	3.12	ХУТ	233	Б.Оттончимэг
12	Дэлхийн номын баярт	41	3.19	НУТ	147	Г.Эрдэнэбулган Б.Эрдэнэцацралт
13	Номын үзэсгэлэн	90	3.27	6-р багийн хөгжлийн төв	59	Д.Долгормаа
14	Инээдмийн баярт	19	3.27	НУТ	137	Г.Эрдэнэбулган Б.Эрдэнэцацралт
15	Номын үзэсгэлэн	65	4.17	Шүүхийн тамгын газар	17	Д.Долгормаа
16	Бичиг соёлын өдөрт	22	4.17	НУТ	753	Б.Эрдэнэцацралт
17	Статистикийн мэдээ мэдээлэл	19	5.06	НУТ	491	Б.Эрдэнэцацралт
18	ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт	30	5.10	ХУТ	247	Б.Оттончимэг
19	ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт	27	05.15-06.01	Салбар номын сан	134	Д.Долгормаа
20	ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт	23	5.30	НУТ	65	Б.Эрдэнэцацралт
21	ЭЕШалгалтанд бэлтгэгчдэд	18	05.20-06.10	Салбар номын сан	180	Д.Долгормаа
22	ЭЕШалгалтанд бэлтгэгчдэд	21	5.01	НУТ	325	Б.Эрдэнэцацралт
23	Хууль, эрхзүйн сэдэвчилсэн номын үзэсгэлэн	14	6.15	НУТ	95	Б.Эрдэнэцацралт
24	Чинван Ханддоржийн мэндэлсэний 150 жилийн ойд зориулсан сэдэвчилсэн номын үзэсгэлэн	12	9.16	АЗДТГ	200	Г.Эрдэнэбулган Б.Оттончимэг
25	Чинван Ханддоржийн мэндэлсэний 150 жилийн ойд зориулсан сэдэвчилсэн номын үзэсгэлэн	12	9.17	НУТ	523	Б.Эрдэнэцацралт
26	Шинэ номын үзэсгэлэн	21	9.09	ХУТ		Б.Оттончимэг
27	Ахмад багш нарын зөвөлгөөнд "Сурган хүмүүжүүлэх ухаан" сэдэвчилсэн үзэсгэлэн		10.3	АЗДТГ	200	Г.Энхбилэг Г.Эрдэнэбулган
28	Шинэ номын үзэсгэлэн	29	10.5	НУТ	371	Б.Эрдэнэцацралт
29	Шинэ номын үзэсгэлэн	29	10.21	НУТ	680	Б.Эрдэнэцацралт
30	ГХБХБГ	60	11.04	Салбар номын сан	18	Д.Долгормаа
31	ШША	65	11.06	Салбар номын сан	9	Д.Долгормаа
32	Булган сумын ЗДТГ	68	11.07	Салбар номын сан	15	Д.Долгормаа
33	ХААН банк	78	11.08	Салбар номын сан	20	Д.Долгормаа
34	2-р цэцэрлэгийн багш ажиллагсад	57	11.19	Салбар номын сан	20	Д.Долгормаа
35	Монгол бахархалын өдөрт зориулсан сэдэвчилсэн номын үзэсгэлэн	26	11.21-11.28	НУТ	159	Б.Эрдэнэцацралт Г.Эрдэнэбулган
36	Гүн ухаан сэдэвчилсэн номын үзэсгэлэн	27	11.28-12.09	НУТ		Б.Эрдэнэцацралт
ДҮН		**1262**			**6908**	

11. СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ

Төрөл бүрийн 19 сургалт, мэдээлэлд давхардсан тоогоор 59 хүн хамрагдсан. Дэлгэрэнгүйг дор оруулав.

Сургалтууд				
2019.12.31				
№	Сургалтууд	Зохион байгуулсан газар	Хугацаа	Оролцсон хүний тоо
1	Эмэгтэйчүүдийн хөгжил оролцоо аймгийн зөвлөгөөн	АЗДТГ	1.04	5
2	Хуримтлал өсөхөөс эхэлнэ хувь хүний хөгжлийн лекц	Лектор Мөнгөн		5
3	Харилцаа хандлага лекц	ГБХЗХГ	2.14	5
4	Алдагдсан ном хэвлэлийг төлүүлэх журам	Т.Мөнгөнтуяа	4.01	8
5	Архив албан хэрэг хөтлөх стандарт	Г.Энхбилэг	4.01	8
6	Архивын албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх сургалт	Аймгийн архивын газар		1
7	Галын аюулгүй байдлын сургалт	ОБГазар	4.24	1
8	Нийгмийн даатгалын хууль, онлайн тайлангийн хэрэгжилт	НДГ	6.11	1
9	Угийн бичиг хөтлөх сургалт	Ш.Шийтэр	6.21	1
10	Статистикийн газрын сургалт	Статистикийн газар	6.21	2
11	Гэр бүлийн үнэ цэнэ	ГБХЗХГ	9.6	2
12	Худалдан авалт		9.26	1
13	Library update	МНСК	9.27-28	
14	Ажлын байран дахь зөв зохистой хоол хүнсний хэрэглээ	ГБХЗХГ	10.7	4
15	Нягтлан бодогчдын сургалт		10.10-11	1
16	Ураг удмын түүх соёл	Соёлын төв	10.31	2
17	Статистикийн газрын сургалт	АСГазар	12.04	9
18	Ойлгоё, хүндлэе	ЦГ, ХГБЗХГ	12.12	2
19	Аргазүйчдын сургалт	МҮНС	12.05	1
Дүн				59

Төсөв мөнгөний хүрэлцээгүйгээс орон нутгийн номын санчдад сургалт зохион байгуулж чадаагүй.

Булган төв номын сан нүүр номын хуудсаар номын сангаас зохион байгуулж буй соёл олон нийтийн ажил, бусад үйл ажиллагаагаа сурталчилж 120 гаруй удаа мэдээлэл оруулж хүн үзэж мэдээлэл авсан байна.

Гэр бүлийн радиод 3 удаа, Монголын радиогийн Соёл, урлагийн редакцид 1 удаа, Булганы мэдээ сонинд 2 удаа номын сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч номын сангийнхаа үйл ажиллагааг сурталчилсан.

12. СОЁЛ ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ

55 соёл олон нийтийн ажилд 5232 хүн оролцож номын сангийн нүүр номд байрлуулсан СОНА-ын мэдээллийг 11806 хүн үзсэн.

13. ШИНЭЛЭГ АЖИЛ

- ✓ “Сайхан Монгол” орон нутгийн телевиз “Номын амт” 5 цуврал нэвтрүүлэг.
- ✓ ОХУ-ын Буриад улсын Закаменск хотын Төв номын сантай хамтран ажиллах гэрээ байгуулж гэрээний хүрээнд Закаменск хотын номын сангийн хамт олонтой хамтран Дундговь, Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай аймгуудын номын сангуудаар туршлага судлах, түүх, соёлын дурсгалт газруудаар танилцах нөхөрсөг аялал зохион байгуулсан. Цаашид номын санч солилцоогоор ажиллуулах боломж бүрдсэн.
- ✓ ОХУ-ын Закаменскийн Төв номын сангийн даргын дэмжлээр сумын номын санчдыг Улаан-Үүд хотын номын сангаар танилцуулан туршлага судалсан.
- ✓ Дархан хотод болсон “Хамтдаа хөгжье” төвийн бүсийн аймгийн номын санчдын илтгэл ур чадварын уралдаанд Тэргүүн байр эзэлсэн.
- ✓ “Норовын намтар” маскот
- ✓ “Амухайн хормогчтой үлгэр”-ийн цаг

14. ТӨСӨВ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2019 онд 140224500 /нэг зуун дөчин сая хоёр зуун хорин дөрвөн мянга таван зуун төгрөг/-ний санхүүжилт авч 10 орон тоотойгоор төрийн үйлчилгээг явууллаа.

Санхүүжилтийг дараах зардлуудад цалинд 97,3 сая буюу 69,4%, ажил олгогчийн НДШ-д 12,2 сая буюу 8,7 % , байр ашиглалтын зардалд 20,2 сая буюу 14,4%,,хангамж материалд 5,9 сая буюу 4,2%, эд хогшил, урсгал засварт 2,2 сая буюу 1,6%, дотоод албан томилолт 0,7 сая буюу 0,5% нормативтба бусадаар гүйцэтгүүлэх , хичээл үйлдвэрлэл зардал гэсэн 3 зардалд 1,1 сая буюу 0,8 %, нэг удаагийн тэтгэмжид 1,0 сая буюу 0,8 % зарцуулсан.

Урсгал зардлыг 2,2 сая төгрөгөөр дулааны узель суурилуулж, цэвэр усны холболт хийлгэсэн.

Цаашид:

1-рт Булган аймагт Дулааны цахилгаан станц ашиглалтанд орсоноор байгууллагын халаалтын сан техникийн шугам хоолойг шинэчлэх шаардлагатай.

2-рт Барилгын ашиглалтын хугацаа дуусаж, ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт олон удаа гарсан тул өргөтгөлийн асуудлыг шийдвэрлүүлэх.

3-рт Батлагдсан төсөвт багтаан ажиллаж байгаа тул ажиллагсад сар бүр ур яадварын нэмэгдэл олгохгүй байгаа.

4-рт Шатахууны зардал байгатай тул хөдөө орон нутагт ажиллах боломжгүй.

15. БУСАД АЖИЛ

Номын сангийн бүх ажиллагсад олон нийтийн болон аж ахуйн 17 ажилд оролцсон мэдээллийг дор оруулав.

1. Байгууллагын их цэвэрлэгээ
2. “Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх бэлэн байдлын дуут дохио” бүх ажиллагсад бэлтгэл хангаж оролцсон
3. ЭӨЦС-ийн 11 ангийн сурагчдын Г.Оюунцэцэг багшдаа туслах аянд нэгдэж бүх ажиллагсад хандив өгсөн
4. Гамшиг осол, гал түймрийн бэлэн байдлын үзлэг сургуулилтад 2 ажилтан оролцсон
5. Булган Марафон-2019-д 3 ажилтан оролцсон
6. Орхон аймагт болсон Монголын номын сангуудын спортын наадамд оролцон Булган аймгийн номын санчдын баг хамт олон 4-р байранд шалгарсан.
7. Соёлын байгууллагуудын дарга, эрхлэгч нарын “Соёлын довтолгоо” аялан тоглолтонд АТНС хамтран ажилласан
8. Номын сангийн ажилагсад “Цэмцгэр Булган” аянд нэгдэн бүх нийтийн хог цэвэрлэгээнд Цагдаагийн постоос цааш засмал зам дагуух 2 талын 900 м газар цэвэрлэсэн

9. Нийтийн уншлагын танхимыг 5 сарын 1-ээс 6 сарын 1-ыг хүртэл уртасгасан цагийн хуваарт шилжүүлж номын санчид ээлжээр ажилласан
10. Байгууллагын дотор, гаднах талбайд их цэвэрлэгээ хийж цэцгийн мандалд гоёлын цэцэг тарьсан
11. Авто зам дагуух бүх нийтийн хог цэвэрлэгээ
12. Бүх нийтээр мод тарих өдөр бүх ажиллагсад Сансар-2 саданд 5 мойлны мод тарьсан
13. Олон нийтийн эргүүлд 4 номын санч ажилласан
14. Тарьсан модны цэнэг усалгааг хийсэн
15. Байгууллагын гаднах орчмын цас цэвэрлэгээ

СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖЛЫН ФОТО

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар ном уншлагын аян

ЭӨЦС-ийн Л.Сандагсүрэн багштай 4 б анги 7 хоног бүр 1 дэх өдөр 15.00 цагт уншлагад ирдэг.

Аймгийн Эрүүл мэндийн газар “Ном уншлагын аян”

7-р цэцэрлэг чанга уншлага

2-р цэцэрлэгт үлгэрийн чанга уншлага

“Амухайн хормогчтой үлгэрийн цаг”

ОБГ-аас жил бүр зохион байгуулдаг гамшиг ослоос урьдчилан сэргийлэх зарлан мэдээлэх дуут дохиогоор ажиллагсад бэлэн байдалд жагслаа

ЭӨЦС-ийн 7 А ангийн сурагчид номын сангаар танилцаж, “Дэлхийн номын сангууд”, “Сурахын төлөө” мэдээлэл

ОУ-ын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан зохион байгуулсан “Эхийн тухай шүлэг”-ийн уралдаан

Номын үзэсгэлэнгүүдээс

"Үндэсний бичиг соёлын хишиг өдөр"-өөр зохион байгуулсан ажлууд

ШШГазрын харъяа 439-р хорих ангид явуулын номын сангаар

7-р цэцэрлэг ахлах бүлэг "АХА" тэмцээн, номын сангаар танилцах аялал, чанга уншлага

Норовын намтар дүрийн тоглолт

ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр номын худалдаа, Норовын намтар маскот

Шүүхийн Тамгын газар явуулын номын үйлчилгээ

1-6 -р багт зуны явуулын номын сан

5-р багт зуны явуулын номын сан

6-р багт зуны явуулын номын сан

СУИС-ийн оюутнууд номын сангаар

Монголын номын санчдын спортын наадам

Ойрын фондын ээлжит бус тооллого

Сайн үйлсийн аян

Цэвэрлэгээ

Дархан хотод 2019 оны 09 сарын 4-5-ны өдрүүдэд болсон Төвийн бүсийн аймгуудын номын санчдын “Хамтдаа хөгжье” илтгэл, ур чадварын уралдаанд аймгийн Төв номын сангийн номын санчид оролцож ТЭРГҮҮН байр эзэллээ.

Гэр бүлээрээ ном унших цаг

Салбар номын сангийн үйл ажиллагаанаас

“Номын амт” 5 цуврал телевизийн нэвтрүүлэг

Байгууллагуудаар явуулын номын үйлчилгээ

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

1. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОН ТОО БҮТЭЦ

Нийтийн номын сан нь 2019 онд удирдах-1, мэргэжлийн-8, аж ахуй үйлчилгээний- 6 нийт 15 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн Засаг даргатай байгуулсан Менежерийн үр дүнгийн гэрээнд үндэслэн, Нийтийн номын сангийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг ханган биелүүлэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжууд, УИХ, Засгийн газрын тогтоол, БСШУЯ-ны сайдын тушаал, заавар, зөвлөмжүүдэд үндэслэн өөрийн үйл ажиллагааг зохион байгуулж ирлээ.

2. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. 2019 онд жилийн эцэст нийт 1775 шинэ уншигч бүртгэж, 14500 ирцэд 28902 ном олголт хийлээ.
2. Уншигч үйлчлүүлэгчдийг шинэ мэдээ мэдээллээр хангах зорилтын хүрээнд 180 удаа аман, 60 удаа бичгийн лавлагаа, 55 номын татгалзал өгөв.
3. Фондын номын эдэлгээг уртасгах зорилгоор 685 ширхэг номыг сэлбэн засаж уншлага үйлчилгээнд гаргалаа.
4. Насанд хүрэгчдийн уншлагын танхимаар 550 сонин, 8 сэтгүүлээр уншигчдад үйлчиллээ.
5. Аймгийн төвийн иргэд олон нийтэд хүрч ажиллах үүднээс зөөврийн номын санг албан байгууллагуудтай гэрээ байгуулж / Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Монгол банк, Тагнуулын хэлтэс, Татварын хэлтэс, Хас банк, Хаан банк, 1,2,3,4,5-р цэцэрлэг, Хаан банк, Ундарга-Алтай ОНӨААТҮГ, Төрийн Аудитын газар, Орон нутаг судлах музей г.м / шинэ уншигч 20-

ыг бүртгэж, 7 хоног бүр очиж зөөврий номын үйлчилгээг үзүүлэн нийт 550 ирцэд 1750 ном олголтыг хийж ажиллаа.

- Нүүдлийн номын сангийн үйлчилгээг Тонхил, Дарив, Хөхморьт, Баян-Уул, Жаргалан сумуудын иргэдэд номын сангийн Үндсэн фондны номыг сумдын Соёлын төвийн номын сангаар дамжуулан хүргэж үйлчиллээ.

- Монгол түмний уламжлалт баяр “Цагаан сар”-ыг тохиолдуулан “Цагаан сар ба ёс заншил” номын үзэсгэлэн, ОУ-ын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан “Тэнгэрлэг бүсгүйчүүд” номын үзэсгэлэн, Төрийн шагналт, төрийн гавьяат зүтгэлтэн Дорнын их яруу найрагч Б.Явуухулангийн мэндэлсэний 90 жилийн ойд зориулсан номын үзэсгэлэн, Инээдмийн баярт зориулан “Шог хошин ертөнц” номын үзэсгэлэн, Дэлхий хүүхдийн номын өдрөөр “Андерсоны номын үзэсгэлэн”, “Үндэсний Бичиг үсгийн баяр”-2019 ховор үнэт номын болон Шинэ номын үзэсгэлэн, ОУ-ын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд Хүүхдийн номын үзэсгэлэн, худалдаа, “Үндэсний их баяр наадам – 2019” шинэ номын үзэсгэлэн, Багш нарын баяр, Улс тунхагласны баяр, Шинэ жилийн баяр гэх мэт тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд шинэ номын болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг тогтмол гарган ажилладаг билээ. 2019 оны Төрийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцон Шинэ болон худалдааны номын үзэсгэлэн гаргаж уншигч үйлчлүүлэгчдэд үнэгүй карт нээн ажиллаа.

Номын үзэсгэлэн

3.ФОНД БАЯЖИЛТ, КАТАЛОГИ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2019 онд 684 ширхэг, 12,026,360 төгрөгийн номоор фонд баяжилт хийн уншлага үйлчилгээнд гарган уншигчдад үйлчилж байна. Фондын чийгшилт номын хадгалалтыг сайжруулан ажиллаж байна. 12 нэр төрлийн 592,800 төгрөгийн хэвлэл захиалан нэгж ном болгон үдэж уншлага үйлчилгээнд гарган үйлчилж байна. Шинэ болон хандиваар ирсэн 486 номыг Lib4U програмд оруулж, бар коджуулан фонд тасгуудад хуваарилан каталоги хэвлэн байрлуулсан. Манай аймаг хэвлэлийн хуудсанаа орон нутгийн картын санд Зууны мэдээ 1, Өдрийн сонин 3, Монголын мэдээ 5-ийг оруулж картын санг баяжуулсан байна.

СУРГАЛТ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ

Тонхил, Баян-Уул, Дарив, Цогт, Хөхморьт сумдын сургууль, Соёлын төвийн номын санч нарын ажил байдалтай танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөн ном солилцох гэрээ байгуулан сум бүрд солилцооны ном хүлээлгэн өгөв. Сумдын номын сан, сургуулийн номын санчдад 25 удаа мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. 2019 оны 03 сарын 30нд Говь-Алтай аймгийн нийт соёлын салбарт ажиллагсадын "Соёлын ажилтны анхдугаар зөвлөгөөн" болж хамт олноороо Соёлын өнөөгийн чиг хандлага, сургалт арга зүйн зөвлөгөө, соёлын салбарт тулгарч буй хүндрэлүүдийг ярилцаж, харилцан туршлага солилцсон зөвөлгөөнд оролцлоо. Мөн оны 4-р сарын 18-20 хооронд Ховд аймгийн Нийтийн номын сан, 3 сургуулийн номын сантай танилцаж, харилцан туршлага солилцож арга зүйн зөвлөгөө авч ажиллаа. 2019 оны 9 сард Нийт Сумдын ном санч нарт Монбиблио программын сургалтыг СУИС-ийн багш Т.Хайдав зохион байгуулж арга зүйн зөвөлгөө өгч шинээр программуудыг суулгаж өглөө. Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339, 340, 2017 оны 67 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангуулах зорилгоор "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг 2019 оны 03-р сарын 21-нд 16 цагт аймгийн Нийтийн Номын сангийн байгууллагын ажилчид бүрэн

бүрэлдэхүүнээрээ жагсаж, Газар хөдлөлтийн гамшигийн аюулаас урдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, өөрийгөө болон бусдыг аврах, анхны тусламж, дэмжлэг үзүүлэх сургалтанд амжилттай оролцлоо. Номын санч мэдээллийн ажилтныг чадавхжуулах улсын сургалт зөвлөгөөнд Ном зүйч С.Цэрэнпил оролцлоо.

Сумдын Соёлын төвийн номын сан



Сумдын Соёлын төвийн номын сан

Гамшгийн сургалтын үеэр

Ховд аймгийн Нийтийн номын сангийн үйл ажиллагаатай танилцах үеэр

Соёлын ажилтны анхдугаар зөвлөгөөн

Номын санч мэдээллийн ажилтнуудын улсын зөвөлгөөн

Монбиблио программын сургалт – Сумдын ном санчид

3. СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ

Үндэсний бичиг үсгийн баяр:

ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСЭГ ТУСГААР ТОГТНОЛ: уриан дор зохион байгуулагдсан "Үндэсний бичиг үсгийн баяр" 2019 оны 5-р сарын 8 нд Нийтийн номын сангийн уншлагын танхимд боллоо. Нээлтэнд БСУГазрын мэргэжилтэн Н.Жаргалсайхан, Ахмад зохиолч Д.Сүрьяагийн нэрэмжит Нийтийн номын сангийн захирал Э.Оюунгэрэл нар нээж үг хэлж, Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн сурагч Баатардорж, Цэрэндондов нар Жалам хар, Морьтон Монгол аялгуугаар хуурын ая барилаа.

Үндэсний бичиг үсгийн баярын нээлт

Сургуулиудын сурагчдын бүтээлийн үзэсгэлэнд

1-р байр 1-р сургууль, 2-р байр 4-р сургууль, 3-р байр Хантайшир –Эрдэм цогцолбор сургууль тус тус шалгарлаа. ЕБС-ийн бүтээлийн үзэсгэлэн болж 1, 2, 3, 4, 5-р сургуулид болон Анагаах ухааны лицей сургуулийн сурагчдын бүтээл тавигдан үзэгчид үзэж сонирхлоо.

Уран бичлэгийн уралдаанд 1,2,4,5-р сургуулиуд, МСҮТ, Анагаах ухааны лицей сургуулийн сурагчид оролцож муутуу цаасан дээр бийрээр уран бичиж авьяас чадвараа сорилоо. Уралдаанд оролцсон сурагчдаас 1-р сургуулийн 11а ангийн сурагч Б.Хишигбаяр 1-р байр, Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн 11а ангийн сурагч Н.Нямдулам 2-р байр, Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн 11а ангийн сурагч Э.Оюун-Эрдэнэ 3-р байр тус тус шалгарч Өргөмжлөл мөнгөн

шагналаар шагнагдлаа.

Уралдааны байр эзэлсэн оролцогчид

Уран бичлэгийн уралдаан – Сурагчдын бүтээлийн үзэсгэлэнгээс

Номын баяр - 2019

Номын баярыг 2019 оны 09 сарын 13-ны 10 цагт Нийтийн номын сангийн уншлагын танхимд зохион байгууллаа. Баярын үйл ажиллагааг нээж захирал Э.Оюунгэрэл үг хэллээ.

Нээлтийн үйл ажиллагаанд Өсвөрийн морин хуурчдын улсын уралдааны тэргүүн

байрын шагналт “Хишигтэн” хамтлаг “Цэцэгт нуурын хөвөөнд” аяаар ая дуугаа өргөн

барилаа.

Нийтийн номын сангийн “Шилдэг уншигч” тэмдэгээр:

1-р сургуулийн 5-г ангийн сурагч Г.Үүрцайх,

1-р сургуулийн сурагч О. Мандухай,

Аудитын газрын жижүүр Г.Бумцэнд ,

“Тэргүүний уншигч” - Д.Нацагдорж тэмдгээр:

МСҮТ-ийн оёдлын ангийн 3-р курсын сурагч Цэрэндолгор,

3-р сургуулийн 9-а ангийн сурагч М.Нандин-Эрдэнэ, 7-б ангийн сурагч Ууганпүрэв,

10-б ангийн сурагч Дүүрэнбилэг, 6-а ангийн сурагч Нинжбадгар, Хишигдаваа,

2-р сургуулийн 4-в ангийн сурач Т.Бүрэнзаяа, 8-б ангийн сурагч Мөнхзул,

4-р сургуулийн сурагч 11-б ангийн Мөнхгэрэл,

Хантайшир –Эрдэм цогцолбор сургуулийн 10-б ангийн сурагч Цэрэндондов,

8-а ангийн сурагч Баатардорж, 10-б ангийн сурагч Бат-Эрдэнэ нар тус тус шагнагдлаа.

Номын баярын үйл ажиллагаанд шинэ ном, ховор ном, Алтайн зохиолчдын номын

үзэсгэлэн, бүтээлийн үзэсгэлэн, шинэ номын худалдаа зохион байгууллаа.

Алтайн зохиолчдын уран бүтээлийн үзэсгэлэн

Номын баярын үеэр орон нутагтаа амьдарч байгаа Алтайн зохиолчдын уулзалтыг Нийтийн номын сангийн Хүүхдийн уншлагын танхимд уншигч хүүхдүүдийн дунд зохион байгууллаа. Уулзалтанд тус аймагт амьдарч байгаа зохиолч Г.Чардаг, Т.Мөнх-Амар, Б. Эрдэнэ-Очир, Х.Чимэдрэгзэн, С.Энхбаатар, Д.Буянжаргал нар оролцон өөрсдийн хүүхэд нас, зохиол бүтээлийн талаар ярилцан, шүлгээ уншин сонирхууллаа.

Уншигч зохиолчдын уулзалтанд оролцсон хүүхдүүдийн дунд өөрсдийн сайн мэдэх шүлгээр нь шүлгийн уралдаан зохион байгууллаа. Тус шүлгийн уралдаанд 15 уншигч хүүхдүүд шүлгээ уншин сонирхуулж авьяас чадвараа сорилоо. Шүлгийн уралдааны 1-р байрыг 1-р сургуулийн сурагч 4-г ангийн сурагч Эрдэнэсувд, 2-р байрыг 1-р сургуулийн 4-г ангийн сурагч О.Энхчимэг, 3-р байрыг 2-р сургуулийн 5-г ангийн сурагч Н.Хатанбаатар нар эзлэн дурсгалын зүйлээр шагнагдлаа.

Тэмцээний үеэр

Шүлгийн уралдааны байр эзэлсэн сурагчид

Уншигч зохиолчдын уулзалтанд оролцсон сурагчдад зохиолч Б.Эрдэнэ-Очир Р.Эмүжингийн

номын цувралаас бэлэглэлээ. Мөн анги хамт олноороо идэвхтэй оролцсон 1-р сургуулийн

4-г ангийнханд Нийтийн номын сангийн зүгээс дурсгалын зүйл хадгалуулав. Уг арга

хэмжээнд 58 сурагчид оролцлоо. Номын баярт нийт 80 гаруй уншигч сурагчид хамрагдлаа.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан”

Нийтийн номын сангийн Гэрээр ном олгох тасгаас

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд Хос бүжгийн аварга,

Цэнгээнт диско бүжгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион явууллаа. Тэмцээнд нийт 50

гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд оролцсоноос Хос бүжгийн аварга – Д.Бүрэнбилэг,

С.Долгормаа, Чөлөөт болон диско бүжгийн аваргаар С.Эрдэнэпүрэв нар тус тус шалгарч

дурсгалын зүйлээр шагнагдав. Мөн тэмцээний үеэр АДБАЧ-ын уран бүтээлч Б.Махбариад

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд амд хөгжмийн уран бүтээлээ толилууллаа. Тэмцээнд

оролцогч нийт иргэддээ аймгийн Улаан загалмайн хорооноос гарын бэлэг гардууллаа. Хөгжлийн

бэрхшээлтэй иргэдэд үнэгүй карт нээж чөлөөт сонголтын уран зохиолын номоор үйлчиллээ.

Үлгэрийн цаг

2019 оны 1-р сарын 31, мөн 11-р сарын 22-нд 3,4-р цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “Үлгэрийн

баатрууд амилсан нь” дүрийн тоглолтуудыг цэцэрлэгийн захиргаа, арга зүйн багийхантай

хамтран зохион байгууллаа. Дүрийн тоглолтыг явуулснаар хүүхдүүдийн хэл ярианы ойлголт,

хамтач, бүтээлч үйлийг илэрхийлэх, эцэг эх багш, ажилчдын хамтын үйл ажиллагааг

сайжруулан хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжихэд энэхүү ажлын гол зорилго оршиж байсан.

Уг жүжигчилсэн тоглолтонд 2 цэцэрлэгийн 10 бүлгийн хүүхэд багачууд оролцон үеийн найз

нартаа үлгэрээр дамжуулан хүүхэд бүр номтой нөхөрлөх үйл ажиллагааг сурталчилсан арга

хэмжээ болсон.

2-р сарын 21, 4-р сарын 5, 12, 26 мөн 5-р сарын 3,17-ны 10-р сарын 10, 29, 11-р сарын 18, 22-

ны өдрүүдэд Есөнбулаг сумын 3, 2, 4, 6, 7-р цэцэрлэгүүлийн дунд, ахлах, бага бүлгийн нийт 350

гаруй хүүхэд багачууд, мөн 1-р сургуулийн 1А ангийн 42 сурагчдад монгол ардын болон орос

ардын үлгэрээр “Үлгэрийн цаг”-ийг явуулан хүүхэд багачуудыг номын ертөнц болон үлгэрийн

далайгаар аялуулсан. /Цэцэн хүү, Хулан хэрээ чоно гурав, Мэргэн галуу ба тэнэг мэлхий, Буга

тэмээ хоёр, Эвтэй дөрвөн амьтан, Гурван алтан бэлзэг, Халамжит эгч алёна хөөрхөн дүү Иван,

Цэцэн бэр, Баавгай, морь чоно гурвын үлгэр, Онгироо заан, Муур багш, Тэнэг хүн зэрэг үлгэрээр/

жилийн турш зохион явуулж ирлээ.

Эрхий мэргэн

Нугасны муухай дэгдээхий

Манжин

“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр” буюу 6-р сарын 1-ны өдрийг тохиолдуулан 2019 оны 05 сарын 31-ны өдөр “Гэр бүлээрээ хамтдаа” сэдвийн хүрээнд нийт албан хаагчидынхаа гэр бүлийг хүлээн авч хөгжөөнт тэмцээн зохион байгуулж, хүүхдүүдийнхээ авъасыг үзэж, байгууллагын дарга хүүхэд бүрт бэлэг гардууллаа. Мөн Жанчивын талбай дээр Шинэ номын худалдаа, Хүүхдийн номын үзэсгэлэн гаргалаа.

“Ахмадын баярын өдрөр” зохиолч яруу найрагч, Д.Пүрэвдорж, Ш.Сүрэнжав, Б.Лхагвасүрэн нарын номоор үзэсгэлэн гаргаж ахмадуудын дунд өөрсдийн зохиосон шүлгийн уралдаан, хөгжөөнт тэмцээнийг зохион явууллаа. Тэмцээнд өндөр настан Ц.Мяндал тэргүүн байр, Х.Дулам дэд байр, У.Нямсүрэн гутгаар байр эзэлж өдөрлөгт нийт 50 гаруй ахмадууд оролцож, номын үзэсгэлэнг үзэж сонирхлоо.

6. Тохижилт үйлчилгээ

Байгууллагын засвар дараах ажлуудыг хийв. Үүнд:

1. Гадна талд байгууллагын гэрэлтэй хаяг хийлгэн байрлуулав.
2. Хайсандаа ногоон байгууламж хийсэн.
3. Гадна хайсыг будсан.
4. Байгууллагын гадна талыг шохойдсон.

Д.Сүрьягийн нэрэмжит аймгийн Нийтийн номын сангийн барилгын ажлыг Улсын төсвийн 956,3

сая төгрөгийн төсөвт өртгөөр “Рокпэйнт” ХХК гүйцэтгэж ашиглалтад оруууллаа.

Номын сангийн шинэ барилгын нээлтийн үйл ажиллагаа 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

болж УИХ-ын гишүүн Ш.Раднаасэд, аймгийн ИТХ-ын дарга Л.Батжаргал, Засаг даргын зөвлөх

В.Сүррагчаа, Засаг даргын орлогч Ж.Ганбат, Засаг даргын орлогч Я.Эрхэмбаяр болон хэлтэс,

агентлагийн дарга нар, номын сангийн хамт олон, ард иргэд, уншигч хүүхэд багачууд өргөнөөр оролцлоо.

ШИНЭ НОМЫН САНГИЙН БАРИЛГЫН НЭЭЛТ

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН
2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Уншлага үйлчилгээний ажлын талаар:

Үйлчилгээндээ байнгын 1534 уншигч, ирэгсэд нийт 18101 уншигчдад 19188 ширхэг ном хэвлэл олгож үйлчиллээ.

Гэрээр ном олгох журамын дагуу бүртгэл хөтөлж 503 уншигчдад1007 ширхэг, ном олгож үйлчиллээ.

Зөөврөөр 234 уншигчдад 410 ширхэг ном хэвлэл олгож үйлчилсэн.

Аудио болон сонсдог номын үйлчилгээгээр 52 уншигчдад 142 ширхэг номоор үйлчилсэн.
Цахим номын үйлчилгээгээр 25 уншигчдад 58 ном хэвлэл олгож үйлчилсэн.
Шинэ, сэдэвчилсэн номын үзэсгэлэн:

Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг **14** удаа **434** ширхэг номоор гаргасан. Нийт **1004** уншигч хамрагдсан.
Үүнээс:
Шинэ номын үзэсгэлэнг 7 удаа 272 ширхэг номоор гаргаж 545 уншигч үзэж сонирхсон.
Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 18 удаа 547 ширхэг номоор гаргаж 1,182 уншигч хамрагдсан.

Соёл олон нийтийн ажил:

Ном-Эрдэм 2 сарын аян, Дэлхийн номын өдөртэй холбогдуулан хүүхдүүдэд **"НОМЫГ БҮТЭЭЛЧЭЭР УНШУУЛАХ АРГА ЗҮЙ ЭЗЭМШҮҮЛЭХ"** сургалтыг ЕБС-ийн монгол хэл, уран зохиолын багш, бага ангийн багш, анги удирдсан багш, нийгмийн ажилтан, номын санч нарт зохион явууллаа. Нийт 170 багш сургалтанд хамрагдсан.

“Хичээлээс гадуурх уншлага” сэдвээр: МУБИС-ийн багш, Д.Нацагдоржийн

шагналт, Хүүхдийн зохиолч О.Сундуй
“Сурагчдын унших чадварыг хөгжүүлэх уншлагын арга барилууд” сэдвээр : Монголын хүүхдийн төв номын сангийн хэлтэсийн эрхлэгч С.Тунгалаг
“Уран зохиол хүүхдийн уншлаганд нөлөөлөх нь” сэдвээр : Монголын хүүхдийн төв номын сангийн арга зүйч Х.Батболор

“**ҮНДЭСНИЙ БИЧИГ, ҮСЭГ**”-ийн өдрийгугтан **“ӨВ СОЁЛ 2019**уралдааныг:

- “Сайхан бичигтэн анги хамт олон”
- “Уран бичлэг “ гэсэн 2 төрлөөр аймгийн хэмжээнд 2 дахь удаагаа амжилттай зохион байгууллаа.

САЙХАН БИЧИГТЭН АНГИ, ХАМТ

ОЛОН"-оор 7-9 дүгээр ангид

Тэргүүн байранд: Шивээговь сумын 3-р сургуулийн А.Шинэбаяр багштай 9а анги

Дэд байранд: 5-р сургуулийн Э.Олонцэцэг багштай 8б анги

Гутгаар байранд: 2-р сургуулийн Б.Энхмэнд багштай 8а

10-12 дугаар ангид

Тэргүүн байранд: 1-р сургуулийн Т.Баянжаргал багштай 11б анги

Дэд байранд: 5-р сургуулийн Ц.Цэцэнзаяа багштай 10а анги

Гутгаар байранд: 2-р сургуулийн Б.Цэвэлсүрэн багштай 11б анги

"УРАН БИЧЛЭГ"-ИЙН уралдааныг сурагчид, Иргэд гэсэн 2 ангилалийн хүрээнд 4-р сарын 30-ны өдөр аймгийн нийтийн номынсанд 2 үе шаттай зохион байгуулсан. Нийт 26 сонирхогч оролцсон. Үүнээс: Сурагчдын ангилалд 16 сурагч иргэдийн ангилалд 10 иргэн

Уран бичлэгийн сонирхогч иргэдийн төрөлд:
Тэргүүн байранд: Их Засаг Их сургуулийн оюутан Х.Энхболд
Дэд байранд: 1-р сургуулийн багш М.Алимаа
Гутгаар байранд: 2-р сургуулийн багш Б.Энхмэнд

Уран бичлэг сурагчдын төрөлд:
Тэргүүн байранд: 5-р сургуулийн 10а ангийн сурагч Э.Бямбасүрэн
Дэд байранд: 5-р сургуулийн 8б ангийн сурагч М.Хонгорзул
Гутгаар байранд: 1-р сургуулийн 11б ангийн сурагч Э.Даваасүрэн нар тус тус байр эзэллээ.

“НОМ- ЭРДЭМ” 2 САРЫН АЯН:

Аяны хүрээнд:

1. “Тэргүүний уншигч” /Бага, дунд, ахлах анги/
2. “Тэргүүний уншигч” анги хамт олон /Бага, дунд, ахлах анги/
3. “Шилдэг багш” гэсэн төрлийн хүрээнд зохион байгуулсан.

Аяны хугацаанд 430 уншигч шинээр карт нээлгэж, нийт **10600** уншигчдад **11614**ширхэг ном олгож үйлчилсэн.

ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ / Бага анги /

1-р сургуулийн 4в ангийн сурагч Н.Хулан 107 ширхэг ном уншиж Тэргүүн байр, 3-р сургуулийн 3б ангийн сурагч А.Алтанбагана 103 ширхэг ном уншсан 1-р сургуулийн 5в ангийн сурагч Г.Номин-Эрдэнэ 96 ширхэг ном уншиж Гутгаар байр тус тус эзэллээ.

ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ / Дунд анги /

2-р сургуулийн ангийн сурагч Э.Наранханд 83 ширхэг ном уншиж Тэргүүн байр, 1-р сургуулийн 8а ангийн сурагч Т.Нургуль 64 ширхэг ном уншиж Дэд байр, 5-р сургуулийн 8б ангийн сурагч Ө.Мөнхзул 46 ширхэг ном уншиж Гутгаар байр тус тус эзэлсэн.

ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ / **Ахлах анги** /
Тэргүүн байр:1-р сургуулийн 10в ангийн сурагч Н.Золбоот
Дэд байр:1-р сургуулийн 10в ангийн сурагч Н.Сайнбуян
Гутгаар байр: 2-р сургуулийн 10а ангийн сурагч М.Ариунтуул нар байр эзэлж "ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ НАЦАГДОРЖ" тэмдэгээр шагнууллаа.

ТЭРГҮҮНИЙ УНШИГЧАНГИ ХАМТ ОЛОН"-оор
Бага насны ангилалд:
1-р сургуулийн Г.Анхтуяа багштай 5в анги **Дунд насны ангилалд:**
5-р сургуулийн Л.Хороллхагва багштай 8а анги **Ахлах насны ангилалд:**
1-р сургуулийн А.Уранчимэг багштай 10в анги тус тус эзэлсэн.

"**ШИЛДЭГ БАГШ**"-аар
1-р сургуулийн 5в ангийн багш Г.Анхтуяа

5-р сургуулийн 8а ангийн багш Л.Хороллхагва
1-р сургуулийн 10в ангийн багш А.Уранчимэг нар тус тус байр эзэллээ.

Дэлхийн зөн ОУБ хамтран ажиллаж буй “ӨСВӨРИЙН СЭТГҮҮЛЧ-НОМЫН САНЧ” клубнь 7 хоногийн Пүрэв гараг бүрийн 6 цагт 14 удаа хичээллэсэн.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн:
Тус ажлын хүрээнд Боржигин наадамтай холбогдуулан “**БОРЖИГИН ӨВ СОЁЛ”, ГОВЬСҮМБЭР 25 ЖИЛ**” цаг тооны бичигцаг тооллын бичиг, байгууллагын тэмдэг бүхий цэцгийн савыг хийсэн.

Болор цом наадмын тэргүүн байр эзэлсэн яруу найрагч, зохиолчдын намтар, түүх, уран бүтээлийг сурталчлантанилцуулга порсторт байрлуулан үзэсгэлэн гаргаж 14 хоног бүр зохиолчдоо сольж байршуулах ажил явагдаж байна.

НҮҮДЛИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

Иргэн төвтэй төрийн үйлчилгээ болон нүүдлийн номын сангийн үйлчилгээг Сүмбэр сумын 4 дугаар багийн 230 иргэнд шинэ номын үзэсгэлэн, санал хүсэлт хүлээн авах үйлчилгээ үзүүлсэн.

Нийгмийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөгөөр шинэ номын үзэсгэлэн, шинээр уншигчдад карт нээж, 2019 оны 1, 2 дугаар улиралд хийсэн ажлынхаа танилцуулгыг постерт байршуулан иргэд үйлчлүүлэгчдэд танилцуулсан. 262 иргэд, хүүхэд багачуудад үйлчилсэн.

72% ХЯМДРАЛТАЙ НОМЫН ХУДАЛДАА

Орон нутгийн иргэдэд номын худалдааг хүртээмжтэй хүргэх зорилгоор **72%** хямдралтай номын худалдааг 2019 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Нийтийн Номын Сангийн уншлагын танхимд “**АЗ ХУР** “ номын их дэлгүүртэй хамтран зохион байгуулсан. Нийт **115** төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, хувийн хэвшлүүдэд үйл ажиллагаа, зохион байгуулж буй ажлаа танилцуулан **1380** ширхэг хямдарсан номын үнийн жагсаалт бүхий сонинг албан тоотоор хүргэж баталгаажуулсан. Тус номын худалдаанд аймгийн иргэд уншигчид өргөнөөр оролцож нийт **1150** иргэд хамрагдсан.

Сургалт, Сурталчилгаа:

Нийт 18 сургалт, арга хэмжээнд оролцов.

1. Онцгой байдлын газраас зохион байгуулсан “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө” шинэчлэн боловсруулах зааварын сургалтанд Арга зүйч Д.Нарнай,Нярав, Архивч Ш.Түмэннаст
2. Орон нутгийн өмчийн газраас зохион байгуулсан “АЗ” сургалтанд Нягтлан бодогч Ц.Цогзолмаа
3. Ном Эрдэм 2 сарын аян, Дэлхийн номын өдөртэй холбогдуулан хүүхдүүдэд **"НОМЫГ БҮТЭЭЛЧЭЭР УНШУУЛАХ АРГА ЗҮЙ ЭЗЭМШҮҮЛЭХ"** сургалтыг ЕБС-ийн монгол хэл, уран зохиолын багш, бага ангийн багш, анги удирдсан багш, нийгмийн ажилтан, номын санч нарт зохион явууллаа. Нийт 140 багш сургалтанд хамрагдсан.

4. "ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ"-ийн хүрээнд төлөвлөлтийн талаар чадавхижуулах,мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх
5. Төрийн албан хаагчийн ёс зүй"

6. “Үйлчилгээний стандарт”сургалтыг байгууллагын албан хаагчдад Арга зүйч Д.Нарнай




7. Бүртгэл Мэдээллийн Номын Санч М.Аюушжав, Уншлага Үйлчилгээний Номын Санч А.Чимэгмаа, Б.Аасүрэн нар монгол бичгийн дунд болон Уран бичлэгийн анхан шатанд суралцаж байна.



8. Нэгдсэн эмнэлгийн арьс, харшилын эмч Э.Сарнай “Харшил гэж юу вэ?”

9. Эрүүл мэндийн газар мэргэжилтэн Д.Түвшинбат “Давсны хэрэглээ”
10. “Тамхины эсрэг”

11. АЗ-ын сургалт Нягтлан бодогч Ц.Цогзолмаа хамрагдсан.
12. Архивын тасгаас зохион байгуулсан “Архив, Албан хэрэг хөтлөлт”-ийн сургалтанд Бүртгэл Мэдээллийн Номын Санч, Нярав. Архивч хамрагдсан.
13. Дотоод аудит хяналтын сургалтанд Бүртгэл Мэдээллийн Номын Санч
14. УЗНАДээд сургуульд бакалаврын “Номын сан судлал” мэргэжилээр эчнээ ангид уншлага үйлчилгээний номын санч Б.Аасүрэн суралцаж төгссөн.
15. Цагдаагийн хэлтсээс “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”,
16. “Зөрчлийн тухай хууль”, “Авлига ашиг сонирхол”,

17. “Замын хөдөлгөөний дүрэм” сэдвээр

18. Угийн бичиг хөтлөлтийн сургалтыг албан хаагчдад зохион байгуулсан.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Төрөөс соёлын талаар баримтлах бодлого шийдвэрийг Аймаг, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, БСШУС-ын сайдтай Аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилтийг бүрэн биелүүлэх, номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, уншигчид бие даан боловсрол эзэмших, номын санг иргэд, оюутан сурагчдын мэдээллийн төв болгон хөгжүүлэхэд ном тойрсон соёл танин мэдэхүйн олон арван ажил, арга хэмжээг зохион байгуулж тэдгээрт оюутан сурагчид, иргэд, уншигчдын оролцоог нэмэгдүүлэхийн төлөө бүхий л ажлаа чиглүүлэн хамт олноо удирдан зохион байгуулж боломж бололцоо бүхний гаргалгааг олж номын сандаа таатай орчинг бүрдүүлэн иргэд уншигчдын талархалыг хүлээн амжилттай ажиллаж байна.

НЭГ. УДИРДЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТАЛААР.

Аймгийн Төв номын сан нь Номын сангийн тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Соёлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд, БСШУСЯам, орон нутгийн засаг захиргаа, нутгийн удирдлагын байгууллагуудаас дэвшүүлсэн зорилт, шийдвэрүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж БСШУС-ын яам, Үндэсний номын сан, номын сангуудын консорциум болон орон нутгийн удирдлагуудаас өгсөн үүрэг даалгавруудад хариуцлага санаачлагатай хандан хамтран ажиллаж ирэв.

Аймгийн төв номын сан нь 2019 онд 15 ажиллагсадтай, 2 салбар номын сантайгаар, орон нутгийн уншигч иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлж байна.

2019 онд манай жилийн төсөв ***200143300*** төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэл ***200143300*** төгрөг байна.

2019 оны 12-р сар

Утга	Төсөв	Гүйцэтгэл
Цалин хөлс	156 245 200	156 245 200
Нийгмийн даатгал	19 530 600	19 530 600
Байр ашиглалт	5 116 300	5 116 300
Хангамж бараа	4 165 300	4 165 300
Ном хэвлэл	3 140 700	3 140 700
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	4 242 500	4 242 500

- ✓ Өөрийн үйл ажиллагааны орлого жилд ***3 000 000*** төгрөг батлагдсанаас байгууллагын үйл ажиллагаанаас ***3 000 000*** төгрөг орлогод оруулж, 2019 оны жилийн орлогын төлөвлөгөөг 100 %-иар биелүүлэв.

- ✓ Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах үүднээс **“Шилэн дансны болон төсөв санхүүгийн ил тод байдал”** самбарыг цаасан болон цахим хэлбэрээр тогтмол ажиллуулж номын сангийн төсвийн нээлттэй байдлыг хანган ажиллаж байна.

- ✓ Төрийн байгууллагуудын нэгдсэн **Эйбл** программаас шаардлагатай мэдээ мэдээллийг тогтмол авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХОЁР. ФОНД, БҮРДҮҮЛЭЛТ, КАТАЛОГИ

Ном бүрдүүлэлтийг "Номын сангийн хууль" болон ном худалдан авах журмын дагуу татгалзал, уншигчийн судалгааг үндэслэн "Интерном", "Номинтав" трейд номын худалдаа, болон зохиолч уранд бүтээлчдийн хандив, тусламж зэргээр бүрдүүлж ирлээ.
2019 онд 8 208 802.60 төгрөгний 623 боть номыг хүлээн авч фондын баяжилтаа хийж
Ном хангамж -17.1 балл, Ном уншилт-18,6 балл, Фондын эргэлт -1,09 баллтай байна.

Ном бүрдүүлэлтээр шинэ ном худалдан авсан мэдээ

д/д	Ямар журмаар авсан	Нэр төрөл	Боть	Бүгд үнэ
1	Худалдаагаар		226	3734065
2	Хандив тусламж		397	4474737.60
	Нийт		**623**	**8 208 802.60**



Номын сангийн программ болон нэг бүрчилсэн бүртгэлд урд оны үлдэгдэлтэйгээ нийт 314 нэр төрлийн 449 боть номыг оруулан номын сангийн хөрөнгөнд бүртгэж авч бар коджууллаа.

Шинээр авсан 449 боть номны 38% нь уран зохиол ба уран илтгэхүйн ном, 11-14% нь Түүх нийгэм, технологийн шинжлэх ухааны ном, 0,042-5% нь Байгал, хэл, Философи, Шашин судлалын ном эзлэж байгаа бөгөөд 2019 онд салбар номын санд 121 боть ном, төв салбарт 209 боть ном, Ном гэрээр олгох тасагт 57 боть хувиарлагдан уншигч олны хэрэглээнд нийлүүлэгдсэн байна.
Архивын фондонд хадгалагдаж байгаа орос хэл дээрх номуудыг номын сангийн Lib4U программд шивж оруулах ажлын хэсгээс ***2600*** боть номыг фонднoос зөөвөрлөн тоосыг арчиж цэвэрлэж номын сангийн программд шивж оруулсан ба нэгбүрчилсэн бүртгэлд шинэчлэн бүртгэж байна. Программд оруулсан номонд бар код хэвлэн нааж ангилан фондонд байрлуулав.
“Аз хур” ХХК-тай хамтран 20-72 хувийн хямдралтай номын худалдаа зохион байгуулж зар сурталчилгааны сонинг захиргааны байгууллага болон Их дээд, ЕБСургууль, цэцэрлэг, үйлдвэр албан байгууллага, ААН, нийт 49 байгууллагад 1000 гаруй сонинг номын санч Т.Тамир, С.Нэргүй нар тарааж номын худалдааны ажилд өөрсдийн хувь нэмрээ оруулав. Энэхүү худалдаанаас 552.368 төгрөгний 23 нэр төрлийн 46 боть номын худалдан авалт хийж номын фонд бүрдүүлэлт хийлээ.

2018 оны сүүлийн хагас, 2019 оны эхний хагас жилийн хэвлэл “Дарханы мэдээ”, “Хүмүүн бичиг”, “Засгийн газрын мэдээ”, “Зууны мэдээ”, “Өдрийн сонин”, “Өнөөдөр” сонингуудыг үдэж 29 багц болгон хавтаслан номын сангийн тогтмол хэвлэлийн дансанд дансаллаа.
2019 онд ***603.800 төгрөгний 11*** нэр төрлийн сонин, сэтгүүлийн хэвлэл захиаллаа.
2018 онд захиалсан 4 дугаарын Номын санч сэтгүүл мөн Цог сэтгүүлүүд нь уншигчдын гар дээр ирээгүй тул Монгол шуудан компаны санхүүгийн албанд шүүлт хийлгэж эдгээр ирээгүй сэтгүүлүүдийн оронд 66500 төгрөгний 3 нэр төрлийн 5 боть номыг захиалан авч фонд бүрдүүлэлт хийлээ.

- ✓ Олон хувьтай эргэлтэнд бага гардаг **1163 боть** номыг **у**ншлагын танхимын фондны данснаас хасаж, архивын фондны дансанд шилжүүлэн бар код болон бусад техник ажиллагааг хийж үндсэн фондонд шилжүүлэв.

Ном сэлбэн засалт:

- ✓ Нийт 115 боть номыг сэлбэн засч уншигч хэрэглэгчдийн хэрэгцээг хангаан ажиллаа. 67 нэр төрлийн номны урагдсан, салсан, нуруу салсан зэргийг засварлаж уншлагын танхимын фондонд хүлээлгэн өглөө.

ГУРАВ. УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ:

2019 онд байнгын уншигч-3800, ирц-60000, ном олголт-65000 төлөвлөснөөс 3823 байнгын уншигч, 62806 ирэгсдэд, 71744 боть ном олгож, уншлага үйлчилгээний төлөвлөгөөг 101%-110%-иар давуулан биелүүлж ирлээ.
Аймгийн Төв номын сан нь уншлага үйлчилгээндээ ном хэвлэлээ тогтмол сурталчилж, шинэ номын жагсаалт гаргах, ном хэвлэлийн тойм, ашигтай зөвлөмж материалуудыг хувилах, онлайн хэлбэрт байршуулах, мэдээллийг түгээх зэргээр уншигчдын эрэлт хэрэгцээг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Ажил үйлчилгээ	*Төлөвлөгөө*	*Гүйцэтгэл*	*Хувь*
Уншигч	3 800	3 823	101%
ирц	60 000	62 806	105%

Ном олголт	65 000	71 744	110%
орлого	3 000 000	3 000 000	100%

Уншлага үйлчилгээний нэгж тасгийн номын санчдын төлөвлөгөөт ажлыг тус бүрээр нь харуулбал:

Д/д	Номын санчид	Уншигч			Ирэгсэд			Ном олголт		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Ц.Долгорсүрэн	950	**1086**	114%	15000	**17360**	116%	16250	**21125**	130%
2	Н.Норжмаа	950	**1051**	110%	15000	**18127**	120%	16250	**20631**	127%
3	Да.Сарантуяа	950	**858**	90%	15000	**13685**	91%	16250	**13716**	84%
4	П.Булгамаа	950	**831**	87%	15000	**13634**	90%	16250	**16272**	100%
	Нийт	3800	**3823**	101,%	60000	**62806**	105%	65000	**71744**	110%

Гэрээр ном олголт:

Өндөр настан, номын санд суух боломжгүй нийт 503 уншигчдад 1099 боть номыг гэрээр олгож үйлчлэв.

Зөөврийн номын сан: Нийт ***18 удаа 1480 уншигчдад 1550 боть ном*** олгож, соёл танин мэдэхүйн ажлыг ***8 удаа*** зохион байгуулж, ***1600 хүн*** оролцлоо.

Энэ ажлын хүрээнд Онцгой байдлын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, ШШГА-ын харъяа хаалттай хорих анги, “Шинэ алхам” дунд сургууль, ХИС-ийн номын сан, 15-р сургуулийн Мөнхсүрэн багштай 4^{А} анги, 18-р цэцэрлэгийн “Баавгай” зөөврийн номын сан, 13-р цэцэрлэг зэрэгт хүрч үйлчлэв.

Урилгат уншлага: **10 удаа 1129 сурагчид хамрагдлаа.**

- 16-р сургуулийн 40 сурагч, Од цогцолбор сургуулийн 6-8-р ангийн 5 бүлэг, Энэрэл цогцолбор, ОИЦ-ын 12-1, Монгол-Оюу сургуулийн 9-1, 15-р сургуулийн 12^{а}, 4-р сургуулийн 12$^{-р}$ ангиуд, СӨББ-ийн 13, 15, 16, 18-р цэцэрлэгийн хүүхэд багачуудад үнэгүй карт нээж номын сангийн уншигчаар бүртгэн авлаа.

Номын сантай танилцах аялалаар ирсэн 7, 10, 21, 13-р цэцэрлэгийн хүүхдүүд, 9, 16, “Монгол-Оюу”, “Шинэ алхам” сургуулийн бага ангийн сурагчдад “Сургамжит өгүүллэг”, “Цүндээлэй”, “Охидын аминчхан яриа”, “Монголоо таниулъя”, “Цэцэн хулганы үлгэр”, “Бяцхан дүү минь” “Бэлэн амт хулгана” гэх мэт номуудаар СӨББ-ын болон ЕБС-ийн бага ангийн 800 гаруй хүүхдэд чанга уншлагыг 12 удаа зохион байгуулав.

СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ

- ✓ 2019 онд Уншигчдын бага хурал-1 удаа 120 хүн,
- ✓ Өдөрлөг - 11 удаа 2763 уншигч,
- ✓ Уралдаан - 4 удаа 220 гаруй иргэд,
- ✓ Лекц -14 удаа 2230 гаруй хүмүүжигчид, оюутан, сурагчид
- ✓ Сургалт 10 байгууллагад - 11 удаа 1000 хүн,
- ✓ Эчнээ уншигчдын бага хурал - 5 удаа 250 хүн тус тус оролцож

нийт 46 удаа СТМА-уудыг зохион байгуулан ***6583*** ажилтан албан хаагчид, иргэд, хүүхэд, залуусыг хамрууллаа.

а/Уншигчдийн бага хурал-1 удаа
Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд Аймгийн ЗДТГ, Төв номын сан, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Гал голомт үндэсний хөдөлгөөний Дархан-Уул аймгийн салбар хүрээ хамтран “Гал голомт” үндэсний хөдөлгөөний тэргүүн, эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан Д.Мөнхөө нарын эмхтгэсэн ***“Монгол гэр бүлийн ширээний ном”***-ыг төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтан, албан хаагчид, иргэдэд уншиж судлуулан, түгээн дэлгэрүүлж, харилцан бие биенээсээ суралцах, тэдэнд гэр бүлийн харилцаа соёл, эрүүл мэнд, эрхзүйн мэдлэг олгох зорилгоор уншигчдын бага хурлыг зохион байгууллаа.
Уншигчдын бага хуралд Аймаг, сумын харъяа төрийн болон төрийн бус байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийн дарга, гишүүд, их, дээд, ЕБС-иудын нийгмийн ажилтан, номын санчид, иргэдийн төлөөлөл оролцсон бөгөөд “Монгол гэр бүлийн ширээний ном”-ны “Гэр бүл-нийгмийн анхдагч орчин”, “Гэр бүл-нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Монголын дэвшилтэд соёл, уламжлал, ёс заншил ба орчин үе”, “Гэр бүл эрүүл амьдралын анхдагч орчин болох нь”, “Ахмад гэр бүл ба ач санах ухаан” зэрэг бүлгүүдээр илтгэлүүд тавигдаж 120 гаруй хүн хамрагдлаа.

Аймгийн ЗДТГ-ын дарга Ч.Энхбат “Уншигчдын бага хурал”-ыг нээж үг хэлэв.

“Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд “Гал голомт” үндэсний хөдөлгөөний тэргүүн, эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан Д.Мөнхөө нарын эмхтгэсэн ***“Монгол гэр бүлийн ширээний ном”***-оор хийсэн уншигчдын бага хуралд Аймгийн ЗДТГ-ын дарга Ч.Энхбат, НБХ-ийн дарга Н.Цасчихэр, Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Тунгалаг-Эрдэнэ нар оролцов.

б/ Лекц: 14 удаа нийт 2230 оюутан, сурагчид оролцов.

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Монголын үг урлаачдын нийгэмлэгийн лектор Г.Баньдцэрэн “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ?”, ГБХЗХГ-ын Залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Гантулга нараар “Өөрийгөө хөгжүүлье”, “Хувь хүний хөгжил”, “Хөгжлийн гараа” сэдвүүдээр ИДС, ЕБС-ийн оюутан сурагчдад лекц уншуулав.

Ахлах номын санч Г.Нямцэнд “Болгар дахь Америкийн их сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр”, “Жендэр гэж юу вэ”, “Жендэрийн судалгаа” сэдвээр Хаалттай хорих 435 ангийн албан хаагчид, Сэлэнгэ аймгийн Сант сумын соёлын төв, Цагдаагийн газар, Од цогцолбор сургуулиуд дээр лекц, Дархан-Уул аймаг дахь Гаалийн газраас зарласан “Хар тамхи, мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодистой холбоотой тулгамдсан зарим асуудлуудыг шийдвэрлэх арга зам” сэдэвт онол практикийн бага хуралд “Мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах” зэрэг сэдвүүдээр Аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд илтгэл тавив.

УБ хотын Боловсролын Зөвлөгөө мэдээллийн төвийн хөтөлбөрийн зохицуулагч Ц.Одончимэг, Г.Уранжаргал, Болгарын их сургуулийн төгсөгч Т.Маргад нараар Литвийн ОУ-ын сургууль, Оросын HSE, Америкийн Tiffin их сургууль, сурагч солилцоо, Болгар дахь Америкийн их сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр сэдвээр ОИЦ, 1, 19, 21-р сургууль, ШУТИС-ийн лицей, Монгол оюу, Дархан дээд сургуулиудад 8 удаа лекц уншуулж 550 гаруй багш, сурагчид хамрагдлаа.
ХГБЗХГ-ын мэргэжилтэн А.Мягмаржаргалаар "Хандлага, харилцаа-хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга" сэдэвт лекцийг ШШГГ-ын Хаалттай хорих 435-р ангийн 130 хүмүүжигчдэд уншуулж хамтран ажиллав.

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Гантулга "ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ" лекц хийв

ГБХЗХГ-ын мэргэжилтэн А.Мягмаржаргал "Хандлага харилцаа-Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга" сургалтын үеэр

Өдөрлөг:- Нийт 11 удаа, 2763 хүнийг хамруулсан байна

"Ном" аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн иргэдийг номын сангийн үйлчилгээнд хамруулах, үйлдвэр аж ахуйн ажилтан албан хаагчид, оюутан, сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүдэд ажлын байранд хүрч үйлчлэх, тэднийг номтой нөхөрлүүлэн оюуны хэрэгцээг хангахад зориулан "Оюунлаг Дарханчууд" өдөрлөгийг зохион явуулж байна. Өдөрлөгөөр Залуу хүний заавал унших номын үзэсгэлэн, "15 минутын уншлага", Электрон каталогоос номоо хэрхэн олох вэ?, "Угийн бичгийг хэрхэн хөтлөх, мэдээлэл хайх арга" сэдвээр лекц, урлагийн номер зэргийг үзүүлэн уншигч хэрэглэгчдэд ном болон номын сангаа сурталчилж дараахь байгууллагууд дээр хүрч ажиллав. Үүнд:

- "Номын сан-Цэцэрлэгт" өдөрлөгийг 10, 13, 21-р цэцэрлэгүүдэд,

- Дэлхийн номын өдрийг тохиолдуулан “Дарханы ирээдүй” сэдэвт өдөрлөгийг JCI Найрамдал салбар байгууллага, ОУБХСангийн Дархан дахь салбар, Залуучууд театртай хамтран зохион байгуулж их дээд сургууль болон ЕБС-ийн нийт 400 гаруй оюутан сурагчид оролцлоо.
- “Номтой өдөр” өдөрлөгийг Дархан өргөө-Политехникийн коллежи дээр хийж 50 гаруй оюутан хамрагдав.
- Гэр бүлийн жилтэй холбогдуулан ШШГЕГ-ын харъяа Хаалттай 435-р ангид “Хүн явахын учир” өдөрлөгийг Залуучууд театртай хамтран зохион байгуулж нийт 130 алба хаагч, хүмүүжигчид оролцлоо. Өдөрлөгт Залуучууд театрын дэргэдэх Хишигсүрэн багштай Дионес агентлагын хүүхдүүд, Залуучууд театрын уран бүтээлчид, ГБХЗГ-ийн мэргэжилтнүүд хамтран ажиллав.
- “Номтой өдөр” өдөрлөгийг Сэлэнгэ аймгийн Сант сумын номын сантай хамтарч зохион байгууллаа.

“Залуучууд” театрын уран бүтээлчид уран бүтээлээсээ толиллуулав.

к ном”-ын үзэсгэлэн

Уралдаан: 4 удаа, 220 гаруй иргэд оролцов.

“Монгол бичгээр хэн хурдан унших вэ?” уралдааныг ЕБС-ийн сурагчдын дунд, “Ухаарахуй” эссэ бичлэгийн уралдааныг ШШГГазрын харъяа Хаалттай хорих 435-р ангид зэрэг байгууллагууд дээр зохион байгуулсан ба “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд Аймгийн ЗДТГ-тай хамтран “Шилдэг уншигч-гэр бүл шалгаруулах” уралдааныг зохион байгуулан өндөр настан уншигч П.Бадамханд, Н.Сүхбаатар, М.Лхагваа, Б.Самдан, багш Ж.Эрхэмсайхан, оюутан Б.Долзодмаа, сурагч Э.Мишээл нар Аймгийн “Шилдэг уншигч-гэр бүл”, “Шилдэг уншигч”-аар шалгарч, өргөмжлөл хадгалуулж номын багцаар шагнан урамшуулав.

- “Дөрвөн бэрх” тэмцээнийг Соёлын байгууллагын ажилчдын дунд зохион байгуулж явууллаа. Тэмцээнд Залуучууд театр, Биеийн тамир спортын газар, сэтгүүлчид Төв номын сан гэсэн 4 баг оролцсоноос Биеийн тамир спортын газрын “Тэмээчин баг”1-р байранд, Залуучууд театрын “Ямаачин баг” 2-р байранд, Сэтгүүлчдийн “Хоньчин баг” 3-р байранд тусгай байранд Төв номын сангийн “Адуучин баг” тус тус

шалгарч монгол уламжлалт зан заншил, тоглоом наадгайг сурталчилсан ажил боллоо. Нийт 60 хүн оролцов.

Үндэсний бичиг үсгийн баяр-2019: Жил бүрийн тавдугаар сарын эхний ням гарагийг үндэсний бичиг үсгийн баяр болгон тэмдэглэх тухай 2003 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн 105-р зарлиг, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-2”, Аймгийн монгол хэл бичгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын өдрийг тохиолдуулан Үндэсний бичиг үсэгт суралцагсдын хэрэглээг нэмэгдүүлэх, уран бичлэгийн ур чадварыг дээшлүүлэх, тэдний бүтээлийг сурталчлах, дэмжих, туршлага солилцох зорилгоор Аймгийн Төв номын сан нь “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын арга хэмжээг 2019 оны 05 дугаар сарын 05-08-ны өдрүүдэд уран бичлэг, уран уншлага, уран бичвэрийн бүтээл, бичвэрийн бус бүтээл зэрэг төрлөөр зохион байгууллаа.



"Бичвэрийн бүтээл" болон "Бичвэрийн бус бүтээл"

Мэргэжил аргазүйн сургалтын талаар: Жилдээ 27 байгууллагад 14 удаа нийт 1207 албан хаагчид, номын санчид оролцов.

Аргазүйн сургалтыг 2 удаа 143 номын санчдад ном ангилах, данслах, номын сан-номзүй, электрон болон цаасан каталоги, номонд техник ажиллагаа хийх, номын сангаас зохиох соёл танин мэдэхүйн ажил сэдвүүдээр ЕБС, Сумдын номын санчдын дунд сургалт зохион байгууллаа.
БСШУС-ын Яамны 5,0 сая төгрөгний санхүүжилтээр Төвийн бүсийн нийтийн номын сангуудын номын санчдын дунд ***"Хамтдаа хөгжье"*** илтгэл, урлаг уран сайхны нэгдсэн арга хэмжээг зохион байгууллаа.
Тус арга хэмжээнд манай урилгаар БСШУС-ын яамны Соёл Урлагийн Бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Б.Сэргэлэн, яамны мэргэжилтэн Б.Баяраа, МҮНС-ийн мэргэжил арга зүйн эрдэм шинжилгээний хэлтсийн дарга Д.Энхтунгалаг, СУИС-ын багш Т.Хайдав, Монголын номын сангуудын консорциумын гүйцэтгэх захирал Ч.Мөнх-Эрдэнэ, Аймгийн ЗДТГ-ын орлогч дарга Т.Ганболд, БСУГ-ын мэргэжилтэн Г.Нарангэрэл, аймгийн Хүүхдийн номын ордон, Их дээд сургууль, ЕБС-иудын номын санчид, Булган, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн нийтийн номын сангийн номын санчид оролцов.
Нийтийн номын сангийн номын санчдын дунд "Номын санчийн хөгжил", "Номын сангаа хамтдаа хөгжүүлье", "Номын сан ба номын санчийн хөгжил", "Монголын номын сангийн автоматжуулалтын хөгжлийн асуудал" сэдвээр илтгэлүүд, урлаг, соёл танин мэдэхүйн ажил гэсэн төрлөөр уралдаж Булган, Орхон, Сэлэнгэ аймгийн номын сангууд шалгарч мөнгөн шагнал, батламж гардан авлаа.
БСШУС-ын Яамны шагнал МУСТА цол тэмдэг, "Жуух бичиг", МНСК-аас "Шилдэг номын санч" тэмдгээр номын санчдыг шагнаж урамшууллаа.
Аргазүйн зөвлөгөөг ЕБС-ийн 1, 4, 8, 14, 15, 16, 18, 21, Од-1, 2, ОИЦ-1 -р сургуулиудын номын санчид, Орхон сумын Соёлын төвийн номын санч, ХУИС, АУСургууль, Нээлттэй хорих 435 ангийн номын сан, Дархан Политехникийн коллеж, Шинэ монгол сургуулийн номын санчид 17 байгууллагын 40 номын санчдыг Төв номын сангийн фонд, катологи, номын бүртгэлүүдтэй танилцуулан аргазүйн зөвлөгөө өглөө.
Салбар номын сангийн мэдээллийн самбарт Мэргэжил аргазүй, Бидний ажил, Шинэ ном, Танин мэдэхүй, Тэргүүний уншигч, Шилдэг ном сэдвүүдээр мэдээ мэдээлэл, Номын санчдын соёл танин мэдэхүйн ажлын хуваарь, Сар бүрийн 17-нд зохиодог Ном солилцох өдрүүдийг хариуцах номын санчдын хуваарь хийж мэдээллийн самбарт байрлуулав.
Номын санчдын 2019 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө, орон нутгийн номын сангуудад арга зүйн зөвлөгөөний хуваарийг хийлээ.
"Угийн бичиг хөтлөх арга", "Жендэрийн талаарх ойлголт, хандлага" сэдэвт сургалтыг ***10*** байгууллагад давхардсан тоогоор ***11 удаа 1063*** төрийн албан хаагчдад Дархан сумын ЗДТГ, Дархан-Уул аймгийн НД-ын хэлтэс, Татварын хэлтэс, ДДЦС, ДСЦТС, ШШГЕГ-ын харъяа Хаалттай 435-р хорих анги, "Дархан ус суваг ТӨХК-ны ажилтан, албан хаагчид харилцан ярилцаж, сургалтад идэвхтэй хамрагдав.



Сургалт зохион байгуулж байгаа нь



Сургалтын явц *Сургалтын дараа*

Дархан-Уул аймгийн татварын хэлтсийн албан хаагчдад “Жендэрийн талаарх ойлголт, хандлага”-ын талаар хийсэн сургалт /2019.10.23/

"Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг угтан Дархан-Уул аймгийн Соёл урлагийн байгууллагуудын ажилтан албан хаагчдын дунд "Монгол хэлний зөв бичих дүрэм", "Угийн бичиг хөтлөх", "Номын сан", "Хувь хүний хөгжил" зэрэг сэдвийн сургалтуудад 100 гаруй ажилтан албан хаагчид оролцов.

“Монгол хэлний зөв бичих дүрэм” лекц 30-р сургуулийн сургалтын менежер Ж.Эрхэмсайхан

“Угийн бичиг хөтлөх” лекцийг төв номын сангийн ахлах номын санч Г.Нямцэнд

“Хувь хүний хөгжил” лекцийг Аймгийн ҮЭ-ийн холбооны сургагч багш Д.Мэнхбаяр

Соёл урлагийн байгууллагуудын нийт уран бүтээлчид

<u>Боловсон хүчнийг чадавхжуулах сургалт:</u>

25 удаагийн сургалтанд давхардсан тоогоор **42** албан хаагч хамрагдав.

<u>Захирал Д.Цэрэндаваа:</u>

1. “Соёл, урлагийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлэлт, нэмэгдүүлэх арга зам” сэдэвт сургалтанд /Улаанбаатар хот ЗГ-ын 2-р байр.2019.12.09/,

2. “Соёл, урлагийн байгууллагын тогтвортой хөгжил- удирдахуйн шинэлэг хандлага-3” сургалт / БСШУС-ын Яам УБ хот.2019.06.17-19/

3. “Монгол гэр бүлийн өнөөгийн нөхцөл байдал, асуудал, үйлчилгээний хэрэгцээ” сэдэвт сургалт,

4. Аймгийн хэлэлцүүлэг: “Сонгодог урлагийг хөгжүүлэх”, “Соёлын биет бус өвийг хамгаалах” тухай бодлогын баримт бичгийн төсөлд “Сонгодог урлаг 3”, “Соёлын биет бус өвийг хамгаалах” аймгийн дэд хөтөлбөрүүдийн төсөлд санал оруулах хэлэлцүүлэгт

<u>Нябо Б.Даваадолгор</u>

1. Удирдлагын Академийн “Төрийн удирдлага” нэг жилийн сургалт

2. Худалдан авах ажиллагааны тайлан төлөвлөгөөний сургалт

3. Дархан-Уул аймаг 2019 оныг Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил болгон олон ажлыг санаачлан хэрэгжүүлэв. Энэ ажлын хүрээнд 2019.05.17-ны өдрийн “Зөв тусгал” уриан дор зохион байгуулсан эцэг эхийн анхдугаар зөвлөгөөнд,

4. Аймгийн хэлэлцүүлэг: “Сонгодог урлагийг хөгжүүлэх”, “Соёлын биет бус өвийг хамгаалах” тухай бодлогын баримт бичгийн төсөлд “Сонгодог урлаг 3”, “Соёлын

биет бус өвийг хамгаалах” аймгийн дэд хөтөлбөрүүдийн төсөлд санал оруулах хэлэлцүүлэгт

Ахлах номын санч, захиргаа аж ахуйн нэгж тасгийн дарга Г.Нямцэнд:

1. “Соёл, урлагийн байгууллагын тогтвортой хөгжил- удирдахуйн шинэлэг хандлага-3” сургалт / БСШУС-ын Яам УБ хот. 2019.06.17-18/

2. Албан тушаалын тодорхойлолт боловсруулахад анхаарах асуудал /ТАЗөвлөлөөс/

3. “Монгол гэр бүлийн өнөөгийн нөхцөл байдал, асуудал, үйлчилгээний хэрэгцээ” сэдэвт сургалт,

4. Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхолын зөрчил, түүнийг зохицуулах хэрэгцээ, үндсэн механизм” сэдэвт сургалт /Аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд/

5. 10 дугаар сарын 15-наас 16-ны өдрүүдэд "Иргэнд чиглэсэн төрийн үйлчилгээ" сэдэвт сургалт

6. “Зөв бичих дүрэм”-ын сургалтыг хэл шинжлэлийн ухааны магистр Ж.Эрхэмсайхан,

7. ”Харилцаа хандлага” Аймгийн ҮЭХ-ны сургагч багш Д.Мэндбаяр

8. Жендэрийн үндэсний хорооноос жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Үндэсний хөтөлбөрийг танилцуулах, хуулийн хэрэгжилтийг орон нутгийн дэд хөтөлбөрөөр дэмжих, төрийн албан хаагчдын чадавхыг дээшлүүлэх зорилгоор бүсийн сургалт, семинар Дархан-Уул аймагт Зүүн 12 аймаг харилцан туршлага солилцох сургалтанд БСУГ-ыг төлөөлж ахлах номын санч Г.Нямцэнд 2 өдрийн сургалтанд сууж 2018-2019 онд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэл”-ээр хийсэн ажлынхаа тайланг тавьж, сайн туршлагаа хуваалцлаа,

9. Аймгийн хэлэлцүүлэг: “Сонгодог урлагийг хөгжүүлэх”, “Соёлын биет бус өвийг хамгаалах” тухай бодлогын баримт бичгийн төсөлд “Сонгодог урлаг 3”, “Соёлын биет бус өвийг хамгаалах” аймгийн дэд хөтөлбөрүүдийн төсөлд санал оруулах хэлэлцүүлэг

Аргазүйч Мэргэжил аргазүйн нэгж тасгийн дарга Дя.Сарантуяа:

1. Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхолын зөрчил, түүнийг зохицуулах хэрэгцээ, үндсэн механизм” сэдэвт,

2. Албан тушаалын тодорхойлолт боловсруулахад анхаарах асуудал /ТАЗөвлөлөөс/

3. МҮНС-аас “Нийтийн номын сан аргазүйн төв болох нь” 1 өдрийн сургалт /УБ хот/

Уншлага үйлчилгээний нэгж тасгийн дарга Ц.Долгорсүрэн:

1. Албан тушаалын тодорхойлолт боловсруулахад анхаарах асуудал /ТАЗөвлөлөөс/

2. Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхолын зөрчил, түүнийг зохицуулах хэрэгцээ, үндсэн механизм” сэдэвт

3. “Монгол гэр бүлийн өнөөгийн нөхцөл байдал, асуудал, үйлчилгээний хэрэгцээ” сэдэвт сургалт

4. СУИС-аас зохион байгуулсан “Зохиогчийн эрх ба номын сангийн үйлчилгээ” сэдэв сургалтанд,

5. Аймгийн ҮЭХ-ны сургагч багш Д.Мэндбаярын сургалт

Номзүйч Н.Солонго

1. Дархан-Уул аймгийн ҮЭ-ийн холбооноос зохион байгуулсан “Хөдөлмөрийн харилцаа- ҮЭ-ийн оролцоо ” сургалт,

2. СУИС-аас зохион байгуулсан “Зохиогчийн эрх ба номын сангийн үйлчилгээ” сэдэв сургалтанд,

3. Аймгийн ҮЭХ-ны сургагч багш Д.Мэндбаярын сургалт

Сан хөмрөгч мэдээллийн ажилтан Н.Норжмаа:

1. СУИС-ийн Соёлын сургуулийн “Номын сан-Мэдээлэл зүйн” бакалаврийн ангид

2. СУИС-аас зохион байгуулсан “Зохиогчийн эрх ба номын сангийн үйлчилгээ” сэдэв сургалтанд

3. Дархан-Уул аймаг 2019 оныг Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил болгон олон ажлыг санаачлан хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд 2019.05.17-ны өдрийн “Зөв тусгал” уриан дор эцэг эхийн анхдугаар зөвлөгөөнд,

4. Аймгийн ҮЭХ-ны сургагч багш Д.Мэндбаярын сургалт

Сан хөмрөгч мэдээллийн ажилтан С.Нэргүй

1. Хүмүүлэгийн их сургуулийн харьяа Эрдэм их Сургуулийн “Соёл судлал”-ын магистр

2. Аймгийн ҮЭХ-ны сургагч багш Д.Мэндбаярын сургалт

Сүлжээний инженер Х.Отгонбаяр

1. Турк улсын Анкара хотод зохион байгуулагдсан “Update people” буюу нийгмийн болон хүмүүсийн шинэчлэл заах арга зүйг сайжруулах 8 хоногийн сургалт

Ном сэлбэн засагч, номын санч, архив, бичиг хэргийн ажилтан С.Энхцэцэг

1. “Төрийн архивын баримтад иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийх, данс, бүртгэл үйлдэх ажлын арга зүй”-н 3 хоногийн сургалт,
2. “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хэрэг бүрдүүллэх, баримтад эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх ажлын арга зүй” сэдэвт 2 хоногийн сургалт,
3. СУИС-аас зохион байгуулсан “Зохиогчийн эрх ба номын сангийн үйлчилгээ” сэдэв сургалт
4. Соёл урлагийн байгууллагуудын ажилтан албан хаагчдын дунд "Монгол хэлний зөв бичих дүрэм", "Угийн бичиг хөтлөх", "Номын сан", "Хувь хүний хөгжил" зэрэг сэдвийн сургалт, 2019.05.17-ны өдөр “Зөв тусгал” уриан дор эцэг эхийн анхдугаар зөвлөгөөнд оролцсон байна.

5. Дархан-Уул аймаг 2019 оныг Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил болгон олон ажлыг санаачлан хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд 2019.05.17-ны өдрийн “Зөв тусгал” уриан дор эцэг эхийн анхдугаар зөвлөгөөнд
6. Аймгийн ҮЭХ-ны сургагч багш Д.Мэндбаярын сургалт
7. Аймгийн хэлэлцүүлэг: “Сонгодог урлагийг хөгжүүлэх”, “Соёлын биет бус өвийг хамгаалах” тухай бодлогын баримт бичгийн төсөлд “Сонгодог урлаг 3”, “Соёлын биет бус өвийг хамгаалах” аймгийн дэд хөтөлбөрүүдийн төсөлд санал оруулах хэлэлцүүлэгт

УБ хотод зохион байгуулагдсан “Төрийн архивын баримтад иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийх, данс, бүртгэл үйлдэх ажлын арга зүй” сэдэвт 3 хоногийн сургалт, “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хэрэг бүрдүүллэх, баримтад эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх ажлын арга зүй” сэдэвт 2 хоногийн сургалтанд бичиг хэрэг, архивын ажилтан С.Энхцэцэг сургалтанд сууж Батламж гардан авлаа.





Үйлчилгээний ажилтан Д.Буянжаргал

1. СУИС-ийн Соёлын сургуулийн “Номын сан-мэдээлэл зүйн” ангид баклаварын зэрэгт суралцаж байна.

ЗУРГАА. Лавлагаа-Номзүйн ажил:

Дархан хот, Дархан-Уул аймагт ажиллаж амьдарч байсан, одоо амьдарч буй зохиолч уран бүтээлчдийн бүтээлээр номзүйч Н.Солонго “Орон нутгийн номзүйн бүртгэл”-ийг эмхэтгэн хэвлүүллээ. Энэхүү бүртгэл нь 494 зохиолчийн 4561 уран бүтээл орсон 3 бүлэг, 382 хэвлэлийн хуудас бүхий номыг Мөнхийн үсэг хэвлэлийн газарт шилжүүлэн өгч 300 хувь хэвлэн гаргаж, БСШУС-ын Яам, МҮНСан, УБ хотын Төв номын сан, Хүүхдийн Төв номын сан, 21 аймгийн нийтийн номын сангуудад төлбөргүйгээр түгээгээд байна.



Номзүйч Н.Солонго шинэ номзүйн бүтээлээ хүлээн авч буй байдал

“Найрамдлын Дархан” сонины 1987-1988 оны 192 дугаараас хайлт хийж бичгийн лавлагааг 1 хүнд хийж өгсөн ба “Цог” сэтгүүлийн 2009, 2017, 2018 оны 159 мэдээ, Дархан таймс 2018 оны 01-р сараас 11-р сар хүртэл 76 мэдээг лавлагаа номзүйн Zetoro программд оруууллаа.

Шинэ номын мэдээг 6 удаа 291 боть номоор агууллагын тайлбартайгаар бэлтгэн хэвлэж уншигч хэрэглэгчдийн хэрэгцээнд гаргаж шинэ номоо сурталчилан ажиллаа.

Лавлагаа:

- ✓ Амаар болон бичгээр 500 гаруй лавлагаа өглөө.

Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн:

Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг ***61 удаа***, ***2481 боть*** номоор гаргаж сурталчилсан байна. Түүхт ой, тэмдэглэлт өдрүүдээр 51 удаа 2152 боть номоор, шинэ номын үзэсгэлэнг 10 удаа 329 боть номоор тус тус гаргаж уншигчдийн хүртээл болголоо.

✓ “Орон орны шинэ жил”, “Монголын цагаан сар” 40 боть ном, “Эх хэл минү” 32 боть ном, “Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт” 38 боть ном, Монголын зэвсэгт хүчин 98 жил” 43 боть номоор, “Дэлхийн яруу найрагчидийн өдөрт” сэдэвчилсэн үзэсгэлэн 50 боть номоор, “Номын сан цэцэрлэгт” сэдэвчилсэн үзэсгэлэн 115 боть номоор, Залуу хүний заавал унших ном 38 боть номоор, “Угийн бичиг хөтлөхөд тусламж” 23 боть ном, Залуу хүний заавал унших ном 38 боть , Монгол зан заншил сэдэвт 45 боть ном, Монголын уламжлалт цагаан сар- 2 удаа 80 боть ном, Эх орончдын өдөрт 38 боть номоор, ОУ-ын эмэгтэйчүүдийн баярын өдөрт 73 боть ном, “Цэргийн баярт” 2 удаа 69 боть номоор, Усны өдөр 32 боть, “Наурыз” –н баярыг тохиолдуулан 28 боть, Инээдмийн баярт-38 боть номоор, 10 ,21,13-р цэцэрлэгт 240 боть хүүхдийн үлгэрийн номоор, Инээдмийн баярт-38 боть номоор, Сансар судлалын өдөрт-33 боть ном, Дэлхийн номын өдөрт-45, Дэлхийн сонгодог зохиолоос 63, Байгаль хамгаалах өдөрт -36 боть номоор, Залуу хүний заавал унших ном-50 боть номоор, Байгаль хамгаалах өдөрт-33 боть ном, Үндэсний бичиг үсгийн баярт-30 боть номуудаар тус тус сэдэвчилсэн номын үзэсгэлэнг нийт 29 удаа 1388 боть номоор гаргаж, номоо сурталчлан ажиллав.

Эчнээ уншигчдын материал: **5** удаа бэлтгэж 6 байгууллага, 250 хүнд сурталчилав.

- ✓ "Монголын уламжлалт цагаан сар" сэдэвт уншигчдын бага хурлын материал бэлтгэж уншигчдад танилцууллаа.

Татгалзлал: *60 боть ном*

Номын санд байхгүй уншигчдын хэрэгцээг хангаагүй 60 боть номыг татгалзалд бүртгэж номын захиалгад оруулаад байна. Үүнд: Пүрэвдоржийн "Багшлахуй менежмент", "Вангийн нулимс" 1,2-р боть, "Хуурай мацагийн тухай", "Даатгалын менежмент", "Даатгалын бүртгэл", "Бодол биелэлээ олдог", "Чамтай учирснаас хойш", "Чамтай учрахаас өмнө", "Бүсгүй минь нүүрээ...", "Тоймжиргүй амьдрах бяцхан урлаг", "Боловсрол судлалын ерөнхий үндэс", "Багш боловсролын үндэс", "Сурган хүмүүжүүлэх үндэс", "Багшлахуй менежмент", "Судалгаа хийх арга зүй", "Гүүрэнд хүрэх зам", "Өглөөний гайхамшиг", "СӨБ-ийн менежмент", "Гэр бүлийн сэтгэл судлал" гэх мэт номуудыг татгалзалд бүртгэж номын захиалгад оруулаад байна.

Мэдээлэл-технологи

Манай электрон каталогт одоогоор ***19394*** нэр төрлийн ***46144*** ширхэг ном бүртгэгдэн уншигчдын эрэлт хэрэгцээг ханган ажиллаж байна.
Номын сангийн үүлэн технологит суурилсан шинэ /lib4u/ програмтай боллоо. darkhan.lib4u.net

Д/д	Хийж гүйцэтгэсэн ажлууд	Нийт
1	Техник хэрэгслийн засвар үйлчилгээг	38 удаа
2	Вэйб сайт аймгийн Төв номын сан болон МУҮНС /Мэдээлэл дамжуулалт/	335 удаа
3	Фэйс бүүкт мэдээ, мэдээлэл оруулах	262 удаа
4	Өнгөт хэвлэлээр сурталчилгааны материал хэвлэн гаргах	524 хуудас
5	И-Мэйл хаяг, болон утсаар мэдээ дамжуулалт	65 удаа
6	Эйбли програмийг ашигласан байдал	10 компьютер
7	Үйл ажиллагааны зураг авалт	54 удаа
8	Фэйс бүүк чат, пэйж хуудсын чат болон аман лавлагаа	230 удаа
9	Төв номын сангийн 2019 оны үйл ажиллагааны зурган тайлан	55 удаа
НИЙТ		**1563**

Засвар үйлчилгээ: Номын санч Н.Норжмаа Н.Солонгын Да.Сарантуяа П.Булгамаа Х.Отгонбаярын компьютр, Салбар номын сангийн USB0.2 camer, хяналтын камерын 1 дуран, Уншигчийн камерын шинэчилсэн программ салбар номын сангийн i5 компьютерт, Lib4U програмын server гэмтсэн, EPSONL360 өнгөт printer суулган таниулах. руйтер сольж, таниулж хэрэглээг зааж өгч Номын сангийн хяналтын камерын 1 дурангийн тохиргоо алдагдсаныг тохируулав.
Цэнэг: Салбар номын сан,С.Энхцэцэг, С.Нэргүй, Г.Нямцэнд нарын printer, цэнэглүүлж 1670hp бул солиулав.

Фэйс бүүк: Сар бүрийн 17 “Ном солилцооны өдөр”, Хүн та тархиндаа, Монгол цэргийн өдөрт, “Ном солилцооны өдөр” болж байна, Модоо хайрлах..., Үргэлж миний зөв гэх мэт
Өнгөт хэвлэл:
Хагас жилийн зурагт тайлан, 2019 оны Төв номын сангийн зурагт тайлан, “Дархан-Уул аймгийн Төв номын сан” хулдаасан хэвлэл шинээр эх бэтгэн 5*1.20 хэмжээтэй, “Сар бүрийн 17” хулдаасан хэвлэл, Ня-бо Б.Даваадолгорт номын сангийн байрнууд болон машины зурагнуудыг тус тус нийт 8%, “Шинэ номын мэдээ 2019 он” 4% хэвлэн, Сэдэвчилсэн үзэсгэлэнгийн хаяг материалуудыг өнгөт принтирээр 524 хуудас хэвлэв.
Зураг авалт: Соёл урлагийн ажилтаны баярын спорт арга хэмжээ, Халхын голын 80 жил, Аз хур номын худалдаа, Сар бүрийн 17 ном солилцоо, Дархан-Уул аймгийн соёл урлагийн ажилтны уулзалт-өдөрлөг, “Номын сан цэцэрлэгт” 10-р цэцэрлэгт “Оюунлаг Дарханчууд” өдөрлөг, “Номын сан цэцэрлэгт” 21-р цэцэрлэгт “Оюунлаг Дарханчууд” өдөрлөг зэрэг

Төсөл боловсруулал

2019 онд 8 төсөл бичиж холбогдох газруудад хүргүүлснээр 3 төсөл дэмжигдэж 5700 000 төгрөгний санхүүжилт авлаа.

- ✓ БСШУС-ын Яамны Соёл, урлагийг дэмжих сангаас 5.0 сая төгрөг авч Төвийн бүсийн нийтийн номын сангуудын номын санчдын дунд “Хамтдаа хөгжье” илтгэл, урлаг уран сайхны нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, “Орон нутгийн номзүйн бүртгэл”-ийг эмхэтгэн 300 хувь хэвлүүллээ.
- ✓ Аймгийн ЗДТГ-аас “Монгол гэр бүлийн ширээний ном”-оор уншигчдын бага хурал хийх 400 000 төгрөг,
- ✓ Аймгийн ЗДТГ-аас “Тэргүүний уншигч” гэр бүл шалгаруулах 300 000 төгрөгний төслүүдийн санхүүжилт авч үйл ажиллагаануудыг зохион байгуулан амжилттай хэрэгжүүлж ажиллаа.

- ✓ Монгол дахь Канадын ЭСЯаманд “Канад Сангийн Орон нутгийн Санаачилга” хөтөлбөрийн хүрээнд “Жендэрийн тэгш байдал ба эмэгтэйчүүдийг чадавхижуулах нь” сэдвээр боловсруулсан 37 138 400 сая төгрөгийн 48 хуудас бүхий төсөл,
- ✓ Дархан сумын 14 дүгээр багийн нутаг дэвсгэрт байдаг 1998 м2 газар дээр Дархан-Уул аймгийн “Төв номын сан-Музейн” Соёлын цогцолборын зориулалтаар барилгын зургийг урьдчилсан байдлаар хийлгэхэд 4224 м2 талбай бүхий зоорийн давхартай, 3 давхар барилга нь 3,9 тэрбум 9,6 сая төгрөгийн өртөгтэй болж байна. Зургийн план, үнийн саналыг БСШУС-ын Сайд Ё.Баатарбилэг, УИХ-ын гишүүн Б.Жавхлан нарт Аймгийн БСУГ-аар дамжуулан хүргүүлээд байна.

- ✓ **20 012 680** төгрөгний Номын сангийн техник тоног төхөөрөмжийн төсөл бичиж БСУГ-аар дамжуулан БСШУСЯ-ны бодлого зохицуулалтын газарт

- ✓ 2020 оны улсын төсөвт санал оруулахаар 1.9 тэрбумын өртөг бүхийн номын

сангийн стандартын барилгын төслийн анкетыг бөглөн Аймгийн Хөрөнгө Оруулалт Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн боловч энэ ондоо дэмжигдсэнгүй.

Ес. Тайлан, мэдээ хүргэлтийн талаар:

- ✓ *Санхүүгийн тайлан*, Бараа материалын гүйлгээ, тогтмол гүйлгээ, нэмэлт санхүүжилтийн гүйлгээ, зардал хоорондын шилжүүлэг, сар, улирал бүрийн

санхүүгийн тайлан, санхүүгийн сар бүрийн мэдээ, НД-ын тайлангуудыг сар бүрээр, худалдан авах ажиллагааны тайлан, татварын тайлангуудыг улирал бүрээр, орон нутгийн өмчийн тайлан, санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, аудитын холбоонд хүргүүлсэн.

Мэдээ, тайлан судалгаа:

- ✓ БСУГ-т Usukhbayar.1225@gmail.com хаягаар ёс зүйн судалгаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны 04-р сарын 10-ны №ХЭГ/934 тоот албан бичгийн хариуг цахимаар, ТЗУХэлтсийн мэргэжилтэн Н.Нарангэрэлд ёс зүйн мэдээг able-ээр, Архивын газарт "Архив бичиг хэрэг"-ийн материал, 2019 оны хагас, бүтэн жилийн бичгийн тайланг БСУГ-т, "Оюунлаг Дархан" хөтөлбөрийн тайланг БСУГ-т, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс "Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2019 оны 01 дүгээр албан даалгаварт дурдагдсан зөрчлүүд манай байгууллага дээр гараагүй ба холбогдох хэрэгжилтийн тайланг, **2019 онд** Аймгийн Засаг даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө гарган БСУГ-т, Хүний нөөцийн онлайн судалгааг дахин хянаж, санхүүгийн бүртгэл тооцоог шивж оруулж дуусгавар болголоо.

- ✓ Номын сангийн 2018 оны жилийн тайланг МҮНС-гийн нэгдсэн онлайн системд 91-н

асуултын дагуу СУ3, СУ10, СУ15 маягтуудыг байршуулан, 2018 оны тайланг МҮНС-гийн вэб сайтруу оруулав. 2018 оны Аймгийн аваргын тодорхойлолтууд, 2019 оны Гүйцэтгэлийн гэрээ, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Хүний нөөцийн судалгаа, Номын сангийн дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний 2019 оны төлөвлөгөө, 2018 оны гүйцэтгэл, 2019 оны өмч хамгаалалын тайлан, 2019 оны өмч дахин үнэлэх ажлын хэсгийн явцын тайлан, Санхүүгийн аудитын тайлан, 2019 оны эд хөрөнгийн тооллогын тайлангууд, Төвлөрсөн номын сангийн ҮЭХ-ны 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, татвар, статистикийн тайлангууд, Номын сангийн Мэргэжил аргазүй, Уншлага үйлчилгээ, Захиргаа аж ахуйн
нэгжүүдийн 2019 онд хийх ажлын төлөвлөгөө, сар, улирал, жилийн бичгийн болон тоон тайлангуудыг гаргаж 7 хоног, сар, улирлаар БСУГ-т гарган өгч байна.
Дэлхийн номын өдрийн төлөвлөгөө, хийсэн ажлын тайланг БСШУСЯ-ны Соёл
урлагийн газарт, Номын сангийн ажилтан албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтуудыг
шинэчлэн боловсруулж, төрийн захиргаа удирлагын хэлтэст, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс "Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2019 оны 01 дүгээр албан даалгаварын хэрэгжилтийн тайлангуудыг гаргаж хавсралтаар хүргүүлэн ажиллав.

Улсын архивын үзлэгт бэлтгэж архив, бичиг хэргийг цэгцлэх, талаар хийсэн ажил:

- ✓ Байгууллагын архивыг тусгай өрөө тасалгаатай, болгож төмөр тавиуртай болгов.
- ✓ 2015-2018 оны баримт бичгүүдийг цэгцэлж үдэн хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивт хүлээн авч данс бүртгэл үйлдэв.

- ✓ 2016 оны 13 баримт, 2017 оны 12 баримт, 2018 оны 21 баримтууд, 70 жил хадгалах баримтууд, 2016-2019 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулав, Устгах хэргийг ялгах, сонгох ажлыг зохион байгуулах, ББНШК-ын хурлаар хэлэлцүүлэв,
- ✓ 2015-2018 оны удирдлагын баримт бичгүүдийг скайнердаж /JPG, PDF/ цахим сангаа нэмэгдүүлэв.
- ✓ 2018 онд ирсэн, явсан бичиг, захирлын тушаал, үр дүнгийн гэрээ, төлөвлөгөө, тайлан болон бусад баримт бичгийг 21 боть болгон үдэж хавтаслан, архивын нөхөн бүрдүүлэлтээр 27 баримтыг сэргээн засварласан,
- ✓ УИХ-ын Цахим бодлогын түр хорооноос төрийн байгууллага болон холбогдох бусад байгууллагуудад өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн одоо хэрэгжүүлж байгаа цахим шилжилттэй холбоотой төсөл арга хэмжээний судалгааны маягтыг бөглөж, албан бичгээр болон uuganaa_b@darkhan.gov.mn хаягаар хүргүүллээ.

- ✓ Дархан-Уул аймаг дахь ШШГЕГ- 445-р “Нээлттэй хорих ангийн дарга дэд хурандаа Ц.Сандагдорж, Аймгийн татварын хэлтэст Монгол дахь Канадын Элчин Сайдын Яамны Канад Сангийн Орон нутгийн Санаачилга хөтөлбөрт хамрагдах төслийн сонгон шалгаруулалтанд оролцож байгааг уламжилж холбогдох лавлагаануудыг авав.

- ✓ Төрийн албанд ажилласан хугацааг тогтоох үндсэн баримт, хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтрүүдийг үндэслэн дараах нэр бүхий ажилтан албан хаагчдын ажилласан жилийг тогтоов. Үүнд: Сан хөмрөгч, мэдээллийн ажилтан Да.Сарантуяа 26 жил 6 сар, Ном сэлбэн засагч номын санч, архив бичиг хэргийн ажилтан С.Энхцэцэг-6 жил 2 сар, жолооч, техникийн ажилтан Д.Цэдэндамба 29 жил, зэргээр номын санчдын ажилласан жилийг тодотгон тогтоов.

- ✓ Номын сан Музейн цогцолбор барилгын зургийн саналыг хийж, “Зөв чиглэл” ХХК-ний захирал Ц.Мөнхбатын цахим хаягаар явуулав.

- ✓ Ажилтан албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтуудыг /33 хуудас/ гаргаж ТЗУ-ын хэлтэст хүргэж өгөв.

- ✓ Хүний нөөцийн судалгааг онлайнааар бөглөж явуулав.

- ✓ Нийтийн номын сангуудын барилга байгууламжтай холбоотой судалгааг гаргаж, БСШУСЯ-ны бодлого зохицуулалтын газарт цахимаар хүргүүлэв. Мөн Барилгын хүчин чадлын судалгааг Аймгийн БСУГ-т цахимаар хүргүүлэв.

- ✓ ТАЗ-ийн 2019 оны 03 дугаар тогтоолын 1,2-р хавсралтуудыг боловсруулж, БСУГ-ын мэргэжилтэнд цаасаар өгөв.

- ✓ Аймгийн БСУГ-аас зохион байгуулсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах” ажлын хэсэгт ахлах номын санч Г.Нямцэнд орж ажиллав.

- ✓ 2019 оны ажлын төлөвлөгөө 5 хуудас, Үр дүнгийн гэрээ /10 хуудас/,

- ✓ 2018 оны Аймгийн аваргын тодорхойлолт /7 хууд/

<u>Зургаа. Гэрээ байгуулж ажилласан талаар.</u>

- ✓ ДДС ХК, ДСЦТС ХК, Ус суваг ХК, Сод монгол групп, Газрын алба, Дархан секрит болон харилцагч бусад байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж ирлээ.

- ✓ Номын сан музейн цогцолбор барилгын зураг хийлгэх 64 000 000 төгрөгийн төсөвтэй гэрээг Төв номын сангийн захирал Д.Цэрэндаваа, Музейн захирал Д.Жамбалдорж нар "Зөв Чиглэл" ХХК-ны захирал Ц.Мөнхбаттай байгуулав. /2019 оны 03 сарын 25-ны өдөр № 19/04/

- ✓ Нүүдлийн номын сангийн чиглэлээр Дархан-Уул аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар - 445 дугаар нээлттэй хорих анги, Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран ажиллах гэрээ байгуулав.

- ✓ БСШУСЯ-ны Хөрөнгө оруулалтын газарт "Хамтдаа хөгжье" 5.0 сая төгрөгний гэрээний загварыг онлайнаар явуулж гэрээ байгуулж санхүүжилт авлаа.

- ✓ Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт байгууллагын газар эзэмшүүлэх гэрээний сунгалтын холбогдох материалуудыг хүргүүлж, 8-р багийн дэвшил дэх номын фондны газрын гэрчилгээг шинээр авч архивт хүлээлгэн өглөө.

<u>Бусад ажил:</u>

- ➢ "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио"-г улс орон даяар 2019.03.21-ний өдрийн үйл ажиллагаанд Төв номын сангийн номын санчид, уншигчидтайгаа аюулгүй байдлыг ханган ажиллаа.
- ➢ Дэлхийн ном хэвлэлийн өдрийг угтан зохион байгуулсан төвийн бүсийн "Хэвлэл 2019" спортын наадамд баг тамирчдыг бүрдүүлэн амжилттай оролцож II байр эзэллээ.
- ➢ Уншлагын танхимын фондноос олон хувьтай эргэлтэнд бага гардаг **1 163 боть** номыг архивын фондонд шилжүүллээ.
- ✓ Салбар номын сангийн сантехникийн хэсэгчилсэн засварыг ***561 000*** төгрөгийн зардлаар дараах ажлуудыг хийлээ.
- ✓ Уншлагын зааланд сантехникийн ажил, бүх паарнуудыг солих, будах, 00 өрөөнд сангийн засвар, гэрэлтүүлэг, гадна хаалганы цоожнуудыг солих, гадна гал командын булан будах, цоож солих, иж бүрдлийг гүйцээж авч тавьлаа.
- ✓ Дэвшил дэх архивын байрны дулаан авах бэлтгэл ажил, хүйтэн усны шугам бүрэн солих, 00 солих, паарнуудыг будах, 1 өрөөний паар солих, дулаалга хийх, цоож солих ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- ✓ Төв номын сангийн 00 өрөөний тосгуур, холигч, уян холбогчуудыг солих, 00 засах, гэрлийн монтаж хийх, даргын өрөөнд тосгуурын холигч солих офиссын болон заалны гэрлүүдийг лед гэрлээр солих, холбох, зааланд үлээдэг тень тавих болон байгууллагын гадна, дотно тохижилтын ажлуудыг гүйцэтгэсэн.

- ✓ Машинд сар, улирал бүхэнд ТҮ-1, ТҮ-2 үйлчилгээ хийх, агергат засвар, гагнуур цахилгаан болон бусад засваруудыг тогтмол хийж ирлээ.
- ✓ 2019 онд нүүдлийн номын сангаар болон орос номыг LIB4U программд оруулах ажилд 6018 км явж ажиллав.
- ✓ Техникийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах засвар үйлчилгээг тогтмол хийж, номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад анхааран ажиллаж ирлээ.
- ✓ Дэвшил дэх номын сангийн Фондны газрын гэрчилгээг шинээр авав.
- ✓ 395 боть номыг уншлагын танхимын фонднoос хасаж, архивын фондонд шилжүүлэн данс, бүртгэлд шилжүүлгийн хөдөлгөөн хийж, бар код, формулярыг шинэчлэх баг хамт олон ажиллаа.
- ✓ Аймгийн НБХ-ийн дарга Н.Цасчихэр, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Б.Буянбат, Захирагчийн албаны мэргэжилтэн М.Анхбаатар, БСУГ-ын дарга Б.Гантулга нар номын сангийн үндсэн фондны байрыг газар дээр нь очиж танилцаж, цаашид авах арга хэмжээний талаар ярилцав.
- ✓ Захирагчийн албаны дарга Равжаадэлгэрэх, БСУГ-ын барилгын мэргэжилтэн Ууганаа нар үндсэн фондны байрыг газар дээр нь очиж танилцаж, цаашид авах арга хэмжээний талаар акт бичиж өгөв.
- ✓ “Монголын соёл урлагийн ажилтны 26 дахь өдөр”-өөр Соёлын байгууллагуудын ажилтнуудын дунд зохиосон спортын арга хэмжээнд баг бүрдүүлэн оролцож шатар, теннисны төрөлд мөнгө, хүрэл медиал хүртсэн. Орхон аймагт зохион байгуулагдсан спортын арга хэмжээнд баг тамирчид бүрдүүлэн оролцлоо.
- ✓ Жил бүр уламжлан зохион байгуулдаг биеийн тамирын сорилд ажилтан ажиллагсдаа 100% хамруулав.
- ✓ "Хэвлэл 2019" спортын наадамд гар бөмбөг, теннис, шатар зэрэг төрлүүдээр амжилттай оролцож багийн дүнгээрээ II байр эзэллээ.
- ✓ Номын сангийн гадна талбайд байрлах 10 ширхэг цэцгийн саванд цэцэг тарьж ургууллаа.
- ✓ “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио”-г улс орон даяар зохион байгуулсан 2019.03.21-ний өдрийн үйл ажиллагаанд Төв номын сангийн номын санчид, уншигчидтайгаа аюулгүй байдлыг ханган ажиллаа.
- ✓ Орос номыг Lib4U програмд оруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж 7000 гаруй номноос одоо 3000 шахам номыг тус програмд оруулаад байна.

<u>Бидний амжилт:</u>

1. Хоол, унаа, нийгмийн даатгал, цалингийн сангийн дутуу **24 227 125 төгрөгийн** санхүүжилтыг нэмэлт тодотголоор оруулж батлуулсанаaар 2019 онд хоол, унааны зардлыг ажилтан ажиллагсаддаа хууль журмын дагуу олгодог боллоо.

2. Сар, улирал, жилийн эцсийн тайланг татвар, нийгмийн даатгал болон харилцагч байгууллагуудад хоорондын тооцоогүй, өр авлагагүй гарлаа.
3. МУСТА цол тэмдгээр сан хөмрөгч Н.Норжмаа, БСШУС-ын Яамны “Жуух” бичгээр сан хөмрөгч мэдээллийн ажилтан Т.Тамир, Дархан-Уул аймгийн “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр номын сангийн сүлжээний инженер Х.Отгонбаяр, аймгийн “Жуух бичиг”-ээр ном сэлбэн засагч, архив бичиг хэргийн ажилтан С.Энхцэцэг нар шагнагдлаа.
4. 2019 оныхоо ажлыг хамт олноороо дүгнэн номын сангийн дэргэдэх захиргааны зөвлөлийн хурлаараа хэлэлцэн 2019 оны “Байгууллагын аварга”-аар Ахлах номын санч, захиргаа аж ахуйн нэгж тасгийн дарга Г.Нямцэндийг, байгууллагын “Шилдэг ажилтан”-аар ном сэлбэн засагч, архив бичиг хэргийн ажилтан С.Энхцэцэгийг, захирлын нэрэмжит шагналаар сан хөмрөгч-мэдээллийн ажилтан, нярав Т.Тамирыг, оны онцлох ажилтнаар ня-бо Б.Даваадолгор нарыг тус тус шалгаруулан журмын дагуу шагнан урамшуулахаар боллоо.

<u>Цаашид тавих зорилт:</u>

1. Хурд сайтай, орчин үеийн шаардлага хангасан техник тоног төхөөрөмжийн төслийг бичиж, холбогдох байгууллагуудад хүргэх
2. Аймгийн хэмжээнд 2008-2019 оны цог сэтгүүлийн мэдээллийн санг бүрдүүлэх
3. Дархан сонины 2010, 2013, 2014, 2015, 2019 оны дугааруудыг нөхөн бүрдүүлэх
4. Дэвшлийн сантехникийн хэсэгчилсэн засварын материалын үнэ ***3 901 600*** төгрөг нэн шаардлагатай байна.
5. Номын сангийн байрыг бариулах асуудлыг орон нутгийн удирдлага, холбогдох яам, УИХ-ын гишүүдэд ахин уламжилж шийдвэрлүүлэх.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХҮҮХДИЙН НОМЫН ОРДНЫ
2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН.

НЭГ: ХҮҮХДИЙН НОМЫН ОРДНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ:

- ✓ Статистикийн мэдээллийн 3-НС-1, 3-НС-2, 3-НС-3, 3-НС-4 маягтуудын дагуу холбогдох мэдээллийг цаг тухайд нь гаргаж, БСУГ-ын соёлын асуудал хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн.

- ✓ 2018 онд БСШУС-ын яамны нэмэлт санхүүжилтээр худалдан авсан номын тайланг гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн.

- ✓ ХНО-ны 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан.

- ✓ 2020 оны төсвийн төсөл боловсруулж, холбогдох газруудад хүргүүлсэн.

- ✓ Гэр бүлийг дэмжих жилийн хүрээнд Иргэний танхимаас зохион байгуулсан хэлэлцүүлэгт номын санч мэдээллийн ажилтан С. Оюунцэцэг, О. Даваасүрэн нар оролцож, 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд саналаа илэрийллээ.

- ✓ Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмын дагуу тус ордны гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, баталгаажуулах хүсэлтээ Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүллээ.

- ✓ Дархан уул аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Иргэний танхим, БУСГ-аас зохион байгуулсан “Сонгодог урлаг III ”, “Соёлын биет бус өвийг хамгаалах” аймгийн дэд хөтөлбөр хэлэлцүүлэгт захирал Л. Мөнхбаатар, Уншлага үйлчилгээний нэгжийн дарга Т. Цэрэннадмид, номын санч мэдээллийн ажилтан Ч. Буяннэмэх, С. Оюунцэцэг, Т. Сумандадар нар оролцож санал бодлоо илэрхийллээ.

- ✓ Үндэсний статистикийн хороо, БСШУС яам, Эрүүл Мэндийн яамны хамтарсан удирдамжийн дагуу статистикийн улсын байцаагч нараас бүрдсэн багаас зохион байгуулсан “Орон нутгийн нэгжүүдэд цуглуулж буй анхан шатны болон тооллого, түүвэр судалгааны анхдагч мэдээллийн чанарын хяналт-шинжилгээ үнэлгээ” сэдэвт шалгалтанд хамрагдаж, заавар зөвлөмж авсан.

- ✓ Байгууллагын эцэг эхийн зөвлөлийг 3 хүний /Зөвлөлийн даргаар Монгол хэл, бичиг уншлага үйлчилгээний танхимын номын санч мэдээллийн ажилтан О. Даваасүрэн, гишүүдэд Англи хэлний уншлага үйлчилгээний танхимын номын санч- мэдээллийн ажилтан А. Ариунтуяа, Цахим номын сан-мэдээллийн танхимын номын санч-мэдээллийн ажилтан Т. Сумандадар/ бүрэлдэхүүнтэй баталж, зөвлөлийн ажиллах журам, төлөвлөгөө боловсруулж хэлэлцүүлэв.

- ✓ Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх, комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, шалгалтанд бэлтгэх төлөвлөгөө боловсруулж ажиллаж байна.
- ✓ Цахим орчинд ажиллах журам, Цахим номын сан мэдээллийн танхимаар үйлчлүүлэх зөвлөмж боловсруулж баталгаажуулан мөрдөж ажиллаж байна.
- ✓ Номын сангийн үйлчилгээний танхимуудад уншигчдын баримтлах дүрэм боловсруулж, баталгаажуулан мөрдөж ажиллаж байна.
- ✓ Архив, бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэж, 2019 оны эхний хагас жилийн баримтуудыг цэгцэлсэн.
- ✓ Хариуцсан сургууль, цэцэрлэгүүдтэй 2019-2020 оны хичээлийн жилд хамтарч ажиллах санал солилцож, олон нийтийг хамарсан 9 ажил төлөвлөсөн.
- ✓ Дархан-Уул аймгийн хүүхэд багачуудад зориулсан “Үүргэвчтэй уншлага” явган аялалын чиглэлээр маршрут гаргаж, түүх соёлын өвүүдийг олон нийтэл сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах хөтөлбөр боловсруулав.
- ✓ Ажилтан албан хаагчдад улирлын ажлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох журмыг шинэчлэн боловсруулж, 2019.11.28-ны өдрийн нийт ажиллагсдын хурлаар хэлэлцүүлж баталгаажуулав.

<u>Мэдээлэл, сурталчилгааны талаар:</u>

- ✓ 2019.01.03. Монгол телевизийн хүүхдийн нэвтрүүлгийн редакциас ХНО-ны үндсэн үйл ажиллагааны тоон мэдээ, уншигч хүүхдүүдийн дунд зохион байгуулдаг болон оны онцлох арга хэмжээний талаар мэдээлэл авч, мэдээллийн хөтөлбөрөөр үзэгчдэд хүргэсэн.

<u>Мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар:</u>

Тус Ордон нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн, тэдэнд ойр, өөрчлөгдөж буй нөхцөл байдалд уян хатан ханддаг, цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн, идэвх, санаачилгатай бөгөөд манлайлагч менежер, мэдлэг чадвартай албан хаагч бүхий байгууллага байх зорилготой 4 зарчимд тулгуурласан “Сургалтын хөтөлбөр” боловсруулан ажиллаж байна.

“ХНО-ы сургалтын хөтөлбөр”-т тусгагдсаны дагуу:

1. Төрийн албан хаагчийн сургалтыг ажлын байранд нь сургах;
2. Өөр байгууллага, хамт олноос суралцах буюу богино хугацааны зорилтот сургалтаар давтан сургах;
3. Боловсролын мэргэжлийн байгууллагад суралцуулах;
4. Тодорхой сэдэв эсвэл мэргэжлээрээ дагнан суралцах гэсэн 4 зарчимд тулгуурлан зохион байгуулж ирлээ.

Тайлангийн хугацаанд:

1. Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагаагаа сайжруулахын тулд албан хаагч нэг бүрийг ажлын байранд нь сургах зорилтын хүрээнд 17 сургалт зохион байгуулагдаж, давхардсан тоогоор нийт 272 ажилтан албан хаагч оролцсон.
2. Өөр байгууллага, хамт олноос суралцах буюу богино хугацааны зорилтот сургалтаар давтан сургах зорилтын хүрээнд 4 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 7 ажилтан хамрагдсан.
3. Боловсролын мэргэжлийн байгууллагад суралцуулах зорилтын хүрээнд 11 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 22 ажилтан хамрагдсан.
4. Тодорхой сэдэв эсвэл мэргэжлээрээ дагнан суралцах зорилтын хүрээнд 1 ажилтан номын санч мэргэжлээр, 2 ажилтан барилгын засал чимэглэлчин мэргэжлээр мэргэжлийн сургуулиудад суралцаж төгссөн.

Нийт 33 удаагийн сургалт, мэдээлэлийн арга хэмжээнд давхардсан тоогоор 288 албан хаагч хамрагдаж, нийт ажиллагсдын 100 % нь хамрагдсан байна. Мөн Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан эцэг, эхийн зөвлөлийн анхдугаар зөвлөгөөнд ХНО-ны эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүн оролцсон.

Тайлангийн хугацаанд нийт 17 орон тоотой ажилласан. Үүнээс:

- ✓ Удирдах албан тушаалтан-1
- ✓ Уншлага үйлчилгээний нэгжийн дарга - 1
- ✓ Үндсэн үйл ажиллагааны ажилтан буюу номын санч-8
- ✓ Туслах үйл ажиллагааны ажиллагсад-7

- ✓ Нийт номын санчдын 77% нь 3-аас дээш жил ажилласан мэргэжлийн номын санчид байна.
- ✓ 2019 онд МУ-ын Соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр 2 ажилтан, “Найрамдлын Дархан” тэмдгээр 1, Аймгийн Засаг даргын жуух бичгээр 2, Сумын засаг даргын жуух бичгээр 2, байгууллагын тэргүүний ажилтанаар 2 хүн тус тус шагнагдсан.

- ✓ Салбар номын сан
- ✓ Уншлагын үйлчилгээний танхим
- ✓ Төрөлжсөн танхим / Англи хэл, Байгалийн ухаан-/Математик/, Монгол хэл, Гэр бүлийн, Цахим ном-мэдээллийн танхим/
- ✓ Захиргаа аж ахуйн гэсэн бүтэцтэйгээр ажиллаж байна.

<u>ХОЁР: ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:</u>

БСШУ-ны Сайдын 441-р тушаалын дагуу номын санд хөтлөгдөх анхан шатны 17 бүртгэл маягтыг стандартын дагуу хөтөлж, мэдээ тайланг тухай бүр холбогдох газруудад хүргүүлж ажилласан. Үүнд:

- ❖ Жилийн ажлын төлөвлөгөө 1 удаа
- ❖ Сар тутмын үйл ажиллагааны төлөвлөгөө 12 удаа
- ❖ 7 хоног тутмын үйл ажиллагааны мэдээлэл 48 удаа
- ❖ Сар тутмын мэдээ 12 удаа

- Хагас жилийн тайлан 1 удаа
- 2019 оны үйл ажиллагааны тайлан 1 удаа
- Бусад тайлан мэдээг цаг тухайд нь гаргасан

2.1.Уншлага үйлчилгээний талаар:

2019 онд Дархан-Уул аймагт сурч байгаа ЕБС-ийн нийт /22074/ суралцагчдын 17,6% нь буюу 3905 хүүхэд, СӨББ-ийн / 8415/ суралцагчдын 0,48% нь буюу 41 хүүхэд номын сангийн уншигч болж, уншлага үйлчилгээнд хамрагдсан үзүүлэлттэй байна.

Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 57425:2007 стандарт аймаг, дүүргийн номын сангийн жишгээр уншигч, ирц, ном олголтыг үндэслэн үйл ажиллагаа бодитой төлөвлөдөг.

Хүснэгт 1

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
Уншигч	3800	4143	109%
Ирэгсэд	38000	53534	140,8%
Ном олголт	55000	75506	137,2%

График 1



Урьд оны мөн үеийнхтэй харьцуулж үзвэл:

Үзүүлэлт	2018 он	2019 он	Хувь
Уншигч	3972	4143	104,3%
Ирэгсэд	50281	53534	106,4%
Ном олголт	77126	75506	97,9%

График 2



График 3

Нийт уншигчдыг насны ангиллаар ангилж үзвэл:

- ✓ 41 уншигч буюу 1% нь цэцэрлэгийн хүүхдүүд
- ✓ 2251 уншигч буюу 54.3% нь I-V ангийн сурагчид
- ✓ 1181 уншигч буюу 28.5% нь VI-VIII ангийн сурагчид
- ✓ 475 уншигч буюу 11.4% нь IX-XII ангийн сурагчид

- ✓ 16 уншигч буюу 0.3% нь оюутан
- ✓ 149 уншигч буюу 3.5% нь насанд хүрэгчид
- ✓ 22 уншигч буюу 0.5% нь ахмад настан
- ✓ 8 уншигч буюу 0.2% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

Хүйсээр авч үзвэл:

- ✓ 59,2% нь буюу 2453 эмэгтэй уншигч
- ✓ 40,8% нь буюу 1690 эрэгтэй уншигч тус тус байна.

Өөрийн орлогын биелэлт:

- ✓ Төлөвлөлт 4,500,000₮
- ✓ Биелэлт 4,620,000₮ Хувь 102,6%

2018 онд өөрийн орлогод 4,634,500 төгрөг бүрдүүлж байсан бол 2019 онд 4,620,000 төгрөг бүрдүүлсэн байна.

2.2. Төрөлжсөн танхимын үйлчилгээ:

ЕБС-ийн сурагчдын хичээлээс гадуурх чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, номтой нөхөрлүүлэх, танилцуулах, бие даан сурч боловсроход нь дэмжин туслах, мэдээ мэдээллээр хангах, зөвлөн туслах, хоцрогдол арилгах, ЭЕШ болон бусад уралдаан тэмцээнд оролцоход бэлтгэх зорилгоор Англи хэл, Байгалийн ухаан, Монгол хэл-бичиг, Цахим ном-мэдээлэл, Гэр бүлийн уншлага үйлчилгээний танхимууд ажиллаж байна.

2019 онд төрөлжсөн танхимуудад нийт 2423 уншигч бүртгэгдэж, 20283 ирэгсдэд 28783 лавлагаа мэдээлэл өгч, ном хэвлэлээр үйлчилсэн байна. Үүнд:

Хүснэгт 1

Төрөлжсөн танхимын нэр	Уншигч	Ирэгсэд	Ном олголт
Байгалын ухааны у/ү /Математик/ танхим	430	3902	6422
Гадаад хэлний /Англи хэл/ уншлагын танхим	495	5593	6355
Монгол хэл, бичиг, уран зохиолын танхим	522	4614	8041
Гэр бүлийн танхим	98	935	2487
Цахим ном-мэдээлэлийн уншлагын танхим	878	5239	5478
Нийт	2423	20283	28783

График 5



2.3. Явуулын номын сангийн үйлчилгээ:

- ✓ “Номтой өдөр” аяны хүрээнд СӨБ-ын 1 цэцэрлэг, ЕБ-ын 9 сургуульд нүүдлийн буюу явуулын номын сангийн үйлчилгээг хүргэлээ. Арга хэмжээний хүрээнд ХНО-ны танилцуулга, шинэ номын үзэсгэлэн, ном уншлага, ном унших арга барил хэрхэн суралцах, номын тэмдэглэл хэрхэн хөтлөх талаар зөвлөмж өгч, танин мэдэхүйн уралдаан тэмцээн, бага ангийн хүүхдүүдэд зориулсан /Байгальд хайртай имж, Дэлхийн үлгэрийн дээжис зэрэг номуудаар/ чанга уншлага хийх зэрэг ажлуудыг зохион байгуулав. Нийт 234 уншигч шинээр бүртгэж, 4023 ирэгсдэд, 9978 ном олгож үйлчилсэн.
- ✓ 2019 оны 6-р сарын 17-оос 8-р сарын 5 хүртэл ХГБЗХГ-тай хамтран “Зулзагын гол” дахь хүүхдийн зусланд амрагч хүүхэд багачууд болон хөдөөгийн уншигчдын амралт чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд зориулан нүүдлийн номын сангийн үйлчилгээг үзүүлсэн. Нийт 4 ээлжийнд 78 уншигч, 546 ирэгсдэд, 2987 боть ном олгож үйлчилсэн. Явуулын номын сангийн үйлчилгээний хүрээнд Шинэ номын үзэсгэлэн гаргаж, чанга уншлага, “Аха” хөгжөөнт танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулан цэвэр агаарт чөлөөт уншлага, гэрээр ном олгох үйлчилгээ, номын утга агуулгыг хэрхэн ойлгосноор нь “Шилдэг уншигч “ шалгаруулах, “Номын хишиг өдөр” зэрэг арга хэмжээнүүдийг тус тус зохион явуулсан.

2.4. Зөөврийн номын сангийн үйлчилгээ:

Алслагдсан суурин, ЕБС, СӨББ-ын хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээг хүргэх зорилгоор зөөврийн номын сангийн үйлчилгээг 6 цэцэрлэг 8 сургуульд нийт 34 удаа **1316** боть ном хүргэсэн байна.

2.5. Гэрээр ном олгох болон гэрээр ном хүргэх үйлчилгээ:

Уншигчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ном унших чиг хандлагыг дэмжих зорилгоор гэрээр ном олгох болон гэрээр ном хүргэх үйлчилгээг тогтмол ажилуулж байна. Тайлангийн хугацаанд нийт **255** уншигчид **1169** боть ном гэрээр олгож, 1 удаа 1 уншигчид 3 боть номоор ном хүргэх үйлчилгээ үзүүлсэн.

2.6. Хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настанд үзүүлэх үйлчилгээ:

Хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настанг номтой нөхөрлөх, мэдээлэл авах, номын сангаар үйлчлүүлэх чиг хандлагыг дэмжих зорилгоор уншигчийн картыг үнэ төлбөргүй нээх ажлыг тогтмол зохион байгуулж байна. 2019 онд хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настан нийт 30 уншигчид үнэ төлбөргүй карт нээж, ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр үйлчилсэн.

2.7. Онлайн үйлчилгээ

- ✓ Цахим хуудсаараа дамжуулан өөрийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах, үйл ажиллагааны талаарх болон шинэ номын талаарх мэдээ мэдээлэлийг уншигч хэрэглэгчдэд хүргэх, лавлагаа мэдээлэл өгөх, ном унших арга барилд сургах талаар зөвлөмж бэлтгэж нийтлэх зэрэг ажлыг тогтмол зохион байгуулж байна. Тайлангийн хугацаанд https://www.facebook.com/Nomiin.ordon/ хуудсандаа нийт 468 мэдээлэл оруулсан.
- ✓ Албан хэрэг хөтлөлтийн ABLE програмыг ашиглан төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцож ажиллаж байна. Нийт 153 мэдээлэл хүлээн авч, 2 мэдээлэл байршуулж, бусад байгууллагын 15 албан хаагчтай мэдээлэл солилцож ажилласан байна.

2.8, “Үдшийн уншлага”

Уншигчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, номтой нөхөрлөх, гэр бүлээрээ ном унших боломжийг нэмэглүүлэх зорилгоор Хүүхэд хөгжлийн ордны гаднах талбайд 2019.06.17,18-нд, Дархан-50 цогцолборт 2019.06.20-27-ны хооронд 17.00-22.00 цагийн хооронд “Үдшийн уншлага” арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд:

- ✓ Уншигчийн карт нээх;
- ✓ Ном уншлага;
- ✓ Ном солилцоо;
- ✓ Ном унших арга барилд суралцах, номын тэмдэглэл хөтлөх талаар заавар зөвлөмж өгөх;
- ✓ Шинэ болон хуучин номын үзэсгэлэн гаргах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн.

Арга хэмжээний хүрээнд нийт 58 уншигч шинээр бүртгэж , 194 ирэгсдэд 746 боть ном олгож үйлчиллээ

<u>2.8. Сан хөмрөг</u>

2019 онд:

- ✓ Сан хөмрөгийн баяжилтийг уншигчдын эрэлт хэрэгцээг судлах, татгалзлын дэвтэр хөтөлсний үндсэн дээр захиалга хийж бүрдүүлдэг. 2019 онд нийт 15 удаагийн сан хөмрөгийн баяжилт хийгдсэн: Үүнээс төсвийн хөрөнгөөр 12 удаагийн худалдан авалтаар 5,161,400 төгрөгийн 158 нэрийн 362 боть ном, Үндэсний номын сан, 9-р сургуулийн төгсөгчдийн хандив, БСУГ-ын хувиарлалтаар 1,422,848 төгрөгийн 91 төрлийн 124 боть ном, нийт 6,584,248 төгрөгийн 249 нэрийн 486 боть номоор сан хөмрөгөө баяжуулсан. Сан хөмрөгийн баяжилтийг урд онтой харьцуулан үзвэл: Номын үнийн дүн 1,2%, номын нэр төрөл 15,7%, тоо ширхэг 11,9%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь зах зээл дэх номын үнэ өссөнтэй холбоотой номын нэр төрөл, тоо ширхэг буурсан гэж үзэж байна.

- ✓ 2019 оны 1, 2, 3, 4- р улирлын сонин, сэтгүүлийг захиалж, улирлаар нь нэгжилж үдэж, бүртгэн авав.
- ✓ Ном хэвлэлийг сэлбэн засварлах ажлыг тухай бүр тогтмол хийж, урагдаж гэмтсэн 379 боть номонд сэлбэн засалт хийж, карт хөтлөн баримтжуулж, уншлага үйлчилгээнд ашиглаж байна.

- ✓ MNS:ISO 11799:2007 “Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага” стандартын дагуу чийг тохируулагч, шавж устгагч, мөөгөнцөртөх, чийгшихээс хамгаалах төхөөрөмжийн үнийн судалгааг хийж, тус бүр нь 450.000 төгрөгний 4 ширхэг /**TCL Агаар цэвэршүүлэгч, чийгшүүлэгч NX450F**/ төхөөрөмж худалдан авч байрлуулах /**1.800.000 төгрөг**/ мөнгийг 2020 оны төсөвт тусгахаар байгууллагын удирдлагад санал оруулсан.
- ✓ Номын сангийн тухай хуулийн 17.1.2-ын ын “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэвлүүлсэн хэвлэлийн бүтээгдэхүүн тус бүрээс гурван ширхэгийг орон нутгийн номын санд шилжүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлэхийг нийт хэвлэлийн газар, ном хэвлэгч, зохиолч нартаа уриалж цахим хуудсандаа зурагт хуудас хэлбэрээр нийтлэл гаргасан.
- ✓ ХНО-ны захирлын 2019 оны 11-р сарын 22-ны өдрийн А/29 тоот тушаалын дагуу тооллогын комисс томилогдон “Номын нэг бүрчилсэн дансаар тоолох” хэлбэрийг сонгон 2019 оны 11 сарын 28 өдрөөс 2019 оны 12 сарын 05 өдөр хүртэл ажлын 8 хоногийн хугацаатайгаар тоолж гүйцэтгэв.

Фондонд: Ерөнхий дансаар 10718, сурах бичгийн дансаар 804, гадаад номын дансаар 915, нийт 12437 боть ном байхаас тоолоход байсан нь:

- ✓ Фондын тавиур дээр байгаа 9455 ширхэг
- ✓ Бусад танхимд түр шилжүүлсэн 2870 ширхэг
- ✓ Уншигчдийн гар дээр байгаа /гэрээр болон зөөврөөр олгогдсон/ 109 ширхэг
- ✓ Түр солилцоогоор явуулсан 1 ширхэг, нийт 12435 боть ном бэлэн байна.
- ✓ Дутагдсан 2 боть ном,

Дутагдсан номыг тухайн номоор төлөх зарчмаар төлбөрийг барагдуулах арга хэмжээ авахыг комисс шийдвэрлэсэн.

<u>2.9. Каталоги зохион байгуулалтын талаар:</u>

Тус ордон нь номын сангийн Монбиблио програмаа үүлэн технологид шилжүүлж, онлайн үйлчилгээнд холбогдоод байна.

Электрон каталогийг зөвхөн номын санч ашиглаад зогсохгүй, уншигчид цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хайлт хийж, номоо захиалах, номын санчид ирэх ачааллыг багасгах, мэдээллийн санг хүссэн үедээ нөөцөлж авах боломжтой болох, програмын шинэчлэлт шууд автоматаар хийгдэх гэх мэт давуу тал бий болсон.

Электрон каталогт нийт 11798 боть ном бүртгэгдсэн. Үүнээс 2019 онд 485 боть ном шинээр бүртгэгдсэн байна.

Дархан-уул аймгийн засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Хүүхдийн номын ордонг “Цахим номын сан” болгох арга хэмжээний хүрээнд Номын сангийн үйлчилгээг цахимжуулах 8,000,000 төгрөгийн өртөг бүхий компьютер, каталогийн шүүгээ, тоног төхөөрөмжүүдийг суурилуулан, хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

<u>2.10. Ном зүйн ажлын талаар:</u>

Шинэ номын мэдээ 14 удаа гаргаж, цаасан хэлбэрээр болон өөрийн ордны facebook хуудсаар мэдээлэл бэлтгэж уншигчдад хүргэсэн.

<u>2.11. СОТ Ажлын талаар:</u>

Сурагчдын ном унших хандлагыг дэмжих, уншигч номын сангийн харилцаа холбоог ойртуулах зорилгоор зохион байгуулдаг Соёл олон түмний ажлыг уламжлалт болон цаг үндэсний хөтөлбөрүүдтэй уялдуулан нийт 7 ажил төлөвлөснөөс нийт 14 арга хэмжээг зохион байгуулж, 2500 гаруй уншигч, хүүхэд багачууд хамрагдсан.

1. “Номын үзэсгэлэн”:

Шинээр ирсэн болон фондын номыг сурталчлах, тэмдэглэлт өдөр, баяр ёслол, зохион байгуулагдаж буй арга хэмжээнүүдэд зориулан шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг тогтмол гаргав. 2019 онд шинэ номын үзэсгэлэнг шинэ ном ирсэн тухай бүр буюу нийт 10 удаа 248 боть номоор, сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 15 удаа 257 боть номоор тус тус гаргаж, мөн өөрийн цахим хуудсаар уншигчдад хүргэж ажилласан.

Эдгээр номын үзэсгэлэнг давхардсан тоогоор 1120 гаруй уншигч үзэж сонирхсон. Энэхүү арга хэмжээний үр дүнд сан хөмрөгийн номыг олон нийтэд сурталчилж, номын эргэлт сайжирсан.

2.“Чанга уншлага, тойм яриа”: “Бид ирлээ-2019” арга хэмжээний хүрээнд СӨБ-ын 9 цэцэрлэгийн 12 бүлгийн 365 хүүхэд багачууд ХНО-д хүрэлцэн ирж үйл ажиллагаатай

танилцаж, гэр бүлийн танхимаар үйлчлүүлэн үлгэрийн болон хүүхдийн /Байгальд хайртай имж, Дэлхийн үлгэрийн дээжис зэрэг номуудаар/ номоор чанга уншлага зохион байгуулав. Мөн нас сэтгэхүйн онцлогт тохирсон асуулт бүхий АХА тэмцээнийг зохион явуулж урамшуулав.

3.Уулзалт, Лекц:

- ✓ 2019.02.19. МСҮТ-ийн багш, оюутан сурагчидад зориулан “Ном бол хүсэл мөрөөдлийг давах жигүүр мөн” сэдэвт ном унших арга зүйд төлөвшүүлэх лекцийг захирал Л. Мөнхбаатар хүргэлээ. Тус лекцийн үеэр ХНО-ны танилцуулга, номын тэмдэглэл хэрхэн хөтлөх талаар зөвлөмж хүргэж, " 60 секунт" хөгжөөнт уралдаан тэмцээн зохион явууллаа Нийт 11 ангийн 120 сурагч, оюутнууд, багш ажиллагсад оролцсон.
- ✓ АШУҮИС-ийн 1-р курсын 28 оюутан ХНО-ны үйл ажиллагаатай танилцаж, мэдээлэл авсан. Мөн багш М. Нарантуяа “Эрүүл хооллолт” сэдвээр лекц хүргэсэн.
- ✓ **2019.III.29.** Захирал Л. Мөнхбаатар 16-р сургуулийн 10-р ангийн 61 сурагчдад “Ном бол хүсэл мөрөөплийг давах жигүүр мөн” сэдэвт лекц уншсан.

4.Шилдэг уншигч, хамгийн их уншигдсан ном: Хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх, ном унших сэдэл төрүүлэх, бусдадаа үлгэр дууриайлал болох, дэмжин урамшуулах зорилгоор Төрөлжсөн танхимуудаас тус бүр 1 уншигч, Салбар номын сан, уншлагын танхимаас сар бүр 2, нийт 40 уншигч хүүхэд шалгаруулж, урамшуулан мэдээллийн самбараар болон цахим хуудсаар олон нийтэд сурталчлан алдаршуулав**.**

5.Дэлхийн номын өдөр

- ✓ “Өглөөний цайтай уншлага” арга хэмжээг “Аав ээжтэйгээ уншъя” сэдвийн хүрээнд 9 дүгээр сургуулийн Л. Норжмаа багштай 11в ангийн хамт олон, эцэг эхийн төлөөлөл, номын санч А. Мөнхтуяа, нийгмийн ажилтан Б. Эрдэнэтогтох нарыг оролцуулан зохион байгууллаа

- ✓ Дэлхийн номын өдрийг тохиолдуулан “Дэлхийн хүүхдийн сонгодог бүтээлүүд” цуврал ном мөн дэлхийн сонгодог бүтээлүүдээр шилэн хоргонд болон номын тавиуруудад сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргасан. Нийт 119 боть номоор үзэсгэлэн гаргаж 79 уншигч үзсэн. Мөн үзэсгэлэнд тавигдсан номуудаар өөрийн ордны фейсбүүк хуудсаар мэдээллийг хүргэсэн.

- ✓ Дэлхийн номын өдрийг олон нийтэд сурталчилах, ном унших хүсэл сонирхлыг дэмжих зорилгоор уншигчдын картыг 8 уншигчид 50 хувийн хөнгөлэлттэйгээр нээсэн.

6. Үндэсний бичиг, үсгийн баяр:

- ✓ **Сэдэвчилсэн номын үзэсгэлэн:** Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Үндэсний бичиг үсэгийн баяр”-ыг тохиолдуулан өөрийн сан хөмрөг дэх Монгол хэл, бичгийн холбогдолтой ном хэвлэлийг сурталчлах, сан хөмрөгийн эргэлттийг сайжруулах зорилгоор 14 боть номоор сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргав.

Үзэсгэлэнг 5-р сарын 4-9 хооронд зохион байгуулж нийт 411 уншигч үзэж сонирхсон. Мөн цахим орчинд үзэсгэлэнд тавигдсан номуудаар мэдээлэл бэлтгэж олон нийтэд хүргэсэн.

- ✓ **Хичээнгүй бичгийн үзэсгэлэн:** 05 дугаар сарын 8-нд "Үндэсний бичиг үсэгийн баяр"-ыг тохиолдуулан үндэсний бичиг үсгээ сурталчлан түгээн дэлгэрүүлэх, сурах хүсэл эрмэлзлэлийг идэвхжүүлэх, алдаагүй, зөв сайхан бичих, монгол бичиг суралцагчдыг дэмжин урамшуулах зорилгоор Монгол хэл, бичиг уран зохиолын танхимын уншигчдын Монгол бичгийн хичээнгүй бичлэгээр бичсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргалаа. Тус үзэсгэлэнд 18 сурагчийн 19 бүтээл тавигдсан. Нийт 72 хүн үзэж сонирхсон.

- ✓ **Монгол бичгийн хурдан уншлагын уралдаан:** "Ном" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Дэлхийн номын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, Үндэсний бичиг үсгийн баярын өдрийг тохиолдуулан Үндэсний бичиг үсгээ эрхэмлэн дээдлэх, бахархах, хүүхэд бүрийг монгол бичигтэн болгох, хурдан унших чадварыг нэмэгдүүлэх зорилгоор "Монгол бичгийн хурдан уншлагын уралдаан"-ыг Хүүхдийн Номын Ордноос 4 дэхь жилдээ зохион байгууллаа.Уралдаанд ОИЦ, Од, Жигүүр, 4, 6, 8, 9, 14, 15,18, Монгол-Оюу, Хүмүүнлэг лицей, ШУТИС лицей зэрэг 13-н сургуулийн 8, 11-р ангийн нийт 63-н сурагч оролцлоо. Хурдан уншлагыг "Хүмүүн бичиг" сониноос 2 эх сонгож уншуулаа. Хурдан уншлагын уралдаанд оролцсон сурагчид 1 минутад хамгийн бага нь 12, хамгийн их нь 93 үг уншсан. Нийт уншсан үгээс зөв уншсан үгийг тооцсон.Өмнөх жилүүдтэй харьцуулбал сургууль, хүүхдийн оролцоо нэмэгдэж, уншлагын уралдаанд ач холбогдол өгч оролцож байгааг харахад уралдааныг үргэлжлүүлэн зохион байгуулж байх нь зөв юм байна гэсэн дүгнэлтэд хүрсэн

7.Уншигчдын клуб:

"Оюуны ундрага" ном уншигчдын клубын сурагчид "Үүргэвчтэй уншлага" аялалыг 2 удаа зохион байгуулсан. Үйл ажиллагааны хүрээнд:

- ✓ Номыг сонирхолтой орчинд унших;
- ✓ "Оюуны хүлэг" шагайн уралдаант хөгжилтэй асуулт хариултын тэмцээн
- ✓ Чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх тоглоом
- ✓ Хүүхдүүд уншсан номоо харилцан ярилцах зэрэг арга хэмжээнүүдийн зохион байгууллаа.

2019 оны 11-р сарын 15-нд Хүүхдийн төлөө зөвлөл, Аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөл хамтран зохион байгуулсан "Бидний оролцоо-Ирээдүйн хөгжил" хэлэлцүүлэг хүүхдийн 9-р чуулганд ХНО-ны дэргэдэх "Оюуны ундарга" уншигчдын клубын хүүхэд багачууд оролцож, шинэ номын үзэсгэлэн гаргаж, уншигчийн клубын үйл ажиллагааг сурталчилсан. Мөн "ОЮУНЫ УНДАРГА" уншигчийн клубын уншигч, өсвөрийн номын санч Б.Оюунцэцэг нь Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газрын МАНЛАЙЛАГЧ алтан медалиар шагнагдлаа.

8. Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах талаар:

Монголын улсын засгийн газрын 2008 оны 293-р тогтоолоор батлагдсан Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, ЕБС-ийн сурагчдыг англи үсгийг зөв унших, бичих улмаар үгсийн санг баяжуулах, англи хэл сурах хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэх, урамшуулан дэмжих зорилгоор ЕБС-ийн 6 дугаар ангийн сурагчдын дунд англи үгийг үсэглэх “ Spelling Bee” уралдааныг Гэр бүл, хүүхэд, хөгжлийн ордонтой хамтран 2019 оны 10 дугаар сарын 16-ний өдөр зохион байгууллаа. Тус уралдаанд ЕБ-ын 10 сургуулийн 49 сурагч оролцож, тэргүүн байранд “Жигүүр” цогцолбор сургуулийн 6 б ангийн сурагч Э. Мөнх-Хүслэн, дэд байранд 18-р сургуулийн 6г ангийн сурагч Ч. Ерөөлтхүү , гуравдугаар байранд ОИЦ сургуулийн 6-13 ангийн сурагч Ж. Хүслэн нар шалгарлаа. Уралдаан зохион байгуулалт сайтай, шинэлэг арга хэлбэрээр амжилттай зохион байгуулагдсан. Нийт 42900 төгрөгний зардал гарсан.

9. Дүрийн тоглолттой уншигчдын бага хурал:

Хүүхдийн номын ордноос хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх, зохиолын баатруудын сайн сайхан чанарыг дуурайх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөрийн нууц мэдрэмж, авьяасаа нээх боломжийг сурагчдад олгох зорилгоор жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Дүрийг хэн сайн амилуулах вэ?” уралдаан ЕБС-ийн 8-р ангийн сурагчдын дунд 7 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа.Уралдаанд 7 сургуулийн 7 багийн 58 сурагч оролцож, “Сургамжит өгүүллэг” /1-8-р цуврал / номооос өгүүллэг сонгон уншиж, сонгосон өгүүллэгээрээ жүжигчилсэн тоглолт хийн уралдаанд оролцлоо.

- ✓ Уралдааны тэргүүн байранд: Шарын гол 6-р сургууль 8а анги "Аваа уучлаарай" өгүүллэг
- ✓ Дэд байранд: ОИЦ сургуулийн 8-4 анги "Хайрын түүх" өгүүллэг
- ✓ Гутгаар байранд: 12 дугаар сургуулийн "Хаант улс" өгүүллэг
- ✓ Тусгай байранд: Од цогцолбор сургуулийн 8а анги "Ухаантны сургууль" өгүүллэг, 4 дүгээр сургуулийн 8в анги "Аваа уучлаарай" өгүүллэгээр тус тус эзэлж,
- ✓ Шилдэг дүрийн шагналыг 6 дугаар сургууль 8а ангийн сурагч А. Зейнеп хүртлээ.

Уралдааныг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар хамтран зохион байгуулж, 9-р сургуулийн номын санч дэмжин ажилласан.

10. Бусад арга хэмжээний хүрээнд:

- ✓ **2019.05.28.** Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 3 дахь жилдээ Төрийн болон хувийн хэвшлийн 4 эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 21 хүүхдүүдэд Хүүхдийн номын ордонд үйлчлүүлэх эрх, хамт олны чин сэтгэлийн захидал, "Витафит ХХК"-ний бүтээгдэхүүний дээж "Пороро" ундааг бэлэглэв.
- ✓ **2019.III.22** Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Хүүхэд хөгжлийн ордонд Ус суваг, 1-р сургууль хамтран ЕБС-ийн 8-р ангийн сурагчдын дунд зохион байгуулсан “Сэтгэлд хоногшсон шүлгүүд” анги нийтээрээ уран унших уралдааныг захирал Л.Мөнхбаатар шүүн тунгаалаа. Уралдаанд Шарын гол сумын ЕБС-ын сурагчид амжилттай оролцсон.

<u>ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2017-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:</u>

Зорилт 6.1.5 “Ном”, ”Авьяас” аймгийн дэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

<u>“Ном” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд:</u>

Аймгийн “Ном” дэд хөтөлбөрийн хүрээнд нийт 5 арга хэмжээ зохион байгуулагдаж нийт 1170 уншигч, хүүхэд багачууд хамрагдсан байна. Үүнд:

- ✓ “Бид ирлээ” аяны хүрээнд СӨБ-ын 9 цэцэрлэгийн 12 бүлгийн 365, ЕБ-ын 8 сургуулийн 21 ангийн 619 сурагч анги хамт олгоороо хүрэлцэн ирж, ХНО-ны үйл ажиллагаатай танилцаж, уншигчийн карт нээлгэн тогтсон өдрүүдэд уншлага зохион байгуулж уншсан номын тэмдэглэл хөтлөх, анги, баг хамт олгоороо хичээл давтах зэрэг үйл ажиллагаанд хэвшээд байна. Тус аяны хүрээнд нийт 619 хүүхэд номын сангийн уншигч болсон.
- ✓ Сурагчдын зуны амралтанд зориулан төрөлжсөн танхимуудаас тусгай хөтөлбөрийн дагуу хичээллэсэн. Нийт 164 хүүхэд хамрагдаж, 1583 ирэгсдэд 2586 ном хэвлэл, мэдээ мэдээллээр үйлчилж, тусгай хөтөлбөрөөр сургалт зохион байгуулсан.
- ✓ “Ном” аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, зохиолч уншигчдын амьд харьцааг бий болгох, хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх, ном униших арга барилд төлөвшүүлэх зорилгоор “Зохиолчийн нэг өдөр” уулзалт арга хэмжээг хүүхдийн номын ордны салбар номын сангаас зохион явууллаа. Арга хэмжээнд хүүхдийн зохиолч, нийтлэлч П. Амаржаргал хүрэлцэн ирж, 15-р сургуулийн П. Энхтуяа багштай 7а ангийн хамт олон /30/ оролцов. Уулзалтын үер зохиогчийн гар бичмэл болон номуудаар үзэсгэлэн гаргаж, хүүхэд багачуудад танилцуулсан.
- ✓ МСҮТ-ийн багш, оюутан сурагчидад зориулан “Ном бол хүсэл мөрөөдлийг давах жигүүр мөн” сэдэвт ном унших арга зүйд төлөвшүүлэх лекцийг захирал Л. Мөнхбаатар хүргэлээ. Тус лекцийн үеэр ХНО-ны танилцуулга, номын тэмдэглэл хэрхэн хөтлөх талаар зөвлөмж хүргэж, " 60 секунт" хөгжөөнт уралдаан тэмцээн зохион явууллаа Нийт 11 ангийн 120 сурагч, оюутнууд, багш ажиллагсад оролцсон.

- ✓ **“**Өглөөний цайтай уншлага” арга хэмжээг нийт 6 удаа зохион байгуулж СӨБ-ын 1 цэцэрлэг, ЕБ-ын 4 сургууль оролцсон. Нийт 237 уншигч хүүхдүүд, багш эцэг эхийн төлөөлөл хамрагдсан.

“<u>Авьяас” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд:</u>

3 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөснөөс 3 арга хэмжээг зохион байгуулж, 1 арга хэмжээ уралдааны төсөв батлагдаагүйн улмаас зохион байгуулагдаагүй. Нийт 656 хүүхэд хамрагдсан. Үүнд:

- ✓ Цардмал талбайн зургийн уралдааны төсөв батлагдаагүй тул зохион байгуулаагүй.
- ✓ Дэлхийн болон Монголын хүүхдийн шилдэг бүтээлийг хүүхэд багачуудад таниулах сурталчлах, тэдний дунд уран уншлагын урлагийг хөгжүүлэх, дэмжин урамшуулах зорилгоор 2 жил тутамд зохион байгуулагддаг “Уран жиргээ-2019” наадам 2019 оны 10 дугаар сарын 20-нд 4 дэх удаагаа 4 насны ангилалаар амжилттай зохион байгуулагдлаа. Тус наадмыг Дархан-Уул аймгийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран зохион байгуулж, Хүүхэд хөгжлийн ордны дэргэдэх дууны болон “Өсвөрийн сэтгүүлч” дугуйлангийн сурагчид дэмжин тусласан.   “Уран жиргээ-2019” наадамд нийт 56 хүүхэд оролцсон. Сургуулийн ахлах насны ангилалд тэргүүн байр эзэлсэн Шарын гол сумын 6-р сургуулийн 11а ангийн сурагч Б. Нандинцэцэг нь “Уран жиргээ-20” улсын уралдаанд 3-р байранд шалгарсан.
- ✓ ЕБС-ийн хүүхэд багачуудын авьяас билиг, зохион бичих ур чадварыг хөгжүүлэх, дэмжин урамшуулах, өсвөр үеийнхнийг номтой нөхөрлүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Найргийн даага” оны шилдэг шүлэг шалгаруулах уралдаан 2019 оны 11 дүгээр сарын 17-нд зохион байгуулагдсан. Уралдаан 6-9, 10-12-р ангийн сурагчдын дунд 2 насны ангилалаар зохион байгуулагдсан. “Найргийн даага” яруу найргийн наадмын насны ангилал тус бүрд тэргүүн байр эзэлсэн шүлэгч хүүхдүүд “Хүрэл тулга-2020” болон аймгийн яруу найргийн “Алтан од” наадамд оролцох эрхтэй. Тус наадмыг Дархан-Уул аймгийн Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газар, МЗЭ-ийн Дарханы салбар хамтран зохион байгуулсан.
- ✓ Дархан хот үүсч хөгжсөний 58 жилийн ойг тохиолдуулан ЕБС-ийн 3-5-р ангийн сурагчдын дунд хүүхэд ан амьтныг хайрлах, хамгаалах, өөрийн дотоод ертөнц уран сэтгэмжээр чөлөөтэй илэрхийлж зурах, бүтээлч авьяасыг хөгжүүлэх зорилгоор бүхий “Миний хайртай амьтан гар зургийн уралдааныг зохион байгуулсан. Уралдаанд нийт 575 бүтээл ирсэн. Тэргүүн байранд Оюуны Ирээдүй цогцолбор сургуулийн 4-2 ангийн сурагч Ундармаа шалгарч, ОИЦ сургуулийн 4-2, 3-5, Од цогцолбор сургуулийн 5-2, 12-р сургуулийн 3а, 4а, 5б, Шарын гол сумын 2-р сургуулийн 3а анги хамт олноороо идэвх санаачилгатай оролцлоо.

Зорилт 6.1.6 “Дарханы иргэд оюунлаг, авьяаслаг” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

- ✓ Гэр бүлийн уншлага үйлчилгээний танхимын байнгын үйлчлүүлэгч, гэрээр ном авч уншдаг уншигчаас 9 гэр бүлийг “Оюунлаг гэр бүл”-ээр шалгаруулж урамшууллаа.

- ✓ Дархан сумын 9-р багтай хамтран “Тэргүүний уншигч гэр бүл” өдөрлөгийг тус багийн 10 гэр бүлийг оролцуулан зохион байгуулсан.
- ✓ Хүүхэд өсвөр үеийг номтой нөхөрлүүлэх, номын орчинг илүү өргөн хүрээнд хөхиүлэн дэмжих, хөгжүүлэх үйлсэд манлайлан, бие даан суралцан, өөрийгөө хөгжүүлэн танин мэдэх их үйлст сургууль, анги хамт олноо хошуучлан оролцож, “Тэргүүний уншигч-Д. Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангаж, номын сангаар тогтмол үйлчлүүлж байгаа 9-р сургуулийн Ц. Насантогтох багштай 7в анги хамт олон, 19-р сургуулийн Д. Цэцэгмаа багштай 5а анги хамт олон, Од цогцолбор сургуулийн Х. Одхүү багштай 7в анги хамт олон, ОИЦ сургуулийн Б. Саранчимэг багштай 4-2 ангийн хамт олныг тус тус “ОЮУНЛАГ ХАМТ ОЛОН”-оор тодруулан Их зохиолч Д. Нацагдоржийн мэндэлсэн өдрийг тохиолдуулан “ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ-Д.НАЦАГДОРЖ ТЭМДЭГТЭН”-ээр шагнаж урамшуулав.

Зорилт 6.1.12 “Хүүхдийн хөгжлийн ордон”-ы бүтээн байгуулалтыг үргэлжлүүлж, ашиглалтанд оруулна.

ХНО-ны салбар номын сан нь тус ордонд 22 суудалтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Салбар нь хуучин Дарханд байрлах ЕБС, СӨББ болон иргэд насанд хүрэгчдэд номыг сангийн үйлчилгээ үзүүлдэг. 2019 онд тус ордонтой хамтран ЕБС-ийн 6-р ангийн сурагчдын дунд “Speelling Bee” англи хэлний уралдаан, “Уран жиргээ” уран уншлагын уралдаан, “Найргийн даага” оны шилдэг шүлэг шалгаруулах яруу найргийн наадам”, “Дүрийг хэн сайн амилуулах вэ” дүрийн тоглолттой уншигчдын бага хурал зэрэг арга хэмжээнүүдийг хамтран зохион байгуулсан.

Салбар номын сангийн уншлага үйлчилгээний үндсэн үзүүлэлт:

- ✓ 1712 байнгын уншигч,
- ✓ 11363 ирэгсдэд,
- ✓ 17598 боть ном, хэвлэл олгож үйлчилсэн.

Урьд онтой харьцуулж үзвэл: Уншигч 0.7%-иар өсч, ирэгсэд 9.2%, ном олголт 14.9%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зорилт 6.1.13 Мэргэжлийн болон сумдын соёл, урлаг, спортын байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, хүний нөөцийн чадавхийг сайжруулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- ✓ Дархан-уул аймгийн засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Хүүхдийн номын ордонг “Цахим номын сан” болгох арга хэмжээний хүрээнд Номын сангийн үйлчилгээг цахимжуулах 8,000,000 төгрөгийн өртөг бүхий компьютер, каталогийн шүүгээ, тоног төхөөрөмжүүдийг суурилуулан, хэвийн ажиллагааг хханган ажиллаж байна.

- ✓ 2019.03.20. Байгууламжийн гадна болон дотор орчны аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгслийг /хяналтын камер/ суурилуулах,

цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох зорилгоор ажиллагсдын бүтээлч санал санаачлагын хүрээнд 6 ш иж бүрэн камер авч суурилуулав.

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛИЙН ХҮРЭЭНД:

2019 оныг гэр бүлийн хөгжлийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан байгууллагын / ХНО-ны / эцэг эхийн зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Уншигчдын дунд:

- ✓ **2019.02.23.** Од цогцолбор сургуулийн Одхүү багштай 6в ангийн сурагчид, эцэг эхчүүдтэй хамтран "Оюунлаг гэр бүл" өдөрлөг зохион байгууллаа. Өдөрлөгөөр ХНО-ны үйл ажиллагаатай танилцах, Гэр бүлийн уншлага үйлчилгээний танхимын талаар мэдээлэл хүргэх, ном унших арга барилд сургах, ном хэрхэн уншдаг талаар өөрийн туршлагаасаа хуваалцах, номын тэмдэглэл хэрхэн хөтлөх талаар заавар зөвлөмж өгөх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж мөн 15 минутын уншлага зохион байгуулан уншсан сэдвээ харилцан ярилцаж амралтын өдрийг үр бүтээлтэй өнгөрүүллээ.
- ✓ **2019.IV.02** Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд Үлгэрийн хаан Х.Х. Андерсаны мэндэлсэн өдөр, дэлхийн хүүхдийн номын өдрийг тохиолдуулан "Гэр бүлээрээ номын санд" уншлагыг "Төгс-Ундраа цэцэрлэгийн Нархан бүлгийн / 18 / багачууд, аав ээж багш нартай хамтран зохион байгууллаа. Уншлагаар үлгэрийн их хаан Х. К Андерсены номын үзэсгэлэн гаргаж, Дэлхийн хүүхдийн зохиолч Х. К Андерсены танилцуулга, үлгэрийн номуудаар чанга уншлага хийн, эцэг эх багш нартайгаа харилцан ярилцах, үлгэр зохиох, мөн ХНО-ны танилцуулга хийх зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа
- ✓ **2019.05.05** ОУ-ын гэр бүлийн өдрийг тохиолдуулан эцэг эхтэйгээ чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, гэр бүлийн халуун уур амьсгалыг бүрдүүлж, хүн бүрт хүүхэд бүрийг хайрлах, гэр бүлээ хүндлэн дээдлэх эерэг сэтгэлгээг төлөвшүүлэх, ном унших чиг хандагыг төлөвшүүлэх, гэр бүлийн уншлага үйлчилгээний танхимын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Гэр бүлийн уншлага үйлчилгээний танхимд байнгын үйлчлүүлэгч, гэрээр ном авч уншдаг уншигчаас 9 гэр бүлийг "Оюунлаг гэр бүл"-ээр шалгаруулж урамшууллаа. Гэрээр тогтмол ном авч уншдаг "Оюунлаг гэр бүл"-ээр А. Итгэлсайхан, Б. Хан-Эрдэнэ нарын гэр бүл шалгарч, нийт 87 ном уншсан байна. Танхимаар байнга үйлчлүүлдэг 6 гэр бүл нийт давхардсан тоогоор 168 удаа хүрэлцэн ирж, 614 боть номоор үйлчлүүлсэн байна. Эдгээр "Оюунлаг гэр бүл"-үүд номын сангаар тогтмол үйлчүүлсэний үр дүнд ном уншихын ач холбогдлыг ойлгож, хүүхдүүдийн хэл ярианы хөгжил, сэтгэн бодох чадвар тодорхой хэмжээнд хөгжиж, өөрийгөө илэрхийлэх чадвартай болсон.
- ✓ **2019.05.15.** Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд Аймгийн ЗДТГ, Төв номын сан, Гэр бүл, хүүхэд, залуучуулын хөгжлийн газар, "Гал голомт" үндэсний хөдөлгөөний Дархан-уул аймгийн салбар хүрээнээс хамтран зохион байгуулсан "Монгол гэр бүлийн ширээний ном"-ын агуулгаар хийсэн уншигчдын бага хуралд номын санч мэдээллийн ажилтан Ч. Буяннэмэх, С. Оюунцэцэг, Т. Цэрэннадмид нар

оролцов. Тус бага хуралд "Монгол гэр бүлийн ширээний ном"-ыг уншиж судлан түгээн дэлгэрүүлэх, харилцан бие биенээсээ суралцах, гэр бүлийн харилцаа соёл, эрүүл мэнд, эрх зүйн мэдлэг олгох зэрэг сэдвүүдээр илтгэл тавьж хэлэлцүүлсэн.

- ✓ **2019.06.13-16**Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан өөрийн сан хөмрөгийг олон нийтэд сурталчилах, номын эргэлтийг сайжруулах, уншигчдыг хэрэгцээт мэдээллээр хангах зорилгоор гэр бүлийн хөгжил, ургийн бичиг хөтлөх зэрэг сэдэв, чиглэлийн номуудаар сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 19 боть номоор шилэн хоргонд гаргаж олон нийтэд дэлгэсэн. Мөн цахим хуудсандаа байршуулж 196 хандалттай байсан байна.
- ✓ Аймгийн "Ном" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд гэр бүлийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, гэр бүлээрээ чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, номын тусламжтайгаар гэр бүлийн бүтээлч ажлыг хөгжүүлэх нөхцөл боломжоор хангах зорилгоор Дархан сумын 9-р багтай хамтран **"**Шилдэг уншигч гэр бүл" арга хэмжээг 2019.11.23- ны өдөр зохион явууллаа. Арга хэмжээнд 9-р багийн засаг дарга Б. Нэмэхбаяр, 9 гэр бүлийн 39, нийт 46 хүнийг хамарсан үйл ажиллагаа болсон.

<u>СПОРТЛОГ ДАРХАНЧУУД ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:</u>

- ✓ Аймаг, хотын номын санчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг спортын 6 төрлийн тэмцээн 2019 оны 04 сарын 26-28 өдрүүдэд Орхон аймагт болж, 16 аймаг, хотын 190 гаруй номын сангийн тамирчид 123 багц медалын төлөө өрсөлдлөө. Тус тэмцээнд баг хамт олноороо амжилттай оролцсон.
- ✓ Эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад, бэрхшээлийг даван туулах бие, сэтгэлийн тэсвэр хатуужилтай шинэ үеийг бий болгох зорилгоор байгууллагын 16 ажиллагсдыг тусгай асуулга, хийж гүйцэтгэх даалгавар бүхий үзүүлэлтүүдээр бие бялдарын сорилд хамруулсан. Сорилын дүнг ажилтан тус бүрийн е-майл хаягаар илгээсэн.
- ✓ Хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, эрүүл зөв амьдралыг эрхэм болгох, бага хамт олны уур амьсгалын бүрдүүлэх, дасгал сургуулалтыг идэвхжүүлэх зорилгоор 7 хоног бүрийн пүрэв гарагт ОИЦ сургуулийн биеийн тамирын зааланд гарбөмбөгөөр хичээллэж байна.
- ✓ Эрүүл мэндийн багцын үзлэг шинжилгээнд 76% буюу 13 хүн хамрагдсан
- ✓ Монголын Соёл урлагийн ажилтны 26 дахь өдрийг тохиолдуулан Дархан-Уул аймгий Соёл урлагийн байгууллагуудын ажиллагсдын дунд зохион байгуулсан Спортын арга хэмжээнд 5 төрлөөр амжилттай оролцож, багийн дүнгээр Хүрэл медаль хүртсэн. Үүнээс: Шатрын төрөлд эрэгтэй тамирчдаас М. Чойжамцан алтан медаль, эмэгтэй тамирчдаас Н. Мөнгөншагай мөнгөн медаль, Дартсын төрөлд Л. Мөнхбаатар хүрэл медаль тус тус хүртсэн байна.

<u>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:</u>

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, санхүүгийн ил тод байдлыг хангах үүднээс санхүүгийн мэдээллийг бүтэн жилээр 5, хагас жилээр 4, улирал тутам 4, сар бүр 44,

тухай бүр сард 96, мэдээлэл, бүгд 153 мэдээлэл оруулсан. Төсвийн ил тод байдлын самбарт сар бүр мэдээллийг тухай бүр тогтмол гаргаж ажилласан.

2. Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын тогтмол болон урсгал зардлын гүйлгээг тогтмол хийж, цалин хөлсний нэмэгдэлд 121.184,4 /сая.төг/, бараа үйлчилгээний бусад зардалд 77.526,5 /сая.төг/ нийт 198.710,9 сая төгрөгийн төсөв гүйцэтгэлтэйгээр 2019 оны санхүүгийн жилийг дуусгалаа.

3. Төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон нийгмийн даатгалын тайланг сар бүр, татвартай холбоотой тайланг улирал бүр харьяа дээд шатны байгууллагуудад тайлагнаж хүргүүлсэн.

4. 2020-2022 оны төсвийн төслийг БСУГ-т, 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг Дархан сумын төрийн санд гаргасан хуваарийн дагуу тайлагнасан.

5. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх тайлагнах журамд зааснаар 1, 2, 3, 4 дүгээр улирлын худалдан авах ажиллагааны тайланг орон нутгийн өмчийн газарт тайлагнаж, 2020 оны төсвийг www.tendergov.mn цахимд төлөвлөгөөг байршуулсан.

6. Дархан-Уул аймгийн Хүүхдийн Номын ордны 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тухай Дархан-Уул аймгийн Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Чүлтэмбатаас ирүүлсэн 2019.02.25-ны өдрийн 167 тоот албан бичигт:

“Дархан-Уул аймгийн Хүүхдийн номын ордны 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББҮУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого журам зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.” гэсэн дүгнэлтийг ирүүлжээ.

<u>АРХИВ АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛ, НЯРАВЫН АЖЛЫН ТАЛААР:</u>

Архив, бичиг хэргийн ажлын хүрээнд: Нийт А тушаал 32, Б тушаал 12 төлөвлөн хянуулж, 65 бичиг боловсруулж холбогдох газруудад хүргэсэн байна. Гадна байгууллагаас 27 албан бичиг ирж холбогдох хүмүүст танилцуулан бүртгэж авсан.

- ✓ Able cloud байгууллагын удирдлагын программ, цахим хаягт ирсэн бичиг, захидлуудыг цаг тухай бүрт нь танилцуулж байна.
- ✓ Архивын хадгаламжийн нэгжид тооллого хийж, чийгшил дулаан хэмжигчийн заалтыг бүртгэн хяналт тавьж байна.
- ✓ Ажилтан албан хаагчдын 17 хавтаст хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлж, жигдрүүлсэн.
- ✓ Хурлын тэмдэглэл хөтөлж батлуулан ХН бүрдүүлж байна.
- ✓ Байгууллагын 2019 онд ХХНЖ-ийг боловсруулж батлуулсан.

- ✓ 2018 оны ирсэн бичиг, явуулсан бичиг цэгцлэн үдэж ХН үүсгэн байгууллагын архивт шилжүүлэн бүртэгсэн.
- ✓ 2019 оны баримт бичгүүдийг цэгцлэн үдэхэд бэлдэж байна.

Санхүүгийн ажлын хүрээнд: Сар бүрийн эхэнд цэвэрлэгээний материал мөн тухай бүрийн ажил, арга хэмжээг шаардагдах материалаар хангаж ажилласан.

Үүнд:

- ✓ Байгууллагын урсгал засварт шаардагдсан бараа материал;
- ✓ Архив, бичиг хэргийн үйл ажиллагаанд болон шалгалтад бэлдэхэд шаардлагатай бичиг хэргийн материал;

Сар бүрийн эцэст:

- ✓ Бараа материалын орлого, зарлагын тайлан;
- ✓ Шатахууны зарцуулалтын тайлан;
- ✓ Бэлэн мөнгөний орлогын тайлан гаргасан.
- ✓ Уншлагын болон төрөлжсөн танхимуудын уншигчийн картны орлогыг номын санчдаас хүлээн авч долоо хоног бүр "Төрийн сан банк"-ны 100190035032, 100190135032 тоот дансуудад тушаасан. /Нийт 4,740,000 төгрөг/ /Банкины хуулгын үнэ 32*500=16,000 төгрөгийг өөрөөсөө гаргасан/
- ✓ Бараа материал, болон ном, хөрөнгийн хагас жилийн болон жилийн эцэсийн тооллогыг комиссын гишүүдийн хамт хийж .
- ✓ Элэгдлийн хугацаа дуусч ашиглалтын шаардлага хангахгүй болсон эвдэрч гэмтсэн хөрөнгүүдийг ялган актлуулахаар хөрөнгийн зураг, жагсаалтыг гаргаж хавсарган ДУА-н ОНӨГ-т хүргэсэн.
- ✓ Сар бүр дулаан, усны тоолуурын заалтыг хянаж, байцаагч нарт бичүүлж нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлсэн.
- ✓ Хаан банк дахь харилцах, дансны хуулгыг сар бүрийн 1-ний өдөр багтаан авч нягтлан бодогчид өгдөг.

<u>Бусад арга хэмжээний талаар:</u>

Засвар үйлчилгээ хийх, өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж ажилласан.

Цэвэрлэгээ, засвар, тохижилт:

- ✓ Гадны орчны болон нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээг тогтмол хийж, бүх нийтийн цэвэрлэгээ, цас мөс арилгах арга хэмжээнүүдийг тухай бүр зохион байгуулж ажилласан.
- ✓ Мод бутыг 3-4 удаа тэгшлэн тайрч, зэрлэг ургамлыг 4-5 удаа зулгааж хогийн цэгт хаясан.
- ✓ Цэцэгжүүлэлт хийсэн.
- ✓ Уншлага үйлчилгээний-1 танхим, номын фонд, 102 тоот, 3 давхрын ариун цэврийн өрөөнүүдэд их засвар хийсэн.

- ✓ Ордны хаалга, түгжээ, хаяг, мэдээллийн самбар, танхимуудын цоож, ширээ, сандалуудын эвдрэл гэмтэл, хана таазны бэхэлгээг тухай бүр хийж хэвийн ажиллагааг хангасан.
- ✓ Камер, хяналтын хаалга суурилуулсан.
- ✓ Ордны урд авто замын хонхорт шороо буулгаж тэгшилсэн.
- ✓ Галын хоруудыг цэнэглүүлсэн.

Сантехник, цахилгааны засвар:

Барилгын дулаан хангамж, цэвэр, бохир усны систем, цахилгаан, засвар тохижилтын ажлыг гүйцэтгэж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.

- ✓ Сантехник: Сальник, крант, жорлонгийн хөвүүр, сангийн шугамын тунгаагуур шинээр солих, ялтсан бойлерын 5 ширхэг монометрийг авч баталгаажуулах, цэвэр усны шугам цоорсныг гагнуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн .
- ✓ Цахилгаан: Талбайн гэрэлтүүлэг засварлах, шатсан гэрлүүдийг солих, цахилгааны утаснуудад далдлагч хийх зэрэг ажлуудыг тухай бүр хийж гүйцэтгэсэн.

Автомашин:

Ордонд АЗДТГ-аас хуваарилагдан ирсэн тусгай зориулалтын Хьюндай Старекс автомашины энгийн суудлын болгон өөрчилж тоноглоход дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- ✓ Дотор талын тоног төхөөрөмжийг салгаж авсан.
- ✓ Цахилгааны утас салгуулж далдалсан.
- ✓ Лист төмрөөр шал хийлгэж будсан.
- ✓ Авто машины дохиоллын гэрлийг салган авч онгорхой хэсгийг төмрөөр битүүлж будсан.
- ✓ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн цахилгаан монтажийг салгаж авсан.
- ✓ Гадна талын хуулга хуулж улсын дугаарыг тогтоосон.
- ✓ Өвлийн дугуй авч сольж тавьсан.
- ✓ Тос, масло, тосоол сольсон.

Олон нийтийг хамарсан үйл ажиллагаа:

- ✓ МУ-ын ЗГ-ын 2011 оны 339, 340-р тогтоолын хэрэгжилтийг хангаж “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио” г улс орон даяар 2019.03.21-ний өдрийн 16:00 цагт дамжууллаа. Тус үйл ажиллагаанд Хүүхдийн номын ордны ажилтнууд уншигчидтайгаа аюулгүй байдлыг ханган барилгаас гаран аюулгүй газарт шилжлсэн.

- ✓ Дархан хот байгуулагдсаны 58 жилийн ойн баярт зориулан зохион байгуулсан Дархан хотын сүлд дуу “Найрамдлын Дархан” дууны хүндэтгэлийн жагсаалд байгууллага хамт олноороо оролцсон.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

№	Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
1.	2.	3.
1.	Байгууллагыг мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангах, нийгмийн баталгааг сайжруулах талаар бүх талын дэмжлэг үзүүлэнэ.	1. Манай байгууллага мэргэжлийн боловсон хүчнээр 95% хангагдан ажиллаж байна. Байгууллагын захиргаа байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран жилд нэг удаа хоёр ажилтанд 50,000, 50,000 төгрөгийг нийгмийн баталгааг хангах үүднээс олгож байна. 2. Дорноговь аймгийн засаг даргын 2019.01.15-ны өдрийн 1/75 тоот албан бичгийг үндэслэн 0-5 насны хүүхэдтэй 2 албан хаагчид цалинтай 3, 3 хоногийн чөлөөг олголоо. 3. Аймгийн Засаг даргын 2019 оны 09 сарын 02-ны өдрийн А/697 дугаар захирамжийг хэрэгжүүлж нэг ажилтанд чөлөө олголоо байна. 4. Ар гэрийн гачигдал, өвчний улмаас улаанбаатар хотод шинжилгээнд орох шаардлагатай албан хаагчдад тухайн хугацааны өдрийн цалинг олгож байна. 5. Байгууллагын албан хаагчдад эрүүл мэндийн шалтгаанаар нэгдсэн эмнэлэгт өдрийн эмчилгээнд орсон 3 ажилтанд цалинтай чөлөө олголоо.
6.	Соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр ажил зохион явуулана.	1. MNS ISO 11799:2007 Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага стандартыг ханган ажиллаж байна. 2. Номын фондын өрөөнд чийгшлийг хэвийн байлгах зорилгоор саванд ус хийж тавих, зориудаар чийгшүүлэлт хийх зэргээр хадгалалт хамгаалалтыг хангаж байна. Мөн нарны шууд тусгалаас хамгаалж хар хөшиг татах, өрөөг лацдах, орсон гарсан хүний бүртгэл хөтлөх гэх мэт аргаар номыг хадгалж хамгаалах стандартыг хэрэгжүүлж байна. 3. Үйлчилгээнд гарч гэмтсэн, урагдсан ном хэвлэлийг сэлбэн засаж байна. 516 ном, хэвлэлийг сэлбэн зассан байна. 4. Номын сангийн үндсэн фонд, гэрээр ном олгох тасгийн фонд, хэвлэлийн фонд, байгууллагын архивын өрөөнд чийг дулаан хэмжигч байрлуулж өдөр бүр заалтыг дэвтэрт бүртгэж байна. 5. Номын сангийн үнэт ховор номыг хадгалж хамгаалах зорилгоор Аймгийн ахмадын хороотой хамтран Ганжуур, Данжуур, Сүмбэн судрууд болох 35

		номонд баринтаг оёж баринтаглан гадны нөлөөллөөс хамгаалсан хөшиг хийж татсан. 6. Фондын үнэт ховор номыг тоос шорооноос хамгаалан татсан хар хөшгийг сард 2 удаа угааж тоосонцроос сэргийлж байна. **7.** Номын сангийн фондуудаас урагдаж гэмтсэн номыг ялган **1650** номыг сэлбэн засаж уншлаганд гаргалаа. 8. Номын сангийн хүлээн авах хэсэгт номын үзэсгэлэнгийн шилэн хоргонд жангар, Сүмбэн судар, таван хэлний толь бичиг гэх мэт ховор номыг байрлуулан сурталчилж, шинээр ирсэн болон **сэдэвчилсэн номын үзэсгэлэнгүүд**ийг гаргаж байна. **Үзэсгэлэнд 2756 ном гаргаад байна.**
7.	Хүүхэд багачуудын үндэсний хэл, соёл, уламжлал, зан заншлаас суралцах өвлүүлэн хөгжүүлэх чиглэлээр соёлын олон талт ажлыг зохион байгуулана.	1. Уламжлалт зан заншлаа сурталчилах монгол ёс заншлын талаар мэдлэг сорьсон болон шагайн наадгайг төрийн бус байгууллагын дунд ХААН банктай хамтран зохион байгуулж 9 байгууллагын 100 гаруй хүн оролцсон. 2. Гэр бүлийн уншлагын танхимд монгол ёс заншлын булан байгуулж монгол гэр барих, шагайгаар наадах 10 төрлийн тоглоом, оньсон тоглоомуудыг хэрхэн тоглох тухай болон ёс заншлын ном түүнээс оньсого таах, ерөөл магтаалын үг цээжлэх, ертөнцийн гурваас цээжлэх зэрэгт байнга сургаж сурталчилан ажиллаж 100 гаруй гэр бүл хамрагдсан байна. 3. “**Ардын уламжлалт зан заншлаа дээдлье**” аяны хүрээнд **4 дахь жилдээ** “**ДӨРВӨН БЭРХ**” тэмцээнийг зохион байгуулж байна. Оролцсон хүний тоо-35 4. Монгол зан заншлыг сурталчилж аймгийн төвийн цэцэрлэгүүд, ахмад настны асрамжийн газрын ахмадуудад үлгэр уншиж өгөх, домог яриа ярьж өгөх зэрэг ажлуудыг зохион байгууллаа. Хамрагдсан хүний тоо-362 5. 9 дүгээр цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд “Болдоггүй бор өвгөн” үлгэрээр чанга уншлага хийж хүний сайн муу араншин, ач тусын талаар яриа хийлээ. 6. Улаанбаатар хотод зохион байгуулсан ДОРНОГОВЬ-СОЁЛЫН өдрүүдэд оролцож орон нутгийн 60 гаруй зохиолчдын 350 –аад номын үзэсгэлэн гаргалаа.

8.	Соёл, урлагийн салбарт ажиллагсдын мэдлэг дээшлүүлэх сургалт, семинарыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн зохион байгуулана.	1. МҮНС, Монголын номын сангуудын консерциумтай хамтран АЗДТГазрын дэмжлэгтэй Хөдөө орон нутгийн соёлын төвийн номын санчдыг хамруулан “НОМЫН САН ОДОО БА ИРЭЭДҮЙ” сургалтыг зохион байгууллаа. Хамрагдсан номын санч-28 2. Г.Баттогтох, С.Цолмон нар Улаанбаатар хотод болсон АНУ-ын элчин сайдын яамнб соёл мэдээлэлийн төвөөс зохион байгууласан АМЕРИКИЙН ТӨВИЙН АЖИЛТАН НОМЫН САНЧДЫГ ЧАДВАХЖУУЛАХ нь 3 хоногийн сургалтад хамрагдлаа. 3. Номын санч Г.Баттогтох МҮНСангаас зохион байгуулсан НИЙТИЙН НОМЫН САН АРГА ЗҮЙН ТӨВ БОЛОХ НЬ сэдэвт нэг өдрийн сургалтад хамрагдлаа. 4. Номзүйч, архи, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан Б.Эрдэнэтуяа нь аймгийн архивын тасгаас ДОРНОГОВЬ АЙМГИЙН СУМ БАЙГУУЛЛАГУУДЫН АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ ХАРИУЦСАН АЖИЛТНУУДАД зохион байгуулсан 2 өдрийн мөн Д.Алтанчимэг, А.Гансүрэн нар Үндэсний номын сангаас зохион явуулсан тус бүр сургалтад хамрагдлаа. 5. Хүний хөгжлийн жилийн хүрээнд байгуллагын ажилчид болон түүний ар гэрийнхэнд Аймгийн Саран хөхөө театраас зохион байгуулсан хувь хүний хөгжлийн тухай лекцэнд бүх ажилчдыг хамрууллаа. 6. Соёмбо салбар номын санд **Англи хэлний үнэ төлбөргүй сургалт** 7 хоногт 2 удаа хичээллүүлж нийт 40 гаруй хүнийг сургаад байна. **Нийтдээ таван номын санч Улаанбаат хотод, хөдөө сумын номын санчдаа 90 хувь аймгийн төвд мэргэжлийн дагуу сургалтад хамруулсан байна.**
9.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш хамруулах зорилгоор соёл урлагийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэнэ.	1. Жил бүрийн 12 сарын 03нд болдог ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ өдрөөр Сайншанд сумын 11-цэцэрлэгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ангид өдөр дутмын ахуй хэрэглээний зүйлээр хандив өгөв. 2. Мөн “Багц ном”- оор Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах өдрөөр 2 айлд гарын бэлэг хүргэж өгч сэтгэлийн дэм өглөө. 10 хүн

		3. 3 иргэнд “Номын багц” номыг гэрт нь хүргэж өгч зөөврийн номын сангаар үйлчиллээ.
10.	Батлагдсан төсвийн төлөвлөгөөг биелүүлэх, давсан орлогыг зарцуулах хүсэлтийг журмын дагуу шийдвэрлэх арга хэмжээ авна.	1. Байгууллагын төсвийг зориулалтын дагуу зарцуулж өр авлага гаргахгүй үйл ажиллагааг хэвийн явуулж байна. 2. Байгууллагын үйл ажиллагааны давсан орлогыг журмын дагуу зарцуулж байна. 3. Шилэн дансанд байгууллагын санхүүгийн тайланг журмын дагуу оруулж байна.
11.	Хүүхдийн уншлагын “Үлгэрийн цаг” тогтмол уншлагын цагтай болж, уншигч хүүхдийн тоог нэмэгдүүлнэ.	1. Дорноговь аймаг 2019 оныг “Гэр бүлийн жил” болгон зарласантай холбогдуулан “Гэр бүлийн уншлагын танхим”-ыг Даваа-Бямба гараг бүр 8-17 цаг хүртэл ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар 1532 ирцэд 2865 ном олгож үйлчилсэн байна. Мөн энэхүү гэр бүлийн уншлагын танхимд албан байгууллагын ажилчдын гэр бүлийг урьж төрөл бүрийн хөгжөөнт оюуны тэмцээн уралдаануудыг явуулж байна. 2. Амралтын өдөр хүүхдүүд эцэг эхтэйгээ оролцож Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх боломжтой англи хэлээр үлгэр сонсох “Үлгэрийн цаг”-ийг хагас сайн өдөр явуулж байна. 3. Япон улсаас монгол улсад суугаа сайн дурын ажилчидтай холбогдон япон хэлээр үлгэр сонсох, кино үзэх цаг булан байгуулж 7 хоногт тогтмол цагаар ажиллаж байна.
12.	Номын сангийн баяжилтыг улирал тутам хийж, сумдын номын санчидтай гэрээ хийсний үндсэн дээр алслагдсан сумдын иргэдэд зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэнэ	1. Зөөврийн номын сангаар ХХБ, ХААН банк, Цагдаагийн газар, ЕБ-ын 3,5 –р сургууль, АШУҮИС, 9,10 дугаар цэцэрлэг НДХ, УЦУОШТ, МСҮТ, Алтанширээ, Сайхандулаан, Зүүнбаян, Даланжаргалан, Хатанбулаг, Хөвсгөл сумдад **Зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэж нийт 11 байгуллага 6 суманд хүргэж 57 удаа 1290 ном олгож 1500 гаруй хүнд үйлчилсэн. Зөөврийн номын сангаар үйлчлүүлэх байгууллага жил дутам нэмэгдэж байна. 2018 онд 8 байгууллага байсан бол 2019 онд 11 болж өссөн нь мөн үйлчлүүлэгчийн тоо нэмэгдэж байгаа юм.**
13.	Уншлагыг дэмжих олон талт арга хэмжээ зохион байгуулж номын сангийн үйлчлүүлэгчдийн уншигчдын тоог нэмэгдүүлэх	1. Зөөврийн номын үйлчилгээг идэвхжүүлж номын сангаар үйлчлүүлэгчдийн орчин нөхцөлд анхааран гэр бүлийн чөлөөт уншлагын танхим байгуулж номын санчдад бүтээлч орон зайг хөгжүүлэх талаар мэдлэг мэдээлэл өгч

		мөн хөдөө сумдаар номын үзэсгэлэн гаргаж зохиолчдын уулзалт ярилцлага хийж байна. Сайхандулаан, Их хэт, Дэлгэрэх сум болон Аймгийн цагдаагийн газарт уншигч зохиогчийн уулзалт хийлээ. 2. Олон улсын хүүхдийн номын өдрөөр 4 дүгээр цэцэрлэгийн О.Алтанзул багштай Дунд бүлгийн хүүхэд багачууд номын сантай танилцаж оюуны тоглоомоор тоглож наадлаа. Данийн хүүхдийн зохиолч Х.Андерсений зохиол бүтээлээс танилцуулж "Ухаант хэрээ" үлгэрээр чанга уншлага явуулж хүүхэд багачууд үлгэрийн тухай харилцан ярилцлаа. 3. ХХБанкны ажилтан, албан хаагчдад "Ном уншихын ач холбогдол" сэдвээр танилцуулга,танин мэдэхүйн номоор тойм яриа хийлээ. Албан хаагчдад уншигчийн карт нээж, онч сургаал үгсээр "Оюуны чихэр" түгээлээ. 4. Цүбаса ХХК-н харъяа "АТЛАС" сургалтын төвийн гүйцэтгэх захирал Оокума Юү-Ичи Соёмбо номын сантай танилцаж, Япон хэлийг шимтэн суралцаж буй хэлний клубын сурагчидтай ярилцаж, хийсэн бүтээлийг нь сонирхож, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. 5. УЦУОШТ, ХХБ, ХХҮХ, 10 дугаар цэцэрлэгийн албан хаагчдад ном уншихын ач тус, холбогдлын тухай танилцуулга, яриа хийсэн. 6. Шинэ номын болон тэмдэглэлт өдрүүд болон сэдэвчилсэн үзэсгэлэнг 46 удаа гаргаж фондын номоо сурталчилсан. 7. Соёмбо салбар номын санд Англи болон Япон хэлний анхан шатны сургалтуудыг явуулж байна. 8. Австрали, Солонгос. Америк, Япон улсад сурч боловсрох, гэр бүлээрээ ажиллаж амьдрах талаар холбогдох сайн дурын ажилтан нараар яриа, сургалтуудыг зохион байгууллаа. 9. Тархи цэнэглэгч номын клубын 2 дахь удаагийн уулзалтаар “Өглөөний гайхамшиг номны хэлэлцүүлэг зохион байгууллаа. 10. ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан " Ээждээ барих миний бэлэг" бүтээлийн уралдааныг 3 дах жилдээ зохион явууллаа. 11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байранд хоригдож байгаа сэжигтэн, ялтан, яллагдагч нарын дунд "Үрсийн зүрхний үг" захидал бичих уралдааныг уламжлал болгон 5 дахь жилдээ Олон улсын эмэгтэйчүүдийн баяр, Эх үрсийн баярын өдрийг тохиолдуулан 2 удаа

		зохион явуулав. Захидлын уралдаанд 50 хүн оролцсон. 12. Дэлхийн яруу найрагчдын өдрөөр МЗЭ-ийн “Хурмаст тэнгэр” төвийн яруу найрагчидтай Уншигч-Зохиолчдын уулзалтыг хийв.
14.	Ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвийн болон орон нутаг дахь номын сангаар үйлчлүүлсэн хүүхдийн тоо	1. Дорноговь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сумын сургуулийн номын сангууд, соёлын төвийн номын сангууд, аймгийн төв болон их дээд сургуулийн номын сангууд нь **НИЙТ 79123 ИРЦЭД 68675 НОМ ОЛГОЖ** үйлчилсэн байна. 2. Үүнээс Аймгийн төв номын сан нь **1319** уншигч, **16079** ирцэд **23205** ном олгож үйлчилсэн байна.
	ХОЁР. “Хөгжлийн төлөө хамтдаа” хөтөлбөрийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр арга хэмжээ	
15.	Номын сангийн номын фондыг нэмэгдүүлэн үйлчилгээг цахимжуулж, соёл, урлагийн байгууллагуудын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэнэ.	1. Аймгийн төв номын сан н 2019 онд 238 ширхэг 4,228,399 төгрөгний төрөл бүрийн шинжлэх ухааны салбарын номоор сан хөмрөгөө баяжууллаа. Номын үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор худалдаагаар 2018 оны ном худалдан авсан тоо 2019 онд буурсан үзүүлэлттэй гарсан. Ийм манай байгууллага ном цуглуулах хандив өрнүүлж шинэ номын баяжилтын тоог 2018 оны тоонд хүргэж чадсаан. Цаашид шинэ ном худалдан авах төсвийг нэмэх шаардлагатай гэж үзэж төсвийн төсөлд санал оруулсан болно. 2. Номын сангийн уншигч бүртгэх, ном олгох, ном хайх гэх мэт үйлчилгээнүүдийг цахим хэлбэрээр хүргэж байна. Гэвч хайлтын компьютер дутагдалтай, дохиоллын хаалгагүй чөлөөт сонголтоор үйлчлэхэд ном алдах эрсдэл маш их байна. Гэвч сүүлийн үеийн шинэлэг тохь тухтай үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна. 3. Байгууллагын зохион байгуулсан ажлуудыг “ДОРНОГОВЬ ТӨВ НОМЫН САН” Facebook хуудсанд байрлуулж иргэдэд сурталчилж байна.
	“Номын сангийн үйл ажиллагааны зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ”	
16.	Шинэ санаа- Бүтээлч ажил	1. Дорноговь аймгийн Төв номын сан нь Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн 2019 оны 06 сарын 10-ны өдрийн 45 дугаар тогтоолоор СГЗ Арлааны Эрдэнэ-Очирын нэрэмжит номын сан болсон нь түүхэн үйл явдал юм. 2. Гэр бүлийг дэмжих жилийн хүрээнд байгууллагын шилдэг гэр бүлээр номын санч Э.Цэндсүрэнгийнхийг шалгаруулж түүний хүү П.Хангалын

		нэрэмжит шатрын тэмцээнийг зохион явууллаа. 3. Байгууллагын ажилчдын гэр бүлийн дунд спортын арга хэмжээ зохион байгуулж түрүүлсэн нэг гэр бүлийг шагнаж урамшууллаа. 4. Эх үрсийн баярыг тохиолдуулан "**Ном болон тоглоомын солилцоо**" өдөрлөг, номын үзэсгэлэн гаргаж хүүхэд багачуудад үйлчиллээ. Хамрагдсан хүний тоо-130 5. 2019 оныг гэр бүлийн жил болгон зарласантай холбогдуулан “Гэр бүлийн уншлагын танхим”-ыг ЗДТГазартай хамтран тохижуулж, оюуны тоглоом, үлгэрийн ном, орчны тохь тухыг ханган албан байгууллага, хамт олон, гэр бүлүүдийг урьж, тэдэнтэй яриа өрнүүлэн, тэмцээн уралдаан зохион байгуулан ажиллаж байна. Гэр бүлийн танхимаар 1532 ирцэд 2865 ном олгож үйлчилсэн байна.
17.	Дэлхийн номын өдөр, бичиг үсгийн баярыг өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүлнэ.	1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, эх хэл, бичиг үсгээ эрхэмлэн дээдлэх, бичиг соёлын дурсгалаа сурталчлах, олон түмэнд таниулах зорилгоор Дэлхийн номын өдөр, Үндэсний бичиг үсгийн баярыг Аймгийн БСУГ, МОНЦАМЭ агентлагийн Хүмүүн бичиг сонины редакцтай хамтран тэмдэглэлээ. Энэ үеэр монгол бичгийн өв соёл, уран бичлэгийг олон нийтэд таниулан сурталчилж Аймгийн Төв номын сангаас Дэлхийн шилдэг ном болон ховор хуучин номын үзэсгэлэн гаргасан. Мөн Сайншанд сумын ЕБ-ын V сургууль, МСҮТ-ийн номын сангууд мэргэжлийн холбогдолтой болон шинэ номоор үзэсгэлэн гаргалаа. Төв номын сангаас иргэдийн дунд зарласан “Ном бидний нөхөр” гар зургийн уралдаан, “Номтой хамт” гэрэл зургийн уралдаан, Миний уншсан хамгийн шилдэг бөгөөд сонгодог зохиол” эссээ бичлэгийн уралдаан, “50 номын хожил” зэрэг уралдаануудыг зарлаж хүүхэд залуусыг өргөнөөр хамрууллаа.
18.	Сумд болон сургуулийн номын санчдад зөвлөн туслах үйлчилгээ хүргэж номын санчдын дунд ур чадварын тэмцээн зохиох	1. Номын санчдад facebook хаягаар групп үүсгэн арга зүйн зөвлөгөөг өгч байна. Мандах, Сайхандулаан, Даланжаргалан, Айраг, Замын-Үүдийн сургууль болон соёлын төвийн номын сангуудад арга зүйн зөвлөгөөг өглөө. Иххэт сумын соёлын төвийн номын санд очиж номын сантай танилцаж арга зүйн зөвлөгөөг өгсөн байна Сум болон сургуулийн номын санчдыг жил бүр мэргэжлийн дагуу сургалтад хамруулж байна. Сургуулийн номын сангууд уран зохиолын ном ховор учир тэдний хүсэлтээр ном солилцоо зохиох ажлыг эхлүүлэн 5-р сургуультай номын солицоог хийлээ.

		2. Сумдын номын санчдын жилийн тайланг мэдээггаргуулан авч ажил байдалтай нь танилцан шилдэг номын санч шалгаруулан шагнаж урамшууллаа. Шилдэг номын санчаад Иххэт сумын номын санч Ш.Мандалмаа, Мандах сумын номын санч М.Оюунцэцэг нар шалгарсан.
19.	Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага" стандарт MNS 5742:2007, "Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага стандарт MNS ISO11799:2007 шаардлагыг хангаж ажиллана.	1. Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн улсын шалгалтад бэлтгэж стандартын хэрэгжилтийг бүрэн хангаж улсын шалгалт угтсан аймгийн комиссын шалгалтаар үйл ажиллагаа хэвийн стандартын хэрэгжилт хангалттай дүгнэгдлээ. 2. Мөн номын сангийн орчны нөхцөл үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж стандартын шаардлагыг бүрэн хангаж мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн төлөвлөгөөт стандартын хэрэгжилтийн шалгалтад зөрчилгүй гарлаа.

ДОРНОД АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН
2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Зорилтод жил: “Номын сан - хүний хөгжилд ”

Зорилтод жилээ тодорхойлон, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, албан хаагчидтай гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулан жилийн эцсээр дүгнэн ажиллалаа.

Үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, иргэдэд номын сангийн үйлчилгээг хүргэх зорилгоор албан байгууллага аж ахуй нэгжид төрийн албан хаагчдад хүрч үйлчлэн “Номтой өглөө” номын хэлэлцүүлгийг 37 удаа зохион байгуулж 37 ном уншиж 1726 төрийн албан хаагч, оюутан залуучууд, сурагчид, уншигчид хамрагдсан. Хэлэлцүүлгийг сонирхолтой болгон “30 номын хожил” танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээнийг зохион байгуулан 24 байгууллагын 72 төрийн албан хаагчид оролцож 21 ном хожсон.

1.Номын сангийн уншлага, үйлчилгээний зохион байгуулалт

Тайлангийн хугацаанд **7072** шинэ уншигч, **84136** ирэгсэд, **107433** ном олгож үйлчиллээ. / Насанд хүрэгсэд 3510, хүүхэд 3562/ Нийт номын сангаар **91208** уншигч үйлчлүүлсэн байна.

Дорнод аймгийн Төв номын сан өгүүллэг, тууж, роман facebook хуудасыг шинээр нээж “Д.Намдаг”, “Ядам”, С.Дашдэндэв “Учрал”, П.Хорлоо “Үймээн”, Б.Бааст “Манаач”, Д.Намдаг “Үр тариа”, Д.Мягмар “Гуа үзэсгэлэн” С.Дашдооров “Улаан гэрийн Юүндэн”, Д.Сэнгээ “Аюуш”, Н.Банзрагч “Алтан намар”, Л.Ванган “Ялигүй юм” өгүүллэг, Д.Тарва “Анхны шинэ жил ”, Ж. Лодой “Идэр замбага хоёр”, С.Пүрэв “Уулын намар” зэрэг 4 тууж, 8 өгүүллэгийг цахимд оруулж, 297 уншигчдад таалагдаж, 9 хүн бусдад түгээж, 28 эерэг сэтгэгдэл үлдээсэн.

Зөөвөр үйлчилгээ:

Зөөвөр номын сангийн үйлчилгээг 26 төрийн байгууллага, 8 ерөнхий боловсролын сургууль, 3 их дээд сургууль, нийт 37 байгууллагын багш, оюутнууд, сурагчид, төрийн албан хаагчид, 23 иргэдэд 3086 номоор үзэсгэлэн гаргаж 3945 ирэгсдэд, 1036 карт нээж, 4412 ном олгосон. Зөөврийн үйлчилгээ үзүүлэхээс гадна "30 номын хожил", "Алтан хонх", "АХА", "Номтой өглөө" уулзалт хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээг байгууллага тус бүрт зохион байгуулсан.

Солилцоо:

Сар бүрийн сүүлийн 7 хоногийн баасан гаригт Ном солилцож унших өдрийн арга хэмжээг тогтмолжуулсан. Хилийн цэргийн 0132 ангид уран зохиолын 25 ном, Баян-уул сумын ерөнхий боловсролын сургуульд 5, нийтийн уншлагын танхимын уншигчид 45, хүүхдийн уншлагын танхимын 8 хүүхэд, уншигч Ц.Дугар 2, С.Лхамжав 5, Ч.Буд 6 , Ц.Батхүү 10, Ц,Батболд3, Г.Дамдин-3, Ц.Зоригт-1 нар өөрсдийн уншсан 32 номоо хоорондоо солилцож уншсан. Нийт 113 ном солилцож уншсан.

Мэдээлэл сурталчилгаа

2019 онд соёл олон нийтийн 20 ажил зохион байгуулж, 9181уншигчид хамрагдсан.

№	Соёл, олон нийтийн ажлын нэр	СОНА төрөл	Хамрагдсан оролцогчид		Зарцуулсан төсөв	Зохион байгуулсан огноо	Шаардлагатай бол тайлбар	Тайлбар
			Бүртгэлтэй	Бүртгэлгүй				
1	Номтой өглөө уулзалт	хэлэлцүүлэг	1726		101000	Жилийн турш		
2	Алтан хонх	уралдаан	26			2 сарын 10		ном
3	Шүлгийн уралдаан "Халхгол цадиг тууж"	уралдаан	50			4сарын23		
4	Номын чуулган		130	20		4сарын23		
5	Үндэсний бичиг үсгийн баяр		360	520		5сарын02		
6	Алтан хонх	Тэмцээн	16			4сарын23		
7	Цэцэг өргөх арга		1950	1924		5,6,9 сард		

	хэмжээ							
8	30 номын хожил	уралдаан	78					
9	Номын баяр		90	40		10 сар		
10	АХА тэмцээн		48	10		10сарын 15		
11	Ижийдээ захидал бичих	Уралдаан	98			3сарын08		
12	Аав ахдаа захидал бичих		102	66		3сарын18		
13	Үлгэрийн цаг	уншлага	1572			Жилийн турш		
14	Шүлгийн уралдаан		10					
15	Талын найраг		50			3сарын21		
16	Сэтгэхүйн хурд тэмцээн		21			5сарын24		
17	Шатар тоглох цаг		225					
18	Зургийн уралдаан		13			5сарын 31		
19	Тархи цэнэглэх уралдаан		36					
20	Монгол бичиг урлаг болгох	Хэлэлцүү лэг	10					
	Нийт		6601	2580				

2.Сан хөмрөгийн бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт

2019 онд нийт 568 ширхэг ном. Үүнээс фонд бүрдүүлэлт төсвийн санхүүжилтээр уншигчдын хэрэгцээ шаардлагатай байгаа 115 нэр төрлийн 160 ширхэг 2397464 төгрөгийн ном, хандив тусламжаар 313 нэр төрлийн 408 ширхэг 3702364 төгрөгийн ном хүлээн авч бүртгэн ангилж программд оруулж бар код нааж уншлагын танхимуудад хүлээлгэн өгсөн. Хэвлэл захиалга 23 нэр төрлийн 754400 төгрөгийн сонин сэтгүүлийг захиалсан.

Нийтийн уншлагын танхим 9056 номын бар кодыг шинэчлэн, программд зөрсөн 51 номын нэрийг засаж залруулсан.

2018 оны 69 багц, 2019 оны 30 багц сонин сэтгүүлийг үдэж хаяглаж хавтаслаж байрлуулсан. Урагдаж гэмтсэн 1226 номыг сэлбэн засаж, хуудас дутуу номыг нөхсөн. Тогтмол хэвлэлийн танхимын номын тооллого хийгдэж, акт тооцоог хийсэн.

3. Каталог, зохион байгуулалт

Шинээр ирсэн болон хандиваар ирсэн 476 номыг данс бүртгэлд тусган программд оруулж, техник ажиллагаа хийж танхимуудад хуваарилан уншлага үйлчилгээнд ашиглаж байна. Орос 2550 номыг программд оруулж бар код нааж электрон каталогт оруулсан.

Zotero программд Дөл, Дорнод, Монголчууд сэтгүүл, Талын анир зэрэг сэтгүүлд гарсан орон нутгийн талаар гарсан 293 мэдээллийг бүртгээд байна.

Төв номын сангийн электрон каталогоор нийт 390 хайлт хийсэн байна.

4.Лавлагаа ном зүйн үйл ажиллагаа:

Номын сан нь ном зүйн мэдээллийн ажиллагааг боловсронгуй болгох үүднээс шинэ болон сэдэвчилсэн, зохиолчдын, тэмдэглэлт өдрүүд, сонин сэтгүүлээр нийт 87 удаа 3307 номоор үзэсгэлэн гаргаж 1889 уншигч үзэсгэлэн үзсэн. Зохиолчдын ой С.Эрдэнэ 90 жил, Р.Бадарч 80 жил, Д.Нямаа 80 жил, Л.Бадарч 100, Ш.Дулмаа 85, Ц.Гайтав 90.

Аман лавлагааг 2312, бичгээр 388, цахимаар 378 лавлагаа нийт 3079 лавлагааг 1568 уншичдад өгсөн.

Эрүүлийг хамгаалах, анагаах ухааны шинжлэх ухааны 498 номоор, техникийн шинжлэх ухааны номоор ном зүй, Дорнод аймгаас төрсөн эрдэмтэн зохиолч, уран бүтээлчдийн намтар ном зүй, хүүхдийн уншлагын танхимын ойрын фондын уран зохиолын 106, аман зохиолын 516 номоор тус тус ном зүйн мэдээлэл, Хэрлэн голын хөвөөнд төрсөн алдартан хүмүүсийн намтараа санамж өгөх ном зүй, 2019 оны 06-10 сард ирсэн шинэ номын мэдээг ном зүйн хэлбэрээр гаргасан.

5.Номын сангуудын орон нутагт судлах үйл ажиллагаа:

Аймгийн Соёл, урлагийн салбарын хөгжлийг дэмжих /2018-2021он/ хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан “Номын санчдын бүтээлч хандлага” сэдэвт сургалтыг 2019 оны 05-р сарын 21, 22-ны өдрүүдэд зохион байгуулж сургалтанд Аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын сургууль, Сумдын нийтийн номын сан болон сургуулийн номын сан, Дорнод Их сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ХЦ-ийн 0132-р анги, нийт 50 гаруй номын санчид хамрагдан сургалтын төгсгөлд номын санчид сургалтын үр дүн, дүгнэлт ярилцлагаар номын сангийн өмнө тулгамдаж буй асуудал, 2020 онд үргэлжлэх соёл урлагийн хөгжлийг дэмжих хөтөлбөрт оруулах саналыг өгч цаашид хийж хэрэгжүүлэх ажлуудад санал солилцон сургалтанд оролцсон бүх номын санчдад сертификат гардуулав.

“Миний номын өргөө”

Японы хүүхдийн ивээх сангаас хэрэгжүүлсэн “Миний номын өргөө” төслийг үргэлжлүүлэн ном тоглоомын багцын 8 ээлж 5 хүүхэд хамрагдсан. 9 ээлж 4 хүүхэд хамрагдаж байна. 9 ээлж 5 дугаарын сарын 25- наас ном тоглоомын багцыг өгч гарааны үнэлгээг авч 2 эрэгтэй, 2 эмэгтэй хүүхдийг хамрууллаа. Ном тоглоомын багцын ариутгал цэвэрлэгээг үйлчлэгч Шүрэнцэцэгтэй хамтран хийж ном тоглоомын тооллого хийсэн. Тооллогоор дутсан Балхүүгийн цуврал, Арслангийн туршуул, Шоргоолж дэвхэргэ, номуудыг орлуулж хийлээ.

Канад сангийн Орон нутгийн санаачилга хөтөлбөрийн санхүүжүүлсэн Хараaны бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл харилцааны шинэ технологиор дамжуулан чадавхжуулах сургалт Төв номын санд 2019 оны 11 дүгээр сарын 09-12 ны өдрүүдэд зохион байгуулагдав. Сургалтанд аймгийн төв номын сангийн номын санчид болон хараагүй иргэд, тэдний асран хамгаалагчид 60 гаруй оролцлоо. Сургалтаар мэдээлэл харилцааны шинэ технологи болох цахим брайл төхөөрөмжийг ашиглах, хэрэглэх аргыг сурч хараaны бэрхшээлтэй иргэд мэдээлэл хүлээн авах, төрөл бүрийн цахим сургалтад хамрагдаж, интернэд орчинд бие дааж өөрийгөө хөгжүүлэх боломжтой боллоо. Төслийн хүрээнд 35 төрлийн 12320604 төгрөгийн техник хэрэгслийг хүлээлгэн өгсөн.

Номын нээлт:

С.Мандаалай нь сургуулийн өмнөх боловсролын байгууллагад тасралтгүй 42 жил ажилласан арвин их туршлагадаа тулгуурлан “Сургуулийн өмнөх боловсрол үүсч хөгжсөний түүхэн замнал” ном нээлтийг хийсэн. Энэхүү номонд сургуулийн өмнөх боловсролын 36 байгууллагын хөгжлийн товч түүх, цэцэрлэгүүдийн түүхэн хөгжил, амжилт бүтээл, үе үеийн удирдлага багш ажилчдын дурсамжууд түүхэн зургууд хэмээх 5 бүлгээс бүрдсэн томоохон бүтээл болсон.

Дорнод аймгийн уугуул Монгол Улсын Гавъяат дасгалжуулагч, Улсын начин, Сурган хүмүүжүүлэх ухааны доктор, профессор /PhD/ Г.Пүрэв- Очир өөрийн гаргасан бүтээлийн номын нээлтийг зохион байгууллаа. Тэрээр бөхийн спортын чиглэлээр судалгаа шинжилгээний олон талт ажлыг үр дүнтэй хийж ирсэн бөгөөд одоогоор 20 шахам ном бүтээлийг олны хүртээл болгон номын дээжийг Аймгийн төв номын санд хандивлан өргөн барилаа.

5.ХҮНИЙ НӨӨЦ

Албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлон “Номын санчдын бүтээлч хандлага” сэдэвт сургалтад Аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын сургууль, Сумдын нийтийн номын сан болон сургуулийн номын сан, Дорнод Их сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ХЦ-ийн 0132-р ангийн нийт 40 гаруй номын санчид хамрагдан ур чадвар мэдлэг мэдээллээ сайжруулан зөвлөгөө мэдээлэл авсан.

АЗДТГ-аас зохион байгуулсан Төрийн албан хаагчдын чадавхжуулах сургалтад Хүний нөөцийн ажилтан М.Ариунаа 2 удаа, Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтад номын санч мэдээллийн ажилтан Х.Чулуунцэцэг 2 удаа, арга зүйчийн сургалтад арга зүйч Ж.Соня нар тус тус хамрагдсан.

Сахилга хариуцлагыг өндөржүүлэн баяр ёслолын өдрүүдэд хариуцлагатай жижүүр томилон ажиллуулсан. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалтыг цагдаагийн газартай хамтран 1 удаа хийж, эргүүлд 2 удаа гарсан. Ажлын хариуцлага алдсан 2 албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулж сануулга-1, цалингийн 20%-иар бууруулах -1, арга хэмжээг тус тус авсан.

Номын сангийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах /2019-2020/ оны хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэн ажиллаж биелэлтийг ханган ажилласан.

Аймгийн Иргэдийн хурлын 2017 оны 06 дугаар тогтоолоор баталсан “ Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөр”-ийн

хүрээнд нийт төрийн байгууллагуудын дунд зохион байгуулсан АСК тэмцээн, Ажил мэргэжлийн ерөнхий ур чадварын уралдаан, Спортын олон төрөлт тэмцээнүүдэд ажилтан, албан хаагчдаа зохион байгуулалттайгаар хамруулан идэвхтэй оролцсон.

Байгууллагын хэмжээнд Дотоод хяналт шалгалт тогтолцоо эрсдэл, Харилцаа хандлага, Хувь хүний хөгжил, Талархал, Хүүхдийн хүмүүжилд гэр бүлийн оролцоо, Жендерийн эрх тэгш байдал, Монгол хэлний найруулга зүй, албан бичгийн найруулга зэрэг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг шалгалтыг угтаж номын санчдад хэсэгчилсэн холбогдох мэдээ мэдээллийг өгсөн.

Хууль, дүрэм журмын дагуу тэтгэвэрт гарах 1 албан хаагчийн 36 сарын цалинтай тэмцэх мөнгөн тэтгэмжийг 2020 оны төсөвт тусгуулсан. Жирэмсний амралттай байгаа 2 албан хаагчийг тэтгэмжийг цаг хугацаанд нь бодож олгон, хүүхэд асрах чөлөөтэй байгаа саруудын нийгмийн даатгалын шимтгэлийг байгууллагаас төлж байна. Шинээр төгсөж байгаа номын санчийн мэргэжилтэн албан хаагчийг нөөцөд бүртгэн ажиллаж байна.

Ажлын үр дүнгээр шалгаран сайн ажиллаж байгаа албан хаагчдаа шагналд тодорхойлох шагнуулах саналыг удирдлагад танилцуулан аймаг орны болон яамны шагналд тодорхойлолтыг бичиж хүргүүлсэн. Номын санч мэдээллийн ажилтан П.Даваацэрэн Боловсрол, соёл шинжлэх ухаан спортын яамны “Жуух бичиг, аймгийн “Тэргүүний ажилтан цол тэмдэг”-ээр, нягтлан бодогч Б.Майцэцэг, Хүний нөөцийн ажилтан М.Ариунаа нар Сангийн яамны “Жуух бичиг”-ээр, мэдээллийн ажилтан Ч.Цогтхүү аймгийн “Жуух бичиг”-ээр, ном зүйч каталогч Э.Учралмаа МҮЭ-ийн “Соёлын тэргүүний ажилтан цол тэмдэг”-ээр, нийтийн уншлагын танхимын номын санч мэдээллийн ажилтан Х.Чулуунцэцэг “Байгууллагын аварга-2019”-аар тус тус шагнагдсан. 2019 оны ажлын үр дүнгээр шалгарсан 13 албан хаагчдад 30-100%-ийн цалингийн урамшуулал олгосон.

Монголын номын сангийн салбарын 2019 оны “Онцлох Гадаад хамтын ажиллагаа”-гаар шалгарч “Онцлох” цом БСШУСЯ-ны нэрэмжит шагнал 3 сая төгрөгөөр шагнагдсан.

Сүлжээний инженер Ч.Цогтхүүгийн байшинд гал гарч шатсанд 150000 төгрөгийн тусламж,1 номын санчид ар гэрийн гачигдалд 100,0 төгрөг, 1 өндөр настанд 100,0 төгрөг, Номын санчдын нормын хувцас оёулахад 315000, үзэсгэлэнгийн тавиурт 320.0, сандал 200.0, жижүүрийн өрөөнд 380.0 төгрөгийг хамтын сан болон байгууллагын Үйлдвэрчний Эвлэлийн хорооноос санхүүгийн

асуудлыг шийдвэрлүүлсэн. Түлээ нүүрсний хөнгөлөлт 60000 төгрөгийг 3 албан хаагчдад олгосон. Амралтын өдөр 1 соёл олон нийтийн арга хэмжээ зохион байгуулж 4 албан хаагчыг нөхөж амраасан.

6. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ

Дорнод аймгийн Төв номын сан өгүүллэг, тууж, роман facebook хуудас нээж номын санчдын өгсөн өгүүллэг, тууж, романыг цаг тухайд нь байршуулж олон нийтэд түгээж 12 тууж, өгүүллэг оруулж 297 хүнд таалагдаж, 9 хүн бусдад түгээж, 28 эерэг сэт Электрон каталогоор нийт 390 хайлт хийсэн байна.

Номын сангаас зохион байгуулагдаж байгаа соёл, олон нийтийн ажил болон бусад үйл ажиллагааг байгууллагын фэйсбүүк хуудас, дорнод аймаг номтой өглөө, дорнод олон нийттэй харилцах ажилтнууд, дорнодчуудын нэгдэл, дорнод аймгийн сумдын соёлын төв, дорнод аймгийн ЕБС болон соёлын төвийн номын санчид, номын сангийн асуудлууд зэрэг группүүдэд нийт 643 мэдээлэл оруулж 4622 хүнд таалагдаж, 1953 хүн бусдад түгээж, 261 сайшаалтай сэтгэгдэл, 10 санал сэтгэгдэл ирсэн байна.

Сумдын нийтийн номын сангуудад хэрэгжээд байгаа цахим программын нэгдсэн тайлангийн мэдээ, нэгдсэн каталогийн мэдээ, нөөц бэлдэх аргачлалыг, Баян-Уул сумын номын сангийн Monbiblio программын тохиргоог хийж, программд яаж ажиллах талаар номын санчид заавар зөвлөгөө өгсөн.

8.АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ

Баримт бичгийг стандартын дагуу хөтлөн боловсруулж захирлын тушаалыг бүртгэн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа. Боловсон хүчин холбогдолтой 3, албан ажлын холбогдолтой 19 тушаал гаргасан. Ирсэн бичиг 106 үүнээс Able программаар 97, цаасаар 10 бичгийг хүлээн авч, хариутай 22 албан бичгийг цаг хугацаанд нь гарган хүргүүлэв. Явсан бичиг 122, программаар 54, цаасаар 67 бичиг явуулсан. Able программын хэрэглээг сайжруулан өдөр тутам ашиглаж байна.

Байгууллагын мэдээллийн цагийг 2019 онд 26 удаа хийж, аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдааны талаарх мэдээ мэдээллийг танилцуулан байгууллагын үйл ажиллагааны талаар үүрэг чиглэл өгч, агентлаг, албан байгууллагын мэдээлэл 5, сургалт 5, шинээр гарсан хууль тогтоомж 3, номын санчдын бэлтгэсэн илтгэл 7 удаа хийгдсэн.

Засгийн газрын 11-11 төв, Аймгийн засаг даргын тамгын газрын 70582233 утсанд номын сантай холбоотой өргөдөл гомдол ирээгүй. 2019 оны 1-12 сарын

байдлаар иргэдээс ирүүлсэн өргөдөл байхгүй. Байгууллагын ажилтан албан хаагчдаас чөлөө хүссэн 7 өргөдөл, санал хүсэлтийн хайрцагт 6 санал, 70584259 утсанд 1санал ирсэн. Өргөдлийг үндэслэн 4 албан хаагчдад цалинтай, 3 албан хаагчдад, цалингүй чөлөө, санал хүсэлтийн хайрцагт ирсэн 4 санал, 2 гомдлыг хүлээн авч бүртгэн утсаар хариу мэдэгдсэн.

Байгууллагын нээлттэй утас 70584259 дугаарт 4 хүсэлт ирснийг бүртгэн авч хариуг утсаар мэдэгдэн шийдвэрлэсэн. Санал хүсэлтийн хайрцагт 4 санал хүсэлт ирснийг бүртгэсэн үүнд: талархал 1, номын санчид ажлын байранд байхгүй1, уралдаан тэмцээн зохион явуулах 2, эдгээр саналууд уншигч хүүхдүүдээс ирсэн. Хариу авах утасны дугаараа үлдээгээгүй учраас буцааж хариу өгч чадаагүй. Санал хүсэлтийн дагуу уралдаан тэмцээний тоог өмнөх жилүүдээс олон төрлөөр зохион байгуулан ажилласан. Номын санчдад ажлын цагт ажлын байранд байхыг анхааруулан үүрэг өгсөн.

2019 онд Албан бичиг -01-200, захирлын тушаалын 50 баланк хийлгүүлсэн. Хэвлэмэл хуудасны зарцуулалтыг бүртгэн ажиллаж байна.

Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг шалгалтыг угтаж, Номын сангийн захирлын тушаалаар ажлыг хэсэг байгуулан ажилласан. Аймгийн үзлэг шалгалтаар хангалттай сайн үнэлэгдсэн.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг жил бүр батлуулан байнга, түр, 70 жил хадгалах баримтын данс, устгах хэргийн актыг байгууллагын ББНШК болон аймгийн Архивын тасгийн комиссоор хэлэлцүүлж, баталгаажуулж, 2009-2015 оны цаасан суурьтай 58 ХН, цахим 58 CD, төрийн архивт байнга хадгалахаар төрийн архивт шилжүүлсэн. Баримт бичгийн эргэлтийн мэдээ тайланг хагас бүтэн жилээр гарган, хэвлэмэл хуудсаа аймгийн архивын тасгаар хэвлүүлэн, ашиглалт болон зарцуулалтын бүртгэл тогтмол хөтөлж байна. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэн байгууллагын 2009-2015 оны цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлж төрийн архивын программд оруулсан.

9. БУСАД

Байгууллагын ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулсан.

“Эндрофин” эмнэлэгт урьдчилсан сэргийлэх үзлэгт бүх ажилтан, албан хаагчдыг хамруулсан. Өвчилсөн 3 ажилтанд эмнэлгээр явж үзлэг оношлогоо

хийлгэхэд 3 хоногийн цалинтай чөлөөг олгосон. Мөн 1 албан хаагчдад 10 хоногийн чөлөөг олгосон.

Засвар үйлчилгээ:

Үүдний вистульд номын үзэсгэлэнгийн тавиур, уншигчийн 2 жижиг сандал авсан. Нийтийн уншлагын танхимд уншигчдад зориулж утас залгах разетка нэмж байрлуулсан. Жижүүрийн өрөөний пилта, цонхны тавцанг сольсон.

Оросын холбооны улсад үйлдвэрлэсэн "ЖАВЕЛЬ СИН" ариутгалын бодисоор Үндсэн фонд, гадаад номын фонд, хүүхдийн уншлагын танхим, нийтийн уншлагын танхимын ойрын фонд, тогтмол хэвлэлийн тасгийн ном, сонин сэтгүүл, архивын өрөөнд журмын дагуу 5, 9 дугаар саруудад ариутгал хийсэн. Хулгана, жоомны хор цацсан.

ТӨСӨВ, САНХҮҮ

ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

АГУУЛГА:

1) Байгууллагын ажиллагсдыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлын хүрээнд:
2) Үйл ажиллагааны онцлог, амжилт:
3) Зохин байгуулсан соёл, олон нийтийн ажил:
4) Хөдөөгийн иргэдэд хүргэсэн “Зөөврийн номын сан”-ийн үйлчилгээ
5) Соёл, урлагийн чиглэлээр зохион байгуулсан сургалтанд хамрагдах
6) Угийн бичиг хөтлүүлэх ажлыг зохион байгуулсан байдал
7) Номын сангаас зохион байгуулсан арга хэмжээ, номын баяжилт, уншигчдын төлөвлөгөө
8) Байгууллагын үйл ажиллагаанд хийгдсэн өөрийн болон хөндлөнгийн хяналт шинжилгээний дүн мэдээ, түүний дагуу авсан арга хэмжээ, ажлын үр дүн, ахиц өөрчлөлт
9) Иргэд, байгууллагын өргөдөл гомдол, түүнийг барагдуулсан байдал

НЭГ. Байгууллагын ажиллагсдыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлын хүрээнд:

Сүлжээний инженер, бичиг хэргийн ажилтныг Архивын ерөнхий газарт "Баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, данс, бүртгэл, акт үйлдэх ажлын арга зүй" сэдэвт мэргэшүүлэх, Удирдлагын академийн мэргэшил дээшлүүлэх институтын "Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа, эрх зүйн зохицуулалт" сэдэвт мэргэжлийн үнэмлэх олгох, Мерит төслийн "Төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх зорилгоор ур чадварт шинжилгээ хийж, тасралтгүй суралцагч байгууллага болох нь", "Сургагч багш бэлтгэх нь" сэдэвт гэрчилгээ олгох сургалтад тус тус хамруулав. Мөн Гэрээр ном олгох танхимын номын санч-мэдээллийн ажилтныг СУИС-ийн Соёлын сургуульд "Цахим ном зүй" мэргэшүүлэх сургалтад сургав.

ХОЁР. Үйл ажиллагааны онцлог, амжилт:

"Дэлхийн номын өдөр"-ийг аймгийн хэмжээнд өргөн цар хүрээг хамран зохион байгуулж баярын жагсаалаар ёслол төгөлдөр эхэллээ. Тус үйл ажиллагааны хүрээнд "Олуулаа уншья-Номтой нөхөрлөе" аяны нээлт, "Цэрэг эх орон танаа" богино өгүүллэгийн уралдааны шагнал гардуулах ёслол, иргэдийн дунд АХА, Алтан хонх танин мэдэхүйн тэмцээнүүдийг амжилттай зохион байгууллаа. Мөн шилдэг уншигч МХГ-ын байцаагч Н.Мөнгөнцэцэг, ЭДЦС-ийн 8г ангийн сурагч С.Нарантөгөлдөр нарт "Номын сайн нөхөр" үнэмлэхийг гардуулав. Баярын жагсаалд нийт 24 байгууллагын 253 албан хаагчид, сурагчид, иргэд оролцлоо.

ГУРАВ. Зохин байгуулсан соёл, олон нийтийн ажил:

- Монгол Үндэсний ёс заншил, түүх соёлоос суралцах, соёлын биет бус өвийг өвлөн уламжлах, хойч үедээ түгээн дэлгэрүүлэх зорилготойгоор зохион байгуулсан "Монгол бахархал - Ёс заншил" тэмцээнд ЕБС-ийн 5 баг, МСҮТ-ийн 1 баг оролцож оюун ухаанаа сорин Тэргүүн байр - Хүмүүнлэг сургуулийн "Таван ухаан" , Дэд байр - Цэгц билиг сургуулийн "Сайхан Монгол", Гутгаар байр - Мандал сургуулийн "Дөрвөн бэрх" баг тус тус эзэллээ. Тэмцээнд идэвхтэй оролцсон МСҮТөвийн "Монгол бахархал", ЭДЦСургуулийн "Монгол Ирээдүй", ГИЦСургуулийн "Монголжин" багууд, хамтран зохион байгуулсан Дундговь аймаг дахь Лидер сурагч академийн тэргүүн Г.Сарнай, болон Эрхэм шүүгч нартаа талархал илэрхийлье.

- 2019 оны Зохиолч - Уншигчдын анхны уулзалтыг амжилттай зохион байгууллаа. Уулзалтанд МЗЭ-ийн шагналт, Нацагдоржийн нэрэмжит шагналт, СТА, хүүхдийн зохиолч Н.Мандал, МЗЭ-ийн шагналт, хүүхдийн зохиолч М.Доржсүрэн, МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч О.Гончигсүрэн нар оролцлоо.

- "Ээждээ захидал бичээрэй" захидлын уралдаан 42 захидал ирж, шалгаруулалтыг аймгийн яруу найрагч О.Гончигсүрэн нар шалгаруулав. Тус уралдаанд

1-р байр: ЭДЦС-ийн 8в ангийн сурагч Э.Цэрэннадмид

2-р байр: Хүмүүнлэг сургуулийн нийгмийн ажилтан, багш Н.Мөнхцэцэг
3-р байр: Эрдэнэдалай сумын номын санч Б.Оюунчимэг нар тус тус шалгарлаа.

- "Ижий ертөнц 2018" яруу найргийн наадмыг 3 үе шаттайгаар зохион байгууллаа. Тус уралдаанд, Хулд, Цагаандэлгэр, Өлзийт сумдууд, Төрийн албан хаагчид, ЕБС-ийн ахлах ангийн сурагчид зэрэг нийт 21 яруу найрагч оролцож шүлгээ ирүүлснээс 2 шатанд 15 яруу найрагч шалгарч өөрийн зохиосон бүтээлээрээ өрсөлдлөө. Шүлгийн уралдаанд:

1-р байр: ТХДЖТ-ын жүжигчин Н.Бямбасүрэн
2-р байр: Малчин Д.Энхбаяр
3-р байр: Хүмүүнлэг сургуулийн 11а ангийн сурагч Э.Цэрэнжаргал
Зохиолчдын нэрэмжит шагналаар ШУТИС-ийн оюутан Ж.Цэрэнтогтох, ЭДЦС-ийн 11в ангийн сурагч Б.Ганшагай нар шагнагдлаа.

- Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 98 жилийн ойг тохиолдуулан Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран анх удаа "Цэрэг эх орон танаа" богино өгүүллэгийн уралдааны сарын аяныг зохион байгуулав. Ууралдаанд нийт 6 өгүүллэг оролцож,

Тэргүүн байр- Б.Уугантуяа /чөлөөт уран бүтээлч/
Дэд байр- Х.Шонхор /Зава Дамдин судлаач, Ган үзэгтэн, МУСТАжилтан/,
Гутгаар байр- Э.Цэрэнжаргал /Хүмүүнлэг сургуулийн 10а ангийн сурагч/
нар шалгарч 4, 5 дугаар байрын эздэд Талархал хадгалуулав.
Мөн "ЭРИЙН ХИЙМОРЬ - ЭР ЦЭРЭГ" яруу найргийн уралдааныг Дундговь аймгийн Утга зохиолын нэгдэл, С.Буяннэмэхийн нэрэмжит төв номын сан, Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 278-р ангийн харьяа 178-р байгууламж, Аймгийн цагдаагийн газар хамтран С.Буяннэмэхийн нэрэмжит төв номын санд 2019.03.09-ний өдөр амжилттай зохион байгууллаа. Уралдааны үеэр Зава Дамдин судлаач, Ган үзэгтэн, чөлөөт уран бүтээлч, зохиолч Х.Шонхор МЗЭ-ийн 90 жилийн ойн медалиар
Тэргүүн байр: МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч Х.Энхтөр
Дэд байр: Хулд сумын Малчин Д.Энхбаяр
Гутгаар байр: 178-р байгууламжийн радио телеграфчин, дэд ахлагч С.Өнөрзул
Тусгай байр: БОАЖГазрын мэргэжилтэн Б.Батхүү, ШУТИС-ийн оюутан Ж.Цэрэнтогтох нар тус тус шалгарч, шагналаа гардан авлаа.

- 2019.03.22-ны өдөр Дундговь аймгаас төрөн гарсан залуу яруу найрагчид Нацагдоржийн нэрэмжит шагналт яруу найрагч П.Нямлхагва, Г.Сэр-Одын нэрэмжит шагналт яруу найрагч А.Сүглэгмаа, МЗЭ-ийн гишүүн яруу найрагч О.Гончигсүрэн, Бадархундага уралдааны "Тэргүүн цом"-ын эзэн яруу найрагч О.Элбэгтөгс, яруу найрагч Э.Гантулга, яруу найрагч И.Оюун-Эрдэнэ нарын номын хурим өргөн дэлгэр боллоо. Яруу найрагчидын өлгийдөн авсан уран бүтээлээс дурьдвал:

- ✓ Нацагдоржийн нэрэмжит шагналт яруу найрагч П.Нямлхагва

  “Сэлүүн тэргэл”, “Тэнүүн дэлгэр” яруу найргийн ном
- ✓ Г.Сэр-Одын нэрэмжит шагналт яруу найрагч А.Сүглэгмаа

“Бүрхэг өдрүүдийн Блюз” яруу найргийн ном, “Гандигар” яруу найргийн СД

- ✓ МЗЭ-ийн гишүүн яруу найрагч О.Гончигсүрэн

  “Дуулахгүй орхиж боломгүй” яруу найргийн ном

- ✓ Бадархундага уралдааны "Тэргүүн цом"-ын эзэн яруу найрагч О.Элбэгтөгс

  “Тэнцвэр” яруу найргийн ном

- ✓ Яруу найрагч Э.Гантулга

  “Эмт одын бороо” яруу найргийн ном

- ✓ Яруу найрагч И.Оюун-Эрдэнэ

  “Романтизмын мөхөл” яруу найргийн ном

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012.08.24-ны өдрийн “Номын баярын өдөр тэмдэглэх тухай” 158-р зарлигийн дагуу тэмдэглэн өнгөрүүллээ. “Номын баярын өдөр-2019”-ын хүрээнд:

- 1-6-р ангийн сурагчдад “Үлгэрийн баатруудыг хэн сайн мэдэх вэ?” зурган асуулт, хариултын тэмцээн зохион байгуулж, 126 сурагч оролцсон

  Тэргүүн байр – У.Хишигсүрэн /Хүмүүнлэг 5б ангийн сурагч/
  Дэд байр – Э.Алтантуяа /Хүмүүнлэг 5б ангийн сурагч/
  Гутгаар байр – Ө.Марал-Эрдэнэ /Мандал 3в ангийн сурагч
- “Номын ертөнцөөр аялахуй” уралдааныг тус тус зохион байгуулсан.

  Насанд хүрэгчдийн ангилал:
  Тэргүүн байр - Б.Ганцэцэг /Хүмүүнлэг сургуулийн багш/
  Дэд байр – А.Дэлгэрмаа /Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын багш/
  7-12-р ангийн сурагчдын ангилал:
  Тэргүүн байр – Г.Сарнай /Цэгц билиг сургууль 11б ангийн сурагч/
  Дэд байр – С.Цогзолмаа /ЭДЦС 11в ангийн сурагч/ нар тус тус шалгарлаа.

Дундговь аймгийн ГБХЗХГазартай хамтран зохион байгуулсан “Үлгэрч аав, ээжүүдийн өдөр”-өөр Дундговь аймаг дахь Шүүхийн Шинжилгээний албаны алба хаагчид амралтын өдрийг хүүхдүүдийн хамт хүрэлцэн ирж, чөлөөт цагаа гэр бүл, хүүхдүүддээ зориулах зорилгоор Хүүхдийн Уншлагын танхимын “Гэр бүл Танин мэдэхүйн танхим”-д гэр бүлийн уншлагыг хийлээ.

"Олуулаа уншья-Номтой нөхөрлөе" аяныг 2 дахь жилдээ 5 сургууль, ААН, Албан байгууллагуудын дунд 2019 оны 02-р сарын 11-ний өдрөөс 11-р сарын 01-ний хооронд зарлан “Тэргүүний уншигч”, “Тэргүүний уншигч-Анги хамт олон”, “Тэргүүний уншигч-Гэр бүл”, “Тэргүүний уншигч-Албан байгууллага, ААН”-үүдийг шалгаруулан зохион байгууллалттай уншлаганд хамруулж ном уншлагын аяныг өрнүүлэн ажиллаа.

ШИЛДЭГ УНШИГЧ

- ✓ 1-5-р анги: А.Эгшиглэн – Мандал сургуулийн 3а анги
- ✓ 6-9-р анги: Э.Хонгорзул – ЭДЦС 9а анги
- ✓ 10-12-р анги: М.Сарангоо – ГИЦС 11в анги

ШИЛДЭГ УНШИГЧ АНГИ, ХАМТ ОЛОН

- ✓ 1-5-р анги: ЭДЦС 4б анги
- ✓ 6-9-р анги: Цэгц билиг 8а анги

- 9 дэх жилдээ зохион байгуулагдаж буй “Миний уншсан ном дүрслэх урлагт” уралдааныг зарлан дүгнэж шагналыг гардуулав.

- ✓ **1-5-Р АНГИ:** БҮТЭЭЛИЙН ТӨРӨЛД

1. Ж.НАНДИН-ЭРДЭНЭ –ГИЦС 4Б анги
2. Б.АЗЖАРГАЛ – ГУРВАНСАЙХАН сум 3А анги
3. Б.БАЗАРСҮРЭН – ГИЦС 4Б анги

- ✓ **1-5-Р АНГИ:** УРАН ЗУРГИЙН ТӨРӨЛД

1. М.ДӨЛГӨӨНМӨРӨН- ХҮМҮҮНЛЭГ 4Б анги
2. Ө.АМАРТҮВШИН – ГУРВАНСАЙХАН сум 5Б анги
3. С.ЭНХ-УНДРАХ – ГУРВАНСАЙХАН сум 5Б анги

- ✓ **10-12-Р АНГИ:** УРАН ЗУРГИЙН ТӨРӨЛД

1. Х.МАРГАД-ЭРДЭНЭ-ЦЭГЦ БИЛИГ 11А анги
2. М.ЭНХЗАЯА – ГУРВАНСАЙХАН сум 12А анги
3. М.БУЯНДАЛАЙ – ГУРВАНСАЙХАН сум 12А анги

- ✓ **10-12-Р АНГИ:** ХАЙЧИЛБАРЫН ТӨРӨЛД

1. Э.НАРАНЗУЛ – ГИЦС 11А анги
2. Б.БҮЖИНЛХАМ – ГИЦС 11В анги

- “С.Буяннэмэх тэмдэгтэн” шагналд 9 сум, аймгийн төвийн 4 сургуулийн 110 бүтээлээс шалгаруулалтыг хийн журмын болзол хангасан 23 сурагчдын нэрсийг Нийгмийн бодологын хэлтсийн Соёл хариуцсан мэргэжилтэнд хүргүүлж Аймгийн Засаг даргын 2019.12.12-ны өдрийн А/430 дугаар захирамжийн дагуу 23 хүүхдэд тэмдэг, үнэмлэхийг гардуулан алдаршууллаа.
- **“Д.НАЦАГДОРЖ ТЭМДЭГТЭН”-ИЙ БОЛЗОЛ ХАНГАСАН СУРАГЧ**

1. БАТТУЛГЫН СОДТУЯА – ЭДЦС 7В анги
2. ХАШ-ЭРДЭНИЙН ЦЭРЭНДЭЖИД – ЭДЦС 4Б анги

- 2019 оны шилдгийн шилдгүүдээ шалгаруулж “Уншигчийн сүлд модны наадам”-аа ёслол төгөлдөр тэмдэглэн шилдгүүдээ шагнаж, алдаршуулав. Шилдгийн шилдгээр

- **“Шилдэг хамтран ажиллагч байгууллага”** номинацд Дундговь аймаг дахь Цагдаагийн газар

- **“Номын сайн нөхөр”** 3 ангилалд 10 сурагч

Бага анги: ЭДЦС-ийн 4в анги М.Анхбилэг, Мандал сургуулийн 3б анги Б.Лхам-Олдох, Мандал сургууйн 2г анги Ө.Баярцэцэг
Дунд анги: ЭДЦС-ийн 9в анги М.Цэрэннадмид, ЭДЦС-ийн 9а анги Г.Болорцэцэг, ЭДЦС-ийн 7д анги Б.Гантигмаа
Ахлах анги: ГИЦС-ийн 12а анги М.Лхагвасүрэн, ЭДЦС-ийн 11б анги Б.Бямбажаргал, ЭДЦС-ийн 11г анги С.Цогзолмаа нар уншсан номоороо тэргүүлж **“Номын сайн нөхөр”** боллоо.

ДӨРӨВ. Хөдөөгийн иргэдэд хүргэсэн “Зөөврийн номын сан”-ийн үйлчилгээ

№	Зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлсэн албан байгууллагын тоо	Үйлчлүү-лэгчдийн тоо	Олгосон ном	Зохион байгуулсан соёл олон нийтийн ажил		Тайлбар
				Хэдэн удаа	Оролцсон хүний тоо	
1	Эрдэнэдалай, Дэлгэрхангай, Өлзийт, Луус, Хулд, Өндөршил, Сайхан-Овоо, Гурвансайхан сумдад	1800	443	8	240	Сумдын ЗДТГ, сургууль, цэцэрлэг, эмнэлэгийн байгууллагын албан хаагчдад болон ард иргэдэд хүрч үйлчилсэн. ЕБСургулийн сурагчдын дунд “АХА” тэмцээн зохион байгуулав.

ТАВ. Соёл, урлагийн чиглэлээр зохион байгуулсан сургалтанд хамрагдах

"Уяхан үамбуу тивийн наран" 3000 уртын дуу, морин хуурчдын урлагийн их наадамд зориулан зохион байгуулж буй сургалтад 2 уртын дуучин, 2 морин хуурч сургаж, тус их наадамд 4 уртын дууч оролцуулав.

Уран үгсийн чуулган “Хөх тэнгэрийн уянга” яруу найргийн цэнгүүнийг амжилттай зохион байгуулав. МУЗН-ийн шилдэг 25 яруу найрагч “Их газрын чулуу” байгалийн цогцолборт газрын байгалийн үзэсгэлэнгийн тухай шүлэг, яруу найргийг уншиж наадамчин олны сонорыг мялаав. “Хөх тэнгэрийн уянга” яруу найргийн наадам нь Дундговь аймгийн мэргэжлийн задгай театрт болсон нь МУ-ын хэмжээнд зохион байгуулагдаж байгаагүй шинэлэг яруу найргийн цэнгүүн байлаа. Уг наадамд МУСГЗ, төрийн соёлхолт яруу найрагч Т.Галсан, До.Цэнджав, Болор цомын эзэд, зохиолч яруу найрагчид оролцлоо.

ЗУРГАА. Угийн бичиг хөтлүүлэх ажлыг зохион байгуулсан байдал

“Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол”, “Угийн бичиг хөтлөх арга зүй” сэдэвт сургалтуудыг Аймгийн Онцгой байдлын газар, Аймаг дахь Цагдаагийн газрын алба хаагчид, Гурвансайхан сумын ЗДТГ, эмнэлэг, цэцэрлэг, сургуулийн төрийн албан хаагчдад зохион байгуулав. Тус сургалтанд нийт 180 хүн хамрагдаж угийн бичгийн талаарх мэдээлэл, мэдлэгтэй болов.

ДОЛОО. Номын сангаас зохион байгуулсан арга хэмжээ, номын баяжилт, уншигчдын төлөвлөгөө

- 4 сарын 22-24-ний өдрүүдэд Мандал худалдааны төв талбайд “Танд ойрхон номын сан”-ийн үйлчилгээг үзүүлж иргэдэд хүрч үйлчиллээ. Тус үйл ажиллагааны хүрээнд үйлчилгээний 3 танхимын үйлчилгээ, ГИЦС-ийн М.Нямаа багштай “Шидэт бийр” уран бичвэрийн дугуйлангийн сурагчдын бүтээлийн үзэсгэлэн, “С.Буяннэмэх тэмдэгтэн” сурагчдын бүтээлийн үзэсгэлэн, сэдэвчилсэн номын үзэсгэлэн, хуучин номын худалдаа, Дундговь аймгаас төрж гарсан зохиолчдын танилцуулга, номзүй зэргээр тус тус үзэсгэлэн гаргаж сурталчиллаа. Тус үйл ажиллагаанд олон төрлийн арга хэмжээ зохион байгуулснаар Танд ойрхон номын сангаар үйлчлүүлэгчдийн тоо 2018 оны эхний хагас жилээс 200 гаруй иргэдээр өссөн байна.
- Аймгийн төвийн СӨБ-ийн 7 цэцэрлэгийн 320 хүүхэд багачууд номын сантай танилцаж, хүүхдийн уншлагын танхимын номын санч тухай бүр чанга уншлага зохион байгууллаа.
- Шинэ номын болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 26 удаа 980 нэр төрлийн ном, сонин, сэтгүүлээр гаргаж уншигч, иргэдэд сурталчилан ажиллаж байна. Үүнд:

1. Төрийн шагналт, зохиолч Д.Нямаа агсаны 80 насны ойд зориулан түүний намтар уран бүтээл, зохиол багтсан нийт 68 номын үзэсгэлэн
2. 4-5 сард ЭЕШ-д бэлтгэгчдэд зориулан “Бид оюутан боллоо” номын үзэсгэлэнг 64 номоор
3. Сар шинийн баярт “Монгол ёс заншил” сэдэвчилсэн үзэсгэлэн 44 номоор,
4. Гэгээн хайрын өдөрт “Гэгээн хайр” сэдэвчилсэн үзэсгэлэн 40 номоор,
5. ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт “Их хувь заяа” 62 номоор
6. Эр цэргийн баярт зориулсан “Монгол цэргийн жавхаа” сэдэвчилсэн үзэсгэлэнг 65 номоор
7. Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд “Үндэсний эх хэл, бичиг соёл минү” үзэсгэлэнг 74 номоор уран бичвэр, 82 ном, сурах бичгээр гаргасан.
8. Миний Монгол бичиг уран бичвэрийн үзэсгэлэнг ГИЦС, Хүмүүнлэг сургуулийн уран бичвэрийн клубтэй хамтран 60 бүтээлээр
9. Дэлхийн гэр бүлийн өдөрт зориулан “Гэр бүлийн аз жаргал” 30 номоор
10. Ялалтын баярт зориулан “Эх орны төлөө” 59 номоор
11. Төрийн албан хаагчдад зориулан 75 номоор
12. Хүүхдэд зориулан “Үлгэрийн орноор аялцгаая” 45 номоор
13. Шинэ номын үзэсгэлэн 10 удаа 125 номоор

14. Олон Улсын инээдмийн баярын өдрөөр Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын харьяат МЗЭ-ийн шагналт, шог зохиолч, яруу найрагч Заяатын Ядмаагийн 75 насны ойд зориулан "ИНЭЭЦГЭЭЕ" сэдэвчилсэн үзэсгэлэн
15. XX Зууны манлай нэрт уртын дуучин Ж. Дорждагвын мэндэлсний 115 жилийн ойд зориулсан "Дуртмал сайхан" 27 номоор
16. "Уяхан үамбуу тивийн наран" 3000 уртын дуу, морин хуурчдын урлагийн их наадамд зориулан "ДУУ ХУУРЫН ӨЛГИЙ ДУНДГОВЬ" сэдвээр 49 ном сэтгүүл, 11 цомог CD-ээр үзэсгэлэн гарган сурталчилж байна.

ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖИЛ

Д	ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ	ӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ҮВЬ
	ІГЧ	20000	20039	100
	ОЛГОЛТ	40000	40790	101
	СЭЛБЭН ЗАСАЛТ	2350	2174	92



2018 оны жилийн эцэстэй харьцуулахад



2019 онд сан хөмрөгийн баяжилт 108 нэр төрлийн 128 ширхэг 2.152.400 төгрөгийн шинэ ном, хандиваар 27 нэр төрлийн 29 ширхэг 260000 төгрөгийн хандивын ном, нийт 135 нэр төрлийн 157 ширхэг 2.412.400 төгрөгийн хэвлэмэл ном, 24 нэр төрлийн 899700 төгрөгийн үнэ бүхий сонин сэтгүүлээр сан хөмрөгийн баяжилт хийж, 100% электрон каталогит оруулан танхимуудад хуваарилан өгч уншлаганд гаргасан. Тус номын сан нь 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 3.312.100 төгрөгийн 159 нэр төрлийн ном, хэвлэлээр фондоо баяжуулан ажиллаа.

НАЙМ. Байгууллагын үйл ажиллагаанд хийгдсэн өөрийн болон хөндлөнгийн хяналт шинжилгээний дүн мэдээ, түүний дагуу авсан арга хэмжээ, ажлын үр дүн, ахиц өөрчлөлт

Номын сангийн цогц программ Lib4U программын 1.8 сервер хувилбарыг шинэчлэн технологийн дэвшил ҮҮЛЭН технологийг нэвтрүүлж, мэдээллийн аюулгүй байдал хангаж, иргэдэд 24 цагийн турш электрон каталогоос мэдээлэл хайх https://lib4u.net/pro/?lib=dundgovi боломжийг бүрдүүллээ. Үүлэн технологи нэвтрүүлнээр электрон каталогийн хайлтын үр дүн 2018 онтой харьцуулахад 80 хувиар өссөн байна.

ЕС. Иргэд, байгууллагын өргөдөл гомдол, түүнийг барагдуулсан байдал

Гадны иргэдээс ирсэн өргөдөл гомдол байхгүй. Байгууллагын 2 ажилтнаас цалинтай чөлөө, 3 ажилтнаас цалингүй чөлөө хүссэнийг шийдвэрлэв.

--- o0o ---

ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗУРГААС

ЗОХИОЛЧ, УНШИГЧДЫН УУЛЗАЛТ 2019
МЗЭ-ийн шагналт, АБТА, СТА, Нацагдоржийн нэрэмжит шагналт, хүүхдийн зохиолч Надмидын МАНДАЛ
МЗЭ-ийн шагналт, Хөдөлмөрийн хүндэт медальт, АБТА, хүүхдийн зохиолч Махсэдийн ДОРЖСҮРЭН
Монголын зохиолчдын эвлэлийн гишүүн, яруу найрагч Ойдовын ГОНЧИГСҮРЭН

POLICE
5555 АУА

ОНЦГОЙ БАЙДЛЫН
ГАЗАР

Ном бол ертөнцийг харах цонх

ТАНД ОЙРХОН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ
НОМЫН САН

Пэрэнлэйн
НЯМЛХАГВА
Иван
ОЮУН-ЭРДЭНЭ

Дундговь нутгийн яруу найрагчдын
НОМЫН НЭЭЛТ
МЗЭ-ын 90 жил, Дундговь аймгийн утга зохиолын нэгдлийн 70 жилийн ойд зориулав

С.Буяннэмэхийн нэрэмжит аймгийн
Төв номын сан
НОМЫН БААР-БИДНИЙ БААР
өдөрлөг

ШИНЭ НОМ ИРЛЭЭ

С.Буяннэмэхийн нэрэмжит аймгийн
Төв номын сан
НОМЫН БААР-БИДНИЙ БААР
өдөрлөг

ЗАВХАН АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Тайлангийн бүтэц:

1. Товч танилцуулга
2. Номын сангийн сан хөмрөг
3. Номын сангийн уншлага үйлчилгээ
4. Лавлагаа номзүйн ажил
5. Номын сангийн мэдээлэл технологийн үйл ажиллагаа
6. Арга зүйн ажил
7. Хүний нөөц
8. Соёл танин мэдэхүйн ажил
9. Төсөв санхүү
10. Бусад үйл ажиллагаа

НЭГ. ЭРХЭМ ЗОРИЛГО, ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга: Завхан аймгийн номын сан нь 1946 онд Гэгээрлийн хэлтсийн даргын 65 тоот тушаалаар аймгийн бага хурлын номын сан нэртэйгээр 500 номтойгоор 1 орон тоотой байгуулагдсан. Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 109-р тогтоолоор төрийн соёрхолт, соёлын гавьяат зүтгэлтэн Б.Явуухулангийн нэрэмжит болон 74 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.

Эрхэм зорилго: Номын сангийн уламжлалт үйлчилгээг орчин үеийн техник технологитой хослуулан цахим номын сангийн үйлчилгээг өргөжүүлэн, түүх соёлын үнэт, өв, ном товхимолыг өсвөр хойч үедээ өвлүүлэн үлдээх, нийгэмд мэдээлэлд тулгуурласан мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэх **"Мэдээллийн нээлттэй"** төв болох

ХОЁР: НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тус номын сан нь 2020 оны байдлаар 52330 ширхэг 110908552 төгрөгийн Монгол, Англи, Орос, Төвд хэл дээрх ном хэвлэлтэй бөгөөд Монгол номын фонд-2, гадаад /орос/ номын фонд- 1, Гадаад /англи/ номын фонд -1 үйл ажиллагаагаа явуулж байна. Сан хөмрөгийн бүрдүүлэлтийг Худалдаа, Хандиваар бүрдүүлдэг бөгөөд ном хэвлэл худалдан авах журмаар бүрдүүлэн ажиллаж байна.
2019 онд 291 нэр төрлийн 554 ширхэг 7421400 төгрөгийн ном хэвлэлээр сан хөмрөгөө бүрдүүлснээс
Худалдаагаар 126 нэр төрлийн 262 ширхэг 4695000 төгрөгөөр
Хандиваар 165 нэр төрлийн 292 ширхэг 2726400 төгрөгөөр фондоо баяжуулан үндсэн фонд болон тасаг танхимуудад хүлээлгэн өгч ажилласан байна.

2019 оноос эхлэн Татгалзлын дэвтэрт бичигдсэн ном захиалгын хэдэн хувь нь бүрдүүлэгдэж байгаад дүн шинжилгээ хийж байгаа бөгөөд номын эргэлтийг судлан уншлаганд гардаггүй, олон хувьтай 1197 ширхэг номыг фонднoос хасах ажлыг хийж Аймгийн орон нутгийн өмчийн газрын дүгнэлтийг гаргуулан үндсэн бүртгэлүүдээс хасч ажиллалаа.

Мөн Нийтийн уншлагын танхим болон Гэрээр ном олгох тасгуудад номын ээлжит тооллогыг хийн акт үйлдэн архивлан ажиллалаа.

ГУРАВ: НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сан нь Уншлага үйлчилгээний:

- Нийтийн уншлагын танхим
- Хүүхдийн уншлагын танхим
- Гэрээр ном олгох тасаг
- Англи хэлний сургалтын танхимаар үйлчилгээ явуулдаг бөгөөд

Номын сангийн стандартын дагуу жилдээ 3800 уншигчдад 55000 ном олгож үйлчлэхээч 3191 уншигч 23398 ирэгсдэд 26496 ном олгож үйлчиллээ. Уншигч- 83,9%-тай, ном олголт 48,1%-тайгаар үйлчилгээ үзүүлсэн байна.

Манай номын сан нь уншлага үйлчилгээг боловсронгуй болгох үүднээс 560 суралцагчдыг зохион байгууллалттай уншлаганд хамруулж танин мэдэхүйн чиглэлээр төрөл бүрийн ажлуудыг тогтмол зохион байгуулж байна.

15 удаа 470 номоор явуулын номын сангийн үзэсгэлэн гаргаж 31 удаа 1228 номоор шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг үйлчилгээний танхимд гаргаж 15 удаагийн тойм хийж 350 хэрэглэгчдэд лавлагаа өгч ажилласан байна.

Зөөврийн номын сангийн үйлчилгээг алслагдсан албан байгууллага аж ахуйн нэгжүүдэд сурталчлах зорилгоор “ Хүлээж суухгүй хүрч үйлчилнэ” уриалга гарган номын сангийн явуулын үйлчилгээг хүргэн ажиллаж байна. /Нийт ЕБ 5-н сургууль, 15 байгууллагад 470 номоор зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэн ажиллалаа.

Мөн сургуулийн өмнөх боловсролын 1, 2, 8 дугаар цэцэрлэгийн ахлах бүлгийн 350 гаруй хүүхдийг зохион байгуулалттай уншлаганд хамруулан номын сангийн үйл ажиллагаатай танилцуулж номын санчид үлгэрийн номоор чанга уншлага хийн тэдэнд ном унших ач тус, номтой нөхөрлөх, талаар яриа таниулга хийлээ.

ЕБС-ийн 560 суралцагчдыг номын сангийн үйл ажиллагаатай танилцуулж чөлөөт цагаараа номын сангаар үйлчлүүлэн, өөртөө хэрэгцээт мэдээлэл олж авах талаар яриа таниулгыг тогтмол хийж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны "Номын баярын өдөр тэмдэглэх" тухай 158-р зарлигийг хэрэгжүүлэх, ном хэвлэлийг сурталчлах ажлын хүрээнд энэ оны 9 сарын 20-нд "НОМЫН БАЯР-2019" арга хэмжээг зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагаанд ЕБС-ын суралцагч, номын санч, багш, яруу найрагчид, идэвхтэй уншигч үйлчлүүлэгчид хүрэлцэн ирж нийт 115 уншигчид оролцлоо.

ДӨРӨВ: КАТАЛОГ, ЛАВЛАГАА НОМЗҮЙН АЖИЛ

Каталог, картын сангийн зохион байгуулалт:

Монгол, орос фондын номыг электрон каталогт бүртгэж дууссанаар номын сангийн бүх ном хэвлэлийг электрон каталогт 100 хувь оруулаа. Мөн 554 ширхэг шинээр ирсэн номонд техник арга ажиллагаа хийн данс бүртгэлүүдэд тусган тасаг танхимууд хуваарилан уншлага үйлчилгээнд ашиглуулж байна.

Мөн ҮДК болон ТАК-т бүрэн редакц хийж картын байрлалыг зөв болгож байрлуулан ажиллалаа.

Орон нутгийн картын санг Завхан нутгаас төрөн гарсан зохиолч, яруу найрагч эрдэмтдийн номоор баяжуулан уншигчдад лавлагаа өгөн ажиллаж байна.

LIB4U програмын онлайнд холбогдон уншигчдыг хаанаас ч номын сангийн ном хэвлэлийг харах, захиалах боломжийг олгон мэдээ мэдээллүүдийг цаг тухай бүрт нь хүргэн ажиллаж байна.

Номзүйн ажил:

Zotero програмд 2019 онд Завхан сонингийн 2009 оны өгүүллийг Үндэсний тогтмол хэвлэлийн өгүүллийн санд оруулах ажлыг хийж нийт 89 өгүүллийг оруулаад байна. 2020 онд Завхан сонины бүх дугаараас шүүлт хийж дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Б.Явуухулангийн 90 насны ойг угтан уншигчдад их найрагчийн намтар уран бүтээлийг сурталчилах зорилгоор түүний намтар номзүйг баяжуулан Номзүй мэдээллийн самбарт байршуулж ажиллалаа.

Мөн “Миний монгол- 2025” аяны хүрээнд Хэлний шинжлэх ухааны фондонд хадгалагдаж буй ном хэвлэлээр санамж өгөх номзүйн бүртгэл хийж уншигчдад лавлагаа өгч ажиллаж байна.

Орон нутгийн номзүй хийх ажлын явц 80 хувьтай байгаа бөгөөд Завхан болон Туяа сониноос өгүүллүүдийг түүн дуусгахаар төлөвлөөд байна.

ТАВ. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЖИЛ

2019 онд өөрийн хэрэглэж буй LIB4U програмын онлайнд холбогдон уншигч хэрэглэгчдэдээ үйлчилж байна.

Сумдын Монбиблио програмыг шинэчлэн үйл ажиллагааг жигд явуулах үүднээс онлайнд холбуулж үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна. Энэ үйл ажиллагаанд 23 сумаас 19 сум онлайнд холбогдон ажлаа явуулж байна.

Фэйсбүүк хуудсаар явуулж буй үйл ажиллагааг ард иргэдэд тогтмол сурталчилан ажиллаж байгаа бөгөөд 2020 онд номын сангийн вэб сайттай болж мэдээ мэдээллээ хүргэхээр ажиллаж байна.

ЗУРГАА: АРГА ЗҮЙН АЖИЛ

Монгол улсын ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийн дагуу Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сан жил бүр "Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Үндэсний бичиг үсгийн баярыг угтаж Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сан уншигчдынхаа нас сэтгэхүйн онцлогт тохирсон олон уралдаан тэмцээн сургалтыг зохион байгууллаа. Байгууллагынхаа ажилтнуудад 20 цагийн Монгол бичгийн сургалт авч монгол бичгийн анхан шатны мэдлэгээ өргөжүүллээ.

LIB4U програмын шинэчилсэн хувилбарыг номын сангийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн Волвес компанийн програмист н.Гантулгатай хамтран програмын сургалтыг 2019 оны 04 сарын 07-08-ны өдрүүдэд байгууллагын ажилтнуудын дунд зохион байгууллаа.



2019 оны 10 сард МҮНС манай номын санд ажиллахтай холбогдуулан сумдын номын санчид болон өөрийн байгууллагын ажилтнуудад мэдээлэл, аргазүйн ажлыг хүргэж сургалтын хэрэгцээг тодорхойлж байна.

МҮНС-аас болон бусад дээд байгууллагаас ирсэн зөвлөмжүүдийг ажилтнуудад мэдээллэж уншлага үйлчилгээнд нэвтрүүлж байна.

СУ мэдээ шинэчилсэнтэй холбогдуулан сумдын номын санчдад мэдээ хөтлөх аргачлалыг фэйсбүүк группээр дамжуулан хүргэж ажиллалаа.

Алдархаан сумын номын санд МҮНС-ийн ээлжит арга зүйн зөвлөгөө ирэхтэй холбогдуулан арга зүйн зөвлөгөө өгөхөөр Номзүйч М.Энхтүвшин, Фондчин Б.Энхцэцэг нар 1 өдөр ажиллалаа.

Мөн сумдын номын санчдад Фэйсбүүк групп болон утсаар байнга арга зүйн зөвлөгөө өгөн ажиллаж байна.

Завхан аймгийн Засаг даргын санаачилгаар 23 сумын Соёлын төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Манлай соёлын төв” уралдааныг 2019 оны 09

сараас 2020 оны 06 сарын 01-ний хүртэл зарлан сар бүр ажлыг дүгнэж байна. Энэ ажлын хүрээнд "Шилдэг номын санч" шалгаруулах ажлын шалгуур үзүүлэлт, дүгнэх журмыг боловсруулан 9-12 дугаар сарын ажлыг дүгнэн НБХ болон БСУГ-т хүргүүллээ. Энэ ажлын хүрээнд номын санчдад өдөр бүр мэдээлэл өгч ажиллаж байна.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 23 өдөр Дугаар 9/285 Улиастай

"Манлай соёлын төв"
шалгаруулах уралдаан зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.1, 2.2, 2.3, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Манлай соёлын төв" шалгаруулах уралдааны удирдамжийг нэгдүгээр, уралдааныг дүгнэх аргачлалыг хоёрдугаар, сумын Засаг даргаар баталгаажуулсан өдөр тутам хийж буй үйл ажиллагааны үнэлгээг гуравдугаар, өөрийн нэрэмжит болгон тогтворжуулсан үйл ажиллагааны нэгтгэлийг дөрөвдүгээр, шинээр санаачлан хэрэгжүүлсэн үйл ажиллагааны нэгтгэлийг тавдугаар, ард иргэдээ соён гэгээрүүлэх чиглэлээр хийсэн үйл ажиллагаа, үр дүнгийн нэгтгэлийг зургаадугаар хавсралтаар тус тус батлсугай.

2."Манлай соёлын төв" шалгаруулах уралдаанд оролцож буй соёлын төвүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажиллахыг сумын Засаг дарга, ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, эрүүл мэндийн төвийн эрхлэгч, төсөвт болон төрийн өмчит байгууллагын удирдлагуудад даалгасугай.

3.Уралдааны удирдамжид заагдсан шагнал урамшууллын эх үүсвэрийг бүрдүүлж, бэлтгэл зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ж.Хүрэлбаатар/-т зөвшөөрсүгэй.

4."Манлай соёлын төв" шалгаруулах уралдааныг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж ажил үүргийн хуваарь гарган удирдамжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, уралдааныг нээлттэй, ил тод шударга дүгнэж аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт танилцуулан ажиллахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар /С.Ганчимэг/-т, энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /А.Шаравжамц/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.БАТСАЙХАН

8111909

Завхан аймгийн төв номын сангийн захирлын
2019 оны 09 сарын 26 өдрийн 9/20 тоот
тушаалын хавсралт

СУМДЫН НОМЫН САНГУУДЫН АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ДҮГНЭХ АРГАЧЛАЛ

1. ШАЛГУУР 1:

1.1. Уншигчийн тоо / 23 сумын номын санчдын сар бүрийн ажлын тайланд тулгуурлан дүгнэх/

Номын сан, мэдээллийн байгууллагад мөрдөх MNS 5742:2007 стандартын дагуу сумын нийтийн номын сан жилд 500-аас доошгүй байнгын уншигчдад үйлчилсэн стандартыг баримтална. / Өссөн дүнгээр: Сар бүрийн шинэ уншигчийг оны эхнээс өссөн дүнгээр нэмж оруулна./

1.2. Иргэсэд / 23 сумын номын санчдын сар бүрийн ажлын тайланд тулгуурлан дүгнэх/

Номын сангаар үйлчлүүлж буй уншигчдын ирцээр энэ шалгуурыг дүгнэнэ. Энэ нь тухайн сард давтагдсан тоогоор хэдэн уншигчдад үйлчилж ном олгосон байдал орно.

1.3. Олгосон ном

Номын сан, мэдээллийн байгууллагад мөрдөх MNS 5742:2007 стандартын дагуу сумын нийтийн номын сан жилд 7800-аас дээш ном олгож үйлчилэл стандартыг баримтална. / Өссөн дүнгээр: Сар бүрийн олгосон ном хэвлэлийг оны эхнээс өссөн дүнгээр нэмж оруулна./

2. ШАЛГУУР 2:

Монбиблио програмд ном оруулсан байдал

Тухайн сумын номын санд хадгалагдаж байгаа нийт ном хэвлэлийг Монбиблио програмд оруулсан номын тоотой харьцуулж гаргана. /2017 онд Төв номын сангийн Захирал, Соёлын төвийн Эрхлэгч, Номын санчийн хамтарсан гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд энэ гэрээнд зааснаар 2017 онд бүх ном хэвлэлээ Монбиблио програмд оруулж дуусгасан байх ёстой боловч ихэнх номын сангууд гэрээний дагуу ном хэвлэлээ оруулж дуусгаагүй байна./

3. ШАЛГУУР 3:

Соёл олон нийтийн ажил

Номын санд уншигч татах зорилгоор үр дүн бүхий СОНА буюу шинээр санаачлан ажил зохион байгуулсан байх тухайн ажилд хамрагдсан бүртгэлтэй болон

"МАНЛАЙ СОЁЛЫН ТӨВ" ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ НОМЫН САНГИЙН АЖЛЫГ ДҮГНЭХ 10 ДУГААР САРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

	Шалгуур 1			Шалгуур 2				Шалгуур 3			Шалгуур 4		Шалгуур 5				Номын сангаар үйлчлүүлсэн иргэдийн тоо			
дын нэр	2019 оны 10 сарын уншигч	Олгосон ном	Авсан оноо	Электрон каталогт ном оруулсан байдал: Нийт номын тоо	Монбиблио програмд ном оруулсан тоо	Хувь	Авсан оноо	Зохион байгуулсан СОНА	Хамрагдсан хүний тоо	Авсан оноо	Загварын дагуу тайлангаа явуулсан эсэх	Авсан оноо	Номын сангийн Уншлагын танхимын болон Фондын зохион байгуулалт	Авсан оноо	Нийт оноо	Эзлэх байр	Иргэсэд	Сумын хүн амын тоо	Харьцуулсан хувь	Тайлбар
хаан	91	124	2	9514	6881	72%	4	4	46	4	тийм	1	хангалттай бус	2	13.1	12	261	2910	8.9	
	35	96	10	3107	3107	100.00%	1	3	221	5	тийм	1	хангалттай	1	18	14	128	975	13.1	
айрхан	23	367	10	5164	5076	98%	1	2	39	6	тийм	1	хангалттай	1	19.1	17	162	2629	6.1	
эс	42	527	1	8313	7685	92%	2	2	90	6	тийм	1	хангалтгүй	3	13	11	220	1835	11.9	
лжин	71	312	2	5547	5547	100.00%	1	4	256	4	тийм	1	хангалттай	1	9.1	6	332	2231	14.9	
	389	947	1	5516	5516	100.00%	1	7	849	1	тийм	1	хангалттай бус	2	6.1	3	621	2529	24.5	
л	52	1783	1	4592	4592	100.00%	1	7	332	1	тийм	1	хангалттай	1	5	1	433	6440	6.7	
нмандал	23	39	10	7234	4259	58.80%	6	3	150	5	тийм	1	хангалттай бус	2	23	21	105	1107	9.4	
	5	55	10	11445	6730	58.8	6	0	0	10	үгүй	10	хангалттай бус	3	39	23	13	2628	0.4	
устэй	54	595	1	9506	9506	100%	1	2	123	6	тийм	1	хангалттай бус	2	11.1	9	228	1778	12.8	
нхайрхан	33	51	10	5367	5367	100.00%	1	1	14	7	тийм	1	хангалттай бус	2	21.1	20	60	1305	4.6	
нчулуут	10	42	10	5493	5493	100%	1	3	179	5	тийм	1	хангалттай бус	2	19	16	189	1286	14.6	
эг	67	615	1	8307	2745	33.30%	8	4	452	4	тийм	1	хангалттай бус	2	16	13	543	1885	28.8	
цэнгэл	51	457	10	11276	7150	63%	5	4	1435	4	тийм	1	хангалттай	1	21	18	1876	9312	20.1	
тэй	69	765	1	7489	6274	84.50%	3	3	394	5	тийм	1	хангалттай	1	11	8	686	1907	35.9	1215
эн	45	303	2	8065	8065	100%	1	3	273	5	тийм	1	хангалттай	1	10	7	491	2809	17.4	
	46	703	1	8128	5018	63.30%	5	3	720	5	тийм	1	хангалттай	1	12	10	509	2900	17.5	3100
ал	54	257	2	6855	6810	99%	1	7	271	1	тийм	1	хангалттай	1	6	2	351	1314	26.7	
маргаз	68	317	2	10246	10246	100.00%	1	5	806	3	тийм	1	хангалттай	1	8	4	347	1588	21.8	
но	44	466	2	6288	6288	100%	1	4	184	4	тийм	1	хангалттай	1	9	5	417	1554	26.8	
-Уул	45	145	10	10125	6800	67.10%	5	3	260	5	тийм	1	хангалттай бус	2	23.1	22	125	1665	7.5	
эхайрхан	15	53	10	4593	3564	77.50%	4	3	188	5	тийм	1	хангалттай	1	21	19	213	1700	12.5	
	102	1250	10	5094	5094	100	1	4		4	тийм	1	хангалттай бус	2	18.1	15	1689	2007	84.1	
	Иргэсэд буюу давтагдсан уншигчийг хүн амын тоонд харьцуулахад 23 сумын дундаж																9999	56294	17.7	

Мөн МҮНС-ийн Хэлтсийн дарга Д.Энхтунгалаг, Аргазүйч Б.Сарандэлгэр нартай Цагаанчулуут, Алдархаан сумдад ажиллаж номын сангийн байдалтай танилцан зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн номын сангийн ажилтнуудад Номын сангийн эрх зүйн акт, Солонгосын номын сангийн талаар 2 цагийн сургалтыг зохион байгууллаа.

Цагаанхайрхан, Эрдэнэхайрхан, Асгат сумдын шинээр орсон номын санчид ирж 5 хоногийн дадлага хийн анхан шатны мэдлэгтэй болон ажиллаж байна.



“Бид соёлынхон 2019” соёлын ажилтнуудын чуулга /2019.08.29-30-ны өдрүүдэд/ уулзалтаар сумдын номын санчдад Шинэчилсэн СУ мэдээ гаргах, Фондын тооллого хийж акт үйлдэх, Номын сангийн үйлчилгээ сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.

ЧЭЛС-ийн багш О.Дуламсүрэн, н.Бямбасүрэн багш нартай хамтран “Монгол хэлний зөв бичгийн дүрэм”-ийн сургалтыг зохион байгуулж ажилтан албан хаагчдын зөв бичгийн дүрмийн мэдлэгийг өргөжүүллээ.

Орон нутаг судлах музейн эрдэм шинжилгээний ажилтан Б.Цолмонтой хамтарч “Ургийн бичиг хөтлөх арга” сэдэвт сургалт зохион байгууллаа.

ДОЛОО: ХҮНИЙ НӨӨЦ

Манай номын сан нь захирал, нягтлан бодогч, ном зүйч, мэдээллийн технологич, мэдээллийн ажилтан, фондчин, номын санч-3, зөөврийн номын санч, үйлчлэгч сахиул гэсэн 11 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Эдгээр ажилтнуудаас Мэргэжлийн номын санч-4, Номын сангийн чиглэлээр Магистр хамгаалсан ажилтан – 3 ажиллаж байгаа бөгөөд номын санчдыг мэргэшүүлэн сургах сургалтанд хамруулж чиглэл чиглэлээр нь туршлага судлуулсан дадлага ажлуудыг хийлгэвэл номын санчдын ур чадвар дээшилнэ.

Байгууллагын ажилтнуудын мэдлэг мэдээллийг тэлэх зорилгоор сургалтын хэрэгцээг тодорхойлон улирал бүр Зөв бичих дүрэм, Монгол бичиг, Ургийн бичиг хөтлөх арга, хууль эрх зүйн мэдлэг олгох сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна.

НАЙМ. СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ

Хэлний бодлогын зөвлөлийн Завхан аймаг дахь салбар зөвлөлтэй хамтран "Босоо бичигтэн" уралдааныг 3 төрлөөр /Бийрэн бичлэг, Уралдаант уншлага, Цээж бичиг/ Завхан аймагт үйл ажиллагаа явуулж буй албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн албан хаагчдын дунд 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Уралдаанд 21 байгууллагын 40 гаруй ажилтан

оролцлоо.

Мөн монгол бичиг анхлан суралцагчдад зориулж 7 хоног бүрийн Лхагва гарагийг Монгол бичгээр унших өдөр болгон эх хэлний ном , сурах бичгүүдээр үзэсгэлэн гаргаж Хүмүүн бичиг сонинг олноороо унших уриалга гарган ажиллалаа.

Дорнын их яруу найрагч Бэгзийн Явуухулангийн 90 насны ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд ойг угтаж, ойн үйл ажиллагааны үеэр цэцэг өргөх ёслолын бэлтгэл ажлууд, Завхан нутгаас төрөн гарсан болон “Очирвааанийн их эгшиглэн” яруу найргийн наадамд оролцогчдын бүтээлээр “Цадиг түүхт цаст уулынхан” сэдэвт номын үзэсгэлэн гаргаж их найрагчийн амьдрал уран бүтээлийг уншигчдад сурталчлах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх, сургамжит болон бусад өгүүллэгээр дамжуулан амьдралын зөв дадал хэвшилтэй болгох, ном уншдаг суралцагчид болон анги хамт олныг алдаршуулан шагнан урамшуулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилготой СУРГАМЖИТ ӨГҮҮЛЛЭГ унших сарын аяныг Б.Явуухулангийн нэрэмжит Төв номын сангийн Хүүхдийн уншлагын танхим болон Дэлхийн зөн Завханхангай ОНХХ-тэй хамтран 3 дугаар сарын 22-ноос 5 дугаар сарын 8-ны хүртэл амжилттай зохион байгуулж дууслаа.

Үсэглэлийн хаад зорилтод уралдаанд ЕБС-н 5-р ангийн суралцагчид хамрагдлаа. /Нийт 12 багийн 60 суралцагчид оролцлоо./

Хүүхэд багачуудыг ном унших дадал зуршилтай болгох, нас сэтгэхүйд тохирсон хуучны болон орчин үеийн зохиолуудыг уншуулах, номтой зөв боловсон харьцуулж сургах зорилготой Завхан нутгийн болон бусад уул усны тухай домог үлгэр өгүүллэгүүдийг уншуулан түүгээрээ асуулт хариултын АХА тэмцээнийг ЕБС-иудын 5 дугаар ангийн бүх суралцагчдын дунд зохион байгууллаа.

Отгонтэнгэрийн УТХГ-ын захиргаатай хамтран эх дэлхийгээ аврахын тулд бид бүгд хамтдаа уриан дор Байгаль-экологийн Миний нутаг сэдэвт илтгэлийн уралдаан ЕБС-ийн сургуулиудтай хамтран зохион байгууллаа.

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Завхан аймгийн монгол банктай хамтран Банкны хөгжил-95 жил аяны хүрээнд монгол банкнаас гаргаж байгаа ном хэвлэмэл бүтээгдэхүүн, цахим хуудсыг сурталчлах иргэн бүрт санхүүгийн мэдлэг олгох, төрийн мөнгөний бодлогийн талаар мэдээлэл өгч, номын үзэсгэлэн гаргаж , үзэсгэлэнгийн тавиур болон 30 гаруй нэр төрлийн 130 гаруй номыг бэлэглэж хамтарсан арга хэмжээ зохион байгууллаа.

Төв номын сангаар идэвхитэй үйлчлүүлэн, зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцож Тэргүүний уншигч "Д. Нацагдорж, "Б. Явуухулан" тэмдэгээр шагнагдсан Шилдэг уншигчдын сүлд модны наадмыг зохион байгууллаа. Уг сүлд модны наадамд 75 хүүхдүүд оролцуулан, гарын бэлэг гардууллаа.

Амжилтын шат төрийн бус байгууллагын захирал лектор Ш.Бадамдорж ЕБС-ийн номч клубын 25-н сурагчдад "Ном унших ач тус" лекц уншиж, халуун яриа өрнүүллээ.

Дэлхийн зөн ОУБ Завханхангай ОНХХ-тэй хамтран Улиастай сумын ЕБС-иудын Номч клубүүдийн дунд гишүүдийн танилцуулах, тэдний хоорондын уялдаа холбоог сайжруулж багаар ажиллах чадварыг дээшлүүлэх зорилгоор олон төрөлд танин мэдэхүйн уралдаанд 2019 оны 11-р сарын 29-нд амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд ЖЦСургуулийн "Номч клуб" ЕБ-ын 3 дугаар сургуулийн "Номч клуб" Дэвшил сургуулийн "Номч клуб'' нар тус тус хамрагдсан бөгөөд Төв номын сангийн зүгээс 4 заал танхимаас тус бүр нэг уралдааныг зохион байгуулсан. Хүүхдийн уншлагын танхимаас "Алтан хонх" танин мэдэхүйн тэмцээн, Гэрээр ном олгох тасгаас "Центавр" танин мэдэхүйн тэмцээн, Гадаад уншлагын танхимаас "Та та тунгаа" хөгжөөнт тэмцээн Нийтийн уншлагын танхимаас "Үсэглэлийн хаад" уралдаан зохион байгууллаа.

ЕС: БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарилгын дагуу жил бүрийн 5 сард бүх нийтээр мод тарих үндэсний өдөр аянд идэвхтэй хамрагдаж байгууллагын гадна талын талбайд 27500 төгрөгийн 11 ширхэг чацарганы суулгац тарьж, 10000 төгрөгийн 10 ширхэг цэцгийн мандалын үр үрслүүлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Б. Явуухулангийн нэрэмжит төв номын сан "ЭКО ЗАВХАН" аяны хүрээнд төлөвлөгөө боловсруулан, байгууллагын даргаар батлуулан 8-н төрлийн ажлыг хийж гүйцэтгэлээ. Уг ажлыг хийж гүйцэтгэхэд **545,800** төгрөгийн төсвийг байгууллагын хөрөнгөөс гаргаж

Архив, албан хэрэг хөтлөлийн үндсэн зааврын дагуу стандартыг мөрдөн ажиллаж байна. Мөн Аймгийн архив, албан хэрэг хөтлөлтийн урьдчилсан үзлэгт 92.8% амжилттай хамрагдлаа.

Номын сангаар үйлчлүүлэгч иргэд, хүүхэд багачуудыг номын сангийн үйлчилгээний төлбөр хураамжийг талаар танхимын номын санч нар зөвлөгөө өгөн ажиллаж байна. Мөн гадуур гаргасан номын хугацаа хэтрэлт, ном ашиглалтын талаар хяналт тавин ажиллаж цахим сайтаар мэдээлэл сурталчилгааг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж байна.

ОРХОН АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Эрхэм зорилго. Илүү нээлттэй, чөлөөтэй, орчин үеийн үйлчилгээг ашиглан хүн бүрт мэдээлэл хүргэх замаар нийгэмд идэвхитэй, мэдлэгтэй ирэнийг төлөвшүүлэхэд оршино.

Зорилт 1: **Номын сангийн үндсэн фондын өрөөний агааржуулалт, хананы тусгаарлагч хийх асуудлыг батлагдсан төсөвийн дагуу хийж гүйцэтгүүлэх** Номын төвийн барилгын үндсэн фондын хэсэгт агааржуулалт, гэрэлтүүлэг, хананы тусгаарлагч хийх засварын ажлыг “Хаст Шонхор” ХХК орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 32911,744 мянган төгрөгөөр хийж гүйцэтгүүлсэн байна.

Зорилт 2: **Аймаг нийслэлийн нийтийн, их дээд сургууль, ЕБС-ийн номын сангуудын ажилтнуудын дунд спортын наадмыг зохион байгуулах** Аймаг нийслэлийн нийтийн номын сан, их дээд сургуулийн номын санчдын шилжин явах цомын төлөөх спортын 7 төрлийн тэмцээнд 16 баг тамирчид оролцсон спортын наадмыг зохион байгууллаа. Тэмцээнд нийт 200 гаруй тамирчид хамрагдаж аймгийн ЗДТГ-аас 3600,0 мянган төгрөгийг шагнал урамшуулалд гаргасан байна.

Зорилт 3: **Номын санчдын мэргэшлийг дээшлүүлэх чиглэлээр дотоод гадаадын сургалтанд хамруулах** Номын санчид “Уншигчидтай ажиллах ажил”, “Номзүй хийх ач холбогдол”, “Соёл танин мэдэхүйн ажил”, “Номын сангийн үйлчилгээ, үйлчилгээний ажилтны соёл” зэрэг мэргэжлийн сэдвээр номын санчид 9 төрлийн мэргэжлийн сургалт хийж номын санчид хооронд бие биенээсээ туршлага судлах мэргэжлийн ном унших зэрэг ахицтай ажлыг хийлээ. Дарханд болсон “Хамтдаа хөгжье” бүсийн ажил мэргэжлийн арга хэмжээнд 8 хүн оролцож 2 байранд шалгарсан

Нэг. Уншлага үйлчилгээ

2019 онд Номын төв нь 4 танхим, 1 салбар номын сангаар ном, сонин олгож үйлчлэн, гэрээр ном олгох, албан газар байгууллагуудаар нүүдлийн номын сан ажиллуулах зэрэг уншлагын үйлчилгээ хийж 7586 шинэ уншигчдад карт нээж байнгын 61514 ирэгсдэд 137797 ном олгож үйлчилсэн байна. Номын төвөөс уншлага үйлчилгээг өргөжүүлэх, хүүхдийг номтой багаас нь нөхөрлүүлэх, номын сангийн үйл ажиллагаатай танилцуулах ажлыг зохион байгуулж ЕБС-ийн сурагчдыг анги бүлгээр нь зохион байгуулалттай авчирч 18 удаа 647 хүүхдийг хамруулсан байна. Шинээр карт нээлгэсэн 7172 уншигчийн бүртгэлийг номын сангийн программд шивж бүртгэн 75 хүний картыг сунгалаа. Номын сангийн үндсэн фондоос нийт 12 нэрийн сонин 18 ширхэг номыг танхимуудын ойрын фондонд татан үйлчилгээ хийж сонингийн материалаас 26 сэдэвчилсэн хайлтын материал олж үйлчилсэн байна.

Виртуал гадаад хэлний танхим, номын сангийн үйлчилгээнээс гадна цахим хэлбэрээр интернет хуурцаг, дискээр үйлчилж интернетээс мэдээлэл хайхад туслах ажлыг давхар хийж 168 хүнд интернет үйлчилгээ, 105 хүүхэд хуурцаг авч ашигласан байна.

2019 онд Дэнжийн болон Хүний хөгжлийн дэргэдэх салбар номын сангууд татан буугдаж аймгийн Гэр бүл залуучууд хөгжлийн газарт нүүж 2 ээлжийн номын санчтай амралтын өдөргүй ажиллан гэр бүлийн уншлагын танхим, салбар номын сангаас уран зохиолын номыг 2193 хүнд 2310 номыг олгож 1135,5 мянган

төгрөгийн орлоготой гэрээр ном олгон, 17 нэрийн сонин, 5 нэрийн сэтгүүл нийт 23 нэрийн тогтмол хэвлэл захиалан авч өдөр тутам уншуулж байна.

Гадаад хэлний танхимын дэргэдэх БЗМТ / Боловсролын зөвлөгөө мэдээллийн төв/ аймагт ажиллаж буй Энх тайвны корпусын багш ажилтануудтай хамтарч англи хэл сонирхогчдын дунд олон төрлийн ажил зохион байгуулан ажиллаж байна. 7 хоног бүрийн Даваа, Мягмар, Баасан, Ням гаригуудад англи хэлний насанд хүрэгчдийн болон хүүхдийн , "Монглиш" хүүхдийн ярианы клуб, насанд хүрэгчдийн кино үзүүлэх, ярианы клуб ажиллуулан кино үзүүлэн ярилцах, энэ оноос шинээр "Кореан speaking club", "Chinese speaking club", "Health club", клубуудыг ажиллуулж 2773 хүн хамрагдсанаас 1837 насанд хүрэгчид, 936 хүүхэд хамрагдсан байна

Хоёр: Ном зүйн үйлчилгээ

Энэ онд нийт танхим номын санчид 8 төрлийн санамж өгөх ном зүй гаргасан байна. Нийтийн уншлагын танхимын номын санч Д.Отгонцэцэг, Ч.Эрдэнэсувд нар Төрийн шагналт, СГЗ яруу найрагч зохиолч Б.Явуухулангийн 90 жилийн ойд намтар номзүй, Төрийн шагналт зохиолч С.Эрдэнийн 80 жилийн ойд намтар ном зүй, Гадаад хэлний танхимын номын санч Н.Ганболор өөрийн танхимд байгаа гадаад хэлний номоор бүртгэн мэдээлэх ном зүй, хүүхдийн уншлагын танхимын номын санч Г.Мөнхдулам Хүүхдийн зохиолч, яруу найрагч Д.Мандахсаны уран бүтээлээр санамж өгөх номзүй зэрэг ном зүйн бүтээлүүд гаргасан байна.

2019 онд шинээр ирсэн 39 номоор шинэ номын мэдээ гарган, , номын санч Ч.Эрдэнэсувд Zatero программын сургалтанд сууж 2011,2013,2012,2018 оны "Өнөөгийн Эрдэнэт" сониноос 342 материалыг тус программд шивж оруулсан.

Нийтийн уншлагын танхим нь лавлагааны дэвтэрийг G-Mail дээр хийн хөтлөж нийт 183 лавлагаа, Татгалзлын дэвтрээр 71 хүнээс татгалзал хүлээн авч урагдаж салсан 284 ном, 30 төрлийн сонин нааж хавтаслах ажил хийгдсэн байна.

Ном сэлбэн засалт



2019 оны эхний хагас жилийн байдлаар Үндсэн хуулийн өдөр, Сар шинийн баяр, Сансрын нисэгчдийн өдөр, Наурызын баяр, Дэлхийн номын өдөр, Үндэсний бичиг үсгийн баяр зэрэг тэмдэглэлт өдөр баярыг угтсан үзэсгэлэн 68 удаа гарган 1460 номоор гарган шинэ номоор 21 сэдэвчилсэн 16 шинэ номоор үзэсгэлэн гаргаж, алслагдсан баг, сургууль байгууллагуудаар зөөвөр 147 удаа 1468 номоор 1978 хүнд хүргэж үүнээс зорилтот бүлгийн иргэдэд 58 удаа 105 номоор 58 хүнд хүргэж үйлчилсэн байна.

Номын тоймыг 75 удаа 1917 хүүхдэд, чанга уншлагыг 64 удаа, 1134 хүүхдэд хийж, үлгэрийн цагийг 3 удаа 1134 хүнд хийсний 2 удаа 60 хүүхдэд гадаад хэлний танхимаас англи хэл дээр үлгэр сонсож ярилцах ажлыг хийж эхлээд байна. Байгууллага, үйл ажиллагааны ажлаа сурталчлах ажлыг орон нутгийн хэвлэл

мэдээлэл, цахимаар 114 удаа үүнээс орон нутгийн телевизээр 10 удаа, FM-ээр 2 удаа бусад цахимаар 105 удаагийн мэдээ мэдээлэл явагдсан байна.

2019 оны   үзэсгэлэн, зөөвөр, номын тойм,
чанга уншлага, үлгэрийн цаг, мэдээ мэдээллийн нэгтгэл

Танхим / Чиглэл	НУЗ	ХУЗ	Го/Гб	В/Гх	СНС	УҮА	ДҮН
Үзэсгэлэн	23 удаа 699ном шинэ ном-6 сэд-17	13 удаа 456 ном ш/н-1 сэд-12	14 удаа 580 ном ш/н-8 сэд-6	7 удаа 249 ном ш/н-1 сэд-6	11 удаа 599 ном ш/н-6 удаа сэд-5 удаа		**68 удаа 2583 ном Ш/н-22 Сэд-46**
Зөөвөр	13удаа 84 ном 206 хүн	17 удаа 340 ном 252 хүн	13 удаа 209 ном 546 хүн	8 удаа 148 ном 243 хүн	38 удаа 582 ном 673 хүн		**89 удаа 1363 ном 1920 хүн**
Номын тойм		23 удаа 350 хүн	24 удаа 400 хүн	17 удаа 583хүүхэд	11 удаа 584 хүүхэд		**75 удаа 1917хүүхэд**
Чанга уншлага		23 удаа 400 хүн	24 удаа 344 хүн	1 удаа 30 хүүхэд	16 удаа 360 хүүхэд		**64 удаа 1134 хүүхэд**
Үлгэрийн цаг				2 удаа 60 хүүхэд	1 удаа 30 хүүхэд		**3 удаа 90 хүүхэд**
Мэдээ мэдээлэл	10 удаа FM-1 FB-9	44 удаа ТВ-2 удаа FB-42 удаа Танх/мэд-13 удаа	7 удаа FB- 7 удаа	6 удаа ТВ-3 FB-6	33 удаа ТВ-2 удаа FB-31 удаа	14 удаа ТВ-3 FM- 1 удаа FB- 10 удаа	**114 удаа ТВ-10 удаа FM- 2 удаа FB-105 удаа**
Зорилтот бүлгийн хүмүүс		33 удаа 68 ном Өөрөө-33 удаа	9 удаа 9 ном Гэрт-9 удаа	5 удаа 5 ном Өөрөө 5 удаа	11удаа 23 ном Гэрт-11 удаа		**58 удаа 105 ном Өөрөө-38у Гэрт-20уда**

НУЗ - Нийтийн уншлагын танхим

ХУЗ- Хүүхдийн уншлагын танхим

В/Гх- Виртуал-гадаад хэлний танхим

Го/ГБ- Гэр бүлийн танхим

ХХС- Хүний хөнжлийн салбар номын сан

СНС- Салбар номын сан

ҮҮА –Уншлага үйлчилгээний алба

Дөрөв. Олон нийт хамтын ажиллагаа

2019 оны жилийн байдлаар Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх эх хэл, бичиг үсэг, баримтат өв соёлоо сурталчлан түгээх зорилгоор зохион байгуулдаг уламжлалт “Үндэсний бичиг үсгийн баяр-2019” аяныг Орхон аймгийн Нийгмийн бодлогын газар, БСУГ, аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулж БСШУС-ын сайдын 2018 оны А/683 тушаалын хавсралт “Уншлагыг дэмжих журам”-ыг үндэслэн Дэлхийн номын өдөр, Дэлхийн хүүхдийн номын өдрийг угтан олон ажил зохион байгуулсанаас гадна байгууллагын төлөвлөгөөт СОНА өв уламжлал зан заншил, танин мэдэхүй, эрүүл мэндийн, байгал экологи, уран зохиолын бусад чиглэлээр аймгийн иргэд, ЕБС, СӨБ-ын хүүхдүүдийн дунд соёл олон нийтийн 40 төрлийн уралдаан, тэмцээн, АХА, номын баяр, тэмдэглэлт өдөр, уулзалт ярилцлага зэрэг ажилд 2145 хүн хамрагдаж нийт 5094,7 мянган төгрөгийг гарган байгууллагаас 1962,7 мянган төгрөг / ЗДТГ-2500,0 төг/ , хамтран ажилладаг байгууллага, хандиваар 2972,0 мянган төгрөг, хандиваар 160,0 мянган төгрөг зарцуулан төлөвлөгдсөн хамтын ажиллагааны хүрээнд хийгдэх соёл олон нийтийн ажлуудаас 4 ажил төсвийн хүрэлцээгүйгээс тасарсан байна. Мөн энэ жил Үндэсний номын баярыг оны эхнээс аймгийн хэмжээнд зохион байгуулж тэгш ой тохиож байгаа зохиолчдын бүтээлээр Төрийн шагналт зохиолч яруу найрагч Б.Явуухулангийн 90, Төрийн шагналт яруу найрагч, зохиолч П.Бадарчийн 80 жилийн ойд “Тэхийн зогсоол” “Есөн эрдэнийн орон” зохиолуудаар их дээд сургуулийн оюутан, 11,12 дугаар ангийн сурагчдын дунд илтгэлийн уралдаан, Төрийн шагналт зохиолч С.Эрдэнийн өгүүлэг, туужаар 8,9 ангийн хүүхдүүдийн дунд дүрийн тоглолттой асуулт хариултын тэмцээн 9,10 ангийн хүүхдүүдийн дунд “Утгын чимэг” уран уншлагын тэмцээн зохион байгуулж 199 хүүхэл хамрагдсан байна. Дэлхийн номын өдрөөр аймгийн “Орхон” МСҮТ-ийн оюутны дотуур байранд байрны багш яруу найрагч Дү. Отгонбаярын санаачилгаар номын сан байгуулах ажлын эхлэлийг тавьж 180 гаруй нэрийн ном, номын тавиур бэлэглэлээ.

“Үндэсний бичиг үсгийн баяр-2019” ажлын хүрээнд “Сайхан бичигтэн” “Түргэн уншлага” “Монгол бичгийн хөрвүүлэг”, “Бүтээлийн уралдаан”, Амьд бичиг” бийрийн уралдааныг нас насны ангилалд явуулж нийт 300 гаруй сурагч, 140 гаруй насанд хүрэгчид хамрагдсан байна. Үндэсний бичиг үсгийн хаалтыг 2019 оны 05 сарын 09 өдөр хийж урилгаар аймгийн Засаг даргын орлогч Д. Түвшинжаргал, БСУГ-ын дарга Э.Бат-Амгалан, БСУГ-ын Монгол хэл бичгийн сургалт хариуцсан мэргэжилтэн Г. Оюунбилэг нар оролцож уралдаан тэмцээний шагнал урамшууллыг гардуулан өглөө. Бичиг үсгийн баярын уралдаан тэмцээний зардлыг аймгийн нийгмийн бодлогын хэлтсээс 2500,0 мянган төгрөг, хүрээнд үндэсний бичгийн анхан шатны мэдлэг, чадварыг шалгах шалгалтын ЕБС, СӨБ, СУБ-ын шагналыг аймгийн хэлний бодлогын зөвлөлөөс санхүүжүүлсэн байна.

Номын төвийн 2019 оны СОНА -ын нэгтгэл

Сэдэв / Танхим	НУЗ	ХУЗ	Го/Гб	В/Гх	СНС	ҮҮА	ДҮН
о□□□□□□□ □□□ □□□□□			1				**1**

[illegible]	2	2	1	3	3		**11**
оз Н[illegible], [illegible]	3	3					**6**
[illegible], [illegible], Бичиг үсгийн баяр	2	1		1	1	4	**9**
Эссэ зохион бичлэг				1			**1**
Уулзалт, ярилцлага лекц мэдээлэл	4	1	2		4	1	**12**
Нийт хийсэн ажлын тоо / Хүний тоо /	**11 удаа 464 хүн**	**7 удаа 261 хүн**	**4 удаа 167хүн**	**5удаа 167 хүн**	**8 удаа 405 хүн**	**5 удаа 690 хүн**	**40 удаа 2154 хүн**
Нийт зардал	**780,000 Бай-565,0 Х/б- 215,0**	**471000 Бай-375,0 Х/б- 96,0**	**155400 Б-80,4 Х/Б-75,0**	**702300 Б-642,3 Хан-60,0**	**486,000 Б-300,0 Х-100,0 Х/Б-86,0**	**2500,0 ЗДТГ-2500,0**	**5094.700 Б-1962,7 Х/Б-2972,0 Х-160,0**

Чиглэл / танхим	**НУЗ**		**ХУЗ**	**Го/Гб**	**В/Гх**	**СНС**	**ҮҮА**	**ДҮН**
Өв уламжлал, зан заншил	2		2		1		1	6
Эрхзүйн боловсрол								
Танин мэдэхүй, чөлөөт цаг	9		4	4	3	7	4	31
Эрүүл мэндийн			1			1		2
Байгал экологи								
Бусад					1			1
Нийт	**11**		**7**	**4**	**5**	**8**	**5**	**40**

НУЗ - Нийтийн уншлагын танхим

ХУЗ - Хүүхдийн уншлагын танхим

В/Гх - Виртуал-гадаад хэлний танхим

Го/ГБ - Гэр бүлийн танхим

СНС - Салбар номын сан

ҮҮА - Уншлага үйлчилгээний алба

Байгууллагын "Нээлттэй хаалганы өдөр"-ийг 2 удаа Урт цагааны талбайд хийж танхимууд өөрсдийн танилцуулга номын дээжээс үзэсгэлэн гаргаж, аймгийн иргэдийн дунд хуучин номын худалдаа, ном солилцоо, уншигчийн үнэмлэхийг 50 хувь хөнгөлөх, 3 хоног гэрээр үнэгүй ном олгох зэрэг үйлчилгээ хийлээ.

Сургалт, ажлын заавар зөвлөгөө:

2019 оны жилийн байдлаар байгууллагын төлөвлөгөөт сургалтаар "Уншигчидтай ажиллах ажил", Номзүй хийх ач холбогдол", "Соёл танин мэдэхүйн ажил", "Номын сангийн үйлчилгээ, үйлчилгээний ажилтын соёл" зэрэг мэргэжлийн сэдвээр номын санчид 9 төрлийн мэргэжлийн сургалт хийж номын санчид хоорондоо бие биенээсээ туршлага судлах мэргэжлийн ном унших зэрэг ахицтай ажлыг хийлээ. Байгууллагын ҮЭ-ийн хороо, ХЗТ-ын ҮЭ-ийн хороотой хамтран Номын

төвийн захиргаа, ҮЭ-ийн хорооноос аймгийн Нийгмийн даатгалын улсын байцаагч Бумаа, Эрүүл мэндийн тасгийн дарга Саранчимэг нараар "Нийгмийн даатгалын сан","Эрүүл мэндийн даатгалын сан" "Хувь хүний хөгжил" сэдвээр сургалт, "Хамтын гэрээгээр зохицуулах харилцаа", ХАБЭА-н сарын аяны хүрээнд анхны тусламж үзүүлэх хөдөлмөр аюулгүй байдын дүрэм журам заавраар сургалт зохион байгуулж Улаанбаатар хотод "Mongolian Library update-2019" номын санчдын зөвлөгөөнд УҮА-ны дарга Н.Отгонцагаан, номын санч Д.Отгонцэцэг нар оролцож, Дарханд болсон "Хамтдаа хөгжье" бүсийн ажил мэргэжлийн арга хэмжээнд 8 хүн оролцож 2 байранд шалгарсан ба энэ онд байгууллагаас гаднаас 6 төрлийн сургалт зохион байгуулж нийт соёл урлагийн байгууллагын ажилтан ажиллагсадтай нийт давхардсан тоогоор 240 хүн хамрагдлаа. Номын төвийн дарга А.Уранчимэг, Уншлага үйлчилгээний албаны дарга Н.Отгонцагаан архив бичиг хэргийн ажилтан С.Урантүлхүүр нар төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургатанд 3 удаа хамрагдсан байна.

Мөн энэ онд аймгийн ЕБС-ийн 6 номын санд УҮА-ны дарга Н.Отгонцагаан шалган зааварлах ажлыг аймгийн МХГ-ын байцаагч Биндэръяатай хамтран хийлээ. Шалгалтын явцад сургуулийн номын сангууд номоо нэгбүрчилсэн бүртгэлд бүртгээгүй, номын формуляр хөтлөөгүй, нэгдсэн бүртгэл огт гаргадаггүй, өдөр тутмын бүртгэлийг тогтмол хөтөлдөггүй, тооллогыг нэг бүрчилсэн бүртгэл программаар хийдэггүй зэрэг дутагдал илэрч байсанд арга зүйн заавар зөвлөгөө өгч ажиллаа.

Мөн Орхон МСҮТ-ийн номын сан шинээр байгуулж зохион байгуулахад заавар зөвлөгөө өгч нэгбүрчилсэн бүртгэл хөтлөх номыг ангилж данслах талаар туслан дэмжлэг үзүүлсэн байна. Номын төвийн дарга А.Уранчимэг Жаргалант сум, Баянцагаан багийн соёлын төвийн номын сангийн ажилтай танилцаж арга зүйн заавар зөвлөгөө өгсөн ба танилцах явцад өдөр тутмын бүртгэлийг тогтмол хөтөлдөггүй, номын сангийн мэргэжлийн ажлыг стандартын дагуу хийж ажиллахыг зөвлөн ажилласан байна.

Фондын ажил, тооллого тооцоо

2019 онд улсын төсвөөр шинээр ном, сонин авах 4368,3 мянган төгрөгийн төсөв батлагдаж үүнээс номын сангийн фондын сан хөмрөгт шинээр 149 нэрийн 243 ширхэг 4724960 төгрөгийн ном шинээр нэмэгдсэнээс төсвөөр 108 нэрийн 181 ширхэг 3377600 төгрөгийн, хандиваар 41 нэрийн 62 ширхэг 1347360 төгрөгийн ном, 17 нэрийн 689100 төгрөгийн сонин, 5 нэрийн 300400 төгрөгийн сэтгүүл нийт 23 нэрийн 989500 төгрөгийн тогтмол хэвлэл захиалан авсан байна. 2019 оны номын сангийн фондын баяжилтыг 2018 онтой харьцуулахад номын тоо ширхэг 70 хувиар, үнийн дүн нь 40 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь БСШУСЯ-наас олгож байсан шинэ ном авах 3,0 сая төгрөгийг энэ жил олгоогүй байдал нөлөөлсөн байна. / харьцуулалтын график доод хэсгээс харах/

Мөн 2010, 2015, 2019 оны номын сангийн фондын баяжилтыг харьцуулалтаар авч үзвэл номын нэр 531-149, номын тоо ширхэг нь 694-243 болон буурч номын үнийн дүн төсвөөр авсан хэмжээ ижил гарсан байна.

Дэнжийн салбар номын сан, Хүний хөгжлийн дэргэдэх салбар номын сан татан буугдаж аймгийн Хүүхдийн ордонд нэгдэн орсон учир салбар номын сангуудаас ирсэн 427 ширхэг 4643000 төгрөгийн номыг нөхөн бүрдүүлэлтээр программд оруулан техник ажил хийсэн байна.

Энэ онд байгууллагын хэмжээнд ээлжит бус номын тооллогыг салбар номын сан 2 удаа, Хүүхдийн танхим 3 удаа, гадаад хэлний танхим 1 удаа, гэр бүлийн уншлагын танхим 2 удаа хийж тооллогоор дутсан 60 гаруй ширхэг номыг номоор нь төлүүлэн номын санчдын хариуцлагыг өндөржүүлэх ажлыг хийсэн байна.

Хүний нөөц, судалгаа, дотоод ажил

2019 ”□д 21 ”□’□□’”□’□□□□□□□□□□20 ”□’□□’”□’□□□□□□□ 9 сард гадаад хэлний танхимд ОХУ-д сургууль төгссөн 1 хүнийг номын санчаар ажилд авч 10 сард жирэмсний амралттай хүний оронд мэргэжлийн номын санч 2 хүн түр ажилд авсан байна. Мөн 1 хүн эрүүл мэндийн улмаас ажлаас чөлөөлөгдсөн байна.. Оны эхэнд нийт ажиллагсдын ажилласан жилийн судалгаа бичиг хэргийн ажилтанд гарган өгч цалингийн шатлал ахих ажилчдыг гаргаж өгсөн байна.

2019 оны Төрийн албан хаагчийн хүний нөөцийн нэгдсэн системийн судалгаа, соёл урлагийн ажиллагсдын хүний нөөц, тоног төхөөрөмж, уншлага үйлчилгээний чиглэлээр □о-10, □о-17, □о-15 “ □□□□□ □□□□□□□ □□□□□□□□ □□□□□ аймгийн Боловсрол соёл урлагийн газар , Үндэсний номын санд □□□□□ □□□□□

1.Номын төвийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гаргаж жагсаалтанд байнга хадгалах 13, түр хадгалах 18, 70 жил хадгалах 3 хадгаламжийн нэгжийг батлуулсан байна. Манай байгууллага дээр одоогийн байдлаар 230 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.



2.Тухайн онд гаднаас ирсэн бичиг 44-албан бичгийг хүлээн авсан байна.

Үүнээс: Захирамж-2, тогтоол1 хариутай бичиг-22, шууд бичиг 23, бичиг баримтыг хүлээн авч бүртгэлд оруулсан байна.Тухайн жилийн хугацаанд ирсэн хариутай бичгийн хариуг хугацаанд явуулсан байна.



3.Тухайн оны /11 сарын байдлаар/ 73 албан бичгийг гадагш явулсан байна. Үүнээс:
мэдээлэл 23, хүсэлт 46, ажлын болон цалингийн тодорхойлолт 7



4. Энэ оны /11 сарын байдлаар/ үндсэн үйл ажиллагааны А тушаал 18 , Боловсон хүчний Б тушаал 11-ыг үйлдэж цаг хугацаанд цаг хугацаанд бүртгэлд оруулсан байна.

5.Өргөдөл гомдлын мэдээг бүртгэж архивын болон аймгийн өргөдөл гомдлын программд оруулан улирал бүр мэдээг өргөдөл гомдол мэдээ хариуцсан ажилтанд хүргүүлсэн. Энэ оны 11 сарын байдлаар 20 нь өргөдөл хүлээн авсан.Үүнээс:

цалинтай- 16, цалингүй чөлөөний хүсэлт-4 байна. Манайд зонхилж байгаа өргөдөл гомдол нь байгууллагын дотоод журмын дагуу олгогддог цалинтай чөлөө ээлж байна

6.Нийт танхимуудын санал хүсэлтийн дэвтэрт ирсэн санал хүсэлтэнийг дүгнэн харахад нийтийн уншлагын танхимын мэргэжлийн номыг шинэчилэн нэмэгдүүлэх , интернэт орчинг илүү хурдтай болгох, ажлын цагийг нэмэгдүүлэх мөн коридорын дуу чимээ ихтэй зэрэг санал гомдол дийлэнх хувийг ээлж байна.

Гэр бүлийн танхимын ном, тогтмол хэвлэлийн төрлийг нэмэх санал ирүүлсэн байна.

Санхүү, материаллаг баазыг бэхжүүлэх талаар

2019 онд 269944,2 мянган төгрөгийн төсвийн санхүүжилт авч ажилласан байна.

2019 онд Номын төвийн өөрийн орлогын төлөвлөгөө 3300,0 мнган төгрөгийн төгрөгөөс биелэлт 6600,0 мянган төгрөг болж Сангийн сайдын 74 дүгээр тушаалыг үндэслэн 3600,0 мянган төгрөгийн давсан орлогыг Номын баярын соёл танин мэдэхүйн ажлын шагнал урамшуулалд 1430,0 мянган төгрөг, баруун аймгийн нийтийн номын сангуудын ажилчидтай туршлага судлах ажлыг хийж 2,0 сая гаруй мянган төгрөгийг зарцуулан ажилласан байна.

Нийт ажиллагсдын цалингийн сан 196311.1 төгрөгөөр батлагдсанаас үндсэн цалинд169669.4 төгрөг зарцуулж ур чадвар үр дүн-14528,2 төгрөг, унаа хоолны зардалд 11500,2 төгрөг, илүү цаг, шөнийн нэмэгдэл- 2525,58, Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 хавсралтаар орон нутгийн нэмэгдэл 10988,0 төгрөгийг тус тус олгосон байна. Мөн энэ онд ахмадын санг бий болгож цалингийн сангийн 2 хувь буюу 3926,2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Урсгал засвар 9003,1 мянган төгрөг батлагдсаныг байгууллагын дээврийн засвар, дотор хана шат будах, цахилгааны монтаж шинэчлэх зэрэг ажил хийж гүйцэтгэлээ.

Номын төвийн барилгын үндсэн фондын хэсэгт агааржуулалт, гэрэлтүүлэг, хананы тусгаарлагч хийх засварын ажлыг “Хаст Шонхор” ХХК орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 32911,744 мянган төгрөгөөр хийж гүйцэтгүүлсэн байна.

Бусад ажил

- Аймаг нийслэлийн нийтийн номын сан, их дээд сургуулийн номын санчдын шилжин явах цомын төлөөх спортын 7 төрлийн тэмцээнд 16 баг тамирчид оролцсон спортын наадмыг зохион байгууллаа. Тэмцээнд нийт 200 гаруй тамирчид хамрагдаж аймгийн ЗДТГ-аас 3600,0 мянган төгрөгийг шагнал урамшуулалд гаргасан байна.
- БСУГ-ын 40 жилийн ойд зориулсан урлагийн наадамд сургуулийн бичиг хэргийн ажиллагсадтай хамтран 40 хүний бүрэлдэхүүнтэй амжилттай оролцож Номын төвийн язгуур урлагийн хамтлаг 2 байранд шалгарсан байна.

- Үндэсний бичиг үсгийн баяраар хүрээнд үндэсний бичгийн анхан шатны мэдлэг, чадварыг шалгах шалгалтын ЕБС, СӨБ, СУБ-ын байгууллагууд оролцсон уралдаанд 20-40 хүнтэй байгууллагын хүрээнд 2 байранд хамт олноороо шалгарлаа.
- Аймгийн соёл урлагийн салбарын байгууллагуудын дунд явагддаг гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулан байгууллагаас 2 баг оролцож тэргүүн дэд байрыг эзэлсэн байна.
- Аймгийн ИТХ-ын даргын нэрэмжит гар бөмбөгийн тэмцээнд эрэгтэй эмэгтэй багаараа амжилттай оролцлоо.
- Байгууллагын ҮЭ-ийн хорооны сонгуулийн тайлангийн хурлаа хийж ҮЭ-ийн хорооны даргаар номын санч Д. Мөнгөнцэцэг, тэргүүлэгчээр номын санч Ч.Эрдэнэсувд, Б.Даариймаа нар сонгогдон 2019-2021 оны хамтын гэрээгээ амжилттай байгууллаа.
- Байгууллагын дотоод хяналт шалгалтыг 2 удаа байгууллагын санхүү нярав, ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт шалгалт хийгдсэн байна.

2019 ОНЫ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ГРАФИКААР ХАРУУЛБАЛ

2019 оны уншлага үйлчилгээ





Номын сангийн фондын баяжуулалт







2019 онд шинээр авсан ном / нэрээр /

Фондын баяжуулалт 5 жилийн давтамжаар



	Нэр	Тоо	Мөнгөн дүн
2010	531	694	4328.2
2015 он	347	487	7023.1
2019 он	149	243	4724.9

2019 ОНД ХИЙГДСЭН НОМЗҮЙН БҮТЭЭЛ

ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР-2019

ҮНДЭСНИЙ НОМЫН БАЯР-2019

ДЭЛХИЙН НОМЫН ӨДӨР



СУРГАЛТ

СПОРТЫН НААДАМ

АГААРЖУУЛАЛТ, ХАНАНЫ ТУСГААРЛАГЧ ХИЙХ ЗАСВАРЫН АЖИЛ



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

АГУУЛГА:

1.Ерөнхий мэдээлэл

2.Сан хөмрөг, Каталог

3.Үйлчилгээ

4.Хүний нөөц

5.Бусад

ТАЙЛБАР :

Өвөрхангай аймгийн номын сангийн 2019 оны үйл ажиллагааны тайланг дээрх 5 бүлэгт хуваан харуулсан байдал.

1.1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Аймгийн төв номын сан нь уншигч иргэдэд мэдлэг мэдээлэл олж авах орон нутгийн оюуны хөгжлийн нээлттэй мэдээллийн төв болоход оршино.

АЛСЫН ХАРАА:

Номын сангийн үйл ажиллагаанд мэдээлэл технологийн технологийн шинэчлэл нэвтрүүлж, цахим электрон номын сангаар иргэдэд үйлчилнэ.

1.2. НОМЫН САНГИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Манай номын сан нь 1946 онд байгуулагдсан. Нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. 2019 онд захирал 1, нягтлан бодогч 1, аргазүйч 1, сан хөмрөгч 1, номзүйч 1, номын санч мэдээллийн ажилтан 3, IT инженер 1, жолооч 1, жижүүр 1, үйлчлэгч 2 гэсэн орон тоотойгоор Боловсрол танхим , Хүүхдийн уншлагын танхим, Гэрээр ном олгох танхим , Хүүхдийн номын ордон , Интернэт танхим, Лавлагаа мэдээллийн танхимуудаар дамжуулан уншлага үйлчилгээ явуулан ажиллаж байна

Facebook хаяг : ӨВӨРХАНГАЙ ТӨВ НОМЫН САН

Номын сангийн албан ёсны имэйл хаяг: UVNOMIINSAN@GMAIL.COM

Ажиллах цагийн хуваарь: 09:00-18:00

Байгууллагын утасны дугаар: 70322613

Номын сангийн захирал: Л.Анхбаяр

2. САН ХӨМРӨГ, КАТАЛОГ

2.1 Сан хөмрөгийн өнөөгийн байдал

Орон нутгийн онцлог уншигчдын эрэлт хэрэгцээ шаардлагыг үндэслэн төсөв, төсөл, бэлэг хандивын журмаар фондоо бүрдүүлж ажиллаа.

2019 оны жилийн эцсийн байдлаар 122 төрлийн 244 ширхэг номоор фондоо баяжууллаа. Номын сангийн фондод байгаа ном хэвлэлийн бүтээгдэхүүний хадгалалт хамгаалалтанд анхааран ажиллаж, тавиур тус бүрийн номуудийг шинжлэх ухааны ангилалын дагуу байрлуулж, шинээр ирсэн номыг хүлээн авч фондын нэгдсэн бүртгэл, танхимуудын бүртгэлд бүртгэн танхимуудад хүлээлгэн өгч байна. Фондоос нийт 570 ном шилжсэнээс Гэрээр ном олгох танхимд 328 ном , Өргөө-2 гэрээр олгоход 152 ном, 90 номыг бусад танхимуудад түр шилжүүлэгээр шилжүүлэн уншигчдын захиалгын дагуу үйлчилсэн байна.



Сар	Танхимуудад түр шилжүүлэгээр шилжүүлсэн номын төрөл	Шилжүүлсэн номын тоо	Буцааж авсан
1	13	18	7
2	63	69	25
3	45	57	25
4	47	76	20
5	19	19	53
6	3	3	14
9	19	27	27
10	16	34	87
11	205	232	86
12	11	15	29
	441	570	373

2019 онд 198,000 төгрөгийн өдөр тутмын 2 нэр төрлийн сонин, 3 нэр төрлийн сэтгүүл захиалан уншигчдад хүргэж байна. Захиалгийн дагуу сонин сэтгүүлийг шалган хүлээн авч бүртгэлийг тогтмол бүртгэж байна. Сонингуудыг хагас жилээр нь үдэн хавтаслаж фондонд хүлээлгэн өглөө

Д/д	**Индекс**	**Хэвлэлийн нэр**	**Тоо ширхэг**	**Үнэ**
1	101606	Үндэсний шуудан	1	20000
2	201095	Улирал ба зохиолч	1	15000
3	200003	Төрийн мэдээлэл	1	15000
4	210083	Эрүүл амьдрах жор	1	7500
5	230421	Космополитан	1	7000
Нийт				64500

Д/д	**Индекс**	**Хэвлэлийн нэр**	**Тоо ширхэг**	**Үнэ**
1	101606	Үндэсний шуудан	1	20000
2	201095	Улирал ба зохиолч	1	15000
3	200003	Төрийн мэдээлэл	1	15000
4	210083	Эрүүл амьдрах жор	1	7500
5	230421	Космополитан	1	7000
Нийт				64500

Д/д	**Индекс**	**Хэвлэлийн нэр**	**Тоо ширхэг**	**Үнэ**
1	100774	Зууны мэдээ	1	17500
2	100012	Утга зохиол урлаг	1	5500
3	201095	Улирал ба зохиолч	1	15000
4	200003	Төрийн мэдээлэл	1	15000
5	210083	Эрүүл амьдрах жор	1	9000
6	230421	Космополитан	1	7000
Нийт				69000



2.2 Номын сангийн электрон каталогт одоогоор 21349 төрлийн 48764 ширхэг ном бүртгэгдсэн ба нийтдээ 14150 удаа уншигчид хайлт хийсэн байна. 2025 уншигчийг программд бүртгэж уншигчийн үнэмлэхийг хэвлэлээ. Уншлага үйлчилгээнд гарч бар код хуучирч, кодгүй болсон 32 ширхэг номыг дахин коджуулж үйлчилгээнд гаргасан ба шинээр ирсэн ном нь хавтасны зураг агуулгын тайлбартайгаар мэдээллийн санд тусгагдаж байна

2.3 КАТАЛОГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хийгдсэн ажил	Тоо хэмжээ
Электрон каталогт бүртгэгдсэн нийт ном	48764
Электрон каталогт шинээр нэмэгдсэн	244
Электрон каталогт редакц хийгдсэн ном зүйн бичлэгийн тоо	43
Электрон каталогт хийгдсэн хайлтын тоо	14150
Картан каталогт бүртгэгдсэн нийт	244

Номзүйн ажлын талаар:

“**Өврийн сайхан хангай ном хэвлэлийн хуудаснаа**” цахим ном зүйг Зотера программ дээр үргэлжлүүлэн хийж нийт Өвөрхангайн элч сониноос 109 ширхэг мэдээлэл нэмж оруулсан ба **“Улирал ба зохиолч “** сэтгүүлийн 2019 оны 1,2,3 –р улирлын сэтгүүлээс 128 мэдээлэл түүвэрлэн авч МҮНС-**ын “Үндэсний тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн сан”-д** оруулсан. **“Улирал ба зохиолч** “ сэтгүүлийн 2019 оны 2 дугаараар санамж өгөх номзүй гаргалаа. Уншигчдын хүсэлтийн дагуу лавлагааг байнга өгч байна. Мөн “Өндөр гэгээн Занабазарт холбогдох номзүй”, “Өвөрхангайн зохиолчдын бүтээлийн намтар номзүй” 2009-2019 оны хоорондох 10 жилийн ном, хэвлэлийн бүтээлүүдийг эмхэтгэн хэвлэлтэнд бэлэн болгоод байна.

2. ҮЙЛЧИЛГЭЭ

2.1 УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

Жилийн эцсийн байдлаар нийт 2025 уншигч , 16231 иргэсдэд 16724 ном олгож уншигчдыг шинэ шилдэг ном сонин сэтгүүлээр ханган үйлчилж , оюуны хөгжлийн нээлттэй төв болох зорилгоо биелүүлэн ажиллаж байна. Аймгийн төв номын сан нь зөөврийн номын сангийн үйлчилгээг Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар , МСҮТөв, Мэргэд сургууль, ЕБ-ын 1-р сургуулийн дотуур байранд үзүүлсэн ба нийт 223 ширхэг номоор үйлчиллээ. Мөн хүргэлтийн номын сангийн үйлчилгээг нэвтрүүлэн төв бараан захын худалдаачдад шинэ болон хүүхдийн уран зохиолын 400 ширхэг номоор үйлчлэн уншигчийн тоог нэмэгдүүлж номын сангийн үйлчилгээг өргөжүүлэн ажиллаа. Манай номын сан нь ном зүйн мэдээллийн үйл ажиллагааг боловсронгуй болгох үүднээс 18 удаа 966 ширхэг шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргаж 5 удаагийн тойм хийж, танин мэдэхүйн ажлуудыг тогтмол зохион байгуулж байна.

№	Танхимын нэр	Үзэсгэлэн	Тоо ширхэг
1	Фонд	“Үндэсний бичиг үсгийн баяр”	143
2		Бүрд суманд соёлын өдрөөр “Д.Пүрэвдоржийн зохиол бүтээлийн үзэсгэлэн	30
3		Зохиолч Ц. Гайтавын номын үзэсгэлэн	30
4		Монгол бахархалын өдрийг угтаж “Монголын хаадууд” номын үзэсгэлэн	47
5		“Чингис хаан” номын үзэсгэлэн	35
6		Улс тунхагласны баяраар “Монголын түүх”-ийн номын үзэсгэлэн	35
7		Олон улсын хүний эрхийн өдөрт зориулсан номын үзэсгэлэн	21
8		Торгоны зам аялал жуулчлалын арга хэмжээнд	40
9	Лавлагаа	Бүрд суманд	30
10		Уянга суманд	30
11		Тарагт суманд	30
12		Торгоны зам аялал жуулчлалын арга хэмжээнд	30
13	Гэрээр ном олгох танхим	Торгоны зам аялал жуулчлалын арга хэмжээнд	65
14		Уянга суманд	65
15		Тарагт суманд	65
16	Хүүхдийн уншлагын танхим	Бүрд суманд	60
17		Торгоны зам аялал жуулчлалын арга хэмжээнд	60
18	Хүүхдийн номын ордон	Дэлхийн номын өдөр	150
Нийт:		**18 удаа**	**966**

Торгоны зам

Үндэсний бичиг үсгийн баяр

Бүрд суманд соёлын өдрөөр “Д.Пүрэвдоржийн зохиол бүтээлийн үзэсгэлэн

“Зохиолч Ц. **Гайтавын**

номын үзэсгэлэн

“ Монголын хаадууд” номын үзэсгэлэн

“Чингис хаан” номын үзэсгэлэн

Тарагт сум

Уянга сум

Бүрд сум

Төв бараан зах

Гэмтэж урагдсан номонд сэлбэн засалт хийж уншлаганд гарахад бэлэн болголоо.

№	Танхим	Сэлбэн засалт хийсэн номын тоо
1	Гэрээр ном олгох танхим	32
2	Хүүхдийн уншлагын танхим	35
3	Хүүхдийн номын өргөө 1	125
4	Хүүхдийн номын өргөө 2	67
	Нийт	259

3.СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ :

2019 оны жилийн эцсийн байдлаар төв номын сангаас зохион явуулсан соёл, олон нийтийн ажлууд:

3.1 Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Мэргэд сургуулийн номын сантай хамтран 2019 оны 04-р сарын 19-нд Дэлгэржаргал багштай 4в ангийнханд “50 номын уналт”, ”Үсэглэлийн хаад” танин мэдэхүйн тэмцээнийг явуулж, амжилттай оролцсон сурагчдыг өргөмжлөл, номоор шагнаж урамшууллаа.

3.2 Ирээдүй хүүхдийн уншлагын тахим нь номын баярын хүрээнд ЕБ-ийн Мэргэд лаборатори сургуулийн номын сан, гэрээр ном олгох танхимтай хамтран

4,5 дугаар ангийн сурагчдын дунд “Монгол наадгай” танин мэдэхүйн тэмцээнийг зохион явууллаа.

Тус тэмцээн :

- Багийн мэндчилгээ
- Хошин бодлого
- Монгол аман наадгай
- Оньсон тоглоом эвлүүлэх гэсэн үе шаттай явагдсан ба

1 дүгээр байранд 28 оноогоор 5а анги
2 дугаар байранд 26 оноогоор 4а анги

3 дугаар байранд 24 оноогоор 4б анги шалгаран дурсамж дурсгалын зүйлээр шагналаа.

3.3. 2019 оны 5- р сарын 1 нд Төрийн соёрхолт, соёлын гавъяат зүтгэлтэн Богд сумын харъяат Ц.Гайтавын 90 насны ойд зориулсан аймгийн шүлэг, найраглалын уран уншлагын уралдааныг Аймгийн БСУГ-ын СУХэлтэстэй хамтран зохион байгуулан Ц.Гайтавын номын үзэсгэлэн гаргалаа.

3.4 2019 оны 5-р сарын 30 нд ЕБС-ийн 2-р сургуулийн 2г ангийн 32 бяцхан сурагчдад, эцэг эхийн төлөөлөл ирж номын сангийн болон танхимын үйл ажиллагаатай танилцан, номтой хэрхэн харьцах, үлгэрийн болон комик номоор уншлага хийж ярилцлаа

Мөн Хүүхдийн номын өргөөтэй 5,8,1,7-р цэцэрлэгийн 187 хүүхэд багш нар, 1-р сургуулийн Өлзийсайхан багштай 5г ангийн 45 сурагчид танилцаж ,хүүхдийн үлгэрээр чанга уншлага явууллаа.

3.5 <u>Дэлхийн номын өдөр</u>

Жил бүрийн 04 дүгээр сарын 23-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлдэг "Дэлхийн номын өдөр"-ийг 2018 оны 04 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүллээ. Тус өдрүүдээр:

1. Сонгодог зохиолын номын үзэсгэлэн
2. " 50 номын уналт ",танин мэдэхүйн тэмцээн
3. "Алтан хонх" танин мэдэхүйн тэмцээн
4. " Бүтээлчээр унших арга зүй " мэдээлэл сургалтыг 56 уншигчдад хийж номын уншихын ач тусын талаар боршур хийн номын тэмдэглэл

хөтлөх мэдээлэл сургалтыг 80 хүүхдэд танилцуулан гарын авлага бэлтгэн тараалаа.

3.6 Үндэсний бичиг үсгийн баяр

Үндэсний **“Бичиг үсгийн баяр**”-ыг тэмдэглэх тухай Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх, монгол бичгийг сурах, түгээн дэлгэрүүлэх, сурч эзэмших явдлыг хөхүүлэн дэмжих, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон тэмдэглэн өнгөрүүлдэг Үндэсний “Бичиг үсгийн баяр”-ыг Өвөрхангай Аймгийн Төв номын сан 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдөр тэмдэглэн өнгөрүүллээ. Үндэсний “Бичиг үсгийн баяр”-ын үйл ажиллагааны нээлтэнд аймгийн БСУГ-ын дарга Ж. Пүрэвсүрэн, БСУГ-ын Соёлын хэлтсийн дарга Л. Пүрэвлхам, Монгол хэл уран зохиолын стандартын мэргэжилтэн Э.Батаа нар хүрэлцэн ирж оролцлоо

Нээлтийн үйл ажиллагаанд Алтан гадас одонд ЕБ-ийн I сургуулийн Наран багштай 2ё ангийн “Инээмсэглэл” хамтлаг хүрэлцэн ирж Төрийн сүлд дууллаа эгшиглүүлэн Ёохор бүжгээр хуран цугласан уншигчид, эрхэм зочиддоо мэндчилгээ дэвшүүллээ.

Үндэсний “Бичиг үсгийн баяр- 2019” –ыг угтан Арвайхээр сумын СӨБ-ийн бяцхан хүүхдүүдийн дунд **“Миний мэдэх үлгэрийн баатар**” дүрийн тоглолтын уралдааныг 2019.05.14-ны өдөр зохион явууллаа.

Уралдааны I байранд: Арвайхээрийн 9-р цэцэрлэг

II байранд: Арвайхээрийн 2-р цэцэрлэг
III байранд: Арвайхээрийн 1-р цэцэрлэгийн хүүхдүүд шалгаран Үндэсний бичиг үсгийн баяраар дүрийн

тоглолтоо тоглон үзүүллээ.

"**Миний монгол бичиг**" бүтээлийн уралдаанд оролцогчдын бүтээлийн үзэсгэлэн, "**Монгол түмний оюуны өв - Монгол бичиг**" номын үзэсгэлэн гаргасан ба **Тэргүүний уншигч, Алдаагүй зөв бичигтэн, Цэвэр сайхан бичигтэн, "Бийрийн уран бичвэр"-ийн уралдаан, "Миний монгол бичиг**" бүтээлийн уралдаануудыг ажилттай зохион явууллаа. Уралдааныг ЕБ-ийн 4, 2, 1, мэргэд сургуулийн монгол хэл бичгийн багш нарыг урин шүүлгэн явуулсан.

"МИНИЙ МОНГОЛ БИЧИГ" бүтээлийн уралдаанд нийт 22 бүтээл ирсэн ба тус үзэсгэлэнд оёмол, наамал, бийрэн бичлэг болон уран дүрст бичлэгүүд, даавуун болон төмөр, морины толгой ашиглан бүтээсэн зохиомжит бүтээлүүд ирсэн байна.

"МИНИЙ МОНГОЛ БИЧИГ" бүтээлийн уралдаанд насанд хүрэгчдын ангилалд :

I байранд: "Шувуун саарал" бүтээлээр ЕБ-ийн I сургуулийн технологийн багш С.Балданцэрэн
II байранд: "Уул" бүтээлээр ЕБ-ийн II сургуулийн багш А.Түгжсүрэн
III байранд: Алдартнууд бүтээлээр Ц.Мөнхбат нар шалгарсан.

"МИНИЙ МОНГОЛ БИЧИГ" бүтээлийн уралдаанд сурагчдын ангилалд :

I байранд: "Хатан" бүтээлээр ЕБ-ийн I сургуулийн 7в ангийн сурагч Н.Гэрэлт-Од
II байранд: "Бөх, Есүхэй" бүтээлээр ЕБ-ийн I сургуулийн 7в ангийн сурагч А.Насанбат

III байранд: "Өвөрхангайн гайхамшигууд" бүтээлээр ЕБ-ийн I сургуулийн 11г ангийн сурагч Г.Мөнхсанаа нар шалгарлаа

“**Хичээнгүй сайхан бичигтэн**” уралдаанд ЕБС-ийн 6-12 дугаар ангийн 217 сурагч оролцсоноос:
I байранд: ЕБ-ийн IV сургуулийн 10а ангийн сурагч Э.Бүжинлхам
II байранд: ЕБ-ийн IV сургуулийн 11б ангийн сурагч А.Ариунаа
III байранд: ЕБ-ийн IV сургуулийн 7в ангийн сурагч Б.Осорсүрэн нар эзэллээ.

Мөн “**ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ**” уралдааныг зохион явууллаа. Тус уралдаанд нийт 100 сурагч оролцсноос:

I байранд: ЕБ-ийн II сургуулийн 11г ангийн Б.Бүжинлхам

II байранд: ЕБ-ийн II сургуулийн сурагч 8в сурагч Ганди

III байранд: Мэргэд лаборатори сургуулийн 9б ангийн сурагч М.Оролмаа нар эзэллээ.

“**Алдаагүй зөв бичигтэн**” уралдаанд 150 сурагч оролцсоноос

I байранд: Мэргэд лаборатори сургуулийн 10а ангийн Б.Мөнхгэрэл

II байранд: ЕБ-ийн IV сургуулийн 10а ангийн сурагч Д.Чулуун-Эрдэнэ

III байранд: Мэргэд лаборатори сургуулийн 10в ангийн сурагч О.Мичидмаа нар эзэллээ.

“**Бийрийн уран бичвэр**”-ийн уралдаанд

I байранд: ЕБ-ийн IV сургуулийн 10а ангийн сурагч Д.Халиунаа

II байранд: ЕБ-ийн II сургуулийн 10б ангийн сурагч Э.Буянханд нар эзэллээ.

3.7 <u>Номын баяр</u> Ардын уран зохиолч Д.Пүрэвдоржийн нэрэмжит Өвөрхангай аймгийн төв номын сан нь 2019 оны 10 дугаар сарын 07-ний өдөр номын баярыг тэмдэглэн өнгөрүүллээ.Номын баярт аймгийн БСУГазрын Соёлын хэлтсийн дарга Л.Пүрэвлхам оролцлоо.

Номын баяраар шинэ, хуучин номын худалдаа болон ном сурах бичгийн солилцоог зохион явууллаа. Уг худалдаагаар “**Оюу тайж**” бичиг хэргийн дэлгүүр, “**Соёл**” номын дэлгүүр номын худалдаа явуулан иргэд, уншигч хүүхдүүдэд үйлчиллээ. Мөн хувь хүмүүс, сурагчид хуучин ном, сурах бичгээ солилцон борлууллаа.

Номын сангийн уншигч хүүхдүүдийн дунд лекц кохион байгууллаа. Лекцэнд Өвөрхангай аймгийн Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Газрын дарга С.Ундрах, Насан туршийн боловсролын төвийн мэргэжилтэн О.Эрдэнэцэцэг, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн Д.Анхбаяр нар урилгаар оролцон “Хувь хүн- бие хүн” , “Зорилго” , “Өсвөр насны хүүхдийн хүмүүжил” зэрэг сэдвүүдээр лекцуншин харилцан ярилцлаа. Уг лекцэнд Арвайхээр сумын ЕБС-ийн 1,2,4,5, мэргэд лабортори сургуулийн 150 сурагчид хамрагдлаа.

Номын баярт хүрэлцэн ирсэн уншигч, сурагчид “ **50 номын уналт** ” танин мэдэхүйн тэмцээнд оролцон оюун ухаан мэдлэгээ сорьлоо. Тэмцээнд таван сургуулийн таван баг оролцсоноос нэг дүгээр байранд ЕБ-ийн 2 дугаар сургуулийн баг , хоёр дугаар байранд ЕБ-ийн 4 дүгээр сургуулийн баг хамт олон шалгаран дурсамж дурсгалын зүйлээр шагнууллаа.

8-р цэцэрлэгийн багш ажилчдын дунд “ Үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолтыг явуулж, нийт 4 баг хүүхдийн насны онцлогт тохирсон үлгэрүүдийг сонгон,жүжигчилсэн тоглолт явуулснаас дунд ангийн баг түрүүлж, 20000 төгрөг,10 үлгэрийн номоор шагнал гардуулж,хамтран ажиллалаа.

Мөн ангиудын бяцхан номын сантай танилцаж,багш нарт номыг хэрхэн байрлуулах,арчлах талаар зөвлөн нийт 15 номыг хамтран сэлбэн заслаа

Шинэ номын үзэсгэлэн гарган иргэд уншигч хүүхдүүдэд суртчилсан ба Номын сангийн идэвхтэн уншигчидаа шалгаруулан “ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ Д.НАЦАГДОРЖ” тэмдэгээр шагналаа.

Нацагдорж тэмдэгтэн:

1. ЕБ-ийн 1-р сургуулийн 5в ангийн сурагч Сүхбаатарын Батсамдан
2. ЕБ-ийн 4 –р сургуулийн 7г ангийн сурагч Гантулгын Мядагмаа
3. ЕБ ийн 1-р сургуулийн 10е ангийн сурагч А.Баясгалан
4. ЕБ-ийн 1 -р сургуулийн 12в ангийн сурагч Ишнаваагийн Оюунгэрэл
5. Өвөрхангай аймгийн 10-р багийн иргэн Оргийн Мөнхдэмбэрэл нар шагнууллаа.

3.8 “<u>Өвөрхангайн соёлын өдөр” арга хэмжээ</u>

Аймгийн Засаг даргын "Бүтээлч-Өвөрхангай 2020" хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байгаа орон нутгийн иргэдийнхээ соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдах оролцоог нэмэгдүүлэх, биет болон биет бус өвөө сурталчлах, түгээн дэлгэрүүлэх утга зохиолд шимтүүлэх, нүүдлийн ном, соёлын үйлчилгээг өргөжүүлэх, монголын уламжлалт зан заншлыг сурталчлах, урлагийн боловсрол олгож, дэлхийн болон орчин үеийн урлагтай танилцуулах олон зорилгыг тавьж 2014 оноос эхлэн зохион байгуулсан "Өвөрхангайн соёлын өдөр" арга хэмжээ 2019 онд Бүрд, Уянга, Тарагт сумдад ажиллаа. Арга хэмжээнд Аймгийн БСУГ-ын Соёл урлагийн хэлтэс, Аймгийн ХДТ, Музейн хамт олонтой баг болон ажиллаж ХДТеатр Төвийн бүсийн шалгаруулалт "Сонгодог бүтээл-2018" уралдааны Гранпри шагналт сонгодог бүтээлээсээ үзүүлж

суртчилан морин хуур, бий биелгээний өвөөс танилцуулсан бол музейн хамт олон нүүдлийн музейгээр үйлчилж , түүхэн хронологийн талаар ойлголт өглөө.

Аймгийн төв номын сан нь сум тус бүр 100 ширхэг ховор ном, хүүхдийн болон шинэ номын үзэсгэлэн гарган иргэд, хүүхэд багачуудад суртчилсан ба төрийн албан хаагчдын дунд "50-н номын уналт” танин мэдэхүйн тэмцээн, сурагчдын дунд “Алтан хонх” тэмцээн, бага ангийн сурагчдын дунд "Монгол гэр" сургалт , "Монгол гэрийг хэн сайн мэдэх вэ?" уралдаан явуулан тэмцээнд оролцогчдыг шагнан урамшууллаа.

3.9 Монголын орчин veийн уран зохиолыг үндэслэгч.Д.Нацагдоржийн мэндэлсний ойд зориулан Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 65 сурагчдыг урин мэдээлэл танилцуулга хийлээ. Үүнд:

1. Зохиолчийн намтар уран бүтээлийн танилцуулга

2.” Цагаан сар ба хар нулимс” өгүүллэгээр цахим уншлага

3.Ном уншихын ач холбогдол зөвлөмж ярилцлага

4.Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж, Д.Нацагдоржийн зохиолуудыг уншин, нийт 115 уншигчид хамрагдлаа.

3.10 Хүүхдийн номын ордон нь Тархи цэнэглэгч номын клубийнхэнд шинэ ном танилцуулж, уншигчдад 7 удаа 68 уншигчид номын тухай ярилцлага хийлээ.

1. Цэнхэр романс
2. Хагацашгүй
3. Өсвөр насны дээдэлж мөрдөх 7 зуршил
4. Хэрхэн сайн найзуудтай болж мөн найзын харилцаагаа хадгалах вэ.
5. Сорхугтани хатан
6. Ногоон нүдэн лам
7. Жаран цагаан хонь

зэрэг зохиолуудаар ярилцлага зохион, зохиолын талаар хүүхдүүд хоорондоо ярилцан, энэ зохиолын сайн муу талыг хүүхэд өөрийн ойлгоцоороо бусдад номын талаар таниулдаг клубтэй хамтран ажиллалаа.

3.10 <u>“Олуулаа уншиж хөгжье” ном унших 3 сарын аян</u>

2019.02.15-05.15-ны хооронд ЕБС-ийн сурагчдын дунд “ОЛУУЛАА УНШИЖ, ХӨГЖЬЕ” ном унших 3 сарын аян зарласан ба аянд ЕБ-ийн дөрвөн сургуулийн 500 гаран сурагч, 5 анги хамт олон оролцсоноос “**ШИЛДЭГ АНГИ**”-иар ЕБС-ийн 1-сургуулийн 10в анги аяны болзолыг ханган шалгарч ангиараа олон улсын “**НАЙРАМДАЛ**” зусланд амрах эрхийн бичгээр шагнууллаа. Мөн **“ШИЛДЭГ ХҮҮХЭД -10”** шалгаруулан “**НАЙРАМДАЛ**” зусланд амрах эрхийн бичгээр шагналаа. ХНХЯСайд С.Чинзориг ивээн тэтгэн хамтран ажиллаа.

“Шилдэг хүүхэд-10”

д/д	Овог нэр	Сургууль, анги
1	Пүрэвсүрэн Отгонжаргал	4-р сургууль 2в анги
2	Сүхбаатар Батзандан	1-р сургуулийн 4в анги
3	Ганхуяг Мөнхдалай	2-р сургууль 4е анги
4	Ганбаатар Төгөлдөрчимэг	4-р сургууль 8а анги

5	Бундхорол Даариймаа	4-р сургууль 8 а анги
6	Нарангэрэл Гойгордулам	1-р сургууль 9е анги
7	Гантогоо Санчиг	2-р сургууль 10б анги
8	Түвшин Номинтөгс	2-р сургууль 10б анги
9	Бямбасүрэн Хонгорзул	1-р сургууль 10в анги
10	Нямсүрэн Энхдэлгэр	1-р сургууль 11в анги

3. ХҮНИЙ НӨӨЦ

Арга зүйн ажлын хүрээнд:

4.1 2019 оны 04 дүгээр сарын 09-нд Аймгийн БСУГазарын СУХэлтэс, Аймгийн төв номын сан, Өвөрхангай аймгийн 18 сумын болон ЕБСургуулийн номын санч мэдээллийн ажилтнуудын дунд ур чадварын уралдаан зохион байгууллаа. Тус уралдаанд Баянгол сумын Соёлын төвийн номын санч мэдээллийн ажилтан Сарангоо, Баянгол сумын ЕБС-ийн номын санч Отгончулуун нар 1-р байранд шалгарлаа.

4.2 Номын санч мэдээллийн ажилтнууд хариуцсан 3 сумдын номын санчидтай уялдаа холбоотой ажиллан мэдээ мэдээллийг цаг тухай бүрт нь өгч ажиллаа. Мөн Бүрд , Уянга, Тарагт сумдын соёлын төвийн номын сан, ЕБС-ийн номын сантай танилцаж, зөвлөн тусалж:

- Номын сангийн бүртгэлүүд хөтлөх
- Программ ашиглалт
- СОТАжил зохион байгуулах
- Фонд зохион байгуулалт
- Хадаглалт хамгаалалтын талаар аргазүйн зөвөлгөө өгч ажилласан ба шинэ номын мэдээ, картын сан, санамж өгөх номзүйг хэрхэн хийж уншигчдад сурталчлах зөвлөгөөг өгч аргачлалыг зааж ажилласан.

4.4 Номын санчидад каталоги зохион байгуулалтын талаар мэргэжлийн зөвлөгөө өгч цаасан каталогийг хэрхэн зохион байгуулах талаар зааварчилгаа өгч ажиллаа. Үүний үр дүнд 18 сумдын номын сангууд 100%-ийн гүйцэтгэлтэйгээр төрөл ангийн каталогийг зохион байгууллаа.

4.5 2019 оны 9- р сарын 27 нд Соёлын гавъяат зүтгэлтэн Л. Намхайдавгын 100 жилийн ойн эрдэм шинжилгээний хуралд Номын санч мэдээллийн ажилтнууд илтгэл бичин оролцож ур чадвараа сорьлоо. Уг уралдаанд :

1-р байранд : Номын санч мэдээллийн ажилтан О.Долгормаа

2-р байранд: Номзүйч Б.Жаргал **”Сумдын соёлын төвийн номын сангийн электрон каталогийг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага”** сэдвээр

3-р байранд: Номын санч мэдээллийн ажилтан Б.Цэрэнпүрэв **“Лавлагаа мэдээллийн ажлын өнөөгийн байдал, цаадшын чиг хандлага”** сэдэвт илтгэлээр тус тус шалгарлаа.

4.6 Аргазүйч Д.Отгонболор **Мэдээ тайлан гаргах аргачлал** цахим сургалт болон Арга зүйчдийн сургалтанд тус тус хамтрагдсан болно.

4.3 2019 оны 5-р сарын 07 –нд Д.Тунгалаг “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого зарчим”, Л. Тунгалаг “Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ”, сургагч багш ажлын үр дүнг үнэлэх үнэлгээний асуудал сургалт зөвлөгөөнд номын санч мэдээллийн ажилтнууд хамрагдлаа.



6.БУСАД

6.1 БНХАУ-аас Монгол улсад суугаа элчин сайдын яам, Өвөрхангай аймгийн ЗДТГазар, Улаанбаатар хот дахь Хятадын соёлын төв хамтран зохион байгуулж буй "**Хятадын аялал жуулчлал, соёлын өдөрлөг-2019**" арга хэмжээний хүрээнд Хятад-Монгол номын үзэсгэлэн зохион байгуулан хамтран ажиллаа. 6.1

“ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙ-2019 “ сарын аяны хүрээнд “Эрүүл аюулгүй ажлын байр” дэвтрийг 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр хүлээн авч дэвтэр аялах хугацаанд байгууллагын ХАБЭА-н зөвлөлийг байгуулан зөвлөлийн 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг баталлаа.. Мөн ажилтан албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулан албан хаагчдын дунд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалт, мэдээллийг хийж номын сангийн хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны эрүүл ахуйн талаар ярилцан тодорхой асуудлуудыг хэлэлцэн ХАБЭА-н хуулийн талаар мэдээлэлтэй боллоо. Мөн иргэд уншигчдад ХАБЭА-г суртчилан банар хийн цахим сүлжээ болон номын сандаа суртчиллаа.

6.2 “**Тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх**” жилийн ажлын хүрээнд номын сангийн урд байрлах 288 мкв ногоон байгууламжийн хогийн

ургамалыг цэвэрлэн 20 ширхэг шар хуайс тарьсан ба “Хүүхдийн номын ордон”-ы ногоон байгууламжийг хамгаалах зорилгоор 8 метр төмөр хайс, 10,5 метр гинжин хамгаалалт хийж ногоон зүлэг суулгахад бэлэн болгосон. Мөн дэлгэрэх голын цэцэрлэгт хүрээлэнд 20 ширхэг мод тарьсан болно

6.3 Хүүхдийн номын өргөө нь номын тавиурын заалт ангийг шинээр хийсэн ба уншигч үйлчлүүлэгчиддээ зориулан **“Хүүхдийн номын өргөө**” бичигтэй аяга хийлээ.

6.4 Гучин-Ус суманд “Соёл урлагийн ажилтны баяр”-ын арга хэмжээний үйл ажиллагаанд оролцон ахмадууддаа хүндэтгэл үзүүлэн спортын тэмцээн уралдаанд амжилттай оролцлоо.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Номоор дамжуулан иргэдийн соёлын түвшинг дээшлүүлэх, иргэдийн ном уншлагыг дэмжих зорилготой ажил, арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж ажиллаа.

1. УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

2019 онд нийт 2735 байнгын уншигч, 20950 ирэгсэдэд 30284 ширхэг ном олгон үйлчиллээ.

Үзүүлэлт	Хүүхдийн уншлагын танхим	Нийтийн уншлагын танхим	Гэрээр ном олгох танхим	Мэдээллийн төв	Сан хөмрөг	Зөөврөөр	Нийт
Уншигч	1230	920	400	185			**2735**
Ирэгсэд	5560	5100	4072	600	200	5418	**20950**
Ном олголт	12732	5051	5130	350	955	6066	**30284**





Урилгат үйлчилгээ:

Сурагчдыг номын сангаар үйлчлүүлэх, номын санд ном унших соёлыг эзэмшүүлэх, номын сангийн үйлчилгээ үйл ажиллагаатай танилцуулах зорилгоор урилгат үйлчилгээнд 21 ангийн 616 хүүхдийг хамрууллаа.

ЕБСургуулийн бага, дунд 11 ангийн 360 хүүхдийг урилгат үйлчилгээнд хамруулж 595 ном олгож үйлчилсэн байна.

1. 3-р сургуулийн 5а анги 28 хүүхэд 36 ном
2. 3-р сургуулийн 7а анги 28 хүүхэд 42 ном
3. 4-р сургуулийн 5а анги 33 хүүхэд 53 ном
4. 2-р сургуулийн 4а анги 33 хүүхэд 49 ном

5.1-р сургуулийн 5в анги 32 хүүхэд 64ш ном уншсан.

6. 1-р сургуулийн 7б анги 25 хүүхдэд 69 ном олгов.

7. 1-р сургуулийн 6а анги 39 хүүхэд 99 ном олгосон.

8. 1-р сургуулийн 4д анги 39 хүүхэд 39 ном олгов.

9. 1-р сургуулийн 4б анги 40 хүүхдэд 40 ном олгов.

10. 5-р сургуулийн 5а анги 38 хүүхдэд 59 ном олгов.

11. 1-р сургуулийн 2а анги 25 хүүхдэд 45 ном олгож үйлчилсэн байна.

ЕБСургуулийн бага, дунд 10 ангийн 256 хүүхдийг урилгат үйлчилгээнд хамруулсан байна. Олгосон номын тоо 317.

1. II/25. 1-р сургуулийн Оюун-эрдэнэ багштай 8В анги хамт олноороо нийт 27 удаагийн давтамжаар ирж карт нээлгэж уншлага үйлчилгээнд хамрагдсан нийт 24 хүүхэд
2. X/6. 1-р сургуулийн Мөнхцэцэг багштай 9В ангийн 25 хүүхэд
3. X/15. 1-р сургуулийн Ургамалцэцэг багштай 9Б ангийн 26 хүүхэд
4. X/16. 4-р сургуулийн Одгэрэл багштай 8В ангийн 26 хүүхэд
5. X/18. 4-р сургуулийн Янжмаа багштай 8А ангийн 27 хүүхэд
6. X/23. 5-р сургуулийн Сонинбор багштай 8А ангийн 22 хүүхэд
7. XI/11. 4-р сургуулийн Баярсайхан багштай 9Б ангийн 31 хүүхэд
8. XI/28. 1-р сургуулийн Чаминчулуун багштай 9А ангийн 34 хүүхэд
9. XII/03. 2-р сургуулийн Ууганбаяр багштай 9А ангийн 18 хүүхэд
10. 2-р сургуулийн 8А ангийн 23 хүүхэд

2. НҮҮДЛИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Номын сангийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилго бүхий нүүдлийн номын сангийн үйлчилгээг 11 цэцэрлэг, 6 сургууль, 14 байгууллага, 14 суманд тус тус хүргэн ажиллав.

Цэцэрлэгүүд: */859 ирцэд 1032 ном/*

1. I/16. 23-р цэцэрлэг 50 ширхэг номоор 65 хүүхдэд
2. II/15. 24-р цэцэрлэг 55 ширхэг номоор 60 хүүхдэд
3. IV/02. 8-р цэцэрлэг 132 номоор 132 хүүхдэд
4. IV/02. 4-р цэцэрлэг 100ш номоор 83 хүүхдэд

5. IV/03. 1-р цэцэрлэг 110 номоор 4-н бүлэгт 106 хүүхдэд
6. IV/03. 11-р цэцэрлэгийн 3-н бүлэгт 76 хүүхдэд 85 ном олгов.
7. V/20. 9-р цэцэрлэгийн 3-н бүлэгт 57хүүхдэд 59 ном олгов.
8. V/21. 2-р цэцэрлэгийн 2 бүлэгт 51 хүүхдэд 51 ном олгов
9. V/22. 26-р цэцэрлэг дээр ахлах 2 анги 69 хүүхдэд 70 ном олгов
10. X/16. 1-р цэцэрлэг 160 номоор 80 хүүхдэд
11. XI/22. 25-р цэцэрлэг 160 номоор 80 хүүхдэд тус тус үйлчиллээ.

Сургуулиуд: */ 1188 ирцэд 1198 ном/*

1. II/25. 4-р сургуулийн сургуульд 271 ирцэд 270 ном олгов.
2. II/26. 5-р сургууль 240ширхэг номоор 240 ирцэд
3. II/27. 3-р сургууль 236 ширхэг номоор 295 ирцэд
4. III/06. 2-р сургууль 185 номоор 156 ирцэд
5. X/08. 1-р сургууль 176 ирцэд 147 номоор
6. XI/14. 7-р сургууль 50 ирцэд 120 ном олгож үйлчиллээ.

Байгууллагууд: */1236 ирцэд 1226 ном/ нийт 14 байгууллага*

1. I/21. Төрийн үйлчилгээний нэгдсэн төв. Ном олголт 100   Ирэгсэд 38

2. II/20. Хилийн цэргийн 0167-р ангийн ажилтан, алба хаагчдад уншлага үйлчилгээ үзүүллээ. Ном олголт 130 Ирэгсэд 150
3. IV/22. 1-р цэцэрлэгийн хамт олны урилгаар явуулын номын сангийн үйлчилгээ үзүүллээ. Ном олголт 25 ирэгсэд 16
4. V/7. Насан туршийн боловсролын төвийн ажилтан, албан хаагчдын хүсэлтээр явуулын номын сангийн үйлчилгээ үзүүллээ. Ном олголт 25. Ирэгсэд 8.
5. VI/14. 3-р багийн хамт олны хүсэлтээр явуулын номын сангийн үйлчилгээг хүргэж үйлчиллээ. Ном олголт 40 Ирэгсэд 13
6. VI/23 2-р багийн иргэдэд явуулын номын сангийн үйлчилгээг хүргэж үйлчиллээ. Ирэгсэд 35 Ном олголт 50
7. VI/28. Статистикийн хэлтсийн хамт олонд нүүдлийн номын сангийн үйлчилгээг хүргэж үйлчиллээ. Ном олголт 20 Ирэгсэд 9
8. VII/01. Соёлыг дэмжих жилийн хүрээнд Ном уншдаг аймаг аяны хүрээнд өндөр настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрч үйлчлэхийн тулд багуудад зөөврийн номын санг бий болгон ажиллаж байна. Нүүдлийн номын сангаар Даланзадгад сумын 1,5,8-р багуудад явуулын номын сангийн үйлчилгээг үзүүллээ. Ирэгсэд 166 Ном олголт 180
9. VII/23. Төв Номын сан нь явуулын номын сангийн үйлчилгээгээр БУЯНТ болон ХӨДӨЛМӨР зусланд амарч байгаа хүүхдүүддээ уншлага үйлчилгээ үзүүллээ. Ном олголт 100 Ирэгсэд 170
10. VIII/2. "ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНТ ХИЛИЙН ЦЭРГИЙН 0131-р" ангийн ажилчид болон цэргийн алба хаагч нарт явуулын номын сангийн үйлчилгээг хүргэж үйлчиллээ. Ирэгсэд 45 Ном олголт 60
11. X/08. 6-р багын номын санд хандиваар ирсэн ном хэвлэлийг ялгалт хийж уншлага үйлчилгээнд гаргах ажилд зөвлөн тусаллаа. Ном олголт 26 Ирэгсэд 6.



12. XI/02-XI/03. Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд Даланзадгад сумын иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй нэг дороос хүргэх “ХӨДӨЛГӨӨНТ БАГ” үйлчилгээгээр хамт олноороо Даланзадгад сумын 8 багт уншигчийн карт үнэ төлбөргүй нээж номын үзэсгэлэн гаргаж ном хэвлэл олгож ажиллав. Уншигч 110 Ирэгсэд 511 Ном олголт 400

13. XI/22. Өмнөговь аймаг ус цаг уур орчны шинжилгээний төвд уншлага үйлчилгээ үзүүллээ. Ном олголт 20 Ирэгсэд 23
14. XII сард Өмнөговь аймгийн цагдаагийн газарт явуулын үйлчилгээгээр үйлчилнэ.Ном олголт 50 Ирэгсэд 46

Сумд: */14 сум 1505 ирцэд 2072 ном/*

- III/12-III/15ны өдрүүдэд Мандал-Овоо, Цогт-Овоо сумдад нүүдлийн номын сангийн үйлчилгээг хүргэж уншлага үйлчилгээ үзүүлэн, сурагчдын дунд соёл танин мэдэхүйн ажил зохион байгууллаа. 145 ирцэд 100 ном олгов.
- X/23. Ханхонгор сумын Соёлын төвийн номын санч А.Болормаа, ЕБСургуулийн номын санч Т.Цэнд-Аюуш нартай уулзаж номын сангийн үйл ажиллагаатай танилцан зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Мөн ЕБСургуулийн багш ажилчид, сурагч хүүхдүүд, эцэг эхчүүдэд уншлага үйлчилгээ явуулж дунд, ахлах ангийн сурагчдын дунд соёл танин мэдэхүйн ажлыг зохион байгууллаа. ЕБСургуулийн сурагч хүүхдүүд, багш, эцэг эхчүүдийн дунд үлгэрийн ном зохиолоор уншлага үйлчилгээ явуулсан. Нийт 95 хүнд 90 ширхэг ном олгож үйлчилсэн.
  Бага ангийн сурагчдын дунд ”ХЭН ХАМГИЙН ОЛОН ШҮЛЭГ МЭДЭХ ВЭ” тэмцээн зохион байгуулсан. Тус тэмцээний шилдэг оролцогчоор 5А ангийн сурагч Г.МӨНХСАРАН шалгарсан.
  Ахлах ангийн сурагчдын дунд “АВХААЛЖТАЙ УНШИГЧ” таниан мэдэхүйн багын тэмцээн зохион байгуулж 4 бага оролцож “СЭХЭЭТЭН” баг 17.3 оноогоор тэргүүлсэн.
- XI/18. ХҮРМЭН сумын Соёлын төвийн номын санч Цэвэлмаатай уулзаж номын сангийн үйл ажиллагаа, номын санд хөтлөгдөх данс бүртгэлүүдтэй танилцан зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Мөн сургуулийн сурагчдад шинэ номын танилцуулга хийж уншлага үйлчилгээ явуулан 3-5-р ангийн сурагчдын дунд сурагчдын дунд ”ХЭН ХАМГИЙН ОЛОН ШҮЛЭГ МЭДЭХ ВЭ” тэмцээн зохион байгууллаа. Нийт 46 хүүхдэд 50 ширхэг ном олгож үйлчилсэн.
- XI/13. НОМГОН сумын Соёлын төвийн номын санч Тэмүүжинтэй уулзаж номын сангийн үйл ажиллагаатай танилцан зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Нийт 58 хүнд 100 ширхэг ном олгож үйлчилсэн.Бага ангийн сурагчдын дунд ”ХЭН ХАМГИЙН ОЛОН ШҮЛЭГ МЭДЭХ ВЭ” тэмцээн зохион байгуулсан. Тус тэмцээний шилдэг оролцогчоор 7А ангийн сурагч Г.АГААРЫНБААТАР шалгарсан ба ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан “ДАРААГИЙН ХУУДАС” танин мэдэхүйн тэмцээнд шилдэг оролцогчоор 8А ангийн сурагч Б.МӨНХЗОРИГТ шалгарлаа.
- XI/08. Цогтцэций сумын Соёлын төвийн номын санч Батцэцэг, Борын нэрэмжит ЕБ-ийн 1-р сургуулийн номын санч Мөнх-Амгалан, Мөрөөдөл сургуулийн номын санч Оюун-Эрдэнэ нартай уулзаж номын сангийн үйл ажиллагаатай танилцан зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. ЕБСургуулийн сурагч хүүхдүүдэд шинэ ном хэвлэлээ танилцуулан уншлага үйлчилгээ явууллаа. Нийт 42 хүнд 100 ширхэг ном олгож үйлчилсэн. Бага ангийн сурагчдын дунд ”ХЭН ХАМГИЙН ОЛОН ШҮЛЭГ МЭДЭХ ВЭ” тэмцээн зохион байгуулсан.
- XII/3. Цогт-Овоо суманд явуулын үйлчилгээгээр очиж соёлын төвийн болон сургуулийн номын санч нарын ажил байдалтай танилцаж арга зүйн зөвлөгөө өглөө 23ирцэд 56 ном олгож үйлчилсэн. Хүүхдүүдийн дунд зохиолын

“Дараагийн хуудас” уралдаан зохион байгуулж ЕБС–ийн 8А ангийн сурагч О.Нандинжаргал түрүүлж дурсамж номоор шагнууллаа.

- XII/04. Ноён сумын соёлын төвийн болон сургуулийн номын санчийн ажилд зөвлөн тусалж сурагчдын дунд уншлага , “ДАРААГИЙН ХУУДАС” танин мэдэхүйн тэмцээн зохион байгууллаа. 39 ирцэд 115 ном олгов.
- XII/05. Гурвантэс сумын соёлын төвийн болон сургуулийн номын санчийн ажилд зөвлөн тусалж сурагчдын дунд уншлага , “ХЭН ХАМГИЙН ОЛОН ШҮЛЭГ МЭДЭХ ВЭ” тэмцээн зохион байгууллаа. 314 ирцэд 942 ном олгов.

Зөөврийн номын сангийн үйлчилгээ

Хүсэлт бүхий байгууллагуудтай харилцан гэрээний дагуу сайн дурын номын санч идэвхтэн уншигчдаар, номын санч, мэдээллийн ажилтны тусламжтайгаар зөөврөөр ном олгох үйлчилгээг зохион байгуулж ажиллаа. Үүнд: 9 байгууллагад 33 удаа нийт 538 ширхэг номоор 630 ирэгсэдэд зөөврийн үйлчилгээг хүргэсэн байна.

ШШГГазар /нийт 16 удаа 217ш ном 270хүнд /

- 2019.01.13 20ш ном 25хүнд
- 2019.02.21 20ш ном 25 хүнд
- 2019.03.15 20ш ном 25 хүнд
- 2019.04.1 20ш ном 20 хүнд
- 2019.04.25 18ш ном 26 хүнд
- 2019.05.22 10ш ном 26 хүнд
- 2019.06.03 10ш ном 12 хүнд
- 2019.07.01 10ш ном 9 хүнд
- 2019.07.30 10ш ном 13 хүнд
- 2019.08.06 10ш ном 12 хүнд
- 2019.09.02 15ш ном 15 хүнд
- 2019.09.26 15ш ном 13 хүнд
- 2019.10.10 8ш ном 8 хүнд
- 2019.10.23 13ш ном 13 хүнд
- 2019.11.12 14ш ном 14 хүнд
- 2019.11.28 14ш ном 14 хүнд

0167-р анги

/нийт 3 удаа 71ш ном 102 хүнд/

- 2019.01.08 22ш ном 36 хүнд
- 2019.02.01 38ш ном 36 хүнд
- 2019.05.23 11ш ном 30 хүнд

24-р цэцэрлэг
/нийт 1 удаа 27ш ном 16 хүнд/

- 2019.01.29 27ш ном 16хүнд

25-р цэцэрлэг

/нийт 2 удаа 40ш ном 46 хүнд/

- 2019.04.04 20ш ном 23
- 2019.04.22 20ш ном 23

2-р цэцэрлэг
/нийт 2 удаа 42ш ном 42 хүнд/

- 2019.04.05 20ш ном 21 хүнд
- 2019.04.19 22ш ном 21 хүнд

2-р багийн төв

/нийт 3 удаа 50ш ном 40 хүнд/

- 2019.07.30 15ш ном 16 хүнд
- 2019.10.17 15ш ном 12 хүнд
- 2019.11.13 20ш ном 12 хүнд

3-р багийн төв
/нийт 3 удаа 51ш ном 34 хүнд/

- 2019.06.27 20ш ном 16 хүнд
- 2019.08.06 15ш ном 10 хүнд
- 2019.10.07 16ш ном 8 хүнд

Шивээ хүрэн боомт МХГазар
/нийт 2удаа 25ш ном 50 хүнд/

- 2019.07.23 15ш ном 25 хүнд
- 2019.09.21 МХГазар 10ш ном 25 хүнд

Гашуун сухайт боомт МХГазар
/нийт 1удаа 15ш ном 30 хүнд/

- 2019.07.29 МХГазар 15ш ном 30 хүнд

3. СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ

Иргэдийн ном унших идэвхийг өрнүүлэх, номын сангийн үйл ажиллагаанд татан оролцуулах, иргэдийн соёлын түвшинг дээшлүүлэх зорилго бүхий соёл танин мэдэхүйн ажлуудыг төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа.

3.1. Зохиолч уншигчдын уулзалт II/28.

Монголын зохиолчдын эвлэлийн 90-н жилийн ойн баярт зориулан аймгийн зохиолч, яруу найрагч, уншигчдын уулзалтыг зохион байгууллаа. Тус уулзалтад Өмнөговь аймгийн зохиолчдын холбооны нарын бичгийн дарга, Тэргүүлэгч гишүүн, сэтгүүлч, яруу найрагч С.Сумъяа, Монголын зохиолчдын эвлэлийн гишүүн МУСТА У.Насанжаргал, Г.Сэр-Одын нэрэмжит шагналт зохиолч Т.Батхүрэл нарыг урьж ЕБСургуулийн ахлах ангийн сурагчидтай халуун дулаан яриа өрнүүллээ. Хүрэлцэн ирсэн хүүхдүүдийн дунд "НОМ" сэдэвт шүлгийн тэмцээн зохион байгуулж 3-р сургуулийн 10б ангийн сурагч Б.Дуламын зохиосон "Ном" шүлэг нь шилдгээр шалгарч гарын бэлгээр шагнаж урамшууллаа. Нийт оролцогч 46.

3.2. Үлгэрийн цаг арга хэмжээний нээлт. III/4.

Үлгэрийн цагийн нээлтийн арга хэмжээгээр хүүхэд багачуудад үлгэр уншуулан үлгэрийн утга санааг ярилцан, урлагийн тоглолт сонирхуулан, ардын уламжлалт тоглоом наадгайгаар тоглуулж, даамны тэмцээн зохион байгууллаа. Арга хэмжээнд 39 хүүхэд оролцон 85ш үлгэрийн ном уншлаа. Даамны тэмцээнд 4-р сургуулийн 5а ангийн сурагч А.Ган-Эрдэнэ тэргүүллээ.

Нээлтээс хойш үлгэрийн цагийг бага ангид 15 удаа явуулсан нийт 420 хүүхдэд 439 ном олгосон. Нэгдсэн цэцэрлэгүүдээс 8-н цэцэрлэгийн 19 анги хамрагдсан нийт 616 хүүхдэд 863 ном олгож үйлчилсэн. Уг арга хэмжээг 32 удаа зохион байгуулж 1611 хүүхэд хамрагдсан байна.

3.3. "Цэгээн нуурын чулуу" номын нээлт III/14.

МЗЭ-ийн Э.Эрдэнээгийн номын нээлтийг Нийтийн уншлагын танхимд зохион байгууллаа. Арга хэмжээнд 15 хүн оролцож яруу найрагчийн ном орсон шүлгүүдээс сонсон, урлагийн үзүүлбэрүүд сонирхлоо. Яруу найрагч Э.Эрдэнээ өөрийн номын дээжээс тус номын санд бэлэглэлээ.

3.4. "Батмөнх даян хаан" номын хэлэлцүүлэг III/14.

Насан туршийн боловсролын төвтэй хамтын ажиллагааны хүрээнд ажилтан ажиллагсдад Батмөнх даян хааны түүхийг судлуулж таниулах зорилгоор номын хэлэлцүүлэг зохион байгууллаа. Оролцогч 10.

3.5. "Зохиолч-Уншигчдын уулзалт" III/21.

Дэлхийн яруу найргийн өдрийг тохиолдуулан МЗЭ-ийн Өмнөговь аймаг дахь салбарын хамт олныг урьж уг арга хэмжээг зохион байгууллаа. Уулзалтад шүлэг яруу найраг сонирхогч 21 сурагчид оролцон яруу найрагчдын шүлгүүдээс сонсож өөрсдийн зохиосон шүлгээ уншин зөвлөгөө, зөвлөмж авлаа. Энэ үеэр Өмнөговь

аймгийн эмэгтэй яруу найрагчдын хамтын бүтээл "ИЖИЙ ГОВИЙН ДУУЛАЛ" номын дээжээс тус номын санд МЗЭ-ийн салбараас хандивлалаа.

3.6. “30 ном уншъя” танин мэдэхүйн тэмцээн /6-9-р ангийн сурагчдын дунд/ IV/3.

Хүүхэд залуучуудад номоор дамжуулан говь нутгийн түүхт хүмүүс Батмөнх Даян сэцэн хааны үүх түүх, үйл хэргийг сурталчлан таниулж нутаг усаараа бахархах үзлийг дээшлүүлэх зорилготой “30 ном уншъя” танин мэдэхүйн тэмцээн /6-9-р ангийн сурагчдын дунд/ зохион байгууллаа.

Өмнөговь аймгийн түүхт хүмүүс, нутаг орны бүтээн байгуулалт, газарзүйн онцлог зэргийг уншиж судлах номын жагсаалтын дагуу сургуулиуд сурагчиддаа уншлага зохион байгуулж хэлэлцүүлэг өрнүүлэн сургууль бүр шалгарсан шилдэг 2 сурагчдыг төлөөлөл болгон оролцуууллаа.

Тэмцээнд 5 сургуулийн тус бүр 2 төлөөлөл нийт 10 оролцогч, хөгжөөн дэмжигчдийн хамт оролцон оюун ухаан, мэдлэгээрээ өрсөлдлөө.

Тэмцээнд хамгийн олон үеийн асуултад буюу 5 үеийн асуултыг амжилттай хариулан 1-р сургуулийн 9а ангийн сурагч Э.Мандуул, 9в ангийн сурагч О.Угтахбаяр нар бусдыгаа манлайллаа.

3.7. Англи номын танилцуулга бүтээлч уншлага IV/5.

Хөгжлийн мэдээлэл сургалтын төвийн гадаад номуудыг танилцуулах бүтээлч уншлагад 5-7-р ангийн англи хэл сонирхон суралцагч сурагчид хамрагдан англи дуу сурч, цаасан нугалбараар номын хавчуурга урлаж сурлаа. /Хамрагдсан хүүхэд 24/

3.8. "Ерэн баатрын дууль" уран уншлагын уралдаан /IV/4-IV/18/

Халх голын түүхт ялалтын 80 жилийн ойн нэрэмжит “Тусгаар тогтнол, түүхэн уламжлал, хөгжил дэвшил” аяны хүрээнд БСУГазар, Төв номын сан, Насан туршийн боловсролын төвтэй хамтран уг уралдааны онлайн хэлбэрээр 1-р шатыг зохион байгууллаа. 1-р шатанд 11 оролцогч шүлгийг уншиж бичлэгээ ирүүлснээс 2-р шатанд 4 оролцогчийг дуудан шүлгийг биечлэн уншуулж шилдгийг шалгаруулсан. Халх голын дайны түүхэн ялалт, баатруудын гавьяаг эргэн дурсах иргэдийн эх оронч үзлийг бадраах зорилго бүхий уралдааныг оролцогч Н.Цолмонгарав манлайлан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа.

3.9. “30 ном уншъя” танин мэдэхүйн тэмцээн /10-12-р ангийн сурагчдын дунд/ IV/23.

Тэмцээнд 4 сургуулийн тус бүр 2 төлөөлөл нийт 8 оролцогч, хөгжөөн дэмжигчдийн хамт оролцон оюун ухаан, мэдлэгээрээ өрсөлдлөө

5-р сургуулийн 10в ангийн сурагч Цэндмаа, 11а ангийн сурагч Баярмаа нар багаараа тэмцээний 8 үеийг амжилттай давж бусдыгаа манлайллаа.

3.10. "Уншингаа урлая" бүтээлч уншлага IV/23.

Дэлхийн номын өдрийн хүрээнд бага, дунд насны уншигч хүүхэд багачуудын унших, урлах авьяас сонирхлыг дэмжсэн "Уншингаа урлая" бүтээлч уншлагыг зохион байгууллаа. Хүүхдүүд уншсан номынхоо үйл явдал, дуртай номын баатруудыг баримлын шавар болон цаасан нугалбараар хийж урлалаа. /22 хүүхэд оролцов/

3.11. "Нүдээрээ сонсоно " номын нээлт IV/29.

МЗЭ-ийн Өмнөговь дахь салбартай хамтран яруу найрагч Ж.Алтанцэцэгийн “Нүдээрээ сонсоно” номын нээлтийг зохион байгууллаа. Тэрээр манай номын сангийн байнгын идэвхтэн уншигчдын нэг байсан юм. /Оролцогчид 60/

3.12. “Бидний бахархал-Монгол бичиг” уралдаан IV/24-V/8

Бичиг үсгийн баярыг угтан үндэсний утга соёлын нандин өв болсон монгол бичгийг хойч үедээ өвлүүлэн уламжлуулж, сурталчлах, иргэдийн монгол бичгийг сурч эзэмших идэвхийг дэмжих зорилгоор Даланзадгад сумын насанд хүрэгсдийн дунд зохион байгуулсан уг уралдаанд 136 оролцогч бичвэрээ ирүүлж оролцлоо.

Уралдаанд материалаа ирүүлсэн оролцогчдын 70%-ийг төрийн албан хаагчид эзэлж байгаагаас 2025 оноос монгол бичгийг албан хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажил орон нутагт амжилттай хэрэгжиж байгааг харж болохоор байна. 4-өөс дээш ажилтан албан хаагчид нь материалаа ирүүлсэн байгууллагууд 14 байгаагаас Баруун сайхны 3-р баг, МХГазар, Статистикийн хэлтэс, Монгол банк, ЗХ-ний 167-р анги, Насан туршийн боловсролын төвийн хамт олон зэрэг байгууллага, баг хамт олон Даланзадгад сумын багийн дарга нарыг онцгойлон сайшаамаар байна. Ажилтан албан хаагчдаа амжилттай оролцуулсан байгууллагуудын нэрийг монгол уран бичлэгээр бичиж /бичиг үсгийн баяр гэсэн үгтэй хамт/ дурсгал болгон өгч урамшуулсан.

Уралдаанд бичвэрээ ирүүлсэн оролцогчдын бичвэрүүдийг монгол хэл бичгийн багш нарын тусламжтайгаар шүүн шилдэг бичвэрүүдийн эздийг энэ Бичиг үсгийн баярын уриа “Үндэсний бичиг тусгаар тогтнолын баталгаа” үгийг бичүүлж байруудыг шалгарууллаа. Үүнд:

I-р байр 4-р сургуулийн математикийн багш Б.Отгонжаргал
II-р байр 1-р багийн иргэн Х.Эрдэнэсайхан /Политехникийн коллежийн багш/
III-р байр ХХҮГазрын мэргэжилтэн Ө.Мөнхсайхан
Шилдэг баг хамт олноор "Баруун сайхны 1-р баг" тус тус шалгарлаа.

Энэ жилийн уралдаанд ирсэн бичвэрүүдийн чанар, оролцогчдын тоо зэргийг харгалзан үзэж бид цаашид илүү ахисан түвшний монгол уран бичгийн буюу бүтээлийн уралдааныг зохион байгуулах хэрэгцээ шаардлага байгааг олж харсан.

3.13. Үндэсний бичиг үсгийн баяр V/10

МУ-ын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлж үндэсний бичиг соёлоо түгээн дэлгэрүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдлэх бичиг соёлын дурсгалыг сурталчлах, Монгол хэл бичгийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, иргэд болон өсвөр үеийнхэнд Монгол бичгээ эзэмших сэдэл, тэмүүллийг бий болгох зорилгын хүрээнд "ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСЭГ ТУСГААР ТОГТНОЛЫН БАТАЛГАА" уриан дор 2019.05.10-ны өдөр бичиг үсгийн баярыг аймгийн дэмжлэгтэйгээр тэмдэглэн өнгөрүүллээ.

Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнд нийт 300 гаруй хүн оролцлоо.

Нээлт: *Нээлтийн арга хэмжээг 5-р сарын 10-ны өдрийн 10 цагт Төв номын сан дээр зохион байгууллаа. Арга хэмжээг нээж БСУГазрын дарга Г.Бат-Эрдэнэ, Номын сангийн дарга А.Одончимэг, Даланзадгад сумын ЗДТГ-ын* Боловсрол, соёл, нийгмийн бодлогын мэргэжилтэн С.Болд *нар үг хэллээ.*

ХЖТеатрын уран бүтээлчид дуу хуураа өргөж 4-р сургуулийн монгол уран бичлэгээр суралцагч сурагчид Арвин, Шижирбат нар уран бичлэгийн үзүүлбэр үзүүллээ.

Мөн баярыг угтан зохион байгуулсан “Бидний бахархал-Монгол бичиг” уралдааны шагналыг шилдэг оролцогчдод гардууллаа.

4-р сургуулийн уран бичлэгт суралцагч 9 сурагчдын хамтран бүтээсэн Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийн уран бичвэр бүхий дурсгалыг 4-р сургуулийн захирал Отгонбаатар Төв номын санд дурсгал болгон гардуулж өглөө.

Монгол бичгийн хурдан уншлага

Баярын үеэр иргэдийн дунд хурдан уншлагын тэмцээн зохион байгуулахад 18 иргэн оролцож 4-р сургуулийн гадаад хэлний багш О.Машчимэг 86 үг уншсан амжилтаар тэргүүллээ.
Монгол бичгийн эх уншиж оролцсон иргэд минутанд 15-86 үг уншсан байна.

Монгол бичгийн шилдэг гарын үсэг

Монгол бичгийг хэрэглээ болгож өдөр

тутамдаа хэрэглэхийг уриалан дэмжиж Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд монгол бичгийн "Шилдэг гарын үсэг" шалгаруулахад 44 хүн оролцож Шилдэг гарын үсгийн эзнээр 4-р сургуулийн бага ангийн багш Б. Мөнхцэцэг шалгарлаа.

Эртний ховор хуучин ном, монгол бичгээр бичигдсэн номын үзэсгэлэн

Үндэсний бичиг соёлын дурсгалыг сурталчлах, сан хөмрөгт байдаг ховор хуучин номыг нийтэд танилцуулах зорилгоор 28 ширхэг гар бичмэл болон барын ном, судар, 21 ширхэг өнгөт зургийн альбом, 41 ширхэг монгол бичгээр бичигдсэн үлгэрийн ном, монгол бичгийн сурахад зориулагдсан 42

ширхэг ном, нийт 132 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж олон нийтэд толилууллаа.

Уран бичлэгийн үзэсгэлэн

Монгол бичгийг түгээн дэлгэрүүлэгч, монгол бичгийн уран бичлэгийг суралцагчдыг урамшуулах, бүтээлийг нь олон нийтэд сурталчлах, иргэдийг монгол бичигт уриалах зорилгоор монгол уран бичлэг сонирхон суралцагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргаж олны хүртээл болголоо.

Үзэсгэлэнд 4-р сургуулийн багш Ү.Мөнхбалжир, 4-р сургуулийн уран бичлэгийн дугуйлангийн 10 сурагчид, 1-р сургуулийн 10а ангийн сурагч О.Эрдэнэчимэг нар нийт 25 бүтээлээрээ оролцлоо.

Уран бичлэгийн үйлчилгээ

ЮНЕСКО-гийн яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн Монгол уран бичлэгийн гайхамшигийг нийтэд таниулах, иргэдэд монгол бичгийг сурч эзэмших хүсэл тэмүүллийг бий болгох, уран бичлэгт суралцагч хүүхэд, залуучуудыг дэмжих зорилгоор уран бичлэгээр нэр, дурсгалын үг бичих үйлчилгээг зохион байгууллаа.
Бидний бахархал-Монгол бичиг” уралдаанд амжилттай оролцсон байгууллагуудын нэр, бичиг үсгийн баярыг дэмжин ая дуугаа өргөсөн уран бүтээлчдийг урамшуулж дурсгалын үг бичсэн бичвэрийг дурсгал болгон өглөө. / багш Ү.Мөнхбалжир шавь 9б ангийн сурагч Арвин, 9а ангийн сурагч Шижирбат нарын бичвэр /5-р сургуулийн 9б ангийн сурагч Х.Намуунбайгаль, 9 ангийн сурагч Б.Эрхсаран нар уран бичлэгийн бичвэр бичиж үйлчилсэн.

3.14. "БИ ЗУРАХ ДУРТАЙ" гар зургийн уралдаан IV/24-V/8.

Хүүхдийн уншлагын танхимаас хүүхдийн авьяас чадварыг дэмжих, номоор дамжуулан хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой "БИ ЗУРАХ ДУРТАЙ" гар зургийн уралдааныг Даланзадгад сумын ЕБСургуулиудын 3-5 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. Уралдаанд 318 зураг ирснээс

I-р байр: 3-р сургууль 5б ангийн сурагч У.Золзаяа
II-р байр: 4-р сургууль 3б ангийн сурагч О.Түмэндэлгэр
III-р байр: 4-р сургууль 5в ангийн сурагч Б.Отгонзаяа
Тусгай байр: 3-р сургууль 3б ангийн сурагч Г.Мөнгөн-Учрал нарын зургууд тус тус шалгарлаа.

Энэ жилийн уралдааны хувьд уралдааны удирдамжид зургийн агуулга, зохиолын баатруудын дүр дүрслэлийг илүү тод томруун гаргаж өгсөн зургууд ирсэн байсан нь зургийг зурахын тулд хүүхдүүд зохиол бүтээлийг илүү уншиж, дүрийг судалсан нь харагдаж байлаа.

3.15. "Өглөөний гайхамшиг" номыг уншигчдын уулзалт, хэлэлцүүлэг V/20.

Өмнөговь аймгийн "ӨГЛӨӨНИЙ ГАЙХАМШИГ" фэйсбүүк групптэй хамтран "ӨГЛӨӨНИЙ ГАЙХАМШИГ" номыг уншигчдын уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтанд оролцогсод номын талаар хэлэлцүүлэг өрнүүлж, өглөөг хэрхэн эрч хүчтэйгээр угтаж амжилт гаргах талаар харилцан ярилцаж туршлага хуваалцлаа.

3.16. Хүүхдийн баярын Номын өргөө VI/1

Хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээнд Номын өргөөнд бяцхан уншигчдынхаа баримлын шавраар урласан бүтээлийн үзэсгэлэн гаргаж, зурагт болон үлгэрийн номоор үйлчиллээ.

Мөн "Мэдлэгтэй чихэр" сугалаа явуулж номын азтан, чихрийн азтан тодруулллаа. Мөндөөлэй номын зохиогч С.Гантогтох ном, шүлэгт дуртай бяцхан уншигчдын дунд өөрийн зохиосон шүлгийг унших уралдаан зохион байгуулж Номтой бэлгээ гардууллаа.

3.17. Бодлын мөнгөн жимээр номын нээлт VI/7.

Нийтийн уншлагын танхимд малын их эмч мэргэжилтэй яруу найрагч Ц.Сундуйн "БОДЛЫН МӨНГӨН ЖИМЭЭР" номын нээлтийг МЗЭ-ийн салбартай хамтран зохион байгууллаа.

3.18. Номын солилцоо, уншигч ээжүүдийн уулзалт VI/22

3.19. "Говийн ээжүүдийн хөгжлийн клуб"-тэй хамтран ээжүүдэд ном уншихын ач тус, хүүхдээ хэрхэн ном унших сонирхолтой болгох талаар болон номын сангийн үйлчилгээний талаар яриа, танилцуулга мэдээлэл хийж уулзалт зохион байгууллаа. Энэ үеэр хүрэлцэн ирсэн ээжүүд маань өөрсдийн гэр бүл болон хүүхдээ ном уншдаг болгоход

нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар ярилцаж, өөрсдийн туршлагаас хуваалцан номын солилцоог зохион байгууллаа. Уулзалтад оролцсон ээжүүдийнхээ дунд номын азтан тодрууллаа.

3.20. Өглөөний уншлага /дугуйт VI/28/

"#Автомашинаас_татгалзая_ажилдаа_дугуйгаар_явья" аянд нэгдэн өглөөг дугуйтай угтагч иргэддээ зориулан хувь хүний хөгжлийн номуудаар дугуйт уншлага зохион байгууллаа. Эрүүл мэнддээ анхаарч өглөөг эрч хүчтэй эхлүүлсэн гэр бүл, хүүхдүүдийг номоор урамшууллаа.

3.21. "ГЭР БҮЛИЙН ШИЛДЭГ " номын сан шалгаруулах уралдаан VIII/29-IX/12

"Соёлыг дэмжих жил" "Бид ном уншдаг аймаг" аяны хүрээнд Даланзадгад сумын ЗДТамгын газартай хамтран Өрх гэр бүлийн гишүүдийн ном уншлагыг дэмжих, өрхийн номын сангийн сан хөмрөгийн баяжилт, ашиглалт эмх цэгцийг сайжруулж, шилдэг гэрийн номын сангуудын туршлагыг олон нийтэд сурталчилан дэмжих зорилгоор "ГЭР БҮЛИЙН ШИЛДЭГ " номын сан шалгаруулах уралдааныг амжилттай зохион явууллаа.

Тус уралдаанд нийт 14 өрх гэр бүлийн номын сангийн танилцуулга материал ирснээс "ХАМГИЙН УРТ НАСТАЙ БАЯЛАГ НОМЫН САН" төрөлд А.Цоож, Ш.Баттөмөр нарын гэр бүл, "ХАМГИЙН ШИНЭЛЭГ НОМЫН САН" төрөлд Б.Хандсүрэн, Л.Ганбаатарын гэр бүл "ХАМГИЙН ОНЦЛОГ НОМЫН САН" төрөлд

П.Мөнхдэлгэрийн гэр бүлийн номын сангууд тус тус шалгарлаа.

3.22. Номын баяр IX/14

МУ-ын ерөнхийлөгчийн 2012 оны "Номын баярын өдөр тэмдэглэх тухай" 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, ном хэвлэлийг сурталчилах, уншлагыг дэмжих, “Бид ном уншдаг аймаг” аяны мэдээллийг олон нийтэд хүргэх, эрчимжүүлэх зорилго бүхийн Номын баярыг 2019 оны 09-р сарын 14-ний өдрийн Бямба гаригт тэмдэглэн өнгөрүүллээ. Номын баярыг зохион байгуулах зардалд орон нутгийн зүгээс 1,201,000 төгрөгийг шийдэж дэмжлэг үзүүллээ.

Номын баярын нээлт

Батмөнх даян хааны талбайд зохион байгуулсан нээлтийн арга хэмжээнд орон нутгийн удирдлагууд баярын үг хэлж, шилдэг тэргүүний уншигчдыг шагнаж урамшуулан, номын баярыг угтан зохион байгуулсан “Гэр бүлийн шилдэг номын сан” уралдааны шилдгүүдийн шагналыг гардууллаа. Баярын нээлтийн арга хэмжээнд Ханхонгор сумын урлагийн сургалттай сургуулийн сурагчид урлагийн үзүүлбэрээ үзүүллээ.

“Авхаалжтай уншигч” тэмцээн

ЕБС-н сурагчдыг монголын шилдэг зохиол бүтээлүүд, зохиолчдыг

таниулах сурталчлах, сурагчдын номыг бүтээлчээр унших арга барил, авьяас чадварыг хөгжүүлэх зорилгоор Даланзадгад сумын ЕБСургуулиудын ахлах ангийнхны дунд уг тэмцээнийг зохион байгууллаа.

Тэмцээнд 5 гишүүн бүхий 5 сургуулийн төлөөлөл оролцон монголын уран зохиол, яруу найргийн сэдэвт 5 үе бүхий даалгаварыг хийж гүйцэтгэлээ. Тэмцээний даалгаварууд сурагчдын заавал унших зохиолууд, зохиолчдын намтар, уран бүтээлийн талаар асуулт үзүүлбэрүүдээс бүрдэж байв.

Тэмцээний Тэргүүн байранд 2-р сургуулийн "ТУСГААР ТОГТНОЛ" баг Дэд байранд 3-р сургуулийн "ЦЭЦГЭН ЭРХИ" багууд шалгарлаа.

“Миний дуртай шүлгүүд” тэмцээн

Номын баярт оролцогчдын дунд 4 мөрт шүлэг зохиох тэмцээн зохион байгуулав. Тэмцээнд оролцогчид “Ном” сэдвээр 4 мөрт шүлэг зохион өрсөлдсөнөөс Яруу найрагч Т.Батхүрэл шалгаран Өргөмжлөл, номоор шагнууллаа.

Ховор хуучин номын үзэсгэлэн

Тус номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байдаг ховор хуучин, түүхэн зурагт альбомуудаар үзэсгэлэн гаргаж үйлчиллээ. /46 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж 127 хүн үзэж сонирхсон байна./

Номын хандив

Номын баярын үеэр яруу найрагчид, иргэд, ном хэвлэн нийтлэгчид номынхоо дээжээс тус номын санд хандивлалаа. Нийт 39 ном хандивласан МЗЭ-ийн Өмнөговь салбарт шилдэг ном хандивлагч Талархал гардууллаа.

Шинэ хуучин номын худалдаа солилцоо

Уншигчид, иргэд энэ үеэр өөрсдийн уншсан ном, хэрэглэж байсан сурах бичгээ худалдан борлуулж, солилцлоо.

Номын азтан

Номын баярт оролцогсдыг урамшуулж ном уншихыг уриалан сугалаа тарааж хаалтын үеэр азтангууд тодрууллаа. Нийт 252 сугалаа тараагдсанаас 2 хүнийг азтанаар тодруулан Монголын нууц товчоо, танин мэдэхүй, уран зохиолын шинэ номоор аз одыг нь мялаалаа.

Мэдээлэл сурталчилгаа

“Бид ном уншдаг аймаг” аяны танилцуулга мэдээлэл, номын сангийн танилцуулга, ном унших зөвлөмж, зөвлөгөө бүхий тараах материалуудыг тарааж ажиллаа. Мөн номын баярын арга хэмжээний мэдээ, мэдээллийг орон нутгийн телевизээр мэдээ болгон олон нийтэд хүргэлээ.

3.23. Говийн мэдээ сонин дахин хэвлэгдэж эхэлсний нээлт IX/30

Говийн мэдээ шинэ өнгө төрхтэй хэвлэгдэн гарч байгаатай холбогдуулан нээлтийн арга хэмжээг редакцитай хамтран зохион байгууллаа. Тус арга хэмжээнд говийн мэдээ сонинд редактор хийж байсан үе үеийн ахмад ажилтанууд хүрэлцэн ирж халуун дотно яриа өрнүүлсэн ба номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа "ГОВИЙН МЭДЭЭ" 1957-1998 оны сонингуудаар үзэсгэлэн гаргаж нийтэд толилууллаа.

3.24. “Шилдэг номын тэмдэглэл”-ийн уралдаан XII/6-XII/14

Номын хур баярыг угтан Даланзадгад сумын ЕБСургуулиудын сурагчдын дунд 3 насны ангиллаар “Шилдэг номын тэмдэглэл”-ийн уралдаан зарлаж уралдааны мэдээллийг ЕБС-ийн 6 сургууль, Политехникийн коллежид хүргүүллээ.

Уралдаанд

1-р сургууль 35 сурагч

2-р сургууль 38 сурагч

4-р сургууль 35 сурагч

5-р сургууль 82 сурагч

3-р сургууль 72 сурагч

Нийт 262 хүүхэд номын тэмдэглэлээ ирүүлснээс

Ахлах ангийн төрөлд

1-р байр 4-р сургууль 12в ангийн сурагч Н. Цэнд-Очир
2-р байр 2-р сургууль 10Б ангийн сурагч Б.Энхжин
3-р байр 1-р сургууль 11А О.Эрдэнэчимэг

Дунд ангийн төрөлд

1-р байр 1-р сургууль 6а анги Ц.Содномянжид
2-р байр 3-р сургууль 6А О.Хүсэлцэцэг
3-р байр 3-р сургууль 6А М.Өлзийхишиг

Бага ангийн төрөлд

1-р байр 5-р сургууль 5б анги Б. Мишээл
2-р байр 1-р сургууль 5В А.Батцэцэг
3-р байр 5-р сургууль 3Д Б.Оньс нар эзэллээ.

Номын хандив

Дэмжигч байгууллага, хувь хүмүүсээс нийт 558 ширхэг ном цугларсныг 300 хүүхдийн номтой бэлэг, Шилдэг тэмдэглэлийн эздэд шагналын номын багцад оруулан зарим нэг утга агуулга, болон эдэлгээний хувьд шаардлага хангахгүй номуудыг номын сангийн сурталчилгааны тавиурт байрлуулан иргэд уншиж судлах буюу авч ашиглах боломжийг бүрдүүллээ.

- АЗДТГазар Нийгмийн бодлогын хэлтэс 300 ном /ном, чихэр, бичгийн хэрэгсэл-1,995,000 төгрөгний, Буянт хотхон зусланд 50% хөнгөлөлттэй амрах 2 эрх /
- УИХ-ын гишүүн Н.Амарзаяа 100 ном /Найрамдал зусланд амрах 4 ширхэг эрх/
- Ухаалаг шийдэл гэгээн амьдрал 100 ном
- МЗЭ-ийн Өмнөговь салбараас 45 ном /Сайнбуян 15ном/
- У.Насанжаргал-МЗЭ-ийн Өмнөговь салбар 10 ном
- Тэнгэрийн хүрд жолооны курсын захирал Г.Ундармаа 50000 төгрөгийн 3 ном

Номын хур баяр XII/14

Хүүхдийн уншлагыг дэмжих, шилдэг тэргүүний уншигчдын туршлагыг хуваалцах, шилдэг уншигч хүүхдүүдийг шагнаж урамшуулах зорилготой уг баярыг 12-р сарын 14-ний өдрийн 11 цагт аймгийн ХЖТеатрт зохион байгууллаа. /Оролцсон хүүхдийн тоо 318/

Баярыг нээж АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Ү.Энхцацрал, УИХ-ын гишүүн Н.Амарзаяа нар уншигч хүүхдүүдэд хандан үг хэллээ.

Баярт 1-р сургуулийн сурагчид ая дууны дээжээ өргөлөө.

ГБХЗХГазрын дэд дарга Б.Төмөрбат уншсан ном, ном унших талаар илтгэлээ толилууллаа.

Шилдэг тэмдэглэлийн уралдаанд байр эзэлсэн сурагчдын шагнал, баяр оролцогч уншигч хүүхдүүдийн төлөөлөлд номтой бэлгийг гардуулж өгөв.

Мөн Шилдэг тэмдэглэлийн уралдааны тэргүүн байр эзэлсэн сурагчид өөрсдийн номд дурласан, номтой нөхөрлөсөн тухайгаа ярьж хүүхдүүдэд хандан ном уншихыг уриалж үг хэллээ.



Баярт сургууль бүрийн төлөөлөл ном уншдаг, номын тэмдэглэл хөтөлдөг 300 сурагчийг урьж оролцуулан номтой бэлгээр урамшууллаа.

Сурагчдын номын тэмдэглэлээр үзэсгэлэн гарган сурагчид нэгнээсээ суралцах боломжийг олгон ажиллаа.

Номын тэмдэглэлийн уралдаанд ирсэн тэмдэглэлүүдээс харахад номын тэмдэглэлийг багшийн зөвлөснөөр хөтөлж эхэлж буй сурагчид байхад өөрийн сонирхлоор тогтмол хөтөлдөг хүүхдүүд бас байна. Бага ангийн сурагчид ихэвчлэн ангиараа нэг загвар бүхий дэвтэр дээр ижил загвараар хөтөлдөг, дунд ангиас эхлэн сурагчид өөрсдийн сонирхлоор тэмдэглэл хөтөлдөг болох нь харагдаж байлаа. Өөрсдийн сонирхлоор тэмдэглэл хөтөлдөг хүүхдүүд илүү бүтээлч, дүрд, болон зохиолдоо дүн шинжилгээ хийсэн, өөртөө тусгаж авсан байдлаар хандаж тэмдэглэл хөтөлсөн байна.

Соёлыг дэмжих жилийн хүрээнд анги хамт олноороо зорилго тавин ном уншиж, номын тэмдэглэл хөтлөх ажлыг зохион байгуулж хүүхдэд дээрх дадал зуршил бий болоход дэмжлэг үзүүлж ажилласан сайн тал харагдлаа.

Номын хур баяр хүүхдүүд уншиж мэдэж, сурч, хөгжсөнийхөө төлөө шагнуулж, урамшуулсанд урам авч, дараа жилийг хүртэл тэмдэглэл хөтлөх, ном унших талаар төлөвлөн ярьж байсан бол эцэг, эхчүүдийн зүгээс өөрсдөө ч ном уншсаны төлөө хүүхдээ баярлуулж байсан удаагүй байхад уншдаг хүүхдүүдийг урамшуулсан сайхан арга хэмжээ боллоо гэсэн талархал дүүрэн байлаа.

4. САН ХӨМРӨГИЙН БАЯЖИЛТ, ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

- 999 ширхэг монгол ном, сонин, сэтгүүлээр сан хөмрөгөө баяжуулсан байна. /Нийт 12854420 төгрөгийн/
  Үүнд:
  - Төсвийн хөрөнгөөр –2640100 төгрөгийн 99 нэр төрлийн 131 ширхэг ном
  - Орон нутгийн дэмлэг- 3,500,000 төгрөгийн 94 нэр төрлийн 162 ширхэг ном
  - Бэлэг хандиваар ирсэн–6088420 төгрөгийн 513 нэр төрлийн 663 ширхэг ном
  - Сонин сэтгүүл – 625900 төгрөгийн 43 нэгж сонин, сэтгүүл
- Сар бүрийн сүүлчийн 7 хоногийн 5 дахь өдөр тавиуруудын бүх номынхоо эмх цэгцэд анхаарч, чийгтэй цэвэрлэгээг хийж, өрөө тасалгааг ариутгаж ажиллав.
- Хуудас салсан буюу урагдаж гэмтсэн 582 номонд сэлбэн засалт хийж ашиглалтыг уртасгах арга хэмжээ авлаа.
- Сан хөмрөгийн өрөөний чийгшил, агааржуулалтанд анхаарч АЗДТГазрын дэмжлэгтэйгээр 2 ширхэг агаар ионжуулж цэвэршүүлэгч авч байрлууллаа.

5. МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА

Номын сангаас зохион байгуулсан арга хэмжээнүүдийг Монцамэ-3 удаа, UCTV-5 удаа, ОНХА-2 удаа, Алтан говь-2 зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийт 12 удаа, байгууллагын нүүр ном хуудсаар 120 удаа мэдээ, мэдээлэл тавьж олон нийтэд үйлчилгээ үйл ажиллагаагаа сурталчилж ажиллав.

Сан хөмрөгийн хуучин ном хэвлэлийг сурталчлах, тэмдэглэлт өдрүүд, тодорхой сэдвийг хамарсан сэдэвчилсэн номын үзэсгэлэнг нийт 44 удаа 1658 ширхэг номоор, шинэ ном хэвлэлийг уншигчид олон нийтэд танилцуулах номын үзэсгэлэнг нийт 22 удаа 483 ширхэг номоор тус тус зохион байгууллаа.

Шинэ номын үзэсгэлэн ***/22 удаа 483 ширхэг номоор 1498 хүнд/***

- Нийтийн уншлагын танхим -5 удаа 84 ширхэг номоор /267 хүнд/
- Гэрээр ном олгох танхим – 7 удаа 242 ширхэг номоор /193 хүнд/
- Хүүхдийн уншлагын танхимаас- 6 удаа 71 ширхэг номоор /863 хүүхдэд/
- Сан хөмрөгөөс -4 удаа 86 ширхэг номоор /175хүнд/

Сэдэвчилсэн үзэсгэлэн ***/44 удаа 1658 номоор 2221 хүнд /***

Нийтийн уншлагын танхимаас / 10 удаа 392 ширхэг номоор 500 хүнд/

1. II/12. Онч мэргэн үгсийн номоор /26 ширхэг ном 34 хүн үзсэн/
2. III/6. Эмэгтэйчүүдэд зориулсан номоор /65 ширхэг номоор 91 хүн үзэж сонирхсон/
3. III/12. Шилдэг яруу найргийн номоор / 40 ширхэг ном 37 хүн /
4. IV/17. Үе үеийн хамгийн их уншигдсан номууд /48 ширхэг ном үзсэн хүний тоо 42/
5. V/24. Хувь хүний хөгжлийн номоор / 45 ширхэг ном 51 хүн /
6. VI/.23нд ТА АЯЛАХАД БЭЛЭН ҮҮ аялалын талаар номын үзэсгэлэн гаргасан нийт / 17 ширхэг ном 6 хүн/
7. IX/.09 залуу эмэгтэйчүүдийн заавал унших номын жагсаалтаар / нийт 27 ном 28 хүн/
8. IX/.10 хичээлийн шинэ жилийг тохиолдуулан дунд, ахлах ангийн ЕБС –ийн хүүхдийн заавал унших номын жагсаалтаар / нийт 34 ширхэг ном 32 хүн /
9. Политехник коллеж дээр мэргэжлийн номоор үзэсгэлэн гаргасан. Нийт 40 ширхэг номоор хүний тоо 150
10. Дэлхийн сонгодог зохиолоор үзэсгэлэн гаргасан нийт 50 ширхэг номоор хүний тоо 29

Хүүхдийн уншлагын танхимаас / 8 удаа 216 ширхэг номоор 670 хүүхдэд/

- I/25. Сар шинийн баярт зориулж: **“АРДЫН УЛАМЖЛАЛТ ЁС ЗАНШИЛ МЭНДЛЭХ ХҮНДЛЭХ ЁС**” сэдэвт үзэсгэлэн 10ш номоор гаргав. 76хүүхэд үзэв.
- II/4. Үлгэрийн цагийн нээлтэнд зориулж “ МОНГОЛ АРДЫН ҮЛГЭР**”** сэдвээр үзэсгэлэн гаргав.42хүүхдэд 49 ном олгов.
- III/24. Сургуулийн ахлах дунд ангийханд зориулсан “**ТУУЖ ӨГҮҮЛЛЭГ**”сэдэвт номоор үзэсгэлэн гаргав. 18ш номоор үзэсгэлэн гаргав**.**64 хүүхэд үзэж сонирхов.
- IV/1. Дэлхийн номын өдөрт зориулж дэлхийн шидэт үлгэрийн хаан Х.К. **Андерсен**ий үлгэрийн цуврал номоор үзэсгэлэн гаргав.20ш номоор үзэсгэлэн гаргав. Үзсэн хүүхдийн тоо 110.
- V/12. **Дүрсгүй жаалын өдрийн тэмдэглэл** цуврал номын үзэсгэлэн 18ш номоор гаргав үзсэн хүүхдийн тоо 54.
- VI/08. Хүүхдийн зуны амралтанд зориулж ”Хөгжилтэй адал явдалт ном” үзэсгэлэн 36ш номоор гаргав. Үзсэн хүүхдийн тоо 129.
- VI/ 24. ” Мэдлэг нэмэх миний ном” 40ш номоор гаргав. 130 хүүхэд үзсэн.
- VII/03 “ Бидний унших дуртай номууд” 25ш номоор гаргав.65хүүхэд уншсан.

Гэрээр ном олгох танхимаас /9 удаа 306 ширхэг номоор 251 хүнд/

1. II/8. Гэгээн хайрын өдөрт зориулсан Хайр сэдэвт үзэсгэлэн /32ш номоор 33 хүн үзэж сонирхсон/

2. III/1. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан эмэгтэй хүн бүрийн унших номоор үзэсгэлэн гаргав. /32ш номоор 30 хүн үзэж сонирхсон/

3. III/18. Монгол цэргийн баярыг тохиолдуулан үе үеийн баатарлаг үйлс бүтээсэн хаадын намтар түүх болон эрчүүдийн заавал унших номоор үзэсгэлэн гаргав. /32ш номоор 26 хүн үзэж сонирхсон/

4. IV/8. Дэлхийн номын өдрийг тохиолдуулан "ГАДААДЫН СОНГОДОГ УРАН ЗОХИОЛЫН" номоор үзэсгэлэн гаргасан. /50ш номоор 38хүн үзэж сонирхсон/
5. V/28. Хүүхдийн баярыг тохиолдуулан хүүхдийн номоор үзэсгэлэн гаргалаа. Нийт 32 номоор 36 хүн үзэж сорирхсон/
6. X/21.Хуучин номын үзэсгэлэн гаргалаа. /32ш номоор 18хүн үзсэн/
7. X/21. Далд ухамсрын номоор үзэсгэлэн гаргасан. /32ш номоор 23 хүн үзсэн/
8. XII/4. “Таны гал тогоонд” сэдэвт номын үзэсгэлэн гаргасан. /32ш номоор 26 хүн үзсэн
9. XII/4. Эрүүл мэнд сэдэвт номын үзэсгэлэн гаргасан./32ш номоор 21 хүн үзсэн

Сан хөмрөгөөс /16 удаа 708 ширхэг номоор 637 хүнд/

1. I/30. Монголчуудын эдийн соёл үзэсгэлэн-25 ш / хүний тоо-32/
2. II/26. Өмнөговь аймгийн зохиолчдын уран бүтээлээс. /45 ш ном/тоо-85/
3. III/06. Монголын эмэгтэйчүүд үзэсгэлэнг-99 сэтгүүлээр./хүний тоо-75/
4. III/13. Малчдад зориулсан мал аж ахуйн номын үзэсгэлэн /42 номоор хүний тоо 51 /
5. IV/15. Халх голын ялалтын 80 жилийн ойд үзэсгэлэнг. /35 номоор/
6. IV/30. Төрийн шагналт зохиолчид үзэсгэлэнг. /54 номоор 25 хүнд/
7. V/09. Бичиг соёл үзэсгэлэнг-42 номоор
8. V/09. Үнэт ховор номын үзэсгэлэнг-48 номоор
9. V/09. Хятад үлгэрүүд үзэсгэлэнг-41 номоор
10. V/09. Хятадын цоолбор зургууд үзэсгэлэнг-31 зургаар. /Бичиг үсгийн баярын үзэсгэлэн үзсэн хүний тоо 210/
11. V/29. Газар тариаланчдад тусламж. үзэсгэлэнг- 52 номоор.
12. VII/3. Эрийн гурван наадам үзэсгэлэнг-32 номоор./хүний тоо-31/
13. IX/14 Түвд монгол бар бичмэл номын үзэсгэлэн-46 номоор/хүний тоо-40/
14. IX/30.Говийн мэдээ 1957-1998 үзэсгэлэнг -40 сонингоор гаргалаа. /хүн тоо-30/
15. X/02. Амтат хоолны энгийн жорууд. Үзэсгэлэнг-46 номоор. /хүний тоо-32/
16. IX/22. Тусгаар тогтнол.үзэсгэлэнг-30 номоор. /хүний тоо-26/

Мэдээллийн төвөөс /1удаа 36 ширхэг номоор 163 хүнд/

1. IV/1. Инээдмийн баярыг тохиолдуулан “ХӨГЖИЛТЭЙ ИНЭЭД” сэдэвт хуучны хошин шог ярианы номоор үзэсгэлэн гаргасан. /163 хүн үзэж сонирхсон/

6. КАТАЛОГ, НОМЗҮЙ, ЛАВЛАГАА

- Электрон каталогт орсон хэдий ч номын нүүр зураггүй буюу талбаруудын алдаатай орсон 2009 оноос хойших 525 номын бүртгэлийг засаж баяжуулан нүүр зургийг оруулллаа.
- ZOTERO программд орон нутгийн “МОНГОЛ ГОВЬ” сонины 2018 оны сонин сонингийн мэдээг бүрэн гүйцэт оруулж 2019 тус онд ирсэн дугаарын нийтлэлийг тухай бүрд нь бүртгэж оруулллаа.

- Танхимуудад аман лавлагаа 158, цахимаар лавлагаа /электрон каталогийн хайлт 2611/ өгсөн ба 72 татгалзал бүртгэгдэж тэдгээрийг ном бүрдүүлэхэд тусгаж ажиллаа.
- 2019 онд шинээр ирсэн 453 ширхэг номыг техник ажиллагаа хийж электрон каталогт бүртгэв.

- ХААҮйлдвэржилтийн жилийн хүрээнд Говийн мэдээ сонины мал аж ахуйтай холбоотой тэргүүн туршлага, мэдээ, нийтлэлүүдийг эмхэтгэн гарын авлага бэлтгэв.
- Төр барьж байсан 37 хаадын нэрсээр он дараалын хэлхээс ном зүйн гарын авлага хийж уншигчдад хүргэв.
- Төрийн шагнал хүртсэн зохиолчдын намтраар гарын авлага бэлтгэн уншигчдад хүргэв.
- Номын сангаар үйлчлүүлэгч уншигч хэрэглэгчиддээ шинэ номын мэдээг цаг алдалгүй хүргэх үүднээсшинэ номын танилцуулгыг зурган болон ном хэлбэрээр 3 удаа гаргаж номын сангийн мэдээллийн самбар болон танхимуудад байршуулсан.
- Эцэг эхчүүд болон хүүхдүүдэд зориулсан “ Хүүхдээ хэрхэн номонд дуртай болгох вэ?” “Бид яагаад ном унших хэрэгтэй вэ?” гэсэн 2 төрлийн гарын авлага хийж нүүдлийн номын сангийн үйлчилгээгээр буюу урилгат үйлчилгээгээр ирж буй шинэ уншигчдад тарааж мэдээлэл хүргэж ажиллаа.
- Соёлын баримтат өвийн талаарх иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Соёлын баримтат өв” сурталчилгааны материалыг иргэдэд зориулан, тус номын сангийн ховор хуучин номуудаар зурагт каталогийг сумдын номын сангуудад зориулан тус тус бэлтгэн гаргав.

7. СУРГАЛТ, АРГА ЗҮЙ

Зохион байгуулсан арга зүйн ажлууд

- 14 сумын номын сандын ажил байдалтай суманд нь очиж танилцан зөвлөж туслаж ажиллаа. Номын сангийн үндсэн бүртгэлүүдийг хэрхэн үнэн зөв

хөтлөх, электрон программын ашиглалт, сан хөмрөгийн эмх цэгц, хадгалалт хамгаалалт зэрэгтэй танилцаж алдаа дутагдалтай байгаа зүйлсийг засаж залруулах зөвлөмж өглөө.

- Шинээр ажилд орсон Мандал-Овоо, Номгон сумдын номын санчдыг 3-5 өдрийн ажлын байрны сургалтанд хамрууллаа.
- 14 сумдаас электрон программын нөөц, нэгдсэн мэдээг хагас бүтэн жилээр авч хадгалан шаардлагатай үед нөөцийг сэргээхэд ашиглаж байна.
- Гурвантэс, Баяндалай, Гурвантэс сумдын номын сангийн электрон программыг дахин суулгаж нөөцийг сэргээлээ.
- Соёлын баримтат өвийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хүрээнд сумдын номын санчдад зориулсан "Соёлын баримтат өв" сургалтыг 11-р сарын 14-15-ны өдрүүдэд АЗДТГазрын дэмжлэгтэйгээр зохион байгууллаа.

  Орон нутагт уг хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, номын санчдын баримтат өвийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилготой уг сургалтаар баримтат өвийн бүртгэл мэдээллийн сангийн ажлын явц, өвийн хадгалалт хамгаалалт, орон нутагт байгаа баримтат өвүүдийг бүртгэн баримтжуулах ажилд номын санчдын оролцох оролцоо, номын сангийн бүртгэлүүдийг хөтлөх арга зүй, каталоги, картын сан зохион байгуулах, орон нутгийн ном зүйн талаарх мэдлэг ур чадваруудыг дээшлүүллээ.

Дотоодын сургалт

Ажилтан ажиллагсдын ур чадвар, ажлын бүтээмж, ёс зүй, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2019 оны дотоодын сургалтын төлөвлөгөөг боловсруулан баталж хүн бүрд сургалт зохион байгуулахыг даалган хэрэгжилтийг хангаан ажиллаа.

Сургалтууд:

1. I/17. Авилгын тухай хуулийн сургалт /ХЭЗХэлтэс мэргэжилтэн Ц.Цэвээн/
2. I/31. 5S ажлын байрны зохион байгуулалт /НТБТөвийн багш Г.Лувсандагва/
3. II/14. Номын сангийн тухай хууль / Фондчин Ч.Түвшинжаргал/
4. II/21. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм.

   Дарга А.Одончимэг

5. II/28. “Monbiblio программын” сургалт Дарга А.Одончимэг
6. III/14. EQ сэтгэл зүйн чадвар /НТБТөвийн багш Г.Лувсандагва/
7. III/28. Төрийн албаны тухай хууль / Номын санч Н.Даваажаргал/
8. IV/18. Хэрэглэгчийн зан төлөв / НТБТөвийн багш Г.Лувсандагва /
9. V/09. “Соёл танин мэдэхүйн ажил” ХУТ номын санч А.Оюунгэрэл
10. V/16. “Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө “ Дарга А.Одончимэг
11. V/16. “Харилцан суралцах арга зүй” Ч.Түвшинжаргал
12. V/30. Каталоги картын сан / Номын санч М.Сувданцэцэг/
13. VI/13 нд Ном зүйн бичилт / Сургалт хариуцсан Ш. Охин/

<u>Орон нутаг, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан сургалт, зөвлөгөөн семинарт хамрагдсан байдал</u>

- 3 сарын 25 нд зохион байгуулагдсан "Соёл урлаг-тогтвортой хөгжил" аймгийн соёл урлагийн ажилтны зөвлөгөөн, зөвлөгөөний салбарын сургалт хэлэлцүүлэгт хамт олноороо оролцлоо.
- IV/10-IV/12-ны өдрүүдэд. Улаанбаатар хотод УИХ-ын гишүүн Н.Амарзаяагийн урилгаар соёл урлагийн байгууллагуудын туршлага судлан, Соёлын аялал

жуулчлал, Соёл урлагийн байгууллагын стратеги төлөвлөлт зэрэг лекцэнд А.Одончимэг, Фондчин Ч.Түвшинжаргал нар хамрагдлаа. Үзэж танилцсан байгууллагуудын туршлага, сонссон лекцийн дагуу хамт олондоо мэдээлэл хийлээ.

- V/3. Даланзадгад сумын төрийн албан хаагчдын зөвлөгөөн сургалтад хамрагдсан. Байгууллагын дарга болон байгууллагын дотоод хяналтын нэгж ажилтан хамрагдаж зөвлөгөөний мэдээлэл болох төрийн албан хаагчийн ёс зүй, цаг үеийн мэдээллийг байгууллагын ажилтан албан хаагчдад мэдээллээ.
- V/14-V/15-ны өдрүүдэд Харилцан суралцах арга зүй нэгдсэн сургалтад байгууллагын дотоод хяналтын нэгж ажилтан суулаа. Сургалтын мэдээллүүдийг хамт олонд хүргэж ажиллаа.
- V/22-ны өдөр байгууллагын дарга, нягтлан бодогчийн хамт “Төсвийн удирдах ажилтны зөвлөгөөн”-д хамрагдлаа.
- 2019.IX/16-IX/20 хооронд Баян хотын Алшаа аймгийн “Номын сан, музей, чулууны музей, монгол сургууль, цэцэрлэг”-ийн үйл ажиллагаатай танилцан туршлага судлалаа.

- 2019.IX/27 Улаанбаатар хотын нийтийн номын санд зохион байгуулагдсан “mongolian library update 2019” зөвлөгөөн сургалтанд номын санч М.Сувданцэцэг, Каталогч Ш.Охин нар оролцлоо.
- XI/01 “ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТ БА ШУДАРГА ЁС” сэдэвт сургалтанд 5 ажилтан албан хаагчийг хамруулав.
- 10-р сарын 24-26ны өдрүүдэд Дундговь, Улаанбаатар хотын номын сангуудын үйл ажиллагаатай танилцах туршлага судлах ажлыг зохион байгуулав. Энэ хүрээнд МУҮНСангаас бэлтгэсэн “Соёлын баримтат өв“ сургалтанд мэргэжлийн ажиллагсадыг хамруулаа.

8. “СОЁЛЫГ ДЭМЖИХ ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД

- Соёлыг дэмжих жилийн нээлтийн арга хэмжээ ”Нар зөвийн эх орон” соёлын жагсаалд хамт олноороо оролцлоо.
- “Бид ном уншдаг аймаг” аяны удирдамж, шалгуурыг боловсрууллаа. Аяны

мэдээллийг олон нийтэд танилцуулж ажиллаж байна. Ялангуяа сошиалд идэвхтэй иргэд фэйсбүүк группуудэд зориулсан уулзалт номын хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж тэднээр дамжуулан нөлөөллийн ажлыг зохион байгуулж ажиллаа. Үүнд: “Өглөөний гайхамшиг-Өмнөговь”, “Говийн ээжүүдийн хөгжлийн клуб” фэйсбүүк группын гишүүдийн дунд номын хэлэлцүүлэг, ээжүүд гэр бүлээ ном уншихад хэрхэн нөөлөлөх талаар уулзалт хэлэлцүүлэг зохион байгууллаа.

- “Бид ном уншдаг аймаг” аяны хүрээнд байгууллагын үйл ажиллагаа, сан хөмрөгийн онцлог, соёлын талаарх ард иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх сурталчилгааны мэдээллийг сошиалаар олон нийтэд хүргэж ажиллаа.
- Ном уншихийг нийтэд уриалан, уншдаг иргэдийг урамшуулах ажлуудыг зохион байгуулж ажиллаа.

- Номын сангийн үйлчилгээ үйл ажиллагааны хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх иргэдэд номын сангийн үйлчилгээг ойртуулах зорилгоор Даланзадгад сумын багуудтай хамтын ажиллагааны гэрэ байгуулан зөөврийн номын сангийн үйлчилгээг иргэдэд хүргэж ажиллаа. Мөн нүүдлийн номын сангийн үйлчилгээг баг бүрт 2 удаа хүргэж ажиллаа.
- Бага насны хүүхдийн уншлагын тав тухтай орчин бүрдүүлэхэд анхаарч Баян-Уул ХХКомпаний дэмжлэгтэйгээр хүүхдийн уншлагын танхимын ширээ сандлыг шинэчиллээ.

9. ХӨДӨӨ АЖ АХУЙ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН ЖИЛИЙН ХҮРЭЭНД

- ХААҮйлдвэржилтийн жилийн хүрээнд зохион байгуулагдсан Малчдын зөвлөгөөнд оролцогч түншийн холбоот сум Цогт-Овоо сумын малчдыг хүлээн авах, байр, хоолны зардлыг байгууллагуудтайгаа хамтран шийдвэрлэлээ.
- ХААҮйлдвэржилтийн жилийн нээлтийн арга хэмжээнд байгууллага хамт олноороо оролцлоо.
- Тус номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байдаг Говийн мэдээ сонины мал аж ахуй, малын хариулгаа, маллагаатай холбоотой туршлага, сайн малчдын талаарх нийтлэлүүдийг эмхтгэн малчдад зориулсан гарын авлага

  материалыг бэлтгэн сумдад хүргэх ажлыг зохион байгууллаа.
- Малчид, газар тариалан эрхлэгчдэд гарын авлага болох номуудаар 2 удаа үзэсгэлэн гаргаж олон нийтэд танилцуулж ажиллаа.
  - III/13. Малчдад зориулсан мал аж ахуйн номын үзэсгэлэн /42 номоор хүний тоо 51 /
  - V/29. Газар тариаланчдад тусламж. үзэсгэлэнг- 52 номоор.

- Түнш Цогт-Овоо сумын ахмадуудыг Өмнөговь аймагт хүлээн авах ажилд хоолны зардалд 50,0 төгрөгийн дэмжлэг үзүүллээ.
- Өмнөговь аймгийн Төв номын сан нь түншийн харилцаатай Цогт-Овоо сумын малчдад өвөлжилтийн бэлтгэл хангахад дэмжлэг үзүүлж 10 боодол өвс Цогт-Овоо сумын Засаг дарга Э.Чойжилсүрэнтэй холбогдон холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өглөө.

10. ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛИЙН ХҮРЭЭНД

- Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллаа.

- Төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган шилэн дансны мэдээллийг тухай бүрд мэдээлж, байгууллагын батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг иргэдэд ил тодоор байршуулж, иргэдтэй холбоотой танхимуудын үйлчилгээний журмыг танхим бүр иргэдэд мэдээлж танилцуулж ажиллав.
- II/21. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг хамт олонд танилцуулж мэдээлэл хийн, байгууллагын ил тодын самбарт байршуулан дагаж мөрдөж ажиллаж байна.

- Ахмад, жирэмсэн, тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчдийг гэрээр ном олгох үйлчилгээг 2 давхарт гаралгүйгээр 1-р давхрын Мэдээллийн төвөөс уг үйлчилгээг авах боломжийг бүрдүүллээ.
- Албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажлын байрны шинжилгээг хийж ажилчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.
- Номын сангийн автоматжуулалтын Lib4you программыг ашиглаж үйлчилгээ үйл ажиллагаагаа түргэн шуурхай үзүүлж ажиллаж байгаа бөгөөд электрон каталогийн онлайн хандалтанд 2611 хүн хандан хайлт хийж номын санд ирэлгүйгээр ном хэвлэлийн мэдээллийг авсан байна. Түүнчлэн электрон каталогийг олон нийтэд сурталчилах ажлыг сошиалд идэвхтэй хийж ажиллаа.

- Байгууллагын үйл ажиллагаа үйлчилгээний талаар иргэд,үйлчлүүлэгчдээс судалгаа авч үйл ажиллагаандаа тусгаж ажиллаа. Судалгаанд нийт 71 хүн хамрагдсанаас:
    - Эрэгтэй 24, эмэгтэй 47
    - Дээд боловсролтой хүн 30
    - Тусгай дунд боловсролтой хүн 27
    - Хүүхэд 14

Судалгаанаас харахад:

- o Төрөл бүрийн шинжлэх ухааны номоор фонд, сан хөмрөгөө баяжуулах.
- o Орон нутгийн уншигч иргэдэд цахим номын сангийн үйлчилгээг сурталчлах, танин мэдүүлэх.
- o Сүүлийн үеийн стандарт шаардлага хангасан тав тухтай шинэлэг номын сантай болох саналыг түлхүү ирүүлсэн байна.

- Ном хэвлэлийг худалдан авахад иргэд, үйлчлүүлэгчийн саналыг тусгах зорилгоор танхим бүрт шаардлагатай номыг бүртгэх Татгалзлын дэвтрийг хөтлөн уншигчдын хүсэлтийн дагуу 272 нэр төрлийн 453 ширхэг ном хэвлэлийг худалдан авч уншлага үйлчилгээнд гарган ажиллаж байна.
- Даланзадгад сумын иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй нэг дороос хүргэх ХӨДӨЛГӨӨНТ БАГ үйлчилгээгээр Төв номын сангийн хамт олон XI/2-XI/3-ны өдрүүдэд Даланзадгад сумын 8 багт ажиллаа.

Хөдөлгөөнт багаар 511 иргэнд лавлагаа, мэдээллийн үйлчилгээг үзүүлсэнээс: 150 ширхэг ном олгож, 458 хүнд зөвлөгөө зөвлөмж өгч, 341 ширхэг гарын авлагыг тарааж үйлчиллээ. Мөн 115 хүнээс номын сангийн үйл ажиллагааны талаар судалгаа авч ажиллаа.

11. БУСАД АЖИЛ:

- 245 хүнд интернэт, компьютерийн үйлчилгээ үзүүлсэн байна.
- III/28. Уншигч үйлчлүүлэгчиддээ тав тухтай, эрүүл орчинд уншлага үйлчилгээ явуулах, өрөө танхимдаа өнгө нэмэх үүднээс уншлагын танхимуудын сандлуудын бүрээсийг сольж шинэчлэв.
- IV/20-оос БТСГазраас зохион байгуулж байгаа "**ЭРҮҮЛ МЭНД-ТАНЫ ГАРТ”** аянд Номын сангийн ажилтан албан хаагч нар биеийн хөдөлгөөн, хөгжлийг дээшлүүлэх, ажилчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, хамт олны уур амьсгалыг нэгтгэх, ажлын ачааллыг хөдөлгөөнөөр хөнгөлөх, эрүүл чийрэг, стрессгүй орчинд ажил үүргээ гүйцэтгэх зорилготойгоор байгууллага хамт олноороо идэвхтэй оролцсон

  - Ажлын байран дахь дасгал хөдөлгөөн
  - Өглөөний дасгал хөдөлгөөнд оролцож эрүүл зөв амьдралын дадалд нэгдэв.

- V/4. “Хайлаасны баяр” бүх нийтээр мод тарих өдөр хамт олноороо хуваарьт талбай болох Даланзадгад сумын ЗДТГ-ын зүүн хойд зам дагуу 10ш модны нүхийг ухаж бэлтгэн 10ширхэг хайлаасны суулгац авж тарилаа.
- Даланзадгад сумын ИТХ-аас 4-р сарын 1-ний өдрөөс 4-р сарын 21-нийг хүртэл зарлагдсан “Хүмүүнлэг үйлсэд иргэн таны оролцоо” хүмүүнлэгийн аянд нэгдэн 5-р сургуулийн Тусгай хэрэгцээт боловсролын ангийн хүүхдүүдэд хичээлийн хэрэглэгдэхүүн, баримлын шавар, энгийн цаас, пламастер зэрэг зүйлс, хүүхэд бүрийн тоогоор бичиж зурдаг ном тус тус бэлэглэлээ.

  - Улаан загалмайн гишүүний татвараа ажиллагсад төлж гишүүнчлэлээ сэргээлээ.

- Дундговь аймгийн Төв номын сангийн хамт олон манай номын сангаар ирж туршлага судлалаа.

- Халх голын ялалтын түүхт 80 жилийн ойн нэрэмжит “Тусгаар тогтнол, түүхэн уламжлал, хөгжил дэвшил” бүтээлч аяны туг, дэвтрийг 04-р сарын 3-ны өдөр хүлээн авч БСУГазар, Насан туршийн боловсролын төвтэй хамтран 4-р сарын 4-ний өдрөөс 4-р сарын 11 хооронд Халх голын дайны түүх, баатруудын түүхэн гавьяаг эргэн дурсах иргэдийн эх оронч үзлийг бадраах зорилго бүхий “Ерэн баатрын дууль”- уран уншлагын уралдааныг Даланзадгад сумын бүх насныхны дунд зарлан зохион байгууллаа. Мөн “Халх голын ялалтын түүхт 80 жилийн ойд” сэдэвт халх голын ялалтын түүх, халх голын баатруудын тухай 30 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж танхимаар болон онлайнаар олон нийтэд танилцууллаа.

- Даланзадгад сумаас сар бүрийн сүүлийн 7 хоногийн 5 дахь өдрийг нийтийн их цэвэрлэгээ хийхээр зарласантай холбогдуулан байгууллагын их цэвэрлэгээг гадна орчны цэвэрлэгээтэй хамт хийж хэвшүүллээ.

- Булган аймгийн номын санчид, Буриадын номын санчидтай хамтран орон нутгийн номын сангийн үйл ажиллагаатай танилцан туршлага солилцох,

сургалт, уулзалт арга хэмжээг зохион байгуулах хүсэлт ирүүлсэний дагуу харилцан туршлага солилцох уулзалт, сургалт арга хэмжээг 2019.07.24-нд амжилттай зохион байгууллаа.

12. ДҮГНЭЛТ

2019 оныг аймаг салбарын хувьд “Соёлыг дэмжих жил” болгон зарласантай холбоотой “Бид ном уншдаг аймаг” аяныг зарласнаар сум, баг, байгууллагууд ном уншлагыг өрнүүлж, номын сантай болох, номын сангаа тохижуулах, байгууллагын номын сангаа баяжуулах зэрэг ажлууд хийгдэж иргэдийн ном унших байдал дээшилсэн.

2019 оны 1-2-р саруудад томуугийн дэгдэлтээс үүдэлтэй нийтийг хамарсан арга хэмжээг хориглосонтой холбоотой уншигчдын тоо 1-2-р саруудад харьцангуй буурсан байдалтай байлаа.

Энэ онд орон нутгаас тус номын санд нийт 9,949,000 төгрөгийн дэмжлэг үзүүлжээ. / Бичиг үсгийн баяр 588,000төгрөг, сан хөмрөг баяжилт 3,5сая төгрөгөөр 94 нэр төрлийн 162 номоор сан хөмрөг баяжуулав. Номын баярт 1201,000 төгрөг, сургалт арга хэмжээ 3,860,000 төгрөг, тоног төхөөрөмж 800,000/ Сан хөмрөг баяжуулахад орон нутаг дэмжлэг үзүүлж ирснээс сүүлийн үеийн өндөр үнэтэй лавлагааны чухал номуудыг цаг алдалгүй авч сан хөмрөгөө баяжуулж ажилласан нь уншигчдад татгалзсан хариу өгөлгүй ямар нэгэн байдлаар лавлагааг гүйцэлдүүлэх боломжтой болсон давуу талууд бий болжээ. Үйл ажиллагаагаа сошиалд байнга мэдээлж ажилласнаар номын сангийн үйлчилгээ үйл ажиллагааны мэдээг байнга авч мэдээлэлтэй байдаг, номын сангийн үйл ажиллагааг дэмжих, сан хөмрөгт ном хандивлах хүсэлтэй иргэд, зохиолчдын тоо нэмэгдсэн.

Номын сангийн хамгийн гол ажил болсон каталоги картын сан, ном зүйг хөгжүүлэх тал дээр анхаарч сургалт, зөвлөгөө авч ажилласнаар энэ жил илүү ахиц гарч уншигчид цахим болон цаасан каталоги ашиглах боломжтой болсон ба лавлагаа болох ном зүйг гаргаж уншигчдад хүргэж ажилласан.

Төсвийн нөөц бололцоо, орон нутаг, иргэдийн дэмжлэгээр байгууллага танхимуудын тохижилт хийгдэж буй хэдий ч номын сангийн зай талбай танхимуудын тоо шинэ үеийн иргэдийн хүсэж хүлээж буй хүлээлтэнд хүрэлцэхгүй байна. Соёл танин мэдэхүйн ажлуудыг зохион байгуулах томоохон зай талбай бүхий танхим, өвөрмөц тохижилт бүхий номын сантай болохыг уншигчдын зүгээс илэрхийлдэг. Иймд 2020 оны аймгийн Нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд шинэ номын сангийн зураг төсвийн зардлыг суулгаж өгөх хүсэлтийг хүргүүлсэн.

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

ХОЁР. ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ БА ТОВЧ АГУУЛГА

2.1. Номын сангийн алсын хараа, зорилго, зорилт

Алсын хараа:
Төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг аймаг орон нутгийн төвшинд хэрэгжүүлэхэд номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн уншигчдад бие даан суралцах, өндөр боловсрол эзэмших, номын санг иргэдийн мэдээллийн төв болгон хөгжүүлэхэд оршино.
Зорилго:
Мэдлэг дээдэлсэн мээдээллийн эрин зуунд номын сангийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг өсөн нэмэгдүүлж, иргэдэд цаг хугацаа, орон зай хамааралгүйгээр хэрэгцээт мэдээллийг номын сангийн үйл ажиллаганы дагуу, мэргэжлийн түвшинд хүргэдэг нээлттэй мэдээллийн төв байхад оршино.
Зорилт:
Илүү нээлттэй, чөлөөтэй, орчин үеийн үйлчилгээг ашиглан мэдээллийн чөлөөт урсгалыг өргөжүүлэн хүн бүрт мэдээлэл хүргэх замаар нийгэмд идэвхитэй, мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
Номын баяжилтыг нэмэгдүүлэх, үндсэн данс бүртгэл, сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах
Нийгмийн зорилтот бүлгүүдэд хүрч үйлчлэх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд ялгаваргүйгээр тэгш оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх

2.2. Номын сангийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодит байдлын үнэлгээ, тулгарч буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга зам

Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, уншлага үйлчилгээний чанарыг сайжруулах, хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэх, сан хөмрөгийн бүрэн бүтэн байдлыг хангах, тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй номын санг харьяалалыг нь үл харгалзан мэргэжил арга зүйн удирдлага, мэдээллээр хангах нээлттэй төв болж ажилладаг.

2.3. Үйлчилгээний хүрээ, зохион байгуулалт, чанар хүртээмжийн талаар (номын сангийн сан хөмрөг, үйлчилгээ, каталог зохион байгуулалт, лавлагаа номзүйн үйлчилгээ, номын сангийн автоматжуулалт, аргазүйн үйл ажиллагаа, хүний нөөцийг чадавхижуулах, захиргаа удирдлага зохион байгуулалтын ажил, бусад, дүгнэлт)

Уншигчдаас эрэлт хэрэгцээт номын захиалга авч, 2019 онд төсвөөр 2424936 төгрөгний 123 төрлийн 217 ширхэг ном, хандиваар 675500 төгрөгний 56 нэр

төрлийн 70 ширхэг нийт 3100436 төгрөгний 179 нэр төрлийн 287 ш номоор фондоо баяжуулж, 104406474 төгрөгний 47097 номын фондтой болоод байна.
Уншлага үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад анхаарч 2019 үйлчилгээндээ “Үүлэн технологи” нэвтрүүлэн ажиллаж, Номын сангийн Lib4U программ хангамж мэдээллийн бааз онлайн орчинд ажиллаж, үйлчилгээг цахим хэлбэрээр явуулж хэвшсэн ба танхимаар:

- Байнгын уншигч -1798
- Ирэгсэд - 7422
- Ном олголт – 13551

Соёл олон нийтийн ажлаар:
5000 гаруй хүнийг хамруулж, 7000 гаруй ном олгож,

Нийт 13000 гаруй хүнд 20000 гаруй ном, хэвлэл олгож үйлчилсэн байна.

Уншигч нарт зориулсан интернэтийн үйлчилгээг үнэ төлбөргүй ашиглуулж, 500 гаруй хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж, байгууллагын цахим хуудас https://aimaglibrary.wordpress.com блогийн агуулгыг шинэлэг байлгахад анхаарч нийт 3,848 зочилсон байна.

Онлайн каталог: https://lib4u.net/?lib=sukhbaatar ийг Google тусламжтайгаар каталогт мэдээлэл хайж **105.172** хуудасны мэдээллийг үзжээ. Нийт электрон каталогийн хэрэглэгчдийн 72.86% нь шинээр орж байгаа хэрэглэгчид, үлдсэн 27.1% нь хуучин хэрэглэгчид тайлангийн хугацаанд холбогдсон байна.

Зохион байгуулж байгаа ажил үйлчилгээгээ олон нийтийн сүлжээгээр сурталчлах, уншигчийн тоог нэмэгдүүлэх зорилгоор :

Холбоо барих утас: 70518215
Facebook: Сүхбаатар аймгийн Нийтийн номын сан
Page: МУСГЗ Г. Мэнд-Ооёогийн нэрэмжит Сүхбаатар аймгийн Нийтийн номын сан
https://aimaglibrary.wordpress.com блогоор цаг алдалгүй сурталчилж ажилладаг.

2.4. Номын сангийн шинэлэг үйл ажиллагаа, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, ололт амжилтыг бодит тоо судалгаа

Аймаг орон нутгаас төрсөн нэрт яруу найрагч зохиолчдын бүтээл, тэдний хүсэл зорилгын биелэлийг хэрэгжүүлж хойч үедээ танилцуулан уламжлуулах, зохиолч, яруу найрагчдаараа дамжуулан хүмүүний сэтгэлийг ариусгаж дотоод ертөнцийн харанхуйд гэрэл гэгээ тусгаж, гэгээрэлд

хүрэх, тэдний сэтгэл оюуныг ариусгаж ойртуулан найрсуулж, итгэлцэл бий болгож аз жаргалын сайхныг эдлүүлэх,“Дорнод монголын уламжлалт ёс, зан заншлын онцлогийг агуулсан, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн уран бүтээл туурвих” зорилгоор Сүхбаатар аймгийн Нийтийн номын сангаас “ӨВӨГ ДЭЭДСЭЭС АВСНАА, ҮР ХОЙЧДОО УЛАМЖЛЪЯ” төслийг БСШУСЯ-ны 7000.0 төгрөгний хөрөнгө оруулалтаар 2 дахь жилдээ хэрэгжүүлж, 5000 гаруй иргэд хамрагдсан.

Уг төсөл нь алслагдсан нутаг дэвсгэрийн иргэдэд номын сангийн үйлчилгээг тасралтгүй хүргэх, ард иргэдэд номын сангийн үйлчилгээг ойртуулж, номын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх, Сүхбаатар нутгаас төрөн гарсан нэрт яруу найрагч, зохиолчдын бүтээл, тэдний хүсэл зорилгын биелэлийг хэрэгжүүлж, хойч үедээ таниулан уламжлуулах, зохиолч яруу найрагчдаараа бахархах үзлийг төлөвшүүлэхийн зэрэгцээ номын санч нар харилцан туршлага солилцож, тус бүрийнхээ үйл ажиллагааг өөрийн биеэр үзэж танилцсанаар номын сангуудын үйл ажиллагаа харилцан уялдаа холбоо сайжирч тэдний мэргэжил, ур чадвар дээшлэн, соёлын “БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ “ бий болгоход чиглэгдсэн.

Номын санчид өөрсдийн авъяас чадварыг нээн хөгжүүлэхээс гадна нутгийн зохиолчдын бүтээлийг сурталчлан, аймгийн бүх сумдаар аялан тоглолт хийж, тоглолтоос орсон орлогыг тухайн сумын соёлын төвийн номын санд 100 хувь шинэ номын баяжилт хийсэн.

№	Сумдын нэрс	Хамрагдсан хүний тоо	Орсон орлого
1.	Асгат	280	500.0
2.	Баяндэлгэр	420	700.0
3.	Дарьганга	550	1225.0
4.	Мөнххаан	420	840.0
5.	Наран	220	317.0
6.	Онгон	330	600.0
7.	Сүхбаатар	560	1000.0

8.	Түвшинширээ	520	750.0
9.	Түмэнцогт	420	500.0
10.	Уулбаян	560	1270.0
11.	Халзан	230	400.0
12.	Эрдэнэцагаан	520	1000.0
	Нийт дүн	**5030**	**9102.0**

Энэ төсөл хэрэгжсэнээр тухайн орон нутгийн зохиолч, яруу найрагчдыг таниулан мэдүүлэх, зохиол бүтээлийг нь сурталчлах, тэднийг алдаршуулах, номын сан, номын санчид болон уншигчид шинэ номоор баяжигдан, алслагдсан нутаг дэвсгэрт амьдарч байгаа иргэдэд шинэ ном хэвлэлийг хүргэж, сум, сургуулийн номын санчид бие биенээсээ суралцаж, харилцан туршлага солилцож, мэргэжил арга зүйн зөвлөгөө авснаар ажлын бүтээмж сайжирч, үр дүн үзүүлж, олны талархал хүлээсэн.

2.5. Номын сангийн үйл ажиллагааны статистик тоон үзүүлэлтүүд

2018 он:



2019 он:



ГУРАВ. НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

3.1. Номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт, бүтэц зохион байгуулалт, боловсруулалт, байрлуулалт, эргэлтийн байдал

Фондын сан хөмрөгийг ном болон тогтмол хэвлэл, хэвлэмэл бус бүтээгдэхүүнээр бүрдүүлж, оюуны бүтээлийн болон үндэсний хэмжээний ном хэвлэлийн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор номын зохиогчоос, нутгийн зохиолчдын уран бүтээл, уншигчдын эрэлт хэрэгцээт ном, хүүхдэд зориулсан уран бүтээл зэргийг худалдан авч, фондоо баяжуулдаг.

3.2. Номын сангийн сан хөмрөгт үнэлэлт, дүгнэлт хийж судалгаа хийсэн байдал

Номын сангийн сан хөмрөгт ном хэвлэлийн тооллогыг тогтоосон хугацаанд номын сангийн сан хөмрөгийн бүртгэл, тооллого хийх журмын дагуу хийж ирсэн.

20 дугаар зүйл.Номын сангийн сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт

Сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтанд анхаарч, “Галын аюулгүй байдлыг хангаж ажиллах 2019 оны төлөвлөгөөг боловсруулан баталж, галын бүлгэмийг байгууллагын захирлын 2019 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн А/05 тоот тушаалаар, “Галын аюулгүй байдал”-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.10 дахь заалт “Галын аюулгүй байдал”-ын дүрмийг боловсруулан баталж, 2019 оны Гал унтраах шуурхай төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж баталсан.
Гамшгийн үед хүний амь бие, эд хөрөнгийг аврах гарцын бэлэн байдлыг хангаж ажиллах зорилгоор аврах гарцын схем зургийг тодорхой болгож, дахин шинэчлэн

хийж, Онцгой байдлын газраар хянуулан баталгаажуулж, анхааруулах тэмдэг тэмдэглэгээг байгууллагын онцлогт тохируулан хийж, байрлуулсан.

3.3. Номын сангийн тооллого, хадгалалт хамгаалалтын талаар хийж хэрэгжүүлсэн ажлын талаар

2018 оны жилийн эцсийн номын тооллогоор дутагдсан номын өр барагдуулалтыг дуусгах тал дээр анхааран ажиллаж, хүүхдийн номын санч Р. Цолмонтуяа 74 ш ном буюу 334.4 төгрөгний ном, фондын номын санчьВ. Энхтуяа нь 23 ш буюу 263.3 төгрөгний ном дутаасныг 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор төлж барагдуулах хугацаат үүрэг өгч ажилласны дагуу төлбөрийг мөнгөн дүнгээр бүрэн хийж барагдуулсан.

ДӨРӨВ. НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1. Уншигчдад номын сангаас үзүүлж буй үйлчилгээ болон номын сангийн үйлчилгээний инноваци, нэн шаардлагатай үйлчилгээ

Уншигчдад үйлчилгээг:
Гэрээр ном олгох танхим
Нийтийн уншлагын танхим
Хүүхдийн уншлагын танхим
Цахим мэдээллийн танхим гэсэн 4 танхимаар явуулж, Lib4U програм хангамжийг 2010 оноос эхлэн үйлчилгээндээ ашиглаж, 2018 онд ҮҮЛЭН ТЕХНОЛОГИ-ийг нэвтрүүлэн илүү хүртээмжтэй чанартай үйлчилгээг орон нутгийн иргэддээ шуурхай хүргэж ажиллаж байна.

4.2. Номын сангуудад шаардлагатай төсөл-хөтөлбөр

Хараагүй Хүмүүсийн Инноваци Хөгжлийн Төв ТББ, Канад сангаас санхүүжүүлэн ХХИХТөвөөс хэрэгжүүлж буй **"Хараавы бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл харилцааны шинэ**

технологиор дамжуулан чадваржуулах нь" төсөл хэрэгжиж, иж бүрэн компьютер 2, скайнэр 1, дэйзи цахим ном тоглуулачгч 3, брайль орбит төхөөрөмж 2 зэрэг нийт 46 сая төгрөгний техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр ханган, уг төслийн сургалт 2019 оны 10 сарын 7-11-нийг дуустал 5 хоног явагдаж, Иноваци хөгжлийн төвийн төслийн зохицуулагч М. Цэнгэл, төслийн сургагч багш Л.Энхтуул, сургагч багш Э. Ууганбаяр, сургагч Б. Ангараг-Эрдэнэ нар хүрэлцэн ирж, номын санчдын "Орбит брайль төхөөрөмжийн сургалт, харааны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэлгэц уншигч программын сургалт, Харааны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэр бүлийн гишүүдэд зориулсан сургалтыг тус тус зохион байгуулж, нийт 120 гаруй хөгжлийн боэхшээлтэй иргэд хамрагдаж, Иноваци хөгжлийн төвийн төслийн зохицуулагч   М. Цэнгэл, Аймгийн Нийтийн номын сангийн захирал Х. Мөнгөн-Өлзий нар цаашид хамтран ажиллах хамтын гэрээ байгуулсан.



4.3. СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

Иргэдэд шинэ ирсэн номын мэдээллийг тогтмол хүргэж, байгууллагын үйл ажиллагаа болон соёл олон түмний ажлыг тухай бүр мэдээллээр ханган сурталчилж ирсэн.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг тэмдэглэлт өдрүүдэд зориулж тогтмол гаргаж ирсэн ба:

- Д. Сүхбаатарын мэндэлсний 126 жилийн ойд -18 ном
- "Монгол ёс заншил, уламжлал"—16 ном
- Яруу найрагч,О.Дашбалбар агсны мэндэлсний 62 жилийн ойд-20 ном
- “Гэгээн хайрын өдөрт -20 ном
- “Олон улсын эмэгтэйчүүдийн өдөрт”- 30 ном
- “Танин мэдэхүйн” -76 ном
- “Театр ба соёл урлаг”-50 ном
- “МЗЭ-ийн 90 жилийн ойд “Монголын зохиолчдын бүтээл сурталчлах аян”-д 1-9 сард төрсөн зохиолчид– 250 ном
- “ЕБС-ийн сурагчдын элсэлтэнд -35 ном

“Дэлхий номын өдөр”- ийн арга хэмжээнд:

- “Монголын нууц товчоо” үзэсгэлэн- 50
- “Дэлхийн шилдэг зохиолууд”-30 ном
- “Нутгийн зохиолчдын шинэ номын үзэсгэлэн худалдаа”-30

- “Дарьганга өв соёл” номын үзэсгэлэн-50 ном
- “Байгаль хамгаалах өдөр”- т 28 ш
- “Уншлагыг дэмжих жил-2019” заавал унших ном-50
- Сурагчдын хичээлийн шинэ жилийг тохиолдуулан сурагчдын гарын авлага-36
- Сүхбаатар аймгийн түүх, соёл-21 нийт 810 номоор тус тус үзэсгэлэн гаргаж сурталчллахад 6000 гаруй хүн хамрагдсан.

ҮЛЭМЖИЙН ОРЧЛОНД ТЭНГЭР ШИГ БАЙ” АРГА ХЭМЖЭЭ

Төр нийгмийн зүтгэлтэн, Төрийн соёрхолт, нэрт яруу найрагч, Цогт эх оронч, Очирбатын Дашбалбар агсны мэндэлсний 62 насны ойд зориулж “ **Үлэмжийн орчлонд тэнгэр шиг бай**” арга хэмжээг 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөд зохион байгуулсан. Арга хэмжээг угтаж:

"УРАН БИЧЛЭГ
“ГАР ЗУРАГ”
“ЭССЭ БИЧЛЭГ"- ийн уралдаан зарлаж дүнгээ гарган, уг арга хэмжээн дээр гардууллаа. Мөн энэ үеэр
"**ШИНЭ НОМЫН ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА,**
СЭДЭВЧИЛСЭН НОМЫН ҮЗЭСГЭЛЭН гарган зохион байгуулахад 130 гаруй хүн оролцож, давхардсан тоогоор 300 гаруй хүн хамрагдсан.



"**ЭСЭЭ"- “Эссэ бичлэг**”-ийн төрөлд: 60

гаруй бүтээл ирснээс

Тэргүүн байр: Мөнххаан сумын ЕБС-ийн 11а ангийн сурагч Т. Золзаяа
Дэд байр: 3-р бүрэн дунд сургуулийн 11а ангийн сурагч Б. Дэлгэрмөрөн
Гутгаар байр: 1-р сургуулийн 11г ангийн сурагч Т. Нандинцэцэг
Тусгай байр: 4-р сургуулийн 10в ангийн сурагч О. Болорцэцэг
"ГАР ЗУРАГ"-Насанд хүрэгсэд, ЕБС-ийн сурагчид оролцсоноос :

Гар зургийн төрөлд: 10 гаруй бүтээл ирснээс **ЕБС-ийн ангиалалд:**
Тэргүүн байр: 2-р сургуулийн 10в ангийн сурагч Д. Батзориг
Дэд байр: 2-р сургуулийн 7д ангийн сурагч Н. Бэлгүүтэй
Гутгаар байр: 1-р сургуулийн 11д ангийн сурагч Х. Жавхлан

Тусгай байр: 2-р сургуулийн сурагч Жавхлан
1-р сургуулийн сурагч Б. Мөнхбаяр
Насанд хүрэгсдийн төрөлд:
Тэргүүн байр: Зураач Ё. Бадарч
Дэд байр: “SB” телевизийн найруулагч Ц. Энхбаатар

"УРАН БИЧЛЭГ"- Насанд хүрэгчид, ЕБС-ийн сурагчид
“Уран бичлэг”- ийн төрөлд: 30 гаруй бүтээл ирсэнээс
Насанд хүрэгсдийн төрөлд
Тэргүүн байр: “SB” телевизийн найруулагч Ц. Энхбаатар
Дэд байр: 3-р сургуулийн монгол хэл, уран зохиолын багш С. Дорждуламрагчаа
Гутгаар байр: Эрдэнэцагаан сумын ЕБС-ийн багш М. Мөнхнаран
Тусгай байр: 1-р сургуулийн монгол хэл, уран зохиолын багш Амаргариг
Түмэнцогт сумын ЕБС-ийн багш Э. Уранцэцэг
ЕБС-ийн ангилалд:“ Уран бичлэг” –ийн төрөлд
Тэргүүн байр: ЕБ-н 2-р сургуулийн 11б ангийн Э. Даваажав
Дэд байр: ЕБ-ийн 3-р сургуулийн 11а ангийн сурагч Э. Болортунгалаг
“**Сайхан бичигтэн”** төрөлд
Тэргүүн байр: 1-р сургуулийн 12а ангийн сурагч А. Мөнхтөр

Дэд байр: 1-р сургуулийн 11г ангийн сурагч Ө. Сайнцэцэг нар тус тус шалгарсан байна.
"**УРАН УНШЛАГА"-**Насанд хүрэгсэд, ЕБС-ийн сурагчид
Насанд хүрэгсдийн ангилалд
Тэргүүн байр: Баруун-Урт Г. Есөн-Эрдэнэ
Дэд байр: Мөнххаан. Б. Анхбаяр
Гутгаар байр: Эрдэнэцагаан. Б. Сод-Эрдэнэ
Сургуулийн нас:
Тэргүүн байр: Э. Сумьъяа: Баруун-Урт сумын 1-р сургуулийн 12а ангийн сурагч
Дэд байр: Б. Оргилмаа: Түмэнцогт сумын ЕБС. 11 анги
Гутгаар байр: Янжинлхам: Баяндэлгэр сумын ЕБС. 11б анги
Тусгай байр: Д. Дэлгэрдалай: Баяндэлгэр сумын ЕБС. 7а анги
М. Огмижав- Уулбаян сумын ЕБС. 9б анги
Н. Цээсүрэн: Онгон сумын ЕБС. 10б анги

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр болон монгол эр цэргийн баярын өдрөөр "Ээжтэйгээ хамт "3х8 "номын уналт", “Аавтайгаа хамт 3х18,

цэнгээнт танин мэдэхүйн уралдааныг Ерөнхий боловсролын 4-р сургуулийн Э. Ганцэцэг багштай 10в ангийнхан, Угсаатны зүйн музейн хамт олны дунд зохион явуулахад нийт   40 гаруй хүн хамрагдсан.



МСҮТ-ийн дотуур байртай хамтран Монголын
уламжлалт соёлын биет болон биет бус өв соёл, ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулсан "Монгол наадгай өв соёл, зан заншил" тэмцээн, монгол бичгийн "Монгол бичиг эх соёл" уралдааны арга хэмжээг хамтран зохион байгуулж ажилласан ба 40 гаруй хүүхэд хамрагдсан.

Сүхбаатар аймагт эмэгтэйчүүдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ, клуб, худалдаа үйлчилгээний байгууллагуудыг хамруулсан “SB womens expo” арга хэмжээнд эмэгтэйчүүдийн холбогдолтой номоор үзэсгэлэн гарган оролцож, номын санч В. Энхтуяа “ Миний аз жаргал” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан “Тэргүүн байр эзэлсэн.

Төрийн албан хаагч нар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хэрхэнх харилцдаг, тэдний хоорондын хамтын ажиллагаа , хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмд оролцох боломж болон иргэний хязгаарлагдмал чадавхиийг ойлгож хүндэтгэх, онцлог хэрэгцээнд нь тулгуурласан үйлчилгээг сайжруулах замаар тэднийг дэмжин хөгжүүлэх, нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх зэрэг өөрөөр нь бахархах хандлага төлөвшүүлэх зорилгоор аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран төрийн албан хаагч нарын дунд “**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН ГЭЖ МИНИЙ БОДЛООР**” эсээ бичлэгийн уралдаан зарлахад 380 хүн хамрагдаж,

Тэргүүн байр: Түмэнцогт сумын ЕБС-ийн монгол хэлний багш Э. Уранцэцэг
Дэд байр: аймгийн ИХТ-ын ажлын албаны ажилтан Ж. Жаргалсайхан
Гутгаар байр: Насан туршийн боловсрол төвийн сургалтын менежер П. Уянга нар эзэлсэн.

"ЗҮҮДНИЙ ЕРТӨНЦӨӨР" ШӨНИЙН УНШЛАГА: Хүүхэд залуусын оюуны санд хөрөнгө оруулалт хийх, тэдний чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, хамтдаа хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор **"Зүүдний ертөнцөөр"** шөнийн уншлагыг зохион байгуулж, МСҮТ-ийн дотуур байрны 40 хүүхэд, 2-р сургуулийн 11б ангийн 16 сурагч, 1-р сургуулийн Ц. Уянга багштай 10г ангийн 22 сурагч нийт 78 сурагч хамрагдаж, "Номын уналт" танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээн, чөлөөт уншлага, үлгэрийн цаг, номын сантай танилцах арга хэмжээ, “Шалгалдаа бэлтгэцгээе” “Ном бол ертөнцийг харах цонх” номын үзэсгэлэнг 100 гаруй номоор гаргаж, уншсан номын талаар ярилцаж, үнэгүй карт нээлгэх гэх мэт олон ажлыг амжилттай зохион байгуулсан.

Жил бүрийн 03 дугаар сарын 27-ны өдрийг дэлхийн “Театрын өдөр” болгон тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай бөгөөд дэлхийн театрын энэ өдөрт зориулж, ХЖТ-тэй хамтран " Театр ба соёл урлаг, уулзалт, ЕБС-ын сурагчдын дунд " АХА" тэмцээн зохион байгуулж явуулахад 70 гаруй хүүхэд, багачууд хамрагдсан бөгөөд Мөн Нийтийн уншлагын танхимаас Театр ба соёл урлаг сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 50 гаруй номоор гарган сурталчилсан.

“Дэлхийн номын өдөр-ийг тохиолдуулан номын олон талт арга хэмжээг зохион байгуулахад 100 гаруй хүн хамрагдаж, “Миний мэдэх яруу найрагч” хөрөг, гар зургийн уралдаан, эсээ бичлэгийн уралдааныг угтаж явуулсан бөгөөд Эсээ бичлэгт 60 гаруй хүн, Хөрөг гар зургийн уралдаанд 30 гаруй хүн бүтээлээ ирүүлсэн байна.

Дэлхийн номын өдрийн арга хэмжээний үеэр “Монголын нууц товчоо” үзэсгэлэн, “Дэлхийн шилдэг зохиолууд” номын үзэсгэлэн, “Нутгийн зохиолчдын шинэ номын үзэсгэлэн худалдаа” – г 160 гаруй номоор гаргаж сурталчиллаа.

"**Хөрөг зураг гар зураг" -** ийн уралдаанд 30 гаруй зураг ирүүлснээс:

Насанд хүрэгсдийн ангилалд:

Тэргүүн байр: М. Ганхөлөг / Наран сум /

Дэд байр:Ц. Мөнхболд / 1-р сургуулийн багш /

Гутгаар байр:Б.Ганзориг / Уулбаян сумын ЕБС-ийн багш

/Тусгай байр:

Э. Маралмаа / 1-р сур 6б анги

Ж. Пүрэвбаатар /Наран сум 6а анги/

10-12 ангийн ангилалд:

Тэргүүн байр:Г. Цэвэгмид /3-р сур 11б/

Дэд байр: Ц. Амгалангоо /1-р сур 10д/

Гутгаар байр: А. Аринусанаа / 3-р сургуулийн 11а анги /



Эсээ билэгийн уралдаанд: Насанд хүрэгсэд

Тэргүүн байр: Уулбаян сум.

Л. Мөнхтуяа / ЕБС-ийн багш /

Дэд байр: Түмэнцогт сум. /Монгол хэлний багш А.Өнөрсайхан /

Гутгаар байр:П.Уянга / НТБТ-ийн СМ /

ЕБС-ийн сурагчид:

Тэргүүн байр: Б. Дэлгэрмаа 3-р БДС
Дэд байр: Н. Цэзсүрэн Онгон сум ЕБС
Гутгаар байр: Х. Ганзул Түмэнцогт сум ЕБС нар тус тус шалгарсан.

"Богино өгүүллэг"- ийн наадам зохион байгуулагдаж, нийт 18 хүн оролцож, 40 гаруй хүн хамрагдсан.

6-9 ангийн ангилалд:
Тэргүүн байр- Г. Ундраа / 1-р сургууль. 9а
Дэд байр: Г. Намуунаа / 2-р сургууль. 6в анги

Гутгаар байр: Баярцэнгэл/Уулбаян /

10-12 ангийн ангилалд:

Тэргүүн байр:Э. Аззаяа / Эрдэнэцагаан сум. 10б анги / Дэд байр:/ Ж. Халиунаа / 1-р **сургууль. 11а анги / Гутгаар байр: / Д. Анударь / 1-р сургууль. 10г анги /**

Насанд хүрэгсэд:

Тэргүүн байр Б. Долгормаа / Түмэнцогт сумын Соёлын төв / нар тус тус шалгарсан.

"АЗ ЖАРГАЛЫН ДАРХЛАА": Баруун-Урт сумын ЗДТГ-аас нийгэм хамгааллын хүрээнд "АЗ ЖАРГАЛЫН ДАРХЛАА" хүүхэд хөгжлийн хөтөлбөрийн II ээлжийг 2

дугаар бүрэн дунд сургуулийн Б. Дуламдорж багштай 11а ангийн 21 сурагчдыг хамруулан "ОЮУНЫ ДАРХЛАА"-г Аймгийн Нийтийн номын сан дээр зохион байгуулж Номын санч Ө.Хонгорзул “НОМ УНШИХ 14 ДАДАЛ”-г танилцуулсан.

“НОМЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ УРАЛДААН”: Хүүхэд залуусын ном унших хүсэл тэмүүлэлтэй болгох, номоор дамжуулан сурагчдын оролцоог нэмэгдүүлэх, номоор дамжуулан бүтээлч сэтгэлгээг нь хөгжүүлэх зорилгоор “Номын тэмдэглэл хөтлөх уралдаан” насанд хүрэгсэд, сурагчдын дунд зохион байгуулахад нийт 183 бүтээл ирүүлж

Насанд хүрэгсдээс Б.Ундрал,
6-р цэцэрлэгийн багш Д.Жавхаа
Сурагчдаас 1-р БДС 10а ангийн сурагч Э.Номин-Эрдэнэ, 4-р БДС-ийн 10-р ангийн сурагч О.Даваажаргал на шалгарсан.

Баруун-Урт сумын соёлын өв тээгчдийн зөвлөгөөний үеэр / 2019. 05.01 / Д. Сүхбаатарын талбайд монгол бичгийн уран бичлэгийн үзэсгэлэн, Дарьганга өв соёлтой холбогдолтой номын үзэсгэлэнг 40 гаруй номоор гарган сурталчилж, мөн

Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд зарласан монгол бичгийн сайхан бичгийн уралдаанд иргэдээс бичвэр бичүүлж авах зэрэг ажлыг зохион байгуулсан.

ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР:

Үндэсний бичиг үсгийн баярыг “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлье” уриан дор Аймгийн Засаг даргын тамгын газар, Боловсрол соёл урлагийн газар, Насан туршийн боловсрол төвтэй хамтран зохион байгуулж, олон төрлийн ажлуудыг санаачлан амжилттай явуулсан.

Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, хүүхэд залуучуудыг хамруулан “Сайхан бичигтэн” хамт олон, иргэдийг шалгаруулах уралдаан, уншлагын түвшин тогтоох сорил, албан байгууллагуудын монгол бичгийн хаягжилтын судалгаа зэргийг авч ажиллахад 40 гаруй байгууллагын 400 гаруй албан хаагч хамрагдаж, нэгдсэн дүнг "Хүмүүн бичиг-Хүн бүрийн бичиг" тэмцээн дээр танилцуулж, шагналыг нь гардуулсан.

"Хүмүүн бичиг-Хүн бүрийн бичиг" тэмцээнийг 2019 оны 05-р сарын 03-нд зохион байгуулахад төрийн болон төрийн бус байгууллагын 9 багийн 45 хүн оролцсон.

Сүхбаатар аймаг дахь “Тархи цэнэглэгч номын клуб "-тэй хамтран номын уулзалтыг Д. Намдагийн “Үрэгдэснийг хүлээгч” зохиолоор хийж, 30 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулагдсан.

Гэр бүлийн аз жаргалын тухай хүмүүсийн бодол хүслийг сонсох, нийгмийн сэтгэл зүйд сайн сайхныг түгээх, соён гэгээрүүлэх үйлсэд хувь нэмэр оруулах, аз жаргалыг бусдад түгээх, байгаа зүйлсдээ сэтгэл хангалуун байх ухаан, гэр бүлийн харилцаагаа хөгжүүлэх, сайхан бүхнээ бусадтай хуваалцах, үр хүүхэд, хань ижлээрээ бахархах, түүнээсээ аз жаргалыг мэдрэх, бусдад талархлаа илэрхийлэх, гэр бүлийнхээ аз жаргалтай, гэгээлэг, сайхан дурсамж сэтгэгдлийн тухай эсээ бичвэрийн уралдааныг ЕБС-ийн сурагчид, насанд хүрэгсэдийн дунд зохион явуулахад нийт 98 бүтээл ирснээс :

ЕБС-ийн сурагчдын ангилалд:

- 1-р байр: Ц.Урангоо Онгон сумын БДС-ийн 12 а ангийн сурагч
- 2-р байр : Т.Золзаяа Мөнххаан сумын БДС-ийн 11 а ангийн сурагч
- 3-р байр. Б.Дэлгэрмөрөн 3-р БДС-ийн 11 а ангийн сурагч
- Тусгай байр : Э. Мөнхцэцэг 1-р БДС-ийн 10 в ангийн сурагч

Насанд хүрэгсдийн ангилалд:

- 1-р байр : Го. Эрдэнэчимэг МСҮТ-ийн дотуур байрын багш

- 2-р байр: Б.Ундрал Судартан бэхи ТББ-ийн тэргүүн
- 3-р байр: С.Мөнхсувд МУИС-ийн 2-р курсын оюутан
- Тусгай байр: Б.Баярсайхан Баяндэлгэр сумын ЕБС-ийн багш

“ЖАРГАЛТАЙ МӨЧҮҮД” ФОТО ЗУРГИЙН УРАЛДААН:

Эх үрсийн баяр” - ыг угтаж, хүүхэд, залуучуудад гэр бүлийн ариун нандин дурсамж, хүндлэл, аз жаргал, инээд хөөр, хайр түгээх, нийгэмд эерэг зөв бүхнийг дэлгэрүүлэх, өөрийн байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх, орон нутгийн иргэдэд байгууллагын үйл ажиллагаагаа сурталчлах зорилгоор “Жаргалтай мөчүүд” фото зургийн уралдааныг онлайнаар зохион байгуулан ажиллаж, 30 гаруй фото зураг ирсэнээс байгууллагын нүүр хуудсаар дамжуулан, нийт 5716 like цуглуулж, 1186 share хийсэн байна.

1-р байр 1508 -Э. Ихмонгол
2-р байр 1307-Г. Бат-Амгалан
3-р байр 1006 Ганхүү
Тусгай байр-778-Ц. Мөнхболд
Тусгай байр- А. Баярхүү- 587 тус тус эзэлсэн.

Тус арга хэмжээг Баялаг нарийн боовны цех, Бүжин цех нар ивээн тэтгэн хамтран ажилласан.

“ХӨГЖЬЕ, СУРЪЯ” ЗУНЫ СУРГАЛТ

Сурагчдын зуны амралтыг тохиолдуулан “Хөгжье,суръя” уриан дор 2019 оны 07 дугаар сарын 01-05-ны өдрүүдэд “SUMMER DAY” сургалт Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулж, " Хүүхдийн харилцаа хандлага ", Өөрөө өөртөө итгэх итгэл", Зураг унших", " Цахим донтолт", " Ном уншихын ач холбогдол", " Хайр" сэдвээр тус тус явуулсан давхардсан тоогоор нийт 120 гаруй хүүхэд хамрагдсан.

Уншлагыг дэмжих жилийн хүрээнд зохион байгуулагдаж буй “Зуны зугаатай уншлага”-ын хөтөлбөрийг Хүүхдийн төв номын сантай хамтран 2019 оны 9-р сарын 07-ны 10 цагт 3-р сургуулийн зааланд зохион байгуулж, ‘’Урт оймст Пиппи’’- Жүжигчилсэн тоглолт, ‘’Гахайн гурван тоорой’’- Хүүхэлдэйн тоглолтыг зохион байгуулж, МУСГЗ, Хэл зохиолын шинжлэх ухааны доктор, Хүүхдийн зохиолч Б.Нацагдорж, “Хүүхдийн элч” хөгжмийн зохиолч, СТА С.Батболд, МЗЭ болон “Алтан өд” шагналт, Хүүхдийн зохиолч Х.Дэмбэрэл, Д.Нацагдоржийн нэрэмжит Утга зохиолын нийгмийн ажилтны дээд сургуулийн захирал Ц.Нацагдулам, Хүүхдийн төв номын сангийн захирал Д.Оюунбилэг, Хэлтсийн эрхлэгч С.Тунгалаг, “Боловсрол хөгжил” танхимын номын санч Б.Бямбадулам, “Өрнө дахины танхим”-ын номын санч Б.Сувдмаа, Инженер техникийн ажилтан С.Алдуул, Герман уншлагын танхимын номын санч Э.Доржханд нар ирж оролцлоо. Нийт 100 гаруй хүүхэд, багачууд үзэж сонирхсон.

НОМЫН ХУРИМ:

Сэтгүүлч, найрагч, МУСГЗ Ай.Төмөр-Очир “Морин шуурга”, сэтгүүлч, найрагч Сумьяагийн Амартайван “Морьтны тэнгэр”, яруу найрагч Ч.Эрдэнэбаатар “Монгол ухааны эрхин хэлхээ” номынхоо гурвалсан хуримыг Сүхбаатар аймгийн “Жавхлант шарга” театрын бага танхимд зохион байгуулж, эдгээр уран бүтээлчдийн номоор үзэсгэлэн, танилцуулгыг бэлтгэн гаргаж, хамтран оролцсон.

“ТАНД ОЙРХОН НОМЫН САН”

Баруун-Урт сумын 1-р багийн Мандал хорооллын оршин суугчдын өдөрлөгт дэлхийн шилдэг 50, 7-р багт 50 нийт 100 номоор зөөврийн номын сангийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээт болон хүүхдийн номоор хүргэж, уншигчдад карт нээж, нутгийн зохиолчдын номын худалдаа, иргэдийн дунд "АХА" тэмцээн, “Номын уналт” танин мэдэхүйн тэмцээн, азын сугалаа, хүүхдүүдийн дунд зургийн тэмцээнийг зохион байгуулж, шалгарсан хүүхдүүдэд ном дурсгав. Энэхүү арга хэмжээнд нийт 200 гаруй хүн хамрагдсан.

НОМЫН БАЯР-БИДНИЙ БАЯР -2019

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийн дагуу ард иргэд, хүүхэд залуусын ном эрдэмд дурлан нөхөрлүүлэх ном унших хөдөлгөөнийг дэмжих зорилгоор “Үндэсний номын баяр" арга хэмжээний хүрээнд МЗЭ-ийн гишүүн, Хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан Я. Түмэннастын уран бүтээлээр "ЗОХИОЛЧ-УНШИГЧДЫН УУЛЗАЛТ"-ыг **"Миний номнууд**" нэртэйгээр, БСУГ-тай хамтарч **Номын баяр-Бидний баяр-2019”** чуулганы тус тус зохион байгуулахад нийт 500 гаруй хүн хамрагдсан.

"ЗОХИОЛЧ-УНШИГЧДЫН УУЛЗАЛТ"

МЗЭ-ийн гишүүн, Хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан Я. Түмэннастын уран бүтээлээр "ЗОХИОЛЧ-УНШИГЧДЫН УУЛЗАЛТ"-ыг "Миний номнууд" нэртэйгээр 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж, энэ үеэр уншигч, зохиолчдын уулзалт, түүний уран бүтээлийн үзэсгэлэн, уран бүтээлийн цэнгүүн, нутгийн зохиолчдын шинэ номын үзэсгэлэн худалдаа зэргийг зохион байгуулахад

400 гаруй хүн үзэж сонирхсон бөгөөд Соёлын түшиг холбооны “ Соёлын гавъяа” одонгоор шагнаж урамшуулав.

Уншигч зохиолчдын уулзалт: Сэтгүүлч, яруу найрагч Я. Түмэннастын “Уншигч-зохиолчдын уулзалтанд аймгийн Засаг Ж. Эрдэнэбаатар хүндэтгэл үзүүлж, аймгийн утга зохиолын нэгдлийн гишүүд, мэргэжил нэгт нөхөд, найз нөхөд, ах дүү, номын клубын хүүхэд багачууд хүрэлцэн ирж оролцсон.

Уран бүтээлийн цэнгүүн: Уг арга хэмжээнд түүний уран бүтээлээр аймгийн ХЖТ-ын хамт олон ая дууны мэндчилгээ дэвшүүллээ.

Уран бүтээлийн үзэсгэлэн: Уг үзэсгэлэнг түүний гаргасан ном, зохиолууд, сонин сэтгүүл дээр гарсан материалууд, түүхэн холбогдолтой зургууд, гар бичмэлүүд, хайчилбар, хуурцгуудаар гаргаж сурталчлав. Мөн Сүхбаатар нутгийн зохиолчдын уран бүтээлээр номын үзэсгэлэн худалдааг зохион байгуулав.



НОМЫН БАЯР-БИДНИЙ БАЯР-2019” ЧУУЛГАН

Нутаг орныхоо түүх соёл, зан заншилтай танилцаж, түүгээр бахархах, хайрлан хамгаалах үзлийг төлөвшүүлэхийн зэрэгцээ сургууль хамт олноороо ном унших хөдөлгөөнийг өрнүүлж, номын санч, багш, сурагч, удирдах ажилтнуудын хамтын ажиллагааг сайжруулах, дэмжих, урамшуулах зорилгоор БСУГ-тай хамтарч уламжлал болгон зохион байгууллаа.

2019 оны 10-р сарын 10-ны өдөр “Номын баяр-Бидний баяр-2019” чуулганыг сэтгүүлч Я.Түмэннастын эмхэтгэл **“Сүхбаатар аймаг түүхэн товчоон”** номын 5-р бүлгээр Сүхбаатар аймгийн сум сургуулийн номын санч, ЕБС-ийн сурагчид, монгол хэлний багш, удирдах ажилтан, иргэдийн төлөөллийн бүрэлдэхүүнийг хамруулан зохион явуулсан.

Удирдамжийн хүрээнд сум, сургуулийн хэмжээнд уг номыг уншиж, танилцах хөдөлгөөн өрнүүлэн ажилласан.

“Номын баяр-Бидний баяр-2019” нэгдсэн арга хэмжээг :

Дарьгангын аман зохиол, зан заншил, соёл, ахуй амьдралыг харуулсан багуудын мэндчилгээ

Багуудын дундах асуулт хариултын тэмцээн

Уншсан номынх нь талаар сурагчдаар сэтгэгдэл бичүүлж, шилдэг 15-20 бүтээлийг шалгаруулан эмхэтгэл бэлтгэж ирэх

Тус номонд ороогүй, сум орон нутгийнхаа түүх археологи, хөшөө дурсгал, гар урлал, дуу хуур, тоглоом наадгай, зан заншил, угсаатны зүйн судалгаа хийж, цахим танилцуулга бэлтгэж ирэх

Сум, сургуулийн номын санч хамтран ”Номын баяр”-ыг угтан зохион байгуулсан ажлын талаарх тайланг ирүүлэх зэргээр зохион байгуулахад уг арга хэмжээнд 120 гаруй хүн оролцсон.

Багийн дүнгээр:
Тэргүүн байр: Наран сумын баг
Дэд байр: Асгат сумын баг

Гутгаар байр: Ерөнхий боловсролын 3-р сургууль тус тус эзэлсэн.

НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР:

МУ-ын Ерөнхийлөгчийн 2007 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн "Нээлттэй хаалганы өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай №97 дугаар зарлигийн дагуу Иргэд, олон нийтэд үйл ажиллагаагаа сурталчлах, мэдээ, мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлэх, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх зорилгоор тусгай төлөвлөгөө гарган ажиллаж, уг арга

хэмжээг 05 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан.

Байгууллагын үйл ажиллагааны танилцуулгыг бэлтгэн, иргэдэд сурталчлан, номын сангийн үйл ажиллагааны талаар гарын авлага, боршур бэлтгэн тарааж, иргэдийн санал хүсэлтийг тусгай хайрцгаар авч, номын сангийн үйл ажиллагааны болон номын санчдын талаар сэтгэл ханамжийн судалгаа авч ажилласан.

Нийт 50 гаруй уншигчдаас номын сангийн үйл ажиллагаа, номын санчдын зан харилцааны талаарх санал асуулга авсан. Санал хүсэлтийн хайрцагт нийт 52 санал ирсэн.

Мөн шинэ номын үзэсгэлэн худалдаа болон Хишиг, Солонго, Жанжин тулга худалдааны төвийн хүүхдийн номын худалдаа оролцож, эрэлт хэрэгцээт номуудыг зарж борлуулсан.

ЕБС-ын сурагчдын дунд танин мэдэхүйн “Номын уналт” арга хэмжээг зохион явуулахад 20 гаруй хүүхэд хамрагдсан.

Иргэдэд үнэгүй карт нээн үйлчилж, Азын сугалаа зохион байгуулан иргэдийг татан оролцуулах ажлыг зохион явуулсан Шинээр насанд хүрэгсэд-35, хүүхэд -15 уншигчдад карт нээсэн.

Уг арга хэмжээнд Төвийн сургуулиуд, МСҮТ-ийн номын сангууд идэвхтэй оролцож өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчлан хамтран ажилласан бөгөөд 100 гаруй хүн хамрагдсан.

Хүүхэд, өсвөр үеийнхнийг номтой нөхөрлүүлэх, номын орчинг илүү өргөн хүрээнд хөгжүүлэн дэмжих, хөгжүүлэхэд зорилгоор жил бүр уламжлал болон зохион байгуулдаг "ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ НАЦАГДОРЖ" ТЭМДЭГТЭН шалгаруулах уралдаанд:

бага нас: ЕБ-ын 2 дугаар сургуулийн 5г ангий Ц. Ариунзаяа, ЕБ-ын 4 дүгээр сургуулийн 6а ангийн сурагч М. Ихнөмөр, 5в ангийн сурагч Д. Сансар, И.Эгшиглэн

Өсвөр нас: ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 10а ангийн сурагч Г. Ундраа, 3 дугаар сургуулийн 12а ангийн сурагч Б. Дэлгэрмөрөн, Мөнххаан сумын ЕБ-ын сургуулийн сурагч Б. Мөнхгэрэл



"Тэргүүний уншигч" анги хамт олноор Ерөнхий Боловсролын 4 дүгээр сургуулийн М. Алтантуяа багштай 5в анги, Ганцэцэг багштай 11в анги тус тус шалгарсан.

Номын сангаар байнга үйлчлүүлж ном уншдаг, ном соёлыг дэлгэрүүлэх ажилд идэвхитэй оролцдог, шилдэг тэргүүний хүүхдийг алдаршуулах, туршлагыг бусдад түгээн дэлгэрүүлэх, үлгэр дууриалал болгох зорилгоор оны тэргүүний уншигч шалгаруулах “Цэцэн хүүхэд” арга хэмжээг 2019 оны 12 дугаар сарын 18-нд зохион байгууллаа.

2019 оны **“Цэцэн хүүхэд”-**ээр:
Т. Нандинцэцэг / ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 12г ангийн сурагч /

“ Эрдэм номд ээлтэй сурагч”-аар:
Б. Дэлгэрмөрөн / ЕБ-ын 3 дугаар сургууль. 12а анги /
Т. Золзаяа / Мөнххаан сумын 12 ангийн сурагч /
Г. Ундраа / ЕБ-ын 1 дүгээр сургууль. 10а анги /

“Оюунлаг сурагч”-аар
Э. Цахирмаа / ЕБ-ын 4 дүгээр сургууль. 5в анги /

Э. Биндэрьяа / ЕБ-ын 2 дугаар сургууль. 6в анги /
Э. Даваасугар / ЕБ-ын 1 дүгээр сургууль. 6а анги / тус тус шалгарсан.

4.4. Ном уншилтыг сайжруулах. Уншлагын төвүүдийг зохион байгуулах, үйл ажиллагааг нь зохицуулах ажил хийсэн эсэх

БСШУС-ын Сайдын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/683 дугаар тушаалаар 2019 оныг “Уншлагыг дэмжих жил” болгон зарласан бөгөөд уг журмын 2.1.7.“Уншлагын цаг”, “Гэр бүлийн уншлага” арга хэмжээ-ний хүрээнд долоо хоног бүрийн 5 дахь өдрийг “Гэр бүлийн уншлагын өдөр” болгон, ирсэн эцэг эхчүүдэд халуун кофе, ундаагаар дайлах, хүүхдэдээ хэрхэн ном унших талаар гарын авлага тараах, гэр бүлийн, хүүхдийн хүмүүжлийн болон шинэ ном уншуулах, санал асуулга авах зэргээр ажиллаж, ирэх жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг зорилт тавьж байна.

Багш нарын баярт зориулж бүх цэцэрлэгүүдийн дунд зарласан анги бүрийг “Номын сан”-тай болох уралдааны шалгаруулалтыг 11 цэцэрлэгээр явж шалгаруулсан.

4.5. Алслагдсан хэрэглэгчдийн үйлчилгээг зохицуулсан байдал

БСШУЯ-ны сайдын 03 дугаар сарын 18-ны өдрийн 570 дугаар тушаал “Зөөврийн номын сан ажиллуулах журам”-ын дагуу алслагдсан нутаг дэвсгэрт амьдардаг иргэдэд ном, хэвлэлээр үйлчилж, тэдэнд номын сангийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор шинэ номын болон нутгийн зохиолчдын номын үзэсгэлэнг 100 гаруй номоор дэлгэн сурталчилж таниулах ажлыг бүх сумдад зохион байгуулсан.

4.6. Зөөврийн үйлчилгээ

Зөөврийн номын сангийн үйлчилгээ-г цэцэрлэгүүдэд сар бүр хуваарийн дагуу хүргэхээр төлөвлөж,
1-11 дүгээр цэцэрлэгүүдэд хүргэж ажилласан. Үүнд:

- 1 сард 1 дүгээр цэцэрлэгийн Учрал багштай ахлах бүлэг-10
- 2 сард 2 дугаар цэцэрлэгийн Анхтуяа багштай ахлах бүлэг-10

багш ажилчдад -24 ном

- 3 сард 4 дүгээр цэцэрлэгийн Мөнгөнчимэг багштай ахлах бүлэг-10
- 4 сард 5 дугаар цэцэрлэгийн Сэргэлэн багштай бэлтгэл бүлэгт үлгэрийн ном-10
- 5 дугаар сард 3 дугаар цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн тайлант өдөрлөгт 20 ном
- 10 дугаар сард 11-р цэцэрлэгийн хөгжлийн бэрхшээлтэй ангид тэдний нас сэтгэхүйд тохирсон хүрч мэдрэх, харж ойлгоход зориулсан 10 ном, мөн цахим номын хамт

- “Танд ойрхон номын сан” өдөрлөгт 1-р багийн Мандал хорооллын оршин суугчдад дэлхийн шилдэг-50 ном
- 7-р багийн иргэдэд-50 ном
- Цайрт Минераль ХХК -7 ном
- Цагдаагийн газар- 37
- МСҮТ-25
- Татварын алба -39
- Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар -50
- Орон нутгийн өмчийн газруудад танин мэдэхүй-75
- Баруун-Урт сумын 9-р багийн ахмад уншигч Д.Бат хүрэл- 90
- Жаахан шарга театрын жүжигчин Ч.Алтанцэцэг-14
- 2-р сургуулийн номын санд-14 номоор зөөврийн номын сангийн үйлчилгээг 545 номоор хүргэж, 1500 гаруй хүн хамрагдсан байна.

4.7. **Хүүхдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал**

Данийн үлгэрийн зохиолч Ханс Кристиан Андерсений төрсөн өдөр буюу Олон улсын хүүхдийн номын өдрийг угтаж, Дэлхийн хүүхдийн шилдэг зохиолоор номын үзэсгэлэнг 30 гаруй номоор гаргаж сурталчлан энэ өдөр хүүхдийн

танхимаар ирж үйлчлүүлэн, сэдэвчилсэн үзэсгэлэнтэй танилцаж, мэдээлэл цуглуулсан бяцхан хүүхэд багачууддаа үлгэрийн ном бэлэглэсэн.

"Уншлагыг дэмжих" жил: Хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх, тэдний хэл яриаг хөгжүүлэх, жужиглэх, хэл зүгшрүүлэх, нээлттэй болгох, эх хэлээ хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажилд өргөнөөр оролцуулах зорилгоор 2019 оныг "Уншлагыг дэмжих" жил болгон зарласантай холбогдуулан Баруун-Урт сумын 1-11 цэцэрлэгийн бэлтэл бүлгийн хүүхдүүдийг номын сантай танилцах" Тойрон

аялал” тусгай хөтөлбөрт хамруулахад бүх цэцэрлэгийн 400 гаруй хүүхэд хамрагдаж, номын сангийн дэргэдэх "Оюуны хөтөч" клубийн хүүхдүүд бага, дунд, ахлах бүлгийн хүүхдүүдэд дүрийн тоглолт болон хуруун хүүхэлдэйг зохион байгуулж, чанга уншлагыг явуулахад нийт 500 гаруй хүүхэд, багачууд хамрагдсан.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон, Нийслэлийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас залуу гэр бүлүүдийг зохистой цахим хэрэглээтэй болгох, хүүхдээ зөв хүмүүжүүлэх орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор үдэш бүр хүүхдүүддээ үлгэр ярьж өгөхийг уриалж, 2019 оны арваннэгдүгээр сарын 11-ний өдрийг “ҮЛГЭРЧ ЭЭЖ, ААВУУДЫН ӨДӨР” болгох уриалга гаргаж сурталчилсан ба хүүхдийн танхимаар үйлчлүүлж буй хүүхдүүд маань мөн энэ өдөр аав ээжүүдээрээ үлгэр яриулах амлалт бичүүлсэн.

4.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал

2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай холбогдуулан Сүхбаатар аймгийн Нийтийн номын сан, Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвтэй гэрээ байгуулсаны дагуу Цахим мэдээллийн танхимаас 2019 он буюу бүтэн жилийн хугацаанд судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулан “Бид чадна” хөтөлбөрт сургалтыг шинээр зохион байгуулан сар бүр төлөвлөгөө гарган амжилтай зохион байгуулан ажиллаж ирлээ.

Эдгээр хөгжлийн бэрхшээлтэй



иргэдийг нийгмийн хөгжил, харилцаа, соёлын арга хэмжээнд идэвхтэй хамруулан интернэтээр үнэ төлбөргүй үйлчлэн хэрэглээний анхан шатны программ, суурин комъпьютер, гар утас, таблет хэрхэн цахим сүлжээг хэрхэн зөв ашиглах, e-mail хаягтай болгох, е-баримт бүртгэх гэх мэт төрөл бүрийн амьдрал ахуйдаа ашиглах сурах энгийн дадлаас эхлээд тэдний ажил мэргэжил, эрүүл мэндэд тустай зөвлөмж зөвлөгөөг сургалтаар өгч хамтран ажиллаж ирлээ. Нийтдээ бүтэн жилийн хугацаанд Хараа, Сонсгол, Тулгуур эрхтэний бэрхшээлтэй 18-65 насны 60 гаруй иргэд давхардсан тоогоор үйлчлүүлсэн байна.

Мөн энэ өдөр “Уншлагын цаг” –ийг тогтмол ажиллуулж, АНЭ-ийн нүдний их эмч Н. Дашжаргал “ Нүдээ хэрхэн хамгаалах, нүдний өвчлөлийн талаар”, татварын

хэлтсийн мэргэжилтэн И. Батгэрэл “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг НӨАТ-ын баримт /ebarimt/ буюу цахим төлбөрийн баримтыг хэрхэн бүртгэх, интернэт facebook орчинд ажиллах, сургалт “ Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн С. Балжинням “ Хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрөөс үзүүлэх тусламж, үйлчилгээ” , аймгийн ИХ-ийн сэтгүүлч, сурвалжлагч П. Оюунцэцэг” Иргэдийн сэтгэл зүй” сэдвээр , нийгмийн даатгалын байцаагч Тамираа” Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчин” сэдвээр , ХБИ-ийн холбооны тэргүүлэгч Т. Энхзаяа, С. Должинсүрэн нар “ Зүүн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалт”-- ын талаар тус тус өгч ажилласан.

Баруун-Урт сумын XI цэцэрлэгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд Хүүхдийн уншлагын танхим, Цахим мэдээллийн танхимаас 10 гаруй цном, мөн “Азхур”-ын цахим номын сан буюу сонсдог номоор зөөврийн номын сангийн үйлчилгээг бүтэн сарын турш үйлчилгээгээ үзүүлэн хамтран ажиллаж, нийтдээ 20 гаруй багш ажилчид, хүүхдүүд хамрагдсан.

4.9. Номын сан болон номын сангийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн эсэх

Байгууллагын өнөөгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, хэрэглэгчдийн хэрэгцээ сонирхлыг судлах, санал хүсэлтийг сонсох, тэдгээрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилгоор уншигч хэрэглэгчдээс цахим хуудсаар болон санал хүсэлтийн хайрцаг аялуулан судалгааг авсан. Судалгааг:

1. “Зүүдний ертөнц шөнийн уншлага”-1 хөтөлбөрт хамрагдсан МСҮТ-ийн дотуур байрны сурагчид

2. “Нээлттэй хаалганы өдөрлөг”- т

3. “Зүүдний ертөнц шөнийн уншлага”- 2 хөтөлбөрт хамрагдсан 2-р БДС-ийн 11 а ангийн хамт олон

4. Танд ойрхон номын сан /1-р багийн өдөрлөгт хамрагдсан иргэд/

5. “Зүүдний ертөнц шөнийн уншлага” -3 хөтөлбөрт хамрагдсан 1-р БДС-ийн 10г ангийн хамт олноос тус тус авсан.

“Зүүдний ертөнцөөр” шөнийн уншлагын цаг”-1.2 .3-т хамрагдсан 77 сурагчдаас судалгаа авахад номын сангийн үйлчилгээ, хүрээ хүртээмж, номын санчдын зан харилцаа, ном, хэвлэлийн хүрэлцээ хангамж, уншигчдын дунд зохиох соёл олон нийтийн ажлуудыг маш сайн гэж дүгнэсэн бол:

Нээлттэй хаалганы өдөрлөг-т ирсэн 50 уншигчаас авсан санал хүсэлтэд сүүлийн үед хэвлэгдэж байгаа шинэ ном дутагдалтай, шинэ номын хүрэлцээ хангамж муу, уншлагын танхимын орчин нөхцөл сайн, номын санчдын зан харилцаа маш сайн гэх зэрэг саналууд ирсэн байна. Мөн үйлчилгээний танхимуудын үйл ажиллагаа болон номын санчдын харилцааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг давхар авсан.

Уг судалгааг хийснээр:Номын санд шинэ барилга байшин зайлшгүй хэрэгтэй, уншигчийн ширээ, сандал муу, эвдэрч гэмтсэн, шинэ номын хүрэлцээ хангамж дутагдалтай, өвлийн улиралд номын сангийн уншлагын танхимууд маш хүйтэн, гадуур хувцастай их суудаг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилдэг танхимууд 2 давхарт байдаг учир тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэд таяг болон бусад зүйлсээр явахад хэцүү, тэдэнд зориулсан гарц, шат байдаггүй гэх мэт санал ирсэн байна.

ТАВ. ЛАВЛАГАА, НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1. Номын сангийн үйл ажиллагаанд лавлагаа номзүйн үйлчилгээг боловсронгуй болгох, нэвтрүүлэхэд чиглэгдсэн ажлын талаар:

Лавлагаа-мэдээлэл ном зүйн үйлчилгээг:
Манай номын санд Шинэ ном ирлээ.
Уншигч та бүхэн ДЭЛХИЙН ХААНА Ч БАЙСАН ИНТЕРНЭТТЭЙ ГАЗРААС https://lib4u.net/?lib=sukhbaatar net хаягаар манай номын сангийн ЭЛЕКТРОН

КАТАЛОГООР аялах боломжтой......та өөрийн хайсан номын мэдээллээ цаг алдахгүй авах боломжтой боллоо.
Холбоо барих утас: 70518215
Facebook: Сүхбаатар аймгийн Нийтийн номын сан
Page: МУСГЗ Г. Мэнд-Ооёогийн нэрэмжит Сүхбаатар аймгийн Нийтийн номын сан
https://aimaglibrary.wordpress.com Эрхэм Оюунлаг уншигч та бүхэн манай байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний тухай мэдээллийг цаг алдалгүй авахыг хүсвэл дээрх хаягуудаар орж танилцана уу. Та бүхэндээ АЖЛЫН АМЖИЛТ хүсье.....
Sbnomiinsan1947@gmail.com гэх мэтээр онлайнаар лавлагаа өгөх, хүлээн авах үйлчилгээ нэвтрүүлэн өдөр бүр байгууллагын нүүр хуудсаар хамтран ажилладаг Төрийн үйлчилгээний байгууллагууд, ЕБС, цэцэрлэгүүд, Сүхбаатар аймгийн зар мэдээ гэх мэт мэдээллийн групуудэд тогтмол өгч хэвшсэн.

“Болор цом-1983-2018 оны Болор цомын тэргүүн байрын шагналт зохиолчдын уран бүтээл”-ээр мэдээллийн самбар булан
“Тал нутгийн зохиолчдын уран бүтээл”-ээс мэдээллийн самбар булан
“Эргэн дурсахуй”: Зохиолчдын төрсөн ой тэмдэглэлт өдрүүдэд уран бүтээлчийн намтар, уран бүтээлээр материал бэлтгэн лавлагаа ном зүйн ажлыг бэлтгэн өгч сурталчилж ирсэн.

Сүхбаатар аймгийн уран бүтээлчид, эрдэмтэн, зохиолчдын талаарх зураг, намтар, уран бүтээлийн талаар сурвалжлан олж байгууллагаас зохион байгуулж байгаа зохиолчдын тэмдэглэлт өдөр, ой гэх мэт өдрүүдээр лавлагаа ном зүйн чиглэлээр PS программ дээр өнгөтөөр материал бэлтгэн тогтмол үзэсгэлэн гаргадаг.

5.2. Ганцаарчилсан хэрэглэгч болон үйлчлүүлэгч байгууллага, хамт олныг мэдээлэл-номзүйн үйлчилгээгээр хангасан байдал

Харааны бэрхшээлтэй иргэдэд 54 удаа лавлагаа өгсөн. Үүнд: Амаар 117, утсаар 15 , мессенжерээр 10, мэйлээр 3 удаа тус тус өгсөн байна.

5.3. Хэрэглэгчийг мэдээллийн соёлтой болгоход чиглэгдсэн ажлууд хийсэн эсэх

Мэдээллийн зуунд уншигчдыг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа татан оруулж идэвхтэй хамруулах үүднээс өдөр бүр байгууллагын нүүр хуудас, нүүр ном, блогоор дамжуулан үйл ажиллагаагаа тогтмол сурталчлан номын сангаар үйлчлүүлэхэд уншигчийн эрх үүрэг, номын санчийн ёс зүй, үйлчилгээний танхимуудын онцлог, ном соёлын үйлчилгээг байнга сурталчлан номтой нөхөрлөснөөр ямар ач холбогдолтой гэх мэт мэргэжлийн чиглэлээр мэдээлэл амаар болон цахимаар тогтмол өгч харилцан хамтран ажиллаж ирсэн.

ЗУРГАА. НОМЫН САНГУУДЫН ОРОН НУТАГ СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1. Орон нутаг судлах цогц төсөл боловсруулах, хэрэгжүүлэх талаар хийсэн ажи
6.2. Орон нутгийн картын сан, номзүйн бүртгэл эрхлэн гаргасан эсэх

"СҮХБААТАР АЙМГААС ТӨРСӨН ЗОХИОЛЧДЫН БҮТЭЭЛИЙН НАМТАР НОМЗҮЙ

Сүхбаатар нутгаас төрсөн зохиолч, уран бүтээлч, эрдэмтдийн бичиж туурвисан бүтээлийг нийтэд мэдээлэх үүднээс намтар номзүйг хийх зорилгоор материалыг цуглуулан эмхэтгэж, зураг татах, сумдаас нэр уран бүтээл нь тодорхойгүй уран бүтээлчийг олж илрүүлэх, материал цуглуулах, сурвалжлах гэх мэт ажлыг хийн, Улаанбаатар хотын номын сангийн арга зүйч нараас зөвлөгөө аван ажиллаж, 2020 онд дуусгаж хэвлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

ДОЛОО. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

7.1. Номын санд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, технологийн үйл ажиллагааг хэрэглэгчдэд хүргэхэд чиглэгдсэн ажлуудын талаар

Lib4U NET буюу “ҮҮЛЭН ТЕХНОЛОГИ”-ийг нэвтрүүллээ.

2009 онд анх интернэт авч, Lib4u номын сангийн программ хангамжийг 2010 онд нэвтрүүлж эхэлсэнээс хойш фондын 16580 нэр төрлийн 40723 номоо цахим каталогт оруулан 2019 оныг хүртэл дотоод сүлжээ серверээр цахим үйлчилгээгээ хүргэн ажиллаж ирсэн. 2019 оноос Lib4U номын сангийн программын шинэ, дэвшилтэт хувилбарыг авч, интернэтээр уншигчдад ашиглуулах, номын сангийн хөмрөгт байх ном, тогтмол хэвлэл, материалуудыг бүртгэх, зураасан кодын тусламжтайгаар номын сангийн үйлчилгээ, тооллого хийх үйл ажиллагааг автоматжуулах, номын сантай холбоотой төрөл бүрийн тайлан, статистик мэдээллээр бүрэн хангах боломжоор хангагдан ажиллаж байна.

Шинэ номын мэдээллийг цахимаар байгууллагын цахим нүүр хуудсаар тогтмол сурталчилж ирсэн. Байгууллагын дотоод сүлжээнд хяналт тавин ажиллаж цахим мэдээллийн танхимд 2 компьютер, хайлтын 1 компьютер нийт 3 компьютероор мэдээлэл лавлагааг тогмол хүргэн ажилласан.
Үндэсний номын сангийн вэб сайтад шинээр Сүхбаатар аймгийн 12 сумдын танилцуулга, номын сангийн мэдээллийг шинээр оруулан ажиллаж байна.

МОНБИБЛИО ПРОГРАММ-ХЭРЭГЖИЛТ ЯВЦ-2019 ОН

Сүхбаатар аймгийн 12 сумдын Монбиблио программын 2019 оны нэгдсэн тайлан, нэгдсэн каталогийн мэдээ, мэдээллийг авч нөөцлөн, 2019 оны байдлаар 12 сумд Монбиблио программын мэдээллээ хугацаанд 100 хувьтай илгээсэн байна.

Баяндэлгэр, Онгон сумын компьютерийн нөөцийг сэргээн форматлаж хэвийн үйл ажиллагаанд оруулан, хэрэглээний программуудыг суулган баркод уншигчийг таниулан, номын санчдын группээр байнга харилцан программын холбогдолтой мэдээлэл зөвлөгөөг тогтмол өгөн ажиллаж ирсэн.

НАЙМ. АРГАЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.1. Номын санчдад аргазүйн зөвлөлгөөг амаар болон биечлэн хүргэсэн байдал

Хөдөө орон нутгийн номын санчдад аргазүйн зөвлөгөөг тогтмол өгч дотоод групп чат, номын санчдын нүүр номоор дамжуулан цахимаар болон утсаар тогтмол өгч хамтран ажиллаж ирсэн.

Мөн "Өвөг дээдсээс авснаа үр хойчдоо уламжилъя" төслийн хүрээнд бүх номын санч нар харилцан туршлага солилцож, бие биенийхээ үйл ажиллагааг өөрийн биеэр үзэж танилцах боломж бүрдэж, номын сангуудын үйл ажиллагаа сайжирч, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн.

8.2. Номын санд томилолтоор явж туршлага судалсан, аргазүйн туслалцаа үзүүлсэн болон дүн шинжилгээ хийсэн байдал (тоо, сэдэв, үр дүн).

Улаанбаатар хотын номын санд туршлага судалсан. Тус номын сангийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх танхимын номын санчидтай холбоо тогтоож хамтран ажиллаж өөрийн номын сан дээр зохион байгуулагдсан 5 хоногийн сургалтад идэвхтэй хамрагдан ажилласан. Мөн арга зүйч Долгорсүрэн нараас мэргэжлийн чиглэлээр зөвлөгөө байнга авч өөрийн мэдсэн зүйлээ хөдөө орон нутгийн номын санчидтай байнга мэдээллээ солилцон ажиллаж байна.

Аймгийн Нийтийн номын сангаас мэргэжил заах арга зүйн удирдлагаар хангаж, зөвлөн туслах үйл ажиллагааг номын санч Т. Чандмань, В. Энхтуяа нар явуулж, заавар зөвлөгөө өгч ажилласнаар номын санчдын мэргэжил, ур чадвар дээшилсэн.

8.5. Номын санчдад зориулсан сургалт семинар зохион байгуулсан байдал.
Өөрийн номын сан дээр болж байгаа сургалт семинарын үеэр хариуцсан ажил үйлчилгээнийхээ талаар слайд бэлтгэн мэдээлэл өгч ажиллаж байна.



2019.05.07-нд "Номын сангийн шинэлэг үйлчилгээ, түүнийг хэрэгжүүлэх нь" сэдэвт номын санчдын нэгдсэн сургалтыг зохион байгуулахад УБХНТНС-ийн хөтөлбөрийн ажилтан Б. Шүрэнбагана, номзүйч О.Долгорсүрэн нар хичээл зааж, нийт төв, хөдөөгийн 25 номын санч оролцсон.

“Номын сангийн үйл ажиллагааны тайлан боловсруулах аргазүйн зөвлөмж” сэдэвт онлайн сургалтанд номын санч Т. Чандмань хамрагдаж, номын санчдын нэгдсэн сургалтан дээр уг сургалтыг өгсөн.

8.6. Мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн байдал

Үндэсний номын сангаас эрхлэн гаргадаг “Номын санч” сэтгүүлд байгууллагаас зохион байгуулсан болон өөрийн танхимаас шинэлэг ажлуудаа бэлтгэн явуулсан.

Өвөг дээдсээс авсанаа үр хойчдоо өвлүүлэн үлдээе-Номын санчдын аялан тоглолт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн төсөл

Сонсголын бэрхшээлтэй иргэдийн “Бид чадна” хөтөлбөрт сургалт гэх мэт....

ЕС. ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

9.1. Номын сангийн хүний нөөцийн өнөөгийн байдал, хангалт (Номын сангийн орон тооны ажилтны тоо, номын санчийн тоо, мэргэжлийн боловсон хүчний тоо /бүрдэлт/-ийг судалгаанд үндэслэж гаргасан байдал)

9.2**.** Хүний нөөцийг чадавхижуулсан байдал (сургалт, семинар, урамшуулал)

Байгууллагын албан хаагчдын мэдлэг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, чадавхийг нь сайжруулах чиглэлээр төрөл бүрийн сургалтуудад хамруулж, ажилчдын ур чадварыг дээшлүүлэн ажиллаж ирсэн.
2019 оны 03 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд Д.Нацагдоржийн нэрэмжит хотын Нийтийн төв номын сангийн үйл ажиллагаатай танилцах, туршлага солилцох зорилгоор төв, хөдөөгийн номын санчид Үндэсний Төв номын сан, Хүүхдийн номын ордонгийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судлаад ирсэн бөгөөд хамтын ажиллагааны санамж бичиг гарын үсэг зурж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна

Жаахан шарга театр, Угсаатны зүйн музейтэй хамтран Сүхбаатар аймгийнхаа "МАНЛАЙЛАГЧ САЛБАР" болох зорилт дэвшүүлэн "Угийн бичиг хөтлөх" сургалтыг зохион байгуулж, нийт ажиллагсад хамрагдсан.

Гал түймэр унтраах аврах 15-р ангийн 2-р салаа, ЭХАС, урьдчилан сэргийлэх тасагтай хамтран гал унтраах дадлага сургууль, сургалтанд нийт ажиллагсад

Сүхбаатар аймгийн Соёл урлагийн салбарын удирдах ажилтны сургалтанд захирал Х. Мөнгөн-Өлзий, номын санч Т. Чандмань

Гэр бүл, хүүхэд залуучуудын газраас зохион байгуулсан “Гэр бүлийн зөвлөгч бэлтгэх” сургалтанд номын санч В. Энхтуяа

Сүхбаатар аймгийн хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдийн анхдугаар зөвлөгөөнд номын санч В. Энхтуяа

БОАЖГ-аас зохион байгуулсан “Өөрчлөлтийг өөрөөсөө, хандлагаа өөрчилье” сэдэвт олон нийтийн уулзалт хэлэлцүүлэгт нийт ажиллагсад

Баруун-Урт сумаас зохион байгулсан “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга зам” сургалт

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Нутгийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчдад сургалт”-д захирал Х. Мөнгөн-Өлзий, номын санч Т. Чандмань, В. Энхтуяа

МУ-ын ЗГ-ын хэрэг эрхлэх газар, Удирдлагын академитай хамтран “Стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг төрийн захиргааны байгууллагуудад нэвтрүүлэх, төвлөрлийг сааруулахад төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалтанд захирал Х. Мөнгөн-Өлзий, номын санч Т. Чандмань

Биеийн тамир, спортын хорооноос зохион байгуулсан “Хүн амын бие бялдарын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах аргачлал сургалтанд жолооч Ж. Лханаа нар тус тус хамрагдсан.

“Эх нутаг, өв соёлоо эрхэмлэн дээдэлье” сургалт "-нд бүртгэл мэдээллийн ажилтан М. Нарангэрэл, номын санч Р. Цолмонтуяа

“Нийтийн номын сан арга зүйн төв болох нь" сэдэвт сургалтанд номын санч Т.Чандмань

Аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 01-ний А/248 тоот захирамжийн дагуу “ Нийтийн бүжиг-Эрүүл мэнд” бүжгийн сургалтанд нийт ажиллагсад, Долоо хоног бүрийн хагас сайн өдрийн гүйлтэнд нийт ажиллагсад хамрагдаж байна.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт, Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх “Ажилчдад зориулсан хичээл” –г номын санч Т. Чандмань, “Гэр бүлийн харилцаа” сэдвээр номын санч В. Энхтуяа нар нийт ажиллагсдын дунд явуулсан.



9.3**.** Номын санд ажиллагсдад тулгарч буй бэрхшээл, цаашид авах арга хэмжээний талаар

10. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АСУУДАЛ

Төсвийн тухай шинэ хуулийг мөрдөж ажиллан, байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилтод тулгуурлан төсвийг дунд хугацаагаар төлөвлөн, төсөв болон тодотгосон төсвийн сар, улирлын хуваарийн дагуу үйл ажиллагаагаа явуулсны үр дүнд 92,005,900 төгрөгний санхүүжилт авч, өр авлагагүй ажилласан.

11. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, АРХИВЫН АЖИЛ:

Байгууллагын удирдлагатай үр дүнгийн гэрээг шинэчлэн байгуулж, 2019 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой жилийн ажлын болон сар бүрийн төлөвлөгөө, календарчилсан төлөвлөгөө, тайлан, тушаал, албан бичиг, хөтөлбөр, удирамжийг боловсруулан ажилласан.

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой төлөвлөгөөний биелэлт, тайлан, мэдээг тогтоосон хугацаанд гаргах, тайлагнахад анхаарч, байгууллагын үйл ажиллагааны бичгийн болон статистик тайланг БСУГ болон Үндэсний номын санд тогтоосон хугацаанд гаргаж өгсөн. Сум болон сургуулийн номын санчдын нэгдсэн статистик тайланг аймгуудын мэдээллийн цахим статистик тайланд нэгтгэж байршуулсан. Сар бүрийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, тайлан, статистик мэдээ, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийг тухай бүр нь гаргаж тайлагнасан.

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн стандартанд анхаарч ажиллан, тусгай төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаг ажиллаж, ХШҮ-ийн өгсөн зөвлөмжийн дагуу тушаал болон өргөдөл, ирсэн бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж байна.



Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр А/ тушаал 10, боловсон хүчний холбоотой Б/ тушаал 5-ийг тус тус төлөвлөн гаргаж, байгууллагын үйл ажиллагааны холбоотой 26 албан бичиг боловсруулан холбогдох газарт хүргүүлэн ажиллаж, ирсэн бичиг 45-ийг бүртгэн авч, хариутай албан бичгийн хариуг тогтоосон хугацаанд нь гарган өгсөн байна.

2019 онд улсын архивын үзлэгтэй холбогдуулан тусгай төлөвлөгөө гарган ажиллаж, удирдамжийг байгууллагын удирдлага болон албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг хангаг ажилласан.

Байгууллагын архивт хадгалагдаж буй баримтуудад нягтлан шалгалт хийж, дутууг гүйцээх, нөхөн бүрдүүлэлтээр олж авсан баримтуудыг ялгах, цэгцлэх, үдэж хавтаслах, хаяглах, баримт ашиглалтын болон баталгааны хуудас хийх, баталгаа бичих, дотоод товъёог үйлдэн, байнга болон түр, 70 жил хадгалах дансанд авч бүртгэх ажлыг хийсэн.

Аймгийн Засаг даргын үр дүнгийн гэрээний тусгай захиалгат бүтээгдэхүүнд тусгагдсаны дагуу болон архивын улсын үзлэгтэй холбогдуулан Архивын цахим программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилгоор архивын цахим программыг 300,0 төгрөг /авч суулгуулсан ба бэлтгэл ажлыг хангаж, 250 хуудас байнгын баримтыг скайнердаж оруулаад байна.

БУСАД АЖИЛ:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, аймгийн Засаг даргын А/168 дугаар захирамжийн дагуу “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”- ийг 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулахтай холбогдуулан Аймгийн Нийтийн номын сангийн хамт олон өөрийн эзэмшил газар болон 5-р тойргийн дагуу тарьсан нийт /49 мод / модоо эргэж, ойр орчны хог хаягдлыг цэвэрлэн, шинээр 12 мод, бут суулгаж, Ойжуулалт-Хайлааст ХХК-ын ажилчдаас заавар зөвлөгөө авч ажилласан.

Урин дулаан цаг ирж байгаатай холбогдуулан шар усны үер болон орчны бохирдол үүсэх эрсдлээс сэргийлж, өөрийн хариуцсан газар болох “Мандарваа” цэцэрлэгийн баруун талаас хойшоо аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн зам дагуу орчны хог хаягдлыг цэвэрлэж, хогийг зөөж шатаах арга хэмжээ авч ажилласан. Мөн ХЖТ-ын зүүн талын өөрийн хариуцсан талбайг давхар цэвэрлэж, хог хаягдлыг нь хогийн цэг дээр аваачиж хаясан.

Хог хаягдлын тухай хуулийн 9.4.12,10.2.10-т зааснаар “Аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн эзэмшлийн талбай болон байгууллагаас 50 метр газрын хог хаягдлыг цэвэрлэх үүргийн дагуу өөрийн хариуцсан талбайн хог хаягдлыг цэвэрлэж, тайланг 2019 оны 08 сарын 20-ны өдрийн №38 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулах тухай Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/281 тоот захирамжийн дагуу шувууны үүр 2 ш - ийг хийж, Баруун- Урт сумын ЗДТГ-т хүлээлгэж өгсөн.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙТИЙН
НОМЫН САНГИЙН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

АГУУЛГА:

1. Ерөнхий мэдээлэл
2. Удирдлага зохион байгуулалт
3. Фонд бүрдүүлэлт болон хадгалалт хамгаалалт
4. Каталог, номзүйн үйл ажиллагаа
5. Үйлчилгээ
6. Хүний нөөц
7. Технологи
8. Зөөврийн номын сангийн үйлчилгээ
9. Зурган тайлан

Тайлбар:
Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг дээрх 9 бүлэгт хуваан харуулсан байдал.

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Эрхэм зорилго:

Номын сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, номын санг мэдээллийн төв болгон хөгжүүлэх нь бидний эрхэм зорилго юм.

Номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл:

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь 1948 онд 267 номтойгоор одоогийн Алтанбулаг суманд байгуулагдаж үндэс суурии тавьжээ. 1961 оноос Сүхбаатар суманд Сэлэнгэ аймгийн Төв номын сан, 2009 оноос Сэлэнгэ аймгийн нийтийн номын сан болон өргөжиж 30000 гаруй номтойгоор Захиргаа аж ахуй, Арга зүй мэдээллийн танхим, Гэрээр ном олгох, тогтмол хэвлэлийн уншлагын танхим, Хүүхдийн уншлагийн танхим, Гадаад уншлагын танхим, Номын сангийн фонд, лавлагаа мэдээллийн тасаг гэсэн бүтэц зохион байгуулалттай нийт 18 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.2014 оноос Зөөврийн номын сангийн үйлчилгээг шинээр нэвтрүүлж алслагдсан баг болон албан байгууллагуудад хүрч үйлчилж байна. Нийтийн номын сан нь жилд дунджаар 2700 гаруй уншигчийг шинээр бүртгэн авч давхардсан тоогоор 16000 гаруй ард иргэдэд 21000 гаруй номоор үйлчилгээ үзүүлж байна. Мөн Сэлэнгэ аймгийн Сургуулийн өмнөх боловсрол болон Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд Соёл олон нийтийн ажлыг тогтмол зохион явуулж байна. Үүнд Үндэсний бичиг үсгийн баяр, Эрдмийн баяр, Номын баяр, Дээлтэй монгол хөтөлбөр, Кофет уншлага, Үлгэрээр хүмүүжье, Чихэртэй уншлага зэрэг олон төрлийн ажлуудыг зохион байгуулж байна.

Номын сангийн албан ёсны имейл хаяг: selengenomiinsan@gmail.com

Байгууллагын утасны дугаар: 7036-2169

Номын сангийн захирал: С.Шинэчимэг.

2. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь 2019 онд 18 ажилтантай нийт 203.058,900 төгрөгийн төсөвтэй 6 номын сангийн үйлчилгээний чиглэл, 3 арга зүй мэдээлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж ард иргэдэд ном соёлын үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулж ирлээ. Мөн ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ болон үр дүнгийн гэрээг байгуулж дүгнэлт хийн ажиллав

2019 онд төрийн албаны хуулийн шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ажил үүргийн уялдаа холбоог сайжруулах номын үйлчилгээг иргэн бүрт хүргэх зарчмыг баримтлан ажиллаж албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах, хяналт шинжилгээ үнэлгээг боловсронгуй болгох ажлуудын хийж хэрэгжүүллээ.

Төсвийн ил тод байдлыг ханган шилэн дансны мэдээлэлийг цаг тухайд нь оруулж, төсвийн төсөөлөлийг зохих хууль тогтоомжийн дагуу бодит байдалд нь суурилан боловсруулаад байна. Соёл урлагийн байгууллагуудын өөрийн орлогыг зарцуулах журмын дагуу уншигчдын картын орлого 360.000 төгрөгийг бичиг хэргийн зардалдаа шилжүүлэн зохион байгууллаа.

Дээд шатны байгууллагаас ирсэн цаг үеийн ажлуудад идэвхи санаачлага гарган ажиллаа. Тухайлбал: БСУ-ын газрын 20-75% хямдралтай номын худалдаа, Нээлттэй хаалганы өдөрлөг, Аймгийн засаг даргын нэрэмжит тэмцээн,Эрдэнэт хотод болсон Аймаг нийслэлийн номын сангуудын спортын тэмцээн, Дархан хотод болсон Төвийн бүсийн номын сангуудын ажил мэргэжлийн уралдаан зэрэг томоохон арга хэмжээнүүдэд амжилттай оролцлоо.

Ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэх залуу гэр бүлүүдийг дэмжих хүрээнд аавын 7 хоногийн цалинтай амралт мэргэжил дээшлүүлэх сургалтанд оролцсон залуучуудад 7 хоног, 45 хоногийн цалинтай чөлөөг олгон дэмжлэг үзүүлэн ажиллаа. Мөн тэдний ажиллах таатай орчинг бүрдүүлж тоног төхөөрөмж ажлын байрны орчинг бүрдүүлэн ажиллаа.

2020 онд өөрийн орлогыг нэмэгдүүлэх маркетингийн төлөвлөгөө гарган баталллаа.

3. ФОНД БҮРДҮҮЛЭЛТ БОЛОН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

Номын дохиолол хамгаалалтын системыг сайжруулах ажлын хүрээнд фондонд хадгалагдаж байгаа ганц хувьтай болон шинээр ирсэн номнуудад соронзон ялтсыг байрлуулж дууслаа. Ном сурталчилах бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор санамж өгөх номзүйг бэлтгэн шинэ болон хуучины номоор сэдэвчлэн гаргаж Сүхбаатар сум дахь Мэдээлэл холбооны газар болон Хөдөлмөр халамжийн хэлтэсийн харъяа ахмадын сувилалын ажилтан албан хаагчдад мэдээлэл хийж ажиллаа.

Фондын номын баяжилтыг нэмэгдүүлэх, хүссэн хэмжээндээ эрэлт хэрэгцээгээ хангасан номын бүрдүүлэлт бага байгаа учраас иргэд уншигчидтай хамтран ном хандивын аяныг 3 дахь жилдээ зохион байгуулж номын фондоо нэмэгдүүлж байна. Тус аянд Эдэлгээ,чанарын хувьд уншигч хэрэглэгчид уншиж хэрэглэх боломжтой нийт 46 ширхэг ном цугларлаа, бусдыгаа манлайлж идэвх санаачлага гарган оролцсон ном хандивлагч идэвхтэн уншигчид Г.Хүлэг эрдэнэ номын сангийн гарын бэлэг талархал гардууллаа.

Номын сангийн үйл ажиллагааг сурталчилан таниулах ,олон нийтэд ном уншлагыг дэмжих зорилгоор номтой Сэлэнгэчүүд аяныг Сүхбаатар сумын төмөр замын ажилчдын дунд зохион байгуулан шинэ болон сэдэвчилсэн номын

мэдээлэлийг хийлээ .Сурагч багачуудыг сэтгэх, бичих чадварыг хөгжүүлэх зорилгоор сургамжит өгүүллэг “ Хэн сайн бичих вэ “ уралдааныг ЕБС-ын ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж материалуудыг хүлээн авч шалгаруулж байна.

Сэлэнгэ аймгийн засаг даргын тамгын газар ,Хөдөө аж ахуйн газартай хамтран зохион байгуулсан “ Нутагтаа сайхан амьдаръя ”өрхийн үйлдвэрлэгчдийн чуулга уулзалт ,үзэсгэлэн худалдаанд оролцолц партизаны талбайд “ Атар 60 “ номын үзэсгэлэнг хөдөө аж ахуйн номоор гаргаж иргэдэд танилцууллаа.

Нийтийн номын сангаас зохион байгуулсан Дэлхийн номын өдрийн хүрээнд МЗЭ-ийн шагналт, Утга зохиолын "Алтан Өд" шагналын эзэн Э.Амарзаяатай хийх "Зохиогч-Уншигчид"-ын уулзалтыг тохиолдуулан “ Дэлхийн сонгодогууд “номын үзэсгэлэн гаргаж ЕБС-ын ахлах ангийн сурагчдад танилцууллаа.

“ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСЭГ-ТУСГААР ТОГТНОЛ” уриан дор Зохион байгуулсан бичиг үсгийн баярыг номын санчидтай хамтран зохион байгуулж номын үзэсгэлэн гаргаж номын сангийн үйл ажиллагааг сурталчилан ажиллаа.

“Монголын баримтат өв соёл ” Сэдэвт номын үзэсгэлэнг фондонд хадгалагдаж байгаа ховор ном, судраар гэрээр ном олгох тасагт гаргаж уншигч хэрэглэгчдэд танилцууллаа.

“ Хаадын сан “ сэдэвт алтан ургын хаад, ноёдын талаарх номын үзэсгэлэнг хаадын товч мэдээлэлийн хамт гаргаж уншигч хэрэглэгчдэд суртчиллаа.

Гэрээр ном олгох тасаг болон зөөврийн номын санчдад хэрэгцээт ном ,хэвлэлээр тухай бүрт нь ханган ажиллаж байна. Сэлэнгэ аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгт толь бичиг ,түүх ,танин мэдэхүйн нийт 53 номоор үзэсгэлэн гаргаж иргэдэд үйлчиллээ.

д/д	**Ном олголт**	**Тоо, ширхэг**
1	Гэрээр ном олгох тасаг	350
2	Явуулын номын санч	276
3	Номын үзэсгэлэн	240
4	Ном солилцоо /Алтанбулаг соёлын төв /	3
5	Нийт	869

Сан хөмрөгийн мэдээллийн төрөл	**Тоо ширхэг**	**Үнэ**
Сан хөмрөг нийт	41786	65,783,144 төгрөг
Хэвлэмэл ном	37687	63,721,033 төгрөг

Сонин, сэтгүүл	5613	1,732,700 төгрөг
Цахим хэвлэл	65	329,411төгрөг

Хадгалалт хамгаалалтын талаар чиглэсэн арга хэмжээ:

Сан хөмрөгийн номнуудыг гэмтэхээс хамгаалж фондын өрөөний цонхнуудыг ном, хэвлэлд нарны гэрэл шууд тусахгүй байдлаар хамгаалсан хуулгийг солиж шинэчиллээ.

Нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрмийн 3,2,6-д заасны дагуу ном хэвлэлийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, урагдаж гэмтсэн 36 ширхэг номонд сэлбэн засалт хийв.

Мөн хортон шавьж үүрлэхээс сэргийлэх төрөл бүрийн хор болон ариутгалын хлорамины 2%-ийн уусмалыг бэлтгэн тавиур болон номыг арчиж,ариутган чийгтэй цэвэрлэгээг улиралд нэг удаа хийж байна. Ном хэвлэлийг хуурайшилтаас хамгаалах зорилгоор агаар чийгшүүлэгчийг байнга ажиллуулж байна.

4. КАТАЛОГИ, НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын сангийн номзүйн ажлыг хэрэгжүүлэх, уншигч хэрэглэгчдэд төрөл бүрийн номзүйн лавлагаа мэдээллийг өгөх, католог зохион байгуулах, шинээр ирсэн болон хандиваар ирсэн ном хэвлэлүүдийг данслан, техник ажиллагаа хийн танхимуудад хуваарилах ажлыг хийж хэрэгжүүлэн ажиллаж байна.
Жилийн эцсийн байдлаар шинээр 229 ширхэг 3.707.732 төгрөгний ном худалдан авч, Худалдаагаар 152 ширхэг 2,250,432 ширхэг, Хандиваар 77 ширхэг 1,457,300 төгрөгний номыг дахин үнэлэх журмын дагуу үнэлэн авч нэгбүрчилсэн бүртгэлд бүртгээд байна.
“Орон нутгийн номзүйн бүртгэл”-ын мэдээллийн санг баяжуулан шинэчилж, Сэлэнгэ аймгийн зохиолчдийн намтар номзүй хийн ажиллаа.
Номын санчдын татгалзлын дэвтэрт дүн шинжилгээ хийж нөхөн бүрдүүлэх шаардлагатай ном хэвлэлийн талаар удирдлагад танилцуулан ажиллаа.
МУҮНС-аас хандиваар 20ширхэг ном ирснийг хүлээн авч дансанд бүртгэн танхимуудад хуваарилан ажиллаа.
Үндэсний тогтмол хэвлэлийн Zotero программд 2019 оны 1-4-р улиралын “Сэлэнгийн мэдээ” сонины мэдээллүүдийг шивж нэгдсэн санд хүргүүлэн ажиллаа.
Мөн Аймгуудын бүх сумдын статистик мэдээнүүдийг нэгтгэх зорилгоор Аймаг-Нэгтгэл статистик мэдээг нэгтгэж сумдын бүх номын санчидтай холбогдон мэдээллийг цуглуулж МҮНСанруу явууллаа.
Байгууллагын аргазүйн мэдээллийн цагаар “4 болон 5 зохиогчтой ном тодорхойлох журам”-аар мэдээлэл хийн каталогийн картанд стандартын дагуу

хэрхэн бичилт хийх талаар мэдээлэл өгч, ажиллагсдын “Албан тушаалтны тодорхойлолт”-ыг хамтран ярилцаж шинэчилэн ажиллаа.
Номын санч ажил хүлээн авсантай холбогдуулан номын ээлжит тооллогыг Гэрээр ном олгох танхим, Хүүхдийн уншлагын танхим, фондын номуудад тооллого зохион байгуулав.
Архив бичиг хэргийн ажилтан сургалтанд хамрагдсантай холбогдуулан бичиг хэргийн ажлыг түр хавсарч хийх хугацаанд Able программд нийт 12 бичиг ирсний 6 бичиг нь номын сангийн үйл ажиллагаанд шаардлагатай бичиг байсныг хэвлэн удирдлагад танилцуулан ажилласан. Энэ ажлын хүрээнд жил бүр улс орон даяар зохион байгуулагддаг “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх өдөр”-ийг номын сангийн нийт ажилчид чиглэлийн дагуу үүрэг даалгаврыг биелүүлж идэвхтэй оролцсон. Тус ажлын тайланг бичиж Онцгой байдлын газарт хүргүүлэн ажилласан. Мөн Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан “Саруул ухаанд –Эрүүл бие” сэдэвт ходоодны хавдраас урьдчилан сэргийлэх сургалтанд хамт олноороо идэвхтэй оролцсон.
Төлөвлөгөөт болон тэмдэглэлт баяруудыг тохиолдуулан:
Зэвсэгт хүчний 0243-р ангийн ажилтан албан хаагчдад шинэ болон сэдэвчилсэн номын мэдээлэл хийж, “Сэлэнгэ аймгийн дурсгалт газрууд” сэдвээр мэдээлэл хийн, үйл ажиллагаагаа сурталчлан ажиллаа.

Сэлэнгэ аймаг атар газар эзэмшсэний 60 жилийн ойд зориулан хөдөө аж ахуйн холбогдолтой номуудаар “Өрхийн аж ахуй” сэдэвт сэдэвчилсэн номзүй бэлтгэн гаргаж иргэдэд сурталчлан ажиллаа.
Дэлхийн номын өдрийг тохиолдуулан МЗЭ-ын шагналт, Алтан өд шагналын эзэн хүүхдийн зохиолч Э.Амарзаяагийн номуудаар “Намтар номзүй” бэлтгэн уншигчдад сурталчиллаа.
2019 онд шинээр ирсэн ном хэвлэлүүдийг сурталчлах ажлын хүрээнд “Шинэ номын мэдээ” бэлтгэн уншигчдад сурталчлан ажиллаж байна.
НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухааны байгууллага ЮНЕСКО 1995 онд анх 4-р сарын 23ны өдрийг дэлхий нийтээрээ ном уншихыг сурталчлах, нийтийн уншлагыг дэмжих “Дэлхийн номын өдөр” болгон зарласантай холбогдуулан Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангаас “Зохиолч-Уншигчдын уулзалт”-ыг Ерөнхий боловсролын 6 сургуулийн багш, сурагчдын дунд амжилттай зохион байгууллаа. Тус уулзалтын хүрээнд МЗЭ-ийн шагналт, Утга зохиолын “Алтан өд” шагналын эзэн Э.Амарзаяа зохиолчын номуудыг сурталчилж, сурагчид уншсан зохиолоороо ханын сонин гаргаж, номын талаарх сэтгэгдэлээ хуваалцаж, зохиолчтой санал бодолоо ярилцаж, идэвхтэй оролцсон сурагчдыг шагнаж урамшуулах үйл ажиллагаа боллоо. Зохиолч-Уншигчдын уулзалт Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын танхимд болж, нийт 135 багш, сурагчид оролцож идэвх санаачлагатай оролцлоо.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдлэх, үндэсний бичиг үсгийн баярыг үндэсний хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх, ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх зорилгоор үндэсний бичиг үсгийн баярыг “ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСЭГ-ТУСГААР ТОГТНОЛ” уриан дор Төрийн болон Төрийн бус байгууллагуудын албан хаагчид, Ерөнхий Боловсролын Сургуулиудын багш, сурагчид, иргэдийн дунд “Өв соёл” номын үзэсгэлэн, уралдаан тэмцээн, Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулдаг монгол бичгийн клубуудын үйл ажиллагааг танилцуулан, сурталчилах, монгол бичгийн уран бичлэгийн бүтээлийн үзэсгэлэн зэрэг ажлуудыг Партизаны талбайд зохион байгууллаа.
Тус ажлын хүрээнд нэгдсэн арга хэмжээний хөтөлбөр бэлдэх болон “Алтан хонх” тэмцээнийг хариуцан ажиллаа. Сүхбаатар сумын ЕБСургуулийн ахлах ангийн сурагчдад үйл ажиллагааны утга учир, үнэ цэнэ, үндэсний хэл соёлын түүхэн үйл явдлыг танин мэдүүлэх цар хүрээг нь тэлж оюун ухааныг шалгах зорилгоор “Алтан хонх” тэмцээнийг зохион байгуулж тэргүүн байранд Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 9а ангийн сурагч Б.Энхсүлд шалгарлаа.
Улс орон даяар бүх нийтийг соён гэгээрүүлэх аян өрнүүлсний хүрээнд “Хамтдаа уншицгаая” аяныг аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд уншлагын цаг гарган зохион байгууллаа. Төмөр замын 2 хэлтсийн нийт 70 орчим ажилагсдад шинэ номын мэдээлэл өгч, хамтдаа уншицгаан, номын сангийн үйл ажиллагааг сурталчлан таниулан ажиллаа.
Өөрийгөө хөгжүүлэх болон бусад ажлын хүрээнд:
Аймаг, Хотын нийтийн номын сангуудын номын санч, ажилчид, их дээд сургууль, ЕБС-ийн номын санчдын дунд номын сангийн ажилтан, албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олныг төлөвшүүлэх, болон мэргэжил нэгт нөхөдтэйгөө танилцах хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Монголын номын сангийн консерциум болон Орхон аймгийн номын төв хамтран зохион байгуулсан билээ. Тэмцээн нь: Сагсан бөмбөг, Гар бөмбөг, Олс таталт, Ширээний теннис, Усан поло, Шатар гэсэн 6 төрлөөр явагдаж 16 багийн 190 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин амжилттай оролцлоо.
Тус тэмцээнд Сэлэнгэ аймгийн нийтийн номын сангийн 12 ажилтан баг бүрдүүлэн 6 төрөлд оролцож “Усан поло” тэмцээнд тэргүүн байр, Шатрын төрөлд 4-р байр, “Олс таталт”-ын төрөлд 4-р байр эзлэн амжилттай оролцлоо.
Өөрийн мэдлэг мэдээллийг дээшлүүлж, сурч хөгжихийн тулд мэргэжлийн болон шинээр хэвлэгдэн гарсан ном хэвлэлийг уншиж судлан өөрийгөө хөгжүүлэн ажиллаж байна.
Номын санчдын ярих ур чадварыг дээшлүүлэх хөгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан илтгэлийн тэмцээнд “Номын сангийн номзүйн үйлчилгээ ба үндсэн зарчмууд” сэдвээр илтгэл бэлтгэж амжилттай оролцлоо.

Төвийн бүсийн Дархан, Эрдэнэт, Булган аймгийн номын сангуудын ажилчдын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлж, туршлага солилцох ажлын хүрээнд зохион байгуулагдсан “Хамтдаа хөгжье” илтгэл, урлагын тэмцээнд амжилттай оролцон байгууллагаараа 3-р байранд орж амжилт үзүүллээ.
“Ээлтэй үйлчилгээ иргэн таньд” нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож Номын сангийн үйлчилгээг иргэдэд танилцуулж, карт нээх үйлчилгээ үзүүлэн ажиллаа.
Koica олон улсын байгууллага болон Боловсрол соёл урлагын газраас хамтран зохион байгуулсан комьпютерийн сургалтанд хамрагдаж photoshop программ ашиглаж сурах, мөн арван хуруугаар түргэн зөв бичиж сурах талаарх сургалтуудад хамрагдлаа. Сургалтын хугацаанд сурч мэдсэн зүйлээ шалгуулах уралдаанд:
Photoshop ‘программын шалгалтанд
1-р байр Б.Мэргэнбаяр
2-р байр М.Орхон
3-р байр Б.Цолмонбаатар
10 хуруугаар зөв, хурдан бичих уралдаанд:
1-р байр М.Орхон
2-р байр Ц.Гэрэлцэцэг
3-р байр Б.Мэргэнбаяр нар амжилттай оролцож дурсгалын зүйлсээр шагнууллаа.

5. ҮЙЛЧИЛГЭЭ

Уншигчдийн хүрээг тэлэх, ном олголтын хүртээмж нэмэгдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, соёл олон нийтийн ажлыг тогтмол явуулах зорилго тавин ажиллаа.

Уншлага үйлчилгээ

2019 оны жилийн эцэст 2089 шинэ уншигч, 13048 ирэгсдэд 23371 ширхэг ном хэвлэлээр үйлчиллээ. Уншигчдад өдөр тутмын тогтмол хэвлэл болон шинэ мэдээ мэдээллээр үйлчилж байна.

Номын сангийн өдөр тутмын бүртгэл, сонин сэтгүүлийн бүртгэлүүдийг стандартын дагуу бүртгэж, өгөгдсөн номзүй мэдээг 245 хэрэглэгчдэд лавлагаа өгч, номын татгалзлын дэвтэрт 43 номын санал бүртгэлээ.

Нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрмийн 3.2.6-д заасны дагуу ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор, урагдаж гэмтсэн 586 ширхэг номыг сэлбэн засаж үйлчилсэн.

Өдөр тутмын бүртгэл, өгөгдсөн номзүйн бүртгэл, номын татгалзлын бүртгэл, үндсэн фондтой харилцах бүртгэл, сонин сэтгүүлийн бүртгэл, ээлж хүлээлцэх дэвтэр, ном сэлбэн засалтын дэвтэр гэсэн бүртгэлүүдийг цаг тухайд нь бүртгэж ажилласан

Уншигчдын эрэлт хэрэгцээг судалж уншигчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Уншигчдын сонирхол, орчин нөхцөл”-ийн талаар судалгаа хийв.

Танхимуудын тавиурт байрлах номуудад соронзон ялтас наах ажлыг тогтмол хийж байна.

Ном хандивлах аяны хүрээнд Гадаад хэлний багш Анхтуяа багш үлгэрийн болон танин мэдэхүйн номууд хандивлалаа.

Албан тушаалын тодорхойлолтыг аргазүйн зөвлөгөөнөөр шинэчлэн боловсруулж, хувийн бичиг баримтын хавтсанд байх бичиг баримтуудыг бүрдүүлэн ажиллаа.

Ажиллагсад бүр хөтлөх хэргийн нэрийн жагсаалт гарган ажлаа төлөвлөн, төлөвлөгөөний дагуу ажлуудаа хийж гүйцэтгэн, хувийн зохион байгуулалтандаа анхаарч бичиг хэргийн хавтаснуудыг шинэчлэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ:

Сургуулийн өмнөх ахлах, дунд, бэлтгэл, ангийн хүүхэд багачуудын дунд “Үлгэрээр хүмүүжье” чанга уншлагыг Сүхбаатар сумын Улсын тэргүүний 3-р цэцэрлэгийн Анхтуяа, Ундраа багштай ахлах бүлэг , 4-р цэцэрлэгийн бага бүлэг болон ахлах бүлгийн хүүхдүүд, Төмөр замын Бужинхэн цэцэрлэгийн Болормаа Бүрэнцэцэг багштай ахлах бүлгийн хүүхдүүдийн дунд зохион явууллаа. Энэхүү уншлаганд нийт 250 гаруй хүүхэд багачууд хамрагдсан.

Уншлагын үеэр зохиогдсон ажлууд:

- ✓ Сургамжит үлгэрийг чанга хэлбэрээр уншиж өгөх
- ✓ Үлгэрээс юуг ойлгосноо ярилцах, зурах
- ✓ Зурагт болон хайлтын номыг сурталчилах

Соёл олон нийтийн ажлын хүрээнд Уламжлал болгон зохион байгуулдаг “Дээлтэй монгол өдөрлөг”-ийн хүрээнд Сүхбаатар сумын ЕБС-ийн 6-7-р ангийн

сурагчдын дунд "Монгол ёс заншил" гар зургийн уралдаан зарлаж 20 хүүхдийн зураг хүлээн авсанаас
1-р байранд 4-р сургуулийн 6/а/ангийн сурагч Б.Уянга / Сар шинийн баяр /
2-р байранд 2-р сургуулийн 6/а/ ангийн сурагч Г.Өнөржаргал /Монгол нүүдэл/
3-р байранд 4-р сургуулийн 6/а/ ангийн сурагч Э.Номин /Жаргалтай хос / хүүхдүүд шалгарч хүүхэд тус бүрт өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулав.
Эмэгтэйчүүдийн баяр, цэргийн баярыг тохиолдуулан Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд "Миний гэр бүл миний ертөнц" сэдэвт эсээ бичлэгийн уралдаан зохион байгууллаа. 1-р байранд 2-р сургуулийн 10 а ангийн сурагч Э.Ану, 2-р байранд 1-р сургуулийн 11 б ангийн сурагч Б.Номин, 3-р байранд 2-р сургуулийн 10 б ангийн сурагч Г.Түмэндэмбэрэл нар тус тус байр эзэлсэн.

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Ерөнхий боловсролын сургуулиудын 6-12 ангийн сурагчдын дунд "Ус бол чандмань эрдэнэ" сургамжит өгүүллэгийн уралдаан зохион байгуулж 30 гаруй сурагчид сургамжит өгүүллэг ирүүлснээс Тэргүүн байранд Улсын тэргүүний 1-р сургуулийн 9а ангийн сурагч Б.Энхбаяр шалгарсан.

Дэлхийн яруу найргын өдрийг тохиолдуулан Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон иргэд олон нийтийг хамарсан "ЯРУУ НАЙРГИЙН УЯНГА" уулзалт өдөрлөг болж 9 сурагч оролцож уран уншлага, өөрийн шүлгээс уншиж сонирхуулж, санал сэтгэгдлээ солилцон ярилцав.

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан, Аймгийн Засаг Даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, соёл, урлагийн газар хамтран Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдлэх, үндэсний бичиг үсгийн баярыг үндэсний хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх, ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх зорилгоор үндэсний бичиг үсгийн баярыг "ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСЭГ-ТУСГААР ТОГТНОЛ" уриан дор 05 сарын 04-ны өдөр Төрийн болон Төрийн бус байгууллагуудын албан хаагчид, Ерөнхий Боловсролын Сургуулиудын багш, сурагчид, иргэдийн дунд "Өв соёл" номын үзэсгэлэн, уралдаан тэмцээн, Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулдаг монгол бичгийн клубуудын үйл ажиллагааг танилцуулан, сурталчилах, монгол бичгийн уран бичлэгийн бүтээлийн үзэсгэлэн худалдаа зэрэг ажлуудыг Партизаны талбайд зохион байгууллаа.
Энэ жилийн үндэсний бичиг үсгийн баярыг өргөн хүрээ хамруулах зорилгоор Сэлэнгэ аймгийн Засаг даргын харьяа агентлагууд болон аж ахуйн нэгж байгууллагуудын дунд "Үндэсний бичиг үсэг, өв соёлоо эрхэмлэгч байгууллага" шалгаруулах аянг

- Байгууллагынхаа ажилчдын дунд монгол бичгийн сургалт зохион байгуулах

- Байгууллагынхаа хаягыг монгол бичгээр болгох
- “Миний нэрийн хуудас” шалгаруулах уралдаан зохион байгуулах
- Байгууллагынхаа зөв, цэвэр бичигтэн шалгаруулах
- Байгууллагынхаа тод, түргэн уншигчийг шалгаруулах зэрэг ажлуудаар

зохион байгууллаа. Уг аянд

1. Сэлэнгэ аймгийн Прокурорын газар
2. Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн тамгын газар
3. Мэдээлэл холбоо сүлжээ ХХК
4. Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар
5. Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс
6. Мэргэжлийн хяналтын газар
7. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
8. Хаан банкны Сэлэнгэ аймаг дахь төв салбар
9. Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэртэс
10. Хөдөмөр халамжийн үйлчилгээний хэлтэс
11. Хилийн 0101-р анги
12. Улсын тэргүүний 1-р сургууль
13. Улсын тэргүүний 2-р сургууль
14. Ерөнхий боловсролын 3-р сургууль
15. Ерөнхий боловсролын 6-р сургуулвь
16. Сүхбаатар сумын 3-р цэцэрлэг зэрэг төрийн болон аж ахуйн нэгж байгууллагууд

идэвхи санаачлагатай оролцож

1-р байранд Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн тамгын газар

2-р байранд Хилийн 0101-р анги

3-р байранд Нийгмийн даатгалын хэлтэс

4-р байранд Сүхбаатар сумын Улсын тэргүүний 1-р сургууль

5-р байранд Сэлэнгэ аймгийн Прокурорын газар тус тус шалгарлаа.

Нэгдсэн арга хэмжээгээр Улсын тэргүүний 2-р сургуулийн Л.Одгэрэл багштай 4а анги, Б.Уранчимэг багштай 4б анги, А.Эрдэнэзул багштай 5а анги, С.Дуламсүрэн багштай 5б ангийн сурагчид Бямбын Ринчиний “Монгол хэл” шүлгийг уран уншлагаар уншиж сонордуулан, Б.Амарсайхан багштай “Таван хан” морин хуурын хамтлаг аялгуут эгшгээр мэндчилгээ дэвшүүлэв. Мөн хүрэлцэн ирсэн албан хаагчид, сурагчид, иргэдийн дунд удирдамжийн дагуу зохион байгуулсан ажлуудад

- “Шилдэг үндэсний өв тээгч” буюу зөв цэвэр бичигтнээр Улсын тэргүүний 2-р сургуулийн 12-р ангийн сурагч Н.Хатан-Эрдэнэ
- “Шилдэг үндэсний бичиг үсгийг сонордуулагч” буюу түргэн, тод уншигчаар Улсын тэргүүний 4-р сургуулийн 12-р ангийн сурагч Б.Амина

- “Шилдэг үндэсний соёлын өвийг түгээгч”-ээр Улсын тэргүүний 4-р сургуулийн Монгол бичгийн багш Алтанхүү нар тус тус шалгарлаа.

Үндэсний бичиг үсгийн баярын нэгдсэн арга хэмжээний үеэр уран уншлага, яруу найргийн уралдаан тэмцээнд идэвхитэй оролцдог, ном унших дуртай идэвхтэн уншигчид болох Улсын тэргүүний 1-р сургуулийн 12б ангийн сурагч Б.Баярмаа, Улсын тэргүүний 2-р сургуулийн 12а ангийн сурагч Б.Барсболд, Улсын тэргүүний 4-р сургуулийн 3а ангийн сурагч Б.Нарангүнж, Улсын тэргүүний 2-р сургуулийн 3-р ангийн сурагч Т.Хулан нарыг "Тэргүүний уншигч" Д.Нацагдорж тэмдэгтээр шагнаж урамшууллаа.

Залуу гэр бүлийг дэмжих зорилгоор зохион байгуулдаг “Гэр бүл”-ийн уншлаганд уншигч 1-р сургуулийн 1/а/ ангийн сурагч Н.Аминаа ээж дүүгийн хамт , 4-р цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн Н.Цогдэлгэр эмээ өвөөгийн хамт, 2-р сургуулийн 2/а/ ангийн сурагч Ц.Цогтбаяр ээжийн хамт гэр бүлийн уншлаганд хүрэлцэн ирж оролцлоо.

Хүүхэд багачуудад залуу зохиолчийн уран бүтээлийг нь сурталчилан таниулах зорилгоор “Ном унших”- аянг гэрээр ном олгох нийтийн уншлагын танхимтай хамтран Хүүхдийн зохиолч Э.Амарзаяа зохиолчийн ахлах дунд ангийн сурагчдад зориулсан тууж өгүүллэгийн номоор 1-р сургуулийн номын санчтай хамтран зохион байгуулж уншлаганд 100 гаруй хүүхдэд номын уншлага, явуулав.

Өсвөр үе хүүхэд багачуудын дунд усаа хайрлан хамгаалах усаа хэмнэхийн ач тусыг мэдрүүлэх, тэднээр дамжуулан бусдадаа бодол санаагаа илэрхийлэх, Дэлхийн усны өдрийг тохиолдуулан “Ус бол чандмань эрдэнэ” сургамжит өгүүллэгийн ЕБС- ийн 5-7 ангийн дунд зохион байгуулж:
1-р сургуулийн 7/б/ ангийн сурагч Б.Мөнх-Учрал тэргүүлж өргөмжлөл дурсгалын зүйлээр шагнаж урамшуулав.

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Сүхбаатар сумын ЕБС-ийн ахлах дунд ангийн сурагчдын дунд МЗЭ-ийн шагнал, утга зохиолын “Алтан өд “ шагналт Э.Амарзаяатай “Зохиолч-Уншигчдын уулзалт”-ыг Аймгийн тамгын газрын хурлын танхимд зохион байгуулав. Уулзалтаар:

- Зохиолчийн намтар уран бүтээлийн танилцуулга
- Гадаад монголын зохиолчдын номын үзэсгэлэн
- Зохиолчийн уран бүтээлээр 6-12 ангийн хүүхдийн дунд ханын зурагт хуудас
- Зохиогчийн уран бүтээлийн дурсамж яриа
- Хүүхдүүд зохиолчийн уншсан номныхоо тухай бусдадаа ярих
- Асуулт , хариулт зэрэг үйл ажиллагааг зохион байгуулав.

“Оюунлаг, бүтээлч ирээдүйн төлөө “уриатай хүүхэд багачуудын зуны амралтанд зориулж хоёр дахь жилдээ зохион байгуулж байгаа “Ном бүтээлчээр

унших тэмдэглэл хөтлөх дугуйлангийн 1-р ээлж 06 сарын 17-наас 07сарын 05-ны өдөр хүртэл, 2-р ээлж 08 сарын 05-наас 08 сарын 16-ны хүртэл зохион ерөнхий боловсролын 1-5-р ангийн нийт 15 хүүхэд хамрагдсан. Монголын уран зохиол болон дэлхийн сонгодог зохиолуудыг уншиж тэр улсын ертөнцөөр аялж, мөн үе тэнгийн найзууддаа үлгэр дууриалал үзүүлэх зөв иргэн болгон хүмүүжүүлэхэд туслах зорилготой. Нийт 19 удаа дугуйланг зохион байгуулж амжилттай оролцсон хүүхэд багачуудыг Алтанбулаг суманд байрлах Аймгийн музей, Оргидог булагтай танилцуулж, дугуйланд хамрагдсан хүүхэд багачууддаа талархал хадгалуулав. Дугуйлангаар:

- Монгол ардын үлгэрүүд
- Тал нутгийг эзэгнэгч
- Сэцэн хатан
- Эхнэр үсний домог,
- Хорвоотой танилцсан түүх
- Аав цэцэрлэгт орсон нь
- Найзынхаа эрхэм чанарыг таньсан хаан
- Өвгөн бар хоёр
- Тольстойн үлгэрүүд, дэлхийн сонгодог зохиолууд,
- Х.К. Андерсний үлгэрүүдээр номын уншлага зохион байгуулав.

Мөн хамтран унших, өөрсдөө бие даан унших, гэртээ бие даан нэг ном унших, тэмдэглэл хөтөлж зураг зурах, өөрсдөө үлгэр зохиох, дүрийн тоглолт хийх, чөлөөт цагаараа хэл зүгшрүүлэх,түргэн хэллэг, АХА тэмцээн, үг бүтээх, хэн хурдан унших бэ?, зэрэг хөгжөөнт тэмцээнүүдийг зохион дугуйлангаараа ватум цаасан дээр уншсан номын баатруудыг зурж будсан.
Эрдмийн баяр нэгдсэн арга хэмжээний хүрээнд Ерөнхий боловсролын 6-р сургуулийн сурагчдын дунд тоог үсгээр орлуулах хөгжөөнт тэмцээнийг ГНОТ-тай хамтран зохион байгуулсан. Энэхүү тэмцээнд авьяас чадвар, хурд хүч, авхаалж самбаагаараа бусдыгаа манлайлан ЕБС-ийн 6-р ангийн сурагч Мөнхбаяр тэргүүн байранд шалгарсан.

“Уншаад хуваалцъя” уншлагын цагийг ЕБС-ийн 3-5-р ангийн сурагчдыг хамруулан явуулж байна. Энэхүү уншлага баасан гараг бүрийн 15:00 цагаас зохион явагдаж байна. Уншлагын хүрээнд монгол ардын үлгэрийн ном, богино өгүүллэг, сонгодог үлгэрүүдээс чанга уншлага, номын тэмдэглэл, уншсан номын талаар ярилцаж тэмдэглэл хөтөлх зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулдаг. Нийт 3 удаагийн уншлаганд давхардсан тоогоор 30 хүүхэд хамрагдсан байна.

Шаамар, Дулаанхаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Оюуны хүлэг” танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулсан. Энэхүү тэмцээнд авьяас чадвар, хурд хүч, авхаалж самбаагаараа бусдыгаа манлайлан ЕБС-ийн 6-р ангийн сурагч Анужин, Хонгорзул нар тэргүүн байранд шалгарсан.

БСУГ 60 жилийн нэгдсэн арга хэмжээний хүрээнд Гэрээр ном олгох нийтийн уншлагын танхимтай хамтран “Номын солилцоо”-г зохион байгуулж 2 хүн оролцож номоо солилцсон.

2-р сургуулийн 3 б ангийн хамт олон ангийн багшийн хамт номын сантай танилцах, номын сангийн дүрэм журмын талаар мэдэх зорилгоор номын сантай танилцах аялал зохион байгуулсан. Энэхүү аялалын хүрээнд сурагчдад шинэ уншигчийн карт нээх, номын сангийн дүрэм журмыг танилцуулах, ном уншихын сайхан чанаруудыг мэдрүүлэх гэх мэтчилэн ажлуудыг зохион байгуулсан.

Улс орон даяар бүх нийтийг соён гэгээрүүлэх аян өрнүүлсний хүрээнд “Хамтдаа уншицгаая” аяныг аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд уншлагын цаг гарган зохион байгууллаа. Энэхүү уншлаганд нийт 7 байгууллагын 262 албан хаагч оролцсон. Номын сангийн үйл ажиллагааг танилцуулах, уншигчийн карт нээх, номын уншлага гэсэн ажлуудыг зохион байгуулсан.

ОУХТ-д худалдаа эрхлэгч болон иргэдэд номын сангийн үйлчилгээг ойртуулж, Зөөврын номын сангийн үйлчилгээг хүргэн ажилласан. 7 хоногийн хугацаанд нийт 20 худалдаа эрхлэгч, 21 иргэд, 13 хүүхдэд уншигчийн карт нээсэн. Үүнээс 10 тэтгэврийн насны иргэдэд үнэгүй карт нээн үйлчилгээ үзүүллээ.

“ Ээлтэй үйлчилгээ иргэн танд” нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож Төрийн болон төрийн бус байгууллагуудын ажиллагсдад номын сангийн үйлчилгээ үзүүлэн, номын үзэсгэлэн гарган ажиллаа.

Сар бүр уламжлал болгон зохион явуулж байгаа “Кофет уншлага”-г жилийн хугацаанд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион явуулж тодорхой сэдвийн хүрээнд чөлөөт ярилцлаа. Энэхүү уншлаганд 50 гаруй сурагч хамрагдаж өөрийгөө илэрхийлэх, ярих чадвараа хөгжүүлэх, бүтээлчээр ном унших арга барилд суралцлаа.

3-р цэцэрлэгийн багш, ажилчдад шинэ номын мэдээлэл хийж, уншигчийн карт нээн номоор үйлчилсэн.

Монгол улсын эрүүл мэндийн өдрийг тохиолдуулан “Эрүүл мэндээ хамгаалахуй” элэг зүрхнй өвчлөлийн талаар мэдээлэл бэлтгэж уншигч, үйлчлүүлэгчдэд танилцууллаа.

Аавуудын баярыг угтаж “Аав, ээж, би” уралдаант өдөрлөг зохион байгуулсан.

Номын үзэсгэлэн гаргасан тоон үзүүлэлт

д/д	Үзэсгэлэнгийн нэр	Үзэсгэлэнд дэлгэгдсэн номын	Үзэсгэлэнд

		тоо	хамрагдсан сурагчид
1	Монгол үлгэр домог	17	461
2	Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Зохиогч-Уншигчд"-ын уулзалтанд "Гадаад зохиолчдын "номын үзэсгэлэн	40	120
3	Х.К.Андерсений уран бүтээлийн үзэсгэлэн	15	100
4	Цэргийн баярт зориулан "Эх орон "сэдэвт номын үзэсгэлэн	26	140
5	Дэлхийн номын өдөрөөр Ном унших аяны хүрээнд "Монголын зохиолчдын номын үзэсгэлэн	23	100
6	Ном унших аяны хүрээнд МЗЭ-ийн шагналт Хүүхдийн зохиолч Э.Амарзаяа зохиогчийн уран бүтээл, болон монгол зохиолчдын номын үзэсгэлэн	60	134
7	"Зуны уншлага "- ЕБС-ийн заавал унших номын үзэсгэлэн	12	300
8	Эрдмийн баяр нэгдсэн арга хэмжээнд зориулж "Шинэ номын үзэсгэлэн	17	400
9	Зуны хөтөлбөрийн сурагчдын хийсэн бүтээлийн үзэсгэлэн	40	120
10	Шинэ номын үзэсгэлэн	25	200
11	"Сонгодог зохиол " номын үзэсгэлэн	20	154
12	Дэлхийн хөгжмийн өдрийг тохиолдуулан "Хөгжмийн боловсрол" номын үзэсгэлэн	17	150
13	Багш нарын баярыг тохиолдуулан "Монгол сурган хүмүүжүүлэх ухаан" номын үзэсгэлэн	18	120
14	Сүхбаатар сумын "Нээлттэй хаалга"-ны өдөрлөгийн номын үзэсгэлэн	29	200
15	Комик номын үзэсгэлэн	24	100
16	"Монгол ардын үлгэр	18	110
17	"Монгол ёс заншлын хэлхээ" номын үзэсгэлэн	26	88
18	Ардын жанжин " номын үзэсгэлэн	16	89
19	Өөрийгөө хөгжүүлэхүй" номын	19	90

	үзэсгэлэн		
20	“Шинэ ном”-ын үзэсгэлэн	34	70
21	“Монгол хэл, соёл” номын үзэсгэлэн	21	65
22	“ Бид мартахгүй” номын үзэсгэлэн	27	72
23	“Бүсгүйчүүд гоо сайхан, эрүүл мэнд, хөгжил” сэдвээр номын үзэсгэлэн	22	82
24	“Яруу найргын уянга” номын үзэсгэлэн	37	81
25	“Эрүүл мэндээ хамгаалахуй” номын үзэсгэлэн	30	94
26	“Оросын зохиолчид”-ын номын үзэсгэлэн	33	65
27	Элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлдэгчдэд зориулсан номын үзэсгэлэн	18	63
28	МЗЭ-ийн шагналт Хүүхдийн зохиолч Э.Амарзаяагийн номын үзэсгэлэн	12	120
29	“Монголын болон гадаадын” зохиолчдын номын үзэсгэлэн	75	100
30	Гэр бүлээ эрхэмнэлэхүй” номын үзэсгэлэн	20	73
31	“Өв соёл ба Монголын музей” номын үзэсгэлэн	25	85
32	“Хэн намайг ийм болгов, хэн намайг эмчлэв” урагдаж гэмтсэн номын үзэсгэлэн	30	89
33	Хүний эрх ба Хүүхдийн эрх” номын үзэсгэлэн	31	69
34	Шинэ номын үзэсгэлэн	30	98
35	“Төрийн байгууллага ба иргэд”	33	100
36	Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтсийн Статистикийн ном, томхимолын үзэсгэлэн	61	99
37	Монгол бахархал номын үзэсгэлэн	17	84
38	Хонхны дуу номын үзэсгэлэн	19	78
39	Би байгальдаа хайртай	16	83
40	Тариаланчдад өгөх зөвөлгөө номын үзэсгэлэн	22	98
41	Шинэ номын үзэсгэлэн	29	400
42	Намтар зохиолчын номын үзэсгэлэн	18	63

43	“Дэлхийн сонгодог зохиол” номын үзэсгэлэн	14	82
44	“Номтой нөхөрлөцгөөе” номын үзэсгэлэн	45	150
45	“Соёлын довтолгоо” номын үзэсгэлэн	15	78
46	“Хөгжмийн боловсрол” номын үзэсгэлэн	24	92
47	Шинэ номын үзэсгэлэн	25	97
48	“Дархлаагаа сайжруулъя” эрүүл мэндийн номын үзэсгэлэн	19	56
	Нийт	1264	5962

Соёл олон нийтийн ажлын тоон үзүүлэлт

д/д	**Соёл олон нийтийн ажлын нэр**	**Хамрагдсан оролцогчид**		**Зарцуулсан төсөв**	**Зохион байгуулсан огноо**
		Бүртгэлтэй	**Бүртгэлгүй**		
1	“Монгол ёс заншил” гар зураг, бүтээлийн уралдаан	20		5000	2019.02.15-2019.02.28
	“Кофет уншлага	50		15000	2019.02.01-2019.06.30
2	“Миний гэр бүл миний ертөнц” сэдэвт эсээ бичлэгийн уралдаан	25		10000	2019.03.13-2019.03.29
3	“Ус бол чандмань эрдэнэ” сургамжит өгүүллэгийн уралдаан	25		5000	2019.03.13-2019.04.01
4	“ЯРУУ НАЙРГИЙН УЯНГА” уулзалт өдөрлөг	10		3000	2019.03.22
7	Зохиогч-Уншигчдын уулзалт	40	70	100,000	2019.04.22
8	Үндэсний бичиг үсгийн баяр “Түргэн тод уншигч”, “Зөв цэвэр бичигтэн” уралдаан		12	30000	2019.05.06
9	Эх үрсийн баяр		30	5000	2019.06.01
10	“Аав, ээж, би”		15	1400	2019.06.08
11	“Оюунлаг, бүтээлч ирээдүйн төлөө “ уриатай зуны хөтөлбөр	25	25	1000	2019.06.18-2019.07.06

12	Эрдмийн баярын хүрээнд “Тоог үгээр орлуулах тэмцээн”		20	7000	2019-09-01
13	БСУГ-ын 60 жил нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Номын солилцоо”	1	1	4000	2019-09-17
14	“Хамтдаа уншъя” 30 минутын уншлага	10	200	1000	2019-10-07 2019-10-08 2019-10-14 2019-10-17
15	ОУХТ-ын худалдаа эрхлэгчдэд зориулан “Номын амталгаа” өдөрлөг	314	917	79800	2019-10-17
16	“Үлгэрээр хүмүүжье” чанга уншлага		174	2000	2019.2.26 2019.4.22 2019.9,23 2019.10,14 2019.10,21
17	“Монгол ёс заншил”гар зургийн уралдаан	20		5000	2019.2.28
18	“Ус бол чандмань эрдэнэ”сургамжит өгүүллэг	20	5	5000	2019.03.29
19	Гэр бүлийн уншлага	5	5	1000	2019.1.10,11,12 2019.09.15 2019.10,15
20	Уншигч-Зохиолчдын уулзалт	40	70	9000	2019.4.22
21	Ном унших аян		100	1000	2019.03.13
22	Улиралын идэвхтэн уншигч	1			2019.4.23
23	Үндэсний бичиг үсгийн баяр	50	50	330000	2019.05.01
24	“Зуны хөтөлбөр”-ийн Номыг бүтээлчээр унших, тэмдэглэл хөтлөх дугуйлан 1,2-р ээлж	5	10	5000	2019.06-17- наас 07.05
25	ЕБС-ийн 6-р сургуулийн сурагчдын дунд “Тоог үсгээр орлуулах” хөгжөөнт тэмцээн	20		7000	2019,09,01
26	Шаамар Дулаанхаан тосгоны ЕБС-ийн 5-7-р ангийн сурагчдын дунд “Оюуны хүлэг” морь уралдах тэмцээн		10	2000	2019.09,11
27	“Уншаад хуваалцъя” уншлагын цаг	15	3	500	2019,09,27 2019.10.15
28	Сэлэнгэ аймгийн ЕБС-ийн 2-р сургуулийн 3/б/ анги хамт олноороо номын сантай танилцах	35			2019.09,23
29	Оюуны хүлэг	5	5	3000	2019.09.11
		751	1722	661,700	

Шинэ санаачлага, бүтээлч ажил

Уншигч хүүхдүүдийг ном унших сонирхол төрүүлэх ,таатай орчинг бүрдүүлэх зорилгоор хүүхдийн уншлагын танхимын цонхон дээр үлгэрийн баатруудыг 4-р сургуулийн 11/б/ ангийн сурагч Ариунжаргалтай хамтран ажиллав.

Хүүхдийн уншлагын танхимаа хамт олноороо засвар хийж, ханаа цоолборт зургуудаар чимж, хүүхэд багачууд номын сангаар үйлчлүүлэхэд таатай орчинг бүрдүүлэн ажиллаж байна.

Уншигчдын хүсэл сонирхлыг тодорхойлох зорилгоор Уншигчдын сонирхол, орчин нөхцлийн талаар судалгаа хийсэн.

Уншигчдыг шинэ мэдээллээр тогтмол хангах зорилгоор Уншигчдын мэдээллийн буланг шинэчлэх

Өсвөр үеийнхний ном унших хүсэл сонирхлыг төрүүлэх, номтой зүй зохистой харилцах хандлага төлөвшүүлэх зорилгоор Урагдаж гэмтсэн номонд сурагчидтай хамтран сэлбэн засалт хийсэн. Уг үйл ажиллагаанд 10 сурагч оролцсон.

Шинээр санаачлан “Уншигчийн баримт бичгийн бүртгэл” гэсэн бүртгэл нээн ажиллаж байна.

Өөрийгөө хөгжүүлэх, бусад ажил:
Аймаг, Хотын нийтийн номын сангуудын номын санч, ажилчид, их дээд сургууль, ЕБС-ийн номын санчдын дунд номын сангийн ажилтан, албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олныг төлөвшүүлэх, болон мэргэжил нэгт нөхөдтэйгөө танилцах хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Монголын номын сангийн консерциум болон Орхон аймгийн номын төв хамтран зохион байгуулсан билээ. Тэмцээн нь: Сагсан бөмбөг, Гар бөмбөг, Олс таталт, Ширээний теннис, Усан поло, Шатар гэсэн 6 төрлөөр явагдаж 16 багийн 190 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин амжилттай оролцлоо.
Тус тэмцээнд Сэлэнгэ аймгийн нийтийн номын сангийн 12 ажилтан баг бүрдүүлэн 6 төрөлд оролцож “Усан поло” тэмцээнд тэргүүн байр, Шатрын төрөлд 4-р байр, “Олс таталт”-ын төрөлд 4-р байр эзлэн амжилттай оролцлоо.
Өөрийн мэдлэг мэдээллийг дээшлүүлж, сурч хөгжихийн тулд мэргэжлийн болон шинээр хэвлэгдэн гарсан ном хэвлэлийг уншиж судлан өөрийгөө хөгжүүлэн ажиллаж байна.
Номын санчдын ярих ур чадварыг дээшлүүлэх хөгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан илтгэлийн тэмцээнд “Номын сангийн номзүйн үйлчилгээ ба үндсэн зарчмууд” сэдвээр илтгэл бэлтгэж амжилттай оролцлоо.

Төвийн бүсийн Дархан, Эрдэнэт, Булган аймгийн номын сангуудын ажилчдын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлж, туршлага солилцох ажлын хүрээнд зохион байгуулагдсан “Хамтдаа хөгжье” илтгэл, урлагын тэмцээнд амжилттай оролцон байгууллагаараа 3-р байранд орж амжилт үзүүллээ.
“Ээлтэй үйлчилгээ иргэн таньд” нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож Номын сангийн үйлчилгээг иргэдэд танилцуулж, карт нээх үйлчилгээ үзүүлэн ажиллаа.
7 хоног бүрийн мэдээллийн цагаар

- “Олон ботит ном тодорхойлох журам” Номзүйч Ц.Гэрэлцэцэг
- “Номын санд бүртгэгдэх дүрэм журам” номын санч П.Баасандорж
- “Хувь хүний ёс зүй” –Номын санч Б.Баасандорж
- “Номын сангийн картын сангийн зохион байгуулалт” Номын санч Д.Бүрэнжаргал
- “Номын сангийн үзүүлэн таниулах ажил” Номын санч А.Цэнд
- “Номын сангийн Каталоги” Фондоч Б.Цолмонбаатар
- “Номын сангийн орчин нөхцөл ба стандарт” номын санч М.Орхон
- “Соёлын тухай хууль” Мэдээллийн ажилтан Б.Мэргэнбаяр нар дээрх сургалт хичээлүүдийг зохион байгууллаа.

Улаанбаатар хотын Орхон дээд сургуулийн номын сангийн ажилтай танилцаж, туршлага судлан Уншигчидтай харилцах бүртгэлийн дэвтрийг, Гэрэр ном олгох уншлагын танхимдаа бүртгэн ажиллаж байна. Өөрийн мэдлэг чадварыг дээшлүүлэхийн тулд Б.Баяраагийн “Номын сангийн заах арга зүй” “Номын санч-мэдээллийн ажилтаны ширээнд”,”Соёл урлаг шинэ нөхцөлд-6” зэрэг мэргэжлийн холбогдолтой номуудыг уншиж ашиглаж байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгээс зохион байгуулсан “ Эрүүл зөв хооллох”,ЗДТГ-аас зохион байгуулсан “Төрийн албаны тухай”, ”Архив бичиг хэрэг боловсруулах”, тухай Хүүхэд Гэр Бүл Хөгжлийн Төвөөс зохион байгуулсан “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого чиглэл” сэдэвт зэрэг сургалтууданд хамрагдлаа.

6. ХҮНИЙ НӨӨЦ

Аргазүйн зөвлөмж,сургалтын ажлын хүрээнд.

2019 онд номын санчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн ажлуудыг зохион байгуулж, зөвлөмж,сургалтуудыг явууллаа.

Үүнд: Номын санд шинээр ажиллагсад болон нийт номын санчдын мэргэжлийн заавар зөвлөмж, сургалтыг ганцаарчилсан болон хэсэг бүлгээр нийт 32 удаа өгөв. Шаамар, Алтанбулаг, Дулаан хаан тосгоны соёлын төв болон Ерөнхий Боловсролын сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч, Шаамар, Баянгол сумын номын санч Сувдмаа,

Мөнгөнцэцэгт номын сангийн анхан шатны мэргэжлийн сургалтыг явуулж номын сангийн хэлтэс тасгуудад дадлага хийлгэн мэргэжлийн чиг үүргийн зөвлөгөө өгөв.

Номын санч А.Цэнд, номын сангийн мэргэжлээр дадалага хийж байгаа А.Байгалмаа нарт “Номын сангаас явуулах саёл олон нийтийн ажил”,сургалт явуулж, ном хэвлэлийг ангилах, техник ажиллагаа хийх, номын сангийн үндсэн бүртгэлүүдийг хөтлөх тухай аргазүйн зөвлөгөө өглөө.

Номын санчид, мэргэжлийн ажилтануудын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэхэд, ажлын дадалага чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн сургалтуудыг хуваарь гарган зохион явууллаа. Үүний дагуу номын санч Д.Бүрэнжаргал “Ном тодорхойлох журам” , Фондын ажилтан Б.Цолмонбаатар, номзүйч Ц.Гэрэлцэцэг болон бусад мэргэжлийн ажилтанууд хамрагдан “1-5 зохиогчтой ном тодорхойлох “ “Соёлын тухай хууль”,”Хувь хүний ёс зүй” ,”Фондын орчин нөхцөл стандарт” зэрэг 16 сэдвээр сургалт зохион байгуулж бусад номын санч нартай санал бодлоо ярилцан дадлага туршлага солилцон мэргэжлийн ур чадвараа дээшлүүллээ. Мөн сургалтанд орсон хичээлүүдийг бататгах зорилгоор номын санч мэргэжлийн ажилтануудаас мэдлэг сорих тестийн шалгалт авлаа.

Номын санч нарт зориулсан “ Номын санд мөрдөгдөх зарим дүрэм журам”, “Номын ертөнц” дүрийн тоглолттой уншигчд бага хурлын зохиомж” **“**АСТ”-ийн зохиомж зэрэг гарын авлагыг боловсруулан гаргалаа.

Гэрээр ном олгох ,нийтийн уншлагын танхимын ном хэвлэлийг 2 удаа номын сан номзүйн ангилалын дагуу байрлуулан цэгцэллээ. Ажилтануудын сарын ажлын төлөвлөгөөг 7 хоногоор төлөвлөн дүгнэж,өдөр тутмын ажилд хяналт тавин, аргазүйн зөвлөгөөний бүртгэлийг хөтөлж байна.

Номын санчид мэргэжлийн ажилтануудад өгсөн аргазүйн зөвлөгөө

д/д	Зөвлөгөө өгсөн сэдэв	Ганцаарчилсан журмаар	Нийтийн журмаар
1	“Ном сурталчлах арга СОНА”- ыг зохион байгуулах	2	4
2	”СОНА-ын удирдамжийг боловсруулах”,	3	8
3	Өгөгдсөн номзүйн лавлагааны бүртгэл	2	8
4	“Сонин сэтгүүлийг бүртгэлийг хөтлөх ба нэгдсэн бүртгэлд бүртгэх тухай	2	8
5	“Номонд техник ажиллагаа хийх стандарт,норм”	2	8
6	“Сонин сэтгүүлийг бүртгэлийг хөтлөх ба нэгдсэн бүртгэлд бүртгэх тухай	3	8

7	Уламжлалт СОНА-ыг зохион байгуулах		8
8	Ажлын төлөвлөгөө,тайлан боловсруулалт биелэлт	2	12
9	Орхон дээд сургуулийн номын сангийн туршлагаас		2
10	Сурагчдын зуны амралтанд зориулж “Зуны хөтөлбөр “ боловсруулах тухай	4	4
	Нийт	20	70

Номын санч мэргэжлийн ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх,харилцан бие биенээсээ суралцах,өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд зорилгоор мэргэжлийн ажилтануудын дунд “Шилдэг илтгэл”-ийн уралдааныг зохион байгууллаа.

Илтгэлийн сэдэв:

- Номын сангийн мэдээллийн технологи .программ хангамж
- Номын сангийн фондын бүрдүүлэлт,түүний чанар,ач холбогдол
- Номын сангийн номзүйн үйлчилгээ,үндсэн зарчмууд
- Хувь хүний уншлагыг удирдах нь
- Уншигчидтай ажиллах ажлыг боловсронгуй болгох нь
- Номын сангийн зохион байгуулалт
- Хүүхдийн нас сэтэхүйг судлан ажиллах нь
- Номын сангийн ном солилцооны ажлыг сайжруулах нь сэдвээр нийт 8 ажилтанууд идэвхтэй оролцож мэдээллийн ажилтан Б.Мэргэнбаяр тэргүүллээ.

Мөн сумдын соёлын төвийн номын санчид болон өөрийн номын санчдын дунд “Номын сангийн хууль”, ”Төрийн албаны тухай” хуулиудаар сургалт зохион байгуулав.

Сүхбаатар сумын ЕБС-иудын 6 номын санч нарт “Сургуулийн номын сангийн үйл ажиллагааг сайжруулах” тухай сургалтыг зохион байгуулав.Сургуулийн номын санчдын мэдлэг чадварыг сайжруулахын тулд нэг сургуулийн номын санг “Загвар номын сан “ болгох бусад номын санчдыг хамруулан дадлага туршлага олгох ажлыг зохион байгуулахаар сургалтаар шийдвэрлэлээ.

Аргазүйн дотоод ажлын хүрээнд

Мэргэжлийн ажилтануудын 2019 оны үр дүнгийн гэрээний төлөвлөгөг боловсруулж батлууллаа.

Ажилтануудын сар бүрийн ажлын төлөвлөгөөг 7 хоногоор төлөвлөн дүгнэж,өдөр тутмын ажилд хяналт тавин аргазүйн зөвлөгөөний бүртгэлийг хөтөлж байна.
Арга зүйн ажилд шаардлагатай бүртгэл дэвтрүүдийг шинэчлэн бүртгэж байна.
Номын санч нартай хамтран албан тушаалтны тодорхойлолт гаргах тухай хэлэлцэн холбогдох хууль дүрмийг уншиж танилцлаа. Үүний дагуу Аймаг Нийслэлийн Нийтийн Номын Сангийн Үлгэрчилсэн Дүрмээр сургалт зохион байгуулав. Улс орон даяар нийтээрээ тэмдэглэн өнгөрүүлдэг “Дэлхийн номын өдөр”, “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд үндэсний бичиг соёл,ном хэвлэлийг ард иргэд, хүүхэд багачуудад сурталчилан,өвлүүлэн таниулах ажлуудыг зохион явууллаа.
Мөн номын санчдын мэргэжлийн ур чадвар, зөвлөмж сургалтын чанарыг сайжруулах тулд нийт 17 сумдын номын санчдаас “ Сургалтын судалгаа”, номын сангийн үйл ажиллагааны хүрээ хүртээмж ,үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор нийт 50 уншигчдаас “Сэтгэл ханамжийн судалгаа” явуулж дүгнэлт гарган цаашид анхаарах ажлуудыг,өөрийн нөөц бололцоог ашиглан үйл ажиллагаандаа тусган ажиллахаар төлөвлөж байна. Гэрээр ном олгох,Хүүхдийн уншлагын танхимын номын санч нарын ажил хүлээлцэхтэй холбогдуулж номын тооллогыг хийж тооллогын актыг үйлдлээ. Хүүхдийн уншлагын танхимыг тохижолтонд анхаарч хүүхэд багачуудын ном уншин таатай орчныг бүрдүүлэхийн тулд номын сангийн ажилтануудаа хамруулан засварын ажлыг хийж гүйцэтгэлээ.

7. ТЕХНОЛОГИ

Мэдээллийн технологчийн ажлын хүрээнд:

Lib4U программын нөөцийг хадгалахад зориулан 80GB багтаамж бүхий хатуу дискэнд тохиргоо хийн программын нөөцийг тасалдалгүй, аюулгүй хадгалж эхлэв.

Өгөгдсөн номзүйн лавлагаа, татгалзал дээр online орчинд ажиллах, бүртгэл мэдээллийг тасалдалгүй зөв хөтлөх боломжийг олгодог хялбаршуулсан платформыг ажил үйлчилгээнд шинээр нэвтрүүллээ.

Өгөгдсөн номзүйн лавлагаа, татгалзал дээр ажиллах заавар, шинэчилсэн бүртгэлжүүлэлт дээр ажиллахын давуу тал, график мэдээллээр нийт ажилчдад сургалт зохион байгуулав.

Wolves LLC-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулж Lib4U cloud программыг номын сангийн үйл ажиллагаанд нэвтрүүллээ.

Сэлэнгэ айгмгийн албан ёсны вэб хуудас / www.selenge.gov.mn /-д Аймгийн нийтийн номын сангийн үйл ажиллагааны танилцуулга, цаг үеийн мэдээлэл бүхий орон зай бий болсонтой холбогдуулан шаардлагатай мэдээлэл, танилцуулгыг бэлтгэн хоблогдох ажилтанд хүлээлгэн өглөө.

Lib4U cloud программыг ажиллуулж эхэлсэнтэй холбоотойгоор ажилтан албан хаагчиддаа программын бүтэц, ажиллагааны талаар сургалт мэдээлэл өглөө.

Номын сангийн үйл ажиллагааг таниулах зорилго бүхий орчин үеийн хэв загварт нийцсэн танилцуулга брошур материал бэлтгэн 100 гаруй ширхэгийг хэвлэн тараагаад байна. Мөн номын сангийн шинэ уншигчидад зориулсан тайлбар карт, номын хавчуурга, номын сангийн нэрийн хуудас зэрэг олон төрлийн хэвлэх материал бэлтгэн тухай бүрт нь хэвлэн бэлтгэж номын санчдадаа хүлээлгэн өгч байна.

Номын сангийн автоматжуулалт, цахим номын сангийн чиглэлээр судалгаа хийн илтгэл тавьлаа.

БСУГ-н 60 жилийн ойн арга хэмжээнд оролцож хэвлэлийн эх болон тараах материалуудыг хийж гүйцэтгэлээ.

Номын сангийн асарт зориулж номын сангийн товч танилцуулга бүхий анносны эхийг бэлтгэж хэвлүүлэв.

Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай судалгаа хийж илтгэл тавьлаа.

Олон улсын худалдааны төвд зохиогдсон “Явуулын үйлчилгээ”-нд номын сангийн сурталчилгааны материал 100 ширхэг, брошур 50 ширхэгийг бэлтгэн хэвлэж номын санчдад хүлээлгэн өгөв.

Номын сангийн ажилчиддаа технолгийн цаг үеийн болон танин мэдэхүйн мэдээлэл бүхий “Энэ юу вэ?” сэдэвт илтгэлийг тавьлаа.

Байгууллагын дотоод сүлжээг шинэчлэн зохион байгуулж дотоод урсгалын тасалдлыг зогсоолоо. Мөн байгууллагын интернэтийн зохистой, тасалдалгүй хэрэглээнд суурилсан филтер бүхий программын ажиллуулж эхэллээ.

Нийтийн номын сангийн ажлын хүрээнд

ГНОТ-с эрхлэн гаргасан “Шинэ номын үзэсгэлэн”, “Өөрийгөө хөгжүүлэхүй” “Монгол хэл соёл” сэдэвт номын үзэсгэлэн, Фондноос эрхлэн гаргасан “Монгол Хаад”, “Монгол ёс заншлын хэлхээ”, “Монголын баримтат өв соёл” номын үзэсгэлэн, мөн Хүүхдийн уншлагын танхимаас сурагч багачуудад зориулан гаргаж буй 30 гаруй номын үзэсгэлэнгүүдийн хэвлэлийн материалыг хэвлэн бэлтгэж номын сангийн цахим хуудсаар тогтмол сурталчлан ажиллаж байна.

Номын сангийн Facebook хуудасны ажиллагаа тогтмолжиж номын сангийн үйл ажиллагаа, соёл олон нийтийн ажил, үзэсгэлэн, тэмдэглэлт өдрүүдийн мэдээлэл,

мэндчилгээ, сурталчигаа тогтмол хийгдэж онлайнаар номын сунгалт хийх, лавлагаа өгөх үйлчилгээ хийгдэж байна.
2019 онд Нийтийн номын сан нь өөрийн цахим хуудсаар дамжуулан 31 иргэд, уншигчиддаа мэдээлэл түгээх, 12 уншигчийн лавлагаанд хариулт өгөх, 19 уншигчийн 41 номонд сунгалт хийх зэрэг үйлчилгээг үзүүлсэн байна. Аймгийн нийтийн номын сангийн цахим хуудас нь 1759 дагагч 5000 найзаараа дамжуулан мэдээллийг түгээн ажиллаж байна.
Дэлхийн номын өдөрт зориулан 7 хоног бүр холбогдолт мэдээлэл постер бэлтгэн цахим хуудсаар сурталчилан ажиллав. Мөн Дэлхийн номын өдрийн арга хэмжээний зохион байгуулалтад оролцож тухайн арга хэмжээний талаар болон уригдан ирсэн зохиолч Амарзаяагийн мэдээлэл бүхий постерийг бэлтгэн цахим хуудсаар сурталчлах, Зохиолч – Уншигчдын уулзалтын үйл ажиллагааны зурган мэдээллийн санг бэлтгэх цахим орчинд сурталчлах, арга хэмжээний техник хангамжийг хариуцах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

“Зуны хөтөлбөр 1, 2”-т холбоотой хэвлэлтийн шаардлага хангасан баннер, постеруудыг бэлтгэж олон нийтийн сүлжээгээр сурталчлан ажиллаа.

Сумдын номын сангийн хүрээнд

Сумдын Monbiblio програмын нөөц, нэгдсэн тайлан, каталогийн мэдээ хүргүүлэх ажлын бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэв.

Хүдэр, Жавхлант, Баруунбүрэн, Хэрх, Алтанбулаг, Орхон зэрэг 6 сумын Соёлын төвийн номын сангийн компьютерыг засаж форматлан Monbiblio программын нөөцийг сэргээж хэвийн ажиллагаанд оруулла.

Сумдын номын санчдад Monbiblio болон бусад программ хангамжуудын талаар сургалт зохион байгууллаа. Сургалтад Monbiblio программын нөөцийн аюулгүй байдал, нөөц авахын давуу талууд болон компьютерын засвар үйлчилгээний талаар нэмэлт мэдээллийг олголоо.

8. ЗӨӨВРИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Үзүүлэлтүүд	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	Нийт
Фондоос авсан ном	0	0	20ш 1удаа	61ш 3удаа	58ш 3удаа	0	0	0	42ш 2удаа	27ш 2удаа	28ш 3удаа	40ш 2удаа	276ш 16удаа
ГНОТ-аас авсан ном	92ш 4удаа	92ш 4удаа	36ш 2удаа	112 5удаа	61ш 3удаа	179ш 8удаа	60 3удаа	59ш 4удаа	241 10удаа	102 5 удаа	197ш 9 удаа	180ш 8удаа	1411 65удаа

ХУТ-аас авсан ном	0	0	62ш 1удаа	60ш 1удаа	60ш 1удаа	0	0	0	0	0	0	0	182ш 3удаа
Нийт авсан ном	**92**	**92**	**118**	**233**	**179**	**197**	**60**	**59**	**283**	**129**	**225**	**220**	**1869**
Шинэ уншигч	122	23	158	132	191	51	0	0	88	13	21	40	839
Иргэсэд	0	95	13	136	68	87	52	52	137	113	222	170	1145
Нийт уншигч	**122**	**118**	**171**	**268**	**259**	**138**	**52**	**52**	**225**	**126**	**243**	**210**	**1984**
Ном олголт	257	209	968	588	770	248	82	92	397	213	417	360	4601
ЕБС-д үйлчилсэн тоо	0	0	2	1	2	0	0	0	4	1	3	2	15
Аж ахуй нэгжид үйлчилсэн тоо	1	1	0	2	2	4	1	3	3	13	3	3	24
Тусгай байгууламжид буй иргэдэд үйлчилсэн тоо	3	3	2	6	2	4	2	1	5	4	4	5	41
Нийт үйлчилсэн сум, албан байгууллага ЕБС-ийн тоо	**4**	**4**	**4**	**9**	**6**	**8**	**3**	**4**	**12**	**6**	**10**	**10**	**80**
СОНА.			40		100				35		20		

Зөөврийн номын сан нь Номын сангийн тухай хууль, Зөөврийн номын сангийн аргачлал зэрэг хууль эрх зүйн актын хүрээнд Алслагдсан сум дүүрэг аж ахуйн нэгж иргэд , тусгай байгууламжид буй иргэдэд номын сангийн үйлчилгээг хүргэх, Зөөврийн номын сангийн үйлчилгээний хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэн, ажлыг төлөвлөгөөг гарган ажиллаа.

Алслагдсан сум дүүрэг,Аж ахуйн нэгж болох Хонгор морьтын 1-р баг, Бор гүвээний 5-р баг,УЦУОШТөвд 24 удаа,Сүхбаатар сумын ЕБ-ын 4,5,6-р сургууль,МСҮТ,Алтанбулаг,Шаамар сум,Дулаан хаан тосгоны ЕБ сургуулиудад 15 удаа ,Тусгай байгууламж болох ШШГГ, Хилийн 0101-р анги, ХЦ-ийн 0243-р анги,Цармын харуул,Номтын застав Ахмадын сувилалд 41 удаа" үйлчилж 2019 онд эдгээр байгууллагад нийт 80 удаа 839 шинэ уншигчдад 4601 ном олгож 1145 ирэгсдэд зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлэн ажиллаа.

, ЗНСан нь 2019 онд Фондын ажилтан Б Цолмонбаатараас 16 удаа 276 ном, ГНОТ-ын номын санч Б Баасандорж, М Орхон,А Цэнд нараас 65 удаа 1411 ном, ХУТ-ын номын санч Д Бүрэнжаргалаас 3 удаа 182 ном, нийт 84 удаа 1869 ном авч хамтран ажиллаа.

2019 оны 10-р сард Сэлэнгэ аймгийн ННСангийн номын санч нарт ЗНСанч П Баасандорж миний бие Ном солилцоо,Номын сангуудын дүрэм ,журам сэдвээр 2 удаа илтгэл,хичээл тавилаа.ННСангийн номзүйч,фондоч,ХУТ,ГНОТ-ийн номын санч нарын илтгэл, хичээлд оролцлоо. Мөн нээлттэй хаалганы өдөрт номын сангаас зохион байгуулсан номын үзэсгэлэн , ЗНСангийн танилцуулага зэргийг хариуцан ажиллаа

ЗНСан нь 2019.03.21-нд сувилуулж ахмадуудын дунд /АХА/ болон хөгжмийн ая зогсоход хэн түрүүлж сандалд суух вэ хөгжөөнт тоглоомыг тоглуулаа. 2019.05.06-нд Сэлэнгэ аймгийн ННСангаас зохион байгуулсан үндэсний бичиг үсгийн баярт үндэсний хувцастай жагсаалийг зохион байгуулалцаж оролцлоо.2019.09.11. ГНОТ-ийн номын санч Б Баасандарж ХУТ-ийн номын санч А Цэнд аргазүйч Т Нарандалайн хамт Шаамар сум Дулаан хаан тосгоны ЕБС-ийн сурагчдын дунд кофет уншлага, Оюуны хүлэг таавaрт танин мэдэхүйн тэмцээн зохион явууллаа. 2019.11.13 ахмадын сувилалд сувилуулж буй ахмадуудын дунд хөгжөөнт АХА тэмцээнийг зохион явууллаа.

№	СОНА-ын нэр	Хамрагдсан иргэд		Зардал төсөв	Зохион байгуулсан огноо	Зохион байгуулсан газар
		бүртгэлтэй	бүртгэлгүй			
1	АХА чөлөөт сэдэв		20	Дурсгалын зүйл	2019.03.21	Ахмадын сувилал
2	Хөгжимийн аянд сандалд өрсөн суух		20	Дурсгалын зүйл	2019.03.21	Ахмадын сувилал
3	Үндэсний бичиг үсгийн баяр	45	55	Нэгдсэн арга хэмжээ	2019.05.06	Партизаны талбай
4	Оюуны хүлэг		5	Шатахууны зардал.	2019.09.11	Дулаан хаан тосгон
5	Оюуны хүлэг		5	Шатахууны зардал.	2018,09,11	Шаамар сум
6	Кофет уншлага		15	Шатахууны зардал	2019.09.11	Дулаан хаан тосгон
7	Кофет уншлага		10	Шатахууны зардал	2019.09.11	Шаамар сум
8	“АХА” “ Чөлөөт сэдэв”		20	Дурсгалын зүйл	2019,11,13	Ахмадын сувилал

ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН
2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2019.12.11

НЭГ. НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт *(тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)* ***бүрээр хүрэх түвшин***		***Жинхэнэ гүйцэтгэл*** *(тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)*	***Өгөх үнэлгээ*** *(0-30 оноо)*	
			НБ Хэлтэс	***ХШҮ Хэлтэс***
1	2	4	5	6
"Нэг.Номын сангийн холбогдолтой гарсан хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлж ажиллах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:				
"1.Төрөөс соёлын талаар баримлах бодлого"хөтөлбөрийн хүрээнд: 1.1. Мэдээллийг иргэдэд цаг тухайд нь хүргэх, хэрэгцээт мэдээллийг чөлөөтэй олж авах боломжийг нэмэгдүүлэх.	Номын сангийн үйлчилгээг иргэд, уншигчдад түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. **2019** онд **3840** байнгын уншигч **14090** иргэсдэд **40320** ном олгож уншуулна. . 2019.01.01-нээс 2019.06.12-ний хооронд 2019 онд аймгийн Нийтийн номын сан нь уншигч иргэд, албан	Аймгийн Нийтийн номын сан нь 2019 оны байдлаар **3915**-н байнгын уншигч, **14682** иргэсэд, нийт **18597** уншигчдад **40767** ном, хэвлэл, мэдээллийн материал олгож уншуулсан нь төлөвлөгөөний биелэлт **100 хувьтай** байна. 		

1.2. Номын сангаас соёл олон түмний ажлыг зохион байгуулан үйлчилгээний хүрээ, хүртээмжийг сайжруулж, үйлчилгээг өргөжүүлэх.	байгууллага, аж ахуйн нэгжийг хамруулж соёлын арга хэмжээний давтамж чанарыг дээшлүүлнэ. */7-н арга хэмжээ зохион байгуулж **1400** хүн хамруулах/* 1.2.1. Зуунмод сумын аварга шалгаруулах “Өсвөрийн шатарчдын” тэмцээнийг зохион байгуулна. 2019 оны 2-р сард 1.2.2. Зуунмод сумын цэцэрлэгүүдийн дунд “Үлгэрийн баатрууд амилсан нь” тэмцээнийг зохион явуулна.	2019 оны хагас жилийн байдлаар Аймгийн нийтийн номын сан нь уншигч иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжийг хамруулж соёлын арга хэмжээний давтамж чанарыг дээшлүүлэхээр. **15-н арга хэмжээ** зохион байгуулж давхардсан тоогоор **2766** хүн хамруулсан байна. Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Өсвөрийн аварга” шалгаруулах шатрын тэмцээнийг Зуунмод хотын ЗДТГ, Аймгийн нийтийн номын сан, Аймгийн шатрын холбоотой хамтран зохион байгууллаа. Энэ удаагийн тэмцээнд нийт **80** гаруй хүүхэд залуучууд оролцож оюун ухаанаараа өрсөлдлөө. Өсвөр үеийн хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, тэдний оюун ухааныг хөгжүүлэх, Шатрын спортын хөгжилд дэмжлэг үзүүлэх, хичээллэгчдийн хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэх, өсвөрийн шилдэг тамирчдыг бэлтгэн гаргах, арга туршлагаа солилцох улс, аймгийн чанартай тэмцээнд бэлтгэл болсноороо үр дүнтэй байлаа.		

	1.2.3. “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг зохион явуулна.	Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Үлгэрийн баатрууд амилсан нь”Аймгийн Анхдугаар наадам 2019 оны 5-р сарын 28- ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнийг БСУГ, ДЗөнТОНХ, АННСан хамтран зохион байгуулж, бүсээс шалгарсан 6 багийн 40 хүүхэд багачууд өрсөлдөж, оюун ухаан, авхаалж самбаагаа сорьсноос 1-р байранд: Зуунмод сумын Ирээдүй цэцэрлэгийн “Эрдэм-2” баг, 2-р байранд: Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн “Эрдэм” баг, 3-р байранд: Аргалант сумын “Янзага” баг тус тус шалгарч алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөлөөр шагнагдлаа. Тусгай байранд: Угтаал Өндөрширээт, Жаргалант сумын багууд орсон. Тэмцээнд оролцсон нийт 40 хүүхдэд Дэлхийн Зөн ТОНХХ-ийн хамт олон бэлэг гардуулав. Үүний үр дүнд хүүхдийн хэл ярианы баялгийг нэмэгдүүлэх, бие биенээ хүндэтгэх, бусдад талархах, зохиолын баатруудын дүрээр дамжуулан хүний сайн, муу зан чанарыг ялгаж, өөрийгөө илэрхийлэх чадварт суралцсан нь үр үнтэй боллоо. Жил бүрийн 5-р сард зохион байгуулдаг Үндэсний бичиг үсгийн баяраар үндэснийхээ утга соёлын нандин		

	1.2.4 БСУГ-тай хамтран “Зохиол миний нүдээр” сэдэвт илтгэлийн уралдааныг аймгийн хэмжээнд ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулна.	өв болсон Монгол бичгийг хойч үедээ өвлүүлэх, үндэсний бичиг соёлоороо бахархах, зөв сайхан бичих, эх хэлний баялаг сангаас эзэмшүүлэх зориогоор ,МСҮТ, ЕБС-ын 11-р анги, төрийн албан хаагч, ажилчдын дунд **Алтан хонх, Хичээнгүй сайхан бичиг, Хурдан уншлага, Криллээр хөрвүүлж бичих , Өгөгдсөн үгийг зөв бичих,** зэрэг уралдаануудыг зохион байгууллаа. **Алтан хонх тэмцээнд:** 1-р байр ХЦАС 11-р ангийн сурагч М.Хонгорзул 2-р байр 5-р сургуулийн 11-р ангийн О.Нансалмаа 3-р байр 5-р сургуулийн 11-р ангийн О. Намуундарь нар шалгарлаа. Төрийн албан хаагчдын дунд зохион байгуулсан **“ҮНДЭСНИЙ БИЧИГ, БИДНИЙ БАХАРХАЛ” тэмцээнд** 1-р байр Аймгийн нэгдсэн эмнэлэг 2-р байр Аймгийн музей 3-р байр Монгол туургатан театрын баг, сурагчид амжилттай оролцлоо. Үндэснийхээ утга соёлын нандин өв болсон Монгол бичгийг хойч үедээ өвлүүлэх, үндэсний бичиг соёлоороо бахархах, зөв сайхан бичих, эх хэлний баялаг сангаас эзэмших, хүсэл эрмэлзлэлийг төрүүлсэн үр дүнтэй арга хэмжээ боллоо. “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг тохиолдуулан гаргасан “Үндэсний бичиг, бидний бахархал” номын үзэсгэлэн 27 номоор иргэд уншигчдад үйлчиллээ.		

	1.2.5. ЕБСургуулийн сурагчдыг номтой нөхөрлүүлэх зорилгоор “Уншлагыг дэмжье” аян зохион байгуулах	Боловсрол, соёл урлагийн газар, аймгийн Нийтийн номын сангаас 4 дэх жилдээ хамтран зохион байгуулсан “**Зохиол-Миний нүдээр**” сэдэвт илтгэлийн аймгийн уралдаанд 29 сургуулийн 9-12-р ангийн 30 сурагч оролцлоо. Сурагчдын өөртөө итгэх итгэл, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадварыг хөгжүүлэх, зохиолоос хүний амьдралын үнэт зүйлийг ухаарах, тодорхой зорилго мөрөөдөлтэй болох, аливааг тусган хүлээж авах, хариуцлага хүлээх, шинэ санааг хөгжүүлэх зэргээр хувь хүний хөгжлийг дэмжих, номтой нөхөрлүүлэхэд ач холбогдолтой боллоо. Мөн сургуулийн нийт сурагчдаа үлгэрлэн, номыг бүтээлчээр унших арга техникт суралцаж, номтой нөхөрлөсөн уралдаанд оролцогч 23 сурагч “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн” боллоо.		

	1.2.6. “Гэр бүлийн уншлагын танхим”-ыг түшиглэн цэцэрлэгүүдтэй хамтран гэр бүлээр нь ном уншуулж, номыг хайрлах, хамгаалах, номонд дурлуулах дадалтай болгох. / 8 цэцэрлэгийг хамруулна/	**2018-2019 оны хичээлийн жилд** Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны “Журам батлах тухай” А/683 дугаар тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд **“Уншлагыг дэмжих сарын аян”-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажилласнаар** багш, сурагчид болон эцэг эхчүүдийн ном унших соёл, дадал хэвшилд тодорхой ахиц гарсан Уг арга хэмжээг зохион байгуулснаар ангийн номын санг эцэг эх, сурагчид, төрийн болон төрийн бус байгууллагын хандив тусламжаар **36,531.3** мянган төгрөгөөр баяжуулснаар нийт бүлгийн **91.7**% нь “Ангийн номын сан”-тай болсон нь өмнөх хичээлийн жилээс 8%-иар, нийт сурагчийн **97.1**% нь сургуулийн номын санд уншигчийн карттай болсон нь мөн үеэс 7.6%-иар тус тус өсөж, **72.9**% нь байнгын уншигч боллоо.		
	1.2.7. Ерөнхийлөгчийн зарлигыг орон нутагтаа хэрэгжүүлж “Номын баяр” арга хэмжээг зохион байгуулна.	“Гэр бүлийн уншлагын танхим”-ыг түшиглэн Уншлагыг дэмжье аяны хүрээнд зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн Норжмаа багштай бэлтгэл бүлэг, Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн эрдэмийн далай ахлах бүлэг Хүмүүн цогцолбор цэцэрлэгийн Ичинхорлоо багштай Бамбарууш бүлэг, Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн Мөнхтуяа багштай зуны анги, Унагалдайн андууд цэцэрлэгийн Буян-Ундрам багштай бүлэггүүдийн нийт **8** цэцэрлэгийн **126** хүүхэд багачууд, эцэг эхийн хамт номын сангийн үйл		

	1.2.8. Зуунмод сумын **8**-н цэцэрлаг **3**-н сургуулийн бага ангийн хүүхдүүдийн **15** хүртлэх хувийг хамруулна.. 2019 оны сар бүр	ажиллагаатай танилцаж үлгэрийн цагаар аяллаа. Жил бүрийн 9-р сард монгол улсын хэмжээнд зохион байгуулдаг. “Үндэсний номын баяр”-ыг тохиолдуулан Төв аймгийн залуус ТББ, Тархи цэнэглэгч номын клуб санаачлан “Номын хур-2019” арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Аймгийн нийтийн номын сан хамтран оролцож Монгол Туургатан Театрт зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэж, Соёмбо принтинг, Номын коллектор ХХК-тай хамтран 20%-н хямдралтай номын худалдаа зохион байгуулж, “Номын хур-2019” номын үзэсгэлэн гаргаж, нийт 148 хүн хамрагдсан байна. Мөн “Уншлагыг дэмжих аян”-ы хүрээнд Нийгмийн салбарийн байгууллагуудын дунд зохион явуулсан 1		

	1.2.9. Монгол бахархалын өдөрт зориулсан арга хэмжээ зохион байгуулах 2019 оны 11 сар	сарын аяны дүн гарч Тэргүүн байрыг Гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн газар, Дэд байранд Боловсрол соёл, урлагын газар, Гутгаар байрыг аймгийн музейн хамт олон шалгаран шагналаа гардан авлаа. Хүүхдийн уншлагыг дэмжих зорилгоор сургууль цэцэрлэгүүдэд сар бүр “Үлгэрийн цаг”-ыг тогтмол зохион байгуулж Бужинхэн цогцолбор цэцэрлэгийн Норжмаа багштай бэлтгэл бүлэг, Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн Эрдмийн далай ахлах бүлгүүдийн нийт 60 хүүхэд багачуудад “Үүлэн бор”, “Алаг эрээн тахиа”,“Улаан малгайт”,"Алтан загас", "Онгироо ухна ба чоно" гэсэн үлгэрүүдийг уншиж өгч нийт **602** хүүхдийг хамруулсан байна. Энэ нь 2-10 насны **3171** хүүхдийн **18,9%** байна. Үлгэрийн цагтай болсноор хүүхэд бүр үлгэрээс юу ойлгосноо бусдадаа ярьж өөр өөрсдийн сэтгэлийг илэрхийлэх чадварийг эзэмшсэн. Хүүхдийн уншлагын танхимыг өөрсдийн нөөц бололцоогоор тохижуулж цэцэрлэгийн хүүхдүүд, бага ангийн сурагчдад “Үлгэрийн цаг” зохион байгуулах ба уламжлалт өв соёлыг эзэмшүүлэх оньсон болон хөлөгт тоглоомоор тоглуулах орчинг бүрдүүлсэн		

2. Аймгаас баримтлах Соёлын бодлого, ***Сум сургуулын номын сангуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллах хөтөлбөр”***-ийн хүрээнд: Номын санчдын мэдлэг чадварыг дээшлүүлж, номын сангуудад мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч, олон нийтэд ном унших соёлыг сурталчилах, урамшуулах ажлыг	2.1.1 Номын санчдын мэдлэг боловсролыг тасралтгүй дээшлүүлэх зорилгоор сум, сургуулийн номын санчдыг хамарсан сургалт семинарыг зохион явуулна **/Номын санчдын 85-аас доошгүй хувийг хамруулах/** 2019 оны 3-р сард 2.1.2 Баянцагаан, Баян-Өнжүүл, Аргалант, Баянцогт, Өндөрширээт, Эрдэнэсант сум, сургуулийн номын сангуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө	“Монгол бахархалын өдөр”-ийг тохиолдуулан Нийтийн номын сан, Аймгийн Музей, Зуунмод сумын ахмадын хороо хамтран МСҮТ, ХЦАС, 5-р сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд ардын уламжлалт тоглоом наадгай, Монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулж сургах, өвлөн уламжлуулах зорилгоор Монгол наадгай, тоглоомын тухай мэдээлэл өгөх, “Монгол наадгай” танин мэдэхүйн тэмцээн гэсэн 2 үе шаттай зохион байгууллаа. “Монгол наадгай” сэдэвт сургалтанд ахлах ангийн 120 гаруй сурагчид хамрагдсан. Тэмцээн нь шагайн наадгай, асуулт хариулт, аман наадгай, оюуны сорил, оньсого таавар гэсэн 5 төрлөөр өрсөлдсөн. ✓ 1-р байр ХЦАС-н “Хүмүүн” Б баг 45 оноо ✓ 2-р байр 5-р сургуулийн “Тэмээчин” баг 40 оноо ✓ 3-р байр МСҮТ-н “Таван-Эрдэнэ” баг 39 оноогоор амжилттай оролцлоо.		

зохион байгуулах.	өгнө. 2019 оны 4,5,9-р сард 2.1.2 МТТеатр, Аймгийн музейтай хамтран **Баянцагаан, Баян-Өнжүүл** суманд үйл ажиллагаагаа сурталчилах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулна. **/2 сумын 190 иргэн/** 2019 оны 4,10-р сард 2.1.4 Багийн иргэдийн нийтийн хуралд оролцож үйл ажиллагаагаа сурталчилах /2,6-р багт/	Аймгийн ЗДТГазрын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймаг, сум, сургуулиудын номын санчид, соёлын төвийн эрхлэгч нарын сургалт семинарыг **“СОЁЛ, УРЛАГ-СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ НЬ”** сэдвийн дор зохион байгууллаа. Уг сургалтанд Монгол туургатан театр, Нийтийн номын сан, Музей, сумдын Соёлын төвийн эрхлэгч, Номын санчид, ЕБС-МСҮТ номын санч нийт 94 ажилтан, албан хаагчид хамрагдсан байна. Нийт номын санчдын **94** хувь нь хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүллээ. Аймгийн нийнийн номын сан нь 2019 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Баянцагаан, Баян-Өнжүүл, Аргалант, Баянцогт, Өндөрширээт, Эрдэнэсант сумын сум, сургуулын номын сангуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Номын сангуудын үйл ажиллагааг дүгнэдэг аргачлалын дагуу үнэлгээ өгч хэрэгжилт хангангалтгүй байгаа заалтуудад зөвлөгөө, үүрэг даалгавал өгсөн. Хугацаатайгаар албан тоотоор ажил эрчимжүүлэх үүрэг, чигийг өгч хэрэгжилтийг хантан ажиллаж байна. БТСГазар, МТТеатр, Аймгийн музейтай хамтран Баянцагаан, Баян-Өнжүүл суманд үйл ажиллагаагаа сурталчилах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг”		

"3.Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр"-ийн хүрээнд: 3.1. Хүний хөгжил мэдээллийн төв болно.	2019 оны 3,5-р сард 3.1.3 Хөдөөгийн сумдын алслагдсан багийн иргэд, Зуунмод сумын албан газар, аж ахуйн нэгж, багуудад зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэж уншигчдын тоог нэмэгдүүлнэ. /**2166 иргэн**/ 2019оны 1,2,4-р улирал 3.1.4 Айл өрх бүрийг номын сантай болгох, ном унших соёлд гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Зуунмод сумын хэмжээнд “Өрхийн номын сан”-тай айл өрхийн судалгааг авч сурталчилан өрхийн номын сантай	зохион байгууллаа. Нээлттэй хаалганы өдөрлөгөөр зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэж, шинэ номын худалдаа зохион байгуулан, сэтгэл ханамжийн судалгаа авч, номын сангуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Энэ арга хэмжээнд **182** иргэн хамрагдсан. НБХэлтсийн харьяа байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож Заамар, Жаргалант, Баянчандмань Зуунмод сумын 2,3,4,5 багийн иргэдэд зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэж, шинэ номын худалдаа зохион байгуулан, сэтгэл ханамжийн судалгаа авч ажилласан. Мөн Монгол туургатан театр, Нийтийн номын сан, Аймгийн музейгээс хамтарсан “Соёл урлаг” сурталчлах өдөрлөгийг Баян, Баянжаргалан, Архуст, Баяндэлгэр сумдад 9-р сард зохион байгуулж 218 иргэнд хүрч үйлчиллээ. Нийт **400** иргэнийг хамруулсан байна. Зуунмод сумын 2, 6-р багт зохион байгуулсан БИНХуралд оролцлоо. Нийтийн номын сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж иргэд, төрийн албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч нийт **178 гаруй** иргэдэд номын сангийн үйл ажиллагааны талаар танилцууллаа.		

	айл өрхийг нэмэгдүүлэх. **15 хувьд хүргэнэ.** 2019 оны I-IV-р улирал 3.1.5 МЗЭ-ийн 90 жилийн ойг тохиолдуулан насанд хүрэгчдын дунд “Утгын чимэг” уран уншлагын уралдаан зохион байгуулах **/27 сумыг хамруулна/** 2019 он 3- р сар	Аймгийн нийтийн номын сан нь Зөөврийн номын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөдөө орон нутгийн иргэдэд үйлчлэх тоо, чанарыг ахиулахын тулд 2019 оны байдлаар Аргалант, Баянцогт, Баянцагаан, Баян-Өнжүүл, Заамар, Шижир алт, Жаргалант, Баянчандмань, Өндөрширээт, Эрдэнэсант соёлын төвийн номын сан, ЕБС-н номын санч нартай хамтран **20-н** багийн **939** иргэнд **1382** ном олгож уншуулсан. Зуунмод сумын **6** байгууллага, 6-н багийн **1165** уншигчдад **1514** ном олгож уншууллаа. Зөөврийн номын сангийн үйлчилгээг нийт **2104** иргэнд хүргэж **2896** ном олгож уншуулсан байна. Ном унших соёлд гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэн, айл өрх бүрийг “ Гэрийн номын сан”-тай болгохын тулд хямдралтай шинэ номын худалдаа зохион байгуулах, гэр бүл, албан байгууллагаар нь ном уншуулах, уншигчдын дунд соёл олон түмний ажил зохион байгуулах зэрэг ажлуудыг аймаг, 27 сумын хэмжээнд зохион байгууллалаа. Үүний үр дүнд **27 сумын 30509 өрхийн 4378 өрх** номын сантай болсон нь **14,3%-тай байна. Энэ нь** өмнөх оноос **4 хувиар** ахисан үзүүлттэй байна.		

\\ ***"4.Сан хөмрөгийн баяжилтыг нэмэгдүүлэх"*** хөтөлбөрийн хүрээнд: 4.1.Сан хөмрөгийн баяжилт, мэдээлэл, лавлагаа, ном зүйн үйлчилгээг сайжруулах	4.1.1 Шинэ ном хэвлэл, мэдээллийн материалаар фонд баяжилт хийж шинээр авсан номыг тухай бүр электрон каталогит оруулж нийтэд мэдээллэж байна. **/1.000.000 төгрөг/** 2019 он 3,10-р сард 4.1.2 Тогтмол хэвлэлд Төв аймгийн тухай гарч буй мэдээллийг түүж“ Төв аймаг хэвлэлийн хуудаснаа” лавлагаа мэдээллийн гарын авлага № 10,11-г хагас бүтэн жилээр гаргана. 2019 он 06, 12-р сард 4.1.3 Тэмдэглэлт өдрүүдээр сэдэвчилсэн	Эх орончдын өдөр, Монголыг зохиолчдын эвлэлийн 90 жилийн ойг тохиолдуулан Д.Нацагдоржийн нэрэмжит аймгийн Нийтийн номын сангаас “Утгын чимэг” уран уншлагын уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд 8 сумын 16 уран уншигч оролцож монголын зохиолчдын богино өгүүллэгээс сонгож өрсөлдсөнөөсТэргүүн байрт Алтанбулаг сумын уран уншигч Б.Батдэлгэр, Дэд байрт Мөнгөнморьт сумын уран уншигч А.Жалбий, Гутгаар байрт Зуунмод сумын уран уншигч А.Цэндсүрэн, тусгай байрт Эрдэнэ сумын уран уншигч Л.Мөнх-Оргил нар тус тус шалгарсан. Эх хэлнийхээ үгийн сангийн яруу сайхантай танилцах, бо гино өгүүллэгийг уран тод уншиж сурах арга барилыг эзэмшүүлэх, оюуны боловсрол олгох, авъяасыг нээн хөгжүүлэх, номтой нөхөрлүүлэх үр дүнтэй тэмцээн боллоо. **2019** оны байдлаар **төсвөөр 1.997.400** төгрөгний **228** ширхэг ном авч фонд баяжилтаа нэмэгдүүлсэн ба **хандив тусламжаар 3.841.500** төгрөгний **267** ширхэг ном, **364.000** төгрөгний тогтмол хэвлэл авч нийт **6.202.900** төгрөгний ном, хэвлэлээр сан хөмрөгөө баяжуулан бүртгэл тооцоонд авч, электрон каталогит оруулан уншигчын хүртээл		

	болон шинэ номын үзэсгэлэн гаргах **/12 үзэсгэлэн/** 2019 он I-IV р улирал 4.2.1 Д.Нацагдоригийн нэрэмжит цахим мэдээллийн танхимаар болон нэмэлт үйлчилгээг иргэдэд хүргэх. **/1100 хүнд/** 2019 он I-IV р улирал	болгож байна. АННСангийн захиалан хадгалагддаг өдөр тутмын сонин Зууны мэдээ, Өдрийн сонин, Үндэсний шуудан,Утга зохиол урлаг сонингуудад нийтлэгдсэн Төв аймгийн тухай мэдээллийн материалаар “Төв аймаг хэвлэлийн хуудаснаа” лавлагаа мэдээллийн **№10,11** гарын авлага гаргасан. Лавлагаа мэдээллийг гаргаснаар орон нутгийн картын сантай болж аймгийн тухай мэдээллийн лавлагаа бий болон богино хугацаанд мэдээллээ олж авах боломж бүрдсэн. Монгол улсын үндэсний номын сангаас зохион байгуулсан "**Үндэсний тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн санд** ZOTERO программд Төв аймгийн “Төвийн мэдээ” сэтгүүлийн **2018-2019** оны **203-н** мэдээ мэдээллийг тогтмол хэвлэлийн нэгдсэн санд оруулсан байна: Аймгийн нийтийн номын сан 2019 онд ➢ Цагаан сарыг тохиолдуулан “Монгол ёс заншил” номын үзэсгэлэн-34 ном ➢ Уншлагыг дэмжих сарын аянг тохиолдуулан “Бидний унших ном” номын үзэсгэлэн-71 ном ➢ Уншлагыг дэмжих сарын аянг тохиолдуулан“Номтой нөхөрлөцгөөе” номын үзэсгэлэн-25 ном ➢ Дэлхийн сонгодог уран зохиолын дээжисээр “Ном дотор зам бий”номын үзэсгэлэн-30 ном ➢ Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Монголын сайхан бүсгүйчүүд” номын үзэсгэлэн-33 ном ➢ Номын санчдад зориулсан “Номын санчдын ширээны ном” номын үзэсгэлэн-29 ном ➢ Хүүхдийн номын өдрийг тохиолдуулан		

4.2.Аймгийн Нийтийн номын сангаас хүргэх цахим мэдээллийн үйлчилгээг өргөжүүлэх.	4.2.2 Номын сангийн үйл ажиллагааг уншигч үйлчлүүлэгчдэд нээлттэй хүргэх зорилгоор өөрийн байгууллагын www.library.to.gov.mn вэб сайтын мэдээллийн санг тухай бүр баяжуулж үйл ажиллагаагаа тогтмол сурталчилна. /Сард 2 удаа/ 2019 он I-IV р улирал 4.2.3 Номын сангийн үйл ажиллагаагны мэдээллийг цахимаар болон орон нутгийн телевизээр сурталчилах /Шторк-2, мэдээ 6/ 2019 он I-IV р улирал 4.3.1 Төсөв санхүүг зориулалтын дагуу өр авлага үүсгэхгүй зарцуулж мэдээ тайланг цаг хугацаанд нь өгч ажиллан шилэн дансны хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж батлагдаж ирсэн төсөв, гүйцэтгэлийг ил тодоор байрлуулан хэрэгжилтийг тухай бүр гаргана. 2019он I-IV р улирал 4.3.2 Номын сангийн нэмэлт үйлчилгээг төлбөртэй явуулж, байгууллагын	“Андерсоны үлгэрүүд” номын үзэсгэлэн 24 ном ➢ Дэлхийн номын өдрийг тохиолдуулан гаргаж буй “Дэлхийн сонгодог уран зохиолын чуулган” номын үзэсгэлэн 41ном ➢ “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг тохиолдуулан гаргаж буй “Үндэсний бичиг, бидний бахархал” номын үзэсгэлэн 27 ном ➢ Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Хүүхдийн ертөнц” номын үзэсгэлэнг 25 ном, Миний унших номнууд, Номын хүр-2019, Монгол бахархал-2019 сэдэвчилсэн 12, шинэ номын үзэсгэлэнг 2 удаа **14**-н үзэсгэлэнг **233** номоор **1306** уншигч иргэдэд хүргэлээ. Цахим мэдээллийн танхимаар иргэд уншигчдад хэрэгцээтэй интернэт, хувилан олшруулах, компьютерийн үйлчилгээг хүргэж байна. Интернэт үйлчилгээнд **26** хүн, канон компьютерийн үйлчилгээнд **145** хүн нийт **160** хүнд хүрч үйлчилж **35.100** төгрөгний орлоготой ажилласан. Цахим танхимын үйлчилгээг өргөжүүлж цахимаар ном унших 3-н TABLET-г шинээр суурилуулснаар **823** орчим уншигчид үйлчлүүлж нийтдээ **1009** хүн үйлчилгээ үзүүлсэн байна. Иргэдэд үйл ажиллагаагаа цахимаар хүргэх зорилгоор http://library.to.gov.mn сайтийг тогтмол ажиллуулаж 2019 оны байдлаар Үйл ажиллагааныхаа талаар 		

4.3 Төсвийг олон нийтэд нээлттэй байлгах болон дотоод үйл ажиллагаа	нэмэлт дансанд тушаан, журмын дагуу зарцуулах **/1.000.000 төгрөг/** 2019он I-IV р улирал 4.3.3 Байгууллагын хийсэн ажлын тайлан мэдээг сар, улирал, жилээр нь цаасан, файл, инфографикаар гаргаж НБХ-т хүргүүлэх. Бодлогын баримт бичиг тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд нь ХШҮ-ний мэдээллийн цахим сангаар тайлагнаж баталгаажуулна. 2019 он I-IV р улирал 4.3.5 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хханган ажиллах 2019 он I-IV р улирал	нийт **29** удаагийн мэдээ, 5 видео мэдээлэл оруулсан. 2019 оны байдлаад 4004 хүн веб сайтад зочилж мэдээлэл авсан байна. Д.Нацагдоржийн нэрэмжит аймгийн нийтийн номын сан нь TBS телевиз болон Төв телевизтэй хамтран үйл ажиллагаагаа сурталчилах зорилгоор **8**-н удаагийн мэдээ,Шторк-2, Төвийн мэдээ сэтгүүлд **2** мэдээ мэдээлэл Үндэсний номын сангаас гаргадаг “Номын санч сэтгүүлд” 1 мэдээ бэлтгэн олон нийтийн хүртээл болгосон. Улирал бүр үйл ажиллагааны гүйцэтгэлийг ИНФОГРАФИКААР гарган уншигчдад хүргэж байна. Байгууллагын төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган сар бүрийн мэдээг гарган, “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг ханган мэдээллийг цаг тухай бүрт байршуулан ажиллаж байна. Нийт 132 мэдээлэл тавигдахаас 121 мэдээлэлийг цаг хугацаанд байршуулж 11 мэдээлэл хоцорч байрлуулсан хэрэгжилт 97,92%-н биелэлттэй байна. Төсвийн тухай хуулийн 44-дүгээр зүйлийн 44.1.3 дахь заалт, 2019 оны үр дүнгийн гэрээг үндэслэн номын сангийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахын тулд Уншлагын танхимуудад карт нээлгэхэд 200 төгрөг Гэрээр ном олгох танхимд карт нээлгэх 1000 төгрөг сургалтын танхимыг ашигласан тохиолдолд 30000 төгрөгний төлбөр хураамж, хугацаа хэтэрсний хураамж зэргээс орлого олж нийт **2.625 700** төгрөгийн орлого төвлөрүүлэн Засгийн газрын тогтоолын дагуу үйл ажиллагаандаа зарцуулан ажиллаа. Аймгийн нийтийн номын сан нь хийсэн ажлын тайланг сар, хагас, бүтэн		

	4.3.6 Үйлчлүүлэгч, уншигчдын эрх зөрчигдөж буй байдлаар мониторинг хийж төлөвлөгөө гарган ажиллах	жилээр цаасаар гарган НБХэлтэст хүргүүлэн ажиллаж байна. Номын сангийн үндсэн үзүүлэлт болох Фонд баяжилт, Уншигч, олгож уншуулсан ном, Зөөврийн номын сан, Орлого, Боловсон хүчний хангалт, Соёл олон түмний ажлыг инфографикаар улирал бүр гарган иргэдэд үйл ажиллагаагаа сурталчилж байна. Мөн Аймгийн ИТХ, ИТХТ-н тогтоол шийдвэр, Аймгийн засаг даргын захирамж, 2016-2020 оны засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, Хууль тогтоомжийн хэрэгжилтйг цахимаар тайлагнан баталгаажуулан ажиллаж байна.		
	4.4.1 Албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад анхаарах, хоолны хөнгөлөлт үзүүлэх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Номын сангийн нийтийн уншлагын танхимыг ном алдах эрсдэлээс хамгаалж хяналтыг сайжруулах үүднээс камерыг ажиллагаанд оруулж, хянах дэлгэцийг номын санчийн хажууд байрлуулсан. Үндсэн фондны утаа болон хөдөлгөөн мэдрэгч дохиоллын систем хэвийн ажиллаж байгаа. Хяналтын дэлгэцийг ажиллуулаcнаар ном алдах эрсдэл буурсан.		
	4.4.2 "Бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын жил"-ийн хүрээнд байгууллагын нөөц бололцоо ажилтан, албан хаагчдын санал санаачилгыг дэмжин амрах өрөөг тохижуулах болон гаднах ногоон байгууламж,	Үйлчлүүлэгч, уншигчдын эрх зөрчигдөж буй байдлаар мониторинг хийх, ая тухтай байдлыг хангах зөрчил дутагдлыг нь арилгах зорилгоор тусгай төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Энэ хүрээнд үйлчлүүлэгчдийн ихэнхи хувийг эзэлдэг ЕБС-н Хүмүүн, 4,5-р сургуулийн 96 сурагчид, 2,6,4-р багийн иргэдээс санал асуулга авч дүгнэлт хийн ажиллаж байгаа ба		

4.4 2019 оны урианы жилийн ажил, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	гэрэлтүүлгийг сайжруулах 2019он I-IV р улирал	“Хүүхдээ сонсох өдөр”-р 5-р сургуулийн сурагчаас гарсан саналын дагуу ЭЕШ-н 9 төрлийн 19 ширхэг номыг авч сан хөмрөгийн баяжилт хийсэн. Татгалзлын дэвтэрээр 16-н номын санал ирж 9 ширхэг номоор фонд баяжилт хийсэн. Номын сангийн фондыг уншигчдын дунд сурталчлах, тэднийг соён гэгээрүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр 14-н номын үзэсгэлэнг **533** номоор **1309** уншигч иргэдэд хүргэлээ. Аймгийн нийтийн номын сангийн албан хаагчдийн нийгмийн баталгааг хангах ажлын төлөвлөгөө ганрган хэрэгжилтийг ханган ажилласан. Энэ хүрээнд албан хаагчдын газар өмчлөл, эзэмшлийн судалгаага гаргасан. Шифийн харилцаатай Мөнгөнморьт суманд эзэмшлийн газрын эрх авахаар сумын ИТХ, Засаг даргад албан тоотыг хүргүүлсэн. 2019 онд батлагдаж ирсэн төсөвт уялдуулан 1 дүгээр сарын 1-ээс албан хаагчидад сар бүр хоолны хөнглөлтийн мөнгө олгож эхэлсэн ба **4.826.500** төгрөг зарцуулсан Улсын бүртгэлийн хэлтэс нүүсэн учраас 1-р давхарт **“Хүүхдийн уншлагын танхим”, “Лавлагаа номзүйн танхим”, “Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан танхим”, “Шинэ номын худалдаа”, “Гэрээр олгох танхим**”-г оруулж үйлчилгээний хүрээгээ өргөжүүлэн ажиллаж байна. УИХ гишүүн Н.Энхболдын дэмжлэгээр Солонгос улсын Пёнтек хотын төлөөлөгчид Аймгийн нийтийн номын сангийн үйл ажиллагаатай танилцан засвар үйлчилгээ хөрөнгө оруулалт хийхээр тохиролцож 1 тэрбум төгрөгний зураг төсвийг хийлгээд байна. Өөрсдийн нөөц боломцоогоор албан хаагчдын амрах өрөөг тохижуулсан. Байгууллагын гаднах ногоон байгууламжийг нэмэгдүүлж улиас, хайлаас тарьж цэцгийн мандал хийж өнгө үзэмжийг сайжруулсан. Аймгийн нийтийн номын сан нь гаднах хаягаа		

		Д.Нацагдоржийн нэрэмжит болсонтой холбогдуулан монгол бичгээр хийлгэж гэрэлтэй болгосон.		
Нийт арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО				

Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт**(тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)**бүрээр хүрэх түвшин		***Жинхэнэ гүйцэтгэл** (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)*	***Өгөх үнэлгээ (0-40 оноо)***	
			НБ Хэлтэс	***ХШҮ Хэлтэс***
1.3 Бүтээлч ажил, арга хэмжээг санаачилж зохион байгуулах	1.3.1 Харааны бэрхшээлтэй иргэдэд номын сангийн үйлчилгээг хүргэх 2019 он I-IV р улирал	Аймгийн нийтийн номын сан нь үйлчилгээний хүрээг өргөжүүлж, уншигчид мэдээлэл авах ая тухтай орчинг бүрдүүлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээг хүргэж ажиллалаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрч үйлчлэхийн тулд хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Зуунмод сумын хөжлийн бэрхшээлтэй иргэдийн төв, Харааны бэрхшээлтэй иргэдийн хобоотой хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Мөн DAISY сонсдог номыг харааны бэрхшээлтэй 6-н иргэний гэрээр нь очиж үйлчилгээ үзүүлсэн. Эдгээр арга хэмжээнд Хөгжлийн бэрхшээлтэй **31**-н иргэнийг хамруулаад байна.		
	1.3.2. Номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа “Анхдугаар таван жил” сонинг скайнердаж цахим хэлбэрт оруулах 2019 он II-XII- сар	Аймгийн нийтийн номын сан нь үйлчилгээний хүрээг өргөжүүлж, уншигчид орон зай харгалзахгүйгээр мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх зорилгоор байгууллагын цахим хуудсын шинэчилэн үйл ажиллагаагаа тасралтгүй иргэдэд сурталчилж байна. Аймгийн “**АНХДУГААР ТАВАН ЖИЛ”** сонинг скайнердаж PDF файл болгон байрлуулж иргэд цахимаар унших боломжтой болсон.		
***"3.Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Үндсэн чиглэл"**-ийн* хүрээнд: Хүний хөгжил мэдээллийн төв болно.	3.1.1 Хүүхэд залуучууд, иргэдийг бие даан сурч боловсрох, хөгжүүлэх зорилгоор дугуйлан ажиллуулна. 2019 оны 3-5-р сард	Аймгийн нийтийн номын сангийн хүүхдийн уншлагын танхимын дэргэд **“Гар урлал”-** ын дугуйлан хичээллүүлж **28**-н хүүхэд хамрагдсан. Мөн Төв аймгийн шатрын холбооны багш Б.Алтантулга нь шатрын анхан, дунд шатны сургалтыг явуулж нийт **16** хүүхдэд, 100 буудалт даамны дугуйланд 12 хүүхэд,		

		Ширээний теннисний дугуйланд 21 хүүхэд хамрагдаж байгаа ба. Нийт **4-н** дугуйланд **77-н** хүүхдүүд хамрагдаж байна.		
	3.1.2 Аймгийн нитийн номын сангийн үйл ажиллагааг хэвийн тогтмол явуулах зорилгоор “**Төслийн баг**”-ийг ажиллуулж судалгаа төлөвлөгөө гарган сургалтанд хамрагдаж төсөл хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх 2018 он I-IV р улирал	Гэрээр олгох танхмыг ”**Гэр бүл хөгжлийн танхим**” болгон өргөжүүлэх төсөл, Мэдээллийн танхимыг “**Хүний хөгжлийн танхим”** болгохоор төсөл боловсруулж Олон улсын байгууллагууд болон хувь хүмүүст уламжлаад байна. Улсын бүртгэлийн хэлтэс нүүсэн учраас 1-р давхарт **“Хүүхдийн уншлагын танхим”, “Лавлагаа номзүйн танхим”, “Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан танхим”, “Шинэ номын худалдаа”, “Гэрээр олгох танхим**”-г оруулж үйлчилгээний хүрээгээ өргөжүүлэн ажиллаж байна. УИХ гишүүн Н.Энхболдын санаачлагаар Солонгос улсын Пёнтек хотын төлөөлөгчид Аймгийн нийтийн номын сангийн үйл ажиллагаатай танилцан засвар үйлчилгээ хөрөнгө оруулалт хийхээр тохиролцож 1 тэрбум төгрөгний зураг төсвийг хийлгээд байна. ДЗОУБ-н Төв ОНХХөтөлбөрийн дэмжлэгтэйгээр БСУГазартай хамтран 2019 оны 12-р сараас 2020 оны 06-р сар хүртэл “Номын сайн нөхөр, сургууль”, “Эх хэл хүүхдийн ертөнц” 2 хөтөлбөрийг хэрэгжүүлж 14.000.000 сая төгрөгний санхүүгийн дэмжлэг авхаар шийдэрлэгдсэн.		
4.3.Төсвийг олон нийтэд нээлттэй байлгах болон дотоод үйл ажиллагаа	4.3.4 Архивын улсын үзлэгийн утгаж төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах	Архивын улсын үзлэгийн утгаж төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилласан. Уг арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан сургалт семинааруудад хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн. Архивийн 2001-2018 оны баримтыг янзлан хадгаламжийн нэгж үүсгэн байршуулсан. Мөн архивын тусдаа өрөөтэй болгон баримт материалыг түр,		

		байнга, 70 жилээр ангилан хаягжуулсан. Архивийн улсын үзлэгийн орон нутгийн үнэлгээгээр 82.22%-н үнэлгээтэй дүгнэгдсэн.		
Тусгай арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО				

ХОЁР. ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

ГУРАВ. МАНЛАЙЛАЛЫН ЗОРИЛТ

Манлайллын зорилт	***Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ***	***Гүйцэтгэл*** */хүрсэн түвшин/*	***Өгөх үнэлгээ (0-30 оноо)***	
			НБ Хэлтэс	***ХШҮ Хэлтэс***
1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар: Зорилт-1: Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана.	а) Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, б) Байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдээс санал асуулга авч, дүгнэлт гаргах	Шинэчлэн батлагдсан төрийн албан хаагчын ёс зүйн дүрмийг бүх албан хаагчдаар уншуулан гарын үсэг зуруулсан. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруусан. Аймгийн нийтийн номын сангийн 12 албан хаагчдад авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх авилга ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх мэдээлэл сурталчилгааны ажлыг хийж, гарын авлага мэдээллийн материал тараасан. Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх авилга ашиг сонирхолын зөрчлөөс ангид байхын тулд төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хanган ажиллаж байна. 2019 онд сахилга хариуцлага, авилга ашиг сонирхолын зөрчилгүй ажилласан. Номын санчдын харилцаа, номын хүртээмж, орчин нөхцлийн талаарЕБС-н Хүмүүн, 4,5-р сургуулийн 96 сурагчид, 2,6,4-р багийн иргэдээс санал асуулга авч дүгнэлт хийн ажилласан.		

		Судалгаанд анализ хийж үзээд уншигчдын хүсэлтийн дагуу ЭЕШ-н 9 төрлийн 19 ширхэг ном, Монголын зохиолчдын сүүлийн үеийн уран зохиолын ном болон хүүхдийн зохиолын ном, гадаад хэл, түүх, танин мэдэхүйн ном авч сан хөмрөгийн баяжилт хийсэн.		
2.Байгууллагын ил тод байдлыг хангах талаар: Зорилт-2: Байгууллагын нээлттэй ил тод байдлыг сайжруулах.	а) Монгол улсын Засгийн газрын 143-р тогтоолыг хэрэгжүүлж, ил тод байдлыг илтгэх самбарын мэдээллийг тухай бүр шинэлэн иргэд уншигчдад мэдээллийг ил тод байлгах. б) Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах, батлагдсан журмын дагуу төлөвлөгөө гарган ажиллана.	Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дээд байгууллагаас гарсан номын сангийн холбогдолтой бүх хууль, тогтоомж дүрэм, журам, зааврыг нийтэд сурталчилах, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зорилгоор номын сангийн 2 давхарын коридорт **400.000** төгрөг зарцуулж мэдээллийн самбарыг шинэчилсэн. Цахим мэдээллийг иргэдэд хүргэхийн тулд www.library.to.gov.mn цахим хуудсыг ажиллуулж **29** удаагийн мэдээ мэдээлэл видео мэдээлэл 5-г оруулсан 2018 онд вэб сайтаа шинэчилснээр Д.Нацагдоржийн бүтээлийг унших болон сонсдог болсноор онцлогтой. Шинээр цахим хуудас ажиллаж эхэлсэн 2018.09.01 ээс хойш **7023** хүн хандаж 2019 оны байдлаар 4004 хүн зочилсон дүнтэй байна Байгууллагын “Дотоод хяналт шалгалт”-ын ажлын төлөвлөгөөний дагуу ажил үүргийг гүйцэтгэж улирал бүр хийсэн ажлын тайланг байгууллагын шуурхайгаар танилцуулан ажилладаг. Мөн ил тод байдлаар цахим болон мэдээллийн самбарт нээлттэй мэдээллэн ажиллаж байна. Мөн аймгийн засаг дарга, АЗДаргын нэрэмжит үзлэгийн тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу тусгай төлөвлөгөөнүүд гарган хэрэгжилтийг ханган ажилласан.		
3.Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах талаар: Зорилт-3: Байгууллагын төсвийн ил тод байдлыг хангаж	а) Батлагдаж ирсэн төсөв болон улирал, сарын тайланг хугацаанд нь гаргаж холбогдох дээд байгууллагад хүргэх ба өөрийн байгууллагын төсвийн	2018 оны төсвийн гүйцэтгэл, 2019 оны төсөв, сар бүрийн төсвийн мэдээг шилэн дансны веб сайт болон байгууллагын цахим хуудас дахь “төсөв санхүүгийн ил тод байдал”-н цэсэнд байрлуулан цахимаар хүргэж байна. Мөн байгуулагын “төсөв санхүүгийн ил тод байдал”ын самбараар		

ажиллах.	ил тод байдлыг самбар, вэб сайтад байрлуулан иргэдэд ил тод байлгах. б) Төсвийн зөв төлөвлөлт, төсвийн хэтрэлт, хууль бус үйлдэл, зориулалт бус зардал гаргахгүй, өр авлага үүсгэхгүй ажиллана.	дамжуулан мэдээллийг иргэд чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн. Байгууллагын төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган сар бүрийн мэдээг гарган, "Шилэн дансны тухай" хуулийн хэрэгжилтийг ханган мэдээллийг цаг тухай бүрт байршуулан ажиллаж байна. Төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажилласнаар өр авлага үүсгээгүй.		
4.Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах талаар: Зорилт-4: Мөнгөн хөрөнгийг зохистой ашиглах Зорилт-5: Биет хөрөнгийн нөөцийг зохистой ашиглах	а) Төсвийг үр ашигтай хуулийн хүрээнд зарцуулна. Төсвийн хууль, холбогдох журам зааврыг мөрдөж зардлыг хэтрүүлэхгүй ажиллана. б) Ашиглагдаж байгаа биет хөрөнгийн хадгалалт хамгаалалтанд хяналт тавина. Биет хөрөнгийн ашиглалтыг сайжруулна.	2019 оны батлагдаж ирсэн төсөвт багтаан сар бүр ажил гүйлгээг зохих дүрэм журмын дагуу үр ашигтай хэмнэлттэй зарцуулан ажиллаж байна. Эд хөрөнгийн хамгаалалтыг сайжруулах үүднээс Дотоодын хяналт шалгалтын 2019 онд хийх ажлын төлөвлөгөөнд тусгасаны дагуу хагас, бүтэн жилийн тооллогыг хийсэн. Мөн бүх албан хаагчидтай эд хөрөнгийн хариуцлагын гэрээг байгуулж үүрэгжүүлэн ажиллаж байна.		
5.Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх талаар: Зорилт-6: Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод нээлттэй байдлыг хангах	а) Боловсон хүчний бүрэлдэхүүн хөдөлгөөн, хангалтыг хариуцан тайланг хугацаанд нь гаргаж байх.	Боловсон хүчний бүрэлдэхүүн хөдөлгөөн, хангалтын тайланг хугацаанд нь гаргаж өгсөн. 2019 онд гарсан сул орон тоо байхгүй.		

УВС АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

АГУУЛГА:

10. Ерөнхий мэдээлэл
11. Сан хөмрөг, Каталог
12. Үйлчилгээ
13. Хүний нөөц
14. Технологи
15. Төсөв. Орлого, Зардал
16. Бусад
17. Хавсралт – Зураг, статистик СУ3, СУ10, СУ15

Тайлбар:
Увс аймгийн номын сангийн 2019 оны үйл ажиллагааны тайланг дээрх 8 бүлэгт хуваан харуулсан байдал.

9. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

9.1. Эрхэм зорилго:

Монгол Улсын Соёлын талаар төрөөс баримтлах бодлого, Соёлын тухай хууль, Засгийн Газрын шинэчлэлийн бодлого, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, **“Номын санг иргэдэд үйлчлэх мэдээллийн төв болгон ажиллах”**

9.2. Номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл:

Манай номын сан нь 1936 онд байгуулагдсан, нийт .14 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Тус номын сан нь Уншлага үйлчилгээний 3 танхим, интернет мэдээллийн танхим, Америкийн соёл мэдээллийн танхим, Туркийн соёл мэдээллийн танхимаар үйл ажиллагаагаа явуулж байна .

Өвлийн улирлын ажиллах цагийн хуваарь: Өвлийн улирлын цагийн хуваарь нь 10-р сарын 01 -наас дараа жилийн 6-р сарын 15 хүртэл үргэлжилнэ.

Зуны улирлын ажиллах цагийн хуваарь: Зуны цагийн хуваарь нь 6-р сарын 15-аас 10-р сарын 01 хүртэл үргэлжилнэ.

Байгууллагын утасны дугаар: 70452477

Номын сангийн захирал: Б. Булган

10. САН ХӨМРӨГ, КАТАЛОГ

10.1. Сан хөмрөгийн өнөөгийн байдал

Орон нутгийн онцлог уншигчдын эрэлт хэрэгцээ шаардлагыг үндэслэн төсөв, төсөл, бэлэг хандивын журмаар фондоо бүрдүүлж байна.

10.2. Сан хөмрөгийн бүрдүүлэлт

2019 оны тайлант жилдТөв номын сан 6010000 төгрөгөөр фондоо баяжуулах төлөвлөгөөтэй байсан ба жилийн эцсийн тайлангаар нийт 599 ширхэг **8.953.599** төгрөгний номоор фондоо баяжуулж ажиллаа .
2019 онд Хүмүүн бичиг, Өдрийн сонин, Зууны мэдээ, Өглөөний сонин, Номын санч сэтгүүл, Төрийн мэдээлэл, Увсын амьдрал гэх мэт **498700** төгрөгний хэвлэл захиалж иргэдэд үйлчиллээ.
Номын фондонд тавигдах Монгол Улсын стандарт MNS5742:2007 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
Фондын стандартыг нөхцөлийг сайжруулахын тулд мэрэгч амьтадаас хамгаалах хор тавьж, хлороминтай усаар тавиур болон номоо арчиж ариутгаж байна.
Фонд хадгаламжийн байранд байгаа номонд тохиолдолын чанартай үзлэг явуулж шаардлагатай номонд сэргээн болон сэлбэн засах ажлыг тогтмол хийж байгаа. Фондын өрөөнд байнга нойтон цэвэрлэгээ хийж,чийгшүүлэх зорилгоор савтай ус,агааржуулах зорилгоор цэцэг тавьж байнга арчилж байна.Мөн стандартанд заагдсанаар тавиур хоорондын зай, өндөр, нам, номын багтаамж зэргийг ханган зориулалтын номын тавиуруудыг тавилаа. Фондын дулаан хэмжих багаж тавьж бүртгэл хөтлөн ажиллаж байна.

2.3. Каталог зохион байгуулалт

Монгол, орос фондын номыг электрон каталогт бүртгэж дуусснаар номын сангийн бүх ном хэвлэлийг электрон каталогт 100 хувь орууллаа. Мөн 599 ширхэг шинээр ирсэн номонд техник арга ажиллагаа хийн данс бүртгэлүүдэд тусган тасаг танхимууд хуваарилан уншлага үйлчилгээнд ашиглуулж

3. **ҮЙЛЧИЛГЭЭ**

3.3. Уншлага үйлчилгээ

- шинээр 5056 шинэ уншигчдад карт нээж үйлчиллээ
- 2019 онд нийт уншигчдын тоог 38239-д хүргэж ажиллаа.
- 10164 нэр төрлийн 45848 ширхэг ном хэвлэл олгож үйлчиллээ

Үзүүлэлт	Тоо, хэмжээ
Аймгийн төвийн иргэдийн тоо	
Бүртгэлтэй уншигчийн тоо	5056
Номын сангийн ирц	38239
Олгосон ном	45848

Мөн ерөнхий боловсролын сургуулиудын зорилтот анги бүлгүүдэд зөөврийн номын сангаар хүрч үйлчлэх, шаардлагатай албан байгууллагуудад гэрээ байгуулан зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Нүүдэл зөөврийн номын үйлчилгээгээр нийт 31 нэгжийн 708 хүнд 1051 ширхэг ном олгож үйлчилсэн байна . Сагил сумын Бижийн хөдөлмөр зусланд амарч байсан 150 хүүхдүүдэд 500ш, ном олгож үйлчилсэн байна .

Мөн сургуулийн өмнөх боловсролын 1, 4, 6, 9-р цэцэрлэгийн 500 хүүхдүүд номын сангийн үйл ажиллагаатай танилцаж тэдэнд ном унших ач тус, номтой нөхөрлөх, талаар яриа таниулга хийлээ.
Ерөнхий боловсролын 16 бага бүлгийн 770 суралцагчдыг номын сангийн үйл ажиллагаатай танилцуулж, танин мэдэхүйн, шинжлэх ухааны номоор тойм яриа хийж, хичээлийн бус цагаар буюу чөлөөт цагаараа номын сангаар үйлчлүүлж өөртөө хэрэгцээт мэдээлэл олж авах талаар яриа танилуулгыг тогтмол хийж байна.

3.4. Соёл олон нийтийн ажил:

Манай номын сан нь ном зүйн мэдээллийн үйл ажиллагааг боловсронгуй болгох үүднээс 82 удаа шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргаж 21 удаагийн тойм хийж, 750 суралцагчдыгзохион байгууллалттай уншлаганд хамруулж танин мэдэхүйн чиглэлээр төрөл бүрийн ажлуудыг тогтмол зохион байгуулж байна

2019 оны жилийн эцсийн байдлаар төв номын сан нийт 12- соёл, олон нийтийн ажил зохион байгуулсан байна. Үүнд:

1. ЕБ-ын 6-р сургуулийн Монгол хэл уран зохиолын багш Г. Оюун-эрдэнэ нь хувийн номын сандаа 150 гаруй номын цуглуулгатай. Хувийн номнуудаасаа сургууль дээрээ үзэсгэлэн гаргаж суртчиллаа.

2.Залуу яруу найрагч Б. Баттогтохын” Хүслийн хязгаар” номын нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа.

3.Д. Намдаг “Үрэгдсэнийг хүлээгч “зохиолоор ХДС-ын оюутнуудын дунд хэлэлцүүлэг зохион байгууллаа.

4. Дэлхийн номын өдрөөр уншигчдын дунд АХА тэмцээн зохион байгууллаа. Танин мэдэхүй АХА тэмцээнийг Ахлах ангийн сурагчдын дунд зохион явуулсан бөгөөд давхардсан тоогоор 100 гаруй сурагч оролцлоо.

   1-р байр Улсын тэргүүний ЕБ-ын лаборатори 1-р Цогцолбор сургуулийн 10в ангийн сурагч Б.Өнөболд,
   2-р байр 11г ангийн сурагч Н.Түвшинбаяр,
   3-р байр 10в ангийн сурагч Б.Батсайхан нар эзэллээ.
5. Өсвөр үеийн яруу найргийн **БАТЗЭВЭГ-2019** шүлгийн 5 дахь удаагийн наадам зохион байгууллаа.
6. Хилийн цэргийн 0245-р ангийн бие бүрэлдэхүүний дунд "Номын өдөрлөг "зохион байгууллаа. Үүнд : "Ном уншихын ач тус" сэдвээр яриа хийх,

   Уншсан номноосоо танилцуулж, хамт олноо ном идэвхтэй уншихыг уриалах

   "Миний унших дуртай ном" 2019 оны азтан шалгаруулах Цэнгээнт тэмцээн зохиох

   Тэргүүний уншигч"-ийг шалгаруулах

   Номын үзэсгэлэн гаргаж ном олгох зэрэг олон төрлийн ажил зохион байгууллаа. 2018 "Тэргүүний уншигч"-аар: Ахмад Д. Энхтуяа, 2019 оны "Тэргүүний уншигч"-аар дэд ахмад Н.Энэрэл нар шалгарч Нацагдорж тэмдэг ,дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа.

   Цэнгээнт тэмцээн зохион явуулсанд: Ахмад Д.Энхтуяа , түрүүлж дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан. Мөн номын санч Цэцэгмаатай хамтран зөөврөөр 247 ширхэг номоор үйлчилгээ үзүүлж, Амьдрах ухаан, Монгол уран зохиол, Гадаадын уран зохиол, Хүүхдийн номоор тус тус үзэсгэлэн гаргалаа.
7. Дэлхийн номын өдрийг тохиолдуулан уншлагын танхимд "Зохиолч,уншигчдын уулзалт" зохион явууллаа. Үүнд: Орон нутгийн ахмад зохиолч Ж.Дэлэг, Б.Цэрэн-Оол нар уншигчидтай ном уншихын ач холбогдол болон хүүхдийн төлөвшлийн талаар чөлөөт ярилцлага хийлээ.

Цогцолбор 2-р сургуулийн байрны багштай хамтран 65 ширхэг ном зөөврөөр үйлчиллээ. Мөн байрны сурагчдын дунд ном унших аян зарлаж, АХА танин мэдэхүйн тэмцээн зохион явууллаа.

8. **Монгол бичгээр сайхан бичигтэн”** уралдааныг зохион байгуулж ирсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж , шалгаруууллаа. Нийт давхардсан тоогоор 100 гаруй бүтээл ирснээс:

Хичээнгүй бичлэгт:

1-р байр: Ахлах 4-р сургуулийн 8-б анги Д.Саруул Өргөмжлөл, алтан медаль, дурсгалын зүйл

2-р байр: Ахлах 3-р сургууль 12-б анги Б.Уугaнзаяа Өргөмжлөл, мөнгөн медаль,

дурсгалын зүйл

3-р байр: Цогцолбор 2-р сургууль 11-в анги Д.Даваасүрэн Өргөмжлөл,хүрэл

медаль,дурсгалын зүйл

Тусгай байр: Цогцолбор 2-р сургууль 11-в анги Сумъяабазар Өргөмжлөл, хүрэл

медаль,дурсгалын зүйл

Бүтээлийн төрөлд:

1-р байр:6-р сургууль 12-в анги Б.Одонтунгалаг Өргөмжлөл, алтан медаль, дурсгалын зүйл

2-р байр: Ахлах 4-р сургууль 11-анги Б.Эрдэнэцэцэг Өргөмжлөл, мөнгөн медаль, дурсгалын зүйл

3-р байр: Ахлах 3-р сургууль 10-а анги Г.Номин-Эрдэнэ Өргөмжлөл, хүрэл медаль,дурсгалын зүйлээр тус тус шагнаж урамжууллаа.

9. Цогцолбор 1-р сургуулийн байрны багш Буянтогтохтой хамтран 115 ном зөөврөөр өгч үйлчилсэн.Мөн сурагчдын уран уншлага,хэл ярианы хөгжлийг сайжруулах зорилгоор “Шүлгийг уран яруу тод унших уралдаан зохион явуулж шагнаж урамшууллаа.

10. Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Цогцолбор 1-р сургуулийн 7р ангийн сурагчдын дунд Монголын нууц товчоог хэн сайн мэдэх вэ? Сэдэвт Дэвжээ тэмцээнийг багш Б.Өлзийтэгштэй хамтран зохион байгуулсан. Мөн хөгжөөн дэмжихээр ирсэн үзэгчдийн дунд хөгжөөнт цэнгээнт "АХА" тэмцээн, Б.Өлзийтэгш "МНТ" Монголын түүхийн гол эх сурвалж болох нь " лекц тавьж , Фондын номын санч Д.Уранчимэг" Номын сангаар үйлчлүүлэх соёл" сэдвээр яриа хийлээ..
11. Улсын Тэргүүний Солонго 4р цэцэрлэг , 5, 7,8,10-р цэцэрлэгийн багачуудад Номын санч гэж хэн бэ, Ном хэрхэн сэлбэн засах болон номын сан гэж юу вэ сэдвээр яриа таниулга хийж Чанга уншлага хийж ажиллаа.
12. "Хорвоо дэлхий уужим хийх ажил их байна" номоор ХХҮХ-ийн ажилтнуудын дунд өглөөний уншлага зохион байгууллаа.
13. Охидоо хамгаалья, Дураараа биш дүрмээрээ аяны хүрээнд Цагдаагийн газрын хүүхдийн байцаагч Ж.Буянтогтох, багийн цагдаа нартай хамтран цогцолбор сургуулиудын ахлах ангийн 60 д сурагчдад Бэлгийн хүчирхийлэл түүнээс сэргийлэх, замын хөдөлгөөний дүрэм, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө өгч хамтран ажиллаа. Мөн энэ үеэр "Охид эмэгтэйчүүдэд "зориулсан номын үзэсгэлэн гаргалаа. Энэ үйл ажиллагааг САМА телевизээр суртчиллаа*.*

- Хүүхдийг бага наснаас нь номонд дуртай болгох зорилгоор цэцэрлэгийн багачуудыг номын сангийн үйл ажиллагатай танилцуулах ажлыг зохион байгуулж 2-р цэцэрлэгийн Цэвэлмаа багштай бэлтгэл 1,2 –р бүлгийн 100 гаруй хүүхдэд үйлчиллээ.

Хүүхдийн уншлагын танхимаас **1251** шинэ уншигчидад карт нээж байнгын уншигчийн тоог өсгөн нийт уншигчдын тоог **11163** –д хүргэж ажиллаа.

Хүүхдийн уншлагын танхимаас хүүхэд багачуудад **2448** төрлийн **13075** ширхэг ном хэвлэлээр үйлчилж ажиллалаа.

Олон улсын гэр бүлийн өдрийг угтан "**Гэр бүлийн уншлага"-**ын цагийг долоо хоног бүрийн хагас сайн өдөр 11-16 цагийн хооронд зарлан ажиллаж байна.

14. Хүүхдийн уншлагын танхимаас хамгийн их ном уншсан уралдааныг зохион байгуулж 2018 оны "**Тэргүүний уншигч**"-аар Цогцолбор 1-р сургуулийн **5и**

ангийн сурагч Б.Өсөх-Ирээдүй , 2018 оны хамгийн их уншлаганд гарсан "**Рекорд ном**"-оор **Илона Б. " Амьтдын хэл"** номыг шалгаруулан суртчиллаа.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоон дээр очиж 150 ширхэг номоор шинэ номын үзэсгэлэн гаргаж үйлчилгээ үзүүллээ.
- Хараaны бэрхшээлтэй иргэдийн төвд сонсдог зохиолуудаас 6 ширхэг цахим номыг СД-нд бичиж хүргүүллээ.
- ХХҮХ-ийн дэргэдэх Асрамжийн төвд асруулж байгаа 13 хүнд нийгмийн ажилтантай нь хамтран зөөврийн номын үйлчилгээг үзүүлж ажиллаа.
- Байгууллагын гаднаас орох хаалганд налуу шат зам шинээр хийлээ.
- Интернэт–Мэдээллийн танхим болон цахим үйлчилгээгээр нийт давхардсан тоогоор 8160 хүнд үйлчилсэн байна. Үүнээс :
- Иргэдийн гар дамжин хэрэглэгдэж элэгдэж урагдсан, хуучирсан 2500 ширхэг номыг сэргээн засварласан. Үүнээс: номын санч Алтанцэцэг 5250 ширхэг, Номын санч Биньеэ 5250 ширхэг, Номын санч Жаргал 500 ширхэг, номын санч Уранчимэг 500 ширхэг ном сэлбэн зассан байна.

4. ХҮНИЙ НӨӨЦ

Арга зүйн ажлын хүрээнд:

- Нийт ажилчид хэлний мэдлэгээ дээшлүүлэн англи хэлний сургалтанд хамрагдав.
- Мөн үндэсний бичиг үсгийн сургалт болох "Монгол бичгийн сургалт"-нд ажилчид хамрагдаж түвшингээ тогтоолголоо.
- Америкийн төвийн ажилтан Соёлмаа Youth opportunities Mongolia залуучуудын олон улсын чуулганд оролцлоо..
- -Номын санчЛ. Алтанцэцэг, мэдээллийн ажилтан Д. Нямбилэг нар номын санчийн эчнээ ангид суралцаж байна.
- Арга зүйч М. Лхагважав УБ хотод арга зүйчдийн сургалтанд хамрагдлаа.

Ня-бо Ц. Батзул Сангийн яамнаас зохиогдсон сургалтанд хамрагдлаа.

- 19 сумын соёлын төвийн номын санчдад"**Нүүдлийн номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх нь**" сэдвээр мэргэжил арга зүйн сургалт зохион байгуулж , тэдний дунд ур чадварын уралдаан зохион байгууллаа.

5. ТӨСӨВ. ОРЛОГО, ЗАРДАЛ

Төсөв санхүүгийн талаар:
Байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд жил бүрийн эхний 7 хоногт багтаан хамт олны хурлаар санхүүгийн мэдээллийг тогтмол хүргэж, “Шилэн халаас”, “Шилэн данс” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийн самбар ажиллуулж, иргэд олон нийтэд мэдээллэж байна. Байгууллагын Вэб сайт болон www.shilendans.gov.mnшилэн дансны вэб сайтад жил, улирал, сар, тухай бүрд төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах өр авлага үүссэн шийдвэрийг байршуулан ажиллаа. 206187580 төгрөгний санхүүжилттайгаар 2019 онд өр авлагагүй ажиллаа.
Шилэн халаас хөтөлбөрийн хэрэгжилт болон монитерингийн үнэлгээгээр “**96,5 “** дүнтэй шалгагдлаа. 2019 онд ирсэн хөрөнгө оруулалт хандив:

- ✓ **БСШУЯ-наас 1.441.550 төгрөгний компьютер**
- ✓ **Иргэдээс -186 ш 1.874.610 төгрөг ном хэвлэл авлаа.**

6. БУСАД

4.Мэдээлэл, ном зүйн ажлын хүрээнд:
Байгууллагын фэйсбүүк хаяг болон ил тод байдлын самбар уншлагын танхимуудын мэдээллийн самбарыг хэрэгцээт мэдээллээр ажиллуулж, зохион байгуулж буй соёл олон нийтийн ажлууд болон олон талт үйл ажиллагааг цахим сайтад тавих нь ном ашиглалтанд сайн нөлөө үзүүлж байна.
Улирал бүр шинэ ирсэн номын мэдээг бэлтгэн ном зүйн мэдээллийн самбарт болон Фэйсбүүк группт байрлуулан, уншигч хэрэглэгчдэд лавлагаа өгч хэрэгцээт мэдээллээр ханган ажиллаж байна.
Уншигчдад хэрэгцээтэй гарын авлага 35 ширхэг хийж үйлчилгээнд ашиглууллаа.

- **Шинээр санаачилж хийсэн шинэлэг бүтээлч ажил:**

- ❖ Байгууллагын судар номонд баринтаг оёлоо.
- ❖ Уншлагын заалны үзэсгэлэнгийн хаягнууд, тэргүүний уншигч, рекорд ном, лавлагааны булан, хичээнгүй бичиг, фондын судар ном, монгол бичгийн булангын хаягнуудыг нийтдээ 18 ш хаяг монгол бичгээр бичүүлж хаягжууллаа.
- ❖ Хүүхдийн уншлагын танхимын таазыг дүүжин болгож, ханыг будаж заслаа.
- ❖ Ном зүйчийн өрөөний шалыг паркет болголоо
- ❖ Оюуны ундарга уншлагын танхимын цонхны хөшигнүүдийг сольж шинэ хөшиг тогтоолоо.

Манай хамт олон 2019 онд амжилт бүтээл дүүрэн ажиллаа. Увс аймагт зохион байгуулдагдсан "Нийгмийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо " чуулганы үеэр Нягтлан бодогч Ц. Батзул санхүү банкны тэргүүний ажилтан цол тэмдэгээр, ном ажиллагч Н. Соёлмаа БСШУС-ын яамны хүндэт жуух бичгээр, номын санч Б. Биньеэ МУСТА цол тэмдэгээр шагнагдлаа.

Хавсралт зураг :

Ном сэлбэн засалт:

7 хоног бүр САМА телевизээр шинэ номоо суртчилж ажилладаг:

Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн 80 удаа гаргаж суртчиллаа.

ХЦ-ийн 0245-р ангид номын баярыг тэмдэглэн
шилдэг уншигчийг шалгаруулаа.

Номын баярын арга хэмжээнээс:

өсвөр үеийн яруу найргийн **БАТЗЭВЭГ-2019** шүлгийн 5 дахь удаагийн наадам:

WORD TEASER" уралдаант хөгжөөнт тэмцээн:

Англи хэл дээрх Алтан хонх тэмцээн:

МНТ зохиолоор дэвжээ тэмцээн:

Сагил сумын Бижийн Хөдөлмөр амралтын зусланд амарч байсан сурагчдад зөөврийн номын үйлчилгээг үзүүллээ.

Охидоо хамгаалья, Дураараа биш дүрмээрээ аяны хүрээнд:

Дэлхийн номын өдрөөр:

Фонд хадгалалт хамгаалалт:

Монгол бичгээр сайхан бичигтэн:

Бүтээлч ажил:

ХЭЛ ШИНЖЛЭЛ
ХҮНИЙ ХӨГЖИЛ
ГҮН УХААН
АМЬДРАХ УХААН

УРАН ЗОХИОЛ
УРАН ЗОХИОЛ
ТҮРК НОМ
ОРОН НУТГИЙН
ЗОХИОЛЧИД
УТГА ЗОХИОЛ
АМАН ЗОХИОЛ

НОМЫН ҮЗЭСГЭЛЭН

ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ
РЕКОРД НОМ

ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ
РЕКОРД НОМ



ХОВД АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН
2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2019.12.10

Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Соёлын талаар төрөөс баримтлах бодлого, Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлтэнд анхааран Аймгийн Засаг Даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллав.

2019 оны эхнээс байгууллагын ажлын төлөвлөгөөг жилээр гаргаж зорилго зорилтууд, хийгдэх ажлын талаар ярилцан нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллав.

Нийтийн номын сан нь 2018-2020 оны Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Оюунтүлхүүр" дэд хөтөлбөр, "Цахим номын сан" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ховд аймгийн Нийтийн номын сан 2019 онд 18 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт 5 тасаг танхимаар уншлага үйлчилгээг хүргэж ажиллаж байна.

Статистик үзүүлэлт:

2019 оны статистик тоон мэдээллийг төлөвлөгөөтэй харьцуулбал:











Байгууллагаас зохион байгуулж буй соёл олон нийтийн ажил болон хийгдэж буй арга хэмжээ, мэдээлэл сурталчилгааг Фейсбүүк хуудсанд тогтмол байршуулан баяжуулан ажиллаж байна. Фейсбүүк хуудасны LIKE 8000 болж өсөж бусад байгууллагуудаас лайкны тоогоороо тэргүүлж байна.



Шилэн дансны мэдээллийг цаг тухай бүрд нь www.shilendans.gov.mn сайтад шивж оруулж тайланг улирлаар цаг тухайд нь илгээсэн.

Байгууллагын админаар захирал Т.Эрдэнэтуяа, хэрэглэгчээр Нягтлан бодогч О.Чанцалмаа, Бичиг хэрэг Б.Оюундэмбэрэл, Мэдээллийн ажилтан П.Бямбазаяа нарыг томилон цаг тухай бүрд нь мэдээллийг тогтмол шивж оруулж ажилласан.

Байгууллагын 2018 оны Ирсэн бичиг, Явуулсан бичиг, Захиралын /А,Б/ тушаал, ажилтнуудын тайлан

, үр дүнгийн гэрээ, хурлын тэмдэглэл, үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг архивын баримт бичгийг хавтаслаж, товъёог үйлдэж, баталгааны хуудас хийж

архивлав.

оны Захиралын А/Б тушаалыг архив бичиг хэргийн AMG програмд оруулав.

I. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД:

2019 оны тасаг танхимуудын хамгийн их уншигдсан аварга номууд шалгарлаа.

Эрдэм шинжилгээ-Чөлөөт уншлагын танхим:

1.Б.Догмид.Оосор бүчгүй орчлон. 2019 оны аварга ном 163 удаа уншигдсан
2.Дэлхийн уран зохиолын 80 сод туурвил 2019 оны аварга ном 159 удаа уншигдсан
3.Б.Батмөнх.Монголын эртний түүхийн лекцүүд 2019 оны аварга ном 151 удаа уншигдсан

Гэрээр ном олгох тасаг:

1. Ц.Оюунгэрэл Жаран цагаан хонь 280 удаа уншигдсан.
2. Д.Пүрэвийн БОЛОР НҮД роман 202 удаа.
3. Т.Эмүүжин ХӨХ САРНЫ ЯВДАЛ 184 удаа.

Уншлагын их танхим:

1. Монголын нууц товчоо 504 удаа
2. Д.Нацагдоржийн шилдэг бүтээл 488 удаа
3. Чингис хаан хүүхдийн цуврал зохиол 500 удаа хамгийн олон уншигдсан аварга номоор шалгарлаа.

Америкийн мэдээллийн төв:

1. English grammar 216 удаа,
2. Oxford толь бичиг 201 удаа,
3. Selected stories by D.H.Lawrence 160 удаа уншигдаж аварга номоор шалгарлаа.

Хүүхдийн Үл мэдэх танхим:

1. Динза цуврал ном хамгийн их ба 986 удаа уншилганд гарсан байна.
2. Ахмад Күүк 749 удаа
3. Гүнжийн үлгэрүүд 621 удаа уншилганд гарч аварга номоор шалгарлаа.

1. АЙМГИЙН ОЮУНТҮЛХҮҮР ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

1.1 Аймгийн Оюунтүлхүүр дэд хөтөлбөрийн 2.1 дэх заалтыг хэрэгжүүлэх, Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэх, Монгол бичгийн түүх, бичлэгийн төрөл,

хэлбэрийг нэмэгдүүлэх, дэлгэрүүлэх, уралдаанд оролцогчдод урам зориг өгөх, бүтээлийг сурталчлах, үзэсгэлэн гаргаж олон нийтэд сурталчлах зорилгоор Үндэсний бичиг үсгийн баярыг 2019 оны 04 сарын 18,19-ны өдрүүдэд Ховд аймгийн БСУГ-тай хамтран зохион байгуулж тэмдэглэн өнгөрүүллээ.

Тус арга хэмжээний хүрээнд зохион явуулсан Монгол бичгийн уншлагын уралдаанд аймгийн төвийн болон хөдөө сумдын нийт 93 сурагч оролцлоо.

6-7-р ангийн ангилалд

Тэргүүн байранд Ерөнхий боловсролын Цаст-Алтай цогцолбор сургуулийн 7б ангийн сурагч А.Номин-Эрдэнэ

Дэд байранд Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 7д ангийн сурагч С.Цэвээндарь

Гутгаар байранд Ерөнхий боловсролын 3-р сургуулийн 7б ангийн сурагч Д.Оюунгэрэл нар

8-9-р ангийн ангилалд

Тэргүүн байранд Ерөнхий боловсролын 6-р сургуулийн 9а ангийн сурагч Г.Дэлгэрсанчир

Дэд байранд Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 8а ангийн сурагч А.Кунсулу

Гутгаар байранд Ерөнхий боловсролын 6-р сургуулийн 8г ангийн сурагч Д.Мөнгөнхорол

10-12-р ангийн ангилалд

Тэргүүн байранд Ерөнхий боловсролын Цаст-Алтай цогцолбор сургуулийн 11а ангийн сурагч Б.Мөнхтуул

Дэд байранд Ерөнхий боловсролын 2-р сургуулийн 12д ангийн сурагч Н.Амарзаяа

Гутгаар байранд Ерөнхий боловсролын 6-р сургуулийн 11а ангийн сурагч Ж.Мөнхзаяа нар тус тус шалгарлаа.

Хичээнгүй бичгийн уралдаанд аймгийн төвийн болон хөдөө сумдын нийт 78 сурагч оролцсоноос

Ерөнхий боловсролын Цаст-Алтай цогцолбор сургуулийн 10 а ангийн сурагч Б.Алтжин

Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 7д ангийн сурагч Б.Энх-Учрал

Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 9а ангийн сурагч Г.Саранчимэг

Ерөнхий боловсролын Цаст-Алтай цогцолбор сургуулийн 11 а ангийн сурагч Б.Сугармаа

Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 9г ангийн сурагч Х.Ундрал

Ерөнхий боловсролын 3-р сургуулийн 10в ангийн сурагч Г.Хонгорзул

Ерөнхий боловсролын Цаст-Алтай цогцолбор сургуулийн 8а ангийн сурагч Х.Алтанжин

Ерөнхий боловсролын Цаст-Алтай цогцолбор сургуулийн 9в ангийн сурагч Б.Анар

Ерөнхий боловсролын 2-р сургуулийн 11а ангийн сурагч Н.Амарзаяа

Ерөнхий боловсролын 3-р сургуулийн 9б ангийн сурагч Г.Учрал нар Хичээнгүй бичигтэн үнэмлэх, тэмдгээр шагнагдлаа.

Мөн тусгай байрыг Прогресс сургуулийн 12а ангийн сурагч Б.Мичидмаа, Ерөнхий боловсролын 6-р сургуулийн 11б ангийн сурагч Н.Сумъяабазар, Ерөнхий боловсролын Цаст-Алтай цогцолбор сургуулийн 7б ангийн сурагч Г.Мишээл нар тус тус шалгарч МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч Б.Ариун-Эрдэнэ өөрийн нэрэмжит шагналаар шагнаж урамшууллаа.

Бичиг үсгийн баярыг тохиолдуулан зохион байгуулсан монгол бичгийн "Уран бичлэг" -ийн уралдааны Тэргүүн байранд Манхан сумын ЕБС-ийн 10а ангийн сурагч З.Хишигдэлгэр, Дэд байранд Ерөнхий боловсролын 3-р сургуулийн багш Ц.Насанхишиг, Гутгаар байранд Ерөнхий боловсролын 2-р сургуулийн багш Б.Эрдэнэболд, Тусгай байранд ХИС-ийн МХУЗ-ын 3-р курсын оюутан Б.Цагаанзаяа, Цаст-Алтай цогцолбор сургуулийн 11а ангийн сурагч Д.Лхагвасайхан нар тус тус шалгарлаа.

“Дараагийн хуудас ТВ” нэвтрүүлэг нь 8 дахь жилдээ уламжлал болгон зохион явууллаа. Уг арга хэмжээнд Жаргалант сумын ЕБ-ийн 7-н сургуулиас зохиолч хүүхдүүд оролцлоо. Энэ ажлын гол зорилго нь хүн төрөлхтний оюуны сор болсон дэлхийн сонгодог зохиолыг бичих Монгол Нобелийн шагналтныг төрүүлэх, уншигчдын сэтгэн бодох чадвар, эх хэлний найруулга, үгийн баяжилт, бие даан асуудлыг шийдэх чадваруудыг хөгжүүлэх болно.

2018 оноос аймгийн БСУГ-тай хамтран зохион байгуулан явуулж байгаа. Өнөөдрийн манай ажлын онцлох үйл явдлын нэг зочин оролцогчоор номын сангийн дэргэдэх “Номын цацраг” клубын болон ЕБС-ийн “Номын гэгээ”, “Оюуны хөлөг”, “Мэргэдийн орон” зэрэг номын клубын гишүүд урилгаар оролцлоо.

Энэ удаагийн зохиол нь Бразилын нэрт зохиолч Пауло Коэльогийн Алхимич хэмээх алдарт зохиолыг манай оролцогч зохиолч хүүхдүүд үргэлжлүүлэн дараагийн хуудас хэмээх зохиолыг бичиж оюун ухаанаа сорин уралдлаа. Уг зохиол нь 65 сая ширхэг борлогдсон дэлхийн дээд амжилт, Геннессийн аварга амжилтад бүртгэгдсэн зохиол болно.

Прогресс сургуулийн 11-б ангийн сурагч П.Сийлэгмаа, 1-р сургуулийн 11-а ангийн сурагч Б.Болорзаяа, 2-р сургуулийн 8-б ангийн сурагч Э.Барсболд нарын бичсэн зохиолууд оролцогчдын шүүлтээр Тэргүүн, дэд, гутгаар байрыг тус тус

эзэллээ.

1.2 УГИЙН БИЧГИЙН СУРГАЛТ

Ард иргэд болон төрийн албан хаагчдад “Угийн бичиг”-ийн сургалт мэдээлэл өгөх, болзолт уралдааныг сурталчлах, “Угийн бичиг” хөтлөх иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор, “Оюунтүлхүүр” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд “**Угийн бичиг**”-ийн сургалтыг зохион байгуулан ажиллаа.

1. Албан байгууллага, аж ахуй нэгж, хувь хүн, иргэддээ зориулсан Угийн бичгийн сургалт. 20 хүн.
2. Музейн албан хаагчдад "Угийн бичгийн сургалт 15 хүн
3. Ус цаг уур орчны шинжилгээний газрын албан хаагчдад "Угийн бичгийн сургалт 25 хүн
4. Цагаан уул сувлалийн амрагч нарт зориулсан "Угийн бичгийн сургалт 20 хүн

5. Жаргалант сумын 12 багийн 60 залуу ээжүүдийг "Угийн бичгийн сургалт 60 хүн
6. "Аз жаргалтай гэр бүл" уулзалт хэлэлцүүлэгт оролцсон нийт төрийн албан хаагчдад Нийтийн сангаас "Угийн бичиг"-ийн сургалт 50 хүн
7. "Аавын сургааль алт" "Угийн бичиг"-ийн 30 хүн
8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба 50 хүн
9. Ховд Аймгийн Цагдаагийн газар 60 хүн
10. Зэвсэгт хүчний 123 ангийн хугацаат цэрэг хамрагдаж сургалтанд Нийт 700 гаруй хүн хамрагдлаа.

Угийн бичиг "УЛСЫН ҮНДЭС үндэсний зөвөлгөөн Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж номын санч Д.Нямгэрэлхамрагдлаа.

Ховд Аймгийн Цагдаагийн газрын нийт албан хаагчидад сургалт мэдээлэл өгөв.

"Аавын сургааль алт" "Угийн бичиг"-ийн сургалт.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба "Угийн бичиг"-ийн сургалт.

"Аз жаргалтай гэр бүл" уулзалт хэлэлцүүлэгт оролцсон нийт төрийн албан хаагчдад Нийтийн сангаас "Угийн бичиг"-ийн сургалт.

Жаргалант сумын 12 багийн 60 залуу ээжүүдийг "Угийн бичгийн сургалт.

Ус цаг уур орчны шинжилгээний газрын албан хаагчдад "Угийн бичгийн сургалт.

Музейн албан хаагчдад "Угийн бичиг”-ийн сургалт.

Зэвсэгт хүчний 123 ангийн хугацаат цэрэг “Угийн бичиг”-ийн сургалт.

НИЙТИЙН НОМЫН САНГААС ЯВУУЛСАН “УГИЙН БИЧИГ”-ИЙН СУРГАЛТЫН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Д/Д	Байгууллага, аж ахуйн нэгж ,хувь хүн	Хамрагдсан хүмүүсийн тоо	Бусад
1	Албан байгууллага, аж ахуй нэгж, хувь хүн, иргэдэд	30	
2	Музейн албан хаагчдад	15	
3	Ус цаг уур орчны шинжилгээний газрын албан хаагчдад	25	

4	Цагаан уул сувлалийн амрагч нарт зориулсан	25	
5	Жаргалант сумын 12 багийн 60 залуу ээжүүд	60	
6	Аз жаргалтай гэр бүл" уулзалт хэлэлцүүлэгт оролцсон нийт төрийн албан хаагчдад	30	
7	Аавын сургааль алт хэлэлцүүлэгт оролцочид	18	
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	50	
9	Зэвсэгт хүчний 123 ангийн хугацаат цэрэгүүдэд	100	
10	Ховд Аймгийн Цагдаагийн газар	60	
11	Улаанбаатар хотноо зохион байгуулсан угийн бичигийн 2-р дугаар зөвөлгөөн, үзэсгэлэнд аймаг төлөөлөн оролцож ард иргэдэд угийн бичигийн үндсэн ойлголт талаар мэдээлэл хийж ажиллаа.	300	

1.3 АЙМГИЙН НОМЫН САНГУУДААР ТУРШЛАГА СУДЛАВ

Нийтийн номын сангийн нийт ажилтнууд 2019 оны 04 дүгээр сарын 22-29-ны өдрүүдэд Дархан, Булган, Орхон аймгийн номын сангуудын үйл ажиллагаа, , тасаг танхимуудтай танилцаж туршлага судлан ажиллаа. Нийт 16 хүний бүрэлдхүүнтэй оролцлоо.

Мөн 2019 оны 9-р сард Увс аймгийн номын сангаар зочилж үйл ажиллагаатай танилцан туршлага судалсан.

1.4 ГАН ҮЗЭГ-2019 ЯРУУ НАЙРГИЙН НААДАМ

МУСГЗ Магсарын Баянзулын нэрэмжит Ховд аймгийн Нийтийн номын сангаас уламжлал болгон зохион явуулдаг Ган үзэг-2019 яруу найргийн наадмыг 13 дах жилдээ 2019 оны 10 сарын 31-нд Нийтийн номын сан дээр зохион байгууллаа.

Үүнд: Хөдөө сумдын болон аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, оюутан залуус нийт 94 оролцогчид оролцож үүнээс 4 ангилал тус бүрээс эхний 5 байр шалгаруулахад нийт 12 сурагч “Ган үзэгтэн” тэмдэгтэн боллоо. Шилдэгийн шилдгийг эхний 3 байранд шалгарсан оролцогчдийн бүтээлийг Нийтийн номын сангийн Фэйсбүүк хуудсанд байршуулан санал авч шалгаруулсан.

4-6-р ангийн насны ангилалд

Тэргүүн байранд Цаст-Алтай цогцолбор

сургуулийн 6г ангийн сурагч П.Анужин “Халзан бүргэдэй” шүлгээр,

Дэд байранд Цэцэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 6б ангийн сурагч Б.Азжаргал “Би жүжигчин болно” шүлгээр,

Гутгаар байранд Ерөнхий боловсролын 3-р сургуулийн 6б ангийн сургач И.Болдсайхан “Би аавынхаа” шүлгээр,

Тусгай байранд Үенч сумын Ерөнхий боловсролын сургуулийн 6в ангийн сурагч Г.Эрдэнэхонгор болон Дуут сумын 6а ангийн сурагч М.Буянжаргал “Миний нутаг ийм сайхан” шүлгээр тус тус шалгарлаа.

7-9 ангийн насны ангилалд

Тэргүүн байранд Ерөнхий боловсролын 3-р сургуулийн 8а ангийн сурагч Б.Мөнхгэрэл “Морьтой монгол” шүлгээр,
Дэд байранд Ерөнхий боловсролын 6-р сургуулийн 7в ангийн сурагч Э.Бүтэнзаяа “Миний чулуу” шүлгээр,
Гутгаар байранд Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 8б ангийн сургач Б.Хонголзул “Байгаль эхийн уйлах дуу” шүлгээр,
Тусгай байранд Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 8б ангийн сурагч Б.Тунгалаг “Би төрсөн” шүлгээр, Цэцэг сумын 7б ангийн сурагч Д.Лхагвасүрэн “Миний эмээ” шүлгээр тус тус шалгарлаа.

10-12-р ангийн насны ангилалд
Тэргүүн байранд Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12а ангийн сурагч Б.Отгонзаяа “Өнөөгийн төрх” шүлгээр
Дэд байранд Дуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 11а ангийн сурагч Х.Гантуул “Хүлээхүй” шүлгээр
Гутгаар байранд Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12а ангийн сургач

Г.Дэлгэрцэцэг “Цэцэг нутаг” шүлгээр
Тусгай байранд Ерөнхий боловсролын 7-р сургуулийн 12а ангийн сурагч Б.Маралмаа “Бодролд” шүлгээр, Ховд их сургуулийн ахлах Лицей сургуулийн 11а ангийн сурагч Б.Сайханжаргал “Сэвтээж үл болно” шүлгээр тус тус шалгарлаа.

Болор цомын эзэн яруу найрагч агсан Х.Эрдэнэбаатарын нэрэмжит шагналаар ангилал тус бүрээс нэг оролцогчийг шалгаруулж урамшууллаа.

Насанд хүрэгчдийн ангилалд
Тэргүүн байранд Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш Г.Сарнай "Өнөөгийн нийгэм" шүлгээр
Дэд байранд Мөст сумын сургуулийн багш Н.Баярсүрэн "Бодрол" шүлгээр,
Гутгаар байранд Ховд их сургуулийн МХУЗ-ын ангийн оюутан Б.Хүлэгбоорчи "Нууц" шүлгээр,
Тусгай байранд Ховд их сургуулийн МХУЗ-ын ангийн оюутан Н.Буянбат "Нэргүй" шүлгээр тус тус шалгарлаа.

1.5 ШУВУУН СААРАЛ БОГИНО ӨГҮҮЛЛЭГИЙН УРАН УНШЛАГЫН НААДАМ

Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч Д.Нацагдоржийн мэндэлсэний 113 насны ойг тохиолдуулан 23 дах удаагаа амжилтай зохион байгууллаа.

Тус наадамд хөдөө сумдын болон аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, оюутан залуус нийт 102 оролцогчид оролцож үүнээс 4 ангилал тус бүрээс эхний 5 байр шалгаруулж шагнаж урамшууллаа. Шилдэгийн шилдгийг эхний 3 байранд шалгарсан оролцогчдийн бүтээлийг Нийтийн номын сангийн

Фэйсбүүк хуудсанд байршуулан санал авч шалгаруулна.

Наадмын 4-6-р ангийн насны ангилалд

Тэргүүн байранд Буянт сумын ерөнхий боловсролын сургуулийн 6а ангийн сурагч А.Мөнхцэцэг

Дэд байранд Прогресс сургуулийн 4б ангийн сурагч М.Номиндарь

Гутгаар байранд Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 6а ангийн сурагч М.Цэлмүүн нар тус тус шагналт байранд шалгарлаа.

Наадмын 7-9-р ангийн насны ангилалд

Тэргүүн байранд Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 9а ангийн сурагч Д.Ундрал

Дэд байранд Дөргөн сумын ерөнхий боловсролын сургуулийн 7а ангийн сурагч Э.Буянтогтох

Гутгаар байранд Буянт сумын ерөнхий боловсролын сургуулийн 9а ангийн сурагч Ш.Амаржаргал

Тусгай байранд Цэцэг сумын 7а ангийн сурагч М.Отгонхишиг болон Буянт сумын 8а ангийн сурагч Ц.Номин-Эрдэнэ нар тус тус шалгарлаа.

Наадмын 10-12-р ангийн ангилалд

Тэргүүн байранд Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 12а ангийн сурагч Г.Баярмаа

Дэд байранд Үенч сумын ерөнхий боловсролын сургуулийн 10б ангийн сурагч Д.Намуунаа

Гутгаар байранд Ерөнхий боловсролын 6-р сургуулийн 12в Г.Халиунаа

Тусгай байранд Ерөнхий боловсролын 6-р сургуулийн 11б ангийн сурагч Х.Айдос болон Дөргөн сумын ерөнхий боловсролын сургуулийн 12а ангийн сурагч Т.Насантогтох нар тус тус шагнагдлаа.

"ШУВУУН СААРАЛ-2019" богино өгүүллэгийн уран уншлагын наадмын Шилдэг оролцогчоор 4-6-р ангийн насны ангилалын Тэргүүн байрын шагналт Буянт сумын ерөнхий боловсролын сургуулийн 6а ангийн сурагч А.Мөнхцэцэг 1040 санал авч шалгарлаа.

"ГАН ҮЗЭГ-2019" яруу найргийн наадмын Шилдэг оролцогчоор 7-9-р ангийн насны ангилалын Тэргүүн байрын шагналт Ерөнхий боловсролын 3-р сургуулийн 8а ангийн сурагч Б.Мөнхгэрэл “Би ээжийнхээ төгсөшгүй үргэлжлэл” шүлгээрээ 1060 санал авч тус тус шалгарлаа.



2. **ЦАХИМ НОМЫН САН ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:**

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Цахим номын сан” дэд хөтөлбөрийг ЗДТГ-ын Худалдан авах ажиллагааны газраас тентер зарлаж Мөнх баян-Эрдэнэ ХХК техник тоног төхөөрөмж нийлүүлэн хэрэгжүүлсэн.

Цахим сан хөтөлбөр нь номын сангийн үйлчилгээг цахимжуулах, орчин үеийн технологийг нэвтрүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой хэрэгжүүлсэн хөтөлбөр юм.

Хөтөлбөрийн хүрээнд номын сангийн Lib4u програмыг шинэчилж интернэттэй газраас номын санч нар програмруу хандах боломжтой болсон. Хүүхдийн номын өргөөний номын санч нар програм ашиглаж үйл ажиллагаагаа явуулж байна. www.library.kho.gov.mn Номын сангийн вэб сайттай болсон.



Мөн өндөр хүчин чадал бүхий сервер, өндөр хурдны сканнер, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан дайзи цахим ном уншигч, зөөврийн жижиг спикер/3 ширхэг/-тэй болсноор хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх, эх материалыг гэмтээхгүйгээр олон уншигчдад зэрэг үйлчлэх боломж бүрдсэн.

БСШУСЯ-аас соронзон хаалга нийлүүлэгдэж тус хөтөлбөрийн хүрээнд 80000 ялтас нэмж авсан.

Цахим танхимд стандартад нийцсэн зориулалтын компьютерийн ширээ15 ширхэг, сандал15 ширхэг, танхимын үйлчилгээний компьютер8 ширхэг, зөөврийн компьютер 1 ширхэг, тог баригч 5 ширхэг, проектор1 ширхэг, Tablet -8 ширхэг, Kindle-8 ширхэг, принтер 4 ширхэг, LCD дэлгэц /1ш 48 инч/, Лед дэлгэц /touch/-3 ширхэг, зургийн аппарат 1 ширхэг, цаг бүртгэлийн төхөөрөмж 1 ширхэг, вирусны програм 5 ширхэг, Бага оврийн узель апратур-1 ширхэг нийлүүлэгдсэн. Мөн Хүүхдийн номын өргөөг шилэн кабелтай холбосон.

Сумдын номын сангууд номын мэдээллээ бүрэн каталогжуулж дууссан ба уншигчдад үйлчлэх, номын тооллого, элетрон каталогыг цахимаар хүргэх боломжтой болсон.

Сумдын номын сангуудад тус бүр 1 ширхэг иж бүрэн компьютерыг сум хөгжүүлэх сангаас санхүүжихээр тусгасан.

Номын сангийн 5 тасаг танхимыг чөлөөт уншлагын танхим болгож Digital Pad Deactivator номын ялтас идэвхжүүлэх, идэхгүй болгох төхөөрөмж суурилуулсан. АНУ-ын ЭСЯ-ны санхүүжилтээр интернэтийн үйл ажиллагаа хэвийн ажиллаж байна.

3. НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР, ИРГЭДИЙН ӨДӨР

3.1 Ерөнхий боловсролын 6-р сургууль дээр зохион байгуулав.

Аймгийн Нийтийн номын сангаас зохион явуулж буй "Монгол ардын уламжлалт ёс заншлаас суралцья сэдэвт номын аяны хүрээнд Нээлттэй хаалганы өдрийг ЕБ-ийн 6-р сургууль дээр зохион байгууллаа.

Тус арга хэмжээний хүрээнд тасаг танхимууд номын үзэсгэлэн гаргаж үйл ажиллагаагаа сурталчиллаа.

Мөн аяны хүрээнд ахлах ангийн сурагчдын дунд Монголын түүх, соёл, ёс заншил сэдэвт АХА тэмцээн зохион байгуулж эхний 3 байранд орсон сурагчдыг өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулав.

3.2 Зэвсэгт хүчний 123-р ангитай хамтран зохион байгуулав.

"Эх орончдын өдөр"-ийг тохиолдуулан Зэвсэгт хүчний 123-р ангитай хамтран "Нээлттэй хаалга"-ны өдөр зохион байгуулж нийт албан хаагчдын дунд "АХА" тэмцээн явуулж, сэдэвчилсэн номын үзэсгэлэн гарган ажиллаа.

3.3 Цагдаагийн газартай хамтран зохион байгуулав.

"Эх орончдын өдөр"-ийг тохиолдуулан Ховд Аймгийн Цагдаагийн газартай хамтран "Нээлттэй хаалга"-ны өдөр зохион байгуулж нийт албан хаагчдын дунд "Угийн бичиг"-ийн сургалт, мэдээлэл , "АХА" тэмцээн явуулж, сэдэвчилсэн номын үзэсгэлэн гарган ажиллаа.

3.4 Нийтийн номын сангийн Эрдэм шинжилгээ- Чөлөөт уншлагын танхимаас ХБЭХ-той хамтран хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд урилгын уншлага хийлээ. Үйл ажиллагааны үеэр номын үзэсгэлэн гаргаж, үнэгүй карт нээж үйлчилэхээс гадна Ном зүйн тасгаас шинэ номын мэдээлэл хийж, Интернэт, цахим танхим, Америкийн мэдээллийн төвийн үйл ажиллагаатай танилцууллаа. Цахим номын санд шинээр ирсэн Таблет, киндл, Дайзи ном уншигчийг танилцуулж тэдэнд сонсдог номоор үйлчиллээ.30

3.5 Нийтийн номын сангаас Иргэдийн өдрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран зохион байгууллаа.

Тус арга хэмжээний хүрээнд ШШГА-ны нийт албан хаагчдад Угийн бичгийн сургалт явуулж, шинэ номын үзэсгэлэн гаргаж номын сангийн үйл ажиллагааг сурталчилж уншлага үйлчилгээ үзүүллээ.60

3.6 "Ухаан далай номоос эхтэй" номын аяны хүрээнд зохион байгуулан явагдсан ажлуудыг дүгнэн тайлагнах, уралдаан тэмцээнд амжилттай оролцсон уншигчдыг шагнах болон тасаг танхимуудын үйл ажиллагаа, танилцуулга, ховор номын, шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж олон нийтэд сурталчилах, уншигчдыг номтой нөхөрлүүлэх тэдний чөлөөт цагийг үр дүнтэй зөв боловсон өнгөрүүлэх, оюун ухааныг хөгжүүлэх зорилготой "Нээлттэй хаалганы өдөр" өдөрлөгийг Жаргалант сумын 12 жилийн ахлах 3-р сургууль дээр зохион байгуулж явууллаа.

Өдөрлөгийг номын сангийн дэргэдэх "Номын мэлмий" клубын сурагчид мэндчилгээ дэвшүүлэн тус сургуулийн болон Нийтийн номын сангийн зохион байгуулах баг хамт олон нээж, үйл ажиллагаагаа явууллаа.

Мөн энэ үеэр Интернэт цахим танхимаас сурагчдын дунд танин мэдэхүйн хөгжөөнт асуулт хариултын тэмцээнийг зохион байгуулж явуулав.

Энэ өдөр тус сургуулийн багш сурагчид Нийтийн номын сангийн бүх тасаг танхимуудаас гаргасан номын үзэсгэлэнтэй танилцаж, сурагчид амралтын хугацаанд манай номын сангаар үйлчлүүлэх ном унших өндөр сэтгэгдэлтэй байсан бөгөөд удирдлагууд нь үр дүнтэй үйл ажиллагаа явуулсан манай хамт олонд талархал илэрхийллээ.

3.7 Ховд аймгийн Нийтийн номын сангийн Цахим танхим, ЭШЧУТ хамтран Хөгжил политехник коллежийн 2-р байранд Бичиг үсгийн баярыг угтаж Бичиг үсэг-Цахим ертөнтөд сэдэвт өдөрлөг зохион байгууллаа. Тус арга хэмжээний үеэр Kindle, Tablet хэрхэн ашиглах талаар танилцуулж, ач холбогдлыг таниулан, DVD,CD цахим номуудаар оюутнуудад үйлчилж, Kahoot програм ашиглан хөгжөөнт

тэмцээн зохион байгууллаа. 50

3.8 Цахим танхим, ЭШЧУТ, Лавлагаа ном зүйн тасгаас ХИС-ийн Номын сантай хамтран Бичиг үсгийн баярыг тохиолдуулан Бичиг үсэг-Цахим ертөнтөд сэдэвт өдөрлөг зохион байгууллаа.

Тус арга хэмжээний үеэр номын үзэсгэлэн гарган Kindle, Tablet хэрхэн ашиглах талаар танилцуулж, цахим номуудаар оюутнуудад үйлчилж, Kahoot програм ашиглан хөгжөөнт тэмцээн зохион байгууллаа.

3.9 "Ахмадуудтайгаа уншъя" нээлттэй хаалганы өдөр

"Ахмадуудтайгаа уншъя" өдөрлөгийг цагаан уул сувлалийн амрагч нарт зориулан зохион байгууллаа. Тус өдөрлөгийн үеэр Эрдэм шинжилгээний танхим, Цахим танхим, Гэрээр ном олгох тасаг, Лавлагаа ном зүйн тасгаас номын үзэсгэлэн гаргаж угийн бичгийн сургалт явуулан номын сангийн үйл ажиллагааг сурталчилж, ном зохиолоор үйлчиллээ. нийт 16 ахмадууд оролцов.

3.10 Нийтийн номын сангаас зусланд гарсан айлуудад Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулан Зөөврийн номын сангийн үйлчилгээг 2019 оны 7 сарын 01-нээс 03-ны өдрүүдэд хүргэж ажиллаа.

Тус арга хэмжээний хүрээнд хүүхдүүдийн дунд АХА тэмцээн зохион байгуулав. Нийт үйлчлүүлсэн ард иргэд хүүхдүүд идэвхтэй ирж ном уншиж байлаа. Нийт давхардсан тоогоор 80 гаруй иргэд хүүхэд байгачууд үйлчлүүлсэн.

4. "БИ НОМЫН НАЙЗ" ӨДӨРЛӨГ

Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран "Би номын найз" өдөрлөг зохион байгууллаа. Тус өдөрлөгөөр ЕБС-ийн Цаст-Алтай цогцолбор, 2-р 12 жилийн нийт 100 сурагч хамрагдлаа. Оролцогч хүүхдүүд Номын эмч арга хэмжээнд идэвхтэй оролцож байлаа.

5. “МОНГОЛ АРДЫН ЁС, ЗАН ЗАНШЛААС СУРАЛЦЪЯ” СЭДЭВТ АЯН

4.1 Монголын уламжлалт өв соёлыг ирээдүй хойч үедээ түгээн дэлгэрүүлж, уламжлан өвлүүлэх улмаар сурталчлан таниулах зорилготойгоор “Монгол ардын ёс, зан заншлаас суралцъя” сэдэвт аяны хүрээнд зохион явуулсан “Монгол ардын тоглоом наадам ном хэвлэлийн хуудаснаа” өглөөлгийг 7-р ангийн сурагчдын дунд амжилттай зохион байгуулж явууллаа. Өглөөлөгт “Дөрвөн бэрх”, “Монгол соёл”, “Монгол наадгай”, “Алаг мэлхий” багууд ардын уламжлалт үгэн тоглоом, хөдөлгөөнт хөгжөөнт тоглоом, хөлөгт тоглоомуудаар тоглож, уг үйл ажиллагааг тэмцээн хэлбэрээр 4 үе шаттай явууллаа. Тэмцээнд “Дөрвөн бэрх” баг бусдыгаа хошуучлан түрүүллээ.

4.3 Тус аяны хүрээнд Ерөнхий боловсролын 6-р сургуулийн 3-4-р ангиудын дунд зохион явуулсан “Аман зохиолыг хэн сайн мэдэх вэ?” тэмцээнд авъяас чадвар, ур ухаанаа

дайчлан амжилттай оролцож Б.Бямбахүү багштай 4а ангийн “Мөрөөдөл” баг Тэргүүн байр,Ч.Түнжин багштай 3г ангийн “Дайралцаа” баг, Дэд байр, К.Мерзедхан багштай 4б ангийн “ Шонхрууд” баг Гутгаар байр эзэллээ.

4.4 Цаст-Алтай цогцолбор сургууль, 3-р сургуулийн 5-р ангийн хүүхдүүдийн дунд "Алтан хонх" танин мэдэхүйн тэмцээнийг зохион явууллаа.

6. “УХААН ДАЛАЙ НОМООС ЭХТЭЙ” АЯН

5.1 Тус аяны хүрээнд зохион явуулсан “Ээждээ хэлэх миний үг” захидлын уралдаанд шалгарсан бүтээлийг олон нийтэд хүргэх, “Номын ач тус, нийгэмд гүйцэтгэх үүрэг” сэдэвт номын цэнгүүнийг амжилттай зохион байгуулж явууллаа.

Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах 108 дахь өдрийг тохиолдуулан явуулсан энэхүү арга хэмжээнд хүүхдүүд энэ дэлхийн нар болсон ачит ээж нартаа чин

сэтгэлийнхээ үгийг хэлж, мэндчилгээ дэвшүүлж, инээд хөөр, баярын нулимс дуслуулан сэтгэлийг баясгасан нэгэн мөчийг хамтдаа маш сайхан өнгөрүүллээ. Энэ үеэр ЦАЦ сургуулийн Цэцэгмаа багштай 10-а ангийг төлөөлөн ээж Оюунчимэг нь бидэнд олон нийтийг хамруулсан маш сайхан ажил зохион явуулсанд талархаж чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлэн “Дэлхийн түүхийг бүтээсэн 100 хүн” гэсэн гоё номыг бүх хүмүүст уншуулж, хамгийн олон уншигдсан шилдэг ном болгохын ерөөлийн хамт дурсгалаа.

Захидлын уралдаанд амжилттай оролцож Тэргүүн байр ЦАЦ сургуулийн 11-б ангийн сурагч Г.Энхцэцэг, дэд байрыг Прогресс сургуулийн 12-б ангийн сурагч Г.Сайханжаргал, гутгаар байрыг 3-р сургуулийн 10-б ангийн сурагч Э.Дэлгэрцэцэг, тусгай байрыг 3-р сургуулийн 10-а ангийн сурагч Б.Булганбуян нар эзэллээ.

7. ШИНЭ НОМЫН НЭЭЛТ БОЛОВ.

7.1 Зохиолч Лацав Тангуд овогт Доржийн Ганболдын “БОШГОТ ХАНЫ АМАН ДОМГИЙН НУГАЛБАР ОРШИВОЙ ”шинэ номын нээлт МУСГЗ М.Баянзулын нэрэмжит Нийтийн номын санд 2019 оны 03 сарын 14-ны өдөр зохион байгуулагдав.

Нээлтэнд ИТХ-ын дарга Г.Пүрэвганди, Ховд их сургуулийн эрдэмтэн багш судлаачид, зохиогчийн журмын нөхөд болон уншигчид оролцсон сайхан арга хэмжээ

болж өнгөрлөө.

7.2 БТА, ахмад багш Н.Гэрэлхүүгийн "ЗҮРХЭНД БАДАМЛАСАН ДӨЛ" дурсамж номын нээлт Ховд аймгийн Нийтийн номын санд зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд ахмад, дунд, залуу үеийн багш нарын төлөөлөл, Н.Гэрэлхүү багшийн ах дүү, үр хүүхэд, шавь нар нь оролцлоо.

7.3 Надмидын Намсрайн "ӨӨЛДИЙН СОЁЛ, ТҮҮХИЙН БИЧИГ ОРШВОЙ" шинэ номын нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа.

Уг ном нь Өөлд судлалын бүтээл туурвилын 2 дах хэвлэл бөгөөд Н.Намсрайн хүү Н.Сэрээнэндорж эрхлэн хэвлүүлсэн байна.

Тус номын нээлтэнд Нийтийн номын сангийн захирал Т.Эрдэнэтуяа, ИТХ-ын нарийн бичгийн дарга Сандагсүрэн, судлаач багш Пунцагдаш, Ховд их сургуулийн доктор профессор Ганболд нар оролцлоо.

8. ААВУУД УНШИЖ БАЙНА.

Монгол цэргийн зэвсэгт хүчний 98 дахь баярын энэ өдөр “Аавууд уншиж байна” номын цэнгүүнийг Жаргалант сумын Цаст Алтай Цогцолбор сургуулийн Жавзандулам багштай 7-б анги, Жаргалант сумын ахлах 3-р сургуулийн Батцэцэг багштай 6-а, Цагаанмандал багштай 6-в ангийн сурагчид аавуудтайгаа ирж, хамтдаа ном уншиж, уншсан номынхоо тухай болон чин сэтгэлийнхээ үгийг ярилцсан, халуун яриа өрнөсөн сайхан арга хэмжээ боллоо. Энэ өдрийн онцлогоос аавууд хүүхдүүддээ сургамж зөвлөгөө өгч, хүүхдүүд аавдаа баярын мэндчилгээ болон өөрийн зохиосон шүлгээ уншиж сонирхууллаа.

Нэгэн аав өөрийн амьдралын туршлагаасаа жишээ авч хүүхдүүд аав ээжийн сонирхлоор биш өөрийнхөө зорилгын төлөө явахыг зөвлөж байлаа. Мөн манай орон нутгийн зохиолч Ч.Баатар өөрийн бичсэн “Нууцаас нууц, далдаас далдыг ил болгох нь” номынхоо тухай ярьж өгөв.

Аавууд манай үйл ажиллагааг маш их дэмжиж, үүнийг цаашид үргэлжлүүлэн маш олон аавыг хамруулж оролцуулах санал тавьж, сэтгэл өндөр байгаагаа илэрхийллээ. Зээгийнхээ урилгаар ирсэн аав өөрийнх нь 3 хүүхэд энэ номын сангаас амьдралынхаа гараа эхэлж, сайхан амьдарч байгаа тухай ярив.

9. "ААВЫН СУРГААЛЬ АЛТ" НОМЫН ӨДӨРЛӨГ

9.1 Нийтийн номын сангаас Алагтолгой багийн засаг дарга Б.Нямсүрэнтэй хамтран Монгол Цэргийн баярын өдрийг тохиолдуулан Жаргалант сумын Алагтолгой багийн аавуудад "Аавын сургааль алт" номын өдөрлөг зохион байгууллаа. Өдөрлөгөөр Угийн бичигийн сургалт явуулах, Номын сангийн тасаг танхимуудын үйл

ажиллагаатай танилцуулах, карт нээж ном, сонин сэтгүүлээр үйлчилэх зэрэг ажлууд зохион байгуулав.

10. “ЭЭЖҮҮД УНШИЖ БАЙНА” БҮТЭЭЛЧ НОМЫН ӨДӨРЛӨГ

Аймгийн Нийтийн номын сангаас Жаргалант сумын ЗДТГ-тай хамтран “Ээжүүд уншиж байна” бүтээлч номын өдөрлөгийг зохион байгуулав. Энэ үйл ажиллагаанд гэртээ үр хүүхдээ асран хүмүүжүүлдэг ээжүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие биенээ хүндэтгэх, өөрийгөө бусдад таниулах бусад ээжүүдээс суралцах, тэднийг ном уншлага үйлчилгээнд татан оролцуулах мөн номын сангийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор Жаргалант сумын 12 багийн 60 залуу ээжүүдийг хүүхдүүдийн хамт оролцууллаа.

Тус арга хэмжээний үеэр Интернэт цахим танхимаас асуулт хариултын тэмцээн, ЭШЧУТ-аас номын үзэсгэлэн гаргаж ээжүүдэд карт нээж уншлага үйлчилгээ, Америкийн төвөөс ээжүүдтэй хамтран бүтээлч ажил,/ хуучин хувцсаа сэлбэн засах/, Ном зүйн тасгаас шинэ номын мэдээлэл болон лавлагаа ном зүйн мэдээлэл, Гэрээр ном олгох тасгаас

“Угийн бичгийн сургалт”, Үл мэдэх танхимаас хүүхдүүдэд “Үлгэрийн цаг”, Уншлагын их танхимаас “Хүүхдүүдээ хэрхэн номонд дуртай болгох вэ?” хэлэлцүүллэг, Фондын тасгаас фондын номын хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээлэл зэрэг ажлуудыг зохион байгуулав.

11. ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НОМЫН ӨДӨР

1967 оноос эхлэн Хүүхдийн номын олон улсын зөвлөлийн шийдвэрээр аугаа их хүүхдийн зохиолч Ханс Кристиан Андерсений төрсөн өдрийг буюу дөрөвдүгээр сарын 2-ныг олон улсын хүүхдийн номын өдөр болгон дэлхий нийтээр тэмдэглэж ирсэн түүхтэй. Энэ жил Үлгэрийн их хаан Х.К.Андерсен 214 насны өдөр тохиож байгаа билээ. Хүүхдийг номтой нөхөрлүүлэх зорилготой энэ өдрийг дэлхий нийтээр 52 дахь удаагаа тэмдэглэж байна. Энэ өдрийг зарим улс оронд хүүхдийн номын үзэсгэлэн гаргаж, хүүхдүүдэд ном үнэгүй бэлэглэх зэргээр тэмдэглэн өнгөрүүлдэг байна. Олон улсын хүүхдийн номын өдрийн зорилго нь хүүхдэд бага наснаас нь номонд дуртай болгон хүмүүжүүлэх явдал юм.

Нийтийн номын сангаас Жаргалант сумын Сансар цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн суралцагчдын дунд номын өдөрлөг зохион байгуулж явууллаа. Тэдэнд дэлхийн үлгэрийн санд томоохон байр суурь эзэлдэг Х.К.Андерсений “Дусал ус”, “Нугасны муухай дэгдээхэй”, “Ямх охин” зэрэг үлгэрийг уншиж өгч, ойлгосон эсэхийг асууж, харилцан ярилцлаа.

Мөн энэ үеэр хүүхдүүд өөрийн мэддэг үлгэрээ ярьж, оньсого таалцаж, зүйр цэцэн үг хэлэлцэж, авьяасаа үзүүлж, өдрийг хөгжилтэй сайхан өнгөрүүллээ. Хүүхдүүд үлгэрийн номоор гаргасан үзэсгэлэн үзэж танилцлаа

12. "ХАМТДАА УНШЪЯ" ГЭР БҮЛИЙН УНШЛАГЫН ӨДӨРЛӨГ

Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан "Хамтдаа уншъя" гэр бүлийн уншлагын өдөрлөгийг Алтангадас одонт 1-р сургуулийн Уранбилэг багштай 7в, Сосорбарам багштай 7г ангийн сурагчид, эцэг эхчүүдийн дунд зохион байгуулж явууллаа. Гэр бүлийн сайн сайхан ирээдүй тухайн улс орны хувьд хамгийн чухал үнэт зүйл юм. Гэр бүлийн эерэг харилцаа хандлага, төлөвшил, үлгэр дууриаллыг өсвөр үе болон нийгэмд түгээн дэлгэрүүлэх, хүүхдээ зөв боловсон төлөвшүүлэхэд хүн бүрийн оролцоог дэмжих нь чухал бөгөөд эрүүл харилцаанаас гэр бүлийн аз жаргал эхэлдэг.

13. ҮЛГЭРИЙН ЦАГ АРГА ХЭМЖЭЭ

Жаргалант сумын хувийн хэвшлийн цэцэрлэгийн насны хүүхдүүдийг номтой нөхөрлүүлэх, үлгэр сонсох, үлгэрийн үйл явдлыг ойлгох, төсөөлөн бодох, сэтгэх чадварыг дээшлүүлэх, хэл ярианы зөв хэрэглээг хэвшүүлэх, хэл яриаг зүгшрүүлэх зорилгоор “Энхж-Од”, Гэрэлт-Оч”, Багачуудын ертөнц” гэсэн 3 цэцэрлэгүүдээр явж "Үлгэрийн цаг" арга хэмжээг нийт 100 гаруй хүүхдүүдэд зохион байгууллаа.

13.1 Гэрэлт-Оч цэцэрлэгийн дунд бүлгийн ангийханд үлшэрийн цаг арга хэмжээг зохион байгуулав.

13.2 Нийтийн номын сангаас Нэмэх цэнэг эмэгтэйчүүдийн клубын бяцхан хүүхдүүддээ "Үлгэрийн цаг" арга хэмжээг зохион байгууллаа.

13.3 Мөн тус арга хэмжээг Энхж-Од цэцэрлэгтэй хамтран зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр хүүхдүүдийн дунд АХА

тэмцээн зохион явуулж шагнаж урамшууллаа.

13.4 Ерөнхий боловсролын 2-р дунд сургуулийн 1-р ангийн бяцхан сурагчдад "Үлгэрийн цаг" арга хэмжээг зохион байгууллаа. Мөн нийт 50 гаруй бэлтгэл бүлгийн бяцхан дүү нартаа танхин мэдэхүйн холбогдолтой асуултуудаар “АХА” уралдаант тэмцээн явуулж, багш ажилчдад нь номын үзэгсэлэн гаргаж ажиллаа.

13.5 Зусланд гарсан айл өрхүүдэд Нээлтэй хаалганы өдөр зохион байгуулан зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэж ажиллаа. Тус арга хэмжээний хүрээнд Үлгэрийн цаг зохион байгуулав.

13.6 “Ээжүүд уншиж байна” бүтээлч номын өдөрлөгөөр Үл мэдэх танхимаас Үлгэрийн цаг арга хэмжээг явуулав.

Жаргалант сумын 11-р цэцэрэг, 14-р цэцэрлгийн ахлах бүлгийн сурагчдад номын сангаа танилцуулаж үлгэрийн ертөнцөөр

аялуулав.

14. “НОМЫН БАЯР”-ЫГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭВ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны “Номын баяр” тэмдэглэх тухай 158 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхэд багачууд , уншигчдыг номонд дурлуулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор "Номын баяр"-ыг тэмдэглэн өнгөрүүллээ.

Уг арга хэмжээг хөтөлбөрийн дагуу “Нээлттэй хаалга”-ны өдөр өдөрлөг зохион байгуулж явууллаа. Энэ өдөр Жаргалант сумын ЕБС-дын дунд “Би мэднэ-бид чадна”

хүүхдүүд уншсан зохиолоороо ном бүтээх бүтээлийн уралдаан, БСУГ-тай хамтарч “Дараагийн хуудас ТВ нэвтрүүлэг”, Их зохиолч “Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан сурагчдад шагнал гардуулах ёслол зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулж явууллаа. Нийт ЕБС-ийн 300 гаруй сурагчид, багш ажилчид, ард иргэд оролцлоо.

15. "ИХЭР ЗАЯА" ӨДӨРЛӨГ

Ихэр хүүхдүүд тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх,бие биетэйгээ танилцах, тэдний авьяасыг нээн хөгжүүлэх зорилготой "Ихэр заяа" өдөрлөг амжилттай зохион байгуулагдлаа.

Авьяаслаг ихрүүдийн “Үлгэрийн баатрууд”амилсан нь дүрийн тоглолт

Өдөрлөгт ЕБС-иудын ихэр сурагчид оролцож тэргүүн байранд Цаст-Алтай цогцолбор сургууль, Дэд байранд Прогресс сургууль, Гутгаар байранд 2-р сургууль, Тусгай байранд 3-р сургууль болон 7-р сургуулийн сурагчид тус тус байр эзэллээ.

16. Ш.СҮРЭНЖАВЫН УРАН БҮТЭЭЛИЙГ СУРТАЛЧЛАХ 10 ХОНОГИЙН АЯН

Нийтийн номын сангаас Зэвсэгт хүчний 123-р цэргийн ангийн ахлагч нарын дунд Ш.Сүрэнжавын уран бүтээлийг сурталчлах 10 хоногийн аянг зохион байгуулж 10 сарын 18-нд дүгнэлээ.

Ахлагч нарын дунд үгийн сүлжээ, таблет ашиглан танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулж, тасаг танхимууд номын үзэсгэлэн гаргаж ажиллаа.

17. УРИЛГЫН УНШЛАГА

17.1 Монголын орчин үеийн утга зохиолыг үндэслэгч их зохиолч Дашдоржийн Нацагдоржийн мэндэлсний 113 насны ойг тохиолдуулан ЕБ-н Алтангадас одонт 1 дүгээр сургуулийн Цэнд-Аюуш багштай 6-б ангийн сурагчид Их зохиолчийн эх зохиолоор тайлант уншлага хийлээ.

17.2 Жаргалант сумын ЕБС-ийн 6-р ангийн сурагчдыг номын сантай танилцуулж, ахлах насны ангиллын танхимаар үйлчлүүлэх мэдээлэл хийж мөн сургууль хоорондоо танилцах нийгмийн хүрээг нь өргөжүүлэх арга хэмжээ авч ажиллаа. Энэ ажлын хүрээнд ЕБ-ийн 6-р сургуулийн Баярмаа багштай 6-а анги, Баасанжав багштай 6-в ангиуд номын санд ирж уншлага хийлээ.

17.3 Урилгат уншлага өдөрлөгт 6-р сургуулийн Цэнд-Аюуш багштай 11-г ангийн хамт олон идэвхтэй оролцлоо.

17.4 Жаргалант сумын 11-р цэцэрлэгийн Уртнасан багштай ахлах бүлэг, Бадмаа багштай бэлтгэл бүлгийн бяцхан хүүхдүүд номын сантай танилцаж, номын тухай ярилцлаа.

17.5 Жаргалант сумын 11-р цэцэрэг, 14-р цэцэрлгийн ахлах бүлгийн сурагчдад номын сангаа танилцуулаж үлгэрийн ертөнцөөр аялуулав.

18. “ЭЕРЭГ БҮХНИЙГ ХАМТДАА ТҮГЭЭЕ” АЯН

Манай Нийтийн номын сан нь 2019 оны 11 сараас 2020 оны 04 сарыг дуустал Зэвсэгт хүчний 123-р ангитай хамтран **“Эерэг бүхнийг хамтдаа түгээе”** аяныг санаачлан зохион байгуулж байна. Тус аяны хүрээнд сар бүр 3 удаа Зэвсэгт хүчний 123-р ангийн байнгын бие бүрэлдэхүүн болон хугацаат цэргийн алба хаагчдад зориулан эерэг хандлага зөв дадлыг хэвшүүлэх, хамт олны үнэ цэнийг бэхжүүлэх, тэдний амжилт бүтээлийг сайшаах, бие биедээ хүндэтгэлтэй хандах, аливаа сөрөг хандлагыг өөрчилж эерэг бүхнийг түгээхээр номын сангаас соёл олон нийтийн ажлыг явуулж байна.

18.1 Цэргийн ангийн номын санд арга зүйн зөвлөгөө өгч зөвлөн туслах баг ажиллаж тус байгууллагын номын санчид нэгдсэн бүртгэл болон өдөр тутмын бүртгэл хөтлөх аргазүйн зөвлөгөө өгөв.

18.2 2019 он намар шинээр ирсэн цэргүүдэд эерэг хандлага зөв далыг хэвшүүлэх, хамт олны үнэ цэнийг бэхжүүлэх зорилгоор өдөрлөг зохион байгуулан багаар ажиллах уралдаан болон танин мэдэхүйн тэмцээн, угийн бичгийн сургалт хүргэлээ.



18.3 Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсаны 108 жилийн ойг угтаж, Хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч Дэндэвийн Пүрэвдоржийн “Тусгаар тогтнол” шүлгийн уран уншлагын тэмцээнийг Зэвсэгт хүчний 123- р ангийн байлдагчдын дунд зохион явууллаа.

Дэлхийн түүхийг мэдье гэвэл Монголын түүхийг мэд, Монголын түүхийг мэдье гэвэл Цэргийн түүхийг мэд гэдэг үнэхээр үе үеийн цэргийн баатарлаг замнал, монгол жанждын суу билэг, яруу алдар Монголын түүхийн амин ундарга, эх булаг нь болдог. Монгол Улсын түүхэнд 200 гаруй жил үргэлжилсэн манжийн ноёрхлыг эцэс болгож Монголчууд үндэсний тусгаар тогтнолоо зарлаж тусгаар тогтносон Богд хаант Монгол Улсыг байгуулсан. Монголчуудын сэргэн мандлын эхийг тавьсан 1911 оны Үндэсний эрх

чөлөөний хувьсгал нь төрт ёсны өнө эртний уламжлалтай Монголын ард түмний түүхийн онцгой хуудас, хойч үе нь бахархан дурсвал зохих түүхт үйл явдал мөн.

18.4 Цахим орчинд соёлтой хандах нь лекцийг байнгын бүрэлдэхүүн болох офицер ахлагч, энгийн ажилтнуудад хүргэлээ.

19. НОМ ХАНДИВЛАВ

19.1 Ховд их сургуулийн түүх, нийгмийн багш, зөвлөх профессор М.Ганболд, Ахмад багш Ж.Рагчаадорж нар Нийтийн номын санд ном хандивлалаа.

19.2 Ховд аймгийн Дэлхийн байгаль хамгаалах сангаас Нийтийн номын санд 6 төрлийн 76 ширхэг 449000 төгрөгний өртөг бүхий ном хандивлалаа.

19.3 Ховд, Увс, Баянөлгий, Баянхонгор, Завхан, Говь-Алтай аймгийн зохиолчид Нийтийн номын сангаар зочилон ирж үйл ажиллагаатай танилцаж ном хандивлав. Мөн ном сонирхогч тэргүүний сурагч болох Э.Оюумаа, Г.Оюунзаяа нарыг шагнаж урамшууллаа.

19.4 АУ-ны доктор Д.Хишигтогтох Ховд аймгийн Нийтийн номын сангаар зочилон өөрийн номоо хандивлав.

19.5 Ховд аймгийн Чандмань сумын харьяат Наваан /Бошго/ овогт Б.Жамъянсүрэн гуай манай номын санд өөрийн бүтээсэн номоо хандивлалаа.

Уг номоо халхын голын дайнд оролцсон аавынхаа түүхийг мөнхлөж үлдээжээ.

Мөн угийн бичгийн талаар онолын мэдлэг олгох, өөрийн угийн бичгийн зураглалыг хийж өгсөн байна.

19.6 АТГ-ын албаны дарга, ахлах комиссар Т.Энхболд болон Хэвлэл олон нийттэй харилцах ажилтан, комиссар Т.Мөнхтунгалаг нар Ховд аймгийн Нийтийн номын сангаар зочилж, ном, гарын авлага хандивлалаа.

20. ТЭРГҮҮНИЙ УНШИГЧИЙН ШИНЭ ЖИЛ

МУСГЗ М.Баянзулын нэрэмжит Нийтийн номын сан 2019 оны Тэргүүний уншигчийн шинэ жилээ зохион байгууллаа.

Оюунтүлхүүр хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан уншлага үйлчилгээ, соёл олон нийтийн ажилд сургууль хамт олноо идэвхтэй зохион байгуулан оролцуулж, хүүхэд багачуудыг оюун ухаан танин мэдэхүйг хөгжүүлэх үйлсэд бусдыгаа хошуучлан хамтран ажилласан шилдэгүүдээ шалгаруууллаа.

2018 оны Хошой аварга "ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ СУРГУУЛЬ"-аар Ерөнхий боловсролын 6-р сургуулийн хамт олон шалгарлаа.

Шилдэг "НОМЫН САНЧ"-аар Ерөнхий боловсролын 6-р сургуулийн номын санч Н.Сувд , Хөгжил Политехник коллежийн номын санч Л.Мандахжаргал нар шалгарлаа.

"ШИЛДЭГ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭГЧ МЕНЕЖЕР"-ээр шалгаруулан Ерөнхий боловсролын 6-р сургуулийн менежер Ц.Онон

"ШИЛДЭГ БАГШ" –аар Ерөнхий боловсролын 6-р сургуулийн М.Сарантуяа,

Ш.Отгон нар шалгарлаа.

“ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ АНГИ ХАМТ ОЛОН”-оор Батгэрэл багштай 8-а ангийн хамт олон, Шийжав багштай 7-б анги, Дашдорж багштай 6-в анги, Урандолгор багштай 6-г анги, Б.Мөнхцэцэг багштай 3в ангийн хамт олон тус тус шалгарлаа.

“ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ СУРАГЧ”-аар 6-р сургуулийн 7а Г.Энх-Амгалан, 6-р сургуулийн 7б Г.Батзориг, 1-р сургууль 6а И.Ирмүүн, ЦАЦ сургууль 6г Д.Норовсүрэн, ХИС-ийн НББ 2р курсын оюутан Н.Эрдэнэшагай, ХИС-ийн НББ 2р курсын оюутан Б.Туулсайхан, Өндөр настан Д.Цэцэгмаа, Хөгжил Политехник коллежийн оюутан М.Энхсайхан, Прогресс сургуулийн 4б ангийн сурагч М.Булган, ЦАЦ сургуулийн 3в ангийн сурагч Б.Ганганцэцэг, ЦАЦ сургуулийн 5б ангийн сурагч Т.Мөнх-Ирээдүй, ЦАЦ сургуулийн 2г ангийн сурагч Б.Ариунсайхан, 6-р сургуулийн 4в ангийн сурагч Х.Батзаяа,2-р сургуулийн 6б ангийн сурагч Н.Отгонжаргал, 3-р сургуулийн 11в ангийн

сурагч М.Бумбаяр, Хөгжил Политехник коллежийн оюутан М.Мөнгөнтуул, Ховд их сургуулийн Эрхзүйн 3-р ангийн оюутан Я.Мөнхцэцэг, өндөр настан Г.Нямсүрэн, Б.Жавхлан, Анирлан нар шалгарлаа.

21. БАЙГУУЛЛАГЫН ШИЛДЭГ АЖИЛТНУУДАА ШАЛГАРУУЛАВ.

Нийтийн номын сан нь 2019 оны ажлаа дүгнэн ажлын үр дүн, ур чадвараараа бусдыгаа манлайлан хошуучилсан шилдэг ажилтнуудаа Захирлын дэргэдэх зөвлөлийн 2019 оны 12 сарын 22-ны өдрийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж шалгаруулллаа.

ШИЛДЭГ АЖИЛТАН-аар нарийн бичиг, нярав Б.Оюундэмбэрэл шалгарлаа

ШИЛДЭГ НОМЫН САНЧ-аар Америкийн төвийн номын санч Г.Баяраа шалгарлаа.

22. АМЕРИКИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Mongolian club:

Боловсрол соёлын газрын англи хэлний мэргэжилтэн Хазелтай Ахмад багш Цэрэнлхам нартай хамтран Энх-тайвны корпусын сайн дурын ажилчидад монгол хэлний хичээлийг Лхагва гаригийн 16-17 цагийн хооронд зохион байгуулж байна.

Тоглоомын хөтөлбөр:

Тоглоомын хөтөлбөр нь: Насанд хүрэгсэд болон, хүүхэд багачууд сурагчдын дунд зохион байгууллагдаж байна. Даваа гариг бүрийн 11цаг 14 цагуудаас зохион байгууллагдаж байна.

Кино үдэш хөтөлбөр:

Кино үдэш хөтөлбөрийг Баасан гаригийн 15 цагаас 18 цагийн хооронд зохион байгуулж байна. Энэ удаагийн кино үдэш хөтөлбөрөөр Америкийн шилдэг кино “Venom”-ыг Ховд их сургуулийн оюутнууд хамрагдлаа.

Англи хэлний сургалт:

Боловсрол соёлын газрын англи хэлний мэргэжилтэн Хазелтай хатран ажилтан албан хаагчдын дунд Лхагва гаригийн 18-19 цагийн хооронд байнга зохион байгууллагдаж байна.

Аксес сургалт:

Аксес сурагчдад англи хэлний вакум сургалтыг 5 хоногийн турш амжилттай зохион байгуулж эцэг эхчүүдэд сургалтынхаа дүнгийн хурал хийж танилцууллаа.

Аксес сурагчидтай хамтран **“Ном эмчлэх цаг ”** хөтөлбөр зохион байгууллаа. Америкийн төвийн урагдсан гэмтсэн номнуудыг эмчилж ажиллаа.

Англи хэлний олимпиад:

Америкийн соёлын өдрүүдийн хүрээнд Ховд их сургуулийн Мэргэжлийн бус оюутнуудын дунд Англи хэлний олимпиад зохион байгууллаа. /Нийт 63 оюутан хамрагдлаа/

Англи хэлний ярианы клуб:

Англи хэлний ярианы клуб Мягмар гаригийн 17 цагаас тогтмол явагдаж байна. Энх-тайвны корпусын сайн дурын ажилчидтай хамтран зохион байгуулж байна.

Khovd webinar group

Англи хэлний багш нарыг хэрхэн англи хэл дээр нь хөгжүүлэх хэрхэн ур чадварыг хөгжүүлэх талаар Ховд вебинар групп үзээд, сэдвийн талаар санал солилцлоо. Хамтран ажиллаж байна. Цуврал хичээл 5 дахь удаагаа орлоо.

Khovd MOOC Camp

“Khovd MOOC Camp” Зуны багш нарын онлайн сургалт хамтран зохион байгуулж явуулж байна.

Олон улсын эссэ бичлэгийн уралдаан:

Олон улсын эссэ бичлэгийн уралдаанд Их дээд сургуулийн болон Ерөнхий боловсролын 7 сургуулийн нийт 136 оюутан сурагчид хамрагдлаа. 6-12 анги оюутан, багш,насанд хүрэгсэд гэсэн 8 ангилалаар 23 хүн шагналаа гардан авлаа.

"Teachers supporting teachers"

“Багш багшаа дэмжье” цуврал семинараа амжилттай зохион байгуулж,

сертификатаа гардууллаа. Өнөөдрийн сэдэв маань АНУ-аас хэрэгжүүлдэг тэтгэлэгт болон солилцооны хөтөлбөрүүдийн танилцуулга байсан ба З.Буянхишиг багш өнгөрсөн жил АНУ-д TEA (ЕБС-ийн англи хэлний багш солилцооны) хөтөлбөрт хамрагдсан туршлагаа хуваалцан Д.Лхамзаяа багш TEA хөтөлбөрт өргөдөл хэрхэн бөглөх талаар зөвлөгөө өгч, ярилцлага хийж хамтран ажиллаа.

Бүтээлч орон зай хөтөлбөр:

Бүтээлч орон зай хөтөлбөрийг ахмад багш Наранцэцэгтэй хамтран хүүхдүүдийн чөлөөт цагийг үр бүтээлтэй, бүтээлчээр өнгөрүүлж, цаасан урлал болон сонингийн хаягдал цаасыг ашиглаж цэцэгийн сав, үзэгний хайрцаг хийж бүтээлчээр хамтран ажиллаа.

Ээждээ бичсэн захидал уралдаан: /англи хэл дээр/





Англи хэл дээр зохион байгуулж явуулсан захидлын уралдаанд ЕБС-ийн 7 сургуулийн сургууль дээрээ шалгаруулсан 34 захидлаас 1-р байрыг Прогресс сургуулийн 11а ангийн сурагч Н.Ариунэрдэнэ түрүүллээ.

Сайн аав гар зургийн уралдаан:

Сайн аав гар зургийн уралдаанд Прогресс, Цаст алтай сургууль, 3-р сургууль бүтээлээ цаг хугацаанд нь ирүүлж тэргүүн байрыг 3-р сургуулийн 8а ангийн сурагч Б.Далхжавын бүтээл шалгарлаа.

Англи хэлний сургалттай 14-р цэцэрлэгтэй хамтран ажиллаж сургалтын материал өгч хүүхдийн нас сэтгэхүйд таарсан сонин сэтгүүлийг танилцууллаа. Америкийн төвийн үйл ажиллагааг таницууллаа.

“American Card Game”

Америкийн хөзрийг хэрхэн тоглох талаар Илтгэгч ELF Scott Poteet олон нийтэд мэдээлэл хийж, илтгэл хэлэлцүүлэг хийлээ.

Дууны уралдаан:

Америкийг сурталчлах аяны хүрээнд Англи дууны уралдаанд нийтдээ 141 оролцогч орсоноос 1-р байрт Цаст –Алтай сургуулийн 10а ангийн сурагч Ё.Дөлгөөнгэрэл шалгарлаа.

Улаан өндөгний баяр:



Америкийн тэмдэглэлт баяр болох **“Улаан өндөгний баяр”-**ыг тэмдэглэн өнгөрүүллээ.

Бүтээлч орон зайн төвийн нээлт боллоо.

Уг нээлтэнд АНУ-ын Элчин сайдын яамны Олон нийттэй харилцах албаны дэд дарга Адам Хенингс оролцож аймгийн орлогч Ч.Уранчимэг , Боловсролын соёлын газрын мэргэжилтнүүд эзцэг эхийн төлөөлөл, Инеженерийн анхан шатны 3 сарын сургалтанд шалгарсан 11 хүүхдэд талархал дэвшүүлж нээлтийг амжилттай эхлүүллээ.

Энх тайвны корпусын бүс хариуцсан хөтөлбөрийн захирал Америкийн төвд зочиллоо.

АНУ-ын Денвер хотод амьдарч буй Монгол иргэд Ховд аймгийн Нийтийн номын сангийн Америкийн төвд хүүхдийн ном, лего тоглоомуудаар хандив өглөө.

Бяцхан хүүхдүүдэд зурдаг ном, англи дуу зааж сургалаа.

Америкийн тэтгэлэгт хөтөлбөр SUSI хөтөлбөрийн талаар Доктор В.Сайнбаяр мэдээлэл хийлээ.

I. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол улсын Үндэсний номын сангаас “Нийтийн ноымн сан арга зүйн төв болох нь ” сэдэвт мэргэжил аргазүйн сургалт Улаанбаатар хотноо 2019 оны 12 сарын 06-ны өдөр зохион байгуулагдлаа. Тус сургалтаар Монгол улсын 21 аймгийн Нийтийн номын сангуудаас Ховд аймгийн Нийтийн номын сан соёл олон нийтийн ажлаараа тэргүүлж туршлагаасаа хуваалцаж илтгэл тавьлаа.

АНУ-ын Элчин сайд номын сангаар зочиллоо.

АНУ-ын Элчин сайд Клечески Америкийн төвийн үйл ажиллагаатай танилцаж америкийн төвд “World book” номыг бэлэглэлээ.

Ховд дахь Америкийн соёл мэдээллийн төв Англи хэл, манлайлалын хөтөлбөрүүдээ амжилттай удирдан явуулж байна. Англи хэлний Аксесс хөтөлбөрийн

багш, сурагчдын авьяас, чадвараар бахархаж байлаа.

Төрийн департаментийн төгсөгчдийн хамт Ховд аймаг дахь ирээдүйн манлайлагчидтай уулзаж, өөрсдийн дадлага туршлага болон АНУ-д боловсрол эзэмших боломжуудын талаар ярилцах сайхан байлаа.

Ховд аймгийн Нийтийн номын сангийн хамт олон ахмад ажилтнууддаа хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардууллаа.

Нийтийн номын сангийн эрхэмсэг сайхан бүсгүйчүүддээ Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн баярын мэнд хүргэж сарнай цэцэг бэлгэллээ.

Манай Нийтийн номын санд Lead Mongolia Сургалт, солилцооны хөтөлбөрийн танилцуулга, уулзалт зохион байгуулагдлаа.

Манай Нийтийн номын санд Говь-Алтай аймгийн номын сангийн хамт зочилж туршлага судаллаа.

Хүүхдийн төв номын сан, Орхон аймгийн Номын төвийн хамт олон манай номын сангаар зочилж үйл ажиллагаатай танилцан туршлага судаллаа.

Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх” Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг,Төрөөс бодлого,аймаг сумын Засаг даргын 2016-2020 оны төр” хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчдыг идэвхижүүлэх зорилгоор 7-н хоног бүрийн Бямба гарагийн өглөөний 9цагийг “Эрүүл мэнд –Идэвхитэй хөдөлгөөн”дасгалын цаг болгосон учир Ард Аюушийн талбайд хамт олноороо бүрэн хамрагдлаа.

Байгууллагын гадна орчны цэвэрлэгээнд хамт олноороо идэвхитэй хамрагдлаа.

Даваа гараг бүрийн 09 цагаас батлагдсан хуваарийн дагуу ажилтнууд Сонсгол мэдээллийг тогтмол хийж байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу 2019 оны 05 сарын 11-ны өдөр нийтээрээ мод тарилаа.

Номын санчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Шилжин явах цомын төлөөх Спортын тэмцээн-2019" Орхон аймагт зохион байгуулагдаж 16 аймаг, хотын 190 гаруй номын сангийн тамирчид оролцсноос Ховд аймгийн номын сангийн баг хамт олон Эрэгтэй, эмэгтэй теннис төрөлд Алтан медаль, Эмэгтэй волейбол төрөлд Алтан медаль тус тус хүртэж нийлбэр дүнгээр ДЭД байр эзэллээ. Тэмцээнд ХИС, Манхан, Мөст, Дуут сумын соёлын төвын номын

санчидтай хамтран Нийт 16 хүний бүрэлдхүүнтэй оролцлоо. УИХ-ын гишүүн, Улаанбаатар хот дахь Ховд аймгийн нутгийн зөвлөлийн дарга Сандагын Бямбацогт, УИХ-ын гишүүн Отгоогийн Батнасан, Орхон аймаг дахь Ховд аймгийн нутгийн зөвлөл биднийг дэмжин туслалцаа үзүүлсэн.

Нийтийн номын сангаас ажилтнуудынхаа бяцхан үрсдээ Эх үрсийн баярын мэнд хүргэж гарын бэлэг гардууллаа.

Ховд аймгийн ҮЭ-н хороон дарга Ариунжаргал “Ёс зүйн талаар” мэдээдэл хийлээ.

Мөн 5s буюу ажлын байрыг эмх цэгцтэй байлгаснаар ажлын бүтээмж дээшлэх талаар мэдээлэл хийлээ.

Ховд аймгийн Нийтийн номын сангийн хамт олон "Хайртай" аянд нэгдэж Хурд хамтлагыг уггах үйл ажиллагаанд оролцлоо.

Зүүн өмнөд Ази хариуцсан бүсийн менежер Рита “Америкийн номын сангуудын өнөөгийн чиг хандлага” сэдвээр аймгийн бүх номын санчдад мэдээлэл сургалт хийлээ. Нийтдээ 23 номын санч оролцлоо.

Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан зарлан мэдээллийн дохиогоор нийт ажилтнууд 5-р цэцэрлэгийн үүдэнд жагслаа.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

АГУУЛГА:

1. Тоон үзүүлэлт
2. Үндсэн үйл ажиллагаа
3. Сан хөмрөгийн баяжилт, хадгалалт хамгаалалт
4. Каталог зохион байгуулалт
5. Ном хэвлэлд хийх техник ажиллагаа, сэлбэн засалт
6. Лавлагаа номзүйн мэдээллийн ажил
7. Архив албан хэрэг хөтлөлт
8. Соёл танин мэдэхүйн ажил
   - Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигууд
   - Аймгийн засаг даргын үйл ажилгааны хөтөлбөрийн хэрэгжилт
9. Мэргэжил арга зүй
10. Байгуулага хамт олны ажил
11. 75 жилийн ойн хүрээнд хийгдсэн ажил

№	Гүйцэтгэлийн нэр төрөл	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт			
		2019 онд гүйцэтгэх	2019 онд гүйцэтгэсэн	**Чанар**	**Өртөг**
1	1	2	3	4	5
	Уншигч	6116	8043 (Зөөврийн НС 1556)	131%	83 хүн өдөр
2	Ирэгсэд	41460	55348 (Зөөврийн НС 8912)	133%	461 хүн өдөр
3	Ном олголт	61980	77296 (Зөврийн НС 10841)	123%	637,7 хүн өдөр

Хоёр. Фонд баяжилт, фондын ажил

№	Гүйцэтгэлийн нэр төрөл	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт			
		2019 онд гүйцэтгэх	2019 онд гүйцэтгэсэн	Чанар	Өртөг
	1	2	3	4	5
1	Татгалзлын дэвтэрт бүртгэгдсэн уншигчдын хэрэгцээний дагуу хэвлэлийн бүтээгдэхүүний захиалга хийх	600	681	100%	2,6 хүн өдөр
2	Ном хэвлэлийг дагалдах баримтын хамт хүлээн авах	600	681	100%	2 хүн өдөр
3	Сонин сэтгүүлийг хүлээн авах /Сонин сэтгүүлийг үсэг дараалаар болгох, сонин сэтгүүлийн карттай тулгах/	8	8 нэр (74 нэгж)	100%	0,07 хүн өдөр
4	Хандив тусламжаар фонд баяжилтийг бүрдүүлэх	150	148	99%	0,4 хүн өдөр
5	Номын сангийн фонд, уншлагын танхимуудад ном хуваарилах / танхимуудын дансанд бичих, нэг бүрчилсэн бүртгэлд тэмдэглэл хийх г.м./	600	681	100%	0,4 хүн өдөр
6	Ном хэвлэлийг фонд, уншлагын танхимуудад данс бүртгэлтэй тулгаж хүлээлгэн өгөх	600	681	100%	0,2 хүн өдөр
7	Фондын байрлалыг шалгах /ном хэвлэлийг тавиурт зөв байрласан эсэхийг шалгах	53977	27000	50%	53,3 хүн өдөр
8	Номын тавиурт ном хэвлэлийг төрөл ангийн байрлалтаар байрлуулах	3000	3685	123%	15,3 хүн өдөр

	➢ Шинэ ирсэн		192		
	➢ Үзэсгэлэнд гарсан		630		
	➢ Код засагдсан		500		
	➢ Тогтмол хэвлэл		9		
	➢ Захиалгаар гарсан		2110		
	➢ Сэлбэн засан (бусад)		253		
9	1	2	3	4	5
	Ангилал засагдсан номуудыг фондоос олох, бар кодыг наах	1000	951	95%	
10	Төрөл анги, үсэг дараалльн байрлалтанд зориулсан ялгагч хийх	500	534	100%	1,3 хүн өдөр
11	Татгалзалтай ажиллах	600	546	91%	3,4 хүн өдөр
12	Уншлагын танхимуудаас ном хэвлэлийн ашиглалтыг шалгаж ном буцаан авах /фондоос захиалгаар гарсан/	1000	1155	100%	3 хүн өдөр
13	Уншлагын танхимуудын захиалгаар ном хэвлэл фондоос гаргах (шилжүүлэх)	2000	2110	100%	

Гурав. Каталог зохион байгуулалтын ажил

№	Гүйцэтгэлийн нэр төрөл	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт			
		2019 онд гүйцэтгэх	2019 онд гүйцэтгэсэн	Чанар	Өртөг
1	1	2	3	4	5
	Каталогт карт байрлуулах / урьдчилан ялгасан картыг үсэг дараалал , төрөл анги , зүйлчилсэн каталогт байрлуулах /	3500	4617	131%	3,7 хүн өдөр

2	Үсэг дарааллын каталогт редакц хийх / номзүйн бичилт зөв эсэхийг шалгах, буруу байрлагдсан картыг авах, нэмэлт картуудыг тулгах /	2 удаа	2	100%	9 хүн өдөр
3	Орон нутгийн картын санд карт бичих	1000	1132	113%	16,7 хүн өдөр
4	Мэдээллийн электрон каталогийн санд хэвлэлийн бүтээгдэхүүн оруулах	1000	1126	112%	35 хүн өдөр
5	Мэдээллийн электрон каталогийн санд редактор хийх /ангилал, түлхүүр үг, гарчиг, товч агуулгад/ номыг нэг бүрчлэн тулгалт хийж алдааг засаж орхигдсон мэдээллүүдийг нэмж оруулах	3000	4515 ш ном редактор хийж засварлав.	143%	18,8 хүн өдөр

Дөрөв. Ном хэвлэлд хийх техник ажиллагаа

№	Гүйцэтгэлийн нэр төрөл	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт			
		2019 онд гүйцэтгэх	2019 онд гүйцэтгэсэн	Чанар	Өртөг
	1	2	3	4	5
1	Ном ангилах /ном хэвлэлтэй танилцах, ННА-ын номноос индексийг олох, ном хэвлэлд индекс бичих/	800	1126	153%	35 хүн өдөр
2	Зохиогчийн тэмдэгтийг тодорхойлох	800	1126	153%	2,3 хүн өдөр
3	Нэгдсэн бүртгэл хөтлөх	25	25	100%	0,3 хүн өдөр
4	Ном хэвлэлийг данслах ба номын нүүр хуудас болон 17-р хуудсанд дансны дугаарыг бичих тэмдэг тавих	600 (дээш)	681	100%	13,7 хүн өдөр
5	Формулярийн уут хайчлах	4556	4675	100%	3,2 хүн өдөр

6	Номонд болон уншигчийн картанд формулярийн уут наах	4556	4675	100%	1,9 хүн өдөр
7	Бар код хэвлэх	1400	1561	100%	16,2 хүн өдөр
8	Бар код хайчлах	1400	1561	100%	0,9 хүн өдөр
9	Бар код наах	1400	1561	100%	0,6 хүн өдөр
10	Номын формуляр бөглөх	600	681	100%	0,9 хүн өдөр
11	Номын сангийн фонд, уншлагын танхимуудад ном хуваарилах / танхимуудын дансанд бичих, нэг бүрчилсэн бүртгэлд тэмдэглэл хийх г.м./	600 аас дээш	681	100%	1,4 хүн өдөр

Тав. Мэдээлэл сурталчилгаа соёл олон нийтийн ажил

№	Гүйцэтгэлийн нэр төрөл	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт			
		2019 онд гүйцэтгэх	2019 онд гүйцэтгэсэн	Чанар	Өртөг
1	1	2	3	4	5
	Сэдэвчилсэн номын үзэсгэлэн	36	47	130%	83 хүн өдөр
	Шинэ номын үзэсгэлэн	16	17	100%	19,2 хүн өдөр
3	Өдөрлөг	2	2	100%	14 хүн өдөр
4	Тойм яриа	19	20	100%	
5	1	2	3	4	5
	Чанга уншлага	19	21	100%	
6	АХА	5	7	100%	
7	Уншигч зохиолчдын уулзалт	2	2	100%	80 хүн өдөр
10	Урилгат уншлага	6	8	100%	4 хүн өдөр

11	Номын аян	2	2	99%	120 хүн өдөр
	➢ Лекц	1	1		
	➢ Уралдаан тэмцээн	2	2		
	➢ Хэлэлцүүлэг	2	2		
	➢ Нээлттэй хаалганы өдөр	3	4		
	➢ Эрдэм шинжилгээний бага хурал	2	1		
	➢ Идэвхтэй уншигч гэр бүл шалгаруулах	2	1		
	➢ Уншигчийн бүтээлийн үзэсгэлэн	2	2		
	➢ Алтан хонх танин мэдэхүйн тэмцээн	2	2		
	➢ Дүрийн тоглолт	3	2		
	➢ Гар зургийн уралдаан		1		
	➢ Бүтээлч уншлага		2		
12	Мэдээлэл	34 удаа	46	135%	
13	Цахим хуудсаар үйл ажиллагааг сурталчилах		172	100%	
14	Телевиз радиотай хамтран үйл ажиллагааг сурталчилах		20	100%	

Зургаа. Лавлагаа номзүйн мэдээллийн ажил

№	Гүйцэтгэлийн нэр төрөл	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт			
		2019 онд гүйцэтгэх	2019 онд гүйцэтгэсэн	Чанар	Өртөг
	1	2	3	4	5
1	Лавлагааны фонд шинэчлэн баяжуулах	250 ном	238	95%	
2	Санамж өгөх номзүй	500 нэр	674	134%	21 хүн өдөр
3	Бүртгэн мэдээлэх ном зүй	470	651	144%	12 хүн өдөр
4	Номын жагсаалт гаргах	1069	1287	120%	20 хүн өдөр
5	Аман лавлагаа өгөх	285	395	112%	7,4 хүн өдөр
6	Аман лавлагааны дэвтэр хөтлөх	285	250	87%	0,5 хүн өдөр
7	Татгалзлыг хөтлөх		371	100%	

Долоо. Нүүдлийн номын сан, Номын сан хоорондын солилцоогоор үйлчлэх ажил

№	Гүйцэтгэлийн нэр төрөл	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт				
		2019 онд гүйцэтгэх	2019 онд гүйцэтгэсэн			Чанар
	1	2	3			4
1	Мөрөн сумын ЕБС-ууд (баг иргэд)	4	5	Уншигч	1036	100%
				Ирэгсэд	8311	
				Ном олголт	10064	
2	Ахмадын асрамж үйлчилгээ	1	1	Уншигч	51	
				Ирэгсэд	75	
				Ном олголт	138	
3	Мөрөн сумын цэцэрлэгүүд	4	4	Уншигч	324	
				Ирэгсэд	381	
				Ном олголт	426	
4	Номын богц	47 (гэр бүл)		Уншигч	145	
				Ирэгсэд	145	
				Ном олголт	213	
Нийт		**Уншигч**	**1556**	**Ирэгсэд**	**8912**	**Ном олголт** **10841**

Найм. Номын тооллогын ажил

№	Гүйцэтгэлийн нэр төрөл		Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт			
			2019 онд гүйцэтгэх	2019 онд гүйцэтгэсэн	Чанар	Өртөг
	1		2	3	4	5
1	Хүүхдийн танхимын номын тооллого хийх /ээлжит/	Нэгбүрчилсэн данс	7512	7512	100%	6 хүн өдөр
		Бар кодоор	1556	1556	100%	0,3 хүн өдөр
2	Нийтийн	Нэгбүрчилсэн данс	4605	4381	95%	3,6 хүн өдөр

	уншлагын танхим (ойрын фондын ном тоолох)	Бар кодоор	4446	4390	98%	0,9 хүн өдөр
3	Гэрээр ном олгох танхим	Нэгбүрчилсэн данс	6124	6124	100%	5 хүн өдөр
		Бар кодоор	2336	2336	100%	0,4 хүн өдөр
4	Үндсэн фондын тооллого	Нэгбүрчилсэн данс	68133	58818	86%	49 хүн өдөр
		Бар кодоор	54396	53977	99%	11 хүн өдөр

Ес. Ном сэлбэн засалт

№	Гүйцэтгэлийн нэр төрөл	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		
		2019 онд гүйцэтгэх	2019 онд гүйцэтгэсэн	Чанар
1	1	2	3	4
	Номыг цоолж үдэх		82	100%
2	Хуудас нөхөх		16	100%
3	Ном хавтаслах, салсан хавтас нааж бэхлэх		102	100%
5	Ном сэлбэн засалтыг баримтжуулах	162	312	100%

Арав. Бүтээлч, шинэ ажил

№	Гүйцэтгэлийн нэр төрөл	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		
		Хэрэгжүүлэх арга зам	**Зардал /Хүн өдөр, мян. төг.-өөр/**	**Үр дүн**
1	1	2	3	4
	Цахим орчинд шинэ Пейж хуудаар болон бусад их үүсвэрээр сурталчилгааг тогтмол явуулж	Хэвлэл мэдээллийн байгуулагатай хамтрах	Ойн хүрээнд бичлэг 300.000 төг	Номын сангийн үйл ажиллагааг харуулсан Видео бичлэгийг Хөвсгөлийн өнгө сайттай хамтран хийсэн.

	байх	Өөрсдийн нөөц бололцоог ашиглах		
2	Уншлагын төрөл хэлбэрийг нэмэгдүүлж “Гэр бүлийн уншлага” зохион байгуулах “Номын богц” нэмэж хийх		“Номын богц” (3 шихэг иж бүрэн) 3*9000=27000	47 гэр бүлийн 147 хүнд 213 номоор үйлчиллээ.
3	Ойн хүрээнд жимсний чанамал хийх		91кг*5000=455,000	Ойн хүрээнд жимсний чанамал 150 ширхэг, ууттай ааруул 150 ширхэг зэргийг бэлтгэсэнээр ойн зочид төлөөлөгчид өгөх 150 хүний гарын бэлэг бэлдэв.
4	0,5 шил		150*200=30,000	
5	Ааруул хийх		39*10000=390,000	
6	Цэцгийн мандал хийх		Гадна талбайд 90,000	Гадна талбайд 4*2,50 метрийн харицаатай ном хэлбэртэй цэцгийн мандал хийж тохижууллаа.
7	Монгол ардын тоглоом		Алаг мэлхий (иж бүрэн эсгий урлал) 21000	Хүүхдийн уншлагын танхимд ардын уламжлалт тоглоомыг сурталчлах зорилгоор хөлөгт тоглоом хийлээ.

Арван нэг. Дотоод хяналтын ажил

№	Гүйцэтгэлийн нэр төрөл	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		
		2019 онд гүйцэтгэх	2019 онд гүйцэтгэсэн	Чанар
	1	2	3	4
1	Байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргах	2	2	100%

2	Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөний дагуу хяналт хийж ажлын мэдээ тайланг байгууллагын захиргаа болон дээд байгууллагад танилцуулах	4	4	100%

Арван хоёр. Архив, албан хэрэг хөтлөлтийн ажил

Гүйцэтгэлийн нэр төрөл		2019 онд гүйцэтгэх	Гүйцэтгэсэ н	Чанар
1		2	3	4
Албан хэрэг хөтлөлт	Байгууллагад ирсэн албан бичиг хүлээн авах	144	144	100%
	Байгууллагад ирсэн албан бичгийг бүртгэх	144	144	100%
	Удирдлагад танилцуулах, шилжүүлэх, хэрэг бүрдүүлэх, цохолт хийлгэх,	144	144	100%
	Явуулах албан бичгийн төслийг хүлээн авах, бүртгэх, баталгаажуулах, илгээх	65	65	100%
	Хэвлэмэл хуудасны хадгалалт, ашиглалт, зарцуулалтад хяналт тавих	2	2	100%
	Байгууллагын ХХНЖ боловсруулах, батлуулах, мөрдүүлэх	11	11	100%
	Баримт бичиг олшруулах	9068	9068	100%
	Үйл ажиллагааны мэдээ, тайлан гаргах / *ирсэн явсан бичиг, өргөдөл гомдол, баримт бичгийн мэдээ...гэх мэт* /	5	5	100%
Архивын ажил	Баримт бичигт эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх ажлын бэлтгэл хангах	22	22	100%
	Баримт бичигт эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх	22	22	100%
	Хадгаламжийн нэгжийн бүртгэл үйлдэх, баталгаажуулах, байрлуулах	4	4	100%

	Тоо бүртгэлийн бусад баримт бичиг хөтлөх	3	3	
	Баримтын хадгалалтын зохион байгуулалт	173	173	100%
	Төрийн архивт баримт шилжүүлэхэд бэлтгэх	10	10	100%
	Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж Тодорхойлон бичих	10	10	100%
	ХХНЖ-ын дагуу хэрэг бүрдүүлж байгууллагын архивт 1-р улиралд багтаан хүлээж авах	22	22	100%

Арван гурав. Манлайлах ур чадвар, мэдлэгээ дээшлүүлэх, арга зүйн ажлын талаар

№	Манлайлах ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэх зорилт	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		
		Хэрэгжүүлэх арга зам	Чанар	Зардал /Хүн өдөр, мян. төг.-өөр/
	1	2	3	4
1	Орон нутгийн номын санчдын мэргэжил дээшлүүлэх буюу давтан сургалтыг зохион байгуулах, хөтөлбөр гаргах	1 удаа	100%	1 өдрийн сургалтын хөтөлбөр боловсруулсан
2	Орон нутгийн номын санчдад номын сангийн үйл ажиллагааг сайжруулахад зориулсан төрөл бүрийн сэдвийн мэдээлэл өгөх	Бичгээр болон амаар төрөл бүрийн мэдээллийн хэрэгсэл ашиглан хүргэх ажлын байранд	100%	30 хүн өдөр
3	Ажиллагсдын хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлж албан хэрэг хөтлөлтийн стандартуудыг эзэмшүүлж, монгол хэлний зөв бичих зүйн болон найруулгазүйн алдаагүй шаардлага хангасан баримт бичиг хөтлөж хэвшүүлэх	1. Урт, богино хугацааны сургалтуудад хамруулах 2. Мэргэжил арга зүйн баримт материалаар хангах	100%	Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт амжилттай бэлтгэж, салбар комиссын үзлэгт амжилттай дүгнүүлэн ирсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн

				ажиллаа.
4	Улсын болон аймаг орон нутгийн сургалт зөвлөгөөнд оролцох	МҮНС-гаас зохион байгуулсан сургалтанд хамрагдах	100%	МҮНС- сангаас зохион байгуулсан 2 удаагийн сургалтанд ажилтан албан хаагчдыг хамруулсан
5	Байгууллагын ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	ЭМГ,Нэгдсэн эмнэлэг болон хувийн эмнэлэгтэй хамтран ажиллар		Байгууллагын ажилчдыг нэгдсэн эмнэлэгийн нүдний тасагт нүдний урдчилан сэргийлэх үзлэг, Цээнэ эмнэлэгт бүрэн үзлэг шинжилгээнд хамруулж, эрүүл мэндийн газартай хамтран сургалт зохион байгуулав.

Арван дөрөв. Байгууллагын үйлчилгээ

№	Гүйцэтгэлийн нэр төрөл	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		
		Хэрэгжүүлэх арга зам	Чанар	Зардал /Хүн өдөр, мян. төг.-өөр/
1	Хүүхдийн уншлагын танхимд Соёл танин мэдэхгүйн ажилд зориулж тайз засал чимэглэл	Хүүхдийн уншлагын танхимд 12 м^2 талбайд тайз хийсэн	100%	290,070

<table>
<tr><td>2</td><td>Байгууллагын гадна орчныг зүлэгжүүлэх, цэцгийн мандал хийх цэцэг тарих эко орчин бүрдүүлэх</td><td>Гадна талбайг зүлэгжүүлж, мандлын цэцэг, мод тарьж, өрөө тасалгаандаа 50 ш цэцэг үрслүүлсэн.</td><td>100%</td><td>362,500</td></tr>
<tr><td>3</td><td>“Уран дөш” хүүхдийн зусланд бүлгийн 1 өрөөнд засвар хийж амрагч хүүхдүүдэд таатай орчин бүрдүүлэх</td><td rowspan="5">Засварын ажлыг тохижилтын ажлыг ажилчдын хүчээр хийж гүйцэтгэв.</td><td>100%</td><td>200,000</td></tr>
<tr><td>4</td><td>Хүүхдийн уншлагын танхимын засвар</td><td>100%</td><td>957,000</td></tr>
<tr><td>5</td><td>Кордор Вес засвар</td><td>100%</td><td>1,125,000</td></tr>
<tr><td>6</td><td>Арга зүйн өрөө</td><td>100%</td><td>321,000</td></tr>
<tr><td>7</td><td>Цэцгийн тавиур</td><td>100%</td><td>312,000</td></tr>
<tr><td>8</td><td>Бусад</td><td>Аймаг орон нутгаас зохион байгуулсан олон нийтийн үйл ажиллагаанд бүрэн хамрагдаж ажиллав.</td><td>100%</td><td></td></tr>
</table>

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР.

8043 уншигчийг шинээр бүртгэж 55348 ирэгсдэд 76533 ш ном хэвлэлийн бүтээгдэхүүн олгож үйлчилсэн нь байна. Уншигч, ном олгох төлөвлөгөөг 123%-131%-аар давуулан биелүүлжээ. Нүүдэл, зөөврийн номын сангаар 1556 уншигч бүртгэж, 8912 ирэгсдэд, 10841 ш ном хэвлэл олгож үйлчлэв.

Манай байгууллагын 2019 оны жилийн эцсийн уншлага үйлчилгээг өмнөх онтой харьцуулахад 105,6%-иар, олгосон ном 112,4%-иар өссөн үзүүлэлттэй байна.



ФОНД БАЯЖИЛТ, ФОНДЫН АЖИЛ, ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

Уншигчдын эрэлт хэрэгцээний дагуу бүртгэсэн татгалзлын дэвтэр, хэвлэлийн газрын каталог зэргээс үндэслэн 7,506,400 төгрөгийн 533 ш ном захиалага хийн худалдан авч, 1,990,700 төгрөгийн 148 ш номыг хандив тусламжаар авч, 657,600 төгрөгийн 9 төрлийн хэвлэл захиалж нийт 9,497,100 төгрөгийн 681 ширхэг ном, хэвлэлээр фонд баяжилт хийлээ.

681 ш ном хэвлэлийг бүртгэж техник ажиллагаа хийн данс бүртгэлтэй тулгаж фонд, уншлагын танхимуудад хуваарилан хүлээлгэж өгөв.

Шинээр ирж байгаа тогтмол хэвлэлийг танхимаар уншлага үйлчилгээнд гаргаж байна.

Шинжлэх ухааны төрөлөөр (681 ширхэг ном)

№	Шинжлэх ухааны салбар	Номын тоо
1	Байгалын ухаан	26
2	Техник, техникийн шинжлэх ухаан	9

3	Хөдөө аж ахуй ба ойн аж ахуй	12
4	Түүх	112
5	Эрүүлийг хамгаалах, анагаах шинжлэх ухаан	15
6	Эдийн засаг	14
7	Төр эрх, хууль цааз	12
8	Соёл,шинжлэх ухаан, боловсрол	50
9	Хэл шинжлэл	23
10	Аман зохиол, утга зохиол судлал	65
11	Уран зохиол	253
12	Урлаг	32
13	Шашин	11
14	Гүн ухаан	19
15	Сэтгэл судлал	11
16	Лавлах хэвлэл	17
	Нийт	**681**

Шинээр ирсэн 681 номын



Ном байрлуулалт: Үндсэн фондын тавиурт 3685 ширхэг ном хэвлэлийг төрөл анги, үсэг дараалаар байрлуулсан.Үүнд:

- Үндсэн сан хөмрөг, уншлагын танхимуу дад тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн арга хэмжээний үеэр үзэсгэлэнд тавигдсан номнууд - 1075
- Уншлагын танхимуудаас захиалагаар гарсан буцаагдсан – 2110
- Бар код шинэчлэгдсэн – 500

- Мөн өмнөх оны 8 нэрийн 74 нэгж сонинг нийтийн уншлагын танхимаас хүлээн авч байрлуулав.

Фонд зохион байгуулалт: I –р фондын цаасан ялгагчуудыг стандарт хэмжээ бүхий эдэлгээ даах төмөр ялгагчаар бүрэн солих зорилт тавин ажиллаж байгаад бөгөөд энэ хугацаанд хуучин 84 ширхэг, шинээр үсэг дарааллын 482 ширхэг ялгагч, төрөл ангийн 52 ширхэг ялгагч нийт 534 ялгагч бэлтгэн байрлуулав.

Мөн I ба II-р фондын номын байрлалыг шалгах ажлыг 6 тавиурын номонд хийсэн. Энэ үеэр гадаадын уран зохиолын ангиллын Г үсгийн номнуудыг өөр газар байрлуулсан, мөн 88 ангийн ном 87 руу орсон зэрэг алдаануудыг засан

байрлуулах ажил хийгсэн.

КАТАЛОГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ.

Шинээр номыг ангилж зохиолчийн тэмдэгтийг тодорхойлон электрон каталогт бүрэн оруулав. Төрөл ангийн уламжлалт каталогт 4617 ш каталогийн карт хэвлэснээс 4617 ш карт, үсэг дарааллын каталогт 978 ш карт байрлуулж, үсэг дарааллын каталогт 2 удаа редактор хийж буруу ангилагдсан, байрлагдсан алдаануудыг засварлав.

Төрөл анги, үсэг дарааллын каталогийн хаягийг шинээр хийж байрлуулав. Каталогийн картын эдэлгээг уртасгах, ариутгаж цэвэрлэхэд хялбар байлгах зорилгоор скочоор бүрж сайжруулав. Электрон каталогийн ном оруулалтанд хяналт тавьж 4515 төрлийн номонд редактор хийж засварлав. Орон нутгийн картын санд 1132 ш карт бичив.

НОМ ХЭВЛЭЛД ХИЙХ ТЕХНИК АЖИЛЛАГАА, СЭЛБЭН ЗАСАЛТ

Номын сан номзүйн ангиллаар ширхэг ном ангилахаас 662 номыг ангилж зохиолчийн тэмдэгтийг тодорхойлон номын сан ном зүйн ангиллаар ангилав.

Шинээр ирсэн болон хуучин 1126 ном хэвлэлд техник үйл ажиллагаа хийлээ. /Данслах, тамга тэмдэг тавих, формуляр бичих, уут наах, бар код наах г.м./. Нэгдсэн бүртгэлд 25 удаа ном хэвлэлийн хөтлөлт хийв. Нийт 4675 формулярын уут хайчилж ном хэвлэл болон уншигчийн картанд наав. Бар код 1126 ширхэгийг хэвлэж номонд наав. Уншигчдийн эрэлт хэрэгцээнд элэгдэж хуучирсан цоолж үдсэн 82 ширхэг, хуудас нөхсөн 16 ширэг, салсан хуудас нааж бэхэлсэн 102 нийт 312 ширхэг ном хэвлэлийг сэлбэн засаж баримтжуулан уншлаганд гаргалаа.

ЛАВЛАГАА НОМЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН АЖИЛ

Уншлагын танхим бүрийн лавлагааны фондыг 238 ширхэг номоор шинэчлэн баяжилуулсан. 674 ширхэг номоор санамж өгөх номзүй, 651 ширхэг номоор бүртгэн мэдээлэх номзүй, цаг үеийн үйл явдлуудтай холбогдуулан 1287 ш номоор номын жагсаалт гарган ном хэвлэлийг сурталчлах ажлыг хийлээ.

Мэдээлэл сурталчилгааны самбарт "Үндсэн хуулийн тухай", "Ном уншихын ач тус", "Гар утасны хэрэглээ, хор уршиг", "Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн" шалгаруулах журам, "Усны тухай", ... гэх мэт сэдвүүдээр 50 гаруй удаа мэдээлэл гаргаж уншигч хэрэглэгчдэд хүргэлээ.

Уншигчдын асуусан төрөл бүрийн лавлагаанд тухай бүрд нь хариулт өгч аман лавлагаа 395 удаа өгч аман лавлагааны дэвтэрт бүртгэсэн.

Цахим хуудас, телевиз радиотай хамтран шинэ номын мэдээг уншигч үйлчлүүлэгчд тогтмол байсан.

АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, АРХИВЫН АЖИЛ

Байгууллагад нийт 144ш бичиг хүлээн авснаас 42 нь хариутай албан тоот, ирлээ. Үүний 38 албан тоотыг хугацаанд хариуг нь өгч, 4ш албан бичгийн хугацааг хоцроосон, 65 ширхэг албан тоотыг дээд шатны байгууллага болон харилцагч байгууллагууд руу явууллаа. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны болон, боловсон хүчний талаар гарсан 14ш тушаалыг холбогдох ажилтанд танилцуулж, бүртгэл хөтөллөө. 2014 оны байнга хадгалах 10 ш баримтаар аймгийн архивын тасагт нөхөн бүрдүүлэлт хийсэн. Аймгийн архивын тасгаас зохиосон сургалт семинар, уралдаан тэмцээнд тухай бүрт нь оролцсон. Дээд байгууллага болон бусад байгууллагаас ирсэн тоотын хариу болох мэдээ, судалгааг албан тоот хавсарган тухай бүрт гаргаж ажиллалаа. Ажилчдын албан тушаалын тодорхойлолт хөдөлмөрийн гэрээг шинэчлэн удирдлагаар хянуулж батлууллаа. Төрийн албаны зөвлөлийн 05 дугаар тогтоолын дагуу боловсон хүчний хувийн хэргийг шинэчилж, бүртгэлийг баталгаажууллаа. ХХНЖ-ийг албан хаагч тус бүрт шинэчилэн боловсруулж, баримтыг индексийн дагуу эмхлэн цэгцэллээ. Байгууллагт хадгалагдаж буй нийт баримтанд нягтлан шалгалт хийж, тоо бүртгэлийн баримтуудтай тулган, хамгаалалтын хайрцаг заагуур үйлдлээ. Байгуулагын 75 жилийн ой баярын үйл ажиллагааг DVD дээр хадгалсан. Байгууллагын архивт нийт 22ш баримтаар нөхөн бүрдүүлэлт хийсэн ба үүнээс байнга хадгалах 11, 70 жил хадгалах 4, түр хадгалах 7ш баримт байлаа. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 4 дүгээр 17-ны 150 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2019 оны 4 сарын 17-ны 46 дугаар захирамжийн дагуу Архивын Ерөнхий газрын улсын үзлэгт амжилттай бэлтгэж, аймгийн ЗДТ-ын салбар комиссын урьдчилсан үзлэгт хамрагдаж, үзлэгийн мөрөөр ирсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн

Албан хэрэг хөтлөлийн ажил 82 хувь, архивын ажил 95 хувьтайгаар амжилттай дүгнэгдлээ.

СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ.

2019 оны жилийн эцсийн байдлаар төв номын сан нийт 148-н соёл, танин мэдэхүйн ажил зохион байгууллаа. Үүнд: “Зохиогч-Уншигчдын” уулзалт, “Яруу найргийн үдэшлэг”, “Шинэ номын нээлт”, “Сэдэвчилсэн номын үзэсгэлэн”, “Зөөврийн номын сангийн үйлчилгээ”, “Номын богц” зэрэг олон үйлчилгээг явуулж, номын сангийн үйл ажиллагааг сурталчлах, уншигчдийн боловсрол, соёл, мэдээлэл, чөлөөт цагийн эрэлт хэрэгцээг хангаан ажиллаа.

Номын сангийн үйл ажиллагаанд шинэлэг арга барилыг нэвтрүүлж, байгууллагаа олон нийтэд сурталчлах, уншигчдын ном унших идэвхийг өрнүүлэх, уншигчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигийн дагуу хийгдсэн ажлууд:

МУ-ын ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарилгийн дагуу “Үндэсний бичиг үсгийн баяр 2019”, “Дэлхийн номын өдөр”, “Олон улсын хүүхдийн номын өдөр” -үүдийг тохиолдуулан “НОМ – БИДНИЙ НӨХӨР” номын аяны хүрээнд “Нүүдлийн номын сан”, ахлан, дунд ангийхны дунд “Уншсан зохиолоо хэн сайн унших вэ?” зэрэг томоохон ажлуудыг зохион байгууллаа.

Төвөөс алслагдсан сургууль, цэцэрлэг, иргэд олон нийтэд зөөврийн номын сангаар үйлчиллээ. Үүнд: Ерөнхий боловсролын сургууль 3, цэцэрлэг 5 , албан
байгуулага 2, МСҮТ, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ахмад настанд нийт 13 удаагийн зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 8912 уншигчдад 10841 номоор үйлчилсэн. Энэ
хугацаанд уншигчдын дунд нийт 12 удаагийн СТМА зохион байгуулж, нийт 1258 уншигчийг хамруулсан байна.

Дэлхийн номын өдөр болон аймгийн нэрлэсэн жилийн хүрээнд Хүүхэд багачуудыг номонд дуртай болгох, ном унших хүсэл сонирхлыг нь төрүүлэх, номыг хайрлах, сэтгэлгээнд сургах, номоор дамжуулан амьдралын арга ухааныг олж авахад туслах, унших, чадварыг сайжруулах, нийгмийн оролцоог нэмэгдүүлхэд зорилгоор ахлах, ангийн сурагчдын дунд “Уншсан зохиолоо хэн сайн ярих вэ?” уралдааныг ДЗОУБ –ын дэмжлэгтэйгээр зохион байгууллаа.

Ахлах ангийн нийт 15 багийн дунд зохион байгуулж шагнаж урамшууллаа.

1-р байр ЭДЦС-ийн Аясгалан баг

2-р байр Авьяас сургуулийн Dream city баг

3-р байр Нутгийн аваргууд сургуулийн Хавар баг, Тусгай байранд Dream баг

Шилдэг Удирдагч багшаар ЭДЦС-ын номын санч Б. Дэлгэрмөрөн тус тус шалгарсан.

➢ Уншсан зохиолоо хэн сайн ярих вэ?” дунд ангийн сурагчдын уралдаанд Мөрөн сумын 5 сургуулийн 13 багын дунд зохион байгуулж

урамшууллаа.

1-р байр Сод – Эрдэм Ирээдүйн илч баг

2-р байранд ЭДЦС-ийн – Оршил баг

3-р байр Авьяас Эрдмийн хөтөч баг

Тусгай байр Нутгийн аваргууд сургуулийн Оч баг шалгарсан.

Шилдэг удирдагч багшаар Сод-Эрдэм сургуулийн номын санч Г. Оюундулам тодорлоо.

Үндэсний бичиг соёлын сурталчилах ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн ахлах дунд ангийн сурагчдын дунд жил бүр уламжлал болгон зохиогддог

уралдаанууды г зохион байгууллаа Мөн уншигчдын дунд “Алтан хонх” танин мэдэхүйн тэмцээн зохион явуулав.

Нийт 29 уншигч хамрагдсанаас

1-р байр ДМЦС, 9г О.Солонго

2-р байр ДМЦС, 9г А.Өлзийнаран

3-р байр ДМЦС,12в Г.ПүрэвбаясгаланТусгай байранд ЭДЦС, 7б Б.Түвшинзаяа нар шалгарч дурсамж номоор урамшууллаа.

НОМЫН БАЯР-2019

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг, 2018 оны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/683 тоот тушаалаар батлагдсан “Уншлагыг дэмжих журам” – ын дагуу “Номын баяр 2019” – ыг зохион байгуулж ажиллаа. Энэхүү номын баярыг Ерөнхийлөгчийн зарлигийн хүрээнд аймгийн Нийтийн номын сан болон бусад байгууллагууд 7 дахь жилдээ зохион байгууллаа.

Номын баярын хүрээнд :

- Шинэ номын үзэсгэлэн
- Ном солилцоо
- Тэргүүний уншигчдаа тодруулж алдаршуулах
- Уншигч зохиолчдын уулзалтыг амжилттай зохион байгуулж ажиллаа.

Нээлтэнд Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн уншигч хүүхдүүд Хөвсгөлийн хүүхдийн сүлд дуугаар мэндчилгээ дэвшүүлж, Эрдмийн далай цогцолбор сургуулийн уншигчид бүжгээр мэндчилж, төрөлжсөн сургалтай “Авьяас 8”-р сургуулийн 4 –р ангийн уншигч Барамсайн “Байяа Байяа” хүүхдийн хошин зохиолоор, аймгийн утга зохиолын нэгдлийн дарга Б. Сарантуяа өөрийн “Тусгаар тогтнол” шүлгээр номын баярт мэндчилгээ дэвшүүллээ.

Иргэд уншигчдад “Ном солилцоо” хийх боломж нөхцлийг бүрдүүлж, энэ арга хэмжээнд ЕБС-иудын номын санчид, монгол хэл уран зохиолын багш нар идэвхитэй оролцсон бөгөөд 41 төрлийн 50 гариу номоор солилцоо хийгдлээ.

Аймгийн нийтийн номын сангаас 2019 онд шилдэг уншигч шалгаруулах журмын

дагуу бусдыгаа манлайлан болзол хангасан 6 уншигчид номын баярын арга хэмжээн дээр “Нацагдорж тэмдэг” – ийг гардууллаа.

Аймгийн Утга зохиолын нэгдэлтэй хамтран уншигч зохиолчдын уулзалтын зохион байгуулж, уулзалтанд аймгийн УЗН-ийн тэргүүн зохиолч Б. Сарантуяа, 2017 оны “Алтан өд” - ийн эзэн МЗЭ гишүүн зохиолч Ц. Ганболд, зохиолч яруу найрагч О. Элбэгтөгс нар оролцлоо. Зохиолчид өнөөгийн уран зохиол, утга зохиолын чиг хандлагын талаар санал бодлоо солилцож, уншигчидтай өөрийн зохиол бүтээлийн талаар ярилцлаа.

Аймаг орон нутгийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд, төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, байгууллагын үйл ажиллагааг сурталчлан мэдээллийн ил тод байдлыг хангах, “Хүүхдэд ээлтэй орон нутаг тогтвортой байдал” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Хүүхэд хамгаалал-Өрхийн хөгжлийг дэмжих” нэрлэсэн жилийн ажлыг зохион байгуулах, албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад чиглэсэн олон үр дүнтэй ажлуудыг зохион байгууллаа.

Хүүхэд хамгаалал-Өрхийн хөгжлийг дэмжих” нэрлэсэн жилийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гэр бүл, ААН, байгууллагад, “Номын богц” хүргэх үйлчилгээ нь гэр бүлийн уншилгыг дэмжих, хүүхдийг номтой нөхөрлүүлэх, эцэг эхчүүдийг гэр бүлдээ цаг зав гаргах, үлгэр дуурайлал болох сайхан нөхцлийг бүрдүүлж уншигчдын талархалыг хүлээж байна.

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Сурагчдаар дамжуулан иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад байгаль орчин, усны үнэ цэнэ, түүний зохистой хэрэглээг таниулах, уншигчдын

чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ном унших аргазүйд суралцуулах мөн төрөлх нутгийнхаа түүх соёлыг судлуулан нийгмийн идэвх сонирхол, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Аймгийн нийтийн номын сан, Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргаа, Дэлгэрмөрөн, Шишхэд голын сав газрын захиргаа, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Улаан загалмайн нийгэмлэг хамтран Мөрөн сумын ЕБС-ын ахлах ангийн сурагчдын дунд "Байгаль орчин ба тогтвортой хөгжил" сэдвийн хүрээнд АСК тэмцээнийг 4 дөх жилдээ уламжлал болгон “ХӨГЖЛӨӨС ХЭН Ч ҮЛДЭХ, ХОЦРОХ ЁСГҮЙ – NO - ONE LEFT BEHIND” гэсэн сэдвийн хүрээндд амжилттай зохион байгууллаа. Энэхүү тэмцээнд нийт Мөрөн сумын 4 сургууль оролцож чиглүүлэгч багш, багийн ахлагч, гишүүд 31 багш сурагч, хөгжөөн дэмжигч 300 сурагч уншигчид оролцлоо.

Тэргүүн байранд – Авьяас сургуулийн "Dream city"" Баг шалгарч алтан медаль, өргөмжлөл, Шилжин явах цом, 100000 төгрөг

Дэд байранд: ЭДЦС-ийн "Энгүүн" баг шалгарч өргөмжлөл мөнгөн медаль 80000 төгрөг,

Гутгаар байранд**:** Мөрөн Гурван Эрдэнэ сургуулийн " Freedom" баг шалгарч өргөмжлөл хүрэл медаль 50000 төгрөг, Шилдэг зохион байгуулагч багшаар ЭДЦС-ын багш шалгарч Өргөмжлөл 30000 төгрөгөөр тус тус шагнагдлаа.

АИТХ-ын дэргэдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран "Цахим орчин дахь хүүхэд хамгаалал" сэдэвт илтгэлийн уралдааныг 2 үе шаттай зохион байгууллаа. Эхний шалгаруулалтыг 5 сарын 3-нд ажлын хэсэгт ирсэн нийт 38-н илтгэлээс 10 илтгэлийг 2 дахь шатанд шалгаруууллаа. Шалгасан 10 илтгэлийг хэлэлцүүлж шилдэгүүдийг тодрууллаа.

- ✓ 1-р байр Арбулаг сумын 11а ангийн сурагч М. Халиун
- ✓ 2-р байр Улаан-Уул сумын 10а сурагч Ш. Энхбилэг
- ✓ 3-р байр Титэм ЕБС-ын 11а сурагч Б. Оюунжаргал
- ✓ Тусгай байр Арбулаг сумын 10а сурагч Б. Санчирмаа
- ✓ Тусгай байр Чандмань – Өндөр сумын 10б ангийн сурагч Б. Мөнхзаяа

“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-т Нийтийн номын сан нь хүүхэд багачуудад зориулсан “Үлгэрийн ном”, “Хүүхдийн цуврал комик ном”, “Хүүхэд - гэр бүл”, номын үзэсгэлэн гаргаж нийт 400 орчим хүүхэд 150 гаруй эцэг эхэд үйлчиллээ. Бяцхан уншигчдынхаа дунд “Хэн хурдан унших вэ?”, “Уншсан үлгэрээ хэн сайн ярих вэ?” хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулж 58 бяцхан уншигч оролцож, шалгарсан хүүхдүүдийг аймгийн Нийтийн номын сангаас урамшуулж, мөн 88 уншигчдад шинээр үнэ төлбөргүй карт нээж номын сангийн

Залуу гэр бүлүүдэд түүх, соёлын өвийг хамгаалах, төлөвшүүлэх, ардын оролцоог хангах, гэр бүлийн соёлд сургах, гэр бүлийн эерэг орчин бүрдүүлэх зорилгоор Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар орон нутгийн хэвлэл

мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулагдсан " Үлгэрч аав ээж " арга хэмжээнд 14 СӨББ-ын 154 гэр бүл буюу 308 хүн хамрагдлаа.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд: Байгууллагын нийгмийн баталгааг хангах 2019 оны үйл ажилгааны төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Албан хаагчдад сар бүр хоолны мөнгө олгодог. Улс болон орон нутагт зохион байгуулж буй сургалт семинарт бүрэн хамрагдаж, албан хаагчид ажлын байранд хөгжих боломжоор дэмжин ажиллаж байна.

Албан хаагчдыг нүдний урьдчилан сэргийлэх үзлэг, Цээнэ эмнэлэгт бүрэн үзлэг шинжилгээнд хамруулаа. Аймгийн ЭМГ-тай хамтран Мөрөн сумын Засаг даргын 2018 оны 11 сарын 27-ны өдрийн А/206 тоот захирамжын дагуу "Тамхидалтын эсрэг хувьсгал – Тамхигүй ажлын байр" аяны хүрэээнд Ц.Ууганжаргал (Халдварт бус өвчтөн хариуцсан мэргэжилтэн) архм тамхины хор хөөөлийн тухай, А,Эрдэнэбилэг (Хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн) Зөв зохистой хооллолтын талаар сургалтыг зохион байгуулж, нийт 40 гаруй уншигч хамрагдсан.

"Аймгийн засаг даргын нэрэмжит спортын олон төрөлт тэмцээнд баг хамт олноороо амжилттай оролцсон. Монгол Улсын Засгийн газрын 05 дугаар тогтоолын хүрээнд ажлын уялдаа холбоог сайжруулж, багийн хамтын ажиллагаа болон бие бялдрын чийрэгжүүлэх зорилгоор нийт соёлын ажилтнуудын дунд "Идэвхитэй хөдөлгөөн хамтын оролцоо-2019" арга хэмжээнд хамт олноороо идэвхитэй оролцлоо.

- Аймгийн Нийтийн номын сан нь орон нутгийн бодлого шийдвэрийг иргэд олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх үүднээс "Мэдээллийн цагийн ажлын зохион байгуулах" аймгийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 08-ны А/529 дугаар захирамжийн хүрээнд төлөвлөгөө гарган байгууллага, орон нутгийн бодлого шийдвэрийг цаг тухай бүрт нь орон нутгийн хэвлэл мэдээлэл, Үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлаг, Хөвсгөлийн өнгө сайт, орон нутгийн Далай Ээж, Эрх чөлөө сонинд тогтмол мэдээлэн хамтран ажиллаж байна. Мөн Сар бүрийн сүүлийн 7 хоногийн баасан гарагт орон нутгийн телевиз, "Хөвсгөлийн өнгө" сайттай хамтарч шинэ ном, сэтгүүлийн мэдээллийг иргэдэд түгээж байна.

- Иргэдийн төлөөлөгчийн хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 78 дугаар тогтоолоор Хөвсгөл аймгийн нийтийн номын сан нь Монгол Улсын Соёлын Гавьяат зүтгэлтэн Далантайн Сүрэнжавын нэрэмжит боллоо.
- Хөвсгөл аймгийн номын сангийн салбарыг хөгжүүлэх хэрэгт баг хамт олноороо үр бүтээлтэй ажиллаж, тодорхой амжилт гаргаж байгаа нэг номын санчийг Монгол улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн зохиолч, сэтгүүлч Д.Сүрэнжавын нэрэмжит "Шилдэг номын санч"-аар шалгаруулах журмыг боловсруулж, мөрдүүллээ. Энэ оны шилдэг номын санчаар Аймгийн нийтийн номын сангийн ахлах номын санч, аргазүйч Ц.Алтантуяа шалгарлаа.

БУСАД СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ

Ном хэвлэлийг олон нийтэд сурталчлах, уншигчдын ном унших идэвхийг өрнүүлэх, уншигчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор шинээр ирсэн ном хэвлэл, МЗЭ шагналт зохиолчдын бүтээл, шилдэг зохиолчдын насны ой, тэмдэглэлт өдөр, баяр ёслол, түүхэн үйл явдал, цаг үеийн үйл ажиллагаатай, холбогдуулан шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 64 удаа 2612 ширхэг номоор, ном хэвлэлийг сурталчиллаа.

СГЗ-н ЗОХИОЛЧ
С.ЛОЧИНГИЙН
80 НАСНЫ ОЙД

ТАМХИГҮЙ ОРЧИН
ТАНЫ ОРЧИН

СГЗ-н ЗОХИОЛЧ
Ш.ДУЛМААГИЙН 85
НАСНЫ ОЙД

ХҮҮХДИЙН УТГА ЗОХИОЛЫН САНГААС
ДЭЛХИЙН ХҮҮХДИЙН НОМЫН ӨДРИЙН МЭНД ХҮРГЭЕ
Х.К.АНДЕРСЕНИЙ БҮТЭЭЛЭЭС

ШИНЭ НОМЫН ҮЗЭСГЭЛЭН

ДЭЛХИЙН БАГШ НАРЫН ӨДӨРТ

- ҮЛГЭР -
- КОМИК -
- ҮЛГЭР -
- ҮЛГЭР -

Бага насны уншигчдыг ном унших, уншсан сэдвээ ярьж, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, зөв дадал хэвшил олгох зорилгоор “Зөрүүд зан зохиомж сургаал” болон “Улаан малгайт” үлгэрүүдээр жүжигчилсэн тоглолт, тойм яриа, чанга уншлага, урилгат уншлага, бүтээлч уншлагуудыг зохион байгуулж байлаа. Шинэ ном болон сэдэвчилсэн номуудаар тойм яриа 20 удаа хийж 986 уншигч, Чанга уншлага 21 удаа зохион байгуулж 891 уншигч хамрагдав. Бүтээлч уншлага 2 удаа явуулж 62 уншигч хамарч уншигчдын бүтээлийн үзэсгэлэн гаргаж байлаа. Урилгат уншлага 8 удаа хийж номын сангийн үйлчилгээ үзүүлэв. Нийт 345

уншигчид үйлчиллээ.

МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН

Мэргэжил арга зүйн зөвлөмжийг БСУГ, ДЗМОУБ-тай хамтран аймгийн нийт номын санчдын мэргэжил дээшлүүлэх сургалтыг 2019 оны 5 дугаар сарын 14-нд зохион байгуулж, сургалтанд нийт номын санч хамрагдсан байна. Аймгийн аймгийн нийтийн номын ахлах номын санч Ц.Алтантуяа, Номын сангийн бүртгэл маягт, Номын санч-мэдээллийн ажилтан Б.Энхтуяа, Номын сангийн соёл танин мэдэхүйн ажил, каталогч Ц.Дуламжав Каталоги зохион байгуулалт, Сүлжээний инженер Д.Батцоож Цахим номын сан сэдвүүдээр сонирхолтой лекц хэлэлцүүлэг зохион байгууллаа. Мөн сургалтанд хамрагдсан номын санч нар нийтийн номын санд 1 өдрийн ажлын туршлага солилцлоо.

Мөрөн сумын ерөнхий боловсролын Гурван-Эрдэнэ, Нутгийн Аваргууд, сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

2019 оны 5 дугаар сарын 17-нд Ахлах номын санч Ц.Алтантуяа Жаргалант, сумын ЕБС-ийн номын сан, Соёлын төвийн номын санд ажиллаж арга зүйн зөвлөгөөг өглөө. Жаргалант номын сангууд нь БСШУ Сайдын 441 дүгээр тушаал “Номын сангийн анхан шатны бүртгэл маягт”-ууд болох Номын нэг бүрчилсэн бүртгэл, нэгдсэн бүртгэл, өдөр тутмын бүртгэлүүдийн хөтлөлт хангалтгүй байлаа.

2019 оны 6 дугаар сарын 26 нд Галт сумын соёлын төвийн номын санд ажиллаж арга зүйн зөвлөгөөг өглөө. Соёлын төвийн номын сан нь БСШУ Сайдын 441 дүгээр тушаал “Номын сангийн анхан шатны бүртгэл маягт”-ууд болох Номын нэг бүрчилсэн бүртгэл, нэгдсэн бүртгэл, өдөр тутмын бүртгэлүүдийн хөтлөлт, үйл ажиллагаа хангалтай сайн байлаа.

Орон нутгийн номын санч нарт утсаар, бичгээр, цахимаар арга зүйн зөвлөгөөг тухай бүрд өгч ажиллаж байна.

Боловсрол соёлын газрын Мэргэжилтэн Х.Баасансүрэн, Оюунтунгалаг нар номын санч нарын дунд соёл танин мэдэхүйн ажлыг хэрхэн үд дүнтэй явуулах талаар хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Улаанбаатар хотод 2019 оны 5 дугаар сарын 3 нд “Үндэсний бичиг үсгийн баяр 2019” үйл ажиллагаа зохион байлагдаж улсын хэмжээнд үйл ажилгаагаараа тэргүүлсэн нэг номын санд олгодог Шилдэг номын сан “Ном цом”-ын эзэн байгууллагаар шалгарлаа. “Номын сангийн үйл ажиллагааны тайлан боловсруулах арга зүйн зөвламж” сэдэвт сургалтанд ахлах номын санч Ц.Алтантуяа хамрагдав.

Монгол Улсын Үндэсний номын сангаас “Нийтийн номын сан арга зүйн төв болох нь” сэдэвт мэргэжил арга зүйн сургалтыг 2019 оны 12-р сарын 6 – ны өдөр Үндэсний номын сангийн эрдэм шинжилгээний танхимд зохион байгуулагдсан сургалтанд Ч.Базар хамрагдлаа. Сургалтын үеэр Сэлэнгэ, Өмнөговь, Хөвсгөл, Ховд аймгууд үйл ажиллагаа арга зүйн туршлага солилцлоо.

БАЙГУУЛГА ХАМТ ОЛНЫ АЖИЛ

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр, 2017оны 67тогтоол, Хөвсгөл аймгийн онцгой байдлын газрын 2019 оны 3 дугаар сарын 19 – ны 36/82 тоотыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Нийтийн номын сангийн хамт олон газар хөтлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх таниулах арга хэмжээ болон гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцлоо.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Мөрөн сумын 210 жилийн ойг тохиолдуулан “Төлөвлөлт сайтай хотоос – тохижилт сайтай хот” аяны хүрээнд гадна, дотно тохижилтын ажлын төлөвлөгөө гарган, тохижилтын ажлууд хийгдэж байна.

Ойн хүрээнд байгууллагын лого бүхий даавуун тор 150 ширхэг, жимсний чанамал 150 ширхэг, ууттай ааруул 150 ширхэг зэргийг бэлтгэсэнээр ойн зочид төлөөлөгчид өгөх 150 хүний гарын бэлэг албан хаагчдын санаачилгаар хийлээ.

Соёл танин мэдэхүйн ажлыг зохион байгуулахад орчин бүрдүүлэх зорилгоор хүүхдийн уншлагын танхинд хүндэтгэлийн тайз, үзэсгэлэнгийн 22 ширээнд бүтээлэг, хөлөгт тоглоом зэргийг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан оёлоо.

Гадна талбайд 4*2,50 метрийн харицаатай ном хэлбэртэй цэцгийн мандал, 25 ширхэг цэцгийн тавиур хийлээ. Хүүхдийн уншлагын танхим, аргазүйн өрөө,

коридор, “ Уран дөш” хүүхдийн зуслан зэрэгт их засвар хийж тохижуууллаа.

HOTEL

HOTEL


Shot on X27
vivo AI camera

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Эрхэм зорилго

Иргэд уншигчдын оюуны хэрэгцээг бүрэн хангахуйц орчин үеийн мэдээллийн төв болох

1.2 Номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл

Манай Номын сан нь 1944 онд байгуулагдаж нийт 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр нийтийн уншлагын танхим, хүүхдийн уншлагын танхим, гэрээр ном олгох танхим гэсэн 3 танхимд 102961.1 мян.төг-ийн үнэ бүхий 50808 номын үндсэн фондтой, өөрийн эзэмшлийн 325м^2 барилга, 1395м^2 газарт үйл ажиллагаагаа явуулж байна.

Facebook: **5000** гаруй найз, дагагч бүхий “Хэнтий аймгийн Номын сан” facebook хуудас ажиллуулж байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулж, шинэ номын мэдээ мэдээллийг түгээж байна.

Номын сангийн үйлчилгээг чөлөөт сонголт буюу нээлттэй үйлчилгээнд шилжүүлж уншигч-үйлчлүүлэгчид мэдээллийг өөрийн хүсэл сонирхлоор сонгон авах боломжийг олгоод байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.6-д тусгагдсан “Нийтийн номын сангийн фондыг баяжуулан, хүүхэд залуусын номтой нөхөрлөх, иргэд олон нийтийн ном унших боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Ном уншицгаая” хөдөлгөөн өрнүүлнэ” гэсэн зорилт болон түүнийг хэрэгжүүлэх 4 арга хэмжээний хүрээнд "Ном уншицгаая" хөдөлгөөнийг өрнүүлэх, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сарын бүрийн 22-ны өдрийг “Уншигчийн өдөр” болгон тогтмол тэмдэглэж уг арга хэмжээнд бүтээлч уншлагын дэвтэр 10 удаа аж ахуйн нэгж, байгууллагуудад аялуулан уншсанаа тэмдэглэн урилгат уншлаганд хамрагдах, номын сантай танилцах, ном солилцоо хийх, номын үзэсгэлэнд хамрагдах, уншсанаа

ярилцах хэлэлцүүлэгт оролцох зэрэг соёл, олон нийтийн ажлуудыг 15 удаа зохион байгуулж 3750 гаруй уншигч иргэд хамрагдлаа.

Мөн зөөврийн номын сангийн үйлчилгээг Дадал сумын Хилийн цэргийн анги, Баян-Овоо, Батширээт, Баянмөнх, Бор-Өндөр, Мөрөн, Баянхутаг сумдын Соёлын төвүүд, Хэрлэн сумын лаборатри I сургууль, IV цэцэрлэг, Бамбар цэцэрлэг, МСҮТөв, худалдаа үйлчилгээний Тамир-Өсөх ХХК зэрэг 15 сумын 25 байгууллага, аж ахуйн нэгжийг хамруулан яруу найраг, уран зохиолын болон танин мэдэхүйн сэдэвт 1324 ширхэг номоор 12396 иргэд, уншигчдыг хамруулан зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүллээ.

Сургуулийн амралтаараа хөдөө орон нутагт малчин аав ээждээ тусалж амрах Жаргалтхаан, Цэнхэрмандал, Батширээт, Мөрөн, Баян-Овоо сумдын ЕБС-ын болон Хэрлэн сумын Тэмүүжин цогцолбор сургуулийн X-XI ангийн 20-оод сурагчид зуны амралтаараа хөдөө орон нутагт амрах явцдаа уншиж судлах 200 ширхэг ном авч үйлчлүүллээ. Мөн Хэрлэн сумын хүүхдийн зуслан, гүүний саам эмчилгээнд амарч сувилуулж буй хүүхдүүд болон Хэрлэн хороолол, багийн төвүүдийн гэртээ амарч буй 350 гаруй хүүхдүүдэд 550 хүүхдийн танин мэдэхүйн номоор үйлчилж насанд хүрэгчдэд хүүхэддээ хэрхэн ном уншуулах, ном сонголт хийх зэрэг яриа таниулгыг анх удаа зохион байгууллаа.



Сар бүрийн 1 өдрийг “Гэр бүлийн өдөр” болгон энэ өдрүүдэд эцэг эх, хүүхдийн оролцоог хангах хамтдаа бүтээлчээр ном унших, уншуулах зэрэг ажлуудыг зохион байгуулж 88 гэр бүлийг хамруулан 1225 номоор үйлчилсэн.

Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо болон Насан туршийн боловсролын газартай хамтран 8-19 насны 23 сурагчдад уншигчийн карт нээж номын сангийн уншлага үйлчилгээний танхимтай танилцах аялал зохион байгуулан номын сангийн байнгын уншигчид болгож мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Алтан хонх” цэнгээнт тэмцээн, зөөврийн номын сангийн үйлчилгээг үзүүллээ. Уг арга хэмжээнд Хэрлэн сумын 30 иргэн хамрагдсан.

“Өглөөний уншлага”-ыг өдөр тутмын тогтмол хэвлэлээс тоймлон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 8 удаа сурталчлан “Урилгат уншлага”-ыг Хэрлэн сумын ЕБС-ийн сурагчдад 5 удаа 300 гаруй хүүхдүүдийг хамруулан байнгын уншигчийн мөн тоогоор нэмэгдүүллээ.

“Гэр бүлийн уншлага”-ыг Хүүхдийн уншлагын танхимаар 4 удаа Хэрлэн ЕБС, цэцэрлэгийн 88 гэр бүлийг хамруулан 135 номоор ярилцлага хийж хамтын бүтээл хийж танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулсан. “Үлгэрийн цаг” уншлагаар Хэрлэн сумын цэцэрлэгийн 5 ангийн 128 хүүхдэд номын сантай танилцах аялал зохион байгуулж бага насны хүүхдийн онцлогт тохирсон танин мэдэхүйн 312 ном зохиол сурталчилж төрөл бүрийн уншлагуудыг зохион байгуулсан.

”Дэлхийн номын баярын өдөр”-ийг тохиолдуулан Х.Болор-Эрдэнийн “Гүйж яваа эмэгтэй” номоор уншсанаа ярилцах “Номын тухай хэлэлцүүлэг”-ийг уншигчидтай зохион байгуулж зохиолчоос талархал хүлээн авсан.

“Бүтээлч уншлага”-ын аймгийн уралдааны удирдамжийг аймгийн ИТХ-тай хамтран нийт сумдын Соёлын төв болон ЕБС, цэцэрлэгийн анги хамт олонд

хүргүүлж эцсийн шалгаруулалт 2019 оны 12 дугаар сард явагдаж шилдэг бүтээлүүдийг 2020 оны 01 дүгээр сард шалгаруулж олон нийтэд зарлана.



Уншлагын танхимын уншигчдад болон бүтээлч уншлагын аяны хүрээнд “Уншсан номын тэмдэглэл” хөтлөх загварыг боловсруулан уншигч хүүхдүүдэд сурталчилж ЕБС-ийн 1200 сурагчдад номын тэмдэглэл хөтлөх богино хэмжээний сургалтуудыг Хүүхдийн уншлагын танхимаар дамжуулан зааж өгсөн.

Хандив тусламж, батлагдсан төсөв болон нөхөн бүрдүүлэлтээр нийтдээ 348 нэр төрлийн 519 ширхэг 7367.0 мян.төг-ийн сан хөмрөгийн баяжилт хийж үүнээс нөхөн бүрдүүлэлтээр 83 нэр төрлийн 84 ширхэг 1200.0 мян.төг-ийн, батлагдсан төсвийн 3.6 хувиар буюу 4434.7 мян.төг-өөр 182 нэр төрлийн 258 ширхэг, хандив тусламжаар 44 нэр төрлийн 72 ширхэг номоор сан хөмрөгөө баяжуулсан. Эдгээрийг мэдлэгийн анги салбараар нь ангилбал байгалийн шинжлэх ухаан 1, техник 2, хөдөө аж ахуй 3, анагаах ухаан 3, түүх 45, улс төр 3, эдийн засаг 2, соёл, шинжлэх ухаан боловсрол 9, хэл шинжлэл 29, аман зохиол утга зохиол 70, уран зохиол 304, урлаг 10, шашин 1, гүн ухаан 10, сэтгэл судлал 7, лавлах хэвлэл 20 тус тус байна. Үүнийг нэгбүрчилсэн бүртгэлд бүртгэж 4 танхимд хуваарилалаа. Үүнд нийтийн уншлагын танхимд 100, гэрээр ном олгох танхимд 154, хүүхдийн танхимд 194, сан хөмрөгт 74 ширхэгийг тус бүрээр хуваарилав.

Аймгийн ИТХ-ын дэмжлэгтэйгээр “Бяцхан номын сан”-г Р.Чойномын нэрэмжит гэрэлт гудамжинд байршуулан Р.Чойномын нэрэмжит “Өд сан” болон Хэрлэн сумын зарим иргэд, номын сангийн 5 ажилтнаас зэрэг нийт 320 ном, сэтгүүл, сонин хандивлан уншигчдын эрэлт хэрэгцээг ханган “Та авч болно, өгч болно” гэсэн уриан дор уг номын санг ажиллуулж байна.

Аймгуудын 16 сумын тэмдэглэлт ойн хүрээнд хэвлэгдсэн танилцуулга бүхий номоор сан хөмрөгөө баяжууллаа.

“Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага MNS ISO 11799:2007 стандартыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу ЗДТГ-аас Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэн Улаанбаатар хотын Квант сервис ХХК-аар 5600.0 мян.төг-ийн өртөг бүхий камер, дохиолол, хамгаалалтыг суурилуулж байгууллагын аюулгүй байдал, гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.



2.САН ХӨМРӨГ, КАТАЛОГ

2.1. Сан хөмрөгийн өнөөгийн байдал

Орон нутгийн онцлог, уншигч-үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээ шаардлагыг үндэслэн улсын төсөв, төсөл хөтөлбөр, хандив тусламжийн хүрээнд фондын баяжуулалт хийгдэж байна.

Энэ онд өдөр тутмын Өдрийн сонин, Үндэсний шуудан болон Утгазохиол урлаг, Дал, Open door, Хүмүүн бичиг, Залуу нас мөн орон нутгийн Хэнтийн мэдээ сонингууд, Цог, Улирал ба зохиолч, Төрийн мэдээлэл, Өрхийн үйлдвэрлэл зэрэг сонин сэтгүүлийг тус бүр 4 улирлын туршид нийтдээ 480.0 мян.төг-ийн хэвлэлийг захиалан уншигчиддаа хүргэж байна.

Сан хөмрөгийн тоон үзүүлэлт

	Тоо ширхэг	Үнэ
Сан хөмрөг нийт	50808	102961.1
Сонин сэтгүүл	12	480.0
Цахимжуулсан	8165 нэр төрлийн 17141 ширхэг	

Өмнөх оны мөн үетэй графикаар харьцуулахад:



2.2 Сан хөмрөгийн бүрдүүлэлт

Тайлант хугацаанд хандив тусламж, батлагдсан төсөв болон нөхөн бүрдүүлэлтээр нийтдээ 348 нэр төрлийн 519 ширхэг 7367.0 мян.төг-ийн сан хөмрөгийн баяжилт хийж үүнээс нөхөн бүрдүүлэлтээр 83 нэр төрлийн 84 ширхэг 1200.0 мян.төг-ийн, батлагдсан төсвийн 3.6 хувиар буюу 4434.7 мян.төг-өөр 182 нэр төрлийн 258 ширхэг, хандив тусламжаар 44 нэр төрлийн 72 ширхэг номоор сан хөмрөгөө баяжуулсан. Эдгээрийг мэдлэгийн анги салбараар нь ангилбал байгалийн шинжлэх ухаан 1, техник 2, хөдөө аж ахуй 3, анагаах ухаан 3, түүх 45, улс төр 3, эдийн засаг 2, соёл, шинжлэх ухаан боловсрол 9, хэл шинжлэл 29, аман зохиол утга зохиол 70, уран зохиол 304, урлаг 10, шашин 1, гүн ухаан 10, сэтгэл судлал 7, лавлах хэвлэл 20 тус тус байна. Үүнийг нэгбүрчилсэн бүртгэлд бүртгэж 4 танхимд хуваарилалаа. Үүнд нийтийн уншлагын танхимд 100, гэрээр ном олгох танхимд 154, хүүхдийн танхимд 194, сан хөмрөгт 74 ширхэгийг тус бүрээр хуваарилан салбар салбарын номоор уншигч-үйлчлүүлэгчдийн татгалзлын бүртгэл судалгаа болон бестселлер бүхий уншигчдын хүсэмжилсэн ном зохиолоор фондоо баяжуулж уншигч-үйлчлүүлэгчдийн гар дээр хүргээд байна.

Номын баяжилтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад номын нэр төрөл 13.2 хувь, тоо ширхэг 11.7 хувиар, мөнгөн дүн 12.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн ИТХ-ын дэмжлэгтэйгээр “Бяцхан номын сан”-г Р.Чойномын нэрэмжит гэрэлт гудамжинд байршуулан Р.Чойномын нэрэмжит “Өд сан” болон Хэрлэн сумын зарим иргэд, номын сангийн 5 ажилтнаас зэрэг нийт 320 ном, сэтгүүл, сонин хандивлан уншигчдын эрэлт хэрэгцээг хангаг “Та авч болно, өгч болно” гэсэн уриан дор уг номын санг ажиллуулж байна.

Аймгуудын 16 сумын тэмдэглэлт ойн хүрээнд хэвлэгдсэн танилцуулга бүхий номоор сан хөмрөгөө баяжууллаа.

2.3 Каталоги зохион байгуулалт

БССШУЯамнаас зарласан номын сангуудыг автоматжуулах тендерт шалгарсан Улаанбаатар хотын Волвес ХХК-ийн номын сангуудыг автоматжуулах 1530.0 мян.төг-ийн өртөг бүхий LiB4U программыг аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр номын сангийн электрон каталоги нь 2019 оны 09 сарын 02-ны өдрөөс эхлэн khentii.LiB4U.Net гэсэн хаягаар интернет орчинд байршиж өнөөдрийн байдлаар 8165 нэр төрлийн 17141 ширхэг ном цахимд бүртгэлжүүлэн, баркод нааж электрон хэлбэрт оруууллаа. Нийт номын 33.7 хувийг цахимд байршуулан цахим бүртгэлийн ажил идэвхтэй явагдаж байна. Цаашид цахимд байрших хувь өссөнөөр уг цахим орчинд ажиллах “ХӨТӨЧ” сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.

Уншигч үйлчлүүлэгчдэд онлайн захиалгыг хийх, эрэлт хэрэгцээтэй номоо хүссэн газраасаа хайлт хийхэд khentii.LiB4U.Net программ руу хандах бүрэн боломжтой болсон. Уншлагын танхимд хайлтын 1 компьютерийг байршуулан байнгын онлайн байна.

Мөн нийт сумдын соёлын төвийн номын санч нарт Monbiblio програмыг албан хэрэгцээнд хэрхэн ашиглах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч уг програмд оруулсан номын тоо болон ашиглалтын явцыг нэгтгэхэд бүх сумдын

үндсэн фондын 103719 номоос 98781 ширхэг буюу нийт номын 95.2 хувийг байршуулж өмнөх оны мөн үетэй харьцуулахад үндсэн фондын номын тоо 46 буюу 0.04 хувиар буурч програмд байршуулсан нь 7931 буюу 8.7 хувиар өссөн байна.

Цаашид энэхүү програмд номын сангийн үндсэн фондод буй ном цахим каталогит шилжсэнээр БСШУСЯ-ны серверт байршиж номын сангуудын үйл ажиллагаа ил тод нээлттэй болж харилцан мэдээлэл солилцох бүрэн боломжтой.

3 ҮЙЛЧИЛГЭЭ

3.1 Уншлага үйлчилгээ

Тайлант хугацаанд нийт уншигчдын тоо 24877 үүнээс нийтийн уншлагын, хүүхдийн уншлагын, гэрээр ном олгох танхимуудын байнгын уншигч буюу шинээр карт нээн үйлчлүүлсэн уншигчдын тоо тайлант хугацаанд 1790, ирцээр буюу байнгын уншигч 23087, олгосон номын тоо 45692 болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад байнгын уншигч 164 буюу 9.1 хувь, ирцээр уншигчийн тоо 15893 буюу 68.8 хувь, нийт олгосон номын тоо 3335 буюу 7.6 хувийн өссөн үзүүлэлттэй байна. Шинээр ирж үйлчлүүлэгч буюу байнгын уншигчийн жилийн төлөвлөлт 100.0 хувийн гүйцэтгэлтэй.

Үүнд танхим тус бүрээр харуулахад:

Нийтийн уншлагын танхим байнгын уншигч 720, ирцээр уншигч 12954, 17772 ном олгож үйлчилсэн.

Хүүхдийн уншлагын танхим байнгын уншигч **720**, ирцээр уншигч **9285**, **23308** ном олгож үйлчиллээ.

Гэрээр ном олгох танхим байнгын уншигч 350, ирцээр уншигч 848, 4415 ном олгож үйлчлэв.

Мөн тайлант хугацаанд өдөр тутмын Өдрийн сонин, Үндэсний шуудан болон Утгазохиол урлаг, Дал, Open door, Хүмүүн бичиг, Залуу нас мөн орон нутгийн Хэнтийн мэдээ сонингууд, Цог, Улирал ба зохиолч, Төрийн мэдээлэл, Өрхийн үйлдвэрлэл зэрэг сонин сэтгүүлийг тус бүр 4 улирлын туршид нийтдээ 480.0 мян.төг-ийн хэвлэлийг захиалан уншигчиддаа хүргэж байна.

Нийтийн уншлагын танхим байнгын уншигч 720, ирцээр уншигчийн тоо 12954, олгосон номын тоо 17772 болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад байнгын уншигч 215 буюу 29.8 хувиар буурч, ирцээр уншигчийн тоо 4049 буюу 31.2 хувиар тус тус өссөн, нийт олгосон номын тоо 839 буюу 4.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүүхдийн уншлагын танхим байнгын уншигч 720, ирцээр уншигчийн тоо 9285, олгосон номын тоо 23308 болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад байнгын уншигч 151 буюу 20.9 хувь, ирцээр уншигчийн тоо 2525 буюу 27.1 хувиар тус тус буурч, нийт олгосон номын тоо 3118 буюу 13.3 хувиар өссөн.

Гэрээр ном олгох танхимын байнгын уншигч 350, ирцээр уншигчийн тоо 848, олгосон номын тоо 4415 болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад байнгын уншигч

100 буюу 28.5 хувиар өссөн, ирцээр уншигчийн тоо 4501 хүнээр, нийт олгосон номын тоо 3984 буюу 90.2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хэрлэн гол бол Монгол улсын хамгийн урт гол, Хэнтийн нуруунаас эх авч Монгол орны зүүн бүс нутгийн дундуур урсан Далай нуурт цутгадаг 1163 км урсдаг гол. Монголын нууц товчоо, Чингис хааны түүхэн амьдралтай салшгүй холбоотой тухай түүх шаштирт бичигдсэн байдаг. Одоогийн цаг үед хамгийн олон дуу шүлэг, аялгууг шингээсэн гол мөрөн гэж үздэг. Иймдээ ч Нийтийн номын сангийн хамт олны зүгээс зөвхөн өөрийн сан хөмрөгт буй домогт Хэрлэн мөрний сан тахилга, айзам уртын болон ардын дуу, шүлэг, найраглал, тэмдэглэл, дуртгал, нийтлэлийг түүвэрлэн “Хэрлэн нутаг сайхан аа” эмхэтгэл номыг хэвлүүлсэн.

3.2 Соёл олон нийтийн ажил

Төрийн шагналт, Ардын уран зохиолч Сэнгийн Эрдэнийн мэндэлсний 90 жилийг ойг угтан зохиол бүтээлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд Политехникийн коллежийн оюутан сурагчдын дунд “Жаргах нас” өгүүллэгээс сэдэвлэсэн илтгэлийн уралдаан, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд “Үгийн жирэм”, “Сэргүүн Галттай-Сэтгэлд ойр” илтгэлийн уралдааныг тус бүр 2 үе шаттайгаар зохион байгуулахад Хэрлэн, Өмнөдэлгэр, Биндэр, Баянхутаг, Баянмөнх сумд болон Өлзийт тосгоны 220 сурагчид оролцож шилдэгийн шилдэг оролцогчдын илтгэлийг олон нийтэд сурталчилж энэхүү арга хэмжээг эцэг эхчүүдийн оролцоо, аймгийн ИТХурал, ДЗОУБ-ын дэмжлэгтэйгээр БСУГ-ын мэргэжилтэн, багш нартай хамтран зохион байгууллаа. Мөн энэ үеэр Хэрлэн сумын ЕБ-ын I. II. III. IV, Өлзийт тосгоны нийт 5 ЕБС-ийн номын санч нартай хамтран дунд ангийн 44 сурагчдын дунд “Алтан хонх” цэнгээнт уралдааныг Сэнгийн Эрдэнийн зохиол бүтээлээр сэдэвлэн зохион явуулж шалгарсан 3 сурагчийг шагнаж урамшуулсан.

Өсвөрийн сэтгүүлч клубын “Дөлгөөн Хэрлэн уншигчийн нэгдэл”-ийн гишүүн ЕБС-ийн 22 сурагчдыг Улаанбаатар хотноо номын сангууд, өдөр тутмын сонины редакц, СУИС-ийн үйл ажиллагаатай танилцах 2 өдрийн “Хамтдаа хөгжиж харилцан суралцая” сэдэвт аялалыг зохион байгууллаа.

Аз хур номын их дэлгүүртэй хамтран аймагтаа анх удаа номын үзэсгэлэн худалдааг 2 өдрийн турш зохион байгуулж олон нийтийн талархлыг хүлээлээ.

ДЗМОУБ-ын Бор-Өндөр 2 ОНХХөтөлбөрийн дэмжлэгтэйгээр МЗЭ-ийн болон Утга зохиолын "Шинэ үнэр" бүлгэмийн гишүүн, Г.Сэр-Одын нэрэмжит шагналт зохиолч, яруу найрагч Өлзийхутагийн ҮЛЭМЖТӨГС-тэй уулзах ЗОХИОЛЧ УНШИГЧДЫН УУЛЗАЛТ, ЯРИЛЦЛАГА Хэрлэн суманд 150 хүүхэд, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, Хурх тосгоны ЕБС-ийн ахлах ангийн 200 гаруй сурагчдын дунд энэ сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулагдлаа. Уг уулзалтанд аймгийн ИТХ-ын нарийн

бичгийн дарга С.Бат-Эрдэнэ, ДЗМОУБ-ын Бор-Өндөр 2 ОНХХөтөлбөрийн ахлагч Г.Жаргалбат болон өсвөрийн сэтгүүлч клубын хүүхдүүд, номын сангийн идэвхтэн уншигч нар оролцож сонирхсон асуултандаа хариулт авсан. Нийт оролцогсдод номын хавчуурга хийж бэлэг барилаа. Мөн тус арга хэмжээнд Хэрлэн I сургуулийн морин хуурч хүүхдүүд уран бүтээлээсээ эгшиглүүлж морин хуурын хөг аялгуу шүлэг яруу найргийг хослуулан сайхан арга хэмжээ болж өнгөрлөө.

Мөн ДЗМОУБ-ын Бор-Өндөр 2 ОНХХөтөлбөрийн дэмжлэгтэйгээр МЗЭ-ийн судлал шүүмжийн үндэсний төвийн дарга, СУИС-ийн Урлаг судлал, утга зохиолын тэнхимийн эрхлэгч, доктор, профессор, МЗЭ-ийн шагналт зохиолч, шилдэг бүтээлийн Алтан өд наадмын 6 удаагийн тэргүүн, олон улсын театрын Гэгээн муза наадмын эзэн Пүрэвхүүгийн Батхуяг, МЗЭ-ийн гишүүн, МОНЦАМЭ агентлаг INTERVIEW сэтгүүлийн тоймч, сэтгүүл зүйн БАЛДОРЖ шагналын шилдэг 1-рт багтаж байсан Гомбын СЭР-ОД-ын нэрэмжит болон сэтгүүл зүйн Ган үзэгтэн шагналт, хайрын шүлгийн Цагаан-Уул наадмын тэргүүн байрын шагналт, Хэнтий аймгийн зохиолч яруу найрагчдын Хэрлэн тооно утга зохиолын нэгдлийн гишүүн Балдоржийн Алтанхуяг нарын оролцсон “Зохиолч-уншигчдын уулзалт, ярилцлага” зохион байгууллаа. Уг уулзалтанд аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга С.Бат-Эрдэнэ, ДЗМОУБ-ын Бор-Өндөр 2 ОНХХөтөлбөрийн ахлагч Г.Жаргалбат болон өсвөрийн сэтгүүлч клубын хүүхдүүд, номын сангийн идэвхтэн уншигч хүүхдүүд оролцож сонирхсон асуултандаа хариулт авсан. Нийт оролцогсдод номын хавчуурга хийж бэлэг барьлаа. Мөн тус арга хэмжээнд Тэмүүжин цогцолбор сургуулийн морин хуурч, Хэрлэн IV сургуулийн гоцлол дуучин хүүхдүүд уран бүтээлийн дээжисээ өргөн барьж, зочин зохиолчид маань өөрсдийн “Шулмын шүлгүүд”, “Очирбатын Дашбалбар” гэсэн уран бүтээлээсээ номын санд хандив өргөж сайхан арга хэмжээ зохион байгууллаа.

Улаанбаатар хотын Хүүхдийн номын ордны хамт олонтой хамтран Мөрөн сумын ЕБС, , Хэрлэн сумын ЕБ-ын IV сургуулийн бага ангийн 120 хүүхдийг хамруулсан хүүхдийн зохиолч Б.Жамбалсүрэн, А.Амарсайхан, Д.Жаргалсайхан, Н.Даваадаш, М.Билэгсайхан нартай биечлэн уулзуулж хүүхдүүдийн сонирхсон асуултанд хариулж, тэдгээрийн зохиол бүтээлээр жүжигчилсэн тоглолтыг зохион байгууллаа.



ДЗМОУБ-ын Бор-Өндөр-2 ОНХХ-ийн дэмжлэгтэйгээр 831.0 төгрөгийн санхүүжилтээр сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдүүдийн дунд Үлгэрийн баатрууд амилсан нь-2019 уралдааныг 8 дахь жилдээ онлайн хэлбэрээр 2 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Үүнд Өмнөдэлгэр, Бор-Өндөр, Дадал, Баянмөнх сумд, Гурванбаян тосгон, Хэрлэн сумын нийтдээ 12 сумын 11-н цэцэрлэгүүдийн 15 бүтээлд 235 хүүхэд оролцсоноос Өмнөдэлгэр, Баянмөнх, Дадал сумдын бүтээлүүд шалгаран дурсгалын зүйл гардуулж байгууллагын Хэнтий аймаг Номын сан фэйсбүүкээр уралдаанд оролцсон нийт бүтээлүүдийг сурталчлан олны хүртээл болголоо

Оролцогч хүүхэд багачуудын аюулгүй байдал алдагдах, гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлж 2018 оноос эхлэн Үлгэрийн баатрууд амилсан нь-2019 уралдааныг онлайн хэлбэрт шилжүүлэн ирүүлсэн нийт бүтээлийг CD хэлбэрт хадгалан архивлаж түүх болгон хадгалж байна.

Жилийн бүрийн олон улсын эмэгтэйчүүдийн баярын өдөр, цэргийн баярын өдрүүдийг тохиолдуулан уламжлал болгон явагддаг "Ээждээ захидал бичээрэй", "Аавдаа захидал бичээрэй" захидлын уралдаанд нийтдээ 425 иргэн ээж, аавдаа хандан сэтгэлийн үгээ илэрхийлж оролцсоноос шилдэг 20 захидлыг улсын уралдаанд оролцуулж уралдааны шалгарсан захидлуудыг гардуулах арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж нийт захидлыг захидлын эздэд гардуулан өгсөн.

Хэрлэн сумын нутаг дэвсгэрт ажиллаж амьдарч бусдадаа үлгэр дууриал болохуйц 10 гэр бүлийн 20 гишүүдийг хамруулан сэтгэлийн үгээ ханьдаа илгээх талархлын захидлын аян өрнүүлж хүүхэд залуусыг гэр бүлийн эерэг харилцаа хандлага, захидал бичих соёлд суралцахыг уриаллаа.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Номон далай" өртөө ажиллуулж оюуны амтат чихрээр 300 гаруй хүүхдийг дайлж, гэр бүлийн хүүхдийн харилцаа хандлага, өсвөр насны хүүхдийн хүмүүжил эрүүл мэнд сэтгэл зүйн боловсролын 60 номоор үзэсгэлэн гаргаж "Манай гэр бүл ба ном" гар зургийн уралдаанд ЕБС-ийн бага

ангийн 50 сурагчид бүтээлээ ирүүлснээр үзэсгэлэн гарган хүүхэд тус бүрт урамшуулал олгосон.

Насан туршийн боловсролын дүйцсэн хөтөлбөрийн суралцагч хүүхдүүдийн дунд Ардын уран зохиолч Сэнгийн Эрдэнийн мэндэлсний 90 жилийн ойг тохиолдуулан түүний уран бүтээлийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах зорилгоор зөөврийн номын сангийн үйлчилгээг үзүүлж Өвгөн шувуу, Нутгийн салхи бүтээлээр нь зурагт ном бүтээх аян зохион байгуулж дээрх сурагчид идэвхтэй хамрагдлаа.



4.ХҮНИЙ НӨӨЦ

4.1 Арга зүйн ажлын хүрээнд

Тайлант хугацаанд аймгийн Нийтийн номын сангийн 2 номын санчийг Улаанбаатар хотод болсон “Үндэсний бичиг үсгийн баярын өдөр”-ийг тохиолдуулан зохион байгуулсан арга хэмжээнд оролцуулан МҮНСанд дадлагажих сургалтанд хамруулж мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, 1 удирдах албан тушаалтныг “Соёл, урлагийн байгууллагын тогтвортой хөгжил-удирдахуйн шинэлэг хандлага-III” сургалтанд, Зүүн бүсийн соёл урлагийн ажилтнуудыг хамруулан СУИС-ийн Соёлын сургуулиас зохион байгуулсан “Бүтээлч хамтын ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөр-I” 2 өдрийн сургалтанд 6 ажилтан, Mongolian library update 2019 зөвлөлгөөнд 3 ажилтан, Нийтийн номын сан арга зүйн төв болох нь сургалтанд 2 номын санч нийтдээ давхардсан тоогоор тайлант хугацаанд 16 ажилтан мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх сургалтуудад амжилттай хамрагдлаа.

Номын сангуудын үйл ажиллагаанд зөвлөн туслах, сургалтын үйлчилгээг аймгийн Нийтийн номын сангийн номын санч нараас БСУГ-ын соёлын асуудал хариуцсан мэргэжилтний хамт 19 сумын Соёлын төв, 7 ЕБС-ийн номын санч нарт мэргэжил арга зүйн

зөвлөгөөг өгсөн. Энэ ажлын хүрээнд номын санчдын мэдлэг ур чадвар дээшилж хамтын ажиллагааг идэвхжүүлэв.



5.ТЕХНОЛОГИ

Тайлант хугацаанд шинээр болон дахин хэвлэлтэнд гарсан анагаах ухаан, түүх, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, сэтгэл судлал боловсрол, хэл шинжлэл, аман болон утга уран зохиол, гүн ухаан шашин, лавлагаа мэдээллийн зэрэг салбар салбарын 302 нэр төрлийн 458 ширхэг 7909.380 мян.төг-ийн үнэ бүхий номоор зурагт тайлбар бүхий мэдээ мэдээллийг уншигч-үйлчлүүлэгчдийн хүртээл болголоо.

БССШУЯамнаас зарласан номын сангуудыг автоматжуулах тендерт шалгарсан Улаанбаатар хотын Волвес ХХК-ийн номын сангуудыг автоматжуулах 1530.0 мян.төг-ийн өртөг бүхий LiB4U программыг аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр номын сангийн электрон каталоги нь 2019 оны 09 сарын 02-ны өдрөөс эхлэн khentii.LiB4U.Net гэсэн хаягаар интернет орчинд байршиж өнөөдрийн байдлаар 8165 нэр төрлийн 17141 ширхэг ном цахимд бүртгэлжүүлэн, варкод нааж электрон хэлбэрт оруулаа. Нийт номын 33.7 хувийг цахимд байршуулан цахим бүртгэлийн ажил идэвхтэй явагдаж байна. Цаашид цахимд байрших хувь өссөнөөр уг цахим орчинд ажиллах “ХӨТӨЧ” сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.

Уншигч үйлчлүүлэгчдэд онлайн захиалгыг хийх, эрэлт хэрэгцээтэй номоо хүссэн газраасаа хайлт хийхэд khentii.LiB4U.Net программ руу хандах бүрэн боломжтой болсон. Уншлагын танхимд хайлтын 1 компьютерийг байршуулан байнгын онлайн байна.

5000 гаруй фэйс найз, дагагч бүхий “Хэнтий аймгийн Номын сан” гэсэн facebook хуудас ажиллуулж байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулж, шинэ номын мэдээ мэдээллийг түгээж байна.

6.ТӨСӨВ, ОРЛОГО, ЗАРДАЛ

2018 оны жилийн эцсийн байдлаар 325м^2 хэмжээтэй 47531.8 мян.төг-ийн үнэ бүхий барилга байгууламж, 31286.7 мян.төг-ийн тоног төхөөрөмж, 20226.6 мян-төг-ийн тавилга, эд хогшил буюу нийтдээ 115017.1 мян-төг-ийн үндсэн хөрөнгийг тоолж бараа материалын тооцоо бодсон баримт үйлдэж албан хаагчдын эд хөрөнгө ашиглалтын картыг шинэчлэв.

Энэ онд 123530.5 мян-төг-ийн төсөв батлагдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж цалин, гэрэл, цэвэр бохир ус, албан томилолтын зардлаас 3134.0 мян.төг-ийн хэмнэлт гарган шаардлагатай байгаа ном хэвлэл, багаж техник хэрэгсэл, мэдээлэл технологийн зардалд холбогдох байгууллагын зөвшөөрлөөр зарцуулаа.

Өөрийн орлогыг сар бүрийн эхний 05-ны дотор танхим тус бүрээр нэмэлт дансанд нийтдээ 1679.7 мян.төг-ийн орлого төвлөрүүлж холбогдох дүрэм журмын хүрээнд зарцуулаад байна.

7.ДҮГНЭЛТ, САНАЛ

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.6-д тусгагдсан "Нийтийн номын сангийн фондыг баяжуулан, хүүхэд залуусын номтой нөхөрлөх, иргэд олон нийтийн ном унших боловсролыг дээшлүүлэх зорилгоор "Ном уншицгаая" хөдөлгөөн өрнүүлнэ" гэсэн зорилт түүнийг хэрэгжүүлэх 4 арга хэмжээний хүрээнд соёл олон нийтийн олон талт ажлуудыг төрийн болон төрийн бус байгууллагын дэмжлэг туслалцаатайгаар зохион байгуулж оролцогсод, хамрах хүрээг өмнөх оноос ахиулсан нь тоон мэдээллүүдээс харагдаж байна.

Үүнээс онцлох олон нийтийг хамарсан ажлуудаас "Гэр бүлийн уншлага", "Зөөврийн уншлага", "Өглөөний уншлага", "Өглөөний хүн", "Яруу найргийн уншлага", "Тогтмол хэвлэлийн уншлага"-уудад хамрагдсан уншигч-үйлчлүүлэгчдийн тоо өмнөх оноос өссөн үзүүлэлттэй мөн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхэд багачуудын дунд 8 дахь жилдээ зохион байгуулж буй "Үлгэрийн баатрууд амилсан нь-2018" жүжигчилсэн тоглолтыг энэ жил оролцогсдын хүрээг тэлж 18 сумын цэцэрлэгийн 23 төрлөөр анх удаа хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эдийн засгийн хэмнэлттэйгээр ОНЛАЙН хэлбэрээр амжилттай зохион байгуулж оролцогсдын бүтээлийг CD болгон номын санд архивлаж, амжилттай оролцсон шилдэг бүтээлүүдийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр сурталчилсан зэрэг ажлууд байна.

Монголын Номын сангийн салбарын 2018 оны "Онцлох соёл олон нийтийн ажил"-аар аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Ном уншицгаая" хөдөлгөөн шалгарч "Онцлог" цом, Монголын Үндэсний номын сангийн нэрэмжит шагналаар шагнагдсан.

БСШУСЯамнаас зарласан номын сангуудыг автоматжуулах тендерт шалгарсан Улаанбаатар хотын Волвес ХХК-ийн номын сангуудыг автоматжуулах 1000.0 мян.төг-ийн өртөг бүхий LiB4U программыг 2017 оны 10 дугаар сараас 2018 оны 10 дугаар сарын 08 хүртэлх 1 жилийн хугацаанд 4 танхимын 4 компьютераар нийт 3498 нэр төрлийн 5608 ширхэг номыг цахим бүртгэлжүүлэн, варкод нааж электрон хэлбэрт оруулж khentii.LiB4U.Net гэсэн хаягаар интернет орчинд уншигч-үйлчлүүлэгчид мэдээ мэдээлэл авч нийт номын фондын 5.9 хувийг цахим бүртгэлжүүлэн тус компанид тухайн жилийн болон цаашид жил тутам төлөгдөх үйлчилгээний хөлс 1400.0 мян.төг-ийг төлөөгүй, цаашдаа жил тутам төлөгдөж үйлчилгээний эрх нээгдэх тухай ойлголцлын зөрүүтэйн улмаас цахим программ хаагдаж цахим үйлчилгээ ашиглагдахгүй байна.

Мөн өөрсдийн нөөц бололцоог ашиглан байгууллагын гадна үүдний хэсэгт хальтирч унахаас сэргийлсэн төмөр хашлага хийж, байгууллагын барилгын гадна талд фасад хийж өнгө үзэмжээ нэмсэн, уншлагын танхимуудыг хөшигтэй болгосон,

....
.... зэрэг тохижуулалтын ажил хийгдэж тохь тухтай орчин бүрдүүлснээс гадна аймгийн ИТХ-ын дэмжлэгтэйгээр "Бяцхан номын сан"-г

Р.Чойномын нэрэмжит гэрэлт гудамжинд байршуулан Р.Чойномын нэрэмжит “Өд сан” болон Хэрлэн сумын зарим иргэд, номын сангийн 5 ажилтнаас зэрэг нийт 320 ном, сэтгүүл, сонин хандивлан уншигчдын эрэлт хэрэгцээг ханган “Та авч болно, өгч болно” гэсэн уриан дор уг номын санг ажиллуулж уншлага үйлчилгээг иргэдэд ойртуулсан.

Мөн бүртгэлгүй сонин сэтгүүлийг бичих /янзалж байх үеийн зураг, сан хөмрөгтөө авсан, бусад ашиглагдахгүй шаардлага хангахгүй сонин сэтгүүлийг хэрхсэн талаарх/

Нийтийн номын сангийн “Өмч хамгаалах орон тооны бус байнгын зөвлөл”, тус байгууллагын нийт ажилтнуудыг хамруулсан өргөтгөсөн хурлын шийдвэрийг үндэслэн Нийтийн уншлагын танхимын сан хөмрөгт хадгалагдаж байсан 56 нэр төрлийн 1359 ширхэг агуулга ач холбогдлын хувьд хуучирч номын санд хэрэгцээгүй болсон тогтмол хэвлэл, сонин сэтгүүлийг Монгол улсын соёлын сайд, сангийн сайдын хамтарсан 1994 оны 83/97 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Номын сангийн ном, хэвлэлийн бүтээгдэхүүнийг худалдах, солилцох, данснаас хасах журам”-г үндэслэн устгалд орууллаа.

Цаашид номын сангийн үйл ажиллагаа орчин үеийн чиг хандлагад нийцсэн, уншигч-үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан тохь тухтай орчин бүрдүүлж үйлчлэхийн тулд нэн түрүүнд зайлшгүй шаардлагатай байгаа доорх саналыг хүргүүлж байна. Үүнд:

1.Улсын дундажтай харьцуулахад орон тооны хувьд хамгийн доогуур үзүүлэлттэй байгааг анхааран орон тоог нэмэгдүүлэх талаар судлах

2. Жилээс жилд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авч байгаа болон хандив тусламж бусад эх үүсвэрээс үндсэн номын сан хөмрөгийн хэмжээ нэмэгдэж түүнийг хадгалах өрөө тасалгаа, тавиурын хүрэлцээ муу уншигч-үйлчлүүлэгчдийнхээ хүрээг тэлж ажиллахад хүндрэлтэй байгаа тул байгууллагын өөрийн эзэмшлийн газарт байшингийн баруун тийш уншлагын танхим шинээр барьж орчин үеийн чиг хандлагад нийцсэн уншигч-үйлчлүүлэгчид ая тухтай чөлөөт сонголт хийж үйлчлүүлэх барилга өргөтгөлөөр барих гэх мэт төсөв санхүүгийн хүрээнд шийдвэрлэвэл зохих асуудлыг судлан үзэж дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хүсч САНАЛ хүргүүлж байна.